



ДЭЛХИЙН

100



ЯАДЯРТАЙ ХОТ



Улаанбаатар хот  
2013 он

Дэлхийн алдартай 100 хот  
Зохиолч: Д.Өлгийсайхан

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Өмнөх үг

Хүн бүр амьдралдаа аялагч болж үл мэдэгдэх орон нутаг, улс орон, хот үзэхийг мөрөөдөж байдаг билээ. Бидний санаанд харь, үл таних орнуудын дүр зураг дүрслэгдэн бий болж тэдэнтэй нүүр тулан уулзахыг тэсэн ядан хүлээдэг.

Өнгөрсөн үе биднээс зуун, мянган жилийн хугацаагаар зааглагдаж байдаг ч эрдэмтэд хуучны судлалын малталтын олдвор, бичмэл эх сурвалжуудыг судалж эрт дээр үед болсон үйл явдлуудыг сэргээн мэддэг болсоор байдаг билээ. Ямар ч хүн тэр ч бүү хэл туршлагатай аялагч үл таних хотод буумагц анхандаа сандарч тэвдэж сэтгэлд нь маш олон бодол санаа төрж хоттой хэрхэн танилцахаа шийдэж ядна.

Замбуулин хорвоогийн хотууд янз бүрийн байдлаар бий болжээ. Зарим нь жингийн замуудын уулзвар дээр үүсэж зах, худалдааны талбай дээр нь олон хэлийн яриа хөөрөө хадаж эхлэжээ. Хотын лангуу, дэлгүүрт умард зүгийн ангийн үс, энэтхэгийн очир алмаас, дорнын торго, Газрын дундад тэнгисийн бүлээн дарс бүхий галуун хүзүүт лонх нүд эрээлжилнэ.

Зарим хот элсэн цөлийн хаа нэгтээ байх ундны устай худгийн хажууд үүсэж байлаа. Төөнөм халуунд ядарч туйлдсан хүмүүс худагны дэргэд ирж цангаага тайлж хэрмийн сүүдэрт түр амсхийн амарч суухдаа хамгийн түрүүнд ирж хот байгуулсан хүмүүсийг бахархан магтана. Зарим хот газар дээр өөд цоройн боссон бол нөгөө хэсэг нь тэнгисийн гүнээс дээш сугаран гарч буй мэт бий болж байв. Хот-цайз, хот-хуаран тэрчилэн усан боомт, үйлдвэр, худалдааны зах тойрон бий болсон хотууд бас бий.

Хотууд янз бүрийн байдлаар үүсэн бий болж янз бүрийн хувь заяа туулжээ. Цагтаа хорвоогийн чимэг болж байсан хотууд буурал түүхийн нугачаанд сүйрч өнөөдөр нуранги, балгас нь л эл хуль цөл, битүү шугуй дотор харлан байна. Гэвч хүмүүс эртний хотуудын цайз, сүмийн балгас дундуур явж шохоорхон танилцаж байхдаа өнгөрсөн баатарлаг үеэ сайтар ойлгож эдүгээ сайхан цагаа илүү бүрэн дүүрэн ухаарч ирээдүйгээ итгэлтэй харж чаддаг болно. Эртний хотуудын оршин суугчид ордон, сүм босгож урлаг, соёлын гайхамшигт бүтээл туурвиж арилжаа наймаа хийж хүүхдүүдээ өсгөн бойжуулж өдөр тутмын дуусашгүй ажил төрөлдөө шамдан яаран байжээ.

Сүйрсэн, мөхсөн хотууд хүн төрөлхтөний соёл иргэншлийн түүхэнд эзлэх ёстой байр сууриа янз бүрийн байдлаар олж авч байлаа. 1880 онд германы хуучныг судлаач Генрих Шлиман малталт хийж суут яруу найрагч И.В.Гетё, Д.Г.Байрон төдийгүй европийн бүх эрдэмтэн үлгэр гэж эс тоож байсан домогт Троя хотыг нээж дэлхий даяар шуугиан тарьж байлаа.

Бараг хоёр мянга гаруй жилийн тэртээ Везувий галт уулын дэлбэрэлтийн хор уршгаар италийн цэцэглэж байсан Помпей, Геркуланум, Стабий гэсэн гурван хот сүйрсэн билээ. Гэвч сөнөсөн хотуудын балгасыг малтан ил гаргахад эртний ертөнцийн амьдрал бидний нүдний өмнө тодрон гарч ирсэн билээ. Ордон, сүм, хотуудын эртний чулуу түүхийн бахархалт аугаа, харамсал эмгэнэлт хуудсуудыг бидэнд өгүүлнэ.

Дэлхийн алдартай хотууд нь аливаа хүн тухайн хотод очиж үзээгүй байсан ч тэнд байгаа

гайхамшигт дурсгалуудыг шууд нэрлэж чаддагаараа их цуутай юм. Францийн нийслэл Париж гэж хэлэхэд л уншигч бүрийн санаанд киноноос ч юм уу гэрэл зургийг нь харсан, хаа нэгтээ уншсан Луврын алдарт музей, Дарь Эхийн сүм, Эйфелийн цамхаг бууна. Германы нэгэн эрдэмтэн Итали орныг “асар том Луврын музей” гэж нэрлэсэн бий. Үнэхээр ч Венеци хотын гоёмсог сувгууд, Пиза, Сиена хотуудын алдарт талбай, Флоренц, Болонь хотуудын төв хорооллууд, Триви усан оргилуурын тансаг гоо сайхныг үгээр магтаж ханашгүй билээ.

Уншигч Танд толилуулж байгаа энэ номонд эртний мөхсөн хотууд төдийгүй зуун, мянган жилийн турш давтагдашгүй дүр төрхөө хадгалсаар ирсэн хотуудын тухай өгүүлнэ. Номын хязгаарлагдмал хэмжээнээс шалтгаалан Троя, Микены, Помпей, Тиананако, Ангкор-Ват, Лос-Анжелес, Хива, Шираз, Загаун зэрэг дэлхийн гайхамшигт хотуудын тухай энэ удаа бичээгүйг уучилна уу.

Зохиогч

## НИНЕВИ

Эртний олон ард түмэн түүхийн тавцнаас оргүй алга болсон билээ. Хүн төрөлхтөний соёл иргэншлийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн шумер, филистимлян, хет зэрэг олон ард түмнээс хуучны судлалын малталтаар гарсан зүйлээс өөр юу ч үлдсэнгүй ажээ.

Харин ассирчууд бол өөр хэрэг. Манай эриний өмнөх 612 онд Ассирийн эзэнт гүрний нийслэл мөхөж дараа нь төр улс нь бүрмөсөн унасан ч ассирийн ард түмэн устаж үгүй болоогүй төдийгүй гадаадын эзлэн түрэмгийлэгчдэд уусаж алга болсонгүй. Тэд Курдистаны хүн туулж нэвтэршгүй уул нуруунд хоргодож аврагдсан хийгээд хөрш орших курдуудын нутагт амьдран сууж нэр алдраа авч гарчээ.

Ниневид хотыг мөхөснөөс зуун жилийн дараа эртний Персийн Дарий хааны ордны хананы бичээст ассирчуудын тухай дэлгэрэнгүй дурдсан байдаг. Суз суурингаас хуучны судлаачдын олсон хааны ордныг хэрхэн барьж байгуулсан тухай бичээст “Газар ухах, хайрга дэвсэх, тойлуу өрөх ажлуудыг вавилончууд амжуулжээ. Хуш гэдэг модыг Ливаны уулсаас буулгаж ассирчууд Вавилонд хүргэжээ.” гэж бичжээ.

Ассирчуудын тухай арабын түүхчид “Ассирчуудын үе залгамжлагчид эх нутагтаа амьдран сууж байна.” гэж бичиж үлдээжээ. Армянский сүм хийд эрт дээр үеэс өнөөг хүртэл Иосул хотын шашны удирдлагаа ассирийнх гэж нэрлэсээр иржээ. Ассирчууд ч түүнийг “курсий д’Нинви” буюу “Ниневид хотын сүм” гэж нэрлэдэг байна. Түүнээс гадна жил бүрийн нэгдүгээр сард “Ниневид хотын өдрийг” ёслол төгөлдөр тэмдэглэдэг. Товгор дүрсүүдэд сийлэн үлдээсэн шовгор оройтой эсгий малгайг өнөөгийн ассирчууд өвөг дээдсийхээ адил өмссөөр байна. Ниневид хотын тухай эртний эх сурвалжуудад төдийгүй библийн хөлгөн сударт мөн өгүүлсэн бий.

“Бурхны нүүр царайны өмнөх их хот.” гэсэн утгатай Ниневид хот жижигхэн, эрдэмтдийн тооцолж байгаагаар тойргийн урт нь 150 километр орчим байжээ. Үүнд зөвхөн барилга байгууламжийн талбай төдийгүй цэцэрлэг, билчээр, зугаалгын газар багтаж байв.

Манай эриний өмнөх VII зуунд сүүлч хавьд Ассирийн эзэнт гүрэн унаж “Библийн довууд” номонд бичсэнээр ассирчуудын өндөр соёл сүйрч бүх хот, тосгон, ордон, сүмийг тоонон дээрэмдэж эвдэн сүйтгэжээ.

Ассирийн эзэнт гүрний нийслэлийг Дур-Шаррукинаас Ниневид шилжүүлж атаархам тансаг, 12 километр урт хэрмээр хүрээлүүлсэн, 15 гулдан хаалгатай хот болгосон гавьяа Саргон хааны хүү Синахерибд ногдоно гэж түүхэн утга зохиолд үзсэн бий. Хотыг ундны цэвэр усаар хангахын тулд Синахериб зарлиг гаргаж уулнаас 20 метр өргөн, 50 километр урт, ёроолоор нь чулуун хавтангууд дэвссэн суваг татуулжээ. Суваг баригчдад хаан онцгой анхаарал тавьж сайтар хувцаслаж хоол ундаар гар татахгүй хангаж байсныг эрдэмтэд тэр үеэс хадгалагдан ирсэн түүхэн эх сурвалжаас олж тогтоожээ.

Ниневид нь 170 мянган хүн амтай том хот байв. Олон сайхан тэгш өргөн уужим гудамжтай хотын гол гудамж нь 26 метр өргөнтэй Хааны гэж нэрлэгдсэн гудамж байлаа. Чулуу дэвссэн

Хааны гудамжны хоёр талаар олон сайхан баримал байжээ.

Хуучныг судлаачид Ашшурбанипал хааны ордны малталт хийх явцдаа ордны 27 том гулдан хаалга, түүний хажууд байрлуулсан Ассирийг ивээн хамгаалагч далавчтай бух, арслангуудын баримлууд байгааг илрүүлжээ. Судлаач Г.Лэйярд хожим нь далан настайдаа туурвисан Перс, Месопотами орнуудаар хийсэн аялалын тухай номондоо “Хана бүрийн голд хүний толгойтой асар том бухуудаар хамгаалуулсан том орц байсан. 124 фут урт, 90 фут өргөн танхимын урт зузаан хананууд нь хойд, өмнө зүгүүд рүү харсан байна. Чухамдаа энэ танхимыг тойруулан бусад танхимыг бүлэг болгон байгуулжээ.” гэж онцлон дурджээ.

Ордны танхимуудын ханыг бүхэлд нь чамбай хийсэн товгор дүрсүүдээр чимсэн байжээ. Тэдгээр товгор дүрсүүд тэрчилэн орцны дэргэдэх асар том амьтдын баримлууд түймэрт өртөж сүйдсэн боловч өчүүхэн хэсэг нь хэвээр хадгалагдан иржээ.

Том танхим рүү хүргэх нарийхан хонгилоор явж 240\*19 футын харьцаатай тасалгаанд очно, Уг тасалгаанаас хоёр хонгил салаална. Баруун тийш харсан хонгилоор явахад урт нь 218 фут, 25 фут өргөн уужим цэлгэр танхимд хүрнэ.

Ордны дийлэнх хэсэг эвдэрч сүйдсэн байсан ч хуучныг судлаачид нэг шугамд байрлуулбал гурван километр орчим урт товгор дүрсүүд сийлсэн гөлтгөнөн хавтангууд байгааг олжээ. Эрдэмтэд чухамдаа эдгээр хэсэг зүйлүүдийг судалж ямархуу хосгүй тансаг ордон байсныг олж тогтоожээ. Асар том далавчит амьтангуудыг тээвэрлэхэд зориулсан барилгын элдэв хэрэгсэл ачсан тэргүүдийг түрж байгаа ажилчдыг Синахериб хаан удирдан чиглүүлж байгаа товгор дүрс байна. Өөр нэг товгор дүрсэнд чулуу бутлах газраас цул чулуу хэрхэн олборлож түүнийг уран баримал болгон хувиргаж байгаа уран барималчийн урланд тээвэрлэн аваачиж байгааг сийлжээ.

Чулуу бутлах газраас цул чулууг завиар тээвэрлэхдээ цул чулуунд хоёр нүх гаргаж түүгээр бүдүүн олс сүлбэн оруулж гурав дахь бүдүүн олсыг завинд холбоно. Бүдүүн олс бүрийг зуугаас илүү хүн чирж урагшилна. Бүдүүн олс бүрийг татдаг хүмүүс өмсөж байгаа хувцсаараа бие биенээсээ ялгагдана. Нэг хэсэг нь хөвөөтэй алчуур толгойдоо зүүж түүний завсраар урт үс нь унжина, нөгөө хэсэг нь оёмол ороолт толгойдоо зүүж үсээ хүзүүндээ баглан уядаг байжээ.

Ордны ойролцоо том танхимууд, хиймэл нууруудтай том цэцэрлэгт хүрээлэн байжээ. Синахериб хаан цэцэрлэгт хүрээлэндээ байлдан дагуулсан орнуудаас авчирсан ховор мод цэцэг ургуулж амьтан өсгөдөг байлаа. Тэнд мөн байгуулсан цөөрөмд хун зэрэг олон шувуу үржүүлдэг байжээ.

Библийн хөлгөн сударт Ниневи хотын тухай олон удаа дурдсан хийгээд эл хот нь улаан цус, дээрэм тонуул, худал хуурмаг, аллагын хот байсан учир хүнгүй эл хуль, цөл шиг хатаж хорчийсон хот болж мөхнө гэж зөгнөн бичсэн байлаа. Тэр ч бүү хэл Ашшурбанипал хааныг амьд байхад Мидийн Фраорт хааны цэрэг довтлон ирж Ниневи хотыг бүслэсэн ч хотын иргэд эрэлхэгээр хамгаалан тулалдаж халдан түрэмгийлэгчдийг элдэн хөөж байжээ.

Домогт өгүүлснээр Ниневи хотыг муу хувь тавилангаас зуун хоног дараалан мацаг барьсан

явдал нь аварчээ. Бүслэлтийн үед хаан зарлиг буулгаж “Хүн, мал, шар үхэр, хонь цөмөөрөө юу ч идэх ёсгүй, билчээрт гарахгүй, ус ууж болохгүй. Хүн бүр буруу замаас гарч хүчирхийлэл үйлдэхээс гараа цэвэрлэхийн төлөө Бурханд хандаж мөргө!” гэжээ. Бурхан тэдний сайн үйлсийг харж заналхийлж байсан аюулыг холдуулжээ.

Ашшурбанипал хааны ноёрхлын үед эзэмшил нутгууд дахь ард түмнүүд эсэргүүцэн тэмцэж байсан бөгөөд хааныг өөд болсны дараа Сири, Финики, Иуди, Египетэд ассирийн хаадын эсрэг бослого гаргажээ. Тэрчилэн Вавилон улс бүрэлдэхүүнээс нь гарч тус улсын амбан захирагч байсан Набопаласар Мидийн Киаксар хаантай холбоотнууд болох гэрээ байгуулжээ.

614 онд Мидийн Киаксар хаан Набопаласарын удирдсан вавилоны армитай хүч хавсран Ниневи хотыг бүслэж хотын иргэдийн хүчтэй эсэргүүцлийг давж хотыг эзлэв. Тэрбээр Хусур гол дээр барьсан даланг нурааснаар Тигр мөрний ус эргээсээ хальж хотын хэрмийн зарим хэсгийг хаман урсгаж мидичүүд хотод амархан нэвтэрчээ. Хотыг эзэмшилдээ авсан халдан түрэмгийлэгчид оршин суугчдыг нь толгой дараалан хядаж хааны ордныг тонож дараа нь бүх зүйлийг хуу дээрэмдэн Эктабаны хот руу илгээж хотыг газрын хөрстэй тэгшилжээ.

Францийн консул П:Э.Ботта Ассирийн эзэнт гүрний нийслэлийг хайж эхлэсэн ч бүтэлгүйтэж харин дөрвөн жилийн дараа эртний Месопотамийн хөндийд ирсэн францийн хуучныг судлаач Астон Генри Лэйярд Ниневи хотыг олж илрүүлж хүн төрөлхтөний өмнө их гавьяа байгуулжээ.

## БАВИЛОН

Багдад хотоос ерээд километр зайтай, дөрвөн том хайрган дов дээр эртний Вавилоны балгас оршино. Хоёр мөрний хоорондох энэ нутагт Семирамида хатан хааны унжмал цэцэрлэг, домогт өгүүлдгээр эмэг эх Ева модноос алим тасалж Адамын дур хүслийг өдөөж байсан диваажингийн төгөл байсан хүн төрөлхтөний соёл иргэншлийн нэгэн гал голомт байжээ.



Вавилон нь эртний ертөнцийн хүчирхэг, догшин улсын нийслэл хот болох хүртлээ олон гар дамжжээ. Вавилоны хаант улс манай эриний өмнөх 538 онд Персийн Их Кир хааны цэрэгт эзлэгдэх хүртэл оршин тогтнож байв. Түүнээс бараг хоёр зуун жилийн дараа Александр Македонский байлдан эзлэж нийслэл хотоо шилжүүлэн байрлуулах гэж бодсоноо больж түүний ойролцоо өөрийнхөө нэрээр нэрлэсэн хотын шавыг тавьжээ.

Вавилон хот аль хэдийнээ мөхсөн ч түүний сүрлэг балгас нь хүн төрөлхтөний бахархлыг төрүүлсээр байна. Эрт дээр үед нутгийн хүмүүс “Бабили” буюу “Бурхны хаалга” гэж нэрлэж байсан ч грекүүд Вавилон гэж өөрчилжээ. Гэхдээ иракчууд одоо ч “Бабилон” гэж дуудна.

Манай эриний өмнөх гурван мянган жилийн дунд үед Аккадын хаант улсыг захирч байсан Саргон хааны тухай домогт Вавилонхотын тухай анх дурдсан байдаг. Тэрбээр харьяанд нь байсан Вавилонд гарсан бослогыг зэвсгийн хүчээр нухчин дарсан тухай өгүүлсэн бий. Манай эриний өмнөх V зууны дунд үед түүхч Геродитийн бичиж үлдээснээр тус хот нь Евфрат мөрний хоёр эргийн дагуу өргөн, урт нь тус бүр 22 километр урт дөрвөлжин хэмжээтэй асар том талбайг эзлэн оршино. Тал бүрт нь 25 гулдан хаалга байх хийгээд хаалга бүрээс гудамж салаална. Байшингуудын хооронд цэцэрлэг, усан үзмийн талбай байгуулахад зориулж том зай гаргасан байна.

Геродитоос хойш 100-150 жилийн дараа амьдарч байсан тайлгач Бероз Вавилон хот, Ассирийн хаант улсын түүх, хаад, бурхдын тухай домгийн тухай томоохон бүтээл туурвисан нь алга болсон нь даан ч харамсалтай. Ромын эзэнт гүрний сүйрэлтэй зэрэгцэн Вавилон хот мөхөх үед тухайн цагийн бүх бичмэл түүхэн дурсгалууд оргүй алга болжээ. Вавилон хот түүхийнхээ 44 зууны хугацаанд түүхийн тавцнаас хоёр удаа зайлуулагдсан ч түүний балгас нь мөнхийн дурсгал болон үлджээ.



Вавилон хотын балгасыг хуучны судлаачид 1850-аад оноос ихээхэн сонирхож А.Г.Лэйярд, О.Рассам, Ж.Смит зэрэг эрдэмтэд түүнийг судалж нууцыг тайлах үйлсэд их хувь нэмэр оруулжээ. Балгас дотроос Нериглиссар, Левинет хаадын нэр бүхий тойпуу ялангуяа хоёрдугаар Навуходоносор хааны нэр бүхий илүү олон тойпуу гарчээ. Чухамдаа хоёрдугаар Навуходоносор хааны үед Вавилон хөгжлийнхөө оргилд хүрчээ. Евфрат мөрнөөр хөвж хотын хойд зүгээс зэс, мах, барилгын материал тээвэрлэн авчирдаг бол хойд зүг рүү хотоос улаан буудай, арвай, жимс ачсан жингийн цувуу хөвөрнө. Өмнөд Ази нутгаас хуримтлуулсан асар их эрдэнэсийг хотыг өргөжүүлэх түүний эргэн тойронд бат бэх бэхлэлт байгуулахад зарцуулжээ.

Берлиний музей 1899 онд эртний Вавилонд малталт хийхийг Роберт Кольдевейд зөвшөөрч германы хуучны судалгааны анги хотын тойргоор бараг 90 километр үргэлжилсэн хоёр эгнээ хэрмийг ухаж гаргажээ. Хэрмийн урт нь XIX зуунд хоёр сая гаруй хүн амтай байсан Лондон хотын тойргийн уртаас хоёр дахин илүү байв.

1900 оны эхээр германы судалгааны анги гурав дахь эгнээ хэрмийг илрүүлэв. Маш зузаан хэрэм дээр хотын хамгаалалтын цэргийн ангийн хуаранг байрлуулсан байв. Эдгээр гурван хэрмийг барихад ашигласан тойпууг зэрэгцүүлэн өрвөл дэлхийн бөмбөрцгийг дунд бүслүүрээр нь 12-15 удаа тойрохоор тийм урт юм.

Хоёрдугаар Навуходоносор хаан нийслэлээ халдашгүй дархан цайз болгон хувиргаж чулуунд дараах үгсийг сийлжээ :

“Би Вавилон хотыг дорно зүгээс нь хүчит хэрмээр хүрээлж түлсэн тойпуугаар гадарласан хэрмийн дагуу гуу жалга ухаж хиймэл нуур бий болгосон. Гуу жалгын ёроолоос өндөр хана босгож хуш модоор гулдан хаалга хийж зэсэн ялтсаар бүрлээ. Би ийнхүү Вавилон хотыг дийлдэшгүй цайз болгон хувиргаж чадлаа!”

Р.Кольдевейн судалгааны анги малталтынхаа явцад “Үхлийн зам” буюу “Мардук бурхны ёслолын зам”-ыг нээж нүдээ орой дээрээ гартал гайхан алмайрч байжээ. Энэ зам нь Евфрат мөрний эргээс Төв гулдан хаалгаар дайрч хотын гол сүм болох Мардук бурханд зориулсан Эсагиле сүм хүртэл үргэлжлэх ажээ. 24 метр өргөн энэ зам нь гайхам тэгшхэн ажээ. Замын голоор том чулуун хавтангууд суулгаж захаар нь улаан тойпуугаар эмжээрлэжээ. Хавтан бүрийн дотор талд “Вавилоны Навуходоносор хаан би, Вавилоны мөргөлчдийн замыг их эзэн Мардукийг хүндэтгэн дээдэлж чулуун хавтангаар бүрлээ. ... Аугаа Мардук! Танд мөнхийн амьдрал бэлэглэе!” гэж сийлэн бичсэн байна.

Роберт Кольдевей Вавилонд “Семирамида хатан хааны унжмал цэцэрлэг”-ийг малтан гаргажээ. Уг цэцэрлэгийг хоёрдугаар Навуходоносор хааны зарлигаар төрөлх нутгийнхаа нов ногоон дов толгодыг санан дурсаж сэтгэл гунихарч байгаа Мидийн хаант улсын хааны гүнж, хайртай Амитис хатандаа зориулан байгуулжээ. Халуу төөнөсөн Вавилонд ховор мод, анхилам үнэртэй цэцэг бүхий сэрүүн цэцэрлэг байгуулсан нь үнэхээр гайхамшиг байлаа.

Вавилон нь буурал түүхийнхээ хугацаанд олон удаа түрэмгийлэн эзлэгчдийн хөлд үрэгдэж байсан ч ассирчууд гээд ямар ч дайсанд буу өгч байгаагүй ажээ. Р.Колдевейн судалгааны анги малталтын явцад хэд хэдэн хот суурингийн балгас илрүүлсний дотор хоёрдугаар Навуходоносор хаанаас мянган жилийн өмнө барьсан Вавилоны алдарт Хаммурипа хааны

өргөө байв.

Библийн судрын Хуучин Гэрээнд эртний Вавилон хотыг Израильтай холбогдуулан хэд хэдэн удаа дурдсан байдаг. Зөнч Даниил мөхлийг нь урьдчилан зөгнөсөн дөрвөн эзэнт гүрний нэг нь Вавилон байв. Э.Церен “Библийн довууд” номондоо Вавилон бол зөвхөн мансуурал, цэнгэл, гэм нүгэлийн төдийгүй шашны гүн сүсэг бишрэлтэй хот байжээ. Малталтаар гарсан нэгэн бичээс дээр хотод их бурхдын 53 сүм, 300 газрын шүтээн, 55 тэнгэрийн бурхад байсан, зөвхөн Мардук бурханд зориулсан 55 шүтээн байсан тухай өгүүлсэн бий.

Эсаниле сүмийн ойролцоо хашаанд нь алдарт Вавилоны цамхаг орших Этеменанки дүүрэг байжээ. Зиккурат буюу орой дээр нь “бурхан тэнгэрээс бууж ирсэн” шүтээн байрлуулсан том шаталсан юм уу цамхагт сүм Шумер, Аккакадын вант улсын аль ч хотод байжээ. Гэхдээ Библийн сударт дурдсан тэр цамхаг Хаммурапи хааны ноёрхлоос өмнө сүйдсэн байв. Түүний оронд өөр шинэ цамхаг босгохдоо түрүүчийн цамхагийн дурсгал болгожээ.

Эртний Грекийн эрдэмтэн Геродит нь Вавилоны цамхагийн талаар бичсэн европ тивийн анхны хүн болжээ. “Хотын хэсэг бүрийн төвд байшин байна. Тэр нь өндөр хэрмээр хүрээлүүлсэн хааны ордон, зэсэн хаалгатай Зэвс бурхны сүм байх жишээтэй. Сүмийн талбай нь тэгш дөрвөлжин хэлбэртэй, талбайн төвд том цамхаг байх бөгөөд зэрэгцэн орших цамхагийн нийт тоо нь найм байна. Эдгээр цамхагийг тойруулан шат хийжээ. Хамгийн сүүлчийн цамхагийн дээр гоё зассан өргөн ор, дэргэд нь алтаар бүрсэн тахилын ширээ бүхий сүм байна. Энэ хавьд бурхны зураг ер байхгүй. Зөнчдийн хэлдгээр орон нутгийн бүсгүйчүүдээс бурхны сонгосон ганц эмэгтэй л энэ сүмд шөнө бүр хонодогоос өөр хүн энд ирдэггүй, харин бурхан сүмд хааяа ирж өнөөх ор дээр унтаж шөнийг өнгөрөөдөг байна.” гэж Геродот ихэд дэлгэрэнгүй бичсэн бий.

Хүмүүст хилэгнэсэн Бурхан олон ард түмний хэлүүдийг хооронд хольсноор тэд бие биентэйгээ ойлголцохоо больжээ. Бурхан бас вавилончуудыг дэлхий даяар тараан суулгажээ.

Вавилоны цамхагийг эзлэн түрэмгийлэгчид олонтаа сүйтгэж байсан ч түүнийг тухай бүр шинэчлэн янзлан сэргээж байжээ. Тухайлбал Персийн Их Кир хаан хотыг эзлээд цамхагийн гайхамшигийг биширч түүнд гар хүрэхийг хориглосноор барахгүй өөрийн шарил дээр жижиг хэмжээний яг адилхан цамхаг босгох зарлиг буулгаж байжээ. Гэвч энэхүү алдарт цамхаг он цагийн уртад нурж эвдэрсэн билээ. Александр Македонский Энэтхэг орох зам зуур Вавилон хотод буудаллахад Персийн Ксеркс хаан цамхагийг балгас болгосонтой таарч байв. Суут цэргийн жанжин балгас болгосон цамхагийг өмнө харуусан зогсож, түүнийг 10 мянган хүн дайчлан ажиллуулж дахин сэргээх ам тангараг тавьжээ. Гэвч удалгүй өвчин тусан өөд болж өгсөн амлалтаа биелүүлж чадаагүй юм.

Персийн Их Кир хааны цэргийн жанжин Гобрий Вавилон хотыг зарим иргэдийн урвалтыг далимдуулан эзлэжээ. Хот эзлэгдсэн ч хоёрдугаар Навуходоносор хааны бариулсан хэрэм бат бэх хэвээр байжээ.

## ИЕРИХОН

Иерихон хот нь арваад мянган жилийн түүхтэй билээ. Далайн түвшнээс дор орших хот элсэн далайн дундах далдуу модны төгөл, жимсний цэцэрлэг бүхий баян бүрд ажээ. Цаг агаарын байдал дулаан болохоор гуравдугаар сард нимбэг, амтат жүрж, гүйлс цэцэглэж өргөст хэмх, ший гуа ид ургаж байна.

Иерохин хотын тухай Хуучин Гэрээнд хэдэнтээ дурдсанаас Мойсей Моавитийн хөндийг туулж уул дээр гарахад Иерихон хот нүдний нь өмнө тодорчээ. Израильчууд дайлаар мордож Ханаанын нутагт хөл тавихдаа хамгийн түрүүнд довлон эзлэсэн хот нь Иерихон байснаараа их алдаршжээ. Нэрт түүхч Эрих Церен “Библийн довууд” номондоо “хэдэн мянган жилийн түүхэндээ, хүн төрөлхтөний буурал түүхийнхээ бүхий л хугацаанд амссан бүслэлтүүдээс Иерихон хотын бүслэлт юутай ч зүйрлэшгүй аймшигтай байсан юм. Домогт итгэвэл бурхад хүртэл байлдан дагуулагчдыг нь ивээж байжээ.” гэж онцлон тэмдэглэсэн байна. Чухам тийм учраас Иерихон хотын хамгаалалтын хэрэм л гэхэд хуучныг судлаачдын анхаарлыг гойд татдаг.

Иерихон хотын балгасыг анх англичууд ихэд сонирхож 1868 оноос малталт хийж эхлэсэн ч үр дүн нь тааруу байсан тул ажлаа зогсоожээ. Гучин жилийн дараа профессор Э.Зеллиний удирдсан германы судлаачид ирж 1908 онд малталт хийж эхлэмэгцээ хотын хуучны хэрмийг олов. Тэгээд тэрхүү хосгүй байгууламжийг нягтлан судалж нурж болзошгүй эмзэг газрыг олохыг чармайж байлаа.

Хэрмийн гадна тойргийн хананы зузаан нь ойролцоогоор бүтэн хагас метр, дотоод тойргийн хананы зузаан нь бараг 3,5 метр хийгээд хоорондох зай нь 3-4 метр хүрч байлаа. Энэ гайхамшигт байгууламж цаг нь болохоор нурж унасан хийгээд гадна тойргийн хананы дийлэнх хэсэг нь гадагшаа, дотоод хананы хэсэг нь дотогшоо хазайн газар унажээ. Үхлийн тэнгисийн ойролцоо Иорданы хөндийд болсон газар хөдлөлтөөс болж хэрэм нуржээ гэж орчин үеийн эрдэмтэд үзэж байна.

Библийн сударт Иерихон хотыг газар хөдлөлтийн дараа сэргээн босгож Вениаминд шилжүүлэн өгсөн ч Моава улсын Еглон хаан байлдан эзлэсэн тухай өгүүлсэн бий. Тэр үеэс хот “далдуу модны хот” гэж нэрлэгдэх болжээ. Дараа нь тэнд хотын байрлал зохимжтой ч ус муу гэж мэдэгдсэн “зөнчдийн хөвгүүд” ирж сууршин суужээ. Тэгээд зөнч Елисей анхны гайхамшигаа бүтээж усанд давс цацан хаяхад ус цэвэршиж тунгалаг цэнгэг болжээ.

Ромын эзэнт гүрний Антоний хаан хайртай бүсгүй, Египетийн хатан хаан Клеопатрад далдуу модны төгөл бэлэглэх хүртэл тэр тухай бараг мэддэггүй байв. Клеопатра хатан хаан дараа нь далдуу модны төглийг Их Иродад шилжүүлэн өгөхөд Их Ирод тэнд ордон босгожээ.

Иерихон хот палестиний уулс хүрэх олон замын уулзвар дээр, газар зүйн маш ашигтай байрлалд оршино. Шашны томоохон баяр ёслолын үед Иордан голоос зүүн талд орших олон орноос Иерусалим руу хөвөрдөг мөргөлчид хотоор дайрна. Есус Христос ч ариун хот руу анхны удаа очихдоо Назаретаас гарч Иерихон хотод буудаллаж байв. Тэрбээр хотод ойртон ирэх үедээ замын хажууд сууж гуйлга гуйж суусан төрөлхийн сохор хүнд хараа оруулсан

билээ.

Өнөөгийн Иерихон хотын захын талбайгаас холгүйхэн орших 20 метр өндөр дов дээр хорьдугаар зууны эхээр дэлхийн эртний хотуудын нэг болох Иерихон хотоос үлдсэн бүхнийг малталт хийж гаргасан юм. Малталт хийсэн нутаг дэвсгэр дээр байгаа газарт гүн суусан том цамхагийн үлдэгдэл эрдэмтдийн анхаарлыг ихээхэн татаж байдаг. Хотын балгасаас хойд зүгт Омейяд угсааны Хишам ибн Аль-Малик халифийн ордон байжээ. Малталтаар VIII зуунд боссон тэр ордны цогцолбороос хэд хэдэн лалын шашны сүм, халуун усны газрын үлдэлдэл илэрчээ. Хишам халифийн ордноос жуулчдын сонирхдог гол зүйл нь шигтгэмэл зургуудын хэсэг юм. Тухайлбал нэгэн шигтгэмэл зурагт алтан жимс сагсагзуулсан “амьдралын мод”, сүүлтэй гөрөөс хөөж байгаа арсланг дүрсэлсэн байна.

Орчин үеийн Иерихон хотын баруун захад 380 метр өндөр “Дөчин хоногийн уул” буюу “Дур хүслийн уул” оршино. Домогт өгүүлснээр Есус Христос чөтгөрөөс үүдсэн дур хүслээ дарах гэж энэ уул дээр дөчин өдөр дөчин шөнө мацаг барин суусан ажээ. Одоо уулын орой дээр Византийн үеийн сүмийн нуранги бий.

Уул хүрэх зам зуур зөнч Елисейн худаг байх хийгээд тэр булгийн эргэн тойрны нуранги нь Иордан голоос 5 бээрийн зайтай байгаа эртний хотын байрлалыг илэрхийлнэ.

## СПАРТА

Лакони нутаг дахь Спарта хотын алдар сууг дэлхий даяар мэднэ. Эртний Грекийн хамгийн нэртэй хот-улсын нэг болох Спарта нь ямар нэгэн үймээн самуун үзээгүй, ямар ч дайсны өмнө хэзээ ч өвдөг сөхөрч байсангүй.



Манай мянганаас бүтэн хагас мянганы өмнө Лаконийг захирч байсан Лакедемон хотыг үндэслэж хатныхаа нэрийг өгчээ. Хот байгуулагдсан анхны зуунд харгис хаан Навиз хотыг тойруулан хэрэм босгосон нь нурсан ч Аппий Клавдий төдөлгүй шинэ хэрэм барьжээ.

Манай эриний өмнөх VII зууны эхний хагаст амьдарч байсан хууль тогтоогч Ликургийг Спарта хот-улсыг үндэслэгч гэж эртний грекүүд үздэг байлаа. Хотын хүн ам спартчууд, периэк, илот гэсэн гурван бүлэгт хуваагддаг байснаас спартчууд хот-улсын иргэдийн эрх ямбыг эдэлж хуулийн бүх шаардлагыг биелүүлэх үүрэгтэй байсан бөгөөд олон нийтийн хүндэт албан тушаалд томилогддог байв. Спартчууд газар тариалан, гар урлал эрхлэхийг таашаадаггүй ч тэдэнд хориглодоггүй байв.

Лаконийн газар нутгийн дийлэнх хэсгийг илотууд эзэмшиж тариа тарина. Спартчууд газар эзэмшихийн тулд, өндөр сахилгатай байх, орлогынхоо тодорхой хэсгийг тухайлбал арвайн гурил, дарс, бяслаг нийтийн хэрэгцээнд өгөх гэсэн хоёр шаардлагыг биелүүлнэ. Ангийн шувууг төрийн мэдлийн ойд агнана. Тавьсан болзлуудыг зөрчих юм уу үл биелүүлбэл иргэний эрхийг нь цуцална.

Периэкүүд нь чөлөөт иргэд ч Спарта хотын бүрэн эрхт оршин суугчид биш ажээ. Периэкүүд нь дан спартчууд оршин суудаг Спартаас бусад хотод сууна.

Илотууд нь Лаконийн хөдөөгийн хүн ам бөгөөд спартчууд, периэкүүдийн эзэмшлийн газар дээр тариа, хүнсний ногоо тариалдаг боолчууд байжээ. Тэд хотод оршин сууна, хувийн байшин эзэмшиж эхнэр хүүхдүүдтэй байж болно, гэхдээ илотуудыг эзэмшил нутгаас нь гадуур худалдахыг хориглоно. Ликургийн боловсруулсан тогтоолын дагуу жил бүр залуу спартчууд кинжаал хутгаар зэвсэглэн Лаконийн нутгаар явж төрд аюулд учруулж байна гэж үзэж байгаа боол илот иргэдийг устгадаг байжээ.

Грек, ромын суут хүмүүсийн намтар, үйл ажиллагааны тухай бүтээлээрээ алдаршсан Плутарх Ликургийн амьдрал, хуулиудын тухай бичихдээ яг таг бодитой зүйл өгүүлж чадахгүй гэж урьдчилан сануулахдаа, түүхэн улс төрийн зүтгэлтэн байсан нь бодитой үнэн гэж нотолсон байдаг. Германы нэрт түүхч К.О.Мюллер домогт Ликург гэж хүн байгаагүй, түүний боловсруулсан хууль тогтоомж гэдэг нь спартчуудын өдөр тутмын амьдралыг зохицуулж байсан эртний ёс заншил гэсэн таамаглалыг 1820-иод оны үед дэвшүүлж байлаа.

Английн хуучны судлалын анги 1906-1910 онуудад Спарта хотод хамгийн эртний сүм болох Артемида Орфия сүмийн балгасанд малталт хийж зургаар чимэглэсэн вааран эдлэл, терракотовын ховор баг, хүрэл, алт, хув, зааны ясаар хийсэн гоёлын зүйл гээд уран сайхны маш олон бүтээл илрүүлжээ. Эдгээр олдвор нь спартчуудын хатуу ширүүн аж төрөх ёс, Спарта нь бусад улс, хотоос тусгаарлагдмал байдалтай байсан тухай тогтсон ойлголтыг эвдсэн юм.

Боол илотууд байсхийгээд л бослого гаргаж хот-улсад байдал түгшүүртэй болсон үед “шинэчлэлтийг санаачлагчид” ямар нэгэн баатар юм уу бурхныг бишрэн шүтэх үзлийг дэлгэрүүлэх шаардлагатай болоход Ликургийг сонгосон нь анхандаа бурхан байснаа хууль тогтоогч болон хувирсан бололтой.

Ликург харгис хэрцгий, үргэлж үймээн самуун өдөөгч ард түмнийг номхруулж журамтай хүмүүс болгох, хамгийн гол нь хөрш орнуудын дайралтыг сөрөн зогсох чадвартай байхын тулд спартчуудыг чадварлаг дайчид болгохоор зорьжээ. Тэрбээр шинэтгэлийн анхны алхам болгож олон түмний хурлаас сонгогдсон болон нэг нь дайны үед арми удирдах үүрэг хүлээсэн хоёр хаан гээд нийт 28 хүнээс бүрдсэн Ахмадуудын зөвлөлийг байгуулжээ.

Манай эриний өмнөх VI зуун Спарта хот-улсын түүхэнд аугаа их бүтээн байгуулалтын жилүүд байв. Тэр үед Меднодомна Афина эм бурхны сүм, Скиадын тагттай саравч, “Аполлоны хаан суудал” гэх зэрэг цуутай барилга байгууламжийг барьжээ.

VI зууны хоёрдугаар хагаст спартчууд олимпийн наадмыг ойшоож үзэхээ болив. Урьд нь олимпийн тоглолтод хамгийн идэвхтэй оролцдог, спортын гол төрлүүдэд түрүүлэгчдийн талаас илүү хувийг эзэлдэг байсан бол манай эриний өмнөх 548-480 онуудад болсон олимпийн наадамд Спарта хотын тамирчдаас Демарат хаан л ганцхан морин тойруулгад болдог морины уралдаанд тэргүүлжээ.

Ликург зөвшилцөл, энх амгалан тогтоохын тулд баялаг, ядуурлыг хот-улсаа эгнэгт устгахаар шийдэж Грек орон даяар хэрэглэж байсан алтан мөнгөн зоосыг халж оронд нь төмөр зоос гүйлгээнд гаргажээ. Төмөр зоосоор зөвхөн Спарта хот-улсад хийсэн бүтээгдэхүүнийг худалдан авч болдог байв.

Ликург гэр бүлийн амьдралын шинэ дэглэм гаргаж хотын бүх оршин суугч жирийн иргэнээс авхуулаад хаан хүртэл ижил нөхцөлд амьдрах хэрэгтэй гэж айлдаж, тусгай журам боловсруулж ямар байшин барих, ямар хувцас өмсөх шаардлагатайг зааж хувцас ямагт энгийн байх ёстой гэж хатуу анхааруулжээ.

Ийнхүү иргэд баялаг, хувийн өмчийг тоохоо больж нийтийн өмчийг арвижуулахыг эрмэлзэнэ.

Баян ч ядуу ч хүнгүй болсон хотод хүмүүс бие биендээ атаархах өрсөлдөх шунах явдал үгүй болжээ.

Спарта хот-улсад хүүхэд хүмүүжүүлэх нь иргэн бүрийн гол үүргийн нэг гэж үзэж гурван хүүтэй эцгийг харуулын алба гүйцэтгэхээс, таван хүүтэй эцгийг нийгэмд гүйцэтгэх бүх үүргээс түүний дотор татвар төлөх үүргээс бүрэн чөлөөлдөг байв.

Хүүхдийг 7 нас хүрмэгц нь эцэг, эхээс нь тусгаарлаж агела нэртэй тусгай бүлгүүдэд тусгайлан сонгосон хянагчдын хараа хяналт дор уншиж бичиж сургаж удтал дуугүй сууж, товч тодорхой ярьж дасгана. Хүүхдүүд гимнастикийн болон спортын дасгалууд хийж авхаалж самбаагаа төгөлдөржүүлж хүч бяр сууна, нийтийн бүжиг хийж сурч биеэ ихэмсэг даруу авч явдаг болно, ойд ан хийж хатуу сорилт ирэхэд тэсэн давах дадлага эзэмшинэ.

Хүүхдийг 16 нас хүрэх үед нь, Артемида эм бурхны шүтээний дэргэд саваагаар занчиж сорилт хийж зодолтыг таг дуугүй тэсвэрлэхийг шаардана.

Плутарх, Ксенофонт нар нотлон бичсэнээр Ликург бүх эмэгтэйчүүд эрүүл саруул, тэнхээ тамиртай хүүхэд төрүүлэхийн тулд эрэгтэйчүүд шиг дасгал сургууль хийх ёстой гэсэн журам гаргаснаар Спарта хот-улсын эмэгтэйчүүд хатуу бэрхийг давж сурчээ. Хүү нь дайнд алагдсан тухай дуулсан эх тулалдааны талбарт очиж хүүгээ хаашаа харж амь эрсэдсэнийг үзнэ. Хүү нь цээжиндээ үхлийн шарх авч алагдсан бол эргэн тойронд байгаа хүмүүс рүү бардам харж ёслол төгөлдөр оршуулна. Хэрэвзээ хүү нь нуруундаа шархдаж үхсэн бол эх нь ичиж зовсондоо уйлж тулалдааны талбараас зугтааж хүүгийнх нь шарилыг анд нөхөд нь оршуулдаг байжээ.

Спарта хот-улсад гэр бүл болох нь хувийн биш төрийн хэрэг байлаа. Бие бялдрын өндөр хөгжилтэй эр эм залуус л хоорондоо гэрлэх эрх эдэлнэ. Гэхдээ нөхрүүд нь хатуу дэгээр амьдарч байхад эмэгтэйчүүд нь гэртээ тансаг байдалд умбан байдаг байв. Тийнхүү эрх чөлөөтэй суудаг эмэгтэйчүүд дур зоргоороо аашилж эрчүүдийг уруу татаж цагийг өнгөрөөнө.

Гарган мөрдүүлж байгаа хууль тогтоомжоо гаднын нөлөөнөөс хамгаалахын тулд Ликург хот-улсын иргэдийг гадаадын иргэдтэй харьцахыг хязгаарлажээ. Онцгой тохиолдлоос бусад үед хотоос гарахыг хориглоно.

Чанд хатуу дэг журмаар амьдарч байсан Спарта хот-улсын ард түмэн аз жаргалгүй, уйтгартай байсан байх гэсэн бодол төрж магадгүй. Гэвч эртний грекийн зохиогчдын бүтээлээс үзэхэд сайн үйлс хийхийн төлөө өрсөлдөөн ноёрхож байсан тул эртний ертөнцийн хамгийн журамтай ард олон байжээ.

Спарта хот-улсын ард түмэн Ликургийн хууль тогтоомжийг баримталж алт мөнгөнд шунахгүй бол хүчирхэг улс хэвээр байх болно үзэж байлаа. Гэвч афинчуудтай хийсэн дайны дараа спартчууд мөнгө зоос авчирснаас мөнгө хөрөнгөнд шунах явдал газар авсаар нэг мэдэхэд хүчирхэг хүчин чадал, өндөр ёс суртахуун нь алга болсон байлаа.

## УР

Ирак улсын нутаг дэвсгэрийн Тигр, Евфрат мөрөн хоёр талаас нь тэвэрч байгаа мэт санагдах тэр хэсэгт очсон хүмүүст тэнд 5-6 мянган жилийн тэртээ хүн ам ихтэй, дэлхийн хамгийн соёлжсон улс байсныг огт тааварладаггүй. Өнөөдөр энэ нутагт бүртийх ч үүлгүй тэнгэрээс нар хайргүй төөнөж бороо хааяа л орно.



Чухамдаа хорвоогийн бөглүү энэ нутагт аугаа их соёл иргэншлийн гал голомт бадарч хамгийн эртний соёл үүсэж шинжлэх ухаанд мэдэгдэж байгаа хамгийн эртний улс оршин тогтнож байжээ. Яхве бурхан сонгож “гэрээ” байгуулж байсан, еврей, арабын ард түмнүүдийг үндэслэгч болох Авраам Урт сууж байжээ. Бурхан Авраамыг Өмнөд Месопотами нутагт дуудан ирүүлж “Чи төрөлх нутаг, эцгийнхээ гэрээс явж миний заах нутагт очиж суу.” гэжээ.

Өнөө үед эл хуль, үржил шимгүй нутагт байгаа довуудыг арабчууд хамгийн өндөр довоор нь “аль-Муккайр” буюу “Давирхайн дов” гэж нэрлэнэ. Баср дахь Английн консул Д.Е.Тейлор 1854 онд Месопотамийн зарим нутагт аялал хийж явахдаа “Давирхайн дов”-ын дор Ур хотын балгас байгаа гэж тодорхойлжээ.

Д.Е.Тейлор сүмийн цамхагийн нуранги дотроос Вавилоны Набонид хааны нэр бүхий бичээс бүхий хэд хэдэн бортого олсон ч тайлж уншиж чадаагүй байна. Гэвч түүний олдворыг хэн ч сонирхсонгүй. Дараа нь XIX зууны сүүлчээр АНУ-ын Пенсильваний их сургуулийн судалгааны анги туршилтын малталт хийсэн ч үр дүнг нь огт нийтлээгүй байна.

Дэлхийн нэгдүгээр дайны дараа Пенсильваний их сургууль Британий музейд хандаж хуучныг судлаач Л.Вуллийн удирдлага дор хамтарсан малталт хийх хүсэлт гаргаснаар 1922 оноос Давирхайн довын орчим хамтарсан судалгаа хийж эхлэжээ. Арван жил малталт хийсний дараа цуглуулсан материалаа боловсруулан хэвлүүлэх зорилгоор ажлаа түр зогсоожээ.

Хуучныг судлаачид Ур хотын балгаст малталт хийж Шумерийн эзэнт гүрний үеэс Персийн аугаа хаад хүртэлх хоёр мянга гаруй жилийн хугацаанд байшин барилга барьж байсан сүмийн талбайг ил гаргажээ. Сүм хийдийг эрт дээр үед тоносон байсан ч үлдсэн зүйлсийг нь үндэслэж эрдэмтэд нилээд зүйлийг мэдэж авчээ. Тухайлбал сүм дуганы модон хаалгуудыг алтан хялтсаар доторлосон, ханыг алтан од, хадаас, нарны туяаны зургаар чимэглэсэн



байсныг олж тогтоожээ.

Ур дахь хамгийн сүрлэг байгууламжуудыг манай эриний өмнөх Ш, П мянганы зааг дээр, гуравдугаар угсааны хаадын үед барьжээ. Хотын төв талбайд Месопотамийн бусад хотын адил зиккурат буюу дээр нь хотыг ивээгч Сарны хүчирхэг Нанна бурхны баримал залсан том олон шатлалтай цамхаг байсан нь хотын хамгийн гоёмсог байгууламж гэж тооцогдож байжээ. “Бурхны уул” гэж нэрлэгдэж байсан цамхаг алс холоос харагдана. Байшингийн шав тавихад газарт булдаг олон шавар шовгор дүрс зиккуратын хананаас гарчээ.

Ур хотын орон сууцны байшингууд тухайн цагийн байдлаар зэгсэн тохилог байв. Байшингийн суурь, хананы доод хэсгийг борооны уснаас хамгаалж шатаасан тоосго, дээд хэсгийг түүхий тоосго өрж хийдэг байжээ. Зарим дүүрэгт нь хоёр давхар байшингууд байсан хийгээд доод давхарт нь хашаанаас гадна ёслолын үүдний өрөө, дээд давхарт нь шүтээн бас гэр бүлийн бунхан мэдээж хэрэг гэрийн эздийн суудаг өрөөүүд байна.

Хотын хүн амын дийлэнх нь уран дархчууд, арьс шир элдэгчид, загасчид, манаач, тайлгач нар байв. Хотын хөдөө аж ахуй эрхэлдэг иргэд нь хот дотор сууна.

Профессор Л.Виллийн удирдсан судалгааны анги Ур хотын сүм, дуган олноор оршдог оршуулгын том талбайд малталт хийв. Асар их үнэт эдлэл, урлагийн хосгүй нандин бүтээл бүхий бунхнуудыг хуу тоносон байсан ч хуучныг судлаачид тонуулчны гар хүрээгүй хоёр бунхан олжээ.

Бунхны үүдэнд зэсэн илд барьсан, зэсэн дуулга өмссөн цэргүүд номхон зогсоно. 10 метр орчим гүнтэй том нүхний буланд чулуун авс дотор нас барсан эзний шарилыг байрлуулжээ. Түүний дэргэд авс дотор хийхээс өмнө амийг нь хороосон хэд хэдэн ойр дотнын хүнийх нь шарил бас байна. Уужим том бунхны налуу ханаар эзэнтэйгээ хамт диваажинд очихоор сайн дураар шийдсэн, оршуулгын ёслолыг удирдагч-тайлгач, дүрэмт хувцастай цэргийн дарга нар, гоё хувцас, үнэт чулуугаар чимэглэсэн малгай өмссөн хааны олон хатан, зарц хөгжимчид, боолууд доош бууна. Оршуулгын ёслолд оролцогчид зэрэгцэн зогсож бие биендээ диваажинд очиж аз жаргалтай байхыг хүсэн ерөөсний дараа хортой ундаатай аяга дамжуулан ууж мөнхийн нойрондоо заларна.

Ур хот дахь хаадын бунхнуудаас маш олон үнэт зүйлс гарснаас “битүү шугуй дахь алтан ямаа”, “хааны туг”, “Мескаламдугийн дуулга, Пу-абийн малгай, дайтаж байгаа хүмүүсийн дүрс бүхий тамгуудыг онцлон дурдаж болно. Тэрчилэн хоёр эвэртэй амьтны дээгүүр хөвж байгаа арслан толгойтой бүргэд, ариун модны дэргэд зогсож байгаа хоёр бух, хойд хоёр савар дээрээ зогсож урд хоёр савраараа зөрүүлэн тэмцэлдэж байгаа арслан, бухын дүрс зэрэг амьтдын шигтгэмэл дүрслэлүүдээр чимэглэсэн трапец хэлбэрийн босоо ятга хөгжим байв. Эртний Ур хотод хэрхэн бухын харьцуулалт бий болсныг эрдэмтэд одоо хүртэл тайлбарлаж чадахгүй байна. Тэр бол зөвхөн бухын дүрс төдий биш байсан нь ойлгомжтой.

Хаадын бунхнаас манай эриний гуравдугаар мянганы үед хамаарах дөрвөн дугуйтай модон сүйх тэрэг олджээ. Сүйх тэрэгний дугуй, бүхээгний өнцгүүдэд мөнгөн болон лазурит урт сондор шигтгэж бухын дүрс бүхий мөнгөн бөгж, сахиусаар чимэглэсэн байлаа.

Өнгөрсөн олон мянган жилийн хугацаанд мод ялзарсан ч бунхан дотор яг хэвээрээ байсан учир эрдэмтэд сүйх тэргийг яг байсан байдлаар нь сэргээж чаджээ. Сүйх тэрэг бүрт хөллөж байсан гурван бухын араг яс бас хадгалагдан ирсэн байна. Бухуудын толгойнуудын өмнө жолооноос нь барьж байсан хөтөч нарынх нь араг яс байв. Сүйт тэргүүдийн дотор хэдэн мянган жилийн тэртээ жолоо барьсан чигээрээ өөд болсон эмэгтэй хөтөч нарын араг яс мөн байжээ.

## ДАМАСК

Дамаск хотын мянга гаруй жилийн настай сүм, ордон, орчин үеийн шинэ гудамж, талбай, шилэн хорго, зарлалын самбарын өнгөний хослолыг гаргаж чадах зураач хорвоод үгүй биз ээ.



Үлэмж сайхан хотын тухай арабын олон ном, домог бий. Хот шар элсээр хүрээлүүлсэн маргад эрдэнэ шиг гайхамшигтай сайхан харагдахад зөнч Мухаммед диваажин ч ийм сайхан харагдахгүй байх гэж айж эмээж байсан тухай домог бий.

Бүхий л амьдралынхаа хугацаанд хуурай газар, далай тэнгисээр 120 мянган километр зам туулсан дундад зууны үеийн алдарт аялагч Ибн Баттута Сирийн нутагт ирж Дамаск хотыг хараад “Дорнын диваажин!” гэж уулга алдаж байв.

Сири улсын нийслэл Дамаск хот нь зургаан мянга орчим жилийн түүхтэй, дэлхийн эртний хотуудын нэг мөнөөс мөн билээ. Хотоос холгүйхэн орших Бейт-Лахья тосгонд хүн төрөлхтөний эмэг эх Ева амьдран сууж байсан тухай домог бий. Евагийн хүү, хорвоо дээрх анхны аллагын золиос болон амь алдсан Авелийг оршуулсан уулыг зааж чулуун зам дээр дуссан түүний цусны дуслуудыг аялагч, жуулчдад үзүүлдэг байна.

Дамаск хотын тухай тоймгүй олон домог яриа байдаг ч бодит түүх нь адал явдалт романыг санагдуулна. Өнөөгийн хотын буурин дээр манай эриний өмнөх IV зуунд суурин байсныг хуучны судлалын малталтаар тогтоожээ. Манай эриний өмнөх XVI зуунд Анатоли, Сирийн хойд нутагт амьдарч байсан хетты омгийнхон уг сууринд хүрч төрөлх хэлээрээ Дамашиа гэж нэрлэжээ. Бүтэн хагас зууны дараа Египетийн гуравдугаар Тутмос фараон хотыг эзэлж өнөөгийн нэрийг өгчээ.

Манай эриний өмнөх X зууны Дамаск арамейскийн олон хүчирхэг вант улсуудын нэгний нийслэл болсон ч манай эриний 732 онд ассиричуудад эзлэгджээ. VI зууны дунд үеэс Персийн Ахеменид угсааны хаадын мэдэлд оржээ. Суут жанжин Александр Македонский Азид довтлон ирж Дамаск хотыг гартаа оруулж мянган жил үргэлжилсэн түүхийн эхлэлийг нь тавьжээ. Дорнын хот “нүүр царайгаа өрнө зүг хандуулж” бүтэн арван зууны турш хувь заяагаа өрнөдийн соёл иргэншилтэй холбожээ.

Дамаск хот руу довтолж байсан байлдан дагуулагчдын нэрсийг товчхон дурдахад л тус хотын амссан зовлон гасланг ойлгож өрөвдөх сэтгэл өөрийн эрхгүй төрнө. Помпей хааны цэрэг 66 онд эзлэсний дараа хот Ромын эзэнт гүрний бүрэлдэхүүнд орсон нь хөгжил цэцэглэлтийн нь эхлэл болжээ. Худалдаа арилжаа идэвхжиж сүм, ордон, театр, халуун усны газар баригдаж ром маягийн урт тэгш гудамжууд бий болжээ. Хотыг хуучин хэрмийн дотор нь өмнөд, хойд хэсэгт хуваасан Тэгш нэртэй гудамж өнөөдөр ч байна.

Византийн Юстиниан хаан Дамаск хотыг байлдаан дагуулсны дараа Сейднайд сүмийн томоохон цогцолбор байгуулж хамба ламаар нь төрсөн эгчээ өргөмжилжээ. Нэгэн жижиг сүм дотор байгаа Эх Дагинын хөрөг зурагнаас заримдаа чидун жимсний тос дуслалахад загалмайтнууд тосон авч Европ тивд тэсэн ядан хүлээж байгаа хайрт бүсгүйчүүдээ үнэт бэлэг болгон илгээдэг байв. Өвдөж шаналсан, аз жаргал мөрөөдсөн хүмүүс сайн сайхныг хүсэж хөрөг зурагны өмнө бурхны жижиг хөрөг, гоёлын хатгуур, хүзүүний зүүлт, алтаар урласан хөл, гар тавьсаар бурхны зургийг халхалсан тул үл харагдах ажээ.

Перс-сасанидууд Дамаскийг эзлэж грек-ром-византийн соёлтой тогтоосон харилцааг нь нэгмөсөн тасалжээ. Дараа нь 635 онд арабууд хотыг гартаа авсан үеэс лалын хот болох түүхэн үе нь эхлэжээ. Арабын цэргийн жанжин Халид ибн аль-Валид хотыг бүслэсний дараа хотын оршин суугчдад хандаж “Аллах бурхны нэрийн өмнөөс, хотын бүх оршин суугч, тэдний эд хөрөнгө, сүм дуганд гар хүрэхгүй гэдгээ ёс төртэйгээр тангараглаж байна. Хотын хэрмийг буулган нураахгүй, иргэдийг лалын шашныг сүсэглэхийг хүчээр тулган шаардахгүй, татвараа зохих ёсоор барагдуулж байвал хэнд ч ямар ч хор хохирол учруулахгүй.” гэсэн амлалт өгсөн байв.

Иймд лалын шашинтан-арабууд анхандаа өгсөн амлалтаа биелүүлж элдэв явууллага хийхгүй байлаа. Гэвч Омейяд угсааны Аль-Валид халифийн үед Лалын шашны их сүмийг барьж чамин гоёоор чимэглэжээ. Одоо тэр сүмээс дээгүүр нь хэд хэдэн жижиг гүүр тавьсан голын эрэг дагуу барьсан уран гоёмсог хийцийн барилга байгууламж бүхий зохиомж л үлджээ. Яг бодитой юм шиг харагдах тэр зохиомжинд Дамаск хотын уран барилгын цогцолборыг хот дундуур урсдаг Барада голын хамт дүрсэлсэн байна гэж үздэг.

Арабын халиф Муавия 661 онд Дамаск хотыг арабын нийслэл Медины хотоос тусгаар болсныг зарлажээ. Тэр үеэс Дамаск зуу гаруй жил нийслэл биш байсан ч соёлын төвийн хувьд тодорхой үүрэг гүйцэтгэсээр байлаа.

Христос шашны шүтлэгтэй харьяат иргэддээ тэвчээртэй нигүүлсэнгүй хандаж байсан Омейяд угсааны хаадын оронд өндөр эрх мэдэлд хүрсэн Аббасид угсааны хаад тэднийг “буруу номтнууд” гэж гадуурхаж эхлэв. “Мянга нэгэн шөнийн үлгэр”-т гардаг Харун-ар-Рашид халиф Дамаск хотод цэргийн жанжин Бармакидоор удирдуулсан цэргийг байрлуулж Омейяд угсааны хаадын үед баригдсан бүх христос шашны сүмийг нураах, албан ёсоор хүлээн зөвшөөрсөн христос сүсэгтнүүдийг тусгай хувцас өмсөж байх зарлиг буулгажээ. Татварын дийлэнхийг нуруундаа үүрч байсан христос шашинтнууд шахалт хавчилтаас зугтан явсаар аажимдаа ганц ч үлдсэнгүй. Чухамдаа тэр үед, халиф буруу хэрэг үйлдсэнээ ойлгосон ч нэгэнт хожимдсон байлаа.

Дамаск хотод лалын шашин эрчтэй дэлгэрч байсныг тэр үеийн бунхнууд гэрчилнэ. Тухайлбал

Их сүмийн зүүн-урт хэсэгт байгаа бунханд лалын сүсэгтэн-шийтүүд хамгийн нөлөө бүхий гэгээнтэн гэж хүндэтгэж байсан зөнч Мухаммедийн ач хүү Хусейний толгой хадгалагдаж байна гэсэн домог бий. Их сүмийн тэр хэсэгт Иракаас мөргөлчид байнга ирдэг учир перс хэлээр мөргөл үйлдэж байгаа нь дандаа сонсогдоно.

Гуты дүүргийн өмнөд захад шийтүүдийн бас нэг шүтээн байгаа нь зөнч Мухаммедийн ач охин “Бяцхан Зейнаб” бүсгүйн мавзолей юм. Эл мавзолейг ираны уран гартнууд урласан болохоор Дамаскийн энэ хэсэгт ираны нутаг бий болсон гэж үзэж болно.

Аз болоход загалмайтнуудын хөлд Дамаск өртөөгүй юм. Тэднийг довтлон ирэхэд дамаскчууд баатарлагаар эсэргүүцэн байлдаж ухраан элдэн хөөжээ. Дундад зууны үед ялагдсан загалмайтнуудад хүлцэнгүй хандаж байснаараа алдаршсан нэрт жанжин Сала-ад-Данийн хяналтад Дамаск хот 1147 онд оржээ. Алдарт жанжны ноёрхлын үед хотод уран барилгын өвөрмөц хийцтэй олон сайхан барилга байгууламж босчээ. Хотын оршин суугчид түүнийг өөд болоход талархлаа илэрхийлж Их сүмийн хананы дэргэд чамин гоё мавзолейд түүний шарилыг хээ угалзаар чимсэн авсанд оршуулж мавзолейн өндөр оройг том ногоон алчуураар ороосон байна.

XIY зуун хүртэл дамаскчууд загалмайтнууд, сельжукууд, монголчууд зэрэг халдан довтлогчдоос төрөлх хотоо хамгаалах үйлсэд ихээхэн хугацаа, хөрөнгө зарцуулж байсан ч гар урлал, худалдаа, урлагийн янз бүрийн төрлийг хөгжүүлж байв. Гэвч Туркийн эрХШЭэлд орж 1918 онд л сая нэг дөрвөн зуун жилийн дарлалаас чөлөөгджээ. Түүний дараа францийн түрэмгийллийн эсрэг тэмцэлд босож 1946 оны дөрөвдүгээр сард л францийн аялан байлдах армийн сүүлчийн цэрэг зовлон ханатлаа амссан Сири орныг орхин гарчээ.

Арабын хотууд тодотголоороо алдаршсан байдгийн адил Дамаск нь “аль-Фейх” буюу “уудам” заримдаа “анхилуун” гэж нэрлэгдэнэ. Дорнын эртний хотуудын нэгэн адил хуучин шинэ хэсэгт хуваагдана. Хуучин хотын гудамж нь дэндүү давчуу болохоор хоёр гараа алдалж гудамжны хоёр талын байшингийн хананд хүргэж болно.

Дамаск хотын голт зүрх нь арилжаалж борлуулж байгаа бараа бүтээгдэхүүний нэр төрөл нь л өөрчлөгдсөн, олон зуун жилийн өмнөх байдлаараа байгаа “Сук Хамедие” зах юм.

Дамаск хотын бахархал, мөнхийн алдар суу нь дэлхийд цуурайтсан христос шашны онолч, зохиолч Иоанн Дамаскин юм. Ассирийн христос шүтлэгтэн айлд мэндэлж арабын нэгэн халифийн шадар тVIIIмэлийн зиндаанд дэвшсэн И.Дамаскин төрөлх хот, өөрийн нэрээ алдаршуулсан олон зохиол туурвиснаас “Диалетик”, “Буруу номын тухай”, “Итгэл үнэмшлийг бодитой тайлбарлах нь” хэмээх гурван хэсгээс бүрдсэн “Мэдлэгийн үндэс” ном нь хамгийн өргөн тархжээ.

## МЕРВ

Эртний Мерв хотын балгас 70 хавтгай дөрвөлжин метр талбайд эзлэнэ. Үүнд Муграб голын сав нутаг дахь баян бүрдэд орших Байрам-Али хотын ойролцоох түүхийн янз бүрийн үе шатад үүссэн хэд хэдэн дагуул хот багтана. Эдгээр дагуул хотын зарим нь удаан мөхөж зарим нь өөр газарт нүүдэллэн шилжиж үгүй болжээ. Хүн орхиж одсон байшингууд нурж дов толгод л хороолол, олон нийтийн байшин, захын талбай



байсныг илтгэнэ.

Хуучин Мерв хотын балгас аль эртнээс эрдэмтдийн анхаарлыг татаж байсан ч 1950-аад үеэр профессор М.Е.Массоны удирдсан хуучны судлалын анги Муграбын баян бүрдийг судлах ажлыг цогцолбороор нь хийжээ. “Хотуудын эх” гэсэн алдарт хүртсэн суурин дорнын соёл иргэншлийн төдийгүй нийт хүн төрөлхтөний түүхэнд маш ховор биз ээ. Тийм алдрыг нэрт аялагч, эрдэмтэн аль-Макдисибид “Хижаз дахь хотуудын эх нь Мекка, Хорасан дахь хотуудын эх нь Мерв, Мерв нь Төв Азид байхгүй асар том нутаг юм, Самарканд, Бухар, ВараХШа, Пенжиикент дэргэд нь хөдөөгийн хотууд юм.” гэж бахархан бичиж байсан эртний туркийн Мерв хот хүртжээ.

Эртний болон дундад зууны үеүдийн зааг дээр Мерв хот тойруулан барьсан хэрмийн хүрээнд л гэхэд 235 га талбай эзлэж байсан ч түүний бүрэлдэхүүнд хотын талбайгаас хэд дахин илүү талбай эзлэх гар урчуудын хотхон, газар тариалангийн өргөн талбай багтаж байлаа. Тийм ч болохоор нь арабын зохиолчид хотын нэрэнд “Шахижан” буюу “Хааны сэтгэл бодол”, “Ертөнцийн эзэн” гэсэн тодотгол нэмжээ.

Ертөнцийн сайхан Мерв хотын түүх нууцлаг бөгөөд түүний насны талаар эрдэмтдийн дотор нэгдмэл ойлголт алга байна. Хотын түүхийн нууцад нэвтрэхээр Курций Руф, Исидор Харкский, Страбон, Ах Плиний, Птоломей зэрэг эртний зохиолч, түүхч, хятадын албан ёсны түүхчид, армяны түүх тэмдэглэгчид тэрчилэн араб, персийн түүхч, газар зүйчид хичээнгүйлэн ажиллаж байв. XII зууны дунд үед Мерв хотын язгууртан гэр бүлээс гаралтай судлаач Абусаид ас-Самани хорин боть “Мервийн түүх” ном бичсэнээс зөвхөн зарим хэсэг нь л бидний үед хадгалагдан иржээ.

Мерв хотын эртний цөм нь шинжлэх ухаанд Эрк-Кала гэж нэрлэдэг “цайз” юм. Энэ цайзыг домгийн хаан Тахумартын зарлигаар барьсан тухай дундад зууны үеийн эх сурвалжид

тодорхой бичсэн байна. Манай эриний өмнөх Хоёрдугаар мянган, Нэгдүгээр мянганы эхний хагас хугацаанд Эрк-Кала цайз хүн ам ихтэй суурингуудын нэг байв.

Цайз Ахеменидийн угсааны хаадын захиргаанд удтал байж дараа нь Александр Македонскийн эрХШээлд орж манай эриний гуравдугаар зууны сүүлчээр Селеквидийн Антиох Сотер хаан Муграб баян бүрдийг тойруулан 230 километр урт хэрмийг элсний түрэлт болон дайнч нүүдэлчин омгуудын халдлагаас хамгаалах зорилгоор барьжээ.

ҮI-ҮШзуунуудад Маргианы муж хэд хэдэн вант улс болон хуваагдаж шинэ захирагч нар болох Сасанидийн шахуудад захирагдах болжээ. Гэхдээ Мерв хот бие даасан байдалтай байж түүнийг “марзубан” гэсэн хэргэмтэй нутгийн феодал удирдаж байлаа. Мерв монголчууд довлон ирэх хүртэл Хорасаны төдийгүй нийт Дундад Азийн соёлын том төв байлаа. Тэндээс цөөнгүй нэрт хүн, зүтгэлтэн төрсний дотор Их Хосров хааны шадар тVШмэл, гарамгай дипломатч Бузуртмирх, нэрт эмч, гүн ухаантан, аялагч Барзуге, хосгүй дуучин, хөгжимчин Барбут нарыг нэрлэхэд л хангалттай.

IX зуунд Мерв хотын эмнэлэгт ажиллаж байсан христос шашинтан-эмч Ибн-Масы хооллох дэглэм, хүний бие бялдарт зарим хоолны үзүүлэх нөлөө, усан эмчилгээ, цус ханах тухай бүтээл туурвиж хосгүй ургамал судлагчийн хувьд ургамлуудын гадаад төрх байдлын тухай дэлгэрэнгүй бичиж байжээ.

Мерв хотын оршин суугчид анхандаа зороастризм шашныг шүтдэг байсан хийгээд Сасанидийн сүүлчийн хаан Иездегерд ариун гал авчирч аташкедийн сүмүүдийн нэгэнд залжээ. Хотод христос шашин шүтдэг иргэн олон байжээ. Тэрчилэн хотын баруун-өмнөд хэсэгт Гуравдугаар зуунд босгосон бүддийн шашны сүм байв. Хотод байсан олон шашны сүмээс лалын шашны Кей-Марзубан ихэд алдартай байжээ.

Нутгийн оршин суугчид “Султан-Санжар” шүлгэн туульсийг маш их хүндэтгэдэг байв.

Үсээ самнаж байгааг нь, алхаж байхад нь хөлийнх нь өсгийг нь хэзээ ч харахгүй, бэлхүүсээр нь тэврэхгүй гэсэн гурван хагуу болзлыг султан Санжар зөвшөөрч тэнгэрээс үзэсгэлэн төгс бүсгүйг хатнаа болгон авчээ.

Султан хатантайгаа хамт аз жаргалтай амьдарч байсан ч өнөөх хачин болзлуудыг бодож дотроо шанална. Тэгээд тэссэнгүй, үсээ хэрхэн самнаж байгааг нь харахаар зориглов. Сэм харахад хайртай хатан нь толгойгой авч ширээ дээр тавиад алтан самаар үсээ самнаж байлаа. Дараа нь хөлийнх нь өсгийг сэм харахад газар дээр явдаг биш агаарт нисэж байдгийг мэдэж мэл гайхав. Тэгтэл хатан нь багтартлаа уурлаж тэнгэрт нисэн одож гэнэ.

Султан сэтгэлээр унаж үзэсгэлэнт хатнаа бодсоор лам нарыг дуудан ирүүлж хатнаа буцаан авахад туслахыг гуйлаа. Лам нар өдөржин шөнөжин мөргөл үйлдсээр хатныг буцаан дэлхийд ирүүлж чадав. Султан хязгааргүй баярлаж хоёр жил хайртай хатантайгаа аз жаргал дүүрэн амьдрал. Тэгээс бас тэссэнгүй, хатнаа бэлхүүсээр нь тэвэрч ясгүй болохыг нь мэдэж бүр их гайхжээ.

Энэ удаа хатан нь түүнээс эгнэгт салан явахаар шийдсэнээ дуулгаж тэнгэр өөд нисэн одохын

өмнө “Чи хэрвээ намайг дахин дахин харж сэтгэлийн цэнгэл эдлэхийг хүсэж байвал хорвоод хамгийн өндөр сүм барь, тэгээд оройд нь нүх гаргаарай, тэгвэл би баасан гариг бүрт тэр нүхээр ирж чамдаа харагдаж байна.” гэжээ.

Султан хайртай хатныхаа хэлснээр бүхнийг хийв. Сүм барих ажил дууссаны дараа хатан нь сүмийн оройд гаргасан нүхээр харагджээ. Тэд ийнхүү уулзсаар урьдын хамтын жаргалтай амьдралаа дурсана. Хатан нь нэгэн удаа нисэн одохын өмнө, алтан самаа доош нь шидтэл, газар унасангүй, тойпууны хооронд тээглэв. Султан самыг буулган авчрах тушаал өгч алтан самыг хайрцагт хийж сүмийн оройд гаргасан нүхийг таглахыг үүрэг болгожээ.

Энэ домогт итгэж алтан самыг авах гэсэн оролдлого олонтаа гарч байлаа.

Сельжукийн хүчирхэг угсааны хаадын сүүлчийн төлөөлөгч болох султан Санжарын XII зууны эхний хагаст босгосон мавзолей уран барилгын гоёмсог хийцээрээ цаг үеийнхээ болон дараагийн үеийн хүмүүсийн бахархал атаархлыг төрүүлж байлаа. Гэвч олон зуун жилийн хугацаанд Санжар султаны бунхан сүрлэг сайхан дүр төрхөө алдсан байна.

Мервийн соёл иргэншил технологийн өндөр түвшнээрээ тухайн цагтаа ч өнөөдөр ч гайхагдаж байна. Тухайлбал эртний ертөнцөд маш сайн чанарын болд хийдэг байсан “маргианы төмөр” ихэд алдартай байв. Плутарх “Харьцуулсан намтар түүх” зохиолдоо парфяний дайчдын нүд гялбуулсан болдон дуулга, хуягийг магтан бичсэн бий.

Хуучныг судлаачид Мерв хотод малталт хийж усан үзмийн болон интоорын яс, улаан буудай, цагаан будаа, ший гуа, хулуу, өргөст хэмхийн үр олсон хийгээд усан үзмийн болон бусад жимсний яс, тарианы үр нь өнөөгийнхөөс хэмжээний хувьд нилээд том байсан нь их сонин байв.

Хуучныг судлаачид мөн чанар сайтай хөвөн бөс даавуу илрүүлжээ. “Мерв нутагт хамгийн хөнгөн хөвөн хурааж хамгийн чанартай даавуу хийхэд ертөнцийн зүг бүрээс ирсэн худалдаачид тэр дор худалдан авч оддог.” гэж IX зууны арабын газар зүйч аль-Истархи бичиж үлдээжээ. Мервийн даавуу нэрд гарч Багдадын халифууд тус хотод тусгай урлан байгуулж тэнд үйлдвэрлэсэн даавууг захиалан авдаг байв. Аль-Мустакфи халифийг нас барсны дараа түүний хөрөнгийг тоолоход алт, үнэт эрдэнэстэй цуг 65 мянган “мервийн” хуйлсан даавуу, 13 мянган “мервийн” толгойны боолт гарч байжээ.



## МЕМФИС

6000 жилийн тэртээ өнөөгийн Египет улсын нутаг дэвсгэр дээр хоёр улс байснаас Дээд Египет нь Нил мөрний хөндийн доод хэсгийг, Доод Египет нь Нил мөрний адаг хавийг эзэгнэн оршин тогтнож байжээ. Энэ хоёр улс нэгдэж нэгдсэн Эртний египетийн улсыг тунхагласан үед Нил мөрний зүүн эрэг дээр нийслэл хот Мемфис үүсчээ.



Хотыг үндэслэсэн Менес хаан зарлиг гаргаж урьд нь Ливийн нутаг дахь уулсыг ундаалж байсан Нил мөрний урсгалыг өөрчилж нилээд хэдэн километр зүүнтэйгүүр урсгадаг болгожээ. Түүхч Геродит зохиол бүтээлдээ Мемфис хотоос өмнө зүгт 18 километр зайтай барьсан далангийн байрлалыг бичиж үлдээсэн бий. Нил мөрнөөс булаан авсан хуурай газар дээр эхлээд “Цагаан хана” цайз барьж дараа нь Менес фараон түүнийг тойруулан хот байгуулсан нь “Маннофер” (эсвээс “Мен-нефер”) буюу “сайхан нутаг” гэсэн нэр авчээ. Тус хотод фараон торгон цэргүүд, ордны тVIIIмэд, тайлгач нартайгаа сууршин амьдардаг болсноор тус орны бүх баялаг энд хуримтлагдаж эхлэжээ. Хот буурал түүхийнхээ хугацаандаа Ази, Африк, Европийн нэрд гарсан бүх ард түмний төлөөлөгчийг харжээ.

Худалдааны хоёр чухал зам Мемфис хотоор дайрдаг болсноор тухайн үеийн томоохон захуудын нэг болон хувирч Баруун-Өмнөд Азиас янз бүрийн даавуу, зэвсэг Дорнод Африкаас зааны яс, алт, анхилуум үнэртэн зөөн авчирч египетийн үр тариа, вааран эдлэл, үнэт эдлэл худалдаална.

Мемфис нь хэдэн мянган жилийн турш Египетийн тэргүүлэх хот, Газрын дундад тэнгисийн дорнод хэсгийн худалдааны томоохон төв байв. Тэрбээр IV, V, VI угсааны фараонуудын үед хөгжлийнхөө оргилд хүрч дараа нь мартагдсан ч Египет орныг гадаадын түрэмгийлэгчдээс чөлөөлсөн XVIII угсааны фараонуудын үед дахин сэргэжээ. Гэвч нийслэлийг Фивы хотод дараа нь Александри хотод шилжүүлсэн үед Египетийн эртний нийслэл ач холбогдлоо алдсан юм.

Грекүүд египет орныг эзлэх үед Мемфис сүрлэг, тансаг байдлаа хадгалж байсан хийгээд дараа нь 640 онд арабууд халдан ирж хотыг оргүй сүйтгэсэн ч балгас нь хэдэн зууны дараа ч сүрлэг сайхан харагдсан хэвээр байлаа.

XII зуунд Мемфис хотын балгасыг харсан арабын зохиолч Абд эль-Латифа шагшин бичихдээ “Хөндий тал тэр аяараа аймаар балгасаар дүүрсэн ч том байшингуудын суурь, энд тэнд сэтгэлд багтамгүй зузаан хэрэм, гулдан хаалга байгаа нь бахдан бахархах бодол өөрийн эрхгүй төрүүлнэ. Болсон гөлтгөнөөр чадамгай урласан хоёр том арслангийн баримал, хоёрдугаар Рамзес фараоны 13 метр орчим баримлыг хараад нүднээс нулимс дусалж билээ.” гэжээ.

Мемфис хотод хорвоогийн хамгийн эртний баганууд бий. Хоёр эгнээгээр байрлуулсан багануудын цаана тухайн үедээ тэгш өнцөгт хэлбэртэй шохойн хавтангуудаар барьсан хэрмээр хүрээлүүлсэн хашаа байв. Одоо тэр хэрмээс балгас үлдсэн ч яг хэвээр байгаа гулдан хаалгаар нь сүм, бунхан, багануудын цогцолбор байсан хашаанд орно. Цогцолбор бүхэлдээ нурж сүйдсэн ч Лянхау сүмийн гурван хана үлджээ.

Мемфис хотын урд захад Саккара дүүрэгт манай эриний өмнөх III мянган жилийн үеийн Египет орны соёлын өндөр түвшинг илтгэсэн дурсгалууд бүхий бунхан бий. Египетчүүд хамгийн гоёмсог бунхнуудын орцны өмнө баганууд бүхий хашаа барьж хаалганы дээр Анубис бурханд хандсан, “аз жаргалтай, урт удаан амьдрал”-ын дараа таатай оршуулж нөгөө ертөнцөд элдэв зовлон бэрХШээлгүй зугаацаж байх гуйлтыг бичсэн байна. Хашаа дотор байгаа Буяны танхимд бүх хүн зэрэг хэргэм, албан тушаал харгалзахгүй чөлөөтэй орж нас барсан хүн нөгөө ертөнцөд зугаацан явахад хэрэгтэй идээ будаа тавина.

1850 онд францийн хуучныг судлаач О.Мариетт энэ нутагт аялал хийж яваад элс дундаас цухуйж байгаа хүн толгойтой чулуун арсланг олж харжээ. Тэр агшинд түүний толгойд эртний түүхч Страбоны бичиж үлдээсэн “Мемфис хотод элсэн дарагдсан Сераписийн сүм бий. Гэхдээ элснээс цухуйж харагдаж байгаагаасаа илүү элсэнд булагдсан хүн толгойтой чулуун арслан нь олон.” гэсэн мөрүүд буужээ.

Огюст Мариетт нилээд хэдэн бунхан олсноос дөрөв нь л яг хэвээрээ бусдыг нь тонож сүйтгэсэн байв. Бунхны цогцолборын яг гол дунд нь Жосер фараоны пирамид байсан хийгээд нэгдүгээр угсааны хатан хаан Хер-Нейтийн бунхан л бусдаасаа илүү сайн хадгалагдсан байлаа. Уг бунхныг шохойн хаданд сийлэн урлаж шал, таазыг нь модоор бүрж ханыг нь тойпуу өрж хийсэн байжээ.

О.Мариетт олон сарын нөр их хөдөлмөр зарцуулж орон нутгийн захиргааны элдэв саадыг давж 141 ширхэг хүн толгойтой чулуун арслан эгнүүлэн байрлуулсан өргөн чөлөө олж дараа нь цул улаан болон хар өнгийн боржин хадаар хийсэн авсууд дотор байрлуулсан ариун бухнуудын газар доорх бунхан болох Серапеумыг илрүүлэв. Бунхныг хуу тоносон байсан ч чулуун хавтанд сийлсэн бичгийг тайлан уншиж Апис ариун бухын нэр байгааг олж тогтоожээ. Тэрбээр гурван жилийн хугацаанд 7 мянга орчим эд зүйл олж гаргаснаас тал хувь нь Апис бухын шүтлэгтэй холбоотой эд зүйлс байв.

Мемфисийн гол бурхан нь урлаг, гар урлалыг ивээгч Птах бурхан байсан ба түүний ертөнц дэх дүр нь тусгайлан барьсан сүмд оршин суудаг ариун бух Апис байв. Апис бух ямагт дэлхийд байсан хийгээд ариун бух үхмэгц тайлгач нар Птах бурхны дүр төрхийг шингээсэн шинэ ариун бух тэр даруй эрж олно. Сонгож авах тугал нь арьсны өнгө, эврийн хэлбэр гээд 28 шаардлагад заавал тохирч байх ёстой байсан тул эрэл хайгуулын ажил заримдаа ихээхэн

сунжирдаг байлаа.

Шинэ ариун бух Аписийг сонгон авмагц тэр даруй Мемфис хотод авчирч баяр ёслол хийж найман өдөр цэнгэлдэнэ. Дараа нь ариун бухыг Птах бурхны сүмд залж үхэх хүртэл нь тэнд таваар нь байлгана. Ариун бухын хоол унд өгөх, баас шээсийг цэвэрлэх ажлыг залуу бүсгүйчүүд хийнэ, тахил өргөх ёслолын үед дээд лам нар заримдаа фараон биечлэн ирж оролцоно. Ариун бухын биеэрээ хийж байгаа, сүүлээ хөдөлгөж байгаа болон толгойгоо эргүүлж байгаа зэрэг бүх хөдөлгөөнийг Птах бурхны хүсэл тэмүүлэл гэж бишрэн шүтнэ.

Апис ариун бух үхэхэд Египет орон даяар гашуудал зарлана. “Птах” бурхан өөд болсон 28 нас хүрээд ариун бух үхэхгүй бол гашуудлын хувцас өмссөн тайлгач нар түүнийг Нил мөрний эрэг рүү хүндэтгэлтэй аваачиж болгоомжтой живүүлж ална.

Гашуудлын ёслол 70 хоног үргэлжилж ариун бухыг бишрэх үзэл улам батжиж өргөн олон түмэн ээлжит ариун бухад зориулсан бунхан барихад зориулж, байгаа бүх эд хөрөнгөө хандивлана. Чухамдаа гашуудал зарласан 70 өдөр египитийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүст Серапеумын бунханд орохыг зөвшөөрнө. Шинэ ариун бух олдмогц гашуудал дуусмагц найман өдрийн баяр ёслолоо үргэлжлүүлэн хийнэ.

Манай эриний өмнөх 525 оны зургаадугаар сард болсон ээлжит Апис ариун бухыг залах баяр ёслол Этиоп руу аян дайн хийж ялагдал хүлээсэн Персийн Камбиз хаан нутагтаа буцан явж байгаа үетэй давхацжээ. Мемфис хотынхон ялагдсаныг нь тавлаж баяр ёслол хийж байна гэж Камбиз уурлаж хотыг дайран эзлэж хотын удирдлагыг цөмийг нь цаазалж, тайлгач нарыг ташуурдан шийтгэж, шинэ ариун бух Аписийг гардан алжээ. Дараа нь цэргүүддээ хандаж хотын бүх сүм, ордонг эвдэн нурааж хотыг галдан шатаахыг тушаажээ. Удсангүй Камбиз хаан бүх учрыг ойлгож хотыг түйвээхээ зогсоохыг тушаасан ч нэгэнт хожимдсон байв. Эртний гоёмсог хот балгас болон хувирчээ.

## АНУРАДХА ПУРА

Энэтхэгийн ханхүү Вижайя Цейлоний арал дээр анхны улсыг байгуулсан гэж эртний эх сурвалжид тодорхой бичсэн бий. Зөрүүд зангаасаа болж хаан эцэгтэйгээ зөрсөн ханхүү хэсэг нөхдөө дагуулан амьдрал эрж тэнгисийн уудамд гарсан тэр явдал Цейлон улсын түүх эхлэсэн манай эриний өмнөх VI зуунд болжээ.



Грекүүд арлыг Тапробан, Синдбад далайчны үеийн арабын худалдаачид Серендиб гэж нэрлэдэг байсан бол англичууд Цейлон гэж дууддаг байв. Нутгийн иргэд эрт үеэс эх орноо “Шри-Ланк” (“Өгөөжтэй газар нутаг”) гэж бахархан хэлдэг байв. “Энэтхэгээс тасарсан дусал” гэж бас нэрлэдэг энэ арал нь Энэтхэг болон дорно зүгт орших орнуудын хоорондох өвөрмөц гүүр болж байдаг юм. Цейлон улсын соёл энэтхэгийн нөлөөгөөр хөгжиж үзэл суртал, шашин нь Энэтхэгээс гаралтай билээ. Бүддийн шашны нэрт онолч, Энэтхэгийн Ашока хааны хүү Махинда Цейлонд ирж бүддийн шашныг түгээн дэлгэрүүлсэн байна.

Эртний нэгэн домгийг сонирхуулья.

Ханхүү Махинда нэгэн удаа ойд явж байгаад тэнд ан хийн зугаацаж байгаа Цейлоны Деванампиятиссу хаантай тааралджээ. Хааныг ордондоо зочлон ирэхийг урихад ханхүү очиж түүнийг сэнхрүүлж бүддийн шашны шүтлэгтэн болгожээ.

Ханхүү Махинда удсангүй хаантай тааралдаж байсан ойгоос холгүйхэн орших Махинтал сууринд очиж агуйд даянчлан суужээ. Хаан түүнтэй уулзахаар байнга ирдэг болж төрийн чухал ажил төрөл, ахуй амьдралын тухай хүүрнэн ярилцана. Тэгээд Деванампиятиссу хаан ханхүүгийн даянчлан суугаа суурингийн ойролцоо хэд хэдэн сүм хийд барьж Ханхүү Махиндаг нас барахад түүний шарилын дээр хамгийн өндөр бунхан босгожээ. Чухамдаа тэр бунхны эргэн тойронд хүмүүс ирж сууршисаар Анурадхапура хот үүсэж Дорно дахины томоохон, сайхан хотуудын нэг болон алдаршжээ.

Манай эриний өмнөх IV зуунд үүссэн хот хэдэн зуун жил оршин тогтнож Махамамса угсааны хаадын нийслэл байжээ. Мянга гаруй жилийн түүхтэй хотын хувьд дэлхийн олон хотыг давж гарчээ. Анурадхапура ид цэцэглэлтийн үедээ гурван сая гаруй хүн амтай, 12 километрийн голчтой нутаг дэвсгэр эзэгнэсэн том хот байжээ.

Цейлон арал дээр эртний нийслэл болох Анурадхапура, Полоннаруву хоёр хотыг “чулуунд шингэсэн яруу найраг” гэж нэрлэнэ. Эртний хотуудын үлдэгдэл нь Шри-Ланк улсын эртний түүхэн “Махавамсы”, “Данивамсы” туульсийн шарласан хуудсуудыг санагдуулна.

Цейлон улсын нийслэлийг өөр хотод шилжүүлснээс хойш Анурадхапура нь буддийн шашны дурсгалуудын цуглуулга болон алдаршжээ. Тиймд уг хотыг жил бүр Шри-Ланк болон дэлхийн өнцөг булан бүрээс буддийн шашны шүтлэгтнүүд, жуулчид ирж сонирхоно.

Европчуудаас хамгийн түрүүнд Цейлон улсын эртний нийслэлд 1630 онд италийн эрдэмтэн Ф.Неграо ирж зарим баганын хэмжээг судалжээ. Анурадхапура хотын дурсгалт зүйлүүдийн тухай дэлгэрэнгүй тайлбарыг Роберт Нокс 1679 онд хийжээ. Эртний эх сурвалж, бидний үед хадгалагдан ирсэн дурсгалт зүйлүүдийг судалж Анурадхапура хотыг анхнаас нь тодорхой зураг төслөөр барьж босгосныг тогтоожээ. Тухайлбал хотын дөрвөн гулдан хаалгыг ертөнцийн дөрвөн зүгт харуулан хийж хотыг тойруулан барьсан хэрэм нь бүр нэгдүгээр зуунд 3 метр орчим өндөр байв. Хоёрдугаар зуунд хэрмийг өндөрсгөж харуулын цамхагууд нэмж барьсан байна.

Эртний Анурадхапура хот нь хааны ордон, шашны чухал байгууламжууд бүхий дотоод хотхон тэрчилэн хожим нь бий болсон гадаад хотхоноос бүрдэж байв. Мутасив хаан дотоод хотхонтой залгуулан алдарт Махамегха цэцэрлэгт хүрээлэн байгуулсныг түүний залгамжлагч, хаан Деванампийатиссу буддийн шашны сүмд бэлэг болгон шилжүүлжээ.

Будда бурхан дор нь сууж гэгээрэлд хүрсэн гэдэг Хойд Энэтхэгт ургадаг модны мөчрийг авчирч Деванампийатиссу хааны үед Анурадхапура хотод суулгажээ. Мөчир төлжсөөр буддийн шашны ертөнцөд “бодхи” нэрээр мэддэг мод ургасан нь одоо ч байна. Тэр мод 2250 настайгаараа дэлхийд хамгийн эртний ургамал гэж тооцогдож байна.

Эртний Анурадхапура хотод хувийн болон олон нийтийн хэрэглээний барилгуудын дийлэнхийг модоор барьж Будда бурхны баримлууд, шүтээний эд зүйлсийг л чулуугаар урлаж байжээ.

Цейлоны үе үеийн хаад Будда бурханд зориулж олон сүм, шүтээн босгожээ. Тэдний нэг нь манай эриний өмнөх хоёрдугаар зуунд Дутагамини хааны барьсан гэдэг Руванвалисая хэмээх эртний сүм юм. Энэ сүмд мөргөл үйлдэхээр олон зуун жилийн өмнөх шиг лам нар, мөргөлчдийн цуваа үл тасрана. Тэрчилэн аугаа түүхээ мэдрэх, өнөө үеийг илүү сайн ойлгохоор оюутнууд, сурагчид мөн тогтмол ирдэг ажээ.

Анурадхапура хотын эртний дурсгалуудын нэг нь Тхупарама, Абхаягири бунхнууд юм. Тэрчилэн 900 тасалгаа бүхий есөн давхар гайхамшигт барилга болох “Зэсэн ордон” байна. Хотод байгаа олон бунхны дотор хээ угалзаар чимэглэсэн чулуун баганууд байна. Тус бүр нь 4 метр өндөр, нийт 1600 шонг тус бүрийг нь 40 ширхэгээр 40 эгнээ болгон байрлуулсан байна. Эрт үед шонгуудын мөнгөн хялтсаар чимэглэж шонгуудаар тулсан дээврийг зэсэн хавтсуудаар бүрсэн байсан учир “Зэсэн ордон” гэсэн нэр авчээ.

Зэсэн ордны бүрэлдэхүүнд хүмүүст болон амьтдад зориулсан хоёр эмнэлэг багтаж байв.

Театрын барилгын өмнөх талбайд ардын туульчид бүтээл туурвилаа хайлдаг байжээ. Арван тосгоны дунд нэг эмч томилж түүний ажлын бүх зардлыг хааны сангаас гаргадаг байжээ. Түүхэн зохиолд “тэнгис” гэж хүндэтгэн нэрлэсэн байдаг том усан сангаас хоолой татаж цагаан будааны тариалалтын талбайг усалдаг байв.

Анурадхапура хот XI зуун хүртэл оршин тогтносон хийгээд дараа нь чольсийн цэрэгт эзлэгдэж үнсэн товрог болж дахин сэргэж чадаагүй ажээ. Тэгээд Цейлон улсын гол хот, соёлын төв нь Полоннарува хот болжээ.

## МОХЕНЖО-ДАРО

Дели хотын нэгэн музейн үзмэрүүдийн дотроос хар металлаар урласан бүсгүй хүний жижигхэн баримал онцгой анхаарал татна. Нүцгэн бүсгүй бүжиглэж дуусаад ташаагаа ихэмсэг тулан зогсож үзэгчдээс нижигнэтэл алга ташихыг хүлээж буй мэт ажээ. Бугуйнаасаа мөрөө хүртэл бугуйвч битүү зүүсэн бүжигчин бүсгүй бүжиглэж ядраад гэх үү эсвээс хүнд бугуйвчинд дийлдээд гэх үү зүүн гараараа өвдгөө тулжээ.



Энэ баримлыг дэлхийн эртний хотуудын нэг болох Мохенжо-даро хотод хийсэн малталтын үед олжээ. 1856 онд хуучныг судлаач эрдэмтэн Александр Каннигам өнөөгийн Пакистан улсын нутаг дэвсгэр дээр Хараппа тосгоны орчим малталт хийж байхдаа бөхтэй бух, ханз үсэг санагдуулсан үл ойлгогдох тэмдэг сийлсэн зааны яс шиг цагаан өнгөтэй чулуу олжээ.

Өнөөх чулуу гарсан дов нь ойр орчмын тосгодын тариачид, төмөр зам баригчид барилгын материал болгон олон жил ашиглаж байгаа шатаасан улаан тойпуугаар “боссон” байлаа. Ийнхүү эртний гайхамшигт хотуудын нэг болох Хараппа аажмаар алга болжээ.

Гэвч 1920 оны эхэн үеэр Мохенжо-даро хотыг нээсний дараа Индийн хөндийд нэн эртний соёл иргэншил байсныг хүн төрөлхтөн анх удаа дуулж чихээ дэлдийлгэжээ. Мохенжо-даро хот нь Хараппагаас бараг гурван мянган километрийн зай оршдог ч хоёр хотод нийтлэг зүйл олон ч Мохенжо-даро нь илүү сайн хадгалагдаж ирснээр ялгагдана.

Энэтхэгийн эрдэмтэн Р.Сахни, Р.Банержи нар ихэр хоёр хотын гудамж талбайг малтан гаргахад адилхан тойпуун байшингууд бүхий сайтар төлөвлөсөн байрлалтай адилхан тэгш өнцөгт хорооллууд байлаа. 260 га хэмжээтэй том талбайд Мохенжо-даро (“Үхэгсэдийн дов”) хотын бүхэл бүтэн хорооллууд, зарим байгууламж оршино. Их хотыг сөнөснөөс 15 зууны дараа Кушаны хаанчлалын үед довыг буддийн шашны мөргөлийн газар болжээ.

Дэлхийн олон орноос ирсэн зарим судлаач, хуучныг судлаач энэ нутаг дахь энэтхэгийн соёл иргэншлийн бие даасан байдлыг үгүйсгэж шумерийн соёлын дорнын хувилбар гэж үзэж байв. Гэтэл зарим судлаач, Хараппа, Мохенжо-даро нь Элам, Шумер, эртний Египетийн соёл иргэншилтэй огт адилгүй юм гэсэн дүгнэлтийг хийж хоёр голын орчимд хотуудын дотоод

байрлал нь шал өөр, түүхий тойпуугаар байшин барилга барьдаг байсан гэсэн үндэслэлийг гаргаж байв. Малталт үргэлжилсээр шинэ хороолол, байгууламж дараалан гарсаар эртний энэтхэгийн гэж нэрлэсэн соёл иргэншил байсан нь нотлогдов.

Эрдэмтэд хоёр хотын тухай эртний зохиол бүтээлд хэрхэн бичсэнийг сонирхож энэтхэгийн эртний уран зохиолын “Ринвед” дурсгалыг нягтлан судлахад “ов зальтай худалдаачид”-тай хотын тухай л хэдхэн мөр байв. Гэвч Индийн хөндийд оршин тогтнож баян тансаг хотын тухай, уг хотод суудаг байсан чөлөөт, гоё хүмүүс бурхдыг хилэгнүүлснээс сөнөсөн тухай домог яриа эрт дээр үеэс ард түмний дотор өргөн тархсаныг олж мэджээ. Домог яриаг нотлох мэт чулуугаар сийлсэн тайлгачийн толгой, эмэгтэй хүний чамин гоёл, тахилын амьтдыг дүрсэлсэн самбар, одоо ч тайлж уншиж чадаагүй ханз үсгүүд гарсаар байлаа.

1950 оны үед английн хуучныг судлаач М.Уилер малталт хийх явцдаа нэгэн байгууламжийг ил гаргаж хамгаалалтын зориулалттай юм байна гэсэн дүгнэлт хийв. Мохенжо-даро хотын төвд барьсан цайзыг 9 метр зузаан хэрмээр хүрээлүүлсэн байв. Малталтыг үргэлжлүүлэн хийсээр хотын өмнөд хэсэгт түүхий тойпуугаар өрж шатаасан тойпуугаар өнгөлсөн зузаан хэрэм байгааг бас илрүүлжээ. Гэхдээ эдгээр хэрмийг дайсны довтолгооноос хамгаалах зорилгоор уу эсвээс үерийн далан болгож барьсан эсэхийг лавтай тогтооход хэцүү байгаа ажээ.

Цайзаас гарч өргөн тэгш гудамжаар явж эрдэмтэд “Хуралдааны танхим” гэж нэрлэсэн байшинд хүрнэ. Түүний хажууд багтаамж ихтэй үр тарианы агуулах, хажууханд нь агааржуулалтын нүхүүд бүхий том тойпуун суурин дээр барьсан хоёр давхар гималайн хуш модон байшин байжээ.

Мохенжо-даро хотын байшин барилга, гудамж, талбайг урьдчилан сайтар бодож боловсруулсан зургаар барьжээ. Тухайлбал гудамжуудыг нь хойд зүгээс өмнөд зүг рүү, зүүн зүгээс баруун зүг рүү чиглүүлэн барьснаар хотыг салхинаас найдвартай хамгаалсан байна. Гол гудамжуудыг нь тэгш хэмээр зөрөлдүүлэн тавьсан учир элдэв саад тааралдахгүй, мухардалд орохгүй, гудамж дагуух байшингуудыг нэгэн шугамд барьсан тул хойш урагш сэртийсэн ганц ч байшин байхгүй байжээ. Хотын гол гудамжны урт нь 80 метр, өргөн нь шар үхэр хөллөсөн хэд хэдэн тэрэг зөрж болохоор 10 метр ажээ.

Цайзын хэрмийн цаана тагтны зориулалтаар мөн ашигладаг тойпуун налуу дээвэртэй тойпуун байшингууд бүхий доод хотхон байна. Тойпууг өнөөгийн энэтхэгийн тариачдын адил задгай хайрцаг дотор шатаан хатууруулдаг байв. Байшингуудын өндөр нь 7,5 метр өндөр хийгээд цонхны оронд шавар, болсон гөлтгөнөөр хийсэн сараалж бүхий агааржуулалтын нүх байна. Гол гудамжнаас тоос шороо булгин орохоос зайлсхийж байшингийн хаалгыг догол гудамж руу харуулан гаргана. Хана, шалыг олбогоор бүрж байшин дотроо тойпуугаар халуун усны сав хийж байрлуулсан байна.

Хороолол болгонд нийтийн хэрэглээний цэвэр усны худгууд байх хийгээд наранд халсан усыг тусгай хоолойгоор хоёрдугаар давхарт хүргэдэг байжээ. Хотод тусгай өрөө, хүүхдийн тасалгаа бүхий нийтийн халуун усны газар байв. Халуун усны газрын хэрэглэсэн ус гудамж болгонд татсан битүүлсэн сувагт урсаж бүх гудамжны сувгийн бохир ус хотын гадна ухсан том нүхэнд урсан юүлэгдэнэ.



Мохенжо-даро хотын иргэд гэрийн ихэнх эд зүйлсийг зэс, хүрлээр урлаж хөдөө аж ахуйн ажилд зориулан анжисны хошуу, хадуур, гар урчуудад сүх, хөрөө, хүрз, цэргүүдэд жад, илд, сэлэм, кинжаал хутга хийж өгнө.

Хотын бүсгүйчүүд гоёлын зүү хатгасан, сувдан бүс юм уу тууз бүхий богино банзал өмсөж дэвүүр хэлбэрийн малгай хэрэглэж сэрүүн өдөр мөрөндөө нөмрөг углаж явна. Эрэгтэйчүүд нь ташаандаа боолт зүүнэ. Хэн ч гутал өмсөхгүй боловч үсний засалтдаа онцгой анхаарна, ялангуяа эрчүүд нь их чамирахаж гэзэг унжуулна, үсээ туузаар орооно.

Бүсгүйчүүд нь мөнгөн гоёл, алтадмал хүрлээр хийсэн бүс, духны боолт, зааны ясаар хийсэн сам, элдэв толгойтой үсний хатгуур хэрэглэнэ.

Эрдэмтэд эртний энэтхэгийн соёл иргэншлийг тал бүрээс нь нарийвчлан судалж байгаа ч дөчин зууны тэртээх хотыг чухам хэн бариулсан, тэд ямар хэл дээр ярилцдаг байсан, төрийн удирдлага нь ямар байсан гэх зэрэг асуудлуудад баттай хариулт өгч чадаагүй байна.

Мохенжо-дарогийн соёл иргэншил нь манай эриний өмнөх 1500 жилийн орчим уналтад орсон бололтой. Мохенжо-даро хот хэрхэн сөнөсөн талаар эрдэмтэд янз бүрийн таамаглал дэвшүүлсээр байна. Газрын царцсын бүтцийн өөрчлөлтөөс үүдэн Инд голын голдрил эрс өөрчлөгдсөнөөс хот сөнөсөн гэж зарим судлаач үзэж байхад нөгөө хэсэг нь олон удаагийн газар хөдлөлтөөс болж хотын нутаг дэвсгэр дээр том нуур үүсэж хотыг живүүлсэн гэнэ. Гурав дахь хэсэг нь арийчууд халдан довтолж хотын оршин суугчдыг толгой дараалан хядаж байшин барилгыг нь эвдэн нураасан бололтой гэж батлаж байна. Гэтэл малталтаар гарсан хүмүүсийн араг ясны судалгаагаар гаднын халдлагад өртсөн тухай таамаглал нотлогдоогүй байна.

## АХЕТАТОН

Манай эриний өмнөх 1368 онд Египетийн хаан ширээнд өргөмжлөгдсөн IV Аменхотеп шинэтгэл хийж тус улсын түүхэнд маш чухал үеийг нээсэн билээ. Түүнийг фараон болохоос өмнө эртний египетчүүдийн шашны тогтолцоо нь дэндүү олон бурхнаас бүрдэж хүн будлимаар төвөгтэй байсан нь тус орны олон омог нэгдэж хүчирхэг нэгдсэн улс бий болоход их саад тотгор болж байлаа. Үүнд анхандаа амьтдыг бурханчлан шүтэж байлаа. Тухайлбал үхэгсэдийн Анубис бурхныг цөөвөр чонын толгойтой хүний дүрсээр, нарны Гор бурхныг



начин шувууны толгойтой хүн юм уу нисэж байгаа начин шувуугаар дүрсэлж байв. Эд нараас гадна Ра, Амон, Птах гээд олон бурхан байлаа.

VI Аменхотеп фараон болмогцоо Амон бурхныг бусад том, жижиг бурхантай цуг шүтэн бишрэхийг хориглов. Амон бурхныг шүтэгчид нийгмийн хамгийн том, нөлөө бүхий давхарга байсан тул Аменхотепийг фараоны эрх мэдлээс зайлуулах оролдлого гарч болзошгүй байлаа

IV Аменхотеп фараон хаанчлалынхаа анхны жилүүдэд Фивы хотод Амон бурхны сүмийн дэргэд анхилуум үнэртэй цэцэрлэгт хүрээлэн дотор “бүхнийг гэрэлтүүлэгч, амьд бүхнийг өмгөөлөгч нэгдмэл Нар”-ны Амон бурханд зориулсан сүм болгож өөрийгөө шинэ бурхны дээд тайлгачаар зарлажээ.

Хаанчлалынхаа зургаа дахь жилдээ хуучны шүтээнүүдийг бишрэхийг бүрмөсөн хориглож Амон болон бусад бурханд зориулсан ёслол, мөргөл хийхийг зогсоож тайлгачдын том эдлэн газруудыг хураан авч улс орон даяар сүм хийдийг хааж нийтийн байшингуудын хананаас бурхдын нэрсийг ховхлон арилгаж байлаа. Тэрчилэн Аменхотеп (“Амон бурхан сэтгэл хангалуун байна.”) нэрээ Эхнатон (“Атон бурхны таалалд нийцүүлэн”) гэж өөрчилж, гэр бүл, цэргүүд, гар урчууд, шинэ тайлгач нар, зураачид, уран барималчид, зарц нараа дагуулан Амон бурхны шүтээний төв болох нийслэл Фивы хотыг орхин одов.

Эхнатон фараон Нил мөрний дагуу явж хадархаг уулаар хүрээлэгдсэн хөндийд хүрч эрэг дээр гарч наранд гялтганасан алтан сүйх тэрэгнээс сууж шадар тVIIIмэдээ дагуулан Атон бурханд зориулан сүм босгохоор товлосон газраа буудаллав. Тэгээд “Амьд Атон бурхан болох Ахетатон” хот байгуулагдсаны ёслол хийж талх, дарс, таргалуулсан бух, эвэргүй тугал, шувуу, шар айраг, жимс, элдэв амттан өргөн барьжээ. Энэ тухай шинэ нийслэлийн хилийн 14

хавтангийн нэгэнд сийлж хавтангийн ар талд хотын хил хязгаараасаа хэзээ ч гарахгүй тухай фараоны тангарагийг мөн сийлэн бичсэн байв.

Хоосон газар чамин гоё хот байгуулахад байшин барилга барих жирийн хүмүүсээс гадна сүм, дуган, ордонг чимэглэх уран гартнууд маш олон хэрэгтэй байсан тул гар урлалын сургалтын хэсэг байгуулан ажиллуулжээ. Хотын төвд Амон бурханд зориулсан сүм босгож дэргэд нь египетийн эртний уран барилгын дэгийн иргэний шилдэг том байгууламж болох фараоны ордонг сүндэрлүүлжээ. Ордон залган барьсан хааны гэр бүлийн хашаа, сүмийг оролцуулалгүй 700\*300 метрийн харьцаатай талбай эзлэнэ. Ордны гол хэсгийг Атон бурхны сүмийн адил цагаан чулуугаар хийж алт, паалантай тоосго, уран зураг, сийлбэр, бичгээр чимсэн байна.

Сүм, ордон харш, язгууртнуудын баян хороолол, цэцэрлэгт хүрээлэн, цөөрөм бүхий шинэ хотыг “Атон бурхны нутаг” гэж тунхаглажээ.

Шинэ хотод эртний египетийн сүмийн дүр төрх шал өөр болжээ. Урьд нь сүм дотор ороход харанхуй угтаж танхилын өмнө асаасан лаа л танхимыг бүдэг гэрэлтүүлдэг байв. Тэгвэл Атон бурхны сүмд ёслол хийх өдөр сүсэгтнүүд орох хаалганы хоёр талаар босгосон тайрсан пирамидын хэлбэртэй шонгууд, фараонуудын баримал, уран зургаар чимэглэсэн сүмийн нар гийсэн том цэлгэр хашаанд орж Нарны бурханд цэцэг, хүнсний ногоо, жимс өргөн барина. Шүтээний дээд талбайд зогсож байгаа Эхнатон фараон хүж үнэртэн асаасан сангийн бойпор гартаа савлуулан хөдөлгөж өндөр тушаалын тVIIIмэд, тайлгач нар, бүх сүсэгтэн босоо ятга, люти хөгжмийн аянд сүлд дууллыг уянгалуулан дуулна:

Амьдралыг тэтгэгч, амьд бурхан Атон минь, тэнгэрийн хаяанаас Таны мандан гарч байгаа чинь ямар сайхан юм бэ! Замбуулин хорвоогийн бүх хүн сэрж биеэ угаан ариутгаж ертөнцийн шинэ өдөр эхэлж байгаад баярлаж гараа сунган Танд талархана! Хуурай газар дээр, усан дотор, агаарт амьдарч байгаа хүн, амьтан, цэцэг, өвс гээд Таны бүтээсэн бүхэн ямар гайхамшигтай, ямар сайхан юм бэ!

Шинэтгэгч-фараоны шинэ үзэл санаа яруу найраг, уран зураг, уран барилга, уран баримлын урлагт төдийгүй өдөр тутмын амьдралд тусгалаа олж байлаа. Эхнатон фараон амьдралынхаа хугацаанд ганц ч удаа аян дайн хийж байгаагүй болохоор бусдын газар нутгийг түрэмгийлж байгаа, өстөн дайсныг устгаж байгаа дүрслэл огт байсангүй. Тийм учраас уран зураг, баримлын урлагт түүнийг гүн бодолд автсан, баялаг дотоод ертөнцтэйгээр дүрсэлж байв.

Эхнатон фараон идэр залуу 35 настайдаа өөд болсон болохоор залгамжлагчаа зарлаж амжаагүй байна. Нэгэн товгор дүрсэнд түүн рүү хэн нэгэн этгээд дайрч байгааг дүрсэлснийг иш үндэс болгон түүнийг хорлож амь насыг нь бусниулсан бололтой гэсэн дүгнэлтийг зарим судлаач дэвшүүлдэг юм.

Хойч үеийн фараонууд түүнийг нэр, түүний бүтээсэн бурхныг мартуулахын төлөө бүхнийг хийж байсан нь харамсалтай. Тэд Эхнатон фараоны бүтээсэн хийсэн бүхнийг устгаж үгүйсгэж байв. Тэдний дотроос Египетийн хаан ширээнд хууль бусаар заларсан цэргийн жанжин Херемхем онцгой муу үйл хийж гоёмсог сүм, ордон, баримал, товгор дүрсүүдийг хуу сүйтгэж тансаг гоё сайхан хотыг газрын хөрстэй тэгшилжээ. Хотын балгас аажимдаа элсэнд

булагдаж хэдэн мянган жил хав дараастай байжээ.

1880 оны сүүлчээр Телль-эль-Амарна тосгоны оршин суугч эмэгтэй үл ойлгогдох үгс сийлсэн хэдэн шавар хаяг олсноор шинэтгэгч-фараоны гайхамшигт хотыг санамсаргүй нээжээ. Тэр эмэгтэй гадаадынхны их сонирхдог “эртний зүйл” болохыг дор нь ойлгож шавар хаягийг хэдэн хэсэг болгон хувааж зуугч хүмүүст хямдхан үнээр өгчээ. Тэдний нэг нь шавар хаяг дээр үл мэдэх үгс байгааг гярхай ажиглаж европийн хэд хэдэн музейд заржээ.

Хуурамч эртний зүйлс худалдан авч хаширсан нилээд хэдэн музей уг хаягийг тоосонгүй, харин Берлиний музейн ажилтнууд шавар хаяг бодит болохыг тогтоосон төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт тарсан бусад хэсгийг нь худалдан авахаар шийдвэрлэжээ.

1890 оны эхээр английн судлаач Уильям Мэтью Флиндерс Питри Телль-эль-Амарна тосгоны ойролцоо малталт хийсэн ч яагаад ч юм дорхноо больжээ. 1907 онд Германы Дорнын судлалын нийгэмлэг малталтыг үргэлжлүүлж эрдэмтдийн багийг удирдаж байсан Л.Бурхард эртний египетийн урлагийн түүхэнд цоо шинэ хуудсыг хүн төрөлхтөнд нээсэн ер бусын гайхамшигт дурсгал болох Нефертити хатны цээж баримлыг олжээ.


Фараон Эхнатон өргөө-хотоо хоосон газар дээр байгуулсан болохоор шинэ нийслэлээ эдлэн газрын маягаар төлөвлөж баян, ядуу хүмүүсийн байшингууд нь адилхан ч баячуудынх нь мөргөлийн байр, боол, зарц нарын байр, аж ахуйн хашаагаар илүү байна. Ахетатон хот дахь баян айлын эдлэн газар 68\*55 метрийн харьцаатай талбай эзлэх бөгөөд хоёр хаалгатай ажээ. Гол хаалгаар нь орж явган замаар явж жижигхэн хашаанд орж олон гишгүүртэй шатаар өгсөж байшингийн саравчтай орц руу хүрнэ. Цааш нь явсаар гэрийн эздийн амралтын төдийгүй зочид хүлээн авдаг өрөө болох дөрвөн баганатай уртавгар тасалгаанд орно. Бүх өрөө тасалгааны цонхыг нь дээвэрт тулган гаргасан байна.

Нарны бурхан Атоны хотын тайлгач нар өндөр саравчтай тагт, мөргөлийн баганууд, уран баримал, товгор дүрсүүдээр чимэглэсэн байшингууд бүхий дүүрэгт сууна. Эхнатон фараоны зарлигаар зарим байшинг Нил мөрний эргийг санагдуулсан байдлаар чимэглэдэг байв. Нарийн гоолиг багана нь зэгс санагдуулах хийгээд хана, шалыг олон төрлийн цэцэг, лянхау цэцгийн цоморлиг, мөрний эргийн шугуйд дэрсхийн нисэж байгаа шувуудын дүрсээр чимэглэсэн байна.

Эхнатон хааныг дүрслэхдээ голдуу хатан, охидтой нь цуг гаргасан байна. Фараон шинэ нийслэлээ босгохдоо хайртай хатандаа зориулж Наранд сүсэглэн мөргөх “Рэ нөмөр” нэртэй тусдаа байр барихаа амлаж байв. Нефертити хатан ордны дэргэдэх усан боомтод фараоны том завины хажууд усанд дайвалзан байдаг мөн том гоёмсог завьтай байжээ.

## ЭБЛА

Хорьдугаар зууны дунд үе хүртэл энэ хотын тухай хэн ч мэддэггүй байлаа. Манай эриний өмнөх гуравдугаар зууны үеийн Ойрхи Дорнодын түүхэн зураг дээр Египет, Аккадын хаант улс гэсэн хоёрхон хүчирхэг гүрэн байжээ. Нил, Месопотамийн хооронд орших өргөн хөндийд өөр бусад соёл иргэншил байгаагүй гэж олонх эрдэмтэд, хуучныг судлаачид үзэж байлаа. Гэвч Телль-Мардих тосгоны тариачид санамсаргүй зүйл олсон нь нээлт болж Сирийн Алеппо хотын нутаг дэвсгэр дээр хийсэн малталт нь дээрх үзлийг өөрчилсөн билээ.



Тариачид анхандаа хүрмэн чулуун аяга олж хотын түүхэн музейд өгчээ. 1964 онд Сири улсын Засгийн газрын зөвшөөрлөөр италийн хуучныг судлаач Паоло Матье Телль-Мардих довд малталт хийж шуугиан тарьсан нээлт хийжээ.

Сирийн янз бүрийн нутгуудаас түрүүнд нь олдсон уран сайхны эд зүйлсийг Паоло Матье судалж тэр бүхэн нэгэн газраас эх сурвалжтай байх гэсэн дүгнэлт хийжээ. Зарим түүхэн зохиолоос тэр төв нь Сири улсад эртнээс оршиж байсан Эбла хот-улс гэдгийг мэдэж байсан ч эл хот чухам хаана байсныг тогтоож чадахгүй байжээ. Эл хотын тухай шумерийн эх сурвалжид Саргон хаан түүний ач Нарамсин нарын ялалтын тухай мэдээнд л зөвхөн дурдсан байв. Нарийвчлан судлахад манай эриний өмнөх гуравдугаар мянганд Ойрхи Дорнодод Египет, Аккадын хаант улстай өрсөлдөж байсан хүчирхэг улсын нийслэл болохыг лавтай батлав.

Хуучныг судлаачид 1968 онд аккад хэл дээр бичсэн үгс бүхий хүрмэн чулуун баримлын довжоо олов. Үгсийг тайлан уншихад эл баримлыг Эбла хотын хаанаас хотыг ивээгч Иштар эм бурханд бэлэг болгон өгснийг мэдэв. “Иштар эм бурхан Танд зориулж Эбла хотын ард түмний Игреш-Хепа хааны хүү би Иббит-Лим энэ ваарыг бүтээж, өргөн барьж байна.” гэж довжоо дээр сийлэн бичсэн байлаа. Ийнхүү Телль-Мардих довын дор алдарт Эбла хот оршин байгааг нээжээ.

1975 онд П.Матьегийн удирдсан шинжилгээний анги сирийн түүхийн хамгийн том олдвор болох манай эриний өмнөх ХХУ-ХХІІІ зууны үеийн бичиг бүхий 17 мянган шавар самбар олжээ. Энэ бол аугаа их нээлт байлаа!

Шумер хэл дээр бичсэн Месопотамийн эх сурвалжийг хүн төрөлхтөний түүхийн хамгийн эртний бичгийн дурсгал гэж үзэж байсныг энэ нээлт эцэс болгов. Шавар самбарын зарим үгсийг шумерийн сэлэм хэлбэрийн үгээр нөгөө хэсгийг нь эрдэмтэд “эблаит” гэж нэрлэсэн үл мэдэгдэх хэл дээр бичсэн байлаа. Энэхүү дуулиант эх сурвалжид хааны ордны үйл ажиллагаа, түүхэн үйл явдал, аян дайны тухай мэдээлэл, гэрээ хэлэлцээрийн эх, худалдаж авсан зарсан эд зүйлсийн бүртгэл, засгийн газрын тVШмэдийн захидлууд, уран зохиол байлаа. Эдгээр эх сурвалжийг тайлан унших ажил одоо хэр үргэлжилсээр байгаа ч нэгэнт тайлж уншсан самбаруудыг үндэслэж Эбла хот-улсын улс төр, төрийн байгуулалт, эдийн засаг, худалдаа, соёлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл олж авчээ.

Манай эриний өмнөх 2400-2250 онуудад Эбла хот хөгжлийнхөө оргилд хүрч Газрын дундад тэнгисээс Аккадын хаант улс хүртэлх асар уудам газар нутгийг нөлөөндөө авсан байлаа. Хамгийн сонирхолтой нь тийм том газар нутгийг аян дайн хийж биш өндөр соёл, хөгжингүй эдийн засаг, худалдааны ачаар “байлдан дагуулсан” ажээ. Эбла хот нь Месопотами, Анатоли (орчин үеийн Турк) хоорондох худалдааны замын уулзвар дээр байрлаж байсан нь үсрэнгүй хөгжлийнх нь үндэс суурь болжээ. Тэнгисийн эргийн ойгоос бэлтгэсэн мод гуалин, олон төрлийн даавуу, вааран эдлэл, ангийн арьс зөөн авчирч борлуулна.

Тус улсыг маликум (захирагч, хаан) удирдах хийгээд эзэмшил нутгуудыг тусгай гэрээгээр захирдаг орон нутгийн хаад түүнд захирагдана. Заримдаа маликумаар эмэгтэй хүнийг сонгож хатан хаанаар өргөмжилж төрийг удирдах эрх олгож байсан нь эртний дорнодын ямар ч соёл иргэншилд байгаагүй үзэгдэл байв. Хаан баян гэр бүлийн гишүүдээс бүрдэх Ахмадуудын зөвлөлийн туслалцаатайгаар төрийн ажлыг удирдан чиглүүлнэ. Тигр мөрний эргийн Ашур, Евфрат мөрний эрэг дээрх Мари улс Эблад ногдуулсан татвараа алт, мөнгөөр төлдөг байв. Нэгэн удаа Мари улсад бослого гарч татвар төлөхөө татгалзахад жанжин Эннадаганы удирдсан цэрэг тус орныг дайлаар мордож босогчдыг толгой дараалан хядаж байжээ.

Эбла нь засаг захиргааны хувьд дүүргүүдэд хуваагдах хийгээд дүүрэг бүрийг туслахууд бүхий хорин тVШмэл удирдана.

Хааны ордон нь улс орныг захирагчийн албан ёсны өргөө төдийгүй улс орны эдийн засаг, соёлын амьдралын төв байв. Хааны ордны цогцолборын олон хашаа, байранд уран барималч, зураачид, улаан модны мужаан, вааран эдлэл, үнэт эдлэлийн дархчуудын урлангууд байрлана. Тэрчилэн тусгай сургуульд төрийн албаны бичээч, тVШмэдийг бэлтгэнэ, сургалтыг шумерийн, эблаит гэсэн хоёр хэл дээр явуулна. Энд шавар самбарууд дээр утга зохиолын бүтээлийг хуулан бичиж улс оронд болсон чухал үйл явдлуудыг тэмдэглэн бичдэг байсан нь бидний өнөө үе хүртэл хадгалагдан иржээ.

Зарим шавар самбар дээр сурагчдын бичсэн зүйлийг багш нь зассан тэмдэглэл байгаа нь их сонин.

Алеппо мужид хийсэн малталтын шинэ улирал бүрийн дараа эрдэмтний ертөнц Элбагийн тухай улам бүр ихийг мэддэг болж байна. Тэртээ дээр үед олон улсын гэрээ байгуулдаг, цуцалдаг байсныг эрдэмтэд мэдмэгц мэл гайхаж цэл хөхөрч байлаа. Цаг үеийнхээ 17 улсын улс төр, эдийн засгийн үйл ажиллагааг хянадаг байсан Элба хот-улсын хаан нэгэн удаа Ассирийн хаанд хандаж тус улсын хилээс алс орнуудтай хийх худалдаа хийхэд нь баталгаа

гаргаж хөнгөлөлт үзүүлэхийг хүссэн бичиг явуулж байжээ.

Шавар самбаруудад бичсэн үгсийг тайлж эблаитийн нийгэм думу-ниты буюу онцгой эрх эдэлдэг хотын иргэд, бар-аны буюу цөөхөн тооны гадаадын иргэд гэж хоёр бүлэгт хуваагдаж байв. Думу-ниты (“Эблийн хөвгүүд” гэсэн утгатай үг) иргэдэд Эбла хотод төрж тус орны иргэний бүх эрх ямбыг эдэлдэг уугуул оршин суугчид хамаарна. Үүнд уран барилгачид, вааран эдлэл урлагчид, мужаан, талх баригч, тээрмийн ажилчид, оёдолчид хамаарна. Хоёрдугаар бүлэгт гадаадын иргэд тэрчилэн боолчууд, цэргийн олзлогдогсод, худалдаачид, армид алба хааж байгаа хөлсний цэргүүд орно. Элба хотод 40 мянга орчим иргэн, бусад 220 мянган иргэн нь бусад нутагт оршин суудаг байжээ.

Эбла хот-улсад янз бүрийн бурхдад зориулсан олон сүм хийд байсан хийгээд лам нар улс төр, эдийн засгийн үйл ажиллагаанд огт оролцдоггүй, дан шашны үйл ажиллагаа явуулдаг байв. Эблагийн иргэд баримлуудад нь тахил өргөх аргаар бурхдаа тахин шүтнэ. Нийт таван зуу орчим бурхаддаа шар айраг, талх, цөцгийн тос, хонь, ямаа өргөн барина. Тэрчилэн алт, мөнгөн цом, бугуйвч, кинжаал хутга, амьтдын дүрс, жижигхэн тэрэг, түрдэг тэрэг мөн өргөн барьдаг байлаа.

Эбла хот-улсын оршин суугчид өргөл барьц өргөхөөс гадна Сикип бурханд зориулсан ариусгалын баяр, Игиш бурханд зориулсан угаалгын баяр зэрэг шашны олон баяр тэмдэглэдэг байжээ.

Эбла хот-улсын түүхэнд манай эриний өмнөх 2400 оноос 2250 он хүртэлх хугацаанд тус орныг захирч байсан таван хааны тухай шавар самбаруудад дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Манай эриний өмнөх 2350 онд хөрш зэргэлдээх дайнч Аккадын нэгдүгээр Саргон хаан Эбла хот руу халдан довтолж хааны ордны цогцолборыг шатаан түйвээжээ. Гэвч хот дахин сэргэж хоёр гурван зуун жил оршин тогтносон ч нүүдэлчдийн аймгуудын хөлд өртөж бүрмөсөн сөнөжээ.

## ПАЛЬМИР

Цөлийн сүйт бүсгүй Пальмир хотыг нээсэн гавьяа италийн эрдэмтэн Пьетро делла Валлед ногдоно. XVII зуунд аялагчид удтал явж ихээхэн бэрХШээл туулж Европ тивд буцан ирээд Сири улсад элсэн цөлд хот байгаа тухай анх ам нээхэд хэн ч итгэсэнгүй. Гэвч дараа зуунд нь Англид цөлийн хотын тухай зурагт нийтлэгдсэнээс хойш түүнийг сонирхох нь ихэсчээ. Оросын аялагч эмэгтэй Л.Пашкова францын сэтгүүлд эртний хотын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл нийтлүүлж Петербург хотын эрдэмтэн С.С.Абамелек-Лазарев гаалийн дүрмийн



тухай “Пальмирийн гаалийн татвар” гэсэн грек-арамейн бичгийг олж орчуулан нийтлүүлж шуугиан тарьжээ.

Нутгийн оршин суугчид эрт дээр үеэс Пальмир хотыг “Тадмор” буюу “сайхан, үзэсгэлэн төгс харагдах” гэж нэрлэсээр иржээ. Чухамдаа хот байгалийн сайхны үргэлжлэл ажээ. Хөх ягаан довуудаар хүрээлэгдсэн хөндийн шар элс дотроос далдуу модны орой шиг баганууд алсаас тодорно. Пальмир хотоос байшингуудын моддын навч, усан үзмийн хонгорцог, тэмээ, илжиг сийлсэн хананы хэсгүүд бидний үед хадгалагдан иржээ.

Хүн төрөлхтөний түүхэнд хачин жигтэй үзэгдэл олонтаа гардаг билээ. Тухайлбал галт уулын хайлмаг Помпейг, хүн ардын олон зуун жилийн марталт Пальмир хотыг хэвээр хадгалж өнөө үед хүргэжээ.

Хот бүлээн, хүхэр бага зэрэг амтагдсан Эфки булгаас эхлэжээ. Холын замд ядарсан аялагч, бадарчин, худалдаачид булгийн дэргэд буудаллаж, цангаагаа тайлж тэмээ, морь, илжигээ ундаалж майхан босгон хонодог байв. Аажимдаа булгийн дэргэд худалдааны дамжлага суурин бий болжээ. Дамаскаас Евфрат мөрний эрэг хүрэх жингийн цувааны замд бий болсон эл суурин өргөжин тэлсээр манай эриний өмнөх анхдугаар мянган жилд гааль, дэн буудал, цайны газар, шар айрагны газар пиг дүүрсэн хот болон хувирчээ. Худалдаачин, зуучлагч, хөтөч, тэнүүлчин, цэрэг, эмч, янз бүрийн шашны тайлгач, оргуул боол, янз бүрийн мэргэжлийн гар урчууд хотоор дайрна. Египет, Бага Азиас авчирсан боолуудыг үнэ хаялцуулан зарна. Энэтхэг, Аравиас хоол амтлагч, элдэв үнэртэн, дарс, хувцас, морины тоноглол, гутал авчирч борлуулна.

Европчууд Ялалтын гулдан хаалга гэж нэрлэсэн хоорондоо нилээд зайтай хоёр давхар хаалгыг пальмирийн уран барилгачид хоорондох зайг нь тэгш хэмтэй байлгах зорилгоор барьжээ.



Хүрмэн чулуу, гантиг, боржингоор манай эриний 200 оны орчим босгосон 20 метр өндөр гулдан хаалгыг хоёр давхар багануудаар тулжээ. Пальмир хотын худалдааны гол гудамж нь хотын нэг талаас нөгөө рүү нэвт гарсан Том багануудын гудамж байв. Нэг километр урт гудамжны хоёр талаар байх дөрвөн эгнээ, тус бүр 17 метр өндөр багануудын дор орон сууцны байшин, агуулах, лангуунууд жирийж байна.

Том багануудын гудамжны дэргэд, ион дэгийн саравчтай тагтуудаар хүрээлүүлсэн дөрвөлжин талбайд сенат, театрын барилга байна. Саравчтай тагтуудыг ром болон пальмирийн цэргийн гарамгай жанжин, тVШмэд, хотын бусад нэртэй хүмүүсийн баримлуудаар чимэглэсэн нь үнэхээр гоё харагдана.

Пальмир хотын оршин суугчид болох цөлөөр хэрэн тэнүүлчлэн явдаг хүмүүс нэгдмэл бурхныг хүлээн зөвшөөрөхгүй, олон бурхан бишрэн шүтнэ. Гэхдээ шашны ёслол хийхдээ голдуу тэнгэрийн Бэла бурхныг дуудна. Тус хотод маш олон шашны сүм дуган байдгаас нийтдээ 200 хавтгай дөрвөлжин метр талбай эзлэх Бэла бурхны сүм сүрлэг чамин байдлаараа бусдаас содон харагдана.

Вавилоны тэнгэрийг захирагч Мардук бурхны хүү Набо бурханд зориулан барьсан сүм байлаа. Нас барагсадын хувь заяаг шийддэг Набо бурхан Месопотамигаас гаралтай хийгээд финикийн Баальшамин бурхан, арабын эм бурхан Аллат, олимпийн Зевс бурхантай эв түнжинтэй аж төрнө.

Пальмир хотын үйл ажиллагааг Сенатад суудаг удирдагчид, тайлгач нар, баян худалдаачид удирдан чиглүүлнэ. Тэдний шийдвэрийг Ромоос томилогдсон амбан захирагч баталгаажуулна. Гэхдээ Адриан хааны ноёрхлын үед татварыг багасгаж амбан захирагчийн албан тушаалыг буулгаж эрх мэдлийг Сенатад шилжүүлжээ.

Он жилүүд өнгөрч Пальмир нь Ойрхи Дорнодын хамгийн сайхан хот болон мандаж түүний асар их баялаг хоорондоо дайсагнагч Парфяний болон Ромын эзэнт гүрнүүдийн шохоорхлыг татаж шуналыг хөдөлгөж байв. Нэгдүгээр зуунд ромчууд Пальмир хотыг дайран эзлэсэн ч бие даасан байдлыг нь хэвээр үлдээв. Гэвч хэсэг хугацааны дараа хотын удирдагчид Ромын сенатын шийдвэрийг дагахаа больж бүрэн бие даасан бодлого явуулж эхлэжээ.

260 онд Персийн Шапур хааны цэрэг Ромын эзэнт гүрний Валериан хааны торгон цэргийг бут цохиж хааныг олзлож Пальмир хотын хэрэмд тулан ирэв. Энэ үед ромчууд Пальмир хотын захирагч Оденатад хандаж тусламж хүсчээ. Тэгтэл хожмын түүхчидийн гайХШийг төрүүлсэн явдал болж Оденат хотынхоо шилдэг нум сумчдыг цуглуулж цус урсгасан байлдаан хийж персийн армийг бут цохижээ.

Персүүд ялагдлын дараа дахин хүчээ сэлбэж ромчуудын эсрэг байлдаан хийхэд пальмирчууд дахин гарамгай гавьяа байгуулж дийлэв. Ромын хаан талархлаа илэрхийлж Оденатийг Дорнын дэд хаанаар өргөмжилжээ. Пальмир хотын захирагч Оденат идэвхтэй үйл ажиллагаагаараа Ойрхи Дорнодод асар нөлөөтэй болж байгаад эгдүүцэж дургүйцсэн ромын удирдлага 267 онд түүнийг Эмесса хотод ажил хэрэг хэлэлцэх нэрийдлээр дуудан ирүүлж ууган хүү Геродинанийн хамт алжээ. Зарим түүхэн эх сурвалжид бичсэнээр Оденатыг алахад түүний хатан Зенобия оролцсон тухай дурдсан бий. Тэрбээр Геродианыг хойт эхийн хувьд

цааш харуулж төрсөн хүү Вабаллатдаа өндөр эрх мэдэлд хүрэх замыг нь засчээ.

Ромын Галлиен хаан Оденатын хоёр дахь хүү нас бага учир төрийн ажил хэрэг явуулж чадахгүй гэж бодсон нь буруутжээ. Ухаантай боловсролтой бэлэвсэн хатан Зенобия алдарт гүн ухаантан Кассий Лонгиний зөвлөснөөр төрсөн хүү Вабаллатаа хотын захирагчаар өргөмжлүүлж дэргэд нь байж төрийн бүх ажлыг гардан хийх болж Ойрхи Дорнодоос ромын торгон цэргийг үлдэн хөөх тааламжтай цаг ирэхийг тэвчээртэй хүлээнэ.

Тэгтэл Ромын удирдлага Пальмир хот хүчирхэгжиж магадгүй гэж эмээж эрх мэдлийг нь хязгаарлах шийдвэр гаргахад Зенобия хатан Ромд дайн зарлав.

Пальмирчууд эмэгтэй хүний удирдлага дор аян дайн мордохгүй байх гэж ромчууд тооцож байтал Пальмирийн цэргийн дарга нар Зенобия хатанд үнэнчээ илэрхийлж аян дайнд мордож Сири, Палестин, Египет орнуудыг дараалан эзлэж Босфор, Дарданеллийн хоолой хүрэв.

Пальмирчуудын аян дайны амжилтаас айсан ромчууд морин цэрэг илгээж хатны цэргийг Евфрат мөрөн хүртэл ухрааж бут ниргэж Зенобия хатныг олзлон авснаар 17 зууны тэртээ Пальмир хот унажээ. Зенобия хатны цаашдын хувь заяаны талаар олон таамаглал байдаг. Үүнд баривчлагдсан даруй алуулсан, бас алтан гинжээр дөнгөлүүлж Ромоор хотоор туулгаж байсан, дараа нь нэгэн сенатын гишүүний эхнэр болсон гэдэг.

Ромын цэргүүд Пальмир хотыг эзлэсний дараа Зенобия хатны баримлыг нурааснаас өөр зүйл огт түйвээж тоносонгүй өнгөрчээ. Хатны ордонг ромын цэргийн хуаран болгон хувиргаж цэвэр усны шинэ хоолой тавьж христос шашны дэгээр бунхан босгожээ.

Пальмирчууд гадаадынхны дарлалтай эвлэрэхийг хүссэнгүй, хэдэнтээ бослого гаргасан ч тухай бүр дарагдаж байв. Тэднийг бууж өгч бүрэн захирагдахгүй байгаад ромчууд дургүйцэж хотыг эвдэн сүйтгэжээ. Сүр сүлд нь мохсон хотоос язгууртнууд, худалдаачид, гар урчууд явж Пальмир хот жирийн нэгэн хилийн цэг, цөллөгийн газар болон хувирчээ.

Дараа нь арабууд, туркүүд ирж сууршин сууж байсан ч хотыг сэргээн босгох талаар ямар ч арга хэмжээ авсангүй, тэрчилэн олон удаагийн газар хөдлөлтөөр сүм, ордон, баганууд нурж, цөлийн элс түрэн ирж нэг мэдэхнээ хотын балгасыг даржээ.

Эртний Пальмир нь дорнын соёлын гайхамшигт төвүүдийн нэг байсан юм. Энд урлагийг амьдралынхаа хэрэгцээ болгосон, урлагийн гайхамшигийг бүтээгч хүмүүсийг бишрэн дээдэлдэг хүмүүс оршин сууж байжээ.

Цөлийн гүнд элснээс цухуйх Пальмирийн баганууд жуулчдын шохоорхлыг соронзон мэт татдаг юм. Тэнд хоёр Тадмор байдгаас нэг нь хүнгүй, мөнхийн музей нөгөөд нь 1928 оноос бедуин омгийн хүмүүс ирж сууршижээ. Сирийн Засгийн газар мөн онд шинэ Пальмир хот байгуулах тухай шийдвэр гаргаснаар шинэ байшин барилга сүндэрлэн босож шинэ гудамж, талбай баригдаж шөнийн цагаар гэрлэн чимэглэл анивчдаг болжээ. Ажилсаг оршин суугчид нь далдуу модны төгөл, цэцэрлэг бий болгож мал ахуй эрхэлж байна. Пальмирчууд эртний уламжлалаараа худалдаа хийж хивс нэхэж, үндэсний хувцсаа оёж жуулчдад арилжаална.

## САМАРКАНД

Афрасиаб гэдэг нь олон зуун жилийн хугацаанд хуучны судлалын 10-15 метр зузаан давхарга бий болсон эртний Самарканд хотын өчүүхэн хэсэг юм. Хоёр мянга гаруй хавтгай дөрвөлжин метр талбай бүхий том доворхог талбай орчин үеийн Самарканд хотын зах хавьд оршино. Шинжлэх ухааны ном зохиолд “Афрасиаб” нэрийг хоёр мянга гаруй жилийн тэртээ дундад азийн нүүдэлчдийн домогт удирдагчийн нэртэй адилтган үздэг. Түүнээс гадна энэ нэрийг Александр Македонскийн байлдан дагуулалтай холбон дурсдаг болохоор бүр Афрасиаб эртний суурин бололтой.



Эртний Ромтой нас чацуу Самаркандын соёлын эх суурь манай эриний өмнөх нэгдүгээр мянган жилд, эртний Согд улсын гол хот болох Мараканда хотод бий болжээ. Чухамдаа Спитамений толгойлсон согдийчуудын бат бэх хэрмийг манай эриний өмнөх IV зуунд Александр Македонский цэргийн гоц авьяас чадвар, ов заль хэрэглэн байж дийлжээ.

Согдын вант улс Кашуны хаант улсын бүрэлдэхүүнд багтаж байсан нэг-гуравдугаар зуунуудад эртний Мараканда хот хөгжлийнхөө оргилд хүрчээ. А.Македонскийн аян дайны ачаар Мараканда хот хүрээгээ тэлж байсан ч Дундад Азид боолын эрхт ёс хямралд орсны уршгаар уналтад оржээ. VI-VII зуунуудад тус оронд феодалын нийгмийн харилцаа гүнгийрэх тусам хотын эргэн тойронд нутгийн жижиг рыцариудын хэдэн зуун дикхан буюу шилтгээн бий болов.

Афрасиаб буурал түүхийнхээ хугацаанд олон эмгэнэл үзсэнээс XIII зуунд Монголын Чингис хааны цэрэг довтлон ирсэн нь хамгийн аймшигтай үйл явдал байлаа. Татар-монголын цэргүүд хотыг газрын хөрстэй тэгшилж хотыг тойруулан босгосон хэрмийг хуу нурааж ордон шилтгээнийг оргүй шатааж олон зууны турш хотыг цэвэр ус хангаж байсан хоолойг сүйтгэжээ.

Гэвч хот сөнөсөнгүй, XIV-XV зууны зааг дээр, аугаа байлдан дагуулагч Доголон Төмөр хаан Афрасиаб-Самарканд хотыг эзэнт гүрнийхээ нийслэлээ болгохоор шийдсэн үед сэргэн босчээ. Доголон Төмөр хааны ордонд сууж байсан Испанийн элчин сайд Рюи Гонзалес де Клавихо Самарканд хотын сайхныг магтаж ном бичихдээ “Доголон Төмөр хаан нийслэлээрээ

бахархана. Байлдан дагуулсан орон бүрээсээ олзны хүмүүс авчирч хотын хүн амын тоог нэмэгдүүлнэ, ялангуяа янз бүрийн мэргэжлийн уран гартнуудыг цөмийг нийслэлдээ ирүүлдэг байсан.” гэж онцлон дурджээ.

Олон ард түмний хувь заяаг ганц үгээр шийддэг байсан Доголон Төмөр хаан нийслэл хотоо тансаг, гоо үзэмжээрээ дэлхийн бүх хотыг давахаар болгохыг эрмэлзэж, бүхий л арга хэмжээг авч байснаар гар урлал, урлаг өндөр хөгжилтөд хүрчээ. Хааны зарлигаар Самарканд хотын эргэн тойрныг хотуудыг түүний дотор дэлхийн гайхамшигт Багдад, Дамаск, Каир зэрэг хотууд тосгон нэр авав. Хотын эргэн тойронд 13 цэцэрлэгт хүрээлэн байгуулснаас хамгийн том нь нэгэн эх сурвалжид бичиж үлдээснээр уран барилгачийн морь алдагдахад бүтэн сар эрэл сурал хийж олж байсан тийм том байжээ.

Төмөр хаалганаас дорно зүг рүү гудамжны хэлбэрээр чиглүүлэн барьсан уран барилгын цогцолбор нь гудамжны хоёр талаарх чамин гоё бунхан, шүтээний барилга байгууламжуудаас бүрдэж байлаа. Самарканд хотын захад Афрасиаб довын налууд “Шахи-Зинда” (“Амьд хаан”) мавзолейн цогцолбор байна. Энэ цогцолборыг хэн ч төлөвлөж бариагүй ч хэдэн зууны туршид бунханууд дараалан боссоор бий болжээ. Эдгээр олон бунхны анхных нь зөнч Мухаммедийн үеэл ах Кусам ибн-Аббасийнх байв. Хожим нь бунхнаа бариулсан олонх язгууртан, шашны зүтгэлтэн шинэ шашин бий болсны алдрыг магтан алдаршуулж байгуулсан энэ мавзолейд аль болох ойрхон “байрлах”-ыг эрмэлздэг байжээ.

Он цагийн уртад Төмөр хаалга аль хэдийнээ байхгүй болж тэрчилэн түүний цаана сүндэрлэн байсан Доголон Төмөр хааны дурсгалын сүм, өөдөөс нь харуулан босгосон Сарай-мульк-ханым бунхан мөн үгүй болжээ. Зөвхөн балгас нь үлдсэн босгосон Сарай-мульк-ханым бунхныг домогт үзэсгэлэн төгс Биби-ханым хатны нэртэй холбож ярьдаг юм.

Доголон Төмөр хаан олон хатан дотроос үлэмж төгс Биби-ханым хатандаа илүү хайртай байв. Аугаа байлдан дагуулагчийг аян дайнд явсан хойгуур Биби-ханым хатан Самарканд хотын шилдэг уран барилгачдыг цуглуулж тэд нар нь тэнгэрийн оддын заасан цагт сүм барих ажилд шамдан оржээ Сүмийн гол уран барилгач залуу Биби-ханым хатны гоо сайхан унаж сүмийн хана босож бөмбөгөр орой тэнгэр өөд цоройж гулдан хаалганы саравчтай тагтыг л хийх үлдээд байхад, хатныг харж байх хугацааг сунгах зорилгоор зориуд удна.

Энэ үед Самарканд хотод элч ирж хаан ирж айсууг мэдэгдэв. Биби-ханым хатан сүмийн барилгыг хаан нөхрөө ирэхэд бүрэн дуусгахыг хүсэж залуу уран барилгачийг шавдуулахад өөдөөс нь зориг гаргаж ганц үнсүүлбэл үлдсэн ажлыг үтэр түргэн дуусгах болзол тулгав. Биби-ханым хатан хацартаа дэр тавьж үнсүүлэхийг зөвшөөрөхөд залуу уран барилгач татгалзсангүй. Залуу эрийн үнсэлт тачаангуй байсан тул хатны хацарт түүний уруулын ор үлджээ.

Харгис Доголон Төмөр хаан нийслэлдээ буцан ирээд хайртай хатны хацарт нь өөр эрийн үнсэлтийн ор байгааг харуут багтартлаа уурлаж буруутныг нэн даруй баривчилж авчрахыг тушаав.

Гарцаагүй үхэл хүлээж байгааг мэдсэн уран барилгач залуу сүмийн орой өөд авиран гарч урьдчилан урласан далавчаар тэнгэр өөд нисэн оджээ.

Доголон Төмөр хааныг Регистан талбай дахь жижиг цөөрмийн дэргэд барьсан Гур-Эмир мавзолейд оршуулжээ. Анхандаа хааны хайртай ач хүү Мухаммед Султанд зориулан босгосон мавзолейд хаан түүний хүүхдүүд, түүний бас нэг ач хүү, дундад зууны үеийн гарамгай эрдэмтэн Улукбекийг оршуулсан байна. Мавзолейн 40 метр өндөр цэнхэр бөмбөгөр орой алсаас тод харагдах хийгээд зааны ясаар чимэглэсэн модон хаалгаар орж ёслолын танхимд хүрнэ. Нарны туяа гантиган сараалжны завсраар шарил дээр байрлуулсан найман хавтан дээр тусна.

Хуучин Самарканд хотын Регистан төв талбайгаас Хуучин хотын бүх нутаг дэвсгэрийг тэгш хэмээр зүссэн гудамжууд тал бүр тийш салаална. Эрт дээр цагт талбайгаар элсэн давалгааг хаасан том суваг дайран гардаг байсан учир Регистан буюу “элсэн талбай” гэж нэрлэжээ.

ХҮ зуунаас өмнө худалдаа-гар урлалын том төв байсан Регистаныг 1409-1447 онуудад Самаркандын захирагч байсан Улубек хааны үед албан ёсны арга хэмжээ зохиодог талбай болгож хааны зарлигийг дуудан сонгож цэргийн жагсаалын үзлэг хийдэг байжээ.

Өнөөдөр Регистан талбайд XVII зуунд барьсан Шир-Дор, Тилля-Кари хэмээх хоёр сүм, ХҮ зуунд эрдэмтэн Улукбекийн үед босгосон лалын шашны сургууль нийтдээ гурван байгууламж сүндэрлэж байна. Эртний эх сурвалжид тэмдэглэснээр Улукбекийн шашны сургуулийн урд талд нөлөө бүхий баян язгууртан Алике-Кукельташ хөрөнгө гаргаж бариулсан хотын гол сүм оршино. Түүнээс холгүй Дундад Азид хамгийн шилдэг, хамгийн сайханд тооцогдож байсан халуун усны газар байжээ.

1420 онд нэрт эрдэмтний заалтаар барьсан Улукбекийн лалын шашны сургуулийн дөрвөн буландаа бөмбөгөр оройтой цамхаг бүхий тэгш өнцөгт хэлбэртэй байшин нь дотоод гоёмсог чимэглэл, чамин гоё шигтгэмэл, тэгш хэмтэй хээ угалз, одод анивчсан тэнгэрийн зургаараа алдартай шинжлэх ухааны жинхэнэ сүм байлаа. Гэвч цаг хугацаа гайхамшигт эрдмийн ордныг хайрласангүй, хоёрдугаар давхар, бөмбөгөр орой нь үгүй болжээ.

Гарамгай эрдэмтэн Улукбекийн үед Самарканд Дундад Азийн шинжлэх ухааны амьдралын төв байсан болохоор нэрт математикч, одон оронч, түүхчид хуран цуглардаг байв. Улукбек сургууль, одон орныг судлах оргилдоо багш нараа биечлэн сонгож авдаг байв. Худалдаачид, гар урчууд, аялагчид, яруу найрагчид, дипломатууд “дэлхийн үнэт сувд эрдэнэ” болох Самарканд хотыг үзэж танилцахаар алс холоос ирдэг байлаа.

## ФИВЫ

Библийн сударт Но гэж нэрлэдэг Уасет хотыг грекүүд “зуун хаалгат Фивы” гэж дуудна. Нил мөрний баруун эрэг дээр орших фараонуудын алдарт нийслэлд Амон бурхны сүмүүд, фараонууд, өндөр тушаалын тVШмэдийн ордон, өргөө сүндэрлэж давчуу харанхуй сэрүүн гудамжуудад хөл хөдөлгөөн ихтэй байжээ.

Гэтэл зүүн эрэг дээр орших хэсэг нь шал өөр дүр төрхтэй, нам гүм ажээ. Тэнд мөн сүрлэг ордон, сүм байх авч нэг нэгнээсээ хол, жижигхэн шавран байшингуудын хүрээлэлд байна. Гэхдээ энэ эрэгт олон мянган завь, чиргүүл буудаллана. Зарим завь, чиргүүлээр шарил зөөн авчирч буулган оршуулгын цуваа уулын бэлээр явж хөндий рүү орно. Энэ бол өөр Фивы, үхэгсэдийн хот билээ. Хаадын хөндийд нийтдээ 62 бунхан байгаагаас дийлэнх нь фараонуудынх ажээ. Эдгээр бунхныг цөмийг нягтлан судалсан учир жуулчдад чөлөөтэй үзүүлдэг болжээ.

Хаадын хөндийн яг голд Сиптах фараоны бунхан байна. Энэ бунхны урт нь хонгилтойгоо нилээд 105 метр байгаа нь бусад фараоны бунхнаас хавьгүй илүү юм. Том австай энэ бунхныг үнэхээр чамин гоё чимэглэжээ.

Үнэндээ бол Фивы хот эртний соёл иргэншлийн гэрэл гэгээ, эртний бунхнуудын гайхамшигийг хүн төрөлхтөнд үзүүлсэн асар их гавьяатай юм. Шинэ хаанчлалын (манай эриний өмнөх 1580-1085 он) үед хот хөгжлийнхөө оргилд хүрчээ. Фивийн урлаг нь улс орны доторх төвлөрсөн эрх мэдлийг бэхжүүлэх түүний гадаадад үзүүлэх нөлөөг өргөжүүлэхэд чиглэж байлаа. Тийм учраас фараон бүр нийслэл, сүм, ордноо улам сайхан, гоёмсог болгохыг эрмэлздэг байлаа.

XIX угсааны фараонуудын хаанчлалын үед гаднаас нь харахад нам тайвуун байгаа мэт санагдах авч фараонууд язгууртнууд, тайлгач нар хоорондоо ач тач тэмцэлдсээр байлаа. Хоёрдугаар Рамсес фараон Амон бурхны улам газар авсаар байгаа нөлөөг шууд зогсоож зүрхлээгүй ч түүний нэр хүндийг бууруулахыг хичээж байв. Тэгээд фараон дээд тайлгачийн үүргийг заримдаа биечлэн гүйцэтгэж заримдаа түүний албан тушаалд өөр хотоос итгэлтэй хүнээ авчирч томилж ёслолыг удирдуулан хийлгэдэг байлаа.

Фивы хотод Нарны бурхан Амон-Ра-д зориулсан Карнак, Луксор хэмээх хоёр том сүм байв. Мөнхийн залуу, хүчирхэг Нарны бурхан өглөө бүр тэнгэрт мандаж газар дээр байгаа амьд бүхэнд амьдрал жаргал хайрлана, орой бүр маргааш нь өглөө нь дахин мандахаар хөгшрөн үхнэ. Бурхад дараа нь дахин сэргэн төрөхийн тулд хөгширч үхэх амьдралын жамыг хүмүүст урьдчилан зааж өгчээ.

Амон бурхны Карнак сүмийн хажууд ариун нуур ухаж гаргажээ. Энэ сүмийг өргөжүүлж Ахетатоны ялагдсаны дараа Амон бурхны шүтэн бишрэхийг аугаа гайхамшигийг харуулах, фивийн тайлгач нарын эрхэм тэмүүллийг гүйцэлдүүлэх тэрчилэн фараонуудын шинэ угсааны хүчирхэг хүчин чадлыг алдаршуулах зорилго тавьжээ. Энэхүү бүтээн байгуулах үйл ажиллагааны далайц үнэхээр их байлаа. Багана, гулдан хаалга, баримлыг урьд нь тийм асар том хэмжээтэй бүтээж байсангүй, сүм хийдийн чимэглэл урьд нь тийм гоёмсог тансаг

байсангүй ажээ. Карнак сүмийн саравчаар битүүлсэн 5000 хавтгай дөрвөлжин метр талбай дээр хатууруулсан элсээр гурван давхар байшингийн хэртэй өндөр асар том баганууд босгожээ.

Сүмийн том танхимыг нэгдүгээр Сети фараоны үед эхлэж түүний хүү Рамзес дуусгажээ. Бүх баганыг фараонуудын ялалт байгуулсан аян дайны сэдэвтэй болон энхийн бүтээн байгуулах үйл ажиллагааг харуулсан товгор дүрсүүдээр чимэглэжээ. Эрдэмтэн Г.Вильсон эдгээр товгор дүрсийн туульсийн шинж чанарыг ажиглаж суут зохиолч Гомер Египет оронд байхдаа энэ дүрслэлийг харж алдарт “Илиада” туульсын байлдааны үзэгдлийг бичсэн байх гэсэн таамаглалыг дэвшүүлж байна.

Саравчаар битүүлсэн танхимд 21 метр өндөр, тойргийн урт нь 10 метр орчим 12 ширхэг “зэгсэн багана” байна. Багана бүрийг таван хүн тойрч гараа сунгахад хүрэхгүй байжээ. Багануудын дээд хөвөөг зэгсний дэлбээлж байгаа цэцгийн хэлбэрээр урлажээ.

Хоёрдугаар Рамзес фараоны бүтээсэн сүм урьд өмнө нь барьсан бүх сүмийг бүх үзүүлэлтээрээ хол давж гарсан билээ. Нэг уран барилгач үхэхэд нөгөө нь орыг нь эзлэж хэдэн арван мянган боол ажлын ачааллыг даахгүй өөд болоход дараачийн ээлжийг нь туун ирж фараонууд, бурхдын хүчирхэг хүчин чадлын билэгдэл болох сүм сүндэрлэн боссоор байжээ.

Карнакийн сүмийн уран барилгын хэлбэрт хуучин, шинэ дэгийг чадамгай хослуулсныг тэмдэглэх нь зүйтэй. Эхнатон фараоны үед зориуд тасласан уран барилгын уламжлалыг сэргээж гэхдээ Ахетатоны дараа египетийн уран барилгад бий болсон шинэ бүхнийг улам төгс болгохыг эрмэлзэж байв.

Фивийн тайлгач, дээд язгууртнууд Эхнатон фараоны үед ялагдал хүлээсэн үеэс хадгалагдаж ирсэн бүхнийг үгүйсгэхийг эрмэлзэж байлаа. Тэрбээр шашны сургаалд заасан хатуу дэгийг баримталж гэхдээ урлагт түүнээс хазайхыг тэвчдэггүй байв. Энэ чиглэл баримтлал нь хаадын баримлыг бүтээхэд тод тусгалаа олжээ. Урьдын уран баримлын дүрүүдийн зэрэгцээ фараонууд тэдний хатдын иргэний агуулгатай дүрүүд бий болов.

Тийм баримлуудын шилдэг нь одоо Италийн Турин хотод хадгалагдаж байгаа хоёрдугаар Рамзес фараоны баримал юм. Уран барималч хүчирхэг харгис фараоны баримлыг бүтээхдээ тавьсан зорилгоо шинэ аргаар шийдвэрлэжээ. Энэ барималд урьд нь албан ёсны урлагийн шаардлагаар дүрсэлдэг шиг төвийсөн булчин шөрмөс, зузаан хүзүү байхгүй, алсыг ширтсан хурц хараа ч алга, харин хорвоогийн жирийн эр хүн шиг энгийн байдалтай, өдөр тутмын хувцастай, хөлдөө сийрсэн шаахай өмссөн байна. Гэхдээ толгойгоо үл мэдэг хажуулдуулж доошоо эгц ширтсэн сүрлэг байдлаараа үнэхээр хязгааргүй эрх мэдэлтэй фараон, Египет улсын харгис дарангуйлагч, “Ра бурхны хүү” болох нь илт мэдэгдэнэ.

Амон-Ра хоёр дахь шүтээн нь Луксор дахь ханыг нь алтаар доторлож шалыг нь мөнгөөр бүрсэн сүм юм. Карнак, Луксор сүмүүдийг хооронд нь чулуугаар сийлж урласан хонин толгойтой арслангийн биетэй аймшигт амьтан бүхий 3 километр урт өргөн чөлөөгөөр холбожээ. Баяр, шашны ёслолын үеэр Амон бурхны баримал байрлуулсан ариун том завь нэг сүмээс нөгөөд явдаг болохор энэ өргөн чөлөөг “бурхдын гудамж” гэж нэрлэнэ.


“Орднуудын хот”, “бүх дэлхийд алдар суу нь түгсэн” алдарт хүмүүс амьдран сууж байсан Луксор нь өнөөдөр хэдэн арван мянган хүнтэй шороо тоос пүрхийсэн бяцхан хот ч дэлхийн аль хот түүний нэр хүндэд атаархана.

Манай эриний өмнөх 663 онд Фивы хотыг Ассирийн Ашшурбанипал хааны цэрэг эвдэн сүйтгэжээ. Гэвч цэнхэр тэнгэрийн дор алсаас тодрох байгаа Луксор, Карнакийн сүмүүдийн сүрлэг балгас очсон хүн бүрт мартагдашгүй сэтгэгдэл төрүүлсээр байна.



## БУХАР

Ханхүү Сиявуш ирж Афрасиаб хааны охинтой гэрлэж цайз барьсан нь яваандаа Бухар хот бий болсон тухай эртний нэгэн домогт өгүүлсэн бий. Хоёр мянга гаруй жилийн түүхтэй хотын дундад зууны үеийн тухай тодорхой судалгаа байдаг ч эртний түүхийн тухай мэдээлэл маш хомс юм. Хуучны судлалын малталтаар өнөөгийн хотын нутаг дэвсгэр дээр эрт дээр цагт томоохон суурин байсныг тогтоожээ.



VI зуунд түркийн удирдагч Шири-Кишвар ядуучуудын бослогыг дарж нийслэлээрээ зарласан үед Бухар хот бий болжээ. Хөндий талаар мурилзан урсаж зэгсэнд төгөлд далдардаг Зеравшан голын адагт тэр үед Нумижгат гэж нэрлэгдэж байсан хот байрлаж байв. Хотын хүн амын үндсэн хэсэг нь ирак гаралтай хүмүүс байсан хийгээд тэд зороастризм шашныг шүтдэг байсныг нь тэнд байсан галын шүтээн гэрчилнэ.

VII зуунд Бидун захирагч цайзыг сэргээж түүн дотор Долоон бурхан одтой адилхан шилтгээн барьжээ. Чухамдаа тэр үеэс Арк цайз феодалын Бухар хотын цөм болж түүний дотор өргөө, ордон, Засгийн газрын тамгын газар, сүм, Эрдэнэсийн сан, шорон байрлуулжээ. Тэгээд цайзын эргэн тойронд шахристан буюу дөрвөн өнцөгт хэрмээр хүрээлүүлсэн хот бий болжээ. Цайзын баруун талд Регистаны талбай байх хийгээд түүний цаана сайтар бэхэлсэн шилтгээнүүд бүхий феодалуудын эдлэн газрууд үргэлжилнэ. Хэрмийн дээх нь талд рабад буюу худалдаа-гар урлалын дагуул хот бий болж 850 онд түүнийг тойруулан мөн хэрэм босгожээ.

Гэвч эдгээр хэрэм нь тэднийг Арабын халифийн дайралтаас хамгаалж чадсангүй. Арабын цэргийн жанжин Кутейба хотыг эзлэн авмагц байшин барилгуудын талыг арабын цэргүүдэд сайн дураар өгөх, хотын ойр орчмын тосгодын оршин суугчид цэргүүдийг хоол хүнсээр агт морьдыг тэжээлээр хангаж байх тушаал буулгажээ.

Арабууд бараг зуу гаруй жил ноёрхсон нь хотын амьдралд тусгалаа олжээ. Хотын оршин суугчид тэрэмгийлэгчдийн эсрэг олонтаа бослого гаргаж байсан ч “залхатлаа хамгаалалт хийснээс хатуу болзолтой энхийн гэрээ байгуулах нь дээр” гэсэн зарчмыг тухай бүр баримталж байснаар хот бараг сүйдсэнгүй өнгөрчээ.

Арабчуудын дараа монголчуудад ирж цэцэглэж байгаа хотыг балгас болгон хувиргажээ. Олон хоног үргэлжилсэн түймэрт хотын дийлэнх хэсэг шатаж тойпуугаар барьсан хэдхэн сүм, ордон л хэвээр үлджээ.

Гэвч ямар ч дайн байлдаан, нутгийн феодалуудын зөрөлдөөний дараа Бухар хот сэргэн босож түргэн хөгжиж байлаа. Доголон Төмөр хаан эзэнт улсынхаа нийслэлээр Самарканд хотыг сонгож улс төрийн ач холбогдол нь буурсан ч Бухар хотод бүтээн байгуулалт тасралтгүй өрнөсөөр байжээ.

Бухар хотод байгаа хамгийн эртний түүхэн дурсгал нь Саманидуудын мавзолей юм. IX-X зууны үед Бухарыг захирч байсан Самани угсааны хаадын энэ мавзолей нь уран барилгын зохиомжийн хувьд дээр нь хагас бөмбөлөг байрлуулсан шоо юм. Хананы өргөн нь бараг 1,8 метр зузаан болохоор өнөөг хүртэл хадлагдан иржээ. Мавзолейн нүүрэн талууд нь цөм адилхан, хана бүрийн дунд хэсэгт, тойпуун тойргуудаар хийсэн тэгш өнцөгт гуунд хийсэн сумархуу хэлбэрийн том нуман хаалга байна. Мавзолейн дээд хэсэгт том нумархуу хэлбэрийн цонхнууд бүхий нуман хаалга хийжээ. Тийм цонх тал бүрт нь арав байна.

Бухар хот руу аль ч талаас нь орж ирэхэд хамгийн түрүүнд нүдэнд тусдаг Калян буюу “Их сүм” бараг есөн зуу гаруй жилийн настай билээ. Цайзын хананы дэргэд байсан сүм хуучран нурж нөгөө нэг лалын шашны сүмийг хотод ойртуулан барьсны дараа Арслан хаан энэ сүмийг бариулжээ. Сүм нь болсон гөлтгөний уусмалаар бэхжүүлсэн дөрвөлжин хэлбэртэй шатаасан тоосгоор хийсэн, дээшлэх тусам аажмаар нарийсах нүсэр баганын хэлбэртэй юм. Баганын дээд хөвөөгөөр сумархуу хэлбэрийн 16 цонхтой дэнлүү хэлбэрийн танхим байрлуулжээ.

Сүмийн цамхаг доторх 105 гишгүүр бүхий нарийхан, эгц шатаар өгсөж оройд нь байгаа дугуй хэлбэрийн байгууламж дотор ороход, хот бүхэлдээ харагдана. Дугуй хэлбэрийн байгууламжийн 16 цоорхойгоор мөргөл хийж байгаа сүсэгтнүүдийн дуу хоолой өдөрт таван удаа хадна.

“Их сүм”-ийг шашны бус зориулалтаар мөн ашиглаж байв. Цамхагийн оройд цэргүүд өдөржин шөнөжин харуул хийж дайсан ойртон ирж байгаа эсэхийг хянадаг байжээ. Сүмийг хожим нь XVIII-XIX зуунуудад нийтийн цаазын газрын зориулалтаар ашиглаж гэмт хэрэгтнүүдийг 46 метрийн өндрөөс доош чулуун талбай руу шидэж цаазалж байсан учир “Үхлийн цамхаг” гэсэн нэр бас авчээ.

Калян сүмийг олон удаа сэргээн засварлаж байснаас Дундад Азид Шейбаниды угсааны хаад ноёрхож байсан үед 1514 онд барьсан байдлаараа өнөөг хүрчээ. Дундад Ази дахь сүрлэг сүмүүдийн нэг болох энэ сүмийг мөн “Жума сүм” гэж нэрлэдэг ажээ.

Нийтдээ 180\*130 метрийн харьцаатай хавтгай дөрвөлжин метр талбайтай Калян сүм нь саравчаар хүрээлүүлсэн уламжлалт хашаатай юм. Хашааны эргэн тойронд том шонгууд дээр байрлуулсан 288 бөмбөгөр орой бүхий бөмбөгөр оройтой бүүдгэр саравчууд дотор ороход нуруу хүйт даана. Баяр ёслолын үед сүмд арван мянга орчим сүсэгтэн цуглардаг байна.

XVI-XVII зууны үед Бухар хот хөгжил цэцэглэлтийнхээ нэгэн оргилд хүрсэн нь түүний уран

барилгын дэг маягт тусгалаа олжээ. Хот үндсээрээ өөрчлөгдөж хотын өвөрмөц дүр төрх болох цогцолборууд бий болсон нь манай үе хүртэл хадгалагдан иржээ. Хуучин Бухар хотын хэрмийн дотор гудамж, талбай, байшингуудын хоорондох зай дэндүү давчуу байдаг тул бүр X зуунд муухай үнэр танараар нь хотыг “жорлон” гэж нэрлэдэг байсан нь нууц биш ээ. Түүнээс гадна хотын гулдан хаалганы цаана байгаа оршуулгын газар нь XVI зууны үед хотын гортиг дотор багтах болсон нь байдлыг улам хурцатгажээ.

Тийм учраас уран барилгачид хурц ухаан гаргаж хоёр-гурван давхар сараалжин байшингуудын төсөл зураг гаргадаг болжээ. Тухайлбал еврей иргэдийн суудаг хороололд олон давхар байшингуудыг дотроо худаг бүхий хашаатай, нэг нэгэнд нь тулган, дээш цоройсон байдлаар барьсан байна.

Бухар хот нь тус бүр нь он цагийн уртад бүрэлдэн бий болсон захиргаа-ахуйн өвөрмөц дэг жаяг бүхий гузар буюу хороололд хуваагдана. Хорооллууд нь тэнд оршин суудаг хүмүүсийн эрхэлдэг гол ажил төрлөөр нэрлэгдэнэ. Үүнд Пухтабофон хороололд шилдэг оёдолчид, Ахгачид хонь, ямаа, бяруу хөнгөлөгчид, Зубдад анхилам үнэртэй өвсний худалдаачид, Лойхураконд шаварчид голдуу сууна.

Регистан талбай дахь Эмирийн ордон нь дан гулдан хаалга бүхий жижигхэн ч өндөр, нэвгэршгүй цайз юм. Дундад зууны үед эгц өгсүү цамхагийн хаалга, битүү хонгилоор явж, жижигхэн налуу талбайгаар дамжиж ордон руу ордог байжээ. Ордны нэгэн хананд тэртээ дээр гаргасан жижиг цонхоор эмир ард түмэндээ харагддаг байжээ. Тэр цонхны дор байх жижигхэн саравч дотроос их бууны ам ёрдойн харагддаг байжээ.

Гулдан хаалганы хажууд эмирийн хязгааргүй эрх мэдлийн билэгдэл болох камчин буюу том ташуур өлгөөстэй байна. Гулдан хаалганы дээд давхарт Кокандаас олзолж авчирсан хананы цагийг байрлуулсан байх хийгээд уг хананы цаг хоногийн цаг бүр дуугарна. Шашны баяр, эмир ордноос гарах ирэх үед, цэргүүдэд мөнгөн шагналыг нь олгох үед цайз дотор найрал хөгжим тоглодог байжээ.

Цайз дотор налуу жижиг талбайны дор канахоны буюу хоригдлуудын өрөөнүүд байв. Кана хэмээх персийн жоомууд хоригдлуудын биеэнд шигдэж их зовоодог байжээ. Орцны баруун талд орших саравч дор нууцаар янагласан, эмэгтэйчүүдийн эртний мэргэжил “эзэмшсэн” бүсгүйчүүдийг тамлан алдаг байжээ. Эмирийн ордны орцны өмнөх талбайд хуран цугларсан олны нүдэн дээр хоригдлуудын хоолойг хутгаар хэрчин амийг нь хороодог байжээ.

Эмирийн ордноос холгүйхэн Доголон Төмөр хааны “Цагаан шилтгээн” нэртэй эртний ордноос үлдсэн цамхаг, өндөр шон харагдана. Хааны гараас салхинд хийссэн бичгийг барьж авахаар дөчин тVШмэл тэр шонгоос усэрч амиа алдсан байсан тухай домог бий.

Эртний Бухар хотын алдар нэр өнөөдөр жуулчдын анхаарал шохоорхлыг гойд их татаж байна. Эрт дээр үеийн 140 гаруй түүхэн дурсгал хотод бий. Бухар шиг олон нэртэй байсан хот дэлхийд бараг үгүй биз ээ. Оросын эрдэмтэн Б.Бартольд “Бухар” нэр нь санскрит хэлний “Бихара” буюу “сүм” гэсэн үгнээс гаралтай гэж үзэж байна. Хотын авьяаслаг уран гартан, уран барилгач, аугаа эрдэмтдийг хүндэтгэж Дорно даяар “бухара-и-Шариф” буюу “Эрхэмсэг Бухар” гэж бахархан дээдэлсээр иржээ.

## АФИН

Грекчүүд чидун жимсний модыг амьдралын мод гэж бишрэн шүтнэ. Уул нуруу, тэнгисийн хооронд шахагдсан грекийн хөндий тал, чидун жимсний модны төгөл усан үзмийн бутнуудтай орооцолдон байдаг уулсын хадархаг налуууг чидун жимсний модгүйгээр төсөөлөх аргагүй билээ. Чидун жимсний мод уулсын орой өөд мацан ургаж хээр талыг бүрхэж шаравгар хөрсийг нь ногоон өнгөөр хучна.



Грек улсын нийслэл эргэн тойронд нь оршдог Акрополь довыг ариун мод мэндэлсэн газар гэж үзнэ. Ер нь бол эртний хотуудыг өндөр хадархаг уулын хажууд байгуулж оршин суугчдыг нь гадны халдан довтолгооноос хамгаалах зорилгоор цайз босгодог байв.

Афин хот байгуулагдсан цаг хугацаа нь нэн эртний үед хамаарна. Манай эриний өмнөх 1825 онд тус оронд ирсэн Аттикийн анхны Кекроп хаан Акрополь дов дээр хааны ордон бүхий цайз босгожээ. Түүний үед Аттикийг эзэгнэхийн төлөө Посейдон бурхан, Афина эм бурхан хоёрын хооронд маргаан гарч хоёул хотод бэлэг сэлт авчрахад Зевс тэргүүтэй олимпийн бурхад шүүгчээр байжээ. Посейдон бурхан сэрээ таягаар хад цохиход хаднаас шорвог ус олгойдон гарч Афина эм бурхан жад газарт хатгахад чидун жимсний мод ургажээ. Бүх бурхан Посейдоныг, эм бурхад, Кекроп хаан Афинаг дэмжжээ. Өөр нэг хувилбараар бол Посейдон морь бий болгож түүнийг нь Аттикийн оршин суугчдад чидун жимсний модноос ашиг тус багатай гэж үзжээ.

Ялагдсандаа уурласан Посейдон бурхан хотын эргэн тойрон орших хээр тал нутагт тэнгисийн хүчит давалгаа илгээж хотын оршин суугчид Акрополь дов дээр гарч амь хэлтэрчээ. Аянгын бурхан Зевс хотын оршин суугчдыг өмөөрч хотын иргэд ч Посейдон бурханд хандаж Сунийон хошуу дээр өөрт нь зориулсан сүм босгоно гэсэн амлалт өгч байж түүнийг номхруулжээ.

Хот анхандаа цайзаас бүрдэж байсан бөгөөд нүүдэлчин омгуудын халдлагаас зугтсан хүмүүс ирж түүний эргэн тойронд сууршижээ. Нүүдэллэн ирсэн хүмүүс манай эриний өмнөх 1350 онд ардын баатар Фезейгийн удирдлагаар цайзтай нэгдэж хот бий болжээ.

Дарангуйлагч Писистрит хаан Акрополь цайзыг шүтээн болгон хувиргажээ. Тэрбээр хаанаар

өргөмжлөгдсөнийхөө дараа ухаантай хүний хувьд ажилгүйдэл нь хуйвалдаан өдөөх шалтгаан болж магадгүй гэж болгоомжилж ордондоо бүх ажилгүйчүүдийг цуглуулж яагаад гар хамхин сууж байгаа учрыг нь асуун шалгааж шар үхэргүй, үрийн будаагүй ядуучууд газар хагалж тариа тарих боломжгүйг ойлгожээ. Тэгээд Афин хотын оршин суугчдыг ажлаар хангахын тулд өргөн далайцтай бүтээн байгуулалт өрнүүлжээ. Кекроп хааны ордны буурин дээр Афина эм бурханд зориулсан Гекатомпедон сүм байгуулж түүнийг барихад оролцсон бүх боолыг чөлөөт иргэн болгож тараан явуулжээ.

Тэр үед Афин хотын төв нь Агора захын талбай байв. Уг талбайд худалдааны лангуунууд эгнэн оршдог төдийгүй ардын, цэргийн, шүүхийн хуралдааны танхимууд, сүм, шүтээн, театрууд байрладаг учир хотын нийгмийн амьдралын голт зүрх байв. Писистрат хааны үед Агора талбайд Аполлан, Зевс бурхдын сүм, есөн урсгалтай Эннеакрунос усан оргилуур, бадарчид хоргоддог Арван хоёр бурхны шүтээнийг баригджээ.

Гэхдээ Олимпын Зевс бурхны сүмийг барих ажил цэргийн, эдийн засаг, улс төрийн зэрэг олон шалтгаанаар хэдэнтээ саатаж байсан хийгээд манай эриний өмнөх Ү зуунд сүм барихад зориулсан барилгын материалыг нь хотын хэрэм босгоход хэрэглэжээ. Сирийн IV Антиох Эпифан хааны үед, манай эриний өмнөх 175 онд сүмийн барилгын ажил сэргэж шүтээн, баганууд нь баригдсаны дараа ажил нь бас л зогсчээ.

Манай эриний өмнөх 86 онд ромын байлдан дагуулагч Сулла Афин хотыг эзлэн сүйтгэж хэд хэдэн багануудыг нь Ром нь зөөн аваачиж Капитолийн дов дээр байрлуулжээ. Хэмжээгээрээ хөлбөмбөгийн талбайтай тэнцэх том талбай бүхий сүмийн барилга Адриан хааны үед л сая нэг дуусчээ.

Сүмийн шүтээний танхим дотор алт, зааны ясаар урласан Зевс бурхны асар том баримал, сүмийн ард талд Адриан хааны дөрвөн баримал байв. 1852 онд болсон газар хөдлөлтийн уршгаар Олимпын Зевсийн сүмийн нэг багана нурсан нь өнөөдөр ч яг хэвээр байна. Европ тив хамгийн томд тооцогдож байсан 104 баганаас нь дөнгөж 15 ширхэг нь л босоо хэвээр байна.

Хожим нь персүүд нураасан Парфенон бурхны алдарт сүмийн шавыг Писистрат хаан тавьжээ гэж эрдэмтэд үздэг. Периклийн хаанчлалын үед манай эриний өмнөх 447-432 онуудад цуут уран барилгач Иктин, Калликрат нарын төслөөр сүмийн барилгыг сэргээн барихдаа түрүүчийн сүмээс хоёр дахин томсгожээ. Сүмийн дөрвөн талд гоолиг гоёмсог багануудын завсраар цэнхэр тэнгэр харагдана.

Парфеноны сүмийн уран баримлын чимэглэлийг хийхэд грекийн нэрт уран гартнууд оролцсоны дотор бүх цаг үеийн аугаа уран барималч Фидий байлаа. Фидий сүмийн чимэглэлийн зохиомжийг боловсруулж зарим чимэглэлийг нь гардан хийжээ. Сүмийн танхимын гүнд хоёр давхар багануудаар гурван талаас нь хүрээлүүлсэн Афина эм бурхны сүрлэг баримал дүнхийж байна. Түүнийг алдарт Фидий бүтээжээ. Афина эм бурхны хувцас, илд, бамбайг шижир алтаар гар, нүүр царайг цав цагаан зааны ясаар хийжээ.

Акрополь цайз доторх Эрехтейон сүмийн цогцолборын урд талд хананы дэргэд дэлхийд цуутай, гантиг сийлэн урласан зургаан бүсгүйн баримал саравчийг тулан байна. Афин хотыг

эзлэсэн туркүүд бүсгүйчүүдийн баримлын гоосайхныг биширч хүн дүрслэхийг хориглодог лалын шашны ёс дэгийг баримталдаг ч тэдэнд гар хүрсэнгүй, зөвхөн нүүр царайг нь хусаж танигдахгүй болгожээ.

Акрополь цайз руу ордог цорын ганц орц нь өргөн шаттай, баганат Пропилей хаалга юм. Домогт өгүүлдэгээр Акрополь цайзанд газар доогуур тавьсан хонгилоор явж нэгэн агуйгаар дамжиж орж болно, 2500 жилийн тэртээ Персийн Ксеркс хааны цэрэг Грек улсад халдан довглоход ариун могой тэр хонгилоор мөлхөж Акрополь цайзаас гарч амь аврагдаж байжээ.

Эртний Грек оронд Пропилей (“хаалганы өмнө зогсож байгаа” гэсэн утгатай үг) гэж талбай юм уу цайз руу баяр ёслолын байдлаар чимэглэсэн орцыг нэрлэдэг байжээ. Манай эриний өмнөх 437-432 онуудад уран барилгач Мнесиклийн урласан Афин хотын Акрополь цайзын Пропилей нь хамгийн төгс төгөлдөр төдийгүй тийм уран барилгын дэгийн хамгийн сонгодог байгууламж гэж тооцогдоно. Туркүүд Афин хотыг эзлэсний дараа Пропилейг даринь агуулахын зориулалтаар ашиглаж байжээ.

Цагтаа Акрополь цайз руу орох хаалганы хамгаалалтын зориулалтаар барьсан цамхагийн өндөр тавцан дээр грек-персийн дайны сэдэвтэй намхан товгор дүрсүүдээр чимэглэсэн ялалтын Ника Аптерос эм бурхны жижигхэн ч чамин гоё сүм байна. Сүмийн дотор байрлуулсан Ника эм бурхны алтадмал баримал үнэхээр үзэмж төгс байсан тул грекчүүд түүнийг нисэж одохоос нь сэргийлж уран барилгачид нь хандаж далавчгүй хийхийг гуйсан ажээ.

Пропилей хаалгаар ороход суут Фидийн урласан дайнч эмэгтэй Промахосын 9 метр өндөр баримлыг голд нь байрлуулсан Акрополь цайзын төв талбай байна. Уг баримлыг Марафоны дэргэд персүүдээс олзолсон зэвсгийг хайлуулж урласан байна. Баримлыг өндөр тавцан дээр байрлуулсан болохоор эм бурхны алтадмал үзүүр наранд гялтганаж далайчдад нэг ёсны гэрэлт цамхаг шиг алсаас харагддаг байна.

395 онд Византийн эзэнт гүрэн Ромоос тусгаарлахад, Грек түүний бүрэлдэхүүнд орж 1453 он хүртэл түүний захиргаанд байжээ. Тиймд Парфенон, Эрехтейон зэрэг олон алдарт сүмийг христос шашны сүм болон хувиргажээ.

Х зуун гэхэд хотын хүн ам цөөрч өнгөрсөн үеийн сүрлэг том байгууламжийн хүрээлэлд амьдран суух нь тохиромжгүй санагдах болж тэгээд ч христос шашин шүтдэг болсноор сүм хийдээ уран сайхан-гоо зүйн өөр дэгээр чимэглэх шаардлага гарчээ. Тиймд Афин хотод хэмжээний хувьд арай бага сүмүүд барьж уран сайхны өөр зарчмаар чимэглэдэг болжээ. Афин хот дахь византийн дэгийн хамгийн эртний сүм нь ромын халуун усны газрын буурин дээр барьсан Гэгээн Никодимийн сүм юм.

Афин хотод дорно зүг алхам тутамд мэдрэгдэнэ. Луус, илжиг хөллөсөн хөлсний тэргүүд, Хааны өргөөний харуулд зогсож байгаа тод улаан өнгийн хүрэм, богино банзал, эсгий шаахай өмссөн торгон цэргүүд зэрэг нь Стамбул, Багдад, Каирийг санагдуулна. Афин хотын эртний хэсэг нь бүр туркийн дарлалын үеийн Плака дүүрэг юм. Эртний уран барилгын дэгээр барьсан жижиг жижиг байшингууд бүхий нэг нэгэнтэйгээ ав адилхан гудамжууд, гудамж, сүмийг холбосон шатууд бүхий эртний энэ гудамжийг 1833 оноос өмнөх байдлаар нь

нандигнан хадгалсаар байна.

Чулуу бүр нь түүхээр амьсгалж байгаа Афин хотод ирсэн хүн бүрийн сэтгэл хөдөлнө. Тийм ч учраас грекчүүд “Хэрвээ Афин хотод очиж үзээгүй бол Та луус, зочлон ирж хотыг үзэж харсан боловч сэтгэл тань догдлохгүй бол Та тэнэг хүн!” гэж ярьдаг нь үнэний ортой билээ.

Дөрвөн мянга гаруй жилийн түүхтэй эртний Афин хот эртний төдийгүй орчин үеийн олимпийн хөдөлгөөн үүссэн хот гэдгээрээ бүр ч илүү алдартай билээ. 2000 оны Алтан олимпийн наадмыг хийх эрхийн төлөө Сидней хотод ялагдсан ч афинчууд сэтгэлээр унасангүй, улам шургуу тэмцсээр, тавьсан зорилгоо биелүүлж 2004 онд Зуны олимпийн XXVI наадмыг зохиох эрхийг авч буурал түүхтэй хотынхоо намтрыг бас нэгэн алтан хуудсаар баяжуулахаар эрч төгс хөдөлмөрлөж зүтгэж байна.

## ИЕРУСАЛИМ

Иерусалим нь манай дэлхийн олон сая хүний хувьд ариун хот билээ. Голлох шашин нь иудизм, христосын болон лалын шашин байсан хэд хэдэн улсын бүрэлдэхүүнд байсан юм уу нийслэл нь байсан манай эриний өмнөх хоёрдугаар мянга жилийн дунд үеэс эл хотын тухай мэдээлэл тархсан байдаг. Хотын оршин суугчид олон шашин шүтэж байсан нь хотын уран барилгын дэг хэв маягт бүхэлд нь тусгалаа олсон байдаг.



Домогт гардгаар чухамдаа Иерусалим хотод “Дэлхийн хүйс” буюу Бурхан хуурай газар бүтээж эхлэсэн гэх Сүмийн уул бий. Сүмийн уул дээр Авраам төрсөн хүү Исаакаа золиослохоор бэлтгэж байсан газар тул Мория буюу “бурхан үзэгдсэн газар” гэж бас нэрлэнэ. Библийн хөлгөн сударт Иерусалим хотын тухай “Иисус Навиний ном”-д анх дурдсан бий. Израиль булаан эзлэхээс өмнө Адониседек Иерусалимийн хаан байсан хийгээд энэ явдал Давид хаан хотыг эзэгнэхээс 400 жилийн өмнө болжээ.

Иерусалим хотын нэрийг хананеичууд өгсөн гэдэг ч Иевус гэж бас нэрлэж байв. Иудууд хотыг булаан авч түймэрдэн түйвээж иевусуудыг хөөн явуулсан ч зарим иевус иргэн хотод үлдсэн байна. Давид хаан Израилийн бүх нутгийг эзлэж хотыг нийслэлээрээ сонгон сууршижээ. Тэр үед Давид хот Офел хэмээх намхан дов дээр байрлаж байв. Хуучныг судлаачид довын зүүн хэсэгт малталт хийж 2,5 метр орчим зузаан хэрмийн хэсэг гаргаж хотыг зузаан өргөн хэрмээр дороос нь тулсан тагт дээр байгуулсныг олж тогтоожээ.

Давид хотын нутаг дэвсгэр дээр Силоамын сав суулга (загалмайлах ёслолд хэрэглэдэг зүйл), “Мария Эх Дагинын усан оргилуур” гэж алдаршсан Гихон булаг байна. “Мария Эх Дагинын усан оргилуур”-ын баруун өмнө талд Иисус Христос төрөлхийн сохор хүнийг усаар нь эмчилж хараа оруулсан Силоамын цөөрөм байна. Христос шашны эртний сүмийн балгас дээр барьсан лалын шашны сүм цөөрмийн эрэг дээр байна.

Соломон хааны үед Иерусалим хот баян чинээлэг болсон ч Вавилоны Навуходонсор хаан манай эриний өмнөх 589 онд довтолж хотыг түймэрдэж Соломон хааны сүмийг газрын хөрстэй тэгшилж иудийн ард түмнийг боол болгон авч оджээ. Сөнөсөн Иерусалим хотод зөнч Иеремиа ор ганцаараа хоцорч хотын балгасыг харж “төгс сайхан хот минь” гэж харуусан



уйлан хайлж байжээ. Гагцхүү далан жилийн дараа Их Кир хааны үед иудийн ард түмэн Иерусалим хотод буцан ирж хоёр дахь сүмийн шавыг тавьжээ.

4000 жилийнхээ ойд ойртож байгаа Иерусалим хот буурал түүхийнхээ хугацаанд ихийг үзсэн нь мэдээж хэрэг билээ. Иисус Христосын үед Ромын эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтаж Иудийн дайны үед манай эриний 70 онд бослого гаргахад ромчууд Иерусалимийг мөн эвдэн сүйтгэжээ.

Хот удтал балгас хэвээр байсныг 136 онд Адриан хаан сэргээн босгож “Элия Капитолина” гэж нэрлэв. Константин хаан христос шүтлэгтэн болмогцоо бөөгийн шашны бүх сүмийг нурааж 326 онд түүний эх, хатан хаан Елена бурхны шарил дээр сүм барьсан нь гурван зуун жил оршин тогтножээ. 614 онд Иерусалимийг персүүд эзлэн түйвээж дараа нь туркүүдийн гарт орж 1099 онд загалмайтнууд эзэгнэв. Тэднээс султан Саладин чөлөөлж 1517 онд Османы эзэнт улсын нөлөөнд оржээ.

Иерусалим хот нь түүхэн талаасаа Шинэ, Хуучин хэсгээс бүрдэнэ. 1948 онд Палестиний нутгийг хуваах үед Израильд лалын шашинтнуудаас зузаан хэрмээр тусгаарласан үндсэндээ Шинэ хот нь ногджээ. Хэдэн зууны өмнөх байдлаараа ямар ч өөрчлөлтгүй байгаа Хуучин Иерусалимийг түүхэн музей гэж нэрлэж болно. Хоёр талаар нь жижигхэн лангуунууд жирийсэн нарийхан давчуу гудамж бүхий Хуучин хотоор хөнгөн тэргээр явах бололцоогүй учир явган алхаж үзнэ.

Хуучин хот руу орж гарч болох долоон хаалганаас XVI зуунд барьсан Шхемийн ганц хаалгаар нь л орж болно. Энэ хаалгаар гарч Шхем, Дамаск руу явдаг тул Дамаскийн хаалга ч гэж нэрлэнэ. Чухамдаа энэ хаалгаар өвөг эцэг Авраам орж гарч байсан хийгээд Иисус Христос иудийн улаан өндөгний баярын өмнө илжиг унан орж ирэхэд иудийн ард түмэн баяр хөөртэй угтан авч байжээ.

Яффа хүрэх замын эхлэл учраас Яффийн гэж нэрлэсэн хаалгыг жуулчид их сонирхоно. XVI зууны дунд үед барьсан уг хаалганд 1898 онд Германы Вильгельм хаан айлчлалаар ирэхэд том нүх гаргасан нь одоо яг тэр хэвээрээ цоорхой байна. Яффийн хаалганы дотор талд баруун тийш эргэхэд “Давидийн цайз” байна. Ирод хаан ордноо хамгаалах зорилгоор бариулсан энэ цайз түүний анд найз, ах, хатныхаа нэрлэсэн Гиппикус, Фасаэль, Мариамна гэсэн гурван цамхагтай ажээ. Хуучин хотын хамгийн найдвартай хамгаалалтын байгууламж байсан уг цайзаас бидний үед түүний суурь, Фасаэль цайзын доод хэсэг л яг хэвээрээ хадгалагдан иржээ.

Давид хааны бунхан Хуучин хотын хэрмийн гадна оршино. XVI зуунд христос шашны сүмийг туркүүд Зөнч Давидийн сүм болгон хувиргажээ. Сүмийн нэгдүгээр давхарт хилэн бүтээлгээр хучсан том чулуун авс байх хийгээд Израиль улсын тусгаар тогтнолын баяр өдөр авсны дээр орчин үеийн Израиль улсын оршин тогтнож байгаа жилийн тоотой тэнцүү мөнгөн титмийг залдаг уламжлалтай ажээ.

Цайзын цаана Хуучин хотын Армяны дүүрэг байна. Эх нутгаасаа хөөгдсөн армянчууд IV зуунд энд ирж сууршижээ. Энэ дүүрэгт байх Армяны сүмийн нутаг дэвсгэр дээр Иерусалимийн анхны христос шашинтан хамба лам Гэгээн Иаковын сүм оршино. XII зуунд

боссон энэ сүм нь эртний христосын уран барилгын үнэт дурсгал юм.

Сүмийн хажууд Армяны хамба ламд зориулан 1853 онд босгосон өргөө байна. Энэ өргөөнд эртний гар бичмэл, судар, үнэт зүйлс хадгалагдаж байгаагийн дотор Армяны сүүлчийн хааны очирт таяг бий.

Армяны дүүрэгт XII зуунд барьсан нүүрэн талыг нь хэе угалзаар чимсэн Ассирийн сүм байна. Энэ сүмийг найдан Маркийн эх Мариягийн байшин байсан газар босгосон бололтой. Домогт өгүүлснээр охин тэнгэрийн туслалцаатайгаар шоронгоос суллагдсан найдан Петр тэр байшинд ирж байжээ. Мария Эх Дагиныг загалмайж байсан мөнгөөр бүрсэн чулуун сав суулга (загалмайлах ёслолд хэрэглэдэг сав) байна. Энэ сүмийн лам нар өвөг эцэг Авраамын хэл болох арамейск хэл дээр шашны зан үйл хийдэг байна.

Армяны дүүргийн баруун-өмнөд зүгт Хуучин Иерусалимийн Еврейн дүүрэг оршино. XVI зуунд сефардийн еврейчүүд анх босгосон одоо ч ажиллаж байгаа дөрвөн сүмээс бүрдсэн цогцолбор тус дүүргийн гол чимэг билээ.

Хуучин хотын зүүн-хойд хэсэгт “Хадны бөмбөгөр орой”, Аль-Акса (“Алс холын”) зэрэг алдарт сүмүүд бүхий Лалын дүүрэг байна. VI зуунд Сүмийн уулын нутаг дэвсгэрийн нэгэн хэсэг дээр Византийн эзэнт гүрний Юстиниан хааны босгосон “Эх Дагиныг сүмд залсан нь” нэртэй христосын бунхан байв. Гэвч Омар халифийн цэрэг Иерусалим хотыг эзлэх үедээ бунхныг нурааж түүний буурин дээр лалын шашны сүм барьсан нь хожмоо Аль-Акса нэртэй болжээ.

747 онд болсон газар хөдлөлтийн уршгаар “Алс холын” сүм нилээд эвдэрч Аббасид угсааны Абу Жафар аль-Мансур халиф сэргээн засах гэж хөрөнгө хүрэлцэхгүй байсанд сүмийн хаалгануудыг чимэглэсэн алт, мөнгийг хуулан зарж олсон мөнгөөр нь засвар хийжээ. Загалмайтнууд Иерусалим хотыг эзлэсний дараа христос шашны сүм болгон хувиргаж “Палатиум” (буюу “Тамплум Соломонис”) гэж нэрлэжээ.

Султан Саладин хотыг эргүүлэн авсны дараа сүмийг лалын шашных болгож урьдын байдлаар нь сэргээн засварлажээ. “Алс холын” сүмийн барилгыг тэгш өнцөгт хэлбэртэй болгож шал, таазанд хавтан суулгаж дотоод чимэглэлд нь шигтгэмэл нэмжээ. Хоёр эгнээ баганууд мөргөлийн танхимыг адилхан хэмжээтэй гурван хэсэгт хуваасан хийгээд шал дээр нэлд нь зузаан хивс дэвсэж танхимын хойд жигүүрт зөнч Мухаммедийн тэнгэрт одсон газрыг онцгойлон тусгаарлажээ.

Хуучин Иерусалимийн баруун-хойд хэсэгт Христосын дүүрэг байна. Византийн эзэнт гүрний Константин хаан ромын бөөгийн шашны сүмийн буурин дээр Бурхны авсны сүмийг босгосон IV зуунд уг дүүрэгт хүмүүс сууршиж эхлэжээ. Өнөө үед уг сүмийг ромын католик шашинтнууд, үнэн алдартны шашин шүтдэг грек, армян, копт, сири, этиоп иргэд хамтран эзэмшиж байна.

1889 онд Палестинд очсон эртний түүх сонирхогч, Оросын их ван Сергей Александрович Орос улсын эзэмшилдээ авсан нутаг дэвсгэр дээр малталт явуулж Аврагч Христосыг цовдолсон Голгофа уулыг олж тогтоожээ.

Виа Долороза (“Хэрээсний зам”) бол христос шашинтнуудын бишрэн хүндэтгэдэг түүхэн дурсгалт газруудын нэг юм. Хүн төрөлхтөний түүхийн хорин зуун Иерусалим хотын газрын зурагт ихээхэн өөрчлөлт оруулсан ч Хүн Төрөлхтөний Аугаа Хүүгийн Голгофа уул руу очсон амьдралын замналыг шинэ үе бүр сонирхсоор өнөөг хүрчээ. Иерусалим хотод ирсэн хүн бүр Аврагч харуулуудад баривчлагдсан Гефсиманий цэцэрлэгээс түүний цовдлуулсан Голгофа уул хүртэлх замаар явж итгэл үнэмшлээ улам батжуулахыг эрмэлздэг билээ.

XIX зууны дунд үед хуучин хотын хэрмийн гадна Шинэ хот бий болсон юм. Сефардын уугуул еврей иргэн, Английн банкны эзэн Мозеса Монтефиоре 1849 онд хотын хэрмийн гадна хэсэг газар худалдан авч уг газар дээр Шинэ хотын анхны дүүрэг болох “Мишкенот-Шеананим”-ийг (“Ертөнцийн оршин суугч”) барих санаачилга гаргаж санхүүгийн томоохон дэмжлэг үзүүлжээ. Шинэ хотын анхны барилга болох нэг давхар жижигхэн байшинд өнөөдөр хотын захиргааны зочид буудал байрлаж байна.

1868 онд Шинэ хотын “Маханэ Исраэль” (“Израилийн хоргодох газар”) нэртэй бас нэг дүүрэг баригдсанаас хойш шөнө болмогц хаадаг төмөр хаалгатай олон дүүрэг дараалан бий болжээ.

Өнөөдөр Иерусалим хотод Хуучин, Шинэ хотуудыг холбох барилгын ажил эрчтэй явагдаж байна, гэхдээ эртний барилга байгууламжийн сүрийг дарж болзошгүй гэж үзэж өндөр байшин барихыг хатуу хоригложээ.

## БЭЭЖИН

Бээжин гэдэг нь “Хойд нийслэл” гэсэн утгатай үг ажээ. Нанжин буюу “Өмнөд нийслэл” оршин тогтнож байхад хот ийм нэр зүүж байв. Хот анх хэрхэн үүсэн бий болсон тухай түүхэн эх сурвалж огт байхгүй нь харамсалтай. Өнөөгийн Бээжин хотын нутаг дэвсгэр дээр өргөө нь байрлаж байсан анхны хаан нь манай эриний өмнөх 1121 онд хотыг захиргаандаа авсан Хуанди хааны удам байжээ. Тэр үед Цзи нэртэй байсан хот манай эриний өмнөх 922 нд Янь угсааны хаадын ноёрхол унахад нийслэл хот байхаа больжээ.



Тэр үеэс нийтдээ 11 зууны турш Бээжин олон өөрчлөлт үзэж Дасин, Бэйцзин, Бэйпин гээд олон нэр дараалан зүүжээ. 936 онд киданчууд хотыг эзлэн авч хотын шавар даланг тойпуун хэрмээр сольжээ. Монголын Хубилай хаан Бээжин газрыг хөрстэй тэгшилж цоо шинэ хот байгуулах зарлиг буулгаж хуучин хотыг Дасин, шинэ хотыг Дайду гэж нэрлэж байлаа.

Олон зууны туршид харийн түрэмгийлэгчдийн гарт удаа дараа орж байсан ч Бээжин нь хятад улсын бусад хоттой харьцуулахад эртний өнгө төрхөө хадгалж үлдсэн цорын ганц том хот болон алдаршсан юм. Хотын уран барилгын бусдаас онцгой ялгарах гол өвөрмөц онцлог нь тэгш хэмтэй байрлал өөрөөр хэлбэл гудамжууд нь нумын сум мэт хотыг нэг талаас нөгөө тал руу нь нэвт “зүссэн” байна.

Хот Дотоод, Гадаад хотхон гэж хоёр хэсэгт хуваагдана, үүнд Дотоод хотхон мөн дотроо мөн хоёр хуваагдаж Хааны хотхон, Гугун буюу Хаалттай хотхоноос бүрдэнэ.

Дотоод хотхонд нь өмнөөс хойд зүг, баруунаас зүүн зүг рүү чиглэсэн өргөн гудамжууд байна, гудамжуудын хоёр талаар ногоон модоор хүрээлүүлсэн гоёмсог байшингууд жирийнэ. Эрт дээр үед Дотоод хотхонд язгууртан феодалууд амьдарч байсан хийгээд жирийн хүмүүст сууршин амьдрах байтугай хонохыг үл зөвшөөрдөг байв. Энд мөн Бээжин хотын энэ хэсгийг гадаадын түрэмгийлэгчид, дотоодын самуун өдөөгчдөөс хамгаалах зорилгоор ХҮ зуунд байгуулсан өндөр чулуун хэрэм бий.

Хятадын хаан Дотоод хотхоныг хувийн өмч шигээ бүрэн эзэмшдэг байсан тул шадар тVШмэдүүд ялангуяа ялалт байгуулсан цэргийн жанжинууддаа ордон, шилтгээн тэр ч бүү хэл

бүхэл бүтэн хороолол бэлэг болгон өгдөг байжээ. Дайнд ялагдсан юм уу хааны дургүйг хүргэсэн цэргийн дарга нар Дотоод хотхонд амьдрах эрхээ хасуулж эхнэр хүүхэд, зарц нараа дагуулан нэн даруй нүүдэг байжээ.

Дотоод хотхоны дүүрэг бүр нь хэрмээр хүрээлэгдсэн байдаг ба Хааны хотхоны хэрмийн урт нь 24 километр орчим, 13 метр өндөр, 11 метр зузаан ажээ. Есөн гулдан хаалга бүхий энэ хэрмийг 1421 онд Мин угсааны хаадын үед босгож 1439 онд засварлажээ. Хэрмийн дагуу тэгш өнцөгт хэлбэртэй хэдэн арван цонхтой, бууны нүхүүд бүхий цамхагууд барьж өнцөгийн болон гулдан хаалганы дээрх цамхагууд нь олон үе вааран дээвэртэй, нүсэр том тойпуун ханатай байшинг санагдуулна.

“Хаалттай хотхон”-ыг тойруулан гуу ухаж ус дүүргэсэн байв. Гууны эгц босоо эргийг боржин чулуугаар доторложээ. Эл хотхоны бүх талбайд тойпуу дэвсэж гудамжуудад нь саарал болон цагаавтар өнгийн боржин том хавтан суулгажээ.

Хаалттай хотхоны “Төгс зохицлын танхим”-д хаан сайд, цэргийн дарга нар заримдаа гадаадын элчин сайд нарыг хүлээн авч уулзаж ярилцана. Хятадын хаан нь Тэнгэрийн хөвгүүн гэж хүндлэгдэх учир хятадаас бусад ард түмнийг бүдүүлэгчүүд гэж нүд үзүүлэж гадаадын зочид, элчин сайд нарыг бүдүүлэг ард түмнүүдийн элч төлөөлөгчдийнх нь хувьд Бээжинд хүлээн авч уулздаг байв.

1900 оноос өмнө Бээжинд сууж байсан гадаадын иргэдийн амьдрал хятад орны нийгмийн амьдралаас тусгаарлагдмал, хятадууд гадаадын иргэдтэй зөвхөн албаны ажил хэргийн яриа уулзалт хийнэ. Хятадын Цы Си хатан хаан 1899 онд Бээжинд сууж байсан гадаад орнуудын элчин сайд нарын гэргий нарыг ордондоо урьж танилцсанаар европчуудтай ойртох анхны алхмыг хийжээ. Гэвч хятадын нийгэм европчуудтай ойртох явц удалгүй дахин саарчээ.

XVI зууны дунд үеэс Дотоод хотхоны захад байгуулсан Гадаад хотхонд жирийн хятад сууршиж эхлэжээ. Гадаад хотхоныг цамхаг, хэд хэдэн том гулдан хаалга бүхий хэрмээр мөн хүрээлүүлжээ. Энд ядуу ажилчид, гар урчууд, жижиг худалдаачид, сүйт тэрэг түрэгчид, хотын хэрэгцээнд зориулан хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэн авчирдаг тариачид сууна.

Хааны хотхонтой танилцахдаа Бээжин хотын засаг захиргааны төв болох Тяньаньминий талбайгаас эхлэнэ. Энд Цэргийн яам, Сангийн яам гээд олон яам байрладаг байснаас хамгийн чухал үүргийг Ёслолын яам гүйцэтгэнэ. Ёслолын яам зөвхөн төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээ биш гол нь Тэнгэрийн Хөвгүүний амьдрал, үйл ажиллагааг тогтсон хатуу ёс дэгийг баримтлан зохион байгуулна.

1980 оны сүүлчээс Тяньаньминий талбайн уран барилгын цогцолборын бүрэлдэхүүнд Мао Зэдуны мавзолей гол чимэг болжээ. 33,6 метр өндөртэй шоо хэлбэрийн “Дурсгалын Ордон”-г маш богино хугацаанд (зургаан сарын дотор) босгосон юм. Ордны өндөр нь “Тэнгэрийн энх амгалангийн ордноос” 10 метр илүү байгаа нь хааны барилга байгууламжаас өндөр барилга байх ёсгүй гэсэн хэдэн зуун жилийн уламжлалыг эвдсэн хэрэг байлаа.

Нийтдээ 6 га газар эзэмших Музейн цогцолбор нь агар, бургас, долоогоно зэрэг модны ногоон өнгөөр хучигдмал ажээ. Бунхны өмнө дарга Маог Яньяни дахь хувьсгалт баазад

өнгөрүүлсэн жилүүдийг билэгдсэн 13 нарс мод байна. Мавзолей нийт арван танхимаас бүрддэг ч заримд нь хүмүүсийг огт оруулдаггүй юм. Жуулчид наран цэцгийн хэлбэрээр урласан 100 чийдэн бүхий Том хойд танхимд ороход зөөлөн сандалд тухлан суусан Мао даргын гантиган баримал өөдөөс угтана. Энэ танхимын хананд “Дундад иргэн улс”-ын уужим цэлгэр нутаг дэвсгэрийг билэгдсэн уул, голыг дүрсэлсэн 157 хавтгай дөрвөлжин талбайтай асар том хивс битүү өлгөжээ.

Жуулчид дараа нь төв танхимд ороход хар боржин тавцан дээр болор авс дотор албаны саарал френч өмссөн дарга Мао мөнхөд нойрсож байна.

Эртний Бээжин хотод янз бүрийн угсааны хаадын үед хамаарах гудамж маш олон бий. Тухайлбал Люличан гудамжийг Тан угсааны хаадын үед (618-907 онууд) барьжээ. Энэ гудамжинд хожим нь гялтганасан вааран дээвэр үйлдвэрлэдэг зуух бий болж Бээжин хотод сүм, ордон олноор баригдаж эхлэхэд гялтганасан вааран дээврийн үйлдвэрлэл эрчтэй хөгжжээ. Люличан гудамжны хөгжилт цэцэглэлтийн оргил үе XVIII зуунд таарчээ. Энд эрдэмтэд, яруу найрагчид хуран цугларч бүтээл туурвилаа бие биендээ танилцуулж цэц булаалдаж маргалдана. Энд мөн төрийн албанд орох хааны нэрэмжит шалгалт өгөхөөр ирсэн залуус байрлана. Төрийн албан тушаалд горилогчид чулуун ханаар хүрээлүүлсэн хороололд “чао-као” нэртэй байранд шалгалт өгнө. Олон танхим бүхий байрны эд тэнд босгосон өндөрлөг сүүдрэвч дотор суусан хянагчид горилогчид шалгалтын материалыг бие даан хийж байгаа эсэхийг хянаана.

Люличан гудамжинд гуч орчим номын дэлгүүр тэрчилэн хэвлэх үйлдвэр ажилладаг байжээ. Шинэ жил буюу Дэнлүүний баяраар гудамны хөл хөдөлгөөн эрс нэмэгдэж хүүхдүүдээ дагуулсан хүмүүс янз бүрийн хэлбэр, өнгийн цаасан дэн, тоглоом худалдан авцгаана.

Өнөөдөр эртний Люличан гудамж өнгөө төрхөө өөрчилж хуучин барилгуудын буурь дээр орчин үеийн шинэ барилгууд сүндэрлэн босож байгаа ч өнө эртний түүхийг санагдуулсан “Эртний түүхийн урлан”, “Цэвэр бичгийн танхим”, “Аз жаргалын үүлний сүм” зэрэг уянгалаг нэрсүүд нь хэвээр байна.

Бээжингийн нэгэн гудамжинд тал хэсгийг нь улаан өнгөөр будсан шонгууд байгаа нь 1694 онд барьж Юн Чжэн хаанаар өргөмжлөгдөхөөсөө өмнө сууж байсан “Юн хэ гун” ордон ажээ. Энд 1744 онд Цянь Лун хааны зарлигаар бүддийн шашны цогцолбор барьжээ. Бүддийн шашны урлагийн сонгодог бүтээлүүдийг байрлуулсан танхим бүрт өнгөний хослол, асар том хэмжээгээрээ сэтгэл хөдөлгөсөн бүддийн шашны бурхад заларсан байна. Жишээ нь өмнөд нутгийн царс модны голоор урласан Бүдда бурхны 25 метр өндөр баримал харц булаана.

Цянь Лун хаан манжуурын ойд ан хийж явахдаа намнасан нийт 6 мянга орчим килограмм жинтэй хоёр баавгайн хар чулуугаар урласан баримлыг нэгэн танхимд өөд өөдөөс нь харуулан байрлуулжээ.

Бээжин хотын тоймгүй олон дурсгалт зүйлсийн үүх түүхийн тухай тодорхой бичих ямар ч бололцоогүй билээ. Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн жуулчид өглөө эрт хотын гудамж, талбайгаар явж байхад мананд умбасан бүддийн шашны сүм, конфуцийн сургаалийг бичсэн сийлбэрүүд хятадын нийслэл гурван мянга гаруй жилийн настайг өөрийг эрхгүй сануулна.

## ХАНЧЖОУ

Бурхан тэнгэрт Диваажин, газарт Ханчжоуг бүтээсэн.” гэсэн эртний хятадын зүйр үг бий. Оновчтой сайхан байрлалаараа энэ хотыг давах хот хорвоод үгүй биз ээ. Тэртээ хөхрөх уулын оргилууд, халуун орны тоймгүй олон ургамал, Сиху нуурын алсад одох гадаргуу бараг хоёр мянга гаруй жилийн өмнө хятадын уран барилгачдын анхаарлыг гойд татжээ.

Зарим жуулчин Ханчжоуг хятадын хамгийн гоё хот гэж шагшин магтдаг. XIII зуунд Ханчжоу хотын оргил цэцэглэлтийн үед нь очиж танилцсан венецийн аялагч Марко Поло түүнийг дэлхийн хамгийн гайхамшигт хот гэж үнэлж байв.

Ханчжоу оновчтой байрлал төдийгүй түүхэн талаасаа маш их сонирхолтой хот билээ. X зууны сүүлчээр Таван угсааны хаадын үед Уюе вант улсын нийслэл байсан хийгээд Өмнөд Сун (1127-1279) угсааны хаадын ноёрхлын үед Хятад улсын нийслэл байжээ. Ханчжоу хотын сувд эрдэнэ нь жилийн аль ч улиралд ямар ч цаг агаарын нөхцөлд бахархан бахдан харж болдог Сиху (Өрнөдийн) нуур юм. Тэнгисийн булан байсан газрыг олон үеийн оршин суугчид нөр их хөдөлмөрийнхөө үр дүнд Хятад улсын хамгийн үзэсгэлэн төгс нуур болгон хувиргаж чадсан нь үнэхээр бахадмаар. Үнэндээ бол Сиху жижигхэн нуур түүнийг гурван талаас нь саглагар мөрөө унжуулсан агч, анар мод, чавга, тоор жимсний мод битүү бүрхсэн уул “хавчина.” Дөрөв дэх талд нь Ханчжоу хот байна.

Нуураас баруун зүгт Янцзы голоос өмнө зүгт орших хамгийн том, хамгийн эртний сүмүүдийн нэг болох бүддийн шашны Линьиньсы (“Сүнс хоргодох байр”) сүм байна. Тус бүр нь уран барилгын хосгүй дурсгал болох гурван том танхимаас бүрдэх энэ сүмийн цогцолборыг Ли Циний үед (1650 жилийн тэртээ) бүддийн шашны лам Хуэй Ли барьжээ. “Дасюнбаодянь” төв танхим нь матигар сиймхий хөвөөтэй гурван давхар вааран дээвэртэй хийгээд гурван давхар байшингийн хэрийн өндөртэй юм. Танхимд хүнд дээврийг тулсан багана ганц ч байхгүй байгаа нь их сонин.

Эхний танхимд үүдийг хамгаалсан тэнгэрийн дөрвөн харуулын чулуун баримал байна. Эдгээр баримлын хажуугаар өнгөрөхөд унжсан гэдэстэй, амаа байдгаараа ангайж инээсэн ирээдүйн бүддийн Митрей бурхны баримал өөдөөс угтана. Бүдда бурхны тийм дүр нь Өмнөд Сун угсааны хаадын үед бий болсон хийгээд тэр үеийн амьдралын баяр баясгалан дүүрэн нэгэн ламын хуулбар гэсэн домог бий.

Төв танхимд гаврын модны 24 голоор сийлж урласан Шакъямуни Бүдда бурхны 19 өндөр баримал байна. Бурхныг лянхуа цэцгийн хэлбэртэй хийсэн том тавцан дээр суумал байдлаар дүрсэлжээ.

Линьиньсы сүмийн эсрэг талд, алс байгаа эх нутгаа их санаж байсан энэтхэгийн лам байгуулсан гэдэг “Нисэн ирсэн уул нуруу” нэртэй сүм оршино. Тэр лам нэгэн удаа өглөө эрт сэртэл шөнө зүүдэнд нь харагдсан дов сүмийн өмнө бий болсныг хараад мэл гайхаж байжээ. Энэ сүмд мянга гаруй жилийн тэртээ сийлж урласан Бүдда бурхан, гэгээнтнүүдийн олон зуун жижиг баримал бий.

Дундад зууны үеийн Хятадын томоохон яруу найрагч Су Ши, Бо Цзюйи нарын дурсгалд зориулан босгосон Боти, Сути гэж нэрлэсэн хоёр нарийхан далан Сиху нуурыг хөндлөн зүснэ. Дээр дурдсан хоёр нэрт яруу найрагч Ханчжоу хотод алба хааж байхдаа усан техникийн томоохон ажил эрхэлж байв.

Нэг далан нь хотыг “Өнчин уул” нэртэй том аралтай холбодог хийгээд тэнд Цжэнцян мужийн түүхэн дурсгалуудыг цуглуулан байрлуулсан том музей бий. Сути далангийн ойролцоо нэрт жанжин Ио Фейгийн бунхан байна. XIII зуунд Өмнөд Сун угсааны хаад бий болж Ханчжоу хотыг нийслэлээ болгож байх үед цэргийн жанжин Ио Фей чжурчжэнейчүүдийн эсрэг хэд хэдэн аян дайн хийж олон удаа томоохон ялалт байгуулжээ. Гэвч түүний нэр хүнд олон түмний дунд өсөж байгаад өширхөж эмээсэн язгууртан феодалууд, тэдэнд худалдагдсан сайдууд гарамгай жанжны нэр төрийг гутааж түүнийг чухал хэрэг хэлэлцэх нэрийдлээр нийслэлд дуудан ирүүлж Суны зартай феодал Цинь Гуй зарлиг гаргаж түүнийг цаазалжээ. Гэвч ард түмэн эрэлхэг зоригт жанжны баатарлаг үйлсийг мартсангүй, нэгэн домогт өгүүлснээр Ио Фей жанжныг цаазлах агшинд түүний ордны дэргэдэх модод шудрага бус шийтгэлд гайхаж цочирдон чулуужсан ажээ.

Мөнхийн ногоон модны дор байх Го Фей жанжны бөмбөгөр орой шиг хэлбэртэй бунхан нь дөрвөн сүүдрэвч, хэд хэдэн чулуун дүрсүүдээс бүрдэх жижигхэн цогцолбор юм. Бунхан хүрэх өргөн чөлөөний хоёр талаар нэрт жанжны мөнхийн нойрыг сахиж байгаа мэт түүний хамтран зүтгэгч цэргийн дарга нарын баримлууд жирийнэ. Тэдгээрийн цаана нарны төөнөсөн туяаны дор төмөр сараалжны дотор Ио Фей жанжныг цааш харуулсан урвагчид тэдний эхнэрүүдийн өвдөглөн суусан баримлууд мөн байна.

Энд ирсэн жуулчид, дотоодын зочид гийчид Ио Фей жанжны амьдрал, цэргийн үйл ажиллагаандаа удирдлага болгон баримталдаг байсан “Эх орондоо үнэнч зүтгэнэ!” гэсэн алдарт үгийг сийлсэн хавтангийн дэргэд удтал зогсон саатна. Их жанжны дурсгалд зориулсан сүмийн голд түүний том баримал сүндэрлэн байна.

Ханчжоу хот урт удаан түүхэндээ баатарлаг, эмгэнэлт олон үйл явдлын гэрч байлаа. Тайпиний бослогын үед хот ихээхэн сүйдсэн ч 1895 оноос түүнд дахин гадаад худалдаа эрхлэхийг зөвшөөрчээ. Дараа нь Сучжоу хоттой усан замаар холбогдож төмөр зам баригдсанаар хотын хөгжил улам түргэсчээ.

Хятадын баячууд Сиху нуурын эрэг дээр хэдэн арван ордон харш барьж байв. Хиймэл арлууд дээр бургасны мөчир дор гоёмсог хийцийн сүүдрэвч, сүүдэрхэг явган зам, задгай шилэн сав дотор алтан загас хөвж байдаг зуслангийн тохилог шилтгээн байлаа. Гэвч гоминданы дэглэмийн үед Сиху нуурын үзэсгэлэн төгс булан, тохой эзгүйрч хөсөр хаягджээ. Хятадыг японы дарлалаас чөлөөлөгдөхөөс өмнө хуучин эзэд нь эдлэн газар, цэцэрлэгт хүрээлэнгүүдээ орхиж одсоноос нуур, худгийн ёроол замагт хучигдаж түүхэн олон байшин барилга эвдэрч нуржээ. 1949 онд “Дансюнбаоянь” танхимын багана шоргоолжинд идэгдэн унаж дараа нь тааз нь нуржээ. Гэвч тэр бүхнийг одоо засварлан босгож сүрлэг, үзэсгэлэн төгс байдлыг нь сэргээжээ.

Эртний Сун угсааны хаадын үеэс Ханчжоу хотод гайхамшигт “Лэйфэнсичжао” сүм босчээ. Уг сүм 12 давхар учраас аз жаргал авчирдаг гэж олон түмэн үзэж дээдлэн хүндэтгэнэ. Хүмүүс



энэ сүмд мөргөхөөр ирж түүний сууринаас жижигхэн чулууг аз жаргалыг билэгдэн авч одно.

Өнөөгийн Ханчжоу хот түүхэн дурсгалуудаара төдийгүй аж үйлдвэр, соёлын томоохон төв болсноороо улам алдаршиж байна. Сиху нуурын ойролцоох “Лууны худаг” гэдэг газар ургуулдаг луцзиний цай дэлхийд хамгийн шилдэг ногоон цайны нэг гэж тооцогдож байна. Тэрчилэн торгон давуугаар урласан хөрөг зураг, байгалийн дүрслэл нь дэлхийд цуутай. Хятадын “Сыкуцюаньшу” нэвтэрхий толийн эх Ханчжоу хотод хадгалагдаж байна.

Хятадын удирдагч Мао Зэдун энд дөч орчим удаа ирж байхдаа байрлаж байсан, Сиху нуурын эрэг дээрх өргөөг “Сицзы” нэртэй зочид буудал болгон өөрчилжээ.

## КАРФАГЕН

Хожим нь Париж хот болон хувирсан галлийн жижигхэн Лютеци суурингаас хэдэн зуун жилийн өмнө Карфаген хот үүсэн болсон юм. Апенниний хойгийн хойд нутагт урлаг, далайн аялал, гар урлалын салбарт ромчуудын багш байсан этруссууд ирж суурших үед Карфаген хот оршин тогтнож байв. Палатины довын эргэн тойронд хүрэл анжисаар газар хагалж Мөнхийн хот-Ромыг босгох ёслол хийж байх үед Карфаген хот гэсэн алдар нэрийг аль хэдийнээ хүртсэн байлаа.



Манай эриний өмнөх 814 онд Финикийн Элисса хатан хааны завиуд Хойд Африк дахь Утики суурингийн ойролцоо эрэгт хүрч ирэхэд холгүйхэн орших бербер омгийн удирдагч тэднийг найрсагаар угтав. Гэвч омгийнхон далайн чанадаас ирсэн хүмүүсийг байнга оршин суухыг нь зөвшөөрөхгүй байв. Тэгтэл омгийн удирдагч нь тэдэнд нэг хүн ганц үхрийн ширнээс илүүгүй газар багтан суух болзол тавьж байнга амьдран суухыг нь зөвшөөрч гэнэ.

Элисса хатан хаан болзлыг зөвшөөрч хүн бүрийн тоогоор өгсөн бухын ширийг нарийхан зүсэж үзүүрүүдийг нь нийлүүлэн тойруулснаар харьцангуй том талбай эзэгнэх болж шинэ суурингаа “Бирс” буюу “Шир” гэж нэрлэжээ. Финикийчүүд суурингаа “Шинэ хот”, “Шинэ нийслэл” буюу “Картхадаш” гэж нэрлэсэн нь яваандаа кириллээр “Карфаген” гэж бичигдэх болжээ.

Элисса хатан хаан суурин бий болгосноос гадна бас нэг гавьяа байгуулжээ. Нутгийн олон омгийн нэгний толгойлогч шинэ оршин суугчидтай хэлхээ холбоогоо бэхжүүлэх үүднээс Элисса хатан хааныг гэргийгээ болохыг гуйжээ. Гэвч Элисса хатан хаан эм хүний аз жаргалаасаа татгалзаж шинэ хот улс, финикийн ард түмний нэр хүнд, нөлөөг өргөжүүлэхийн төлөө амиа золиослохоор шийдэж “Бурхдын гуйлтаар би тэнгэрт халилаа!” гэж хэлээд, дүрэлзэж байгаа түүдэг галд орж, амиа егүүтгэжээ.

Энэ домгийг баримтжуулах талаар эрдэмтэд судалгаа хийж байгаа ч лавтай нотолгоо олоогүй байна. Хуучны судлалын малталтаар гарсан эд зүйлс нь манай эриний өмнөх VII зуунд хамаарч байна.

Финикийчүүд шинэ нутагт өндөр мэдлэг, гар урлалын уламжлал, соёлын илүү өндөр түвшин

авчирснаар төдсөнгүй нутгийн омгуудыг захиргаандаа авчээ. Тэд египетчүүдээс дутахгүйгээр шил, нэхмэл, вааран эдлэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж арьс, шир элдэж хүрэл, мөнгөөр эд зүйлс чадварлаг хийдэг болж, Газрын дундад тэнгисийн эргийн орнуудад алдаршжээ. Тэд мөн загас барих, худалдаа арилжаа хийх талаараа их ахиц олжээ. Чухамдаа тэр үед чидун жимсний модны төгөл, жимсний цэцэрлэгүүд бий болгож газар хагалж суваг татан тариа тарьж эхлэхэд ромчууд хүртэл атаархаж байлаа.

Хоёр зуун жилийн дараа гэхэд Карфаген хот-улс цэцэглэн хөгжиж Болеарын болон Корсикийн арлыг эзэгнэж Сардини арлыг грекүүдтэй өрсөлдөн эзлэхээр зэхэж байв. Тус хот улсын худалдаачид Атлантын далайн эрэг хавиар хийгдэж байгаа худалдаа арилжааг хяналтдаа авч алс холын нутагт судалгааны анги явуулж байлаа. Тус хотын ажилсаг иргэд ус хадгалах чулуун чингэлэг хийж олон давхар байшин барьж хиймэл цөөрөм байгуулж од гариг судалж ном туурвиж элдэв төрлийн тоног төхөөрөмж хийдэг байжээ.

Тэд эх нутагтаа төдийгүй Ливан, Египет, Израиль улсуудад сүм, ордон босгож 22 тэмдгээс бүрдэх цагаан толгой зохиосон нь хожмоо грек, латин, кирилл бичиг үүсэх үндэс суурь болсон юм.

Манай эриний өмнөх 300 оны үед Карфаген улс хөгжил цэцэглэлтийнхээ оргилд хүрчээ. Тэр үед Ромын эзэнт гүрэн Газрын дундад тэнгисийн хүчирхэг улс болон хувирч алдарт хотын заналт дайсан Марк Порций Катон Ромын сенат дээр үг хэлэх бүрдээ “Карфагенийг үндэс товрог болгох хэрэгтэй гэж би үзэж байна.” хэмээн дайрч давшилна. Сенатч Катон манай эриний өмнөх хоёрдугаар зуунд Карфаген улсад Ромын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтан айлчлал хийх үедээ баян тансаг байдалд умбаж байгаа нутгийн язгууртнууд, дэлхийн олон орны мөнгө тэмдэгтээр том наймаа арилжаа хийж байгаа худалдаачид, олон орны усан хөлөг, завь бүхий усан боомт, усан үзмийн тариалангийн талбайг хараад, ихэд атаархаж өш хонзон санажээ.

Газрын дундад тэнгист эзэмшил газар нутгаа өргөжүүлж бүрэн эзэмшихийн төлөө Карфаген. Ром хоёр улс бараг зуун жил шахам хоорондоо дайтаж эцэст нь карфагенчүүд Сицили, Андалузиас хөөгдөж дайны төлбөрт арван мянган талант төлж усан цэргийн флот, байлдааны заанууд, ихээхэн газар нутаг өгчээ. Ийм хохирлын дараа Карфаген улсын хүчин чадал мөхөн доройтох байтал улам цэцэглэн хөгжиж байгаад ромчууд гайхан бүр илүү дүргүйцнэ.

Ромчууд цэргийн их хүчээр халдан довтолж карфагенчүүдийн шургуу эсэргүүцлийг дарж нийслэл хотыг нь эзлэж дээрэмдэн тоносны дараа газрын хөрснөөс арчжээ. Ромчууд гудамж талбайг хүнд анжисаар сэндийчиж, жимсний цэцэрлэгүүдийг нь хядаж дахин жимсний мод ургуулахгүйн тулд давс битүү асгажээ. Ромын эзэнт гүрний сенатын шийдвэрээр Карфагенийг үнсэн товрог болгох үүрэг хүлээсэн цэргийн жанжин Спипион Эмилиан дэлхийд алдар суу нь түгсэн гайхамшигт хот нүдний нь өмнө үгүй болж байгааг хараад харамсан уйлж байжээ.

Ялагчид тус хотын сүм, ордуудад байсан хэдэн зуун жилийн туршид хуримтлуулсан бүх алт, мөнгө, бүх үнэт эдлэл, зааны ясан эдлэл, хивсүүдийг дээрэмдэн тонож ном, тэмдэглэлийг шатаажээ. Карфагенчүүд дийлдэхийнхээ өмнө зарим үнэт эрдэнэсээ нуусан байх гэж таамаглан бодсон ромын шуналтай эзлэн түрэмгийлэгчид олон жилийн турш сөнөсөн хотын

балгасыг сэндийчэн ухсаар байжээ.

Карфаген хотыг сүйдэлснээс 24 жилийн дараа ромчууд буурин дээр нь шинэ хотыг Ромын үлгэр жишээгээр өргөн гудамж, талбайтай, цагаан чулуун байшингуудтай босгожээ. Хэдхэн арван жил дараа гэхэд үнс нурамнаас сэргэн боссон Карфаген Ромын эзэнт гүрний хоёр дахт том хот болж тансаг байдал, цэнгэл жаргалаараа гайхагдах болжээ.

Ү зууны дунд үед хот Ромын захиргаанаас гарч Византийн мэдэлд орж бүтэн хагас зууны дараа арабуудад эзлэгджээ. Берберийн омгууд арабын байлдан дагуулагчдыг талархан угтаж лалын шашин дэлгэрүүлэхэд саад тотгор хийсэнгүй. Бүх хот, тосгон, гацаанд арабын сургууль нээгдэж утга зохиол, анагаах ухаан, шашин судлал, одон орон, уран барилга, гар урлал эрчтэй хөгжиж байлаа.

Арабын ноёрхлын үед ээлжлэн солигдож хоорондоо дайсагнагч олон угсааны хаадын тэмцэлдээнээс болж Карфаген хот их хохирч байлаа. Тэрбээр дахин нэг удаа сүйрч тэр үеэс ахин сэргээгүй ч үхэшгүй мөнхийн билэгдэл болон алдаршжээ.

Сүрлэг сайхнаараа ертөнцийг гайхуулж байсан Карфаген хотын буурь нь өнөөдөр Тунис улсын нийслэлийн дагуул хот юм. 1953 оноос эхлэн тэнд арван жилийн турш малталт хийж Бирсээс холгүйхэн, манай эриний өмнөх 146 онд болсон түймрийн нуранги дороос бүхэл бүтэн хороолол байгааг илрүүлжээ. Тунис улсын Засгийн газар эртний хотоос үлдсэн өчүүхэн төдий дурсгалыг хойч үеийнхэнд хэвээр нь үлдээхийн тулд тусгай хороо байгуулсан байна. Түүнээс гадна ЮНЕСКО шийдвэр гаргаж Карфаген хотыг Бүх дэлхийн өвийн жагсаалтад оруулжээ.

Өнөөгийн бидний үеийнхэн гайхамшигт Карфаген хотын тухай дайснуудынх нь бичиж үлдээсэн мэдээллээр л мэддэг нь харамсалтай. Түүхийн хүрд арай өөрөөр эргэсэн бол Карфаген Ромын оронд эртний ертөнцийн бүрэн эрхт эзэн болох байсан билээ.

## ЕРЕВАН

Ереван бол буурал эртний түүхтэй хот хийгээд хотын нэр “эрэвель” хэмээх армян хэлний үйл үгээс үүссэн гэж үздэг. Дэлхийг нөмөрсөн үерийн үеэр бурхны хайрласан завиар гэр бүлтэйгээ аврагдсан сүсэгтэн Ной Арарат уулнаас бууж байхдаа энэ газрыг харж, хот барихаар шийдсэн тухай эртний домог бий.



Манай эриний өмнөх VIII зуунд харьяат иргэд нь ассиричуудын эсрэг тэмцэлд боссон хэцүү бэрх цаг үед хаан суудалд заларсан Урарын нэгдүгээр Аргишти хааны чулуунд сийлсэн түүх 1916 онд Ван хотын ойролцоох хаднаас олджээ. Аргишти хааны эцэг, хаан Менуа улс орноо хөгжүүлж, бүтээн байгуулах өргөн далайцтай үйл ажиллагааг явуулж байсныг нь бидний үед хадгалагдан ирсэн шаантаг хэлбэрийн олон тооны чулуун сийлбэр гэрчилнэ. Тэрбээр цайз, ордон, сүм олноор бариулсны дотор алдарт цайз-хот Тушпа байв. Тэрчилэн услалтын суваг олныг татсанаас одоо хэр Ван хот руу цэвэр ус татдаг Шамирам суваг байна.

Нэгдүгээр Аргишти хаан эцгийнхээ үйлсийг үргэлжлүүлж манай эриний өмнөх 782 онд Эребуни цайз барьж 6600 цэрэг байрлуулжээ.

Гэхдээ Ереван хотын эх суурь болох цайзыг Аргишти хаан чухам хаана анх бариулсныг эрдэмтэд нотолж чадахгүй байсаар 1950 он хүрчээ. Хуучныг судлаачид хотын захад орших Арин-берд дов дээр малталт хийхэд эртний цайзын хананд зурсан олон сайхан зураг тэрчилэн хаданд сийлсэн шаантаг хэлбэрийн бичиг олжээ. Түүнийг Ван хотын ойролцоогоос олдсон хадны бичигтэй харьцуулж судлаад Эребуни гэдэг нь Ереван хотын анхны нэр, уг хотыг манай эриний өмнөх 782 онд байгуулсан болохыг тогтоожээ.

Нэгдүгээр Аргишти хаан хотыг байгуулахдаа байлдан дагуулсан газар нутгийн хойд хэсгийг бэхжүүлэх стратегийн зорилгыг удирдлага болгож Эребуни цайзыг цэргийн тVIIИц газар гэж үзжээ. Цайзын эргэн тойронд олон барилга байгууламж баригдсаар түүний хүрээ өргөн тэлж байлаа.

Цайз доторхи хамгийн том барилга нь Аргишти хаан Араратын хөндийд байхдаа буудалладаг байсан ордон байсан хийгээд 4 метр орчим өндөр хана, ёслолын танхимууд, тахилын танхим гээд бараг хэвээрээ өнөө үеийг хүрчээ.

Арин-бердээс хэдэн километрийн зайтай бас нэг дов байх хийгээд түүнийг ув улаан өнгөөр нь Кармин-блур буюу Улаан дов гэж нэрлэжээ. 1930 оны сүүлчээр тэр довоос Урурын өөр нэг хаан Русын тухай шаантаг хэлбэрийн бичиг олжээ. Эртний сүмийн чулуун суурь дээр дайны бүрхан Тейшебийн нэрээр нэрлэсэн Тейшебаини цааз-хотын нэрийг сийлсэн байв. Тейшебаини нь сайтар бэхжүүлсэн цайз төдийгүй цэцэрлэгт хүрээлэн, усан үзмийн талбай, улаан буудайн тариалангийн талбайгаар хүрээлэгдсэн хот байжээ. Улаан довоос дуулга, саадаг, бамбай тэрчилэн хүрэл, алт, мөнгөн гоёлын эд зүйлс гарчээ.

Тейшебаини цайз-хот бүтэн зуун жил оршин тогтсоны дараа манай эриний өмнөх VI зуунд скифүүдэд эзлэгджээ. Гэвч Эребуни цайзын амьдрал манай эриний V-VI зуун хүртэл үргэлжилжээ. Урурын улс унаснаар Араратын хөндийд Арташат, Двин зэрэг хотууд бий болж Ереван хотын ач холбогдлыг бууруулжээ.

V зууны хоёрдугаар хагаст Армян улсын нийслэл болсон Двин хотын хөгжилтэй Ереваны дахин сэргэлт холбоотой билээ. Учир нь гэвээс Двин хот худалдааны том төв болон тодорч түүний олон жингийн цувааны нэг зам нь Ереванаар дайрдаг болжээ.

Гадаадын олон удаагийн халдан түрэмгийлэл Ереван болон нийт Армяны эдийн засгийн хөгжилд ихээхэн хор хохирол учруулж байлаа. XI зуунд туркүүд дараа нь татар-монголчууд тус орныг гал мэсээр эзлэн түрэмгийлж ихэнх хот, тосгоныг эвдэн сүйтгэж заримыг нь газрын хөрстэй тэгшилжээ. Татар-монголчууд засаг захиргааны төвүүд болгон хувиргасан хотуудыг л, түүний дотор Ереваныг бүрэн эвдэн сүйтгээгүй орхижээ.

Ереван нь XIII зууны хоёрдугаар хагасаас Араратын хөндийгөөс Кавказын хойд нутагт хүрэх замд чухал цэг болсон ч том хотын хэмжээнд хүртэл хөгжиж чадсангүй. Тус хотод бүтээн байгуулах үйлс өрнөж аж амьдрал дээшилж оршин суугчид нь чинээлэг болох үеэс гадаадын түрэмгийлэгчид довтолж байлаа. XIV зууны сүүлчээр Доголон Төмөр хааны цэрэг хот руу дайрч 1554 онд түркийн арми хотыг эзлэж байшин барилгыг түймэрдэн шатааж оршин суугчдыг нь бөөнөөр нь алан хядав. Тэр аймшигт явдлаас тавин жилийн дараа Шах-Аббасын удирдсан персийн арми туркийн армийн гол хүч байрласан Ереван хотыг бүсэлж цэргийнхээ өмнө армян тариачдыг хөөж туун давшилт хийж байлаа. Тэгтэл туркийн цэргүүд армян тариачдыг хайр найргүй хядаж байсан нь үнэхээр аймшигтай. Хоёр армийн цэргүүд армян иргэдийг баривчилж эмэгтэйчүүд, хүүхдүүдийг олзонд авч боол болгон зардаг байлаа.

Турк, Персийн армиудын хоорондын удтал үргэлжилсэн дайн армян орны баруун хэсгийг Турк, Ереван хот орших дорнод хэсгийг Перс эзэмшилдээ хуваан авснаар 1639 онд сая нэг дуусчээ. Тэгээд дорнод хэсгийг сардар (Персийн амбан захирагч) захирах болж түүний томилсон полицмейстер Ереван хотын бүрэн эрхт эзнээр залрав. Тэрбээр асар том тVШмэдийн алба байгуулж түүний зардлыг гаргуулахаар татвар хураамжийг огцом нэмэснээр хотын оршин суугчдын амьдрал эрс дордов.

Ереван хотын хүн амын дийлэнх нь эрт дээр үеэс газар тариалан, мал аж ахуй, цэцэрлэгийн аж ахуй эрхэлдэг армян иргэд билээ. Харин XVII зууны сүүлчээс ваар, мужааны зэрэг гар урлал эрхэлдэг оршин суугчдын тоо нэмэгджээ. Гэвч хотын оршин суугчдын бүтээж байгаа асар их баялагийг сардар татвар, хураамж нэрийдлээр хүчээр хураан авч шахуудаас дутахгүй тансаг амьдарч байлаа. Жишээ нь сүүлчийн сардаруудын нэг болох Гусейн-Кули-хан өндөр

настай ч үзэсгэлэн төгс цэл залуу жаран бүсгүйг эхнэрээ болгож ордондоо хорьж үдэш бүр найр цэнгүүн зохиож цагийг өнгөрөөдөг байв. Гусейн-Кули-хан армян иргэдтэй маш харгис хэрцгий харьцаж гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд боссон иргэдийн хэлийг огтолж нүдийг сохолж гарыг тасдаж цаазалж шийтгэдэг байжээ.

Гэвч эрх чөлөөг эрмэлзэгч армяны ард түмэн гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг цөхрөлтгүй тэмцээр байлаа. Персийн дарлалыг эсрэг армян, гүржийн ард түмнүүдийн тэмцэл Оросын эзэнт гүрний засгийн газрын дорно зүгт явуулж байгаа бодлоготой тохирч П.Д.Цициановын удирдсан оросын цэрэг 1804 онд Ереваны вант улсын нутагт дэвсгэрт нэвтрэн ороход, армяны иргэд талархан угтаж хүнсний зүйл, малын тэжээлээр хангаж түрэмгийлэгчдийн тухай үнэт мэдээллээр хангаж байлаа. Гэвч генерал И.Ф.Паскевичийн удирдсан оросын цэрэг хорин жилийн дараа л Ереваны цайзыг эзлэжээ. Персийн хэдэн зуун жилийн дарлалыг унагасны түүхт үйл явдалд зориулсан баяр ёслол Ереван хотод хэдэн хоног үргэлжилж арав дугаар сарын 6-нд цэргийн ёслолын жагсаал хийж их буугаар 101 удаа ёслолын буудлага хийжээ.

Армяны ард түмний олон зууны жилийн эрх чөлөөний төлөө мөрөөдлийг билэгдэж Евреван хотод галт тэрэгний буудлын дэргэдэх талбайд ариун сайхан сэтгэлтэй, мятаршгүй хатан зоригтой домгийн баатар Давид Сасунскийн хөшөөг босгожээ. Заналт дайсныг галт жадаар хяргахаар урагш дүүлэн тэмүүлж байгаа Давид Сасунскийг цул хүрмэн чулуун дээр тэнгэрийн уудам, тэнгисийн гүнийг давхилт дундаа “мэдэлдээ авч” байгаа үлгэрийн Жалиль армаг хөлгийг унаснаар дүрсэлжээ. 25 метрийн голчтой усан сангийн голд байрлуулсан чулуун тавцан дээр сийлэн хийсэн аяга руу цул хүрмэн чулуунаас усны дусал тасралтгүй цацрана.

Ереван нь Вавилон, Ниневи, Персеполь зэрэг одоо үгүй болсон эртний хотуудтай нас чацуу боловч олон түрэмгийлэгч дээрэмдэн хайр найргүй тонон дээрэмдэж шатаан сүйдэлж байсан учир хуучны дурсгалт зүйл бараг байхгүй билээ. Гэвч нов ногоон цэцэрлэгт хүрээлэн, ус цацраасан усан оргилуур бүхий хот юм. Ереван нь ягаан, шар, улбар шар, цагаан, улаан өнгөөр солонгорно. Эл хот нь байшин барилгын нүүрэн талуудыг нь огт шохойддоггүй дэлхийн цорын ганц хот байж магадгүй. Байгаль дэлхий хүрмэн чулуу, боржин, гантигийн өнгийг “биечлэн” зохицуулж армяны уран барилгачдад өвөрмөц, хаана ч давтагдашгүй уран барилгын дэг, хийц урлах боломж олгосон бололтой.

## РОМ

Ром хотын үүссэн түүх нь маш энгийн, ууланд амьдарч байсан малчид хөндий рүү уруудан буун ирж Палатиний дов дээр сууршижээ. Хэсэг хугацааны дараа ойр орчмын олон дов толгод дээр бий болсон суурингууд нэгдэж тойруулан хэрэм барьснаар Ром хот манай эриний өмнөх 753 онд үүсчээ.



Эртний түүхчдийн бичиж байснаар ирээдүйн Ром хотын нутаг дэвсгэр дээр амьдарч байсан харь иргэдийн анхны удирдагчид нь Янус (эхлэл төгсгөл, орох гарахын хоёр нүүрт бурхан), арвин ургацын бурхан Санчир байжээ.

Санчир өндөр ёс суртахуунтай бурхан байсан тул түүний үед боол, хувийн өмчтөн байсангүй, бүх өмч нийтийн, хуваагдашгүй байв. Тэгтэл хорон санаат Бархасвадь бурхан ирээд сайн санаат Санчирыг тэр үед Санчирын гэж нэрлэгдэж байснаа Капитолийн гэж нэрлэгдэх болсон довоос хөөжээ. Капитолийн дов дээр бий болсон улсын хаан Бархасвадийн дараа Фавн хаанаар өргөмжлөгдөж түүний үед харь нутгаас хүмүүс ирж зэргэлдээх дов дээр сууршиж Паллантион гэж нэрлэсэн нь хожим нь “Палатин” гэж өөрчлөгдсөн бололтой.

Капитолийн дов дээр домгийн баатар Геракл албат иргэдээ дагуулан ирж сууршив, Фавнын охин Марика Гераклаас Латин хэмээх хүү төрүүлсэн нь 35 жил хаан ширээнд суужээ. Дараа нь эх нутгаасаа хөөгдөж ирсэн Энейгийн удирдсан троянчууд довлон ирэхэд Латин хаан харьяат иргэдээ зэвсэглэн тэмцсэн боловч дийлдсэн байна. Гэхдээ тэр тухай өөр хувилбар байдаг. Тулалдаанд дийлдсэн Латин хаан Эней хаанд хандаж, энх тайвны гэрээ байгуулж төрсөн дүү Лавинияг хатан болгон өгчээ. Төрсөн дүү охинтойгоо өмнө нь сүй тавьсан байсан Ругулын хаан Турнтай хийсэн байлдаанд Латин хаан алагдаж нутгийн оршин суугчид нь Эней хааны эрХШээлд оржээ.

Эней хааныг төрсөн дүү нь эрх мэдлээс нь зайлуулж бүх хөвгүүнийг алсан ч охин Рея Сильвия нь Марсаас Ромул, Рема нэртэй хоёр ихэр хүүхэд төрүүлэхэд хорон санаат Амулий тэднийг Тибр мөрөнд шидэж цааш харуулахыг тушаажээ.

Гэвч тушаал авсан зарц нар хоёр ихэр бяцхан хүүг өрөвдөж Тибр мөрний эрэг дээр байдаг нялх нярай хүүхдүүдийг хөхүүлэн тэжээгч эм бурхан Руминад зориулсан модон дор орхижээ.



Тэднийг тоншуул шувуу, эм чоно хоёр олж хамгаалан тэжээж, өсөж том болох үед нь малчин Фаустул олж гэртээ авчирч эхнэрийнхээ хамт хүмүүжүүлжээ.

Хоёр ихэр хүү эрийн цээнд хүрч гарал үүслийнхээ тухай мэдмэгц бяцхан баг цэрэг бүрдүүлж хорон санаат Амулийг алж өшөөгөө аваад хааны эрх мэдлийг буцаан авч шинэ хот байгуулахаар шийджээ. Хоёр хүү шинэ үйлсийг эхлэхдээ заншил ёсоор тэнгэрийн таашаалыг хүлээж байтал 18 элээ нисэн ирж тэдгээрээс 6 нь Авентин дов дээр байгаа зогсож байгаа Рем залуугийн дээр, шинэ хотыг 12 зууны туршид оршин тогтнохыг билэгдсэн 12 нь Палатин дов дээр байгаа Ромул залуугийн дээр эргэлдэн байлаа.

Тэгтэл Рем нөгөө өрөөсөнд илүү хүндэтгэл үзүүлэв гэж агаархаж Ромулыг алахаар завдаж хоёул амь өрсөн тулалдахад Рем дийлджээ. Тэгээд Ромул хот байгуулж өөрийн нэрийг өгч анхны хаанаар нь заларчээ. Тэрбээр хотын хүн амын тоог нэмэгдүүлэх зорилгоор Лукарис бурхны ариун төгөлд эх нутгаасаа оргосон чөлөөт иргэд, боолчуудад зориулан хоргодох байр байгуулснаар оршин суугчдын тоо нь эрс өсчээ.

Ромул гэдэг хаан энэ хорвоод амьдарч байсанд ромчууд итгэдэг. Манай эриний өмнөх нэгдүгээр зуун, манай эриний нэгдүгээр зууны зааг дээр Ромын эзэнт гүрнийг үндэслэгч Октавиан Август Ром хотод Августын Форум гэдэг шинэ талбай байгуулах түүнийг аугаа ромчуудын баримлаар чимэглэх баримал бүрийн тавцангийн хананд албан ёсны хүндэтгэлийн үгс бичих зарлиг буулгажээ. Дараа нь баримлуудын хуулбарыг италийн бусад хотод хийж тавьснаас Помпей хотоос Ромулын баримлын тавцангийн хананд сийлсэн хүндэтгэлийн үгс манай үеийг хүртэл хадгалагдан иржээ. Уг сийлбэрт:

“Марс бурхны хүү Ромул Ром хотыг үндэслэж 38 жилийн турш захирчээ. Тэрбээр гарамгай жанжин болохын хувьд гол дайсан болох ценинүүдийн удирдагч Акроныг алж түүнээс булаан авсан хуягийг Бархасвадь Феретрид бэлэглэн өгч тэр нь өөд болсныхоо дараа Квириин нэртэй бурхан болон мөнхөрчээ.” гэжээ.

Ромул амь хураасныхаа дараа тэнгэрт одсон гэж домог байдаг ч Ром хотод түүний шарил байсан тухай эртний зохиолчид бичиж үлдээсэн бий.

Ром хотод 1839 онд хийсэн малталтын үеэр алдарт Форум талбайг чимж байсан олон гайхамшигт дурсгалуудаас хамгийн битүүлэг нь болох *Lapis niger* буюу “Хар чулуу”-г олжээ. Эрдэмтэд Септимийн гулдан хаалганаас зайдуухан хар гантигаар хучсан, дотор нь ямар нэгэн тавцан, багануудын суурь бүхий агуй маягийн байгууламж олжээ. Уг байгууламж дотор шавар болон ясаар урласан шүтээнүүд, амьтдын араг яс, грек, этруссийн бичигтэй төстэй хадны бичгийн арилж холцорсон хэсэг байснаас “Ариун шүтээн болоорой!” гэсэн цорын ганц үг л гаргацтай үлдсэн байжээ. Дээр нь хоёр арслан байрлуулсан энэ бунхныг ромчууд Ромулын шарил гэж бишрэн хүндэтгэдэг байжээ.

Ромулын хаанчлалын жилүүдэд ромчууд хоёр дов дээр оршин суудаг, үүнээс Палатин дов дээр уугуул ромчууд, Капитолий дов дээр сабинууд сууршисан байв. Чухамдаа тэр үед намгаар битүү хүрээлэгдсэн байсан хоёр довын хоорондох зайд хотын иргэд цугларч зөвлөлгөөн, цуглаан хийдэг байсан тэр газар тус хотын нэрийн хуудас болох Форум талбайг байгуулжээ.

Эрдэмтэд XX зуунд хийсэн малталтаар Ром хотод эртний шүтээний байгууламжууд бүр манай эриний өмнөх 720-630 онуудын хооронд бий болсныг тогтоожээ. Тухайлбал Ромын хоёр дахь хаан Нума Помпилий цаг үеийнхээ өргөн мэдлэгтэй хүний хувьд Ром хотод тайлгачид бэлтгэх сургууль байгуулж шинэ бурхад бий болгож хоёр нүүрт Янус бурхан болон гэр бүлийн гал голомтын эм бурхан Веста нарт зориулсан шүтээн бариулж байжээ.

Ромчууд уран сайхны сэтгэлгээ, ур чадварын хувьд тэднээс материаллаг соёлын өндөр түвшинд байсан хөрш орших этрусчуудаас ихээхэн хамааралтай байжээ. Манай эриний өмнөх VI зуунд нэр нь бидний үед мэдэгдэж байгаа этруссийн гарамгай уран гартан Валка амьдран сууж байжээ. Бяцхан хөвгүүд Ромул, Рем хоёрыг асрамжилж байгаа эм чонын хүрэл баримлыг чухамдаа түүнийг бүтээсэн гэж үздэг. Тэр алдарт баримлын хөвгүүдийн хэсэг нь алга болсныг нь хэдэн зуун жилийн дараа дахин сэргээн урлажээ.

Манай эриний VI зууны сүүлчээр ромчууд хаант ёсыг халж бүгд найрамдах засаглалыг сонгожээ. Тэр үеэс алдарт Форум талбай өнгө төрхөө өөрчилж Ромын улс төр, нийгэм, шашны амьдралын төв болон хувирав. Эргэн тойронд нь гоёмсог барилгууд сүндэрлэн боссон талбайд өдөр бүр уран илтгэгчид оюун ухаанаа уралдуулж Ромын сенат хуралдаанаа хийж гайхамшигт ялалт байгуулсан ромын иргэд ард түмнээсээ шагнал хүртэж чухамдаа энд нийт эртний ертөнцийн хувь заяаг шийдвэрлэж байлаа.

Форум талбайд байрлах ард олны хуралд зориулсан Комициум талбайны хажууд сенатын хуралдааны байр болох Курия, гадаадын элчин сайд нар суудаг байсан Грекостатис байшин байрлана. Форум талбайны захаар Янус бурхны сүм, цэнгэг усны эм бурхан Ютурны шүтээн, галын бурхны шүтээн Волканал, Веста эм бурхны дугуй хэлбэрийн сүм байрлаж байжээ. Эдгээр үзэмж төгс барилгаас цөөнх нь өнөө хүртэл хадгалагдаж ирснээс хэд хэдэн удаа сэргээн завсварлагдсан Веста эм бурхны сүм, цэвэр усны Ютурн шүтээний балгас байна. Гэхдээ байрлалаа хэд хэдэн удаа өөрчилсөн уран илтгэгчийн индэр тэрчилэн чимэг, хэлбэрээ олонтаа өөрчилж байсан мөнхийн галын сүм л Форум талбайн түүхийн гэрч болсоор өнөөг хүрчээ.

Урьж ирүүлсэн Ромын католик шашны хамба лам VII Георгийд дургүйцсэн Р.Гискар хааны цэргүүд Ромын Форум талбайг 1080 онд эвдэн сүйтгэж, дийлэнх байшин барилгыг балгас болгон хувиргажээ. Тэр эмгэнэлт явдлаас хэдэн зуун жилийн дараа XVI зууны дунд үед гуравдугаар Павел хамба лам Форум талбайг сэргээх гэж биш балгас дунд дарагдсан гантиг, барилгын материалуудыг гарган авах зорилгоор талбайг ухаж төнхөхийг тушааж байв.

Ромын Бүгд Найрамдах Улсын түүх нь ромын зэвсгийн ялалтын түүх юм. Дайныг аж амьдралын салшгүй бүрэлдэхүүн гэж үздэг ромчууд тулаанд мордсон дайчид ямагт ялалт байгуулахыг билэгдэж Янус бурхны сүмийн модон хаалгыг үргэлж дэлгээстэй байлгадаг байлаа. Ром хүчин чадлаа нэмэгдүүлж хөрш омгуудаа нэгтгэсээр таван зууны дараа гэхэд бүх италийг эрХIIIээлдээ оруулсан билээ. Ялалтад омогшиж зоригжсон ромын цэргүүд омог биш бүхэл бүтэн улс орныг дараалан эзлэж европ тивийг бүхэлд нь мэдэлдээ авчээ. Гэвч дараа нь ромын соёлын уналт мөхөл ирж тэр бүхэн Ром хотын түүхэнд тодорхой ул мөрөө үлдээжээ.

Колизейн задгай театр, Нерон хааны “Алтан ордон”, Каракаллы халуун усны газар, Марк Аврелийн морь унасан баримал, Траяны багана гээд Ромын түүхэн дурсгалын тоо

хэмжээлшгүй их хийгээд түүнийг судалж танилцахад нэгэн хүний амьдрал хүрэлцэхгүй. Нэгэн жишээ дурдахад Виктор Эммануэлийн талбайд нэгэн эртний байшингийн хананд өвөрмөц дурсгал бий. Гэдэс нь унжсан хоёр хом аймшигт амьтан хамгаалж байгаа гантиган хавтан дээр учир нь үл ойлгогдох тэмдгүүд сийлсэн байна. Уг тэмдгүүдийг тайлж уншиж чадсан хүн алт үйлдвэрлэх энгийн томьёог олж хөлгүй их баяжина гэсэн домог байдаг ажээ. Өнгөрсөн зуунуудад олон мянган хүн ирж уг тэмдгүүдийг “тайлж унших”-аар оролдсон ч ганц нь ч чадаагүй ажээ.

Ромыг усан оргилуурын хот гэж мөн нэрлэнэ. Тоймгүй олон, жавхаалаг усан оргилуурууд нь хотын том жижиг бүх талбайг чимж сэтгэл сэргээнэ. Жуулчид Тревийн алдарт усан оргилуурт ирж усанд нь зоос хаяж Ром хотод дахин ирэх хүслээ илэрхийлнэ. Уг талбайгаас холгүйхэн байх Навоны талбайд нэрт уран барилгач Л.Бернинийн урласан дэлхийн бүх том мөрөн голын бурхдыг билэгдсэн асар том баримлууд бүхий усан оргилуур байна.

Янз бүрийн соёлын дурсгалт зүйлс олноороо орших тийм хот дэлхийд Ромоос өөр байхгүй. Хотод орчин үеийн байшингуудтай зэрэгцэн өнө эртний түүхийн сүм, цэнгэлдэх хүрээлэн, ордон, олон нийтийн байр оршино. Музейн хот болох Ромоор жуулчид аялал хийж байхдаа орчин үеийн байдлыг нь умартан өнгөрсөн зуунуудад айлчилж байгаа мэт баярлан хөөрнө.

## ВИФЛЕЕМ

Бяцхан Вифлеем хот Иерусалим хотоос 7 километрийн зайтай оршино. Хамба лам Иаков гэр бүлээ дагуулан Вефилиэс гарч явж байтал эхнэр нь Ефрафаас холгүйхэн нярайлж хүү төрүүлэхэд Вениамин нэр өгчээ. Гэвч эхнэр нь нас барахад хамба лам Иаков Ефрафа буюу Вифлеем орох замд нутаглуулж шарил дээр нь хөшөө босгожээ. Гадаад дүрх төрх нь он цагийн уртад нилээд өөрчлөгдсөн тэр хөшөөг өнөөдөр ч очиж үзэж болно.



Ариун газар нутгийг Иисус Навины үед израильчуудад 12 муж болгон хуваахад Вифлеем бусад хэд хэдэн хотын хамт Иудин мужийн бүрэлдэхүүнд багтжээ. Зөнч Самуил Израилийн хаанаар Иессейн найман хөвгүүний нэгийг нь сонгох тухай Бурхны айлдварыг хүлээн авсны дараа Вифлеем хотод ирж Бурхны таашаалд нийцүүлэн Иессейн отгон хүү Давидийг нууцаар сонгожээ. Давид хаан бага насаа Вифлеем хотод өнгөрөөв. Бурхан хаан Давид, зөнч Самуил хоёрт, өөрийнх нь омгоос ертөнцийн Аврагч төрнө гэж амласан байв.

Гэвч Давид хааны залгамжлагчид Иерусалим хотод байнга амьдран сууж Вифлеем хот руу үл зүглэх учир тус хотод Давид хааны хамгийн аугаа залгамжлагч хүү төрнө гэж огт тааварлахгүй байв. Гэтэл зөнч Михей иудийн ард түмэнд хандаж Вифлеем хотод Аврагч мэндэлнэ гэж сануулжээ. Энэ түүхэн явдал Иисус Христос төрөхөөс 700 жилийн өмнө болсон ч элдэв таамаглалд итгэдэг иудийн ард түмэн зөнч Михейн үгийг мартсангүй, Аврагч төрөлх Вифлеем хотод мэндэлнэ гэдэгт итгэсээр байжээ.

Он жилүүд өнгөрсөөр хот халдлага довтолгоонд олонтаа өртжээ. Навуходоносор хааны цэрэг Вифлеем хотыг эзлэсний дараа оршин суугчдыг нь бүгдийг нь хөөж Вавилонд тараан суулгажээ. Гэвч Иессейн удмын чухам хэнээс нь Аврагч төрөхийг хэн ч мэдэхгүй байлаа. Тэгээд ч Давид хааны удмынхан ард түмнийг захирахаа больж улс орон даяар тархан амьдарч байв.

Гэвч Бурхны зөгнөн айлдсанаар Аврагч төрөх цаг ирлээ. Алс хол орших Ромд бүх харьяат иргэний бүртгэл явуулахад Бурхны айлдвараар 12 муж болон хуваагдсан иудын ард түмэн гарал үүслээрээ бахархдаг байдгаа ил тод илэрхийлж байлаа. Тэгээд Давид хааны ядуу залгамжлагч Иоаким, эцгийнхээ шугамаар мөн удамд хамаарах Мария нар Вифлеем хотод очиж Давид хааны удмынхаа бүртгэлд орох хэрэгтэй болов.

Тэд Вифлеем хотод үдэш ойртож ирсэн ч бүртгэлд орохоор ирсэн хүмүүс дэн буудлуудад пиг дүүрсэн тул хоноглох газар олдохгүй байв. Эрт дээр үед Вифлеем хотын эргэн тойронд байсан тал хөндийд хонь, ямаа хариулдаг байв. Аадар бороо асгарч төөнөм халуун шатахад малчид хаданд агуй цавчин гаргаж хонь, ямаагаа туун хоргоддог байв. Чухамдаа “Хоргодох байр” гэсэн нэртэй тийм нэг агуйд Иоаким, Мария хоёр Ариун гэр бүл мэндлэх шөнийг хамт өнгөрөөжээ. Чухамдаа энэ агуйд Эх Дагина Мария Бурхнаас урьдчилан зөгнөсөн ертөнцийн Аврагчийг төрүүлжээ. Эх Дагина дөнгөж нярайлсан хүүгээ өлгийдөж малын ховоо дотор тавьжээ.

Намуун саруул шөнө бүгд унтаж ямар чухал үйл явдал болсныг хэн ч тааварлахгүй байлаа. Гагцхүү Вифлеем хотын ойролцоо билчээр дээр сүрэг малаа манаж байгаа малчид л унтаагүй, сэрүүн байв. Тэгтэл Бурхан гэнэт гэгээ татуулан гарч ирэхэд малчид айн мэл гайхав. Бурхан тэднийг тайвшруулж “Надаас бүү ай, би ертөнцийн бүх хүн ардад аугаа баярт мэдээ дуулгахаар ирлээ. Вифлеем хотод Бурхан миний амласан ертөнцийг Аврагч мэндэллээ. Бяцхан хүүг өлгийдэж малын ховоо дотор тавьсан байна!” гэж хэлэв. Энэ агшинд тэнгэрт тоймгүй олон охин тэнгэр бий болж Бурхныг магтан “Бүхний дээд Бурхны алдар бадартугай, хөрст дэлхийд энх амгалан, зон олонд аз жаргал ерөөе!” гэж дуулна.

Охин тэнгэрүүд нисэн одсоны дараа малчид хоорондоо ярилцаж Вифлеем очиж ямар үйл явдал болсныг нүдээр харж итгэхээр явцгаав. Тэд хотод яаран ирж агуй дотроос бяцхан хүү Христийг олж түүний эх Мариад хандаж билчээр дээр болсон явдлыг нэгд нэгэнгүй хүүрнэжээ.

Византийн эзэнт гүрний Елена хатан хаан 326 онд уг агуй дээр “Христос мэндэлсэн сүм” бариулж хоёр зуун жилийн дараа Ромын эзэнт гүрний Юстиниан хаан сүмийг өргөжүүлж улам гоёмсог болгожээ. Палестин дахь “Христос мэндэлсэн сүм” бараг 17 дахь зуундаа ямар нэгэн томоохон өөрчлөлт, засваргүйгээр оршин тогтнож байна. Энэ хугацаанд шашны ёслол тогтмол хийгдсээр ирсэн нь бүр ч гайхалтай.

“Христосын мэндэлсэн сүм” цагтаа гурван хаалгатай байсны хоёрыг нь битүүлжээ. Гэвч үлдсэн ганц хаалга нь дэндүү өргөн байсан тул тойпуу өрж нарийхан болгожээ. Сүмийн мөргөлийн танхимд дээд хүрээг нь хөвөөгөөр чимэглэсэн ягаан боржингоор урласан дөрвөн эгнээ баганууд байна. Сүмийн баганууд, ханыг бүр византийн үед хийсэн библийн хөлгөн судрын сэдэвтэй уран зургаар чимсэн байсны ул мөр одоо ч байна.

Бурхны хөрөг зургуудаар ханыг нь нэлд чимсэн тахилын баруун, зүүн талд байх нарийхан шатаар явж Эх Дагина Мария Бурхны хөвгүүнийг төрүүлсэн “Бурхан мэндэлсэн агуй”-д хүрнэ. Нийтдээ 22 хавтгай дөрвөлжин метр талбайтай агуйг гантигаар доторложээ. Сүмийн хананд гаргасан гүнзгий биш хонхорхойд жижигхэн тахил байрлуулж түүний өмнө шал дээр “Энд Эх Дагина Мария суут Иисус Христос хүүгээ энд төрүүлсэн.” гэсэн латин үгүүдийг бичсэн мөнгөн од шигтгэн суулгажээ. Энэ мөнгөн од нь хоёр мянган жилийн тэртээ ертөнцийг Аврагчид мөргөхөөр замд гарсан дорнын ухаантнуудад явах замыг нь заан өгч байжээ. Мөнгөн од явах чиглэлийг заасаар одоо янз бүрийн шашны урсгалыг баримтлагчдын дэнлүү унжуулсан тэр газарт хүрээд хөдөлгөөнгүй болж байжээ. Христосын шашныг бишрэн шүтэгч бүр мөнгөн одонд гараа хүргэх ядахдаа харахыг эрмэлзэнэ. Мөнгөн одноос хэдхэн алхмын зайтай байх гурван гишгүүртэй шатаар алхаж, агуй дотор ороход Эх Дагина дөнгөж

нярайлсан хүүхдээ өлгийдэж тавьсан ховоог билэгдэж хананд гаргасан жижигхэн хонхорхой байна.

“Христос мэндэлсэн сүм”-ийн дэргэд эрт дээр цагт Иосиф мужааны байшингийн буурин дээр барьсан францискүүдийн сүм байна. Түүнээс холгүйхэн Ирод хааны тушаалаар нярай хүүхдүүдийг алж худагт шидэж байсан тэр газар босгосон “Гэм буруугүй цагаан цайлган сэтгэлийн бунхан” бүхий Гэгээн Екатерина цацар сүм байна.

Вифлеем хот дахь Давид хааны нэртэй холбоотой цорын ганц газар нь түүний удирдсан цэрэг Рафаимын талд филистимляний армитай байлдаж байхад ус авч зөөн аваачиж байсан худаг юм. Одоо тэр газар VI зуунд византичуудын байгуулсан грекийн сүм оршиж байна. Сүмд шавилан сууж байсан лам нарын шарилыг оршуулсан газар доорх бунхан-агуйнуудыг энд мөн үзэж танилцаж болно.

“Христос мэндэлсэн сүм”-ийн зүүн тийш “Тэнгэрийн заадсын” гудамж зурайна. Эх Дагина Тэнгэрлэг хүүгээ хөхүүлж байтал хэдэн дусал сүү дусахад хар чулуу тэр даруй цав цагаан болсон гэдэг агуйны дээр барьсан францискийн сүм энэ гудамжинд оршино. Хар байгаад цагаан болсон чулууг тэр үеэс ид шидтэй гэж бишрэн шүтэх болж эхчүүд ирж хүүхдүүддээ хоол ундтай байхыг гуйж мөргөнө.

Вифлеем гэдэг нь “талхны нутаг” гэсэн утгатай хийгээд тэнгэрээс буусан амьд талх болох Бурхны Хүү төрсөн газарт энэ нэр нь үнэхээр зохицсон ажээ.

## МЕРОЭ

Нил мөрний эргийн дунд хавьд хойд талдаа Асуаны далан, өмнө талдаа Судан улсын Дабб хотуудын хооронд орших түүхэн мужийг Нуби гэж нэрлэнэ. Энэ нэр нь эртний египетийн “нубу” буюу “алт” гэсэн үгнээс гаралтай ажээ. Нил мөрний эргийн намхан хадархаг уулнаас эрт дээр үеэс алт олборлосоор өнөөг хүрчээ.



Эртний египетчүүдийн хувьд эргийн дагуух нарийхан хөндийд буй Нуби нутаг “Африк тив орох хаалга” байжээ. Египет улс хүчирхэгжсэн үедээ Нубиг эзлэн түрэмгийлж нубичууд хөл дээр зогсохоороо бослого гаргаж бие даасан байдлаа сэргээдэг байжээ. Манай эриний өмнөх VIII-VII зуунд нубичууд Египетийн ХХУ угсааны хаадыг тодруулж Египет орныг захирч байсан удаатай. Түүнээс хойш Нуби нутагт Куш, Напат, Мероэ нийслэлтэй улсууд дараалан оршин тогтнож байв.

Эрдэмтэд Муссарават-эль-Суфра хөндийд малталт хийж эртний Мероэ хотын түүхийн нууцыг нээсэн билээ. Энд олон нээлт хийснээс Кушийн захирагчдын эрт дээр үед тоносон пирамидуудыг малталт хийж гарган судалжээ. Тэрчилэн хатан хаадын бунхнуудад хүрэх газар доорх хонгилуудыг мөн олжээ.

Английн судлаач Б.Дэвидсон одоо ч бага судлагдсан эртний хотын тухай ийн бичжээ: “Хоёр мянга гаруй жилийн тэртээ цэцэглэж байсан соёл иргэншлийн илэрхийлэл болох ордон, сүмүүдийн балгас Мероэ хот, түүнтэй залгаа нутгуудад оршино. Сүрлэг дүр төрхөө алдаагүй байгаа балгасын эргэн тойронд энэ гайхамшигт өргөө ордон, сүмүүдийн бүтээсэн хүмүүсийн оршуулгын овоонууд байна. Үл ойлгогдох үсгүүд сийлсэн улаан хүрмэн чулуун хана, цагтаа цайз, сүмийн чимэглэл болж байсан цагаан болсон гөлтгөнөөр хийсэн товгор дүрсүүд, олон өнгийн шавар сав суулганы хэлтэрхий, хээ угалз сийлсэн чулуу гээд энд байгаа бүх зүйл аугаа их соёл иргэншлийн бодит нотолгоо болж байна. Нарны Амон-Ра бурхны гантиган баримал хаа сайгүй хөглөрнө.”

Куш улс түүхийнхээ анхны хэдэн зуун жилд египетийн ноёрхолд байсан болохоор хааны ордон нь египетийн дэгийг санагдуулах хийгээд язгууртнууд, тайлгач нар египетийн ёс заншлыг чанд дагадаг байжээ. Гэхдээ нубичууд египетчүүд шиг гол мөрөнтэй холбоотой биш байсан тэднээс ялгаатай нь ургамал бут тарчиг, ховор халуун орны тал нутагт мал аж ахуй

эрхэлдэг байжээ.

Манай эриний өмнөх 800 оны орчим хүчин чадал нь суларсан Египетийн XXII угсааны фараонууд Куш улсад тусгаар тогтнолыг аргагүйд тулж хүлээн зөвшөөрчээ. Кушууд хонийн дүрээр илэрхийлдэг Амон бурхны шүтээний төв болох Напата хот шинэ улсын нийслэлээр тодорчээ. Тодорхой хугацааны дараа Куш улсын хаад хойд зүгт аян дайн өдөөж Египетийн өмнөд нутгийг эзлэжээ. Авьяаслаг цэргийн жанжин болохоо харуулсан Пианхи хаан Египетийн фараоны цэргийг дийлж “этиоп”-ийн ХХҮ угсааны хаадын эхлэлийг тавьжээ. Гэвч хүрэл, чулуун зэвсэгтэй египетчүүд, кушчуудыг төмөр, жад, сэлмээр зэвсэглэсэн ассирчууд ялсан ч Нил мөрний дээд хэсэг рүү яваагүй тул кушчууд тусгаар тогтнолоо алдсангүй аврагджээ.

Цөлийн шар элс Нубийн хаант улсын нийслэл Мероэ хотын балгасыг бүтэн хагас мянган жил нуун далдалж байлаа. Хойд зүгт орших Напатта хотын оронд Нубийн хаант улсын нийслэлээр өргөмжлөгдсөн Мероэ хотын тухай манай эриний өмнөх нэгдүгээр зуунд грек, ромчууд анх дуулж мэджээ. “Яагаад нийслэлээ сольсон юм бол? Тэр явдал чухам хэдэн он болсон, ямар үүх түүхтэй хот вэ?” гэсэн асуултуудын хариу өнөөдөр ч алга байна. Ром, грекийн зохиолчид бүтээл туурвилдаа Мероэ хотын тухай маш цөөн үгээр дурдсан бий. Мероэ хотын нутаг дэвсгэр бамбайны хэлбэртэй учир “Мероэ арал” гэж нэрлэж байжээ. Нил мөрөнд цутгадаг голуудаар бүх талаасаа хүрээлэгдсэн дугуй хэлбэртэй хуурай газар гэж эл хотыг тухайн үеийн газрын зурагт тэмдэглэсэн байв.

Мероэ хотоос Ром хотод хэдэнтээ элчин сайд ирж сууж байсан ч элчин төлөөлөгчид, худалдаачид алс хол орших төрөлх нутгийнхаа тухай ромчуудад өчүүхэн төдий мэдээлэл хэлдэг байв. Нерон хаан нэгдүгээр зуунд Нуби руу хэсэг офицер тагнах зорилгоор томилон явуулсан нь Мероэ хотоос цааш явсан байжээ. Тэдгээр тагнуулчдын олж ирсэн мэдээллийг нэрт газар зүйч, байгаль судлаач Ах Плиний “Байгалийн түүх” номондоо тодорхой дурдахдаа Нуби арлыг Кандак хэмээх үе залгамжилсан нэртэй нууцлаг хатан хаад захирдаг тухай, египетийн нарны Амон бурханд зориулсан сүм байдаг тухай, 250 мянган цэрэгтэй арми, дөрвөн мянга орчим зураач суудаг тухай өгүүлсэн байна.

Мероэ хот оршин байсан гэж үздэг тэр газар хуучныг судлаачид малталт хийж 1822 онд том хотын балгас олжээ. Гэвч эртний зохиогчид хотын хил хязгаарыг тодорхой дурдаагүй байсан учир Мероэ хотын балгас яг мөн байна гэсэн дүгнэлтийг хийж болохгүй байлаа. Гагцхүү нэг зуун жилийн дараа Мероэ хот нь Нил мөрний үндсэн голдрилийн баруун эрэг дээр, чухамдаа баруун өмнөд талаасаа цэнхэр Нил мөрөн, зүүн-хойд талаасаа Атбара голоор хүрээлэгдсэн нутаг дээр оршиж байсныг лавтай тогтоожээ. Гэхдээ тэр нутаг нь эртний хүмүүсийн үзэж байсан шиг дугуй биш харин дөрвөлжин хэлбэртэй ажээ.

1920 оны үеэс хуучныг судлаачид зөвхөн хаадын бунхнуудыг судалж хорьдугаар зууны үеэс л Мероэ хотын нутаг дэвсгэр дээр төлөвлөгөөтэйгээр малталт хийх болжээ. Шар элс олон зуун жил хотыг нууж бидний үе хүртэл хадгалж ирсэн нь их сонин.

1960 оны хавар германы эрдэмтэн, профессор Ф.Хинцийн удирдсан судалгааны анги Муссаварат-эль-Суфра хөндийд ирэхэд элсэн далай дундаас багануудын орой, энд тэнд чулуун хавтангууд цухуйж байжээ. Малталтын үр дүнд сүм хийд, бунхан зэрэг олон



байгууламжийн балгасыг гаргаж чаджээ. Дараа нь гарсан ариун чулуун арслангийн баримлаар нь “Арслангуудын сүм” гэж нэрлэсэн газар малталт хийхэд уг сүмийг үндэслэгч гэж үздэг Арнекамани хааны дүрс бүхий шавар самбар илрүүлжээ. Сүмийг барьсан чулуун хавтангуудыг чимэглэсэн бичээс, зураг, товгор дүрсүүдийн дийлэнх нь яг хэвээрээ байлаа. Тэгээд ч хөндий Муссаварат-эль-Суфра буюу “Дүрсүүдээр чимэглэсэн газар” гэж нэрлэгддэг нь цаанаа их учиртай байжээ.

Дайн, үр жил шимийн арслан толгойтой Апедемак бурханд зориулсан “Арслангуудын сүм” байгалийн ямар нэгэн гамшгийн уршгаар нурсан бололтой гэсэн таамаглалыг профессор Ф.Хинце хийжээ. Чулуун хавтангуудыг өрж сүмийг сэргээн барихад товгор дүрсүүд, зургаар чимэглэсэн гоёмсог сайхан байгууламж сүндэрлэн босчээ. Нэгэн товгор дүрсээр Апедемак бурхныг гартаа нум барьчихсан, олзны хүн тууж яваагаар гаргажээ.

Хаан түүний өмнө өвдөглөн суусан үе залгамжилсан ханхүү, тэрчилэн сүм рүү орж ирж байгаа хүмүүсийг угтан авч байгаа арслангуудын 15 метр өндөр товгор дүрс харсан хүн бүрийн сэтгэлийг хөдөлгөнө. “Арслангуудын сүм” дотроос олдсон нилээд хэдэн алтан хавгасны зориулалтыг эрдэмтэд судалж сүмийн доторх багануудыг бүрсэн байжээ гэсэн дүгнэлт хийжээ.

Мероэ хотоос гучаад километр зайтай Кушийн нэгэн захирагчийн сүрлэг ордны балгас гарчээ. 300 мянган хүнийг цэвэр усаар хангаж чадах 250 метр орчим голчтой, 10 метр гүнзгий “хафир” буюу борооны ус цуглуулах дугуй нөөцлүүрийг чулуугаар доторлож хэрмээр хүрээлүүлсэн байв. Дайсан довтолж бүслэлтэд орсон үед оршин суугчдыг цэвэр усаар найдвартай хангаж байх зорилгоор энэ нөөцлүүрийг хийсэн бололтой.

Мероэ манай эриний өмнөх IV зуунд Кушийн хаант улсын нийслэл болжээ гэж зарим эрдэмтэн үздэг. Гэвч И.Можейко зэрэг эрдэмтэн тэр үйл явдал манай эриний зааг дээр болсон, хатан хаадын бунхнуудыг Напата биш чухамдаа Мероэ хотод барьж эхлэсэн гэсэн таамаглал дэвшүүлдэг.

Манай эриний өмнөх 235-221 онуудад босгосон “Арслангуудын сүм”-ийн бичээс, товгор дүрсүүд нь Мероэ хотын хөгжил цэцэглэлт нь Апедемак бурхныг шүтэж байсантай холбоотой болохыг гэрчилнэ. Үүнээс үзэхэд египетийн Амон бурхан гээд бусад бүх бурхан Апедемак бурхнаас доогуур байр суурьтай байв. Тиймд Амон, Апедемак бурхдын хоорондын тэмцлийн далд учир нь нийгмийн бодит харилцаа байжээ гэсэн дүгнэлтийг хийж болно. Кушийн хаант улсын нийслэлийг Напата хотоос Мероэд шилжүүлсэн нь Амон бурхны тайлгач нарын эсрэг тэмцэлтэй төдийгүй Апедемакийг үндэсний бурхан болон шүтдэг болсонтой холбоотой байжээ.

## ПЕТРА

Медины, Акаба хотуудаас гарсан замуудын билчир дээр орших Маан хотоос баруун-хойд зүгт дөчөөд километрийн зайтай Вади-Муса буюу Мойсейн хөндий оршино. Чухамдаа жингийн цуваа дайрдаг энэ нутгаар Мойсей еврейчүүдийг Египетээс гаргасан юм. Энд хадархаг уулын замд ядарч туйлдсан оргодлууд жаргалын оронд очих итгэл найдвар хадгалан цангаж, өлсөхийг үл хайхран урагшилж байжээ. Мойсей энд таягаараа хад цохиж хага ярахад булгийн ус олгойдож оргодлууд цангаагаа тайлж байжээ. Өнөөдөр уулын налуугаар цэцэрлэг, хүнсний ногооны талбай ногоорч үр шимтэй хөндий хүмүүсийн хөдөлмөрийн үр шимийг нь үнэлж жилд гурван удаа ургац хайрлана.



Ногоон цэцэрлэгийн цаана орших нүүдэлчин бедуин омгийнхны нутгаар дайрч ягаан хадны Петра хот хүрнэ. Хэдэн зуун аялагч, судлаач, зохиолч улаан хаданд сийлэн урласан сүрлэг сүм, ордныг хараад Петра хотыг сарнай шиг улаан, цаг хугацаа шиг эртний гэж магтан дуулсаар иржээ. Петра хотын эгц хадан хясааг улаан, цэнхэр, шар, цагаан өнгө алагласан дорны хивстэй зүйрлэнэ.

Хот руу очихдоо зам зуур Баб эль Зик хавцал маш давчуу болохоор толгойгоо бөхийлгөн гарна. Гэвч хавцал гэнэт тэлж манай эриний өмнөх VII зуун хүртэл Иордан улсын өмнөд хэсгийг захирч байсан арабын набатей омгийн эртний нийслэл нүдний өмнө тодорно.

Энд сууршисан эрэлхэг зоригтой, дайнч набатей омгийнхон Газрын дундад тэнгисийн зүг нутаг дэвсгэрээр нь дайран гарч байгаа жингийн цуваануудаас хэт өндөр гаалийн татвар авч татгалзсан тохиолдолд худалдаачдыг зодож занчиж тээж яваа бараа эд зүйлсийг нь “түр хугацаагаар хадгалахаар хураадаг.” байжээ.

Набатей омгийнхон нийслэлээ ямар ч дайсан хүрч чадахааргүйгээр уулын гүнд байгуулжээ. Оройнууд нь 90-180 метрийн өндөрт хоорондоо бараг наалдах шахам орших нарийхан Баб эль Зик хавцлаар километр гаруй явна. Хад тэнгэр халхалж тэнгэр тэртээ дээр нарийхан цэнхэр тууз мэт л харагдана. Тийм учраас набатей омгийн цөөхөн цэрэг дайсны бүтэл бүтэн армийг дийлж чадаж байжээ.

Набатей омгийнхны ялагдашгүй цэргийн тухай алдар ихэд түгсээр Петра хот түүний хаад

баяжсаар байлаа. Манай эриний өмнөх нэгдүгээр зуунаас манай эриний 40 он хүртэл Набатейн улс хөгжил цэцэглэлтийнхээ оргилд хүрч тэдний эзэмшил нутаг Дамаск хүрч байв. Түүний их баялгийн тухай дуулсан ромчууд гурван удаа дайтахаар ирсэн ч тухай бүр дийлдэж байжээ.

Гэвч ромчууд Петра хотыг дайтаж биш бүслэлт хийж усан хоолойг нь хааж набатейчуудыг тэсэшгүй цангааж байж сая нэг эзлэжээ. Манай эриний хоёрдугаар зууны эхнээс Петра Ромын эзэнт гүрний муж болж хөгжил нь нэг хэсэгтээ саараагүй байсан ч жингийн цуваа өөр замаар явдаг болсноор нэр хүнд нөлөө нь буурчээ.

Хожим нь IV зуунд Петра хот христос шашин шүтдэг Византийн эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтсан ч удаа дараагийн газар хөдлөлтөөс айж эмээсэн хүмүүс хотыг орхин гарсаар байлаа. Петра хотын сүүлчийн барилга байгууламжууд XII зуунд, загалмайтны аян дайны үед хамаарна. Тэр үеэс нутгийн бедуин омгийнхон ягаан чулуун агуй, сүм, мавзолейд амьдрах болж Петра хотыг гадаад ертөнц мартжээ.

Швейцарийн аялагч, хуучны судлаач И.Л.Бурхардт уулын гүнд орших нууцлаг хотын тухай сонсож, 1812 онд жингийн цуваа дагаж Дамаск хотоос Каир хот хүрч араб хэл сурч Аравийн цөлөөр явж байхдаа лалын шашинтны дүрд хувилж зөнч Аароны шарилд мөргөхөөр явна гэж тайлбарлана.

И.Л.Бурхардт ягаан, шар, цэнхэр өнгийн хад асга гэнэт багана, гоёмсог тагттай багануудаар чимэглэсэн байшин барилга болон хувирахыг харж мэл гайхжээ. Оршин суугчид нь цонх, хаалгаа хаахаа мартаад түр зуур гарсан мэт санагдана. Зам болгон дэвссэн хавтангууд он цагийн уртад хайрга болон бутарч усан оргилуур, усан сан нь хов хоосон, сүм, байшингийн хананууд цөлийн халуун салхинд өнгө төрхөө алджээ.

Петра хотын бүх ордон, сүм, бунхныг цул хаданд сийлэн хийснийг И.Л.Бурхардт олж хараад анхандаа нүдэндээ итгэхгүй байжээ. Орон сууцны байшингуудыг хүртэл хаданд ухаж сийлэн хийсэн байлаа. Зарим байшин нь хоёр давхар хийгээд хоёрдугаар давхартаа гардаг байсан шат нь алга болсон бололтой. Ихэнх байшингийн нүүрэн талуудыг ромын дэгээр хийсэн бөгөөд нэгэн гудамжны хоёр талаар ярайх байшингууд нь египетийн сүмүүдтэй адилхан байв. Петра хот Ромын эзэнт гүрний бүрэлдэхүүнд байхад 3000 хүний суудалтай театр, сүм, форум зэрэг олон барилга байгууламж баригдсан нь илт мэдэгдэж байдаг.

Библийн хөлгөн сударт гардаг Мойсей хотын тухай И.Л.Бурхардтын илтгэл түүнийг нас барснаас арван жилийн дараа нийтлэгдсэн нь бөөн шуугиан дэгдээж аялагч, судлаач, түүхчид тийшээ цувж эртний гар бичмэлүүд судалж эрдэмтэд удтал маргалдаж гарчээ.

Библийн хөлгөн судрын талыг баримтлагчид, Петра хэмээх хот нь Библийн сударт гардаг Синай (грек хэлээр петра гэдэг нь “хад” гэсэн утгатай ажээ.) хот мөн, еврейчүүд дөчин жил хэрэн тэнүүчилсний эцэст энд сууршижээ гэсэн таамаглал дэвшүүлэв. Гэвч Петра хотод ирэгсэдийн тоо нэмэгдэх тутам түүхэн баримт улам ихээр олдох болж тэдний таамаглал буруу болох нь бүр лавшрана. Ялангуяа хорьдугаар зууны эхээр хийсэн малталт эрдэмтдийн маргааныг нэг тийш болгож эцсийн цэг тавьжээ.

Өнөөдөр Баб эль Зик хавцал дотор ороход чулуунд сийлж товгор дүрсүүдээр чимэглэсэн набатей омгийнхны шүтээнүүд байна. Набатей омгийнхны цул чулуунд ухаж сийлсэн барилга байгууламж ялангуяа цул хадны судлууд жуулчдыг бахархал гайХШийг төрүүлнэ. Ягаан-улаан задгай театр, мөн адилхан өнгийн багана, хөвөө бүхий сүм, бунхан байна. Шүүхийн Триклинуим байшинг хар, улаан өнгө хослуулсан, долгион хэлбэртэй, саарал судлууд бүхий хадаар хийжээ.

Петра хотын хамгийн гоёмсог барилга нь үнэт эрдэнэс болох Эль-Касна ордон билээ. Баганат, хананд гаргасан баганууд, уужим цэлгэр танхим бүхий ордны улаан өнгийн нүүрэн талыг хаданд гүнзгий ухаж гаргасан хийгээд чулуун саравч нь бороо, нарнаас найдвартай хамгаалжээ. Эль-Касна ордны хийцийг набатей биш чухамдаа сонгодог дэг гэж үзэж болно.

Манай эриний нэгдүгээр зуунд барьсан набатейн омгийн захирагчдын өргөө бүх бүрэлдэхүүн хэсгийг нь цул хаданд сийлж урласан уран барилгын хосгүй нандин дурсгал билээ. Багануудын дээд хөвөө нь зараа уул ургамлын навч дүүргэсэн сагсыг санагдуулна. Дугуй танхимын голд байгаа сав дотор набатей омгийн захирагчид үнэт эрдэнэсээ хадгалдаг байсан тул уг ордныг гэнэдүүлэн дайрч дээрэмдэх гэсэн зэвсэгт оролдлого олонтаа гарч байжээ. Үүнийг нь ордны үүдний хажуу дахь ялангуяа толгой, хөл нь бусад хэсгээсээ илүү бууны суманд сийчүүлсэн баримал гэрчилнэ. Тэрчилэн үүдний нэг тулгуур баганыг нураасан ч ордон олон зуун жил байрандаа баттай байсаар байна.

Аль-Касна ордны цаана хөндий тал, нүүрэн талыг нь өнгөлсөн, зөөлөн ягаан болон өөр бусад олон өнгөөс бүрдэх хадан бунхнууд байна. Петра хотод бунхан тоймгүй олон байдаг тул түүнийг далайн түвшнээс дээш 900 метрт хадан ухаж сийлсэн бунхнуудын хот ч гэж бас нэрлэнэ. Зарим бунхныг хүн хүрч чадахааргүй эгц хадан хясаанд урласан нь үнэхээр мэл гайхмаар билээ.

Иордан улсын бахархал, нэрийн хуудас болох Петра хотыг үзэхээр жуулчид дэлхийн өнцөг булан бүрээс жил бүр хэдэн саяараа ирсээр байна.

## КОНСТАНТИНОПОЛЬ СТАМБУЛ

Стамбул хот нь үнэндээ Хар тэнгисээс, Босфорын хоолойд орох тэр хэсэгт сүндэрлэн байгаа Румелифенерийн цамхагаас эхлэнэ. Хотын европийн хэсгийг эргэн тойронд Румелихисарын цайзын зузаан хэрэм, шүдтэй цамхагууд харагдана. Босфорын хоолойны өргөн 450 метр байдаг тэр газарт Румелихисарын цайзыг барьсан хийгээд гадаадын олон түрэмгийлэгч уг цайзаар дайрч хоолойг гаталсаар иржээ.



Алтан Эвэр тэнгисийн булан болон Гантигийн тэнгисийн хооронд орших арал дээр грекийн Мегара хотоос дүрвэгсэд Византи хотыг манай эриний өмнөх 658 онд байгуулжээ. Анхандаа загасчид, худалдаачид сууршисан ч газар зүйн ашигтай байрлалынхаа ачаар Византи эрчтэй хөгжиж удалгүй грекийн бусад хот-улсын дотор тэргүүлэх байр суурь эзлэх болжээ.

Манай эриний өмнөх 196 онд Ромын Септимий Север хаан гурван жил бүслэлт хийсний эцэст Византи хотыг буулган авч эвдэн сүйтгэсэн ч зарлиг гаргаж сэргээн босгожээ. Ромын эзэнт гүрний Константин хаан 330 онд Византи хотод шилжин сууршиж шинэ нийслэлээ Шинэ Ром гэж нэрлэсэн ч бүтсэнгүй, Константинополь гэсэн нэр нь хэвшжээ. Хаан шинэ нийслэлээ Ром хотоос илүү үзэсгэлэн төгс болгохын тулд Коринф, Афин, Эфес, Антохи зэрэг хотуудаас шилдэг баримал, ховор гар бичмэл, шашны эд зүйлс, гэгээнтнүүдийн занданшуулсан шарилыг авчрах зарлиг буулгаж шилжин сууршигчдад хөнгөлөлт эдлүүлж төрийн сангаас талх, цөцгийн тос, дарс, түлш олгож байлаа. Уран барилгач, уран барималч, уран зураач, мужаан, чулуучдыг бүх татвараас чөлөөлжээ.

Константин хааны үйлсийг түүний залгамжлагчид нь үргэлжлүүлж Ром хотын сүм, талбайн чимэг болж байсан гантиган болон зэсэн багануудыг буулган авчруулж хотыг чимэглэхэд нийтдээ 60 тонн алт зарцуулжээ.

Ромын адил долоон дов дээр орших Константинополь үнэхээр сайхан хот байлаа. Өргөн цэлгэр гудамжууд, багана баримлууд бүхий уужим талбай, сүрлэг сайхан сүм ордон, ялалтын хаалгануудтай Константинополь хотыг эзэгнэхийг Дорнын олон захирагч, Өрнөдийн хаад санаархаж, аян дайн дараалан өдөөж байлаа. Тус хотыг грекүүд, ромчууд бүсэлж персүүд, болгарууд, киевийн вангууд, арабууд, туркууд довтлон дайрч байлаа. XI зууны үед загалмайтнууд дайлаар ирж нэгэн удаа хотыг эзлэж түйвээн сүйтгэж байжээ.

ХҮ зуунд Константинополь Османы эзэнт гүрний нийслэлээр өргөмжлөгдөж Инстанбул (Стамбул) нэртэй болжээ. Туркүүд хотыг өөрсдийн уламжлал, ёс дэгийн дагуу өөрчилж хаа дуртай газраа байшин босгож барилга бүрийг тойруулан хашаа барьж хотыг өнгө үзэмжийг дордуулжээ. Гэвч шинээр олон барилга байгууламж барьж байснаас хамгийн алдартай нь Цэнхэр сүм юм. 19 настай султан Ахмедийн зарлигаар босгосон сүм дотор ороход цэнхэр шигтгэмэл, цэнхэр өнгийн шаазан гээд бүх зүйл нь цэнхэр болохоор усанд шумбаж байгаа мэт сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө. Цэнхэр сүмийн Мекка рүү харуулан гаргасан хонхорхойд Каабаас авчирсан хар чулуу шигтгэн суулгасан болохоор энэ сүмд хамгийн чухал мөргөл хийдэг, тэрчилэн Зөнчийн төрсөн өдрийг тэмдэглэдэг байжээ.

Цэнхэр сүмээс холгүйхэн Египетээс зөөж авчирсан гурван гэрэлт хөшөө байгаагийн нэг нь Феодосий хааны хөшөө байлаа.

Стамбул хотын хамгийн том сүм нь арван мянган хүний багтаамжтай Сулейман султаны сүм ажээ. Уран барилгач Мимар Синаны төслөөр 1550-1557 онуудад босгосон сүмийн хана, бөмбөгөр оройд дотроо хөндий хоосон, цуурай давтагч домбо суулгажээ. Тийм учраас сүмийн мөргөлийн танхим дулдац сайтай болсон учир мөргөл үйлдэх үед аядуу зөөлөн үг хэлэхэд ч танхимын аль ч хэсэгт тод сонсогдоно.

Сулеймание-жами нь Сулейман султаны соён гэгээрүүлэх, сайн санааны үйл ажиллагааны тод жишээ юм. Лалын шашны цогцолборын бүрэлдэхүүнд дөрвөн медресе (медресе гэдэг нь лалын шашны сургууль гэсэн утгатай үг), сурагчид болон мөргөлчдөд зориулсан үнэ төлбөргүй үйлчилдэг цайны газар, номын сан, эмнэлэг, дэн буудал, халуун усны газар багтаж байв. Сулейман султан XVI зууны үед туйлын ховор болох энэхүү цогцолборыг байнгын ажиллагаатай байлгахын тулд тусгай сан байгуулж түүнд эд хөрөнгөнийхөө дийлэнх хувийг хандив болгон шилжүүлэн өгсөн байна.

Сулейман султаны шарилыг сүмээс холгүйхэн орших найман өнцөгт бунханд оршуулжээ. Түүний дэргэд байгаа хэмжээний хувьд арай жижиг бунханд түүхэнд Роксолана гэж мөнхөрсөн алдар цуут Хюррем хатан үүрд нойрсож байгаа ажээ.

Стамбул нь лалын шашны сүмүүдийн хот шиг сэтгэгдэл төрүүлнө. Султануудын зарлигаар юм уу тэдний дурсгалд зориулсан учир голдуу тэдний нэрээр нэрлэгдсэн таван зуу орчим сүмийн бөмбөгөр орой, жад хэлбэрийн ганжирууд холоос харахад хотыг бүрхсэн мэт үзэгдэнэ. Алтан Эвэр тэнгисийн булангийн төгсгөлд Эюп сүм байна. 670 онд Константинополь хотын анхны бүслэлтийн үед алагдсан султан Мехмедийн тугч Эюпийн шарил мөчир нь сагсайсан моддын дор байна.

Стамбул хотынхон сүмүүдээ Ром дахь Гэгээн София сүмийг дууриалган барьдаг байсан атал Османы эзэнт гүрний асар том нутаг дэвсгэрт сүм босгохдоо Стамбул хотын сүмүүдийг хуулбарладаг байсан нь их сонин. Ромын эзэнт гүрний Юстиниан хаан алдарт Айя София сүмийг бариулахдаа улс орныхоо таван жилийн татварын бүх орлогыг гар таталгүй зарцуулжээ. Энэ сүмийн бүх зүйл өвөрмөц сонин. Тухайлбал шохойг арвайн усаар зуурч цементэд цөцгийн тос нэмж байлаа. Хаан ширээний дээд тавцанг хийхдээ шинэ “материал” бий болгож хайлуулсан алтанд молор, сувд, нил болор, индранил, бадмаараг зэрэг үнэт чулуу хийж өнгө хослуулсан нь үнэхээр сайхан харагдана. Үнэндээ бол Айя София сүм бол

Византийн хамгийн гоёмсог сүм, Юстиниан хааны бахархал байлаа. 2

Туркүүд Константинополь хотыг эзлэсний дараа сүмийг лалын шашны сүм болгон хувиргаж дөрвөн ганжир нэмж барьжээ. Сүмийн танхимуудын ханыг янз бүрийн өнгийн гантигаар доторлож хоёр эгнээ гоолиг баганууд, хээ угалзаар чимэглэжээ. Тагт бүхий танхимуудад нь эртний византийн ханын зураг, шигтгэмэл хөргүүд байна. Сүмийг туркийн уран гартнуудын чимж михраб (Мекка руу харуулан хананд гаргасан хонхорхой), минбар (ламын индэр), максура (султанд зориулсан сараалжин хашлагаар тусгаарласан тавцан) зэргийг бахдам сайхан урлажээ. XIX зууны дунд үед сүмийг Аллах бурхан, зөнч Мухаммед түүний ач Хасан, Хусейн нар тэрчилэн анхны халиф Убу Бекра, Омар, Осман, Али нарын нэрийг алтан араб үсэг шигтгэн бичсэн том самбараар мөн чимжээ.

Стамбул хот өглөө эрт сэрж хөдөлгөөнд орно. Сагсанд талх, жимс, хүнсний ногоо дүүрэн хийсэн худалдаачид хамгийн түрүүнд гадаа гарна. Стамбул хотыг цэвэр усны худалдаачидгүйгээр төсөөлөх аргагүй билээ. Олон хонх унжуулан тогтоосон том зэсэн домботой ус нуруундаа үүрч шилэн аяга дүүрэн жижигхэн хайрцаг гартаа барьсан ундны усны худалдаачид гудамж захаар өдөржин хөлхөлдөн явна.

Стамбул нь дорно зүгийн аливаа хотын адил худалдааны захаараа алдартай. Хамгийн эртний худалдааны зах нь саравчаар битүүлсэн Капалы-Чарсы зах юм. Капалы-Чарсы бол гэрэлтэй, харанхуй гудамжуудтай, дэлгүүр, мухлаг, лангуу эцэс төгсгөлгүй үргэлжлэх бүхэл бүтэн хотхон ажээ.

Зах шиг эртний бас нэг байгууламж нь 450 гаруй жилийн түүхтэй “Пандилли” зоогийн газар юм. Хөх зураасууд бүхий цэнхэр паалантай тоосгоор барьсан зоогийн газрын танхимуудыг холбосон ханануудад тавгууд өлгөж өндөрт байгаа бөмбөгөр оройнуудаас цэцгэн дэн унжуулсан байх агаад санаанд багтамгүй зузаан хананд гаргасан цонхоор хотын дуу шуугиан сонсогдоно. Дэлхийд цуутай энэ зоогийн газарт хооллохоор дорнын гал тогоог сонирхогчид Франц, Испани, Өмнөд Америк, Япон зэрэг олон орноос байнга ирдэг.

Стамбул хот түүхэн дурсгалт зүйлүүдээр баян хийгээд түүний нэг нь Атмейдан талбай юм. Эл талбайд Константин хааны “Могойн багана”, Византийн Константин хаанаас аугаа Василий Македонский хаанд зориулан X зуунд босгосон багана байна.

Стамбул хот хоёр тив дамнан оршдог болохоор зарим оршин суугч нь Ази тивд амьдардаг ч Европ тив рүү ажилдаа явна.

Олон зууны тэртээ өнөөгийн Байлдан дагуулагч Мехмед султаны цайзаас холгүйхэн Персийн Дарий хаан хөхүүр ашиглан армия Босфорын хоолойгоор Европ тив рүү гаргаж байсан тухай эртний түүхчид бичиж үлдээсэн бий. Их Микеланжело гүүрүүд барьж хоёр тивийг холбохыг санал болгож байсан нь бодит үнэн билээ.

Чухам ийм учраас энд Европоос Ази руу орох Галатскийн гүүрийг барьжээ. Босфорын хоолойн эрэг дээр Стамбулын загасны зах байдаг болохоор гүүр дээрээс, эргийн орчим завинаас загас барьж тэр дор нь амьдаар нь юм уу шарж борлуулна.

## АЛЕКСАНДРИ

Александри хотод тэнгисийн замаар усан хөлгөөр ирж байгаа гадаадын иргэний нүдэнд хамгийн түрүүнд усан боомтын зүүн хэсэгт байрлах шар-саарал чулуун цайз тусна. Уг цайзын суурь дээр ертөнцийн долоон гайхамшигийн нэг болох Фароссын цамхаг цагтаа сүндэрлэн байжээ. Эрт дээр үеэс гадаадын иргэдэд таагүй ханддаг египетчүүдийн хувьд Африк тивийн хойд эргийн хад асга, хайрга харь нутгийн усан хөлгүүд буудаллахад саад болж байдагт баярладаг байв. Гэтэл энд ирж сууршсан грекчүүд Тунисаас 500 бээрийн зайтай, усан хөлөг зангуугаа хаяж болох цорын ганц газар болох арал дээр гэрэлт цамхаг босгожээ.



Суут жанжин Александр Македонский өнөөгийн Александри хотод ирэхэд загасчны Ракотис хэмээх жижигхэн тосгон байжээ. Их жанжны дагуулан яваа хүмүүсийн дотор цэргийн дарга, түүхч, ургамал судлаач, амьтан судлаач, бүжигчин бүсгүйчүүдээс гадна уран барилгач Дейнократ байв. Тэрбээр их жанжинд түүний “өндөр нэр хүндийг өргөх” хот байгуулах төсөл зураг гаргаж танилцуулахад Македонский хариуд нь “Чиний гаргасан хотын төсөл зураг надад их таалагдаж байна, гэхдээ хүнсний бүтээгдэхүүнээр бүрэн хангаж чадахгүй бол олон хүн амьдрах суурин газар бий болохгүй. Чиний хөдөлмөр, зүтгэлийг хүндэтгэж байгаа ч төслийг чинь дэмжиж чадашгүй нь..” гэж татгалзжээ.

Гэвч Александр Македонский Египетийг бүрэн эрхэндээ оруулах тэр үед Дейнократын “од” гийжээ. Тэнгис, Мариут нуурын хооронд усан боомт байгуулж болох тохиромжтой сайхан газар, тэрчилэн египетийн үржил шимтэй тариан талбай, ойрхон орших Нил мөрнийг хаан олж хараад хот босгохыг уран барилгач Дейнократад хандан даалгажээ.

Уран барилгач газар дээр цэргийн цув дэлгэн тавьж дээр нь элс нимгэн асгаж дараа нь ирээдүйн хотын гудамж, талбай болох тууш, хөндлөн зураасыг хуруугаараа татаж, дээр нь гурил асган тодотгон их жанжинд тайлбарлаж байтал тагтаа нисэн ирж гурил тоншин идэхэд, тэнд байсан бүх хүн хот босгох үйлс бүтэмжтэй болох нь гэж баярлажээ.

Хотыг барих ажлыг Александр Македонскийг одсоны хойно эхлэсэн ч тун эрчтэй өрнөв. Энэ бол 5 километр орчим урт, 1 километр хүрэхгүй өргөнтэй эллиний хийцийн хот байсан нь өнөөдөр урт нь 25 километр болж цагтаа тэнгисийн буланг зүсэж шорвог устай том нуурын эрэг болж байсан хошуурсан элсээр дамнан сунжирчээ.



А.Македонскийг Вавилонд гэнэт үхэхэд Македоний жанжин Птоломей Александри хотыг тэр даруй нийслэлээрээ сонгожээ. Египетийн сүүлчийн хаан болон эллиний ертөнцийн нийслэл, шинжлэх ухаан урлагийн томоохон төвийн тухай эртний олон зохиогч бахархам дурсамж бичиж үлдээсэн бий. Тухайлбал нэрт эрдэмтэн Афинеи түүнийг “алтан хот” гэж шагшин магтаж байлаа.

Александри хотыг зүүн талаас баруун тал руу нь хойд зүгээс нь өмнө зүг рүү чиглэсэн өөр нэг гудамжийг тэгш өнцгөөр зүссэн 30 метр өргөн гудамж хөндлөн гарна. Замын голд мод суулгасан нь түүнийг хоёр хуваасан мэт харагдана. Хотын гудамжууд нь голдуу шүтээний болон хаадын нэртэй, жишээ нь “Хоёрдугаар Арсиниягийн гудамж” гэдэг нь Птоломей хааны хатны нэр ажээ.

Александрия хот байгуулагдсанаасаа таван жилийн дараа гэхэд 300 мянган хүн амтай болж, манай эриний эхэн гэхэд оршин суугчдын тоо нь нэг саяд хүрсэн байлаа. Грекийн алдарт аялагч, газар зүйч Страбон “Газар зүй” номондоо тус хотын тухай бичихдээ “Хотын нутаг дэвсгэрийн бараг гуравны нэг хэсгийг олон нийтийн сайхан байшингууд, хааны тансаг орднууд эзэлнэ. Хааны ордныг хэрмээр хүрээлүүлсэн нь бат бэх цайз шиг харагдана.” гэжээ.

Хааны ордны нэг хэсэгт гүн ухаантан Деметрий Фалерийн саналаар байгуулсан Мусейон хэмээх гайхамшигт номын сан байна. Номын санд бүх эллиний ертөнцөөс үнэт, ховор гар бичмэлүүдийг цуглуулж дараа нь тэдгээрийг ангилж судлуулах, зохиол бүрт тайлбар хийлгэх зорилгоор эрдэмтдийг урьж ирүүлжээ.

Эрдэмтэд гар бичмэлүүдийн олон хувилбарыг хооронд нь харьцуулан судалж үр дүнг нь хамтран хэлэлцэнэ. Гүн ухаантнууд сургаалаа дэвшүүлж яруу найрагчид шүлгээ уншиж хэл зүйчид Гомер болон бусад сонгодог зохиолчийн бүтээлийг чангаар дуудан уншина.

Хотын төвд байрлах том ордонд төрийн байгууллагууд байрлана. Орон сууцны байшингууд нь намхан, хэдхэн давхар юм. Хотын баруун хэсэгт, хотын төвөөс зайдуухан гачуур модны боргоцойны хэлбэртэй хиймэл дов дээр Пан бурхны шүтээн байна.

Том усан боомтын хажууд, баруун орцных нь дэргэд Фароссын гэрэлт цамхаг байрлах арал харагдана. Цаг үеийнх нь техникийн бүх ололтын ашиглан хийсэн, 150 метрийн өндөрт байрлуулсан цамхагийн дээд тавцан дээр, бөмбөгөр оройны дор байрлуулсан галыг өнгөлсөн боржингоор хийсэн толиор гялбааг нь улам тодотгоход цамхаг 90 километрийн алсаас тод харагдана. Усан цэргүүд цамхагийг шинэ од гэж андуурч байсан удаа бий.

Сувгийн нөгөө эрэг дээр янз бүрийн бурхдад зориулсан шүтээнүүд байдгаас хамгийн сүрлэг нь Серапийон бурхны шүтээн юм. Энэ шүтээнийг Птоломей нэгдүгээр Сотер хаан санаачилж египетийн тайлгач Манефон, Афин хотын Тимофей удмын тайлгач нарын туслалцаатайгаар босгожээ. Энэхүү шинэ бурхны шүтээнийг Египет улсын египет болон грек хүн амыг шашны үндэс дээр эвлэрүүлэх зорилгоор бүтээжээ.

Египет орныг Птоломей угсааны хаад захирч байх үед Александри хотоор худалдааны олон зам дайрч байсан тул эдийн засгийн ач холбогдол нь улам нэмэгдэж байлаа. Янз бүрийн орноос жингийн цуваагаар авчирсан бараа, бүтээгдэхүүнийг Александри хотын боомтуудаас

Итали, Карфаген, Бага Ази, Сири зэрэг бусад оронд тээвэрлэнэ. Хотод вааран болон зэгсэн эдлэлийн урлал өндөр хөгжиж Энэтхэгээс авчирсан үнэт чулуу, африкийн зааны ясыг үнэт эдлэлийн урлангуудад боловсруулна.

Александри хотын уран барилгын дүр төрх өнөөдөр орчин үеийнх байгаа нь даан ч харамсалтай. 700 мянга гаруй ховор гар бичмэл хадгалагдаж байсан Мусейон номын сан байхгүй болж, уг номын сан чухам хаана байрлаж байсан асуудлаар эрдэмтэд харилцан хүлээн зөвшөөрөхүйц дүгнэлтэд одоо ч хүрээгүй байна. Гишгүүр дээрээс нь үзэгчид усан боомт, Антиродос арал дээрх шилтгээнийг хардаг байсан Их театрын барилга он цагийн уртад мөн алга болжээ. Хаадын тансаг орднууд үгүй болж аугаа жанжин А.Македонскийн бунхан хаана байгаа нь ч мэдэгдэхгүй өнөөг хүрчээ.

Александри хот дахь эртний ганц дурсгал нь “Помпейн багана” хийгээд түүнийг яагаад тэгж нэрлэсэн учрыг ч тайлж чадаагүй байна. Зарим судлаачийн үзэж байгаагаар Ром дахь Траяны багана шиг ялалтын хаалга бололтой. Энэ баганыг Египетийн Помпей мужаас өөрийгөө Египетийн хаанаар зарласан Ахиллейг дийлсэн ялалтын дараа нь Диоклетиан хааны дурсгалд зориулан 297 онд босгожээ. Өөр нэг хувилбараар бол нэгдүгээр Феодосий хаан 391 онд “христос шашин Египет оронд бүрэн ялалт байгуулсан”-д зориулан барьжээ.

Асуаны улаан боржингоор урласан “Помпейн баганыг” элсэн дов дээр байрлуулсан хийгээд тавцангаасаа орой хүртлээ 27 метр орчим өндөр ажээ.

Тэнгисийн яг эрэг дээр зөнч Даниилийн гудамжны төгсгөлд XIX зууны сүүлч хүртэл байрлаж байсан хоёр гэрэлт хөшөөг өнөөдөр харах боломж алга. “Клеопатрагийн зүүнүүд” гэж нэрлэгдэж байсан нэг гэрэлт хөшөө нь босоо хэвээрээ нөгөө нь элсэнд хагас далдарсан байв. Гуравдугаар Тутмос, хоёрдугаар Рамзес, хоёрдугаар Сети фараонуудын нэрсийг сийлсэн энэ хоёр гэрэлт хөшөөг Ромын амбан захирагч Барбар 19 онд Гелиополис хотоос зөөж Александри хотод байрлуулсан байсныг нэгийг нь 1979 онд Лондон хот руу нөгөөг нь 1880 онд Нью-Йорк хот руу авч оджээ.

Александри хот түүхийнхээ 2500 жилийн хугацаанд олон удаа халдлан довтлолт, тонуул дээрэм үзэж байсан бөгөөд арабууд 14 сар бүслэлт хийсний дараа 642 оны есдүгээр сард эзлэснээр Египет улс Византийн эзэнт гүрний бүрэлдэхүүнээс гарч, боомтын хотын ач холбогдол буурчээ. Хоёр зуун жилийн дараа гэхэд хотын нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо нь хоёр дахин багассан байлаа. Сайн санааны хошуугаар дайрч дорно зүг рүү арилжаа наймаа хийдэг худалдааны шинэ зам нээгдсэнээр Александри хотын усан боомт элсэнд булагдаж эртний байшингууд нь балгас болон хувирчээ. 1798 онд Наполеоны арми дайлаар ирэхэд хотын хүн амын тоо 7 мянган хүн болтлоо буурсан байжээ.

Александри хот Мухаммед Али султаны хаанчлалын (1805-1849) жилүүдэд сэргэн цэцэглэж тэнгисийн аялалын төв болж нутаг дэсгэрийн хэмжээ, хүн амын тоо нь аажмаар өсчээ.

Каир хоттой харьцуулахад Александри лалын шашны эртний сүм зэрэг арабын уран барилгын шилдэг бүтээлүүдээр дутмаг нь ойлгомжтой. Нүүрэн талд нь дорнын дэгээр хийсэн битүү тагттай байшин хаа нэгтээ л байна. Гэхдээ хотын тэгш, өргөн гудамжууд нь ороонгоор урласан хивс, шавж хийсэн дүрсүүд зэргээрээ ялангуяа XIX зууны үеийн итали

орныг санагдуулна. Александри хот уран барилгын дүр төрх гэхээсээ илүү олон мянган жилийн түүхийг бүтээсэн алдар цуутай хүмүүсийн нэрсээрээ анхаарал их татна.

## МЕККА

Уулсын дундах жижигхэн хөндийд хүний нүднээс далд лалын шашны шүтээн болох Мекка хот оршино. Чухамдаа дэлхийн өнцөг булан бүрт аж төрж байгаа лалын шашинтан бүр энэ хотын зүг рүү өдөрт таван удаа харж мөргөл хийдэг юм. Мекка хот нь Улаан тэнгисээс 70 километр зайтай, уулархаг Хижаз, төөнөм халуун Тихам хоёрын зааг дээр оршино. Хур бороо багатай болохоор энд газар тариалан эрхлэх боломжгүй, тэжээлийн ургамал, өвс тааруу тул энд мал аж ахуй огт хөгжөөгүй байна.



Гэхдээ уул нуруу, хагас цөлийн дунд оршдог болохоор худалдаа арилжаа хийхэд тохиромжтой, аюулгүй байдлын талаас ч боломжийн нутаг ажээ. Тиймд Өмнөд Арави, Сири, Газрын Дундад тэнгисийн эрэг хүрэх жингийн зам үүгээр дайрдаг байв. Мекка хот болон түүний эргэн тойронд арабын олон омгийн шүтээн оршдог учир энэ нутгийг ариун газар нутаг гэнэ. Аравийн өнцөг булан бүрээс мөргөлчид тасралтгүй ирдэг болохоор хотын иргэд тэдэнтэй наймаа арилжаа хийж амьжиргаагаа залгуулсаар иржээ.

Мекка хот нь уул нуруу, цөлөөр хүрээлэгдсэн байдаг тул дорно зүгийн бусад хотын адил хэрэм байхгүй. Хотын дундуур хөндлөн үргэлжлэх Массай гудамж руу уулын налуу дагуулан барьсан том, жижиг байшингуудаас олон давхар замууд сунжирсаар нийлнэ. Массай гудамжны дунд хавьд хөндий талын хамгийн доод хэсэгт байх захын талбай дээр алдарт Месжид-эль-Гарам (“Бурхны ордон”) сүм буюу Мекка хотын гол шүтээн болох Хаалттай сүм байрлана. Сүмийг шоо хэлбэрээр нь арабчууд “Кааба” гэж нэрлэнэ. Сүм барьсан газарт ертөнцийн төв оршдог, чухамдаа ертөнц ч биш газарт унасан тэнгэрийн хэсэг юм гэж лалын шашинтангууд итгэсээр иржээ.

Талбай дорно зүгийн уламжлалт хашаатай адилхан ч хэмжээний хувьд хавьгүй том ажээ. Түүнийг гантиг, боржин, жирийн чулуугаар урласан гурван заримдаа газартаа дөрвөн эгнээ багануудаар хүрээлүүлжээ. Багануудыг шовх нуман хэлбэртэй нуруугаар холбож дээр нь жижигхэн цагаан бөмбөгөр оройнууд байрлуулжээ. Багануудын цаанаас лалын шашны долоон цамхагтай сүм харагдана.

Хаалттай сүм анхандаа зургаан цамхагтай, Стамбул дахь Цэнхэр сүм мөн тооны цамхагтай байжээ. Тэгтэл Мекка хотын сүмийн хамба лам, ямар ч сүм Кааба сүмтэй адилхан байх

ёсгүй, энэ бол маш зохимжгүй зүйл гэж буруушаахад Ахмед султан Хаалттай сүмд дахин нэг цамхаг нэмж барих зарлиг буулгажээ.

Хаалттай сүмийн нутаг дэвсгэр нь бүх дэлхийн лалын шүтлэгтэнгүүдийн хувьд ариун газар шороо билээ. Тэр тухай лалын шашны Коран сударт “Та хаана ч төрсөн бай хамаагүй, Хаалттай сүмийн зүг харж бай, Та хаана ч явсан ялгаагүй үргэлж Хаалттай сүмийн зүг ширтэж бай!” гэж сургажээ.

Бишрэн шүтдэг бөөгийн бурхад нь мөн Каабад оршдог байсан тул эртний арабчууд Меккад байнга ирдэг байлаа. Кааба сүм бүх бурхдын бунхан учир аливаа шүтлэгтэн хүний хэрэгцээг хангаж чадаж байлаа. Уг сүмд 360 орчим шүтээн, бурханчлан шүтэж байгаа хүмүүсийн уран баримал түүний дотор арабын Илат, Уэза, Хубал зэрэг бурхад, ассир-вавилоны Мардук, Син, Самас, Астарт, Христ хүүг гар дээрээ барьсан еврейн хамба лам Авраам, Эх Дагина Мария нарын баримал байна.

Арабчуудын домгоор бол Кааба сүмийг хүн төрөлхтөний өвөг эцэг болох Адам шүтээний тахилын зориулалтаар босгожээ. Адам нүглээ наманчилсны дараа диваажингаас хөөгдөж мөргөл үйлдэх сүмгүй болсондоо их харамсаж машид зовж байв. Бурхан түүнийг өрөвдөж сүмийн хуулбарыг газарт буулгажээ. Сүм барихад хялбар байхыг бодож охин тэнгэр Жабриал агаарт унжмал, барилгын материал болох хавтгай чулууг Ибрахимд (Авраам) авчирч өгчээ. Өвөг эцгийнх нь хөлний мөр гарсан тэр чулуу одоо ч Кааба сүмд хадгалагдаж байна.

Талбайн голд 13 метр орчим өндөр, хавтгай дээвэртэй цул чулуу байгаа нь цагтаа бөөгийн шашны гол шүтээн байсан, одоо бол лалын шашны ертөнцийн гол сүм болох Кааба юм. Сүмд цонх байхгүй, мөнгөн хавтсаар өнгөлсөн хаалга нь газраас 120 сантиметр өндөрт байдаг тул шашны баяр ёслолын үед түрж авчирдаг модон шатаар явж сүм дотор орно. Хаалганы дээрх хэсгийг, сүмийн дөрөвний гуравны өндөрт сүмийн ханыг найман хэсэг хар торгон даавуугаар бүрсэн байна. Уг торгон даавуунд алтан, мөнгөн утсаар Коран судрын сургаалийг угалзлуулан оёсон байна.

Кааба сүмийн барилгын ажил дуусах үед шашны ёслолын үед сүмийг тойрох газрыг хананд заах чулуу хэрэгтэй болоход охин тэнгэр Жабриал Ибрахимд алдарт Хежер эль-Эсвад буюу Хар чулуу авчирчээ. Бурханд илэрлээ олсон нарны тогтолцоо болох нэгдмэл төвд бүх амь амьтан захирагддаг гэсэн бурхны тогтоосон журмын билэгдэл болох таваф буюу сүмийг долоон удаа тойрох ёслолыг Кааба сүмд мөргөл үйлдэхээр ирсэн сүсэгтэн бүр хийнэ.

Домогт дурдсанаар Хар чулуу Мекка хотоос дөрвөн хоногийн зайтай газар тэнгэрээс буухдаа цав цагаан байсан ч зам зуур хүн зоны нүглийн улмаас улам харласаар сүмд ирэх үедээ тас хар өнгөтэй болжээ. Сүсэгтнүүд Хар чулууг озон үнсэж Аймшгийн шүүхийн өдөр Хар чулуу хэлд орж Аллах бурханд тайлагнаж цэвэр ариун сэтгэлээ уудлан үнсэж чин сэтгэлийн үгээ хэлсэн хүмүүсийг нэрлэхдээ нэрийг нь дурдаасай гэж гуйна.

Кааба сүмээс холгүйхэн Замзам хэмээх ариун булаг бий. Ус арвин энэ ариун булагийг Бурхан өвөг эцэг Ибрахим түүний хүү, хойд африкийн омгуудын удирдагч Исмаилд зориулан бий болгожээ. Саррад хөөгдсөн зарц бүсгүй Хажар бяцхан хүү Исмаилийг дагуулан цөлөөр явж байхад уух ус олдохгүй арга баржээ. Тэгтэл бяцхан хүү Исмаил цанган уйлж суухдаа

жижигхэн хөлөөрөө газар цохитол тэр газраас цэвэр ус олгойдон булгилжээ Зарц бүсгүй Хажар бяцхан хүүгийн хамт цэвэр ус ууж цангаагаа тайлж булгийн усыг алдахгүй гэж элс тойруулан хамгаалжээ. Нар төөнөсөн цөлөөр цэвэр ус эрж шаналж байсан зарц бүсгүй Хажарын дурсгалыг хүндэтгэж үнэнч лалын шашинтнууд Мекка хотын урт нь 4000 гаруй метр урт гол гудамжаар нааш цааш долоон удаа гүйдэг юм.

Лалын шашинтан хүн амьдралдаа ядахдаа ганц удаа Меккад ирж мөргөл үйлдсэн байх ёстой гэж үзнэ. Эрт дээр үед Мекка хот руу аялал хийх нь зардал ихтэй, аюултай ч байв. Үнэнч лалын шашинтан Мекка орж мөргөл үйлдээгүй бол хойд насандаа аймшигт шийтгэл хүлээнэ гэж айж эмээдэг байв. Мекка орж мөргөл үйлдсэн хүний урьд өмнө үйлдсэн нүгэл уучлагдана.

Меккад ирсэн мөргөлчин олон ёслол үйлдэхдээ Зөнч Магомет бүх сүсэгтэн Аллах бурхны өмнө тэгш эрхтэй тул Меккад ирсэн бүх сүсэгтэн баян, ядуу ялгаагүй цөмөөрөө адилхан ихрам хувцастай байх ёстой гэж сургасан учир сүсэгтэн бүр нэгээр нь бэлхүүсээ ороож нөгөөг нь мөрөндөө тохдог ямар ч оёдолгүй хоёр хэсэг цагаан даавуу хэрэглэнэ.

Мөргөлчин Арафат уулын оройд гарч ламын хэлж байгаа сургаалийг тэмээнээс буухгүй сонсоно. Тэрчилэн Мине голын усанд чулуу хаяж Кааба сүмийг долоон удаа тойрч Хар чулууг үнсэж Замзам булгийн уснаас ууж Сафу болон Марва довуудын хооронд долоон удаа гүйнэ. Чухамдаа ийм ёслол үйлдсэний дараа “хаж” хэргэм хүртэж цагаан алчуур толгойдоо боох эрхтэй болно.

## БАРСЕЛОН

Манай хот Ромын Бүгд Найрамдах Улстай нас чацуу гэж оршин суугчид нь бахархан ярьдаг Барселон нь Испанийн хамгийн орчин үеийн хотуудын нэг юм. Түүнээс гадна тус орны аж үйлдвэржсэн томоохон мужуудын нэг болох Каталон мужийн гол хот ажээ. Гот хийцийн сүрлэг сүмийн хүйтэн саарал чулуу, орчин цагийн тэнгэр баганадсан өндөр байшингийн толин хана, жирийн иргэдийн даруухан орон сууц, хотын зах хавиар баячуудын босгосон тансаг байшингуудтай хороолол, хүний хөл тасардаггүй төв гудамжууд, хуучин хот дахь давчуу нарийхан гудамж, энэ бүхэн Барселон хотын дүр зураг ажээ.



Тэнгисийн зүгээс усан боомт руу ороход байгалийн гоц сайхан бүтээл болох эгц элгэн хад бүхий Монтжуих хэмээх том уул дүнхийн угтана. Усан боомтоос өргөн шатаар өгсөж уул дээр гарахад Х.Колумбын баримлыг оройд нь залсан, бэлээр нь асар том арслангийн баримлууд байрлуулсан 60 метр өндөр хүрэл багана байна. Усан боомтын дэргэд Х.Колумбын хөлөглөж Шинэ Тив хүрсэн “Санта-Мария” далбаат завины загвар байна.

Испанийн хаад бараг гурван зуун жилийн турш дараа нь дарангуйлагч Ф.Франко Каталонийг ямагт гадуурхаж шахан хавчдаг байжээ. Тийм учраас каталончууд дундад зууны үеэс бусад хоттой хамтран мавруудын эсрэг тэмцэж байхдаа бие даан тусдаа байх өвөрмөц “сэтгэлгээ”-тэй болжээ.

XIII зуунд каталончууд орон нутгийн язгууртан, сүм, хотын хүн амын янз бүрийн давхаргын эрх ашгийг илэрхийлсэн орон нутгийн засаг захиргааны байгууллага болох Кортес эмхлэн байгуулж байснаараа бахархдаг. Барселон хотын Кортес нэгдүгээр Рамон-Беренгер вангийн үед бий болсон ба гуравдугаар Роман-Беренгер вангийн хаанчлалын үед (1096-1113) Барселоны гүнлэг байгуулагджээ.

Дундад зууны үед Барселон тухайн цаг үеийнхээ аливаа хотын адил гар урлалын төв байлаа. Тус хотод нэхмэлийн аж үйлдвэрийн салбар эрчтэй хөгжиж торго, даалимба, хөвөн даавууны олон төрөл үйлдвэрлэж байжээ. Мөн арьс шир, гоёлын, вааран эдлэлийн салбар сайтар хөгжиж тэр ч бүү хэл Умард Америкийн эрэг хүрч шүр олборлодог байв.

Хаанаас 1453 оны наймдугаар сарын 20-ны өдөр гаргасан зарлигаар Арагоны хаант улсад

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг гадаадын усан онгоцоор тээвэрлэхийг хориглож, мөн худалдааны усан онгоцуудыг далайн дээрэмчдээс хамгаалах шаардлага амьдралаас урган гарсан учир тус хотод иргэний төдийгүй цэргийн зориулалттай усан хөлөг онгоцны үйлдвэрлэл далайцтай хөгжиж эхэлжээ.

Дундад зууны үеийн Барселон хот нь Египет, Сири, Тунис, Византи, Италийн Венеци, Генуя зэрэг Бүгд Найрамдах Улс гээд Газрын дундад тэнгисийн эргийн олон орон тэрчилэн Англи, Нидерланд, Португал, Герман зэрэг орнуудтай худалдааны өргөн харилцаатай байлаа. Барселоны худалдаачид ч Сицилийн, Кипр, Родос, Корсик арлууд хүрч төрөл бүрийн даавуу, шүр, жимс, элсэн чихэр арилжаалж зүү, хутга, төмөр утас, толь, бүрх малгай, орны цагаан хэрэглэл зэрэг төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн тээвэрлэн авчирдаг байжээ.

Каталон, Арагон мужуудын хаадын хооронд ураг төрлийн холбоо 1479 онд бий болсны үр дүнд Испанийн эзэнт улс байгуулагджээ. Энэ үеэс эзэнт улсын бүрэлдэхүүнд орсон Каталон мужийг дэд хаан захирах болсон ч Барселон хот засаг захиргааны нэгжийн хувьд бие даасан байдлаа хадгалж үлджээ.

Испанийн хаан ширээг залгамжлахын төлөө амь өрсөн тэмцэлд каталончууд Австрийн Карл ванг дэмжсэн боловч түүний өрсөлдөгч Филипп Анжуйский ялан дийлсний дараа Карлыг хаанаар өргөмжлөх амлалтаа биелүүлэх гэж тэмцлээ үргэлжлүүлж байжээ.

1714 оны есдүгээр сард испанийн цэргүүд Барселоныг эзлэж Каталоний кортес, “Зуугийн Зөвлөл”, цэргийн удирдлага гээд засаг захиргааны бүх нэгжийг татан буулгаж Серварээс бусад хот дахь их сургуулиудыг хаажээ. Түүгээр ч зогссонгүй, XVIII зуунд боловсрол, эрх зүйн салбарт каталон хэлийг хэрэглэх, ном хэвлэлийг хориглосон хэд хэдэн зарлиг гаргаж байжээ. Гэвч каталончууд соёлоо хадгалж хориглосон төрөлх хэлээрээ хоорондоо ярилцаж бяцхан цайз шиг хэлбэртэй орон сууцаа барьсаар асар том хүүхэлдэй, лууны жагсаал хийж хөгжилдсөөр байлаа.

Бүр хорьдугаар зуунд дарангуйлагч Ф.Франког нас барсны дараа нэгдүгээр Хуан Карлос хаан каталончуудад үндэсний соёлоо чөлөөтэй хөгжүүлэх бүх бололцоог олгожээ. Испанийн бусад түүхэн мужийн адил бие даасан эрхтэй болж парламентын үйл ажиллагааг сэргээж каталон хэлийг албан ёсны хэл болгожээ. “Каталон бол Испани биш харин Барселон хот Мадридаас хамаагүй дээр.” гэж онгирдог ч энэ үгэнд нь “улс орны хоёр дахь хот” гэсэн санаа цухалзаж байна. Ийм учраас барселончууд ням гариг бүр хотын сүмийн дэргэд үндэсний сардана бүжиг хийдэг байж магадгүй.

Таван зуу гаруй жилийн түүхтэй үндэсний сардана бүжгийг зөвхөн каталончууд л хийдэг. Үлээвэр найрал хөгжмийн хамтлагийн тоглож буй түргэн аялгуунд тус бүр нь 20-30 хүн бүхий 5-6 эгнээгээр тойрон бүжиг хийнэ. Ёслолын энэ бүжгийг каталоний эв нэгдлийг илэрхийлэн атгасан хоёр гараар толгой дээрээ барьж битүү цагираг үүсгэн бүжиглэнэ. Тойрон бүжигт оролцогчид инээх ёсгүй ажээ.

Барселон хотын гол чимэг болох алдарт Саград Фамилийн “Ариун гэр бүлийн сүм” 1884 онд баригдаж эхэлсэн ч барилгын ажил нь одоо ч үргэлжилсээр байна. Эргэн тойронд нь байгаа айлуудыг нүүлгэн шилжүүлж чадвал энэ сүм хэдэн арван жилийн дараа гэхэд суут уран



барималч Антонио Гауди төсөөлж байснаар 170 метр өндөр Аврагч Христос хөшөө тэрчилэн “Эх Дагина Мария”, “12 найдан” зэрэг нийт 18 цамхагтай сүрлэг сайхан сүм босох юм.

Газрын гүнээс тэнгэр өөд цоройж олон цаг үе, хотын уран барилгын дэгтэй зөрчилдөж байгаа Саград Фамилийн сүм нь Барселон хотын нэрийн хуудас болсоор зуу гаруй жил болж байна.

Сүмийн эргэн тойронд зүг бүрт сунжран орших нарийхан гудамж, талбай бүхий хороолол нь Готын гэж албан ёсны нэртэй ч дундад зууны үеэс уламжлагдан ирсэн “Өндөгний шар” нэрээрээ алдаршсан билээ.

Домгийн Геракл баатрын зүтгэлээр юм уу финикийн авхаалжтай худалдаачны ач, буянаар Барселон хот бий болсон бололтой.

## КОРДОВА

Испани улсын нутаг дэвсгэрийн хойд хэсэгт орших Андалус муж нь бараг таван зуун жилийн өмнөх үеийн аль-Андалус улсын түүхийг үргэлжлүүлж байгаа билээ. Аль-Андалус улсын хөгжим, гоо зүй, яруу найраг, уран барилгын уламжлал өнөө үеийн амьдралд ялангуяа арабын ертөнцөд хүчтэй нөлөөтэй хэвээр байсаар байна.



IX-XI зуунуудад аль-Андалус нь бие даасан эмирүүд дараа нь шилтгээн, харшны тансаг чамин байдал нь Багдад дахь эздийнх нь өргөө, ордныг хол давсан халифууд захирч байсан нэгдмэл хүчирхэг улс байв. Андалузын тал хөндийг зүүн-хойд зүгээс нь баруун-өмнөд зүг рүү хөндлөн урсах Гвадалквивир голын тохойд Сьерра-Морена уулсын өмнөд бэлд орших Кордова хот 717 онд аль-Андалус орны нийслэл болжээ.

Финикийн соёл иргэншлийн үед байсан хот ромын ноёрхлын үед Кордуба нэртэй болж хотын оршин суугчид Ром руу Ганнибалын хийсэн аян дайнд оролцож байв. Энэ хотод ромын суут иргэн гүн ухаантан Сенека, яруу найрагч Лукиан нар төржээ.

Дундад зууны үед энгийн иргэдийн 113 мянга орчим, язгууртнуудын 60 мянган байшин, 3711 усан сан, олон тооны гар урчуудын урлан, худалдаачдын мухлаг бүхий баян Кордова хот нь мавританы соёл, шинжлэх ухаан, урлагийн төв байв. Тэрчилэн вааран болон алт, мөнгө, болор, зааны ясан эдлэлээрээ алдартай байв.

Өнөөдөр хөдөөгийн бяцхан хот болох Кордова нь үржим шимтэй тариан талбай, цэцэрлэгийн дунд орших хийгээд испани орны үзэсгэлэнт нутгийн нэг билээ. Хотод ирсэн зочид, жуулчид хотын эртний хэрэм дээр гарч ромын гүүрийн үлдэгдлээр арабчуудын босгосон гүүрээр зугаалж мавритан хийцийн ордон сонирхож алдарт Альгамбра лалын шашны сүмийн баганат танхимуудтай танилцана.

711 онд Испанийн газар нутагт халдан ирсэн арабын жанжин Тарик бен Саид нийслэл Толедо хот руу цэргийн гол хүчээ хөдөлгөж Кордова хот руу бяцхан баг цэрэг илгээжээ. Хотын иргэд цөөхөн тооны халдан түрэмгийлэгчид ирж байгааг мэдээд төрөлх хотоо эрэлхэгээр хамгаалж байсан ч дайсанд хот орох замыг зааж өгсөн урвагч малчны гайгаар эзлэгджээ.

Хотыг эзлэснээс тавин жилийн дараа Омейядугсааны нэгдүгээр Абд ар-Рахман халифаар заларснаар хотын хөгжлийн шинэ үе шат эхэлж Кордова хот “хоёр дахь Багдад”, “Шинжлэх ухааны эх орон” алдар хүртэв. Тэр үед хосгүй ажиллах чадвар, шинжлэх ухааны олон талт үйл ажиллагаагаараа суут эрдэмтэн ибн-Рушид буюу Аверроэс алдаршиж байлаа. 1126 онд Кордова хотод төрсөн нэрт эрдэмтэн бага наснаасаа шашин, эрх зүй, арабын уран зохиол судалж гүн ухаан, байгалийн шинжлэх ухаан, анагаах ухаан, эрх зүй, хэл зүйн шинжлэлийн олон сонгодог бүтээл туурвиж байжээ.

IX-X зуун жилүүдэд шинжлэх ухаан, соёл оргил хөгжилдөө хүрч Кордова хотыг “ертөнцийн чимэг” гэж шагшин магтаж байв. 500 мянган оршин суугч амьдардагаараа европын аль ч том хотыг ардаа хол орхисон Кордова хотод 70 номын сан түүний дотор ховор ном судар бүхий 400 мянган орчим номтой хоёрдугаар Хакемийн номын сан байв. Хотын хүн ам бараг бүхэлдээ бичиг үсэгт тайлагдсан, эрэгтэй төдийгүй эмэгтэй оршин суугчид нь ном уншдаг төдийгүй номын цуглуулга хийдэг байлаа. Жил бүр 18 мянган ном, судар хуулан бичдэг байв. Олон язгууртан хүмүүс ном, гар бичмэлийн цуглуулгатай байх нь нэр төрийн хэрэг гэж үзэж гэртээ хуулан бичигч нарыг хөлслөн ажиллуулдаг байв. Кордова хотын оршин суугчид ном бишрэн дээдэлдэг тэрчилэн хуулан бичигчдийн өндөр ур чадварыг үнэлж Византийн хаад цэнхэр арьсан дээр алтан утсаар бичсэн талархлын илгээмжийг хотын захирагчид ирүүлж байв.

Омейяд угсааны удирдагчдаас хамгийн хүчирхэг нь болох хоёрдугаар Абд ар-Рахман эмир 1929 онд халифаар өргөмжлөгдөж хотоос 5 километрийн зайтай чамин гоё ордон, шилтгээний цогцогбор барьж хайртай хатан Захрагийн дурсгалд зориулж ордон босгож Мадинат аз-Захра гэж нэрлэжээ. Тэрбээр өргөөгөө чимэглэх зорилгоор алт, үнэт чулуугаар урласан 12 амьтны баримал бүхий ногоон гантигаар хийсэн усан оргилуурыг Византийгаас захиалан авчирч байжээ.

Византийн хаан халифт бэлэг болгож 150 гантиган багана, тэрчилэн Карфаген, Тунисаас 1003 багана, Францаас 19 багана нийтдээ 40 мянга орчим багана ирүүлж байв. “Хүлээн авалтын танхим”-д зааны яс, зандан модоор хийсэн баганууд, мөнгөн усан худаг байв. Халифийн Каср аль-Хулаф шилтгээн, Дар аль-Мулюк ордны цогцолборыг модон, гөлтгөнөн сийлбэр, баримал, хээ угалз, алтадмал сийлбэрээр чимэглэсэн байв. Өргөөний үүдэнд Захра хатны гантиган баримал байна.

XI зуунд бербер омог Кордова хотыг довтлон эзлэсний дараа эвдрэн сүйтгэж, тэрчилэн дотоодын байнгын өрсөлдөөн тэмцэлдээнээс халифын засаглал унаж хэд хэдэн муж болон хуваагджээ. 1236 онд Кордова хот Испанийн гуравдугаар Фердинанд хааны захиргаанд оржээ.

Кордова хотын хамгийн урт, өргөн гудамжийг хотын захирагч нарын нэг болох мятаршгүй хатан зоригт Диего Фернандесийн дурсгалд зориулан Гран Капитан гэж нэрлэжээ. Кордова хотын олон зуун жилийн түүх, цэцэглэлттэй холбоотой бүх зүйл тэрхүү алдарт сүмд төвлөрсөн гэж үзэж болно. Нэгдүгээр Абд ар-Рахман вестготуудын Гэгээн Висентийн сүм байрлаж байсан газрыг христос шашинтан иргэдээс худалдан авч 785 онд шинэ сүмийн шавыг тавьжээ. Сүмийг тойруулан газрын өндөр намтай уялдуулан 8-аас 20 метр өндөртэй хэрэм барьж түүний хажуугаар явган явагчдыг аадар бороо, төөнөсөн нарнаас хамгаалах саравчтай баганууд босгожээ.

Сүмийн угаалга үйлдэх таван усан оргилуур бүхий Амтаг жүржний дотоод хашаа руу Хонхны хаалгаар дамжин орно. Энэ сүм мянган жилийн түүхээсээ илүү дийлэнх хэсэг нь сүйддсэн гантиган багануудаараа ихэд цууд гарсан билээ. Тус бүр нь гурван метр орчим өндөр багануудыг хоёр өнгийн хоёр давхар нуман хаалгаар чимэглэжээ.

Хөгжим, уран зохиол, одон орны судлал, гүн ухаан сонирхогч хоёрдугаар Абд ар-Рахманы үед Багдад хотоос ираны нэрт дуучин Зириаб Кордова хотод ирж алдарт андалусын хөгжмийн дэгийн үндсийг тавьж консерватори байгуулжээ.

XIII зуунаас хойш Кордова хотын хувь заяанд бараг өөрчлөлт гарсангүй, түүхэн өнгөрсөн үе, урлаг соёлын алдар суу, уран баримлын “мудехар” дэгийн дурсгалууд нь нэрийн хуудас нь болсоор иржээ. Уран барилгын мудехар дэгийн сонгодог жишээ болсон сүмийг 1315 онд босгосныг еврейчүүдийг хотоос үлдэн хөөсний дараа эмнэлгийн зориулалтаар ашиглаж байгаад Гуталчдын нөхөрлөлийн мэдэлд шилжүүлжээ.

Уг сүмийн хашаа дотор Кордова хотын уугуул иргэн, дундад зууны үеийн нэрт гүн ухаантан, эмч, хуульч Маймонидийн мэндэлсний 800 жилийн ойд зориулан байрлуулсан чулуун хавтан бий. Дундад зууны үеийн еврейн томоохон гүн ухаантан болох Маймонид нь аль-Андалусын сэхээтнүүдийн шилдэг төлөөгч байсных нь хувьд түүнд зориулсан гартаа ном барин сууж байгаа эрдэмтний хүрэл баримал түүний нэрэмжит талбай дахь чулуун тавцан дээр сүндэрлэн байдаг.

Кордова хот орох Севилийн гулдан хаалганы дэргэд нэрт улс төрийн зүтгэлтэн, гүн ухаантан, яруу найрагч абу Мухаммед Али ибн Хамзын хөшөө байна. Тэрбээр шашны сэдэвтэй олон удаагийн маргаанд оролцож байсан хийгээд нэг биш удаа шоронд сууж, түүний зохиол бүтээлийг түүдэг галд шатааж байжээ. Түүний туурвисан “Тагтаан сондор” зохиол нь дундад зууны үеийн үргэлжилсэн үгийн шилдэг зохиолын нэг болон алдаршжээ.

## СИАНЬ

Хятадын эртний хотуудын нэг болох Сиань нь хятадын олон угсааны хаадын нийслэл байв. Үржил шимтэй Гуаньчжун хөндийд Хуанхэ голын тохойрлын ойролцоо орших тус хотод эрт дээр үеэс хүмүүс сууршисан байна. Хятадын аугаа их соёл иргэншлийн хөгжлийн түүх тусгалаа олсон Сиань хотыг таньж мэдэж байж Хятад орны мөн чанарыг ойлгоно.



Энд бүх зүйл хуучныг санагдуулж хот түүний эргэн тойрны бүх зүйл музей мэт сэтгэгдэл төрүүлнэ. Хятадын эртний түүхийн хэдэн мянган оршуулгын булц, дурсгал өнөөг хүртэл хадгалагдан иржээ. Хуучныг судлаачид хотын эргэн тойронд шинэ чулуун зэвсгийн үед хамаарах янз бүрийн гуч орчим суурин олжээ. Тэдгээрээс хамгийн том нь дагуул хот дахь Баньпоцунь тосгоны нутаг дэвсгэрээс олдсон суурин юм. Хуучныг судлаачид 1950 оны үед энд 45 мянга хавтгай дөрвөлжин километр талбайд малталт хийж тэгш өнцөгт, дөрвөлжин, дугуй хэлбэрийн 43 байгууламж илрүүлжээ. Ханыг нь банзаар доторлосон эдгээр газар доорх байшингуудыг хооронд нь шуудуйгаар холбож сууринг тойруулан гуу ухаж далан босгосон байлаа.

Суурингийн дэргэдээс вааран эдлэл хийх зуух олжээ. Тэндээс үр тариа хадгалах, ус зөөх том саваас авхуулаад давс хийх жижиг сав хүртэл өчнөөн төчнөөн сав суулга гарчээ.

Домогт Хоу Цзигээс түүх нь эхлэсэн гэж үздэг чжоу омгийн төрөлх нутаг Сиань байжээ. Чжоугийн үеийн нэгэн бунхнаас дугуйт тэрэг, гоёмсог тоноглолтой 6 морины шарил гарчээ. Хүрэл, тана, дунгаар урласан үнэт эд зүйлс нь ёслолын ач холбогдолтой байсныг нь гэрчилнэ.

Манай эриний өмнөх 770 онд Баруун Чжоу улс сөнөсний дараа уг улсын удирдагчид дорно зүгт нүүдэллэж Сиань нутаг эртний хятадын Цинь хааны захиргаанд оржээ. Сиань нутаг хэдэн зууны туршид хятадын түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгээгүй ч манай эриний өмнөх IV зууны дунд үед Цинь угсааны хаад нийслэл Саньян хотоо байгуулжээ. Хятад орныг нэгтгэж хятадын цагаан хэрмийг барьж эхлүүлсэн Цинь Шихуанди хаан түүхэн үеэ мөнхжүүлэхийн зорилгоор Саньян хотод Афангун ордны цогцолбор барих зарлиг буулгажээ. 10 мянган хүн, 16 метр өндөр туг багтаж байсан алдарт ордноос өнөө үе хүртэл өндөр далангийн хэсэг л үлдэж хоцорчээ.

Сиань хотод хятадын уран барилгын олон хосгүй сайхан ордон, сүм байв. Тэдний тоонд 652 онд босгож 704 онд өнөөгийн өндөрт нь хүргэсэн Даяньта буюу “Зэрлэг тогорууны том сүм” багтана. Гадна байдлаараа шаталсан пирамидыг санагдуулсан долоон тагт бүхий энэ сүмийн оройд намхан зузаан шовгор ганжир байна. Энэ сүмийг хятадын аялагч, бүддийн шашныг сурталчилагч Сюань Цзан үүсгэн санаачилсан бөгөөд сүмийг барьж дууссаны дараа тэнд ажиллаж Энэтхэгээс авчирсан бүддийн шашны судруудын орчуулга хийж байжээ.

Хятадын бас нэг аялагч-лам И.Цзиний нэртэй холбоотой Саоньта буюу “Зэрлэг тогорууны жижиг сүм” мөн цуутай билээ. 707 онд барьсан, 45 метр өндөр энэ сүмд 1555 онд болсон газар хөдлөлтөөр ан цав гарсан ч одоо ч хэвээр байна.

Сиань хот нь хятад дахь феодализмын алтан зууны билэгдэл болох Тан угсааны хаанчлалын үед хөгжил цэцэглэлтийнхээ оргил үед хүрсэн Хятад орны баян тансаг нийслэл байлаа. Хотыг тойруулан тэгш өнцөгт хэлбэртэй хэрэм барьж түүний дэвсгэр нутаг 85 хавтгай дөрвөлжин километр хэмжээтэй байсан нь өнөөгийн Сиань хотоос долоо дахин том байжээ. Хааны болон Ордны хотхонуудын гоёмсог барилгууд нь хажуу талаар нь мод, бут тарьсан гудамжуудыг чимж байлаа. Хятадын хаад эртний египетийн фараонуудын адил өөрсөддөө зориулан сүрлэг бунхнууд бариулж байв.

VII зууны дун үед Тан угсааны хаан Тайцзун уулын энгэрт Нефрит цэцгийн ордон, өөр нэг хаан Сюань Цзунь Туяаран гэрэлтдэг ордон бариулсаныг эртний хаадын орд харштай харьцуулж байв. Ард түмний амьдралд сайнаар нөлөөлдөг сансрын хүчийг татдаг гэж үзэж байсан Туяаран гэрэлтдэг сүмийг өндөрлөг газар байгуулсан хийгээд цэнхэрдүү өнгийн чулуу дэвссэн лууны сүүл шиг мурилзсан зөрөг замаар явж хүрнэ. Зөрөг замаар өгсөх зам зуур Хүлээл авалтын танхим, Зугаа цэнгэлийн танхим, номын сан, сүм, цэргийн хуарангаар дайрна. Байгууламжуудын эргэн тойронд хулс болон элдэв чамин мод тарьж горхинууд дамнуулан жижиг гүүр тавьжээ. Цөөрөм, нууруудын усанд загас сүлжилдэн хөвж бургас, цэцэгний дүрс тусна.

Анхилам үнэр ханхлах Туяаран гэрэлтдэг ордонд өдөржин, шөнөжин хөгжим эгшиглэж урлагийн тоглолт, зугаалга болно.

Гайхамшигтай гэж алдаршсан Сюань Цзунь хаан армидаа шинэчлэлт хийж улс орныхоо хил хязгаарыг бэхжүүлж эдийн засгийн бүх салбарыг төрийн хатуу хяналтад авч үр тарианд хатуу үнэ тогтоож хааны зарлигийн биелэлтийг хянадаг байцаагч нарын албыг бий болжээ. Сюань Цзунь хаан урлаг, уран зохиол ивээгч байж ордны номын сангийн үйл ажиллагааг цэгцэлж олон судар номоор баяжуулж ном, судрын тоог 6 мянгад хүргэжээ.

1974 оны гуравдугаар сард Сиань хотоос холгүйхэн орших тосгоны тариачид худаг ухаж байгаад газар доорх хонгил олжээ. Тэр бол дэлхий даяар шуугиан тарьсан Цинь Шихуанди хааны үеийн уран баримлын цогцолбор байлаа. Хуучныг судлаачид Цинь Шихуанди хааны шарилын малталтаар бодит хэмжээгээр нь урласан 6 мянга гаруй явган болон морин цэргийн баримал гарчээ. Эртний уран гартнууд шатаасан шавраар баримлуудыг урлахдаа цэргүүдийн үндэсний өвөрмөц онцлог, нүүр царайны хувирлыг гайхамшигтай сайхан гаргасан байна. Цэргүүдийн дүрэмт хувцас, биеийн байрлалаар нь албан тушаалын ялгаа, цэргийн ямар төрөлд хамаарагдаж байгааг нь тодорхойлж болж байлаа.

Сиань хотын бүх дурсгалт газрын тухай бичих болмжгүй бөгөөд энд Түүхийн музейн тухай цухас дурдая. Вэнь-Цзун хаан 837 онд эртний судруудыг хуулан бичих явцад алдаа гаргахаас урьдчилан сэргийлж том чулуун хавтангуудад эртний 12 чухал судрыг хуулж сийлэн бичих зарлиг гаргажээ. Дараа нь мөн 13 судрыг сийлэн бичжээ. Тэгээд хавтангуудыг хадгалах зорилгоор 1090 онд тусгай байшин бариулснаас Бэйлин (“Хавтангуудын төгөл”) музейн түүх эхлэжээ. Эдгээр хавтангуудад судрыг хятадын алдарт цэвэр бичигтэнгүүд хуулан сийлж бичсэн тул зөвхөн түүхэн төдийгүй уран сайхны маш чухал дурсгал болж байдаг юм.

## АКСУМ

XVII зууны дунд үе хүртэл европчууд Этиоп (Абиссини) улсыг бодит гэхээсээ илүү үлгэрийн орон гэж үздэг байв. Гэтэл Этиоп нь бүтэн хагас мянганы тэртээ дэлхийн дөрвөн том гүрний нэг байв. Персийн зөнч Мани тэр цагийн их гүрнүүдийг тоочиж Перс-Вавилоны, Ромын, Хятадын, Аксумын эзэнт гүрнүүд гэж бичжээ. Этиопийн эртний зохиолд манай эриний өмнөх хоёр зуун жилийн тэртээ нийслэл байсан Аксумыг ариун хот гэж нэрлэсэн байна. Хот анх байгуулагдсан үеэс уламжлагдан ирсэн нэгэн домгийг сонирхуулья :

Тэр үед тус орны гол хот нь асар том луу захирдаг Шеба байв. Тэрбээр харьяат иргэдээсээ мал, залуу бүсгүйчүүд татвар болгон авна. Нэгэн удаа эрэлхэг зоригт залуу Агабозын сүйт бүсгүй луунд татвар болон өргөн барих хүүхнүүдийн дунд багтжээ. Агабоз хайртай бүсгүйгээ аврахаар зориг шулуудаж харгис лууг халз тулаанд дуудан тэмцэлдэж, түүнийг алахад баярлаж талархсан ард түмэн түүнийг хаанаар өргөмжилжээ. Хаан Агабоз хайрт бүсгүйгээ хатнаар залж ухаантай, сайхан охинтой болсон нь хожим нь дэлхий даяар хатан хаан Савская нэрээр алдаршсан Македа байв.



Нуби, Өмнөд Аравийн сүм хийдийг эвдэн нурааж Египет улсад христос шашин шүтлэгийг бараг дарсан лалын шашинтнууд VII зуунаас эх оронд нь халдан ирэхэд Аксумын хаант улсын иргэд баатарлагаар эсэргүүцэн тэмцэж байлаа. Византи, Иран хоёр орны хооронд гарсан дайны хөлд армянчууд, коптууд, сирийн иргэд үрэгдэж байдал нэн түгшүүртэй байлаа. Тэгээд Египет, Сирийн удирдагчид христос шашныг эх орондоо төрийн шашнаар өргөмжилсөн Аксумын хаант улсын захирагч Калев Элла-Эсбегад хандаж дайтагч хоёр улсын эсрэг тэмцэлд Ойрхи Дорнодын ард түмнүүдийг нэгтгэх үүрэг гүйцэтгэхийг хүсчээ.

Тэр үед гэхэд л Аксум 700 жилийн түүхтэй буурал хот болсон байв. Тус орны ард түмнийг соёлжсон иргэд гэж эртний ертөнцөд ихээхэн хүндэтгэнэ. Төрөлх гээз хэлийг нь гадаад орнуудад мэддэггүй байсан тул тухайн үеийн боловсролтой хүмүүс болох худалдаачид, лам хуврагууд, дипломатууд цаг үеийнхээ олон улсын хэл болох грек хэлийг шамдан сурдаг байв. Аксумын хаант улсын далайн гол боомт хот болох Адулис хотоос гарсан усан хөлгүүд Египет, Энэтхэг, Цейлон орно. Жингийн цуваа жил бүр Этиоп улсын өмнөд хэсэг, одоо Сомали, Судан гэж нэрлэдэг улс орнуудыг чиглэн аян замд гарна.



Африкийн бусад орон тэрчилэн Европ, Азийн худалдаачид Аксумын хаант улсад дандаа ирнэ. Тус улсад зочлон ирж байсан VI зууны нэрт газар зүйч Козьма Индикоплов Аксумыг “аугаа их хот” гэж бахдаж хотын олон дурсгалт зүйлээс Калев Элла-Эсбех хааны хүрэл дүрсүүдээр чимэглэсэн “дөрвөн цамхагт ордныг” онцлон магтсан бий.

Византийн Юстиниан хааны элч Аксумын хаант улсын хааны ордонд зочилсон тухай тэмдэглэлдээ “Калев хаан алтаар чимсэн маалинган хувцас өмсчээ. Хувцасны зах нь бас цул алт юм. Гартаа жижиг бамбай, хоёр илд барьсан хааныг дөрвөн заан хөллөсөн тэрэг хөлөглөн зорчиход Хааны зөвлөлийн тVIIIмэд, бишгүүр үлээсэн хөгжимчид дагалдана.” гэж бичиж үлдээжээ.

Хааны ордон нь бүх барилга байгууламжийг нь нэгэн том суурин дээр босгосон Такха-Мариам нэртэй асар том цогцолборын бүрэлдэхүүнд багтана. Энэхүү цогцолборын балгасыг германы хуучныг судлаачид 1906 оноос судалж эхлэсэн ч бүтэлгүйтэж, дэлхийн хоёрдугаар дайны өмнө италийн фашистууд Этиопийг эзлэж цогцолборын нутаг дэвсгэрээр цэргийн зориулалттай зам тавихдаа түүнийг устгажээ.

Аксум хотод өөр олон ордны суурь хадгалагдан иржээ. Тэдгээрийн шалыг, Такха-Мариам цогцолборын адил солбицуулан суулгасан цагаан, ногоон гантиган хавтан юм уу тойпуугаар хийсэн байна. Хана, цонхыг үнэт чулуу, алтадмал хүрэл, ховор гантиг, модоор чимэглэжээ.

Этиоп улсын хамгийн ариун газар нутгийн нэг нь Аксумын сүм түүнийг хүрээлүүлсэн хашаа юм. Аллага үйлдсэн хүн энд ирж хоргодож шийтгэлээс мултарч байжээ. Тэрбээр сүмийн хаалгыг цохиж хоргодохоор ирснээ чанга дуугарч мэдэгдэнэ. Гэр бүл, анд нөхдүүд нь хоол ундаар хангаж гэмт хэрэг үйлдсэн хүн ийнхүү хатуу цээрлэлээс чөлөөлөгдөнө. Сүмийн хашаа дотор Аксум улсын хаан, хатан хаан ч дураар орох эрхгүй байжээ. Хашаа дотор байгаа жирийн сүмд эмэгтэйчүүд мөргөл үйлддэг байсан хийгээд сүмийн үүдэнд хүүхэд загалмайлах ёслолд хэрэглэх том сав байрлуулжээ.

Аксум хотын ариун зориулалт нь түүний хамгаалалт болж байв. Орон нутгийн зэвсэгт мөргөлдөөн гарахад, аль ч тал нь ариун хотод халдаж зүрхэлдэггүй байв. Галлийн нэгэн удирдагч Аксум хотыг эзлэж тонон дээрэмдэхээр шийдэж хотод ойртож ирэх үедээ морьтойгоо цуг оргүй алга болж байсан тухай домог яриа бий.

Ромын эзэнт гүрэн мөхөснөөс хойш Аксумын ухаант улсыг мартаж загалмайтны аян дайн хүртэл бараг дурсан санахгүй байлаа. Тэр үед дорно зүгт хаа нэгтээ христос шашин шүтдэг ард түмэн байдаг, тэд буруу номтнуудаас болж зовж зүдэрч байгаа тухай сураг чимээ европ тивээр тархжээ. Тэгээд загалмайтнууд Бурхны ариун орныг чөлөөлөх төдийгүй адил итгэл үнэмшилтэй хүмүүст туслахаар аян дайнд мордов. Гэвч тэд хаана амьдран суудгийг огт мэдэхгүй байв. Тэгтэл Португалийн хаан Энрике Далайчин бусдаасаа илүү алсыг хардаг төрийн зүтгэлтний хувьд урьдчилан элчин төлөөлөгч тэрчилэн тагнуул туршуул илгээж персүүд Европ тивээс салган авсан дорнын орнуудын тухай мэдээлэл цуглуулж байхдаа Аксумын хаант улсын тухай бодитой мэдээллийг авч тэр мэдээллээ европийн бусад оронтой хуваалцжээ.

Аксум хот орох замд грек, араб, гезз гэсэн гурван хэл дээр бичсэн гэрэлт хөшөө байдаг.

Бослого өдөөсөн хөрш орнуудын эсрэг аян дайн хийж байснаа мөнхжүүлэх зорилгоор Эзан хаан энэ хөшөөг босгожээ гэж эрдэмтэд үздэг.

“Ялагдашгүй Махрем бурхны хүү, Аксумын хаан Эзан би, хөрш босогчдыг дийлж ялалт бэлэглэсэнд талархаж, Махрем Бурхан Танд алтан, мөнгөн, төмөр гурван баримлыг өргөн барьж байна.” гэсэн үгсийг гэрэлт хөшөөний хананд сийлсэн байна.

Манай эриний өмнөх үеийн уран барилгын дурсгалаас Аксумд гэрэлт хөшөөнүүд л байна. Орчин үеийн Аксум хотын иргэд, чулуу хайлуулж чаддаг байсан ганц нүдэт том амьтад эдгээр гэрэлт хөшөөнүүдийг бүтээсэн гэж итгэлтэй ярина. Ганц нүдэт том амьтад чулууг хайлуулж урт модон хэвд цутгаж хатмагц нь засаж янзлан гэрэлт хөшөө болгон хувиргадаг байсан гэнэ. Зарим гэрэлт хөшөө хагаран унасан нь даан ч харамсалтай. Дайны үед италичууд нэгэн гэрэлт хөшөө авч одсон нь одоо Ром хотын нэгэн талбайн чимэг болжээ.

Эрдэмтэд малталт хийх явцдаа Хааны ордноос баруунтаа Бетэ-Гиоргис дов байгааг илрүүлжээ. Эртний барилгачид энэ довыг зузаан том хавтангуудаас бүрдсэн гурван давхар тавцан болгон хувиргажээ. Тавцан дээр дэлхийд хамгийн өндөрт тооцогдож байгаа 21, 24, 33,5 метр өндөр, цэнхэрдүү өнгийн цул хүрмэн чулуугаар урласан, тус бүр нь хэдэн мянган тонн жинтэй гурван гэрэлт хөшөөг байрлуулжээ. Гагцхүү Луксор дахь Египетийн Хатшепсут хатан хааны гэрэлт хөшөө, Ром дахь Латераны гэрэлт хөшөө л эдгээр гэрэлт хөшөөнээс арай өндөр ажээ.

Аксумын уран гартнууд гэрэлт хөшөөнүүдийг олон давхар байшингийн хэлбэртэй бүтээдэг байснаас хамгийн өндөр нь 14 давхар байшинтай тэнцэх өндөр ажээ. Дийлэнх гэрэлт хөшөөний хананд нэгэнд нь тойргийн хэлбэртэй нөгөөд нь хавирган сарны хэлбэртэй хоёр хонхорхой гаргадаг байв. Эдгээр хонхорхойд Нар, Сарыг дүрсэлсэн алтан, мөнгөн хялтас, Аксумын хаадын эрх мэдлийн билэгдэл болох алтан мөнгөн жад суулгадаг байсан бололтой гэсэн таамаглалыг эрдэмтэд дэвшүүлдэг.

VI зуунд Этиоп улсад христосын шашин бүрэн нэвтэрсний дараа хаадыг бунхан барьж оршуулдаг болсон нь олон зууны туршид шүтээн болон иржээ. Язгууртан хүмүүсийг хотын зүүн-хойд хэсэгт орших дов дээр нутаглуулдаг хийгээд дов руу очихдоо Савская хатан хааны усан сав гэж нэрлэдэг цэвэр усны том чингэлэгийн хажуугаар гарна. Асар их үнэт эдлэл бүхий хаадын бунхнуудыг эрт дээр үед тоносон учир тэнд одоо хоосон авснууд л байна.

VI зууны сүүлчээр персүүд Өмнөд Аравийг эзлэж Аксумын хаант улс тусгаар тогтнолоо хадгалан үлдсэн ч азийн орнуудтай хийдэг худалдаа нь зогсчээ. Гэвч VII зууны эхээр Аксум улсын хаадын нэр хүнд өндөр хэвээр байв. Этиопийн хаад оршин суугчдаа шашны үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхдаггүй байсан учир шахалт хавчлагаас болж Мекка хотоос зугтсан лалын сүсэгтнүүд Аксумд ирж хамгаалалтад ордог байв.

VIII зууны сүүлчээр Аксумын хаант улс бүрмөсөн унаж Этиопийн ариун хот эзгүйрчээ. Нийслэл хотын байрлалыг өөрчилсөн ч Аксум хот XIX зуун хүртэл чухал ач холбогдолтой хот хэвээр байж тус орны шашны төвийн үүргийг өнөөдөр ч гүйцэтгэсээр байна.

## ТОЛЕДО

Бурхан Нарыг бүтээж түүнийг Толедо хотын дээр байрлуулжээ.” гэж эртний нэгэн домогт өгүүлсэн бий. Толедо хот чухам хэдийд үүссэн тухай түүхийн лавтай мэдээлэл одоо ч алга байна.

Толедо хотыг тольдон харахад бодит бус, үлгэрийн юм шиг сэтгэгдэл төрнө. Тахо мөрөн дээгүүр тавьсан цамхаг бүхий гүүрүүд, хадархаг баруун эрэг дагуух хэрмийн цаана дорно зүгийн намхан байшингууд нэг нэгэндээ бараг наалдан оршино, хотын гол сүмийн шовх ганжир тэнгэр өөд цоройж Алькасар сүрлэг цайз сүндэрлэнэ. Хотын нарийхан гудамжаар алхаж явахад хуяг дуулга өмссөн, илд агссан рыцарь эрүүд дараалан гарч ирнэ. Бэлэг дурсгалын дэлгүүрийн эзэд эртний баатруудын загварыг байрлуулсан нь энэ ажээ.



Толедо хот түүхийн тавцанд эрт дээр үед гарч ирсэн болохоор испанийн бусад хотоос илүү олон домог түүхтэй ажээ. Эртний нэрт түүхч Тит Ливий “Ромын түүх” номондоо ромчууд Пиренейн хагас арлыг эзлэсэн тухай бичихдээ ашигтай байрлалтай Толетум хэмээх бяцхан хотыг шургуу эсэргүүцлийг нь дарж байлдан дагуулсан тухай дэлгэрэнгүй өгүүлсэн бий.

Пиренейн хагас дээр ромын соёл өргөн дэлгэрч Толедо хот ромын дэгээр барьсан сүм, цирк, театртай болсон ч тэдгээрээс өнөө хүртэл хадгалагдаж ирсэн нь дэндүү цөөхөн. Харамсалтай нь Толедо хотыг хожим нь эзлэсэн вестготууд ромчуудын босгосон барилгуудыг сүм дугана барихаар нурааж байжээ. 20 мянган хүний суудалтай ром хийцийн циркийн балгас Толедо хотоос холгүйхэн байдаг. Түүний ойролцоо хот үүссэн тухай домогтой холбоотой “Геркулесийн агуй” оршино.

Толедо хотыг 456 онд эзлэсэн вестготууд түүнийг хаант улсынхаа нийслэлээр зарлаж улс төр, соёл, шашны төв болгон хувиргажээ. Сүм хийдийн тогтоолууд төрийн зарлигийн ач холбогдолтой болсон VI зуунд Толедо хот түргэн хөгжин цэцэглэжээ.

Гэвч вестготын язгууртнууд эрх мэдлийн төлөө хоорондоо байнга тэмцэлдэж байсныг нь далимдуулан арабчууд дайтахаар иржээ. Маврчууд ойртож байгаа тухай мэдээ авсан вестготуудын Родриго хаан өөдөөс нь цэргээ хөдөлгөж 711 оны зургаадугаар сард Гуадалупын дэргэд болсон алдарт тулалдаанд ялагдал хүлээжээ.

Арабчууд испанийн хотуудыг дараалан эзлэж Толедо хотынхон төрөлх хотоо хамгаалан эрэлхэгээр тулалдсан ч нэгэн урвагчийн гайгаар дийлджээ. Гэсэн ч Толедо хотынхон эзлэн түрэмгийлэгчдийг хүлээн зөвшөөрсөнгүй, маш олон удаа бослого гаргаж байв. Хотыг Толаитола гэж өөрчлөн нэрлэсэн маврууд тус хотод дөрвөн зуу гаруй жил ноёрхжээ.

Толедочууд эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэж байсан ч олон зуун жилийн хугацаанд арабын соёлын нөлөөнд өөрийн эрхгүй орсон билээ. Арабчууд хотод олон тооны сүм, ордон барьснаас XI зууны хоёрдугаар хагаст Ал Мамлюк эмир хотын гадна өргөө байгуулсан нь үнэхээр бахдам сайхан байсныг арабын түүхчид бичиж үлдээсэн байдаг. Том цөөрмийн голд байгуулсан үзэсгэлэнгийн танхимыг солонгын долоон өнгөөр алагласан паалантай тоосгоор доторложээ. Хамгийн сонирхолтой нь цөөрмийн ус дээшилж үзэсгэлэнгийн танхимын дээд өнцөгт хүрэх мөртөө дотогшоо нэвтрэн ордоггүй байсан ажээ.

Испанийн цэргийн давшилтын үед гээд арабын ноёрхлын үеийн олон байшин барилга нурж сүйджээ. Тухайлбал лалын шашны Баб ал Мардомын сүмийг Санто-Кристо де ла Лусын сүм болгон хувиргажээ. Уг сүмд хамба ламын очирт таяг барьсан, улаан нөмрөгтэй настайвтар хүний баримал байгааг мавруудыг Толедогоос хөөн гаргасны дараа тодорсон анхны хамба лам Бернгардынх гэж урлаг судлаачид үздэг.

VI Альфонс хааны удирдсан испанийн цэрэг Толедо хотыг 1085 онд чөлөөлж мавританы захирагчдын Алькасар ордны дээр испани улсын тугийг мандуулжээ. Толедог нийслэл хотоор зарласны дараа лалын шашныг дэмжигчидтэй тэмцэлдэхээр Испани төдийгүй европийн бусад орноос рыцарь эрчүүд тогтмол ирдэг байв.

Мавруудын эсрэг тэмцлийн явцад испанийн хотуудын хүчин чадал, баялаг нэмэгдэж түүний дотор Толедо хамгийн баян хот болон хөгжиж испанийн утга зохиол болон уран сайхны амьдралын төв болон манджээ. Түүнээс гадна европийн шинжлэх ухааны төвүүдийн нэг болж ялангуяа орчуулгын дэг нь цууд гарав. Энд Аристотель, Платон зэрэг эртний грек, ромын алдарт зохиолчдын бүтээлүүдийг араб хэлнээс орчуулж байв.

1226 онд Толедо хотын хамба лам Хименес де Радын санаачилгаар гот хийцийн сүрлэг сүм босгож эхлэсэн нь хоёр зуу гаруй жилийн турш баригджээ. “Испани төдийгүй европ тив дэх гоо үзэсгэлэн, төгс төгөлдөр сүм”, “гот дэгийн сүрлэг сайхан сүлд дуулал”, “гайхамшигт ард түмний дурсгал” гэж уг сүмийг нэрлэдэг ажээ. Энэ сүм хэмжээний хувьд Милан, Севиль дэх сүмүүдээс бага ажээ. Хэдэн зуун жилийн хугацаанд эл сүмд хуримтлуулсан урлагийн хосгүй нандин бүтээл үнэхээр гайхмаар олон билээ.

Дундад зууны үед Толедо нь Испани улсын улс төр, соёлын төдийгүй аж үйлдвэр, худалдааны төв байлаа. Толедод үйлдвэрлэсэн болдоор хийсэн чинжаал хутга, жадыг хамгийн шилдэгт тооцож торгон даавуу үзэмж, өвөрмөц сайхан зургаараа гайхагдаж ваар, сав суулга зэрэг вааран эдлэл нь шагшигдаж байв.

Испаничууд Толедог эзлэсний дараа үеэс католик шашныхан лалын урлагтай зүйл бүрээр тэмцэж байсан ч түүний нөлөө хэвээр байлаа. Толедо хотын урчууд шашны зориулалттай барилга байгууламжийг барихдаа мавританы уран барилгын дэгийн өвөрмөц шинжийг европ тивийн орнуудаас суралцсан роман, гот дэгүүдтэй донжтой хослуулж гоёл-уран зургийн

шинэ дэг бий болсныг “мудехар” гэж нэрлэжээ.

Хойд нүүрэн талыг нь мавританы дэг бүхий нуман хаалгаар чимэглэсэн Санта-Исабель де лос Райес сүмд мудехар дэг бүрэн илэрлээ олсон байдаг. Сүмийн танхимуудад гөлтгөнөөр урласан гоёмсог чимэглэл бүхий нуман хаалганууд бий.

Толедо хотыг нийслэлээр зарламагц испанийн язгууртнууд хааны ордонд ойр байхын тулд бөөнөөрөө ирж суурших болж ордон шилтгээн барихдаа мавритан дэгийн барилгуудыг үлгэр жишээ болгож нүүрэн талыг нь энгийн, төлөв байдлаар, төмрөн сараалжин бүхий цөөхөн цонх, хүнд бэхлээстэй модон нүсэр хаалгануудтай хийжээ. Гэхдээ дотор талд нь ороход үзэсгэлэнгийн жижиг танхим, цэцгийн мандал, усан оргилуур бүхий чамин гоё хийцтэй хашаа, олон өнгийн вааран чимэглэл харц булаана.

Хэмжээлшгүй эрхт хаант ёсыг хамгаалагч хоёрдугаар Филипп хаан эрх чөлөөт байдлыг эрмэлзэгч Толедо хотын оршин суугчдаас зайлсхийж нийслэлээ 1561 онд Мадрид хотод шилжүүлжээ. Хааны талын хүмүүс шинэ нийслэл рүү мөн шилжиж хотын хүн амын тоо багассан ч амьдрал байдал хэвийн явагдаж шашны баяр ёслолыг урьдын адил өргөн дэлгэр хийнэ. Габсбургийн угсааны хаадын эрхИШээлд орохыг үл хүсэгч, дундад зууны үеийн Испанийн эрхэм тэмүүллийг бишрэгч бардам, эрх чөлөөт язгууртнууд уран зураг, уран баримлын урлагийг ивээн тэтгэгч хэвээр байж хотын уран сайхны амьдрал улам эрчтэй явагдаж байлаа. Испаний сэхээтнүүдийн шилдэг төлөөлөгчид Толедо хотод ирж уран бүтээлээ туурвина. Толедо хотыг Сервантес “ертөнцийн бахархал гэрэл гэгээ”, Лопе де Вега “Испанийн голт зүрх”, Бедекер “испанийн түүхийн чулуун судар” гэж бахархан үнэлж байв.

Тахо мөрний эгц эргийн өндөр хадархаг талбай дээр оршдог, эртний язгууртны удам угсаа олноороо оршин суудаг, дундад зууны үеийн шилдэг уламжлалтай, эртний хотын уур амьсгал нь “кастилийн шашны уран зураач” болох Эль Грекогийн онгодыг хөглөж байлаа. Мадрид хотод хааны ордонд байр сууриа олж чадаагүй крит арлын уугуул иргэн Эль Греко Толедо хотод шилжин ирж гүн де Вильений ордонд сууршижээ. Хорьдугаар зууны эхээр түүний эдлэн газрын зарим хэсгийг XVI зууны дэгээр сэргээн засварлаж түүний гэр музейг байгуулжээ.

Суут зураачийн гэр музейд Толедо хотын дүр төрхийг харуулсан олон зураг өлгөөстэй байдгаас ширээт лам Таверийн эмнэлгийн барилгыг дүрсэлсэн зураг бусдаас онцгойрно. Үүлний цаанаас тусаж байгаа бүдэг гэрэлд хот үзэгч рүү ойртон байгаа амьд дүр мэт санагдана.

“Хамгийн испани зураач”-ийн олон бүтээл Толедо хотоос гадна байдгаас АНУ-ын алдарт Метрополитен музейд буй хотын өвөрмөц уур амьсгалыг гаргасан “Толедо хотын дүр төрх” нэртэй зураг ихэд цуутай билээ.

Толедо хотын хөгжөөнт, эрчимт амьдрал байдал аажимдаа саарч эртний уран барилгын дүр төрхөө хадгалж шидэт нойронд умбажээ. Хорьдугаар зууны жар, далаад оны үед испанийн олон хот бүтээн байгуулалт өөрчлөлтөд ороход Ф.Франко Толедо хотод ямар нэгэн өөрчлөлт хийхийг хориглож байв. Тиймд Толедо хот Эль Грекогийн үеийнх шиг яг хэвээрээ байна.

## КАБУЛ

Кабул хотын тухай анхны бичмэл эх сурвалж манай эриний өмнөх Хоёрдугаар зуунд хамаарна. Эртний грекийн нэгэн эрдэмтний зохиолд Афганистан улсын өнөөгийн нийслэл оршиж байгаа газрыг Кабур гэж нэрлэсэн байдаг. Тус хот Дундад Азиас Энэтхэг орох замд маш ашигтай байрлалд байдаг учир худалдаа арилжаа эртнээс эрчтэй хөгжиж байсан ч гадаадын байлдан дагуулагчдын шуналыг бас хөдөлгөж байжээ. Хот байгаа хөндийгээр Александр Македонский, Персийн Дарий хаан гээд олон байлдан дагуулагч цусан мөр татуулан өнгөрч байлаа.



Кабул хот XIII зуунд татар-монголчуудын морин цэргийн хөлд сүйдсэн ч Их Моголын эзэнт гүрний бүрэлдэхүүнд орсноор сэргэжээ. Их Моголын хаадын угсааг үндэслэгч Бабур хаан Кабул хотыг гоёмсог сайхан хот гэж үзэж нийслэлээ болгожээ. Тэрбээр хотыг Адамын перс хэлээр “Кабил” нэртэй нэг хүү үндэслэсэн гэж итгэдэг байв. Бабур хааныг Агра хотод өөд болоход, гэрээсэл ёсоор нь Кабул хотод оршуулжээ.

1737 онд Персийн Надир-шах Афшар хаан Кабул хотыг эзлэж эвдэн сүйтгэсэн ч хот урьдын адил сэргэн босчээ.

Хотын нэр хэрхэн үүссэн талаар эрдэмтэд нэгдмэл дүгнэлтэд хүрээгүй байна. Гэхдээ кабулчуудын ярьдаг олон домгоос нэгийг нь толилуулья.

Энэ нутаг дээр үед намгархаг байсан болохоор зам харгуй муу, бороо орсон үед явах бололцоогүй болно. Падишах нэгэн удаа замаар явж байтал морьдын хөл нь шаварт шигдэж цааш явах аргагүй болов. Өмнө нь усны мандал нь цэлэлзэн байгаа нуурын голд жижигхэн арал харагдана. Падишах хэсэг бодлогошросноо шадар сайдаа дуудаж гарам хийхийг тушаав. Ойролцоох тосгодоос дайчлагдан ирсэн тариачид сүрэл авчирч давхарлан тавьсаар сүрлэн гүүр бэлэн болгов. Падишах сүрлэн гүүрээр явсаар арал дээр очиход чөлөөт цагаа дуу, бүжигт зориулдаг хөгжимчид дуу тоглож байв.

Падишах тэдний тоглолтыг их таашааж, арал дээр ирснээ билэгдэж “КаХПоль” буюу “Сүрлэн гүүр” гэж нэрлэжээ. Он цагийн уртад нуурын ус ширгэж сүрэл зөөн авчирч байсан тосгон хот болон хувирчээ. КаХПоль нэр яваандаа Кабул гэж дуудагдах болжээ.

Кабул хот хоёр уулсын нурууны бэлд оршиж байсан ч өргөжин тэлж уулын хавцлаас мултарч баруун зүгт Кабул голын урсгалаас дээш өргөжжээ. Хот хуучин-өмнөд, шинэ-хойд гэсэн хоёр хэсэгт хуваана. Шер-Дарваз нурууны бэлд орших хуучин хот нь эрт дээр үеэс хэрмээр хүрээлэгдсэн байлаа.

Кабул хотод шөнийн цагаар нисэх онгоцоор нисэн ирэхэд тэнгэр баганадсан байшингуудаар хүрээлүүлсэн том хул аяга мэт харагдана. Гэвч өглөө нь олон давхар байшин биш, уулын эгц налуу өөд өгссөн жижиг байшингууд нүдний өмнө тодорно. Чухамдаа эдгээр жижиг дэнлүү шөнийн цагт гэрлэн далайг үүсгэдэг ажээ.

Шавар, гар хийцийн түүхий тойпуун байшингуудад хотын оршин суугчдын дийлэнх нь сууна. Нүүдэлчид, тариачид хотод шилжин ирж уул өөд мацан байшин барьсаар уран барилгач, ариун цэврийн эмчийн хяналтгүй эмх замбараагүй кишлак бий болжээ. Тийм учраас хотын олонх гудамж нэргүй, оршин суугчид нь хаяггүй ажээ.

Жуулчид сонирхмоор эрт цагийн дурсгал Кабул хотод маш ховор байдаг. Гэхдээ хоттой ойртон танилцахад лалын шашны 583 сүмээс гадна хуучны үеийн дурсгалт зүйлс цөөнгүй байгаа нь мэдэгдэнэ. Үүнд шийтүүдийн мөргөлийн ордон, индуизмын шашны сүм, христос сүм гээд нийтдээ эртний үеийн 38 мөргөлийн газар бий.

Кабул хотын худалдааны голт зүрх нь 1880 онд английн аялан байлдах цэргийг бут цохисон Кандагар хотын ойролцоох нутгийг мөнхжүүлэх зорилгоор нэрлэсэн Майванд өргөн чөлөө юм. Өргөн чөлөөнд тэрхүү түүхт үйл явдалд зориулан босгосон сиймхий нүхүүд бүхий далавчуудыг нь гялтганадаг хавтангаар бүрсэн шовгор хэлбэрийн цамхаг байна.

Майванд өргөн чөлөөний дэргэд олон зах байдгаас Чар-Чата (“Дөрвөн гулдан хаалга”) зах бусдаасаа их содон ажээ. Нарийхан муруйж тахиралдсан гудамж, догол гудамжуудаас бүрдэх зах дээр хэдэн мянган хүн гараараа тэнгэр өөд зааж зүрхэн талдаа барьж нэгэн зэрэг хашгирч маргалдана, арилжаа худалдаа хийнэ. Гагцхүү сихки буюу даавууны наймаачид Кабул хотын бүх оршин суугчийг нэгэн зэрэг хувцаслаж болох хуйлсан торго, хилэн, даалимбаны дэргэд хөлөө өвдгөөрөө нугалан дуугүй сууна.

Кабул хотын тоймгүй олон захын хаан нь Миндаи билээ. Энд байхгүй зүйл огт үгүй хийгээд кабулчууд “Хэрвээ Та Миндаи захаас эрж хайсан зүйлээ олж чадаагүй бол тэр зүйл хорвоод огт байдаггүй гэсэн үг.” гэж хошигнон ярьцгаана.

Дуу шуугиантай худалдааны хотын дэлгэц дээр том тэгш бус шүдтэй, бууны нүхүүд бүхий зузаан хэрэм их сонин харагдана. Ү зуунд барьсан, зарим хэсэгтээ 7 метр өндөр, суурийн өргөн нь 4 метрээс илүүгүй хэрэм Шер-Дарваз нурууны хяраар Кабул хотын дээгүүр мурилзан сунжирна.

Шер-Дарваз нурууны зүүн салааны бэлд Бала-Гиссар цайз сүндэрлэн байна. Эрт дээр үед эмирүүдийн эсрэг бослого гаргасан тариачдын удирдагчдыг энэ цайзанд хорьж байжээ. Англичуудын эсрэг афганы ард түмний тэмцэлд энэ цайз их тус хүргэжээ. Английн цэргүүд 1879 оны есдүгээр сард Кабул хотыг эзлэж байшин барилгыг түйвээж урьд хожид дуулдаагүй харгислал үйлджээ. Бала-Гиссар цайз дотор “үхлийн тойруулга” гэж нэрлэсэн тойрог

хэлбэрийн цаазын дүүжлүүр хийж афган иргэдийг хэдэн арваар нь нэгэн зэрэг цааш харуулдаг байв.

Өнөөгийн Кабул нь олон өнгө төрхтэй хот билээ. Уулын хяр, налуугаар сүлжин байгаа нарийхан давчуу гудамжуудын зэрэгцээ афганы уран барилгачдын бүтээлүүд сүндэрлэн босож байна. Кабул голын зүүн эрэг дагуу орших шинэ хотод европийн уран барилгын дэг илт мэдрэгдэнэ. Энд тэгш, өргөн гудамжууд сунжирна. Хотын энэ хэсэгт гадаадын элчин сайдын яамд, Афганистаны Засгийн газрын яам, тусгай газрын орчин үеийн барилгууд байна. Хотын хоёр хэсэг олон гүүрээр холбогдоно. Олон арван жил үргэлжилсэн дайны аюулаас ангижирч эрх чөлөөтэй болж байгаа афганистаны ард түмэн эртний түүхтэй нийслэл хотоо улам сайхан болгох нь мэдээж хэрэг.



## ФЛОРЕНЦ

Флоренц хот байгуулагдахаас бүр өмнө Арно мөрний эргийн үржил шимтэй газар нутагт хүмүүс амьдран сууж байжээ. Мөрний эрэг дээр биш, өндөр дов дээр Этруссын Фэзулы хот байв. Этруссчууд VIII зууны үед энд ирж сууршихдаа Арно мөрний үерээс гадна хамгийн гол нь байгалийн гамшиг аюулаас дутуугүй хор уршигтай хорон санаат хүмүүсээс зайлсхийж зориуд өндөрлөг газар сонгон сууршиж байжээ.



Этрусс улсыг ромчууд эзлэж тусгаар тогтнолыг нь устгасан ч Фэзулы хот ач холбогдлоо алдсангүй, манай эриний өмнөх 90-88 онуудад италийн бусад хотын хамт ромчуудын эсрэг бослого гаргасан ч дийлджээ. Юлий Цезарь “Уулын Фэзулы” хотыг сүйтгэж хожим нь тэтгэвэрт гарсан ахмад дайчдаа суулгажээ. Ромын ахмад дайчид шинэ хот барихдаа цэргийн хуарангийн маягаар дөрвөлжин хэлбэрийг сонгосон байна. Чухамдаа “Castra Florentia” буюу “Цэцэглэж байгаа цэргийн хуаран” үгнээс хотын нэр үүссэн гэсэн таамаглалыг эрдэмтэд гаргадаг юм.

Ромын эзэнт гүрний үед Флоренц хот хөгжиж байсан ч онцгойрч байсангүй. Италийн бусад хотын адил эл хотод сүм, халуун усны газар, задгай театр, театр, мэдээж хэрэг форум нэртэй төв талбайг барьсан байв. IX-X зууны үед Дунд болон Хойд Италийн нутгуудад гар урлал газар тариалангийн үйлдвэрлэлээс салж барааны үйлдвэрлэл улам өргөжсөн. Флоренци хотод банк, зуучлалын худалдаа, нэхмэл ноосны үйлдвэрлэл голчилон хөгжиж байлаа.

XI зуунд хот нөлөө бүхий язгууртан, гүн Тосканы удмын мэдэлд шилжиж тэдний хаанчлалын жилүүдэд хотын хүн амын орлого эрс нэмэгдэж амьдрал огцом дээшилж хот хүрээгээ улам тэлжээ. XII зуунд Тосканы угсааны гүнгүүдийн хаанчлал дуусахад Флоренц хот “чөлөөт коммуна” нэртэй бие даасан эрх эдлэх болж үсрэнгүй хөгжлийнхөө замд оржээ. Чөлөөт хотод хууль тогтоох эрх мэдлийг ард түмэн эдэлж гүйцэтгэх засаглалыг 1138 оноос Флоренц хотын дүүрэг бүрээс нэг жилийн хугацаагаар сонгогддог Консулын зөвлөл бүрдүүлдэг болжээ. Мэдээж хэрэг рыцарь эрчүүд, нөлөө бүхий сеньор, язгууртан гаралтай хүмүүс консулаар сонгогддог байсан хийгээд хамба лам хотын амьдралд ихээхэн нөлөө үзүүлдэг байлаа.

Зэвсэглэсэн рыцарь эрчүүдийн шилтгээн хотын эргэн тойронд бий болж худалдаачид, гар

урчууд ихээхэн хөрөнгө хуримтлуулж Италийн бусад хот төдийгүй гадаад орнуудтай өргөн арилжаа наймаа хийж байв. Энэхүү дайчин, хийморьлог язгууртнууд тариачдыг газар эзэмшигч сеньоруудаас чөлөөлсөн авч эрХШээлдээ оруулжээ. Эрх чөлөөтэй болсон тариачдын хувьд Флоренци хотын өргөн талт үйл ажиллагаанд оролцох сонирхолтой байв.

Худалдаачид аж үйлдвэрийн язгууртнуудтай тэрсэлдсээр ХШ зууны эхээр тэдний тэмцэлдээн нийгмийн бүлэглэл төдийгүй угсаа, гэр бүл, ззарим хүмүүсийн хооронд болон өргөжсөөр хуйвалдаан бослого тасрахаа байж байнга цус урсана. Энэ үед хаан, хаант засаглалыг дэмжигч феодалууд болох гибеллийн намынхан болон иргэний засаглалын төлөө тэмцэгч гвельфийн намынхны хоорондын удтал үргэлжилсэн сөргөлдөөн эхлэжээ.

Гэвч 1250 онд гвельфийн талынхан ялалт байгуулж гиббеллинчуудыг Флоренцээс хөөж анхны Үндсэн хуулийг баталж ард түмний иргэний эрхийг тунхаглав. Энэ үеэс хотын хүрээ тэлж олон гудамж хотоос салаалж хот дундад зууны нийтлэг дүр төрхийг олов. ХШ зууны сүүлчээр хотыг тойруулан хоёр дахь хэрмийг барьж түүнээс цааш гол мөрний хөх тууз, нов ногоон дэнж дов үргэлжилсэн байгалийн сайхан нүд баясаж сэтгэл сэргээдэг болжээ.

ХШ зуунд хотын иргэд өнөөдөр жуулчин гийчин бүрийн сэтгэлийг эзэмдсэн үзэмж төгс ордон, шилтгээн барьж эхлээгүй байсан ч хуучин сүм дуганаа засварлан шинэчилж байлаа. Тухайлбал тус хотын хамгийн эртний сүмд тооцогдох Загалмайлагч Гэгээн Иоанны сүмийн байшинг янзалжээ. Уг сүм ХШ зууны дунд үе хүртэл хотын гол цацар сүм байсан эл сүмд шинээр мэндэлсэн оршин суугчдыг бүгдийг нь загалмайлах ёслолыг хийдэг байв.

Эртний хотын ивээгч гэж бишрэн шүтдэг байсан Марс бурхны сүмийн буурин дээр 448 оны үед босгосон эл сүмийн барилга найман талт хэлбэртэй агаад түүний нүүрэн талуудыг цагаан, хар-ногоон гантигаар өнгөлж өндөр гоолиг багануудыг нь хагас дугуй хэлбэртэй нуман хаалгаар чимсэн байв. Флоренцчууд христос шүтлэгтэнгүүд болж ивээгчээ сольсон ч Марс бурхны баримлыг Арно голын нөгөө эрэгт шилжүүлж гүүрний дэргэд байрлуулжээ. Энэхүү баримлыг хэрхэн нандигнан хадгалахаас Флоренц хотын алдар суу, оршин суугчдын сайн сайхан аж амьдрал шууд хамаарна гэсэн итгэл үнэмшил хотын иргэдийн дотор өнөө үед хүртэл байсаар байна.

Флоренц нь дундад зууны үед италийн гэгээрсэн хотуудын нэг байлаа. Ромын ноёрхлын үеэс уламжлагдан ирсэн “долоон чөлөөт шинжлэх ухааны” сургуулиуд, сүм хийдийн дэргэдэх сургуулиудад шашны номлолоос гадна гүн ухаан, уран зохиол заадаг байв. Тэр үед их сургууль байгаагүй ч нийтийн сургууль, эрдэмтдийн хувийн дугуйлангуудад шинжлэх ухаан заах явдал өргөн дэлгэрсэн байв. Их Дантегийн багш, нэвтэрхий тольч Б.Латинийн алдар нэр европ даяар түгжээ.

Флоренц хотын оршин суугчид ХШ зууны эхнээс яруу найргийг бишрэн дээдлэх болж Сицили болон Умард Италийн нутгуудад провансалийн бүрээчдийн тоглодог уянгалаг аялгуу өргөн тархжээ.

XIV зууны дунд үеэс Флоренц хотын амьдралд Строцци, Альберти зэрэг шавхагдашгүй эрч хүчтэй, ажил хэрэгч хэд хэдэн гэр бүл тодрон гарч ирсний дотор Медичийн угсааных хамгийн баян, хамгийн нөлөө бүхий гэр бүл болон мандав. Ах гэж түүхэнд мөнхөрсөн

Медици өргөн мэдлэг боловсролтой хүн байгаагүй ч боловсрол, урлагийг бишрэн шүтэгч байв. “Эх орны эцэг” гэж алдаршсан Козимо Медич хувийн ордон, шилтгээн төдийгүй хотыг чимэглэх зорилгоор уран зураг, уран баримлыг цуглуулга бий болгохоор хөрөнгө мөнгө гар татахгүй гаргадаг болсноор алдарт Уффицийн уран зургийн галарей бий болжээ.

Цаг хугацаа урагшилсаар шашны үзэл суртлын эсрэг хүнлэг хэмээх шинэ үзэл суртал бүрэлдэн бий болж аж төрөх нөхцөл байдал урьдын адил хатуу хүтүү хэвээр байсан ч хүмүүс энэ хорвоо дэлхийн гоо сайхныг мэдэрч идэвх зүтгэлтэй, чөлөөтэй сэтгэдэг, ёс суртахууныг дээдэлдэг хүнийг хорвоогийн амьдралын гол хүчин зүйл гэж үздэг болов. Өвөг дээдэс нь Флоренц хотод амьдран сууж байсан Франческо Петрарки “Зэрлэг амьтад, загас, шувуу, могойнуудын мөн чанарыг судлан мэдэхийг эрмэлздэг мөртөө хүмүүс бид юуны төлөө энэ замбуулин хорвоод мэндэлсэн юм бэ, бид хаашаа явж байгаа тухай эрэгцүүлэн бодож хүний мөн чанарыг ойлгохыг тэмүүлэхгүй байгаа нь ямар ч утга учир алга.” гэж харуусан бичиж байлаа.

Ертөнцийг үзэх хүнлэг үзэл Флоренц хотод хөгжил цэцэглэлтийнхээ оргилд хүрч Сэргэн мандалтын урлаг төлөвшин бий болох үндэс болжээ. Бидний амьран байгаа хорвоо ертөнц, хүнийг танин мэдэх маш их сонирхол нь дундад зууны үед алга болсон хөрөг зургийн урлаг сэргэхэд хүргэв. Сэргэн мандалтын үеийн анхны суут уран барималч болох Флоренцийн уран гартан Донателло 1411-1413 онуудад Гэгээн Маркийн гайхамшигт баримал бүтээснийг Орсанмикель дэх сүмд байрлуулжээ. Их Микеланжело тэр баримлыг өндөр үнэлж “Журамт хүнтэй ав адилхан энэ баримал шиг бүтээлийг би урьд өмнө нь огт хараагүй, Гэгээн Марк яг ийм хүн байсан юм бол түүний сургаалд итгэж болно.” гэжээ.

Хүнлэг үзэл Ф.Брунелескийн уран барилгын бүтээл, реалист уран зургийн аргыг гарамгай эзэмшиж домгийн баатруудыг жирийн хүмүүсийн дүр төрхтэй дүрсэлсэн Т.Мазаччийн уран зургуудад илэрлээ олж байв. “Христосыг өрөвдсөн нь” баримлаараа алдаршсан Микеланжело Ромоос төрөлх хотдоо буцан ирж сүмийн хашаанд хаясан цул гантигаар домгийн баатар Давидийг сэтгэл санаа хөдөлсөн үедээ Голиаф руу чулуу шидэгчээр буудах гэж байгаа тэрхүү агшныг нь 1504 онд урлаж дэлхийн урлагийн хосгүй бүтээлүүдийн нэгийг бүтээжээ.

Суут Рафаэль 1504 оны сүүлчээр Флоренц хотод дөрвөн жил ажиллах хугацаандаа алдарт Эх Дагинын дүрүүдээ туурвижээ. Леонардо да Винчи чухамдаа энэ хотод алдарт “Жоконда” зургаа гараасаа гаргажээ.

ХҮ зууны эхээр францийн VIII Карл хааны цэрэг Неаполь хотыг дайлаар мордох замдаа Флоренц хотыг эзлэж тус хотын хөгжлийг таслан зогсоосон билээ. 1480 оны үед Флоренцийн эзэн болсон лам Д.Савонарола уран сайхан үгээр хотын иргэдийн итгэлийг хүлээсний дараа Данте, Ф.Петрарки, Д.Бокаччо нарын зохиолыг түүдэг галд шатааж “зохимжгүй” гэж үзсэн уран зураг, сийлбэр, уран баримал тэрчилэн тачаал төрүүлэх элдэв зүйл, толь, хөзөр, шатрын хөлөг зэргийг устгажээ. VI Александр хамба лам хорвоогийн аз жаргалыг эсэргүүцэгч Д.Савонаролаг шашны үйл ажиллагаанаас холдуулж 1498 онд түүнийг хоёр аялдан дагагчийнх нь хамт Синьорийн талбайд цаазалжээ.

Флоренц харьцангуй жижиг хот ч дэлхийн соёлын түүхэнд зүйргүй их үүрэг гүйцэтгэсэн билээ. Түүхэн болон уран сайхны дурсгалуудаараа алдартай италийн бусад хотын дотор

Флоренц хот урлагийн эрдэнэсийн сан гэж зүй ёсоор тооцогддог юм.

## ЛОНДОН

Кельт омгийн жижигхэн тосгон Лондон гэсэн нэртэй байсан боловч чухам ямар түүхэн үед бретончуудын кельт омгийнхон энд сууршиж байсан нь одоо хэр тодорхойгүй байна. Довтлон ирсэн ромчууд энд цайз барьж бараг дөрвөн зуу шахам жил ноёрхжээ. Юлий Цезарь манай эриний өмнөх 55 онд анх удаа 54 онд хоёр дахь удаагаа кельт омгийнхныг байлдан дийлжээ. Гэхдээ манай эриний 43 онд Клавдий хаан Английн газар нутгийг бүрмөсөн эзлэжээ.



Ромчуудын ноёрхлын үед Лондон хотын дүр төрх олж тэр үед худалдааны томоохон төв болж өнөөгийн Тауэрийн цайзын буурин дээр ромын цамхаг, одоо Гэгээн Павелийн сүм байгаа дов дээр ромын Диана сүм сүндэрлэн боссон байв. Хожуу үед Баадикеея хатан болон ромчуудын хооронд болсон тулалдаан ялангуяа 367 оны бүслэлтийг үед хот их сүйджээ.

Хуучны судлалын малталтаар эрт дээр үеийн дурсгалт зүйл цөөхөн гардаг ч нэгэн сүмийн нүүрэн талд шигтгэсэн Лондонгийн чулуу хэмээх хана ихээхэн цуутай юм. Ш зууны үед ромын ноёрхлын үед хотын төвд байрлуулсан тэр хананаас зүг бүр тийш сунжирсан замуудын уртын хэмжээг тодорхойлдог байжээ.

Ромчууд Их Британи улсаас 412 онд хөөгдөн явсан ч Ү зуунд бретоны эртний язгууртнууд төрийн эрх мэдлийг булаан авснаар тэдний ноёрхол дуусчээ. Гэвч дайчин, хүчирхэг олон хөрш улс нь бретончуудад бие даасан байдлаа тогтооход нь удтал саад болж байжээ. Тухайлбал саксууд 585 онд тус орныг эзлэж долоон ванлиг байгуулснаас Эссекс ванлигийн нутаг дэвсгэрт Лондон харьяалагдах болжээ. Саксчууд христос шашныг шүтлэг болсноор тэдний анхны хамба лам нь Лондонд байнга оршин суух болжээ.

Лондон хот хөгжил цэцэглэлтийнхээ оргил үед хүрсэн XI зуунд Эдуард хаан түүнийг нийслэлээ болгожээ. Гэвч Гастингсийн дэргэд болсон тулалдаанд ялалт байгуулсан нормандчуудын удирдагч Байлдан дагуулагч Вильгельм Вестминстерийн аббатство ордонд өөрийгөө тус орны хаанаар өргөмжилжээ. Нормандын хаад Лондон хотыг эзлэсэн ч дайсагнагч иргэдийн дунд амьдран суухаас эмээж хотын гаднах Сити дүүрэгт сууршиж хэрэм босгожээ. Тэр үеэс нормандын хаад Тауэрийн хэрэмний дотор суух болж Лондон хотын оршин суугчдад хандан анхны тунхаглалаа гаргаж эртний бүх эрх дархыг нь эдлүүлэхээ амлажээ.

Темза мөрний адаг хавийг хяналтдаа байлгах төдийгүй хотын үл дагах оршин суугчдаас амь насаа хамгаалах зорилгоор Тауэрийн цайзыг барьжээ. Цайзыг Байлдан дагуулагч Вильгельм анх барьж дараагийн олон хаан барьж гүйцээжээ.

Тауэрийн цайз түүхэн урт хугацаандаа олон үүрэг гүйцэтгэж байлаа. Дундад зууны үед зоос цутгаж дараа нь төрийн архив байрлуулж мөн одон орныг судлах оргилын байр байв. Мэдээж хэрэг дундад зууны үеийн аливаа цайз, хэрмийн адил түүнийг шорон, өндөр тушаалын цагдан хорих зориулалтаар ашиглаж байжээ. Тухайлбал Францийн Сайхан сэтгэлт Жан хаан, энд Орлеаны ван Шарль 25 жил хорионд суужээ. 1535 онд суут сэтгэгч Томас Морыг энд цаазалжээ. Аугаа хүнлэг үзэлтний охин олон тооны харуулыг давж эцгийнхээ хүзүүнд зүүгдэж байсан “Урвагчдын хаалгыг” жуулчид ихэд сонирхдог.

Өнөөгийн Тауэрийн цайз жигд хяргасан зүлэг бүхий нов ногоон өргөн талбайд оршино. Тэгш өнцөгт хэлбэртэй цамхагууд дахь буудлагын нарийхан нүхүүд тэрчилэн мөрний эрэг дээр зүлэг дээр байрлуулсан их бууны харлах амууд Темза мөрөн рүү ширтэнэ. Цайзыг тойруулан ухсан жалгыг битүүлж цэцэрлэгт хүрээлэн, цэргийн сургалтын талбай болгон хувиргажээ.

VIII Генрих хааны үед босгосон голланд хийцийн намхан байшинд цайзын комендант сууна, дэлхийн хоёрдугаар дайны үед Гитлерийн намын ажил эрхэлсэн орлогч Герман Гессийг уг байшинд хорьж байжээ.

Таур цайзын дотроо хашаатай нэгэн цамхаг дотор “Хатан хааны түлхүүр” гэсэн уламжлалт ёслолыг өдөр бүр 700 дахь жилдээ хийсээр байна. Энэ ёслолыг дайны үед ч тасралтгүй хийж байв.

Цайзын дэнлүүгээр бүдэг гэрэлтүүлсэн өндөр зузаан хана дагуу улаан өнгийн дүрэмт хувцас, баавгайн арьсан малгайтай цэргүүд чулуун шалаар гутлынхаа өсгийг дуугарган алхсаар харуулын дөрвөн цэрэг зогссон цамхагийн хаалганд тулж ирнэ.

Улаан нөмрөгтэй, гартаа дэнлүү барьсан цамхагийн харуулын дарга гарч ирээд харуулын дөрвөн цэргийг дагуулан цайзын хаалгыг хаахаар очно. Хаалганы харуул чанга дуугаар:

- Хэн бэ? гэж асууна.

- Бид түлхүүр авч явна! гэж харуулын дөрвөн цэргийн нэг нь хариулна.

- Ямар түлхүүр авч явна вэ?

- Хатан хааны түлхүүрийг авч явна!

- Елизавета хатан хааны түлхүүрийг барьж яваа хүмүүс орцгоо!

Хаалганы харуул харуулуудын хамт дотоод хашаа дотор орж ирэхэд офицер удирдсан харуулын 12 цэрэг жагссан байна. Хаалганы харуул малгайгаа авч амандаа мөргөл уншаад түлхүүрийг комендантын байшинд оруулж маргааш өглөө болтол хадгална.

Хуучны ёс заншил Лондон хотод алхам тутамд тааралдана. Тухайлбал гартаа хийн хураагуур,

шат барьсан гэрэлтүүлэгч дугуйгаар явж байна. Тэрбээр хийн дэнлүү өлгөсөн шонгийн дэргэд зогсож шатаар өгсөж дэнлүүг асаана. Дэргэд нь орчин үеийн гэрлэн чимэглэл анивчина.

Лондон хотын олон байшингийн хананд бичиг үсэгт тайлаагүй зарим шууданч, сүйх тэрэгний хөтөч нарт зориулсан эрт дээр үеийн алчуур боосон мавр эрийн толгой юм уу хамрыг нь тайрсан бүргэд толгойтой далавчтай арслангийн товгор дүрс гэх зэрэг “таних тэмдгүүд” байна. Байшингийн хонгилуудад олон зууны түүхтэй шар айрагны газрууд байрлана, тэдгээрээс “Чөтгөр” шар айрагны газар Д.Свифт, “Чеширийн хуучны бяслаг” шар айрагны газар У.М.Теккерей, Ч.Диккенс нар тогтмол ирж үйлчлүүлж байсан гэж бахархана. Энд 221-Б дугаартай байшинд алдарт эрэлч цагдаа Ш.Холмс түүний дотнын анд доктор Ватсон нар зуу гаруй жилийн тэртээ амьдран сууж байжээ.

XVI зууны дунд үе хүртэл Лондон хот Сити дүүрэгт л багтаж байв. Түүнийг тойруулан барьсан хэрмийн хойд, зүүн талуудад жижигхэн тосгод тэдгээрийн цаана тал хөндий, нуга, баруун талд нь Вестминстерийн ордон, Хааны ордон, Парламентын ордон гэх зэрэг хэд хэдэн байгууламж байлаа. XIX зуунд төмөр замаас гадна газар доогуурх зам, омнибус, трамвай бий болсноор дагуул хотууд бий болж хотын хүрээ эрс түргэн тэлжээ. 1863 онд байгуулагдсан анхны газар доорх зам болох нарийхан хоолойгоор тохилог, гэрэл цацраасан вагонууд хурдлан өнгөрнө. Темза мөрний хоёр эргийг 25 гүүр, 4 хонгил холбож байв.

Английн нийслэлтэй танилцахдаа хоёр давхар алдарт улаан автобусанд сууж Вестминстерийн ордон болон Тауэрийн цайзын хооронд орших Сити дүүргээр хамгийн түрүүнд явна. Сити дүүрэг нь хотын доторх хот боловч байшин бүр нь ордон, шилтгээн билээ. Банк, даатгалын болон худалдааны компаниуд, албан байгууллагуудын байшингууд нүүрэн талуудаараа нэг нэгэндээ бараг тулан алдан нарийхан гудамжны хоёр талаар ярайна. Сити дүүргийн худалдаачид 1600 онд хааны тусгай зарлиг, парламентийн тогтоолоор олж авсан Дорнод Энэтхэгтэй арилжаа наймаа хийх онцгой эрх дархаа өнөө хүртэл нандигнан эдлэсээр байна. Сити дүүрэг нь ажил хэргийн ач холбогдлоороо Лондон хотын голт зүрх, “нийт английн контор” ажээ. Чухамдаа энэ дүүргийн сүлдийг Англи орны сүлд болгон өргөмжилжээ.

Лондон хотын бахархал болох цэцэрлэгт хүрээлэнгүүд нь бусад орныхоос өөр, баримал, усан оргилуур, цэцгийн мандал бараг байхгүй, ер нь хөдөө нутгийн байгалийг санагдуулна. Кенсингтоны цэцэрлэгт хүрээлэнд том цөөрмийн усанд ихэмсэг хун, янз бүрийн өнгийн өдтэй нугас хөвж цахлай шувууны сүрэг дэрс хийн хөөрнө. Эхчүүд, асрагчид хүүхэд суулгасан тэрэг түрж бяцхан хүүхдүүд шувуунд идэх зүйл шидэн өгч зарим нь усанд цаасан усан онгоц тавьж наадна. Цэцэрлэгт хүрээлэнгийн гол гудамжаар явахад Виктория хатан хаан хүүхэд насаа өнгөрөөсөн ордонд хүрнэ. Ордны гадаа хатан хааны хөшөө, цэцэрлэгт хүрээлэнгийн өмнөд хэсэгт хатан хааны нөхөр болох ханхүү Альбертийн том хөшөө сүндэрлэн байна.

Вестминстерийн Гэгээн Петрийн сүмийн харьяанд байсан Hyde ‘а шилтгээнээс нэр нь үүссэн Гайд цэцэрлэгт хүрээлэн ихэд цуутай билээ. Грекийн Афин хотын Пропилей гулдан хаалганы хуулбар болох том гулдан хаалганы багануудаар гарч Пикадиллийн талбайгаар явж Гайд цэцэрлэгт хүрээлэнд хүрнэ. Гулдан хаалганы зүүн талд гүн Веллингтоний дурсгалд зориулан босгосон Ахилла баримал байна. Оксфордын гудамжнаас энэ цэцэрлэгт хүрээлэн рүү ороход

ромын дэгээр урласан алдарт уран барималчдын товгор дүрсээр чимэглэсэн гантиган нуман хаалга байна.

Вестминстерийн ордны гот дэгийн цамхагт байгаа Биг Бен цаг нь Лондон хотын олон билэг тэмдгийн нэг билээ. Биг Бен цаг шиг гоёмсог, сүрлэг биш ч түүнээс дутахгүй цууд гарсан бас нэг билэг тэмдэг бий. Тэр бол Пикадилли талбай дахь усан оргилуурт байрлуулсан жижиг нум, сумаар харваж байгаа далавчит нэгэн залуу амьтны баримал юм. Зуу гаруй жилийн өмнө уран барималч А.Гильбертийн хөнгөн цагаанаар урласан энэ баримлыг лондончууд “Эрос” гэж нэрлэж заншжээ.

XII-XIII зууны үед нэгдүгээр Эдуард хаан хатныхаа дурсгал зориулан 1291 онд төвд нь хэрээс босгосон “Charring” тосгон байрлаж байсан газар байгуулсан Чаринг-кросс талбай Лондон хотын бас нэг чимэг билээ. Харамсалтай нь Английн хувьсгалч парламент уг хэрээсийг 350 жилийн дараа буулгажээ.

1805 онд франц-испанийн хамтарсан усан флотыг дийлсэн адмирал Г.Нельсоны ялалтыг билэгдэж Трафальгарын гэж нэрлэсэн цэцэрлэгт гудамж Чаринг-кросс талбайн хойд хэсэгт оршино. Трафальгарын талбайн өмнөд хэсэгт 1633 онд урласан нэгдүгээр Карл хааны морь унасан баримал бий. Хааныг цаазлах шийдвэр гаргасан парламентын гишүүдийг цааш харуулсан цаазны индэр байсан газар баримлыг хожим нь шилжүүлэн байрлуулжээ.

Трафальгарын талбайн төвд адмирал Нельсоны дурсгал зориулсан багана бий. Уг баганын тавцангийн ханануудад алдарт адмиралын ялалт байгуулж байсан тэнгисийн тулалдааны явцыг харуулсан хүрэл товгор дүрсүүд байна.



## ПАРИЖ

Париж хот нь Сена мөрний дунд орших Сите хэмээх бяцхан арал дээр галльчууд гүүрүүдийн хамгаалалтыг бэхжүүлэх, замын аюулгүй байдлыг хангах зорилгоор барьсан бэхлэлтээс үүссэнийг өнөө үед багтай тогтоогоод байна.



Манай эриний өмнөх 53 онд алдарт жанжин Юлий Цезарь паризүүдийн суурин болох Лютиция хотод харьяат орнуудын төлөөгчдийг дуудан ирүүлсэн тухай эх сурвалж нь Париж хотын тухай анхны мэдээлэл болдог. Ромчуудын түрэмгийллийн үед Лион мужийн бүрэлдэхүүнд байсан Париж хот Ү зууны сүүлчээр франкуудад эзлэгдэж франкын хаан Хлодвиг Сена мөрний зүүн эрэг дээр барьсан Тэрм ордонд сууж байв.

Каролинг угсааны хаадын үед хот уналтад орж тэр ч бүү хэл Их Карл хаан өргөөгөө нүүлгэн шилжүүлж байв. Норманчууд хотыг хэд хэдэн удаа эзлэж түйвээн дээрэмдэж байсан ажээ.

Филипп-Август хаан Париж хотын түүхэнд чухал үе үүрэг гүйцэтгэсэн юм. Түүний хаанчлалын жилүүдэд олон сүм, эмнэлэг, сургууль, зах, усан оргилуур, усан хоолой баригдсан хийгээд алдарт Дарь Эхийн сүмийн барилгын ажлыг эхлүүлжээ. Эртний байшин байгууламж, цэргийн эмнэлгийн бараан барилгатай зэрэгцэн орших Дарь Эхийн сүмийн өмнөх талбайд ямаа дагуулсан цыган бүсгүй Эсмеральда галтай цогтой бүжиглэж сүмийн харанхуй танхим, өрөөгөөр бөгтөр, аймаар царайтай Квазидомо сүлжин явж байсан билээ. Сүмийн талбайгаар францийн хаад тэдгээрийг дагалдсан хатад ихэмсэг алхаж байлаа.

XVII зуунаас XIX зууны бараг дунд үе хүртэл Дарь Эхийн сүмд бүдүүлэг, зохимжгүй өөрчлөлт, засвар хийж байсан бөгөөд Францийн аугаа их хувьсгалын үед христос шашны сүм байсныг болиулж 1793 оны 11 дүгээр сард Оюун ухааны сүм гэж зарлажээ. Сүмийн бүх танхим, өрөөнд Шудрага үнэний лаа асааж балетийн бүжигчин бүсгүй Майер хаан суудалд Оюун ухааны билэгдэл болон заларна. Түүний дагуул болох бүсгүйчүүд ёслолд оролцсоны дараа сүмийн дотоод хашаа дотор тойруулан барьсан 37 жижиг сүм дотор шүтэн бишрэгчидтэйгээ зугаацан цэнгэлдэнэ. Наполеон Бонапарт 1802 онд дээрх ёслолыг зогсоож дахин христос шашны сүм болгож хаан болох ёслолоо хийжээ.

1204 оны орчим Филипп-Август хаан Луврын музейн барилгыг босгох ажлыг эхлүүлж хорин

мянга орчим сурагчидтай хотын сургуулиудыг Их сургууль болон нэгтгэжээ. XI Людовик хаан дахин найман сургууль байгуулсны дотор алдарт Сорбонны их сургууль байв.

XIII зуунд Гэгээн Людовик хааны дотнын анд, лам Робер де Сорбон Шашны жижиг сургууль байгуулсан нь яваандаа Парижийн их сургууль болон өргөжиж европийн бүр орноос эрдэмтэд, ухаантнууд ирдэг болжээ. Их сургуулийн хамгийн эртний байрыг 1629 онд ван Ришелье тушаал гаргаж бариулжээ.

Париж хотод олон зууны туршид баригдсан тагт, цонхондоо сийлбэртэй модон хаалттай эртний жижиг байшингууд бүхий төөрч будлим нарийхан гудамж тоймгүй олон бий. Зарим тийм гудамжинд машин тэрэг явахыг хориглосон хийгээд явган зорчигчид л чөлөөтэй алхална. Тийм нэгэн гудамжинд Сен-Северэн сүм оршино. Бяцхан дэлгүүр, кафе, зоогийн газрууд нь гудамж дагуу төдийгүй дээр дээрээсээ давхарлан байна.

Париж хот үргэлж шинэчлэгдэж өргөжин тэлж байдаг. Цагтаа XIV Людовик хааныг Версалийн цогцолбор барих нь, ХФХ зуунд уран барилгач Г.Эйфелийг цамхаг босгох нь гэж шүүмжилж байсан билээ.

1889 онд болсон Дэлхийн үзэсгэлэнд зориулан босгосон Эйфелийн цамхагийг барихыг Ги де Мопассан, хүү А.Дюма, Ш.Гуно зэрэг францийн соёлын нэрт зүтгэлтнүүд эсэргүүцэж ойр орчмын хорооллын оршин суугчид цамхаг “Парижийн мөнхийн гоо сайхныг” гутааж байна гэсэн гомдлыг хотын захиргаанд гаргаж байв. Тэр ч бүү хэл америкийн саятан Г.Форд цамхагийг худалдан авч АНУ-д нүүлгэн аваачиж босгох санал ч гаргаж байлаа. Гэтэл өнөөдөр “парижийн хамгийн цуутай бүсгүй” болох цамхаг тус хотын нэрийн хуудас болон алдаршжээ.

Париж хотод дэлхийд цуутай түүхэн дурсгалт зүйлүүдээс гадна гэнэтийн сонин зүйлс цөөнгүй бий. Тухайлбал Бастилийн талбай доогуур урсах Сен Мартен сувагт завь, чиргүүл онгоц дээр хүмүүс одоо ч амьдран суусаар байдаг.

Бастилийн шоронгоос талбай дээр суулгасан мөлгөр чулуу, метроны буудлын үүдний танхимд байрлуулсан хэдэн чулуу л үлджээ. Талбайн төвд оройд нь Эрх чөлөөний алтадмал билэгдэл бүхий 52 метр өндөр багана бий. XIV зуунд Y Карл хаан цайз барьсныг хожим нь шорон болгож эхэндээ гадаадын дайснууд яваандаа эрх чөлөөг эрмэлзэгч эх орон нэгтнүүдээ хорьдог болжээ. 1789 онд босогчид Бастилийн шоронг дайран эзлэж газартаа тэгшилжээ.

Жуулчид Париж хоттой танилцахдаа Латинь хороололд орших Сен-Мишель өргөн гудамнаас эхэлнэ. Тус хорооллын голт зүрх болох нарийхан, тахир гудамжуудад оюутнууд суудаг болохоор үргэлж шуугиантай байна. Уг хорооллын төвд XVII зууны эхээр Мария Медичи хатны хүсэлтээр уран барилгач С.Дебросын төслөөр барьсан Люксембургийн ордон байна. Ордны эргэн тойронд орших хэдэн зуун жилийн түүхтэй гоёмсог цэцэрлэгт хүрээлэн нь тус хот дахь ногоон арал мэт санагдана.

Францийн хаан түүний хатан, италийн Флоренц хотын уугуул Мария Медичи бүсгүй хоёрын дурлалд зориулсан “Рубенсийн уран зургийн галарей” нь ордны цогцолборын сувд эрдэнэ билээ.

Париж хотын гайхамшигт түүхэн дурсгалуудын нэг нь Ялалтын хаалга билээ. Урьд нь түүн рүү хөнгөн тэргээр очих боломж байгаагүй бол газар доогуур гарц хийснээр чөлөөтэй дөхөн очиж өргөдөг шатанд сууж 50 метрийн өндөрт гарч хотын дүр төрхийг тольдон харж болно. Ялалтын хаалгыг Наполеон хааныг алдаршуулах зорилгоор биш хотын чимэг болгох зорилгоор 1806 оноос нийтдээ гучин жилийн хугацаанд барьжээ. Хаалгыг барих ажлыг XVIII Людовик хаан түргэвчлүүлэхгүй байсан ч гүн Ангулемский испаничуудыг дийлсэн ялалтаа алдаршуулахаар барилгын ажлыг үргэлжлүүлжээ. 1830 оны хувьсгалын дараа Луи-Филипп хаан Ялалтын хаалгыг францийн армийн 1792 онд байгуулсан ялалтад зориулахаар шийдэж нээлт нь 1836 оны долоодугаар сарын 29-ний өдөр болжээ. Марсельеза, Ялалт, Эсэргүүцлийн хөдөлгөөн, Энх тайвныг билэгдэсэн товгор дүрсүүд тэрчилэн францийн армийн түүхэн үйл явдлуудыг харуулсан дүрсүүдээр Ялалтын хаалгыг чимэглэжээ.

Париж хот гайхамшигт музей, уран зургийн галарей, уран сайхны урлангуудаараа цуутай билээ. Луврын музей хаалттай үед жуулчид, урлаг судлаачид Латинь хороолол дахь эртний эд зүйлсийн дэлгүүр, лангуу, зураачдын урланд пиг дүүрнэ. Алдарт Монмартрын дов дээр байгуулсан Тертрийн талбайд өвөл зун, өдөр, шөнө ялгаагүй уран зураг худалдаална.

Париж хотын анхны хамба лам Гэгээн Дионисийг толгойг нь тасдан цаазалсан учир “mons Marturum” (“Тамлуулагчийн уул”) гэсэн эвгүй нэртэй 100 гаруй метр өндөр Монмартр дов нь францийн нийслэлийн зочдын хувьд зугаа, цэнгэлийн газар болно.

Тертрийн талбайд уран бүтээлээ туурвидаг байсан чөлөөт уран бүтээлчид дэлхийн нэгдүгээр дайны дараа “язгууртан” зохиолч, яруу найрагч, зураачдын ертөнц болох Монпарнасын хороололд шилжин сууршижээ.

1977 онд Бобурын эртний гудамжинд Жорж Помпидугийн нэрэмжит Урлаг, соёлын үндэсний төвийн цогцолборын нээлт болжээ. Уг цогцолборын бүрэлдэхүүнд орчин үеийн урлагийн болон уран зургийн галарей, үзэсгэлэнгийн танхимууд, том номын сан, гэрэл зураг, бичлэгийн цуглуулга байрлана. Уг цогцолборын төслийн уралдаанд 681 бүтээл ирснээс италийн уран барилгач Р.Пьяно английн уран барилгач Р.Рожерс нарын төсөл түрүүлжээ. Цогцолборын 50 метр өндөр, 150 метр урт, 50 метр өргөн барилга эртний хороололтой донжтой зохицжээ.

Елисейн тал гудамж нь францийн нийслэлийн гол чимгийн нэг билээ. XIV Людовик хаан грекийн домогт гардаг охин тэнгэрүүд дураар сэлгүүцэн байдаг газрын нэрээр уг гудамжийг анх “Элезиум” гэж нэрлэж байжээ.

Алдарт Зөвшилцлийн талбай XVI зуунд хотын гадна байрлаж байжээ. Анх байгуулсан XVI Людовик хааны нэрээр нэрлэгдэж байсан уг талбайд хааны морь унасан хөшөө байжээ. 1792 онд босогчид хөшөөг нурааж хувьсгалын талбай гэж өөрчлөн нэрлэжээ. Жилийн дараа уг талбайд XVI Людовик хаан түүний хатан Мария-Антуанетта хоёрыг, дараа нь Робеспьер, Дантон зэрэг бусад хувьсгалчдыг нийтдээ бол 2800 орчим хүнийг цаазалжээ. Аллага хядлага дууссаны дараа 1795 оны аравдугаар сараас Зөвшилцлийн талбай гэх болжээ.

Шөнийн цагаар францийн өнцөг булан бүрээс болон гадаадын орнуудаас Хойд тэнгисийн хясаа, Бордо, Бургундын дарс, Голландаас цэцэг, Испаниас цөцгийн тос тэрчилэн мах,

хүнсний ногоо, жимс, ангийн шувуу, загас пиг дүүрэн ачсан хөргөгч бүхий машинууд Париж хотод цувран орж ирнэ. Өглөөний 6 цагт зах онгойход бөөнөөр худалдан авагчид ирж бүгдийг хуу худалдан авч 10 цаг гэхэд захын лангуу хоосорсон байна.

Дэлхийн олон зуун сая хүн Париж хотод очихыг мөрөөддөг. Энэ хот Ром, Нью-Йоркоос илүү хүний сэтгэл зүрхийг эзэмддэг юм. Э.Хумингуэй “Париж хот нь сэтгэлийг тань байнга эзэмдэх баяр хөөр билээ.” гэж шагшин магтсан билээ.

## КЁЛЬН

Кёльн хотын эдийн засгийн ач холбогдол эрт дээр үед тодорч XI зууны сүүлч гэхэд махны, загасны, хүнсний ногооны, талхны, шар айрагны зэрэг төрөлжсөн захууд бүхий европийн худалдааны томоохон төвүүдийн нэг болсон байлаа.



Эл хотын худалдаачид Англи, Франц, Итали, Норвег, Орос зэрэг европийн олон оронтой арилжаа, наймаа хийж гадаадын олон хотод төлөөлөгчийн газар нээсний дотор Лондон дахь Кёльнийн наймаачдын Худалдааны танхимыг Английн хатан хаан ивээлдээ авсан байлаа.

Дундад зууны үед тус хот улам өргөжсөөр X-XII зуунуудад гурван удаа хэрэм давхарлан барьжээ. XI зуунд тус хотод зорчсон Английн нэгэн лам “Германы орны төв, тэргүүлэх зэргийн хот юм байна!” гэж уулга алдаж байжээ. Хорин мянга орчим хүн амтай хотын хэрэгцээг ваарчин, арьс элдэгч, талхчин, гуталчин, сүйт тэрэг үйлдвэрлэгч, гурил үйлдвэрлэгч гээд тавь гаруй мэргэжлийн хүмүүс хангадаг байсан төдийгүй тус хотын үнэт эдлэлийн дархчуул, зэвсэг үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг Герман төдийгүй гадаадын олон оронд сайн мэддэг байлаа.

Тус хот Германы улс төрийн тогтолцоонд чухал байр суурь эзлэж байлаа. X зууны үеэс хотын захирагч нар нь эдлэн газар, усан үзмийн талбай, давс олборлох үйлдвэр, үл хөдлөх хөрөнгийг удам угсаа дамжуулан эзэмшдэг болсон төдийгүй төрөлжсөн захууд, загасны үйлдвэрүүд, мөнгө цуглах үйлдвэрийн нийт орлогын гуравны хоёрыг хувьдаа авдаг, хотод ирсэн, хотоос гарсан бүх хүнээс хураамж, Рейн мөрнөөр бараа тээвэрлэсний татвар авч бүх бараа, хүнсний зүйлд татвар ногдуулдаг байв.

Иймд байдалд дургүйцсэн хотын оршин суугчид үе үе бослого гаргаж байлаа. 1074 онд хотын захирагч хоёрдугаар Ганнон зочлон ирсэн Мюнхен хотын сүмийн хамба ламд зориулан завь гаргах зарлиг буулгаснаар түүний шадар тVIIIмэд нэгэн худалдаачны завийг шууд булаан авч бараа бүтээгдэхүүнийг нь газар шидэлж гарчээ. Түүнээс үүдэн хотын захирагчийн болон завины эзний талынхны хооронд зодоон эхэлсэн нь төдөлгүй өргөжиж хотын захирагчийн бурангуй үйлдэлд эгдүүцсэн иргэд завины эзнийг хамгаалж түүний өргөөг бүсэлж цонх руу

нь чулуу нүүлгэж гарчээ.

Олны уур хилэнгээс айсан хотын захирагч өргөөнөөсөө зугтан гарч сүмд нуугдаж байгаад шөнө дөлөөр хотоос оргон гарчээ. Маргааш нь цэрэг хөдөлгөж босогчдыг хэрцгийлэн дарж 600 орчим баян худалдаачин дайжин зугтахад тэдний тохилог орон сууц, үйлдвэрийн байр, захыг эвдэн сүйтгэж эд хөрөнгийг нь дээрэмдэн хураан авчээ. Бослогод идэвхтэй оролцсон зарим хүний нүдийг сохолж заримыг нь саваагаар хэдэн зуун удаа занчин шийтгэжээ. Энэ бослогын уршгаар хот нэлэнхүйдээ сүйдсэн ажээ.

Гэвч XII зуунаас хотын оршин суугчид төрийн удирдлагын байгууллагад төлөөлөгчөө илгээж байх эрхийг тэмцэн байж олж авчээ. Тэдний эрх ашгийг баян худалдаачид төлөөлдөг болсон нь мэдээж хэрэг. XII зууны дунд үеэс “Баячуудын цех” гэсэн корпораци байгуулагдсан нь хэдэн арван жилийн дараа гэхэд хотын захирагчийг үйлдвэрүүдийг удирдах ажлаас холдуулж бүх үйл ажиллагааг хяналтдаа авч чадсан байлаа.

Аль дундад зууны үеэс Кёльн хот өвөрмөц сайхан багт наадмаараа алдаршиж “Умардын Венеци” гэж нэрлэгдэж байжээ. Тус хот нь бүх нийтийг хамарсан баяр ёслолоороо эртний уламжлалтай бөгөөд шинэ он тооллын эхэн үед Доод Германы нийслэл болж Клавдий хааны хатан, Нерон хааны эх болох Агрипинагийн дурсгалд зориулан Colonia Claudia Ara Agrippinensium гэж нэрлэдэг болжээ.

1794 онд тус хотыг хувьсгалт францийн цэргүүд эзлэж генерал Дарьегийн гаргасан нэгэн тушаалыг газар сайгүй наасан байлаа. Уг тушаалд “Хорон санаатай хүмүүс нийгмийн дэг журмыг зөрчих зорилгоор элдэв эрээн мяраан хувцас өмсөж багт наадам зохиохыг санаархаж магадгүй юм. Иймд элдэв баг өмсөж ганц нэгээрээ юм уу хэсэг бүлгээрээ гүйлдэн шуугилдахыг хатуу хориглосугай.” гэж онцлон заасан байлаа. Гэвч францчууд энэхүү хоригоо 1800 онд аргагүйд тулж цуцалжээ.

Түүхч Г.Т.Фабер 1800 онд болсон багт наадмын тухай “Бүх насны, нийгмийн бүхий л давхаргын хүмүүс олс, маалингаар урласан янз бүрийн өнгийн хиймэл үс, янз бүрийн хэмжээтэй хачин жигтэй хэлбэрийн хамар, хацартаа хэдэн арван үү тавьж хотын гудамж талбайд шуугилдан дуулж бүжиглэн хөгжилдөх юм.” гэж тэмдэглэн үлдээсэн байдаг.

1815 онд Кёльн чөлөөт хотын эрхээ алдаж Пруссын эрХШЭэлд оржээ. Гэвч 1823 онд “Баярын зөвлөл” хэмээх тусгай журам гаргаж кёльнчуудын багт наадмыг кохион байгуулалтын тодорхой дэгтэй хийдэг болжээ. Тэр баяр ёслол тэр үеэс дэлхийн хоёрдугаар дайны зургаан жилд тасалдсанаас жил алгасалгүй тасралтгүй зохиогдсоор өнөөг хүрчээ.

Дайны дараа Кёльн хотод багт наадмын уламжлалаа сэргээсэн нь “германы эдийн засгийн гайхамшиг”-ийн бүрэлдэхүүн хэсэг байлаа. Жил бүрийн багт наадмын ёслолд урьдаас нухацтай бэлтгэнэ. Багт наадмын бэлтгэл ажлын хороод жил бүр 11 дэх сарын 11 дэх өдрийн 11 цаг 11 минутанд цугларна. Багт наадмын үндсэн бүрэлдэхүүн хэсгийн хамгийн гол нь “кельше” (рейн аялгуугаар Кёльн хотын оршин суугчдыг тэгж нэрлэдэг ажээ.) нар заавал хөгжилтэй байх ёстой ажээ.

Багт наадмын баярын үед хотын хүндэт иргэд “Багт наадмын ханхүү”-г сонгоно. Нэгэн удаа

энэ эрхэм хүндтэй хэргэмийг алдарт “кельний ус” буюу үнэртэй усны үйлдвэрийн эзэн сонгогдож байжээ. “Багт наадмын ханхүү”-гийн гадаад төрх байдал олон арван жилийн хугацаанд бараг өөрчлөгдсөнгүй. Тэрбээр “тогосны өдөн алтан титэм” (тогосны өдийг эрт дээр үеэс үхэшгүй мөнхийн билэгдэл гэж үздэг ажээ.) өмсөж бэлхүүсээрээ алтан гинж бүсэлнэ, цагаан хувцасныхаа дээгүүр үенгийн арьсаар хийсэн тайжийн нөмрөг нөмөрнө, баруун гартаа очирт таяг барьж зүүн гараараа бариулыг нь тулж ихэмсэг зогсоно.

Багт наадам эхлэхэд Кельн хотын нэг сая гаруй оршин суугч гудамж, талбай гарч, цэцэрлэгт хүрээлэнд очиж “Мацаг барих өдөр” буюу “үнсэн лхагва” гаригийн өмнөх гурван өдөр дараалан хөгжилдөнө.

Багт наадмын баяр нь тус хотын сүмийн адил Кельн хотын нэрийн хуудас болдог билээ.

## ТИПАЗА

Алжир улсын нийслэлээс баруун зүгт 70 километр зайтай, Шенуа уулын бэлд бяцхан цагаан Типаза хот оршино. Хотын нэрийн “Ти” угтвар нь бербер омгийн үг бололтой. Хот үүссэн, туулсан түүх гэвэл тэнгис, хад шиг нэн эртнийх ажээ. Эх нутгаасаа зугтсан финикичүүдийг тэнгисээр хөвсөөр эрэг дээр буухад бербер омгийнхон хэрхэн угтсаныг бүү мэд, ямар ч атугай тэд энд үүрд сууршижээ. Тэр явдал одоогоос 3000 жилийн тэртээ болсон нь бодитой үнэн билээ.



Типаза хот Ромын эзэнт гүрний эзэмшил нутаг болсон манай эриний өмнөх Нэгдүгээр зууны үеэс уг хотын мэдээлэл байдаг. Түүнээс нэг зуун жилийн өмнө бардам Карфаген хотыг цус асгаруулсан тулаан хийж байлдан дагуулсан ромын торгон цэргүүд шагнал урамшуулал шаардаж эртний Типаза хотын усан боомт, эргэн тойрны үр жил шимтэй газрыг хуваан олгоход тэд маш их баярлажээ.

Францийн хуучныг судлаачид 1949 онд малталт хийж замын 200 метр хэсгийг ухан цэвэрлэж ил гаргав. 14 метр өргөнтэй, тэгш зам он цагийн уртад муудсангүй, яг хэвээрээ байсан тул засаж сайжруулах шаардлагагүй байлаа. Замын хавтангуудыг хооронд нь яг тулган суулгасан учир завсраар нь өвс цухуйн ургасангүй ажээ.

Замын эргэлтийн цаана усны эм бурхдад зориулсан том усан оргилуур байна. Уулын шүд ташим хүйтэн цэвэр усыг хотын зарим хэсэгт одоо ч байгаа гурван давхар өндөрт байрлуулсан гүүрэн сувгаар усан оргилуур руу татан ирүүлдэг байжээ. Хиймэл усан санг хагас тойрог үүсгэн хүрээлүүлсэн цэнхэрдүү өнгийн багануудын хоорондуур гантиган ховилоор ус доош садран урсаж хүрхрээ шиг бургилан буух усыг сэтгэлдээ төсөөлөн бодоход үнэхээр сайхан. Гүүрэн сувгаар татсан цэвэр ус хотын иргэдийн ундны хэрэгцээг хангах, усан үзмийн талбайг услахад хангалттай хүрэлцэж байжээ.

Ромчууд Типаза хотод цэнхэр хул аяганы хэлбэртэй театр байгуулсан нь Хойд Африкт бараг анхных нь байлаа. Түүнээс холгүйхэн байгуулсан задгай театрт ромын мэсчингүүд цус урсган тулалдан алалдаж үзэгчид хоолой мэдэн уухайлан хашгиралдана. Задгай театрын цаанаас гол гудамж залгаж түүний хоёр талаар нарс зэрэг модод эгнүүлэн тарьжээ. Задгай театрын хавтан дэвссэн шатаар өгсөж үзэгчдийн суудалд хүрнэ. Задгай театрын партерийн суудлын эхний



гурван эгнээ, лоож, тайзны ар талын танхим, найрал хөгжмийн хамтлагийн суудлууд яг хэвээрээ өнөөг хүртэл хадгалагдан иржээ.

Хойд зүгт тэнгис рүү чиглэсэн гудамжаар явж язгууртнуудын шилтгээнүүдийн балгаст хүрнэ. Тэдгээрээс өргөн, том, нарийхан саравчит багануудаар хүрээлүүлсэн “Ханын зурагтай шилтгээн” нэртэй ордон бусдаасаа содон харагдана.

Шилтгээнүүдийн балгасны хажууд Бархасвадь дээд бурхан түүний хатан, гэр бүл, төрөлтийг ивээгч Юнона, аялагчдыг ивээгч, мал аж ахуй, худалдааны Буд бурхдад зориулсан шүтээнүүд, олон сүм бүхий дов оршино. Довыг тойруулан 50 метр урт, 25 метр өргөнтэй, хавтангууд суулгасан талбайнууд байгуулжээ. Энэ талбайд хотын Захиргааны зөвлөлийн хуралдааны байр, уран илтгэгчдийн индрийн суурины үлдэгдэл байна.

Ромчууд эзлэснээс гурван зуун жилийн дараа гэхэд Типаза хот өргөжин тэлж ойр орчмын дов, хөндийг хүрээндээ оруулж хүн амын тоо нь хорин мянга хол давсан байлаа.

Цаг хугацаа өнгөрсөөр бөөгийн шүтлэгтэй Типаза хотод христосын шашин дэлгэрч эхлэв. Сальса хэмээх христос шүтлэгтэй бүсгүй дургүйцлээ илэрхийлж бөөгийн шүтлэгийн шүтээнийг нь зориуд нураахад бөө шүтлэгтэй хүмүүс түүнийг хүлж голд шидэж живүүлжээ. Гэвч тэнгис түүнийг хүлээн авсангүй, эрэг дээр болгоомжтой гарган тавьжээ. Тэгээд христос шашныхан түүнийг шүтээн болгон өргөмжилж тэр үеэс Сальса хотын ивээгч болжээ.

IV зуунд хотод сүрлэг сайхан бунхан барьсан нь алс тэнгисийн зүгээс ч харагддаг байв. Одоо тэр жавхаалаг сүмээс гоёмсог сайхан шигтгэмэл шал, сүмийн мөргөлийн танхимыг есөн хэсэгт хуваасан багануудын үлдэгдэл л байна. Сүмийн үүдэнд загалмайлах ёслол үйлддэг байсан хамба лам Александр Типаза хотын цацар сүмийн анхны хамба лам түүний найман хамтран зүтгэгч нарыг мөнхжүүлж хуучин оршуулгын газар чамин гоё жижигхэн сүм барьж сүсэгтнүүдийн талархлыг хүлээжээ. Гантиган тавцан дээр сийлэн урласан есөн авсыг тойрог үүсгэн байрлуулжээ.

484 онд Хунерик хааны цэргүүд хотыг эзлэж сүсэг бишрэлээсээ татгалзахыг тулган шаардаж аймшигт аллага үйлдсэн ч христос шашинтнууд итгэл үнэмшлээсээ татгалзсангүй, зарим нь Испанид зугтан гарч үлдсэн хүмүүсийнх нь хэл, баруун гарыг тасдан шийтгэжээ.

Типаза хот түүхэндээ олон удаа зовлон тарчлаан үзсэн учир VI зуунд дайлаар ирсэн византичууд хотыг тойруулан чулуун хэрэм босгож харуулын цамхагууд барьжээ. Тэдгээр цамхагаас ганц нь л өнөөдөр яг хэвээрээ байна. Нурсан чулуун хэрмийн балгасаар дүүрэн цахилдаг, сарнай, шимтэглэй цэцгүүд пиг ургажээ.

Типаза хот буурал түүхэндээ маш олон удаа газар хөдлөлтийн аймшигийг үзэж хаширсан билээ. Газар хөдлөлт бүр оршин суугчдын хувьд төдийгүй эртний барилга байгууламжийн хувьд сүйрэл болж байлаа. Иймд Алжир улсын Засгийн газраас тусгай хөтөлбөр гаргаж эртний түүхэн барилга байгууламжийг найдвартай сахин хамгаалах, сэргээн засварлах нөр их ажил өрнүүлж байна.

## ЖЕНЕВ

Оршин суугчид нь Леман гэж нэрлэж заншсан Женев нуурын эрэг дээр мөн нэртэй хот оршино. Эвэр нь өмнө зүг рүү харсан шинийн сарны хэлбэртэй энэ нуур нь Швейцар улсын хамгийн том, хамгийн тунгалаг устай нуур ажээ.



Байрлалын хувьд халуун уур амьсгалтай өмнөд зүгт ойрхон тэрчилэн цасан оргилтой уулын бэлд оршдог болохоор зөөлөн дулаан ажээ. Иймд зуны цагт халуун нар төөнөж байхад уулын зүгээс хүйтэн салхи үлээж сэрүүн байдаг.

Женев нь анхандаа галлийн омгийн эзэмшлийн цайз байсан бөгөөд манай эриний өмнөх 120 оны үед галльчууд ромчуудад эзлэгдэж өнөөгийн Женевийн нутаг дэвсгэрийг ромын ахмад дайчдад шагнал болгон хуваан өгчээ. Ромын ахмад дайчид эзэмшүүлэн өгсөн газар нутаг дээр хэд хэдэн цайз нэмж барьж Ромд эзлэгдээгүй омгууд байгаа улс орон нутаг дэвсгэрийг заагласан Рону голоор гарах ганц гүүр орших Женев хотын бэхлэлтийг улам сайжруулжээ. Тэр үеэс латин хэлний “колонь” буюу гүүр гэсэн үгнээс гаралтай Колоньи нэртэй хороолол бий болжээ.

Ромын эзэнт гүрний Юлий Цезарь хаан “Галлийн дайны тухай тэмдэглэл” дурсамжийн номондоо манай эриний өмнөх 58 онд гелветүүдтэй хийсэн байлдааны тухай өгүүлэхдээ Ронү гүүрийн тухай дурдсан нь Женев хотын тухай анхны мэдээлэл байсан юм. Тийм учраас хотын төвд байрлах цамхагийн хананд “Галлийн дайн тухай тэмдэглэл” номын зургаан мөрийг сийлсэн чулуун хавтанг суулгасан байна. Харин хуучин хотын хананд Юлий Цезарийн цэрэг Женев хотод орж ирж байгааг дүрсэлсэн шигтгэмэл байна.

Ромын эзэмшлийн үед Женев цэцэглэн хөгжиж ромчууд зам харгуй, суваг бүхий гүүр барьж цайзын эргэн тойронд суурингууд бий болж аажимдаа хот болон өргөжжээ. Гэхдээ III зууны үед Швейцарийн нутаг дэвсгэрт довлон орж ирсэн германы омгууд, дараагийн зуунд бургундчууд ромын ноёрхлын ул мөрийг бүрмөсөн арилгажээ.

Женев хот нь байгуулагдсан үеэсээ багахан нутаг дэвсгэртэй ч ашигтай байрлалынхаа буянгаар ихээхэн давуу талтай байлаа. Тийм ч учраас шашны баяруудаар үзэсгэлэн худалдаа зохиодог, тэдгээрт Ломбардаас улаан буудай Франц, Фламандаас даавуу Англиас цэмбэ,

хүйтэн болон галт зэвсэг, үнэт эдлэл Испаниас маалинга Оросоос ангийн арьс, зэс Германы хотуудаас төмөр сав суулга, зэвсэг авчирч арилжаалдаг байв.

Хотод гар урлал эрчтэй хөгжиж гуталчин, оёдолчин, бээлий, зураачдын урлан бий болж бараа бүтээгдэхүүнээ Итали, Испани, Франц, Фламандр руу аваачиж борлуулна. Шуудангийн үйлчилгээ бий болж тээврийн компани, анхны даатгалын компаниуд, XIV-XV зуунд банкууд үүсчээ.

Гэвч газар зүйн аугаа нээлтүүдийн үе эхэлснээр худалдааны хуучин замууд хаагдаж Женев хот уналтад оржээ. Түүнээс гадна XVI зуунд шашны, улс төрийн нөлөөтэй төвүүдийн нэг болж “үнэн алдартны шашны Ром” гэж нэрлэгдэх болсон тул католик шашинтай орнуудын хаад хэлхээ холбоогоо тасалжээ.

Феодалууд болон шинээр төрөн гарч байгаа хөрөнгөтнүүд хоорондын тэмцэл хурцдаж европийн орнуудад эхэлсэн нийгэм-улс төрийн шинэчлэлтийн үйл явц Женев хотыг ч тойрсонгүй. 1636 оны тавдугаар сард Женевийн оршин суугчид Христосын ариун сургаалийн дагуу хууль цаазыг шүтэн амьдрах болсноо тунхаглажээ.

Тэр үйл явдлаас хоёр сарын дараа Францаас эл хотод ирсэн залуу лам Жан Кальвин төрийн ямар нэгэн албан тушаал хашиж байгаагүй ч тус улс орныг шашны үндсэн дээр өөрчилжээ. “Христос шашны байгууллагууд” хэмээх алдарт номыг зохиогч маань 1554 онд нас барах хүртлээ үнэн хэрэгтээ Женев оршин суугчдын хотын оюун санааны болон иргэний удирдагч байсан юм. Хотын Ерөнхий зөвлөл Ж.Кальвиний удирдлага дор боловсруулсан “Шашны тогтоомжууд”-ыг баталжээ. Ж.Кальвин үнэн алдартны шашны сүмийг жижигхэн, католик шашны ёслолын сүржин байдлыг дууриадагийг болиулж даруухан болгосон ч шашны баяруудын тоог ажлын өдрийн тооноос илүү болгожээ.

Ж.Кальвин түүний дотнын хамтран зүтгэгч Г.Фарель, Без нар женевчүүдээс маш хатуу дүрэм журам баримтлахыг шаардаж театрын тоглолт болон олон нийтийг хамарсан зугаалга цэнгүүн хийхийг хориглож урлагийг бурангүй зүйл гэж зарлажээ. Хууль тогтоомж гаргаж хувцас, үс засалт, гоёл ямар байхыг зааж бүсэндээ үнэтэй горхи, алтан товч, илгэн торгон оймс өмсөхийг цээрлэж хүлээн авалт дээр аль болох цөөн хэрэглэхийг онцлон заасан байв. Ийм байдалд гайхаж дургүйцсэн алдарт зохиолч Вольтер Женев хотыг “Оршин суугчид нь инээхээ больсон хот.” гэж харамсан бичиж байжээ.

Кальвинизмын үзэл бяцхан Женевээс хальж өргөн дэлгэрсэн ч тус хот хорьдугаар зуун хүртэл европ дахь үнэн алдартны шашны төв байлаа. Гэвч яваандаа тэр байр сууриа алдаж Женевийн их сургуулийн бүрэлдэхүүнд байгуулсан алдарт Шашны академиас Шашин судлалын факультет л үлджээ. Гэвч Шинэчлэлтийн үед Женев олон улсын ач холбогдолтой хот хэмээх алдрыг зүй ёсоор хүртжээ.

1815 онд Вена хотод болсон Европийн улсуудын их хурлаас Швейцар улсыг “Төвийг сахисан мөнхийн орон” гэж дэлхий даяар тунхаглан зарлажээ. Төвийг сахисан нутаг дэвсгэр дээр янз бүрийн орны иргэд хуран цугларч ямар ч маргаантай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд маш тохиромжтой байдаг ажээ. Францийн нэрт дипломатч Ш.М.Талейран “дэлхийд Европ, Ази, Америк, Африк, Женев гэсэн таван тив байдаг.” гэж хэлж байжээ.

Тэр үеэс олон улсын уулзалт, чуулган тогтмол зохиогддог болсон Женев хотод 1830 онд Энх тайвны нийгэмлэг байгуулагдаж дэлхийн бүх улс орны хооронд бат бэх энх амгалан байдал хэрхэн тогтоох асуудлаар олон улсын зохион бичлэгийн уралдаан зарлан явуулж байжээ. Тус нийгэмлэг олон улсын арбитрын шүүх байгуулж олон улсын болон улс хоорондын маргааныг эв зүйгээр зохицуулж байх өргөн эрх мэдэл олгохыг эрмэлзэж байжээ. Гэвч тэр эрмэлзлэл бараг зуун жилийн дараа Үнэстнүүдийн Лиг байгуулагдсанаар биелэлээ олжээ. Гэвч дэлхийн хоёрдугаар дайн эхэлснээр Үндэстнүүдийн Лигийн үйл ажиллагаа зогсосноос Женев хот нам гүм болж олон улсын байгууллагуудаас Олон улсын улаан загалмайн нийгэмлэг л ганцхан үйл ажиллагаа явуулж байв.

Дэлхийн хоёрдугаар дайн дуусаж 1946 онд АНУ-ын Сан-Франциско хотод байгуулагдсан НҮБ-ын Европ дахь өргөө Женев хотод байрлаж дахин хөл хөдөлгөөнд оржээ.

Женев хотод олон улсын харилцааны маш олон амин чухал үйл явдал болж байсан тул эл хотыг олон сая хүн амтай, тансаг гоё орд харш пиг дүүрэн, олон улсын байгууллагуудын тэнгэр баганадсан барилгуудтай хот байх гэсэн бодол хүн бүрийн санаанд буудаг. Гэтэл тийм биш өнөөгийн Женев нь жижигхэн, тохилог, нам гүм хот бөгөөд хоёр-гурван цаг явган явж хотыг тойрон танилцаж болно.

Тус хотод ганцхан харш байдаг нь НҮБ-ын Европ дахь салбар байрлах Үндэстнүүдийн ордон юм. Саятан Г.Ревийогийн 1890 онд Женев хотын захиргаанд бэлэглэсэн “Ариана” цэцэрлэгт хүрээлэнд тэрхүү ордон байрлана. Уг ордонд 820 өрөө тасалгаа, хуралдааны 20 танхим, 2000 хүний суудалтай Зөвлөлүүдийн Танхим, Ассамблейн Том Танхим бий.

Үндэстнүүдийн ордонгийн ойролцоох нэгэн эртний байшинд Олон улсын улаан загалмайн нийгэмлэг байрлана. “Мон репо” цэцэрлэгт хүрээлэн дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллагын байр харагдана.

Женев хотод АНУ-ын Ерөнхий консулын газар байрладаг “Отель дю Рон” гэсэн тэнгэр баганадсан ганц байшин буй. Гэхдээ өндрөөрөө биш АНУ дахь тэнгэр баганадсан байшингуудыг дууриалган барьсан учраас л тэгж нэрлэгддэг юм.

Женев хотын бараг төвд Молар хэмээх эртний цамхагийн хананд зовж зүдэрсэн дүрвэгчийн дээрээс тонгойсон эмэгтэйн товгор дүрс байх бөгөөд түүний дээд талд “Женев бол дүрвэгчдийн хот” гэсэн үг сийлсэн байна. XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеийн хатуу бэрх цагт эх орондоо дарангуйлал, шашны хүчирхийллийн эсрэг тэмцэгч олон хүнийг тус хот ивээлдээ авч байсан юм. Үүнд францийн гугенотууд, гарибальдчууд, 1863 оны польшийн бослогод оролцогчид, Бисмаркийн хаанчлалын үеийн германы хувьсгалчид гээд эрх чөлөөг эрмэлзсэн үзэл санаагаа хамгаалж тэмцсэн олон орны зүтгэлтэн энд ирж хоргодож амь насаа аварч байсан билээ.

## КАППАДОКИ

Хэдэн сая жилийн тэртээ гуравдагч галавын үед Бага Азийн хамгийн өндөр уул болох Эржиеш-Дагы галт уул дэлбэрч хайлмагийн урсгал Гереме хөндий рүү урсан бууж хэдэн мянган километр хавтгай дөрвөлжин газрыг зузаан давхарга үүсгэн бүрхжээ. Дараагийн олон зууны хугацаанд салхинд үлээгдэж бороо шавьсуулсаар царцаж хатсан хайлмаг, хатуурсан үнс нь аажимдаа боловсруулахад хялбар, бат бэх барилгын материал болон хувирчээ. Тэгээд Каппадокийн (“Каппадоки” гэдэг эртний хетт омгийн үг нь “Цагаан морьдын нутаг” гэсэн утгатай ажээ.) өндөр шовгор хэлбэрийн хад асга буюу хэдэн арван километр алсад үргэлжилсэн янз бүрийн өнгийн чулуун шон, ганжир, цамхагуудын бүхэл бүтэн ой бий болжээ. Аялагчийн нүдний өмнө тогтонги чулуун давалгааны тэнгис тодорч тэдгээр давалгаа нь нэг болохоор эгц дээш цоройж нэг болохоор доош үсрэн бууна.



Бага Азийн бусад хэсгээс нэвтэршгүй ой, өндөр уул нуруугаар тусгаарлагдсан энэ нутагт хүмүүс аль эрт дээр үед амьдран сууж байжээ. Хүмүүс хатаж царцсан хайлмаг, хатуурсан үнсээр орон сууц, зоорь барьж үржил шимтэй тал хөндийд үр тариа, жимс, хүнсний ногоо тариалдаг байжээ.

IV зуунд Гереме хөндийн эл хуль хоосон агуйнууд христос шашны лам нарын анхаарлыг онцгой татаж Ромын эзэнт гүрний өнцөг булан бүрээс ирцгээнэ. Лам нар дэлбэрсэн галт уулын хайлмагаас үүссэн шовгор хэлбэрийн агуйд Бурханд ойрхон гэж даянчлан сууж бясалгал хийнэ. Агуй маш олон байсан ч хачин хэлбэрийн хад асгыг ухаж цоолон орон сууц болгон хувиргах тэрчилэн шуудуу татах их амархан ажээ. Лам нар хад асгыг ухаж янзлан сүм, дуган бий барьж хана, бөмбөгөр оройг нь янз бүрийн зургаар чимнэ.

Сүм дуган нь хэлбэр, хэмжээгээр бие биенээсээ ялгагдана. Византид байгаа шашны дээд удирдлагаас алс байгаа лам нар сүм хийддээ нэр өгөхдөө дураар дургиж бүүдгэр харанхуй байвал Харанхуйн сүм, үүдний өмнө нь алимны мод ургасан бол Алимны сүм гэж дуудна.

Каппадокийн сүм хийдийн хана, тааз, багана, бөмбөгөр оройг гоёмсог зургаар чимэглэжээ. IX-X зуунд хийгдсэн тэр зургууд хуурай сэрүүн орчинд байнга байдаг болохоор хэдэн зуун жилийг ардаа хийсэн ч анхны үзэмжтэй байдлаа алдаагүй байна. Өндөгний шарыг ургамлын болон эрдэсийн бодисуудтай хольж будгийг хийснээр чийг даадаг, бас хагардаггүй болжээ.

Гэгээнтнүүд нүүр царайд хаа нэгтээ зураас байгаа нь сельжукүүдийн сэлэмний ор ажээ.

Эдгээр хосгүй сайхан зургийг бүтээсэн хүмүүсийн нэрсийг түүх бидэнд үлдээсэнгүй, гэхдээ агуйн сүмүүдийг армян тэрчилэн Килики, Византийн грек урчууд чимэглэсэн тухай зохиол бүтээлд дурдсан байдаг.

Агуйн доторх орон сууц, сүмүүдийн орцыг сайтар далдалж орон сууцнуудаас сүм дуганд орох шуудууг нууц нүхнээс түрж гаргадаг дугуй чулуун хавтангуудаар хааж яндан, агааржуулалтын хоолойг хүний нүдэнд харагдахааргүй хийсэн байна.

Каппадоки дахь газар доорх хотхонууд нь агуйн сүмүүдээс тооны хувьд олон ажээ. Газар доорх хотуудыг манай эриний өмнөх хоёрдугаар мянган жилд эртний хетт омог, ассиричууд байгуулсан гэж судлаачид үздэг. Ромын эзэнт гүрний оргуул боолууд, аллагаас зугтсан мэсчингүүд хожим нь Византийн эзэнт гүрнээс дайжсан арабууд ирж газар доторх хотуудад ирж хоргодож байжээ.

Гереме хөндийгөөс өмнө зүгт оршдог Каймакли, Деринкюю хотуудад өнөөдөр ч малталт хийсээр байна. Каймакли хот нь хоёр давхар хийгээд газар доорх хот нь дөрвөн түвшинд оршдог шуудуу, уужим танхимуудаас бүрдэнэ.

Харин Деринкюю хот газрын гүнд 85 метрт орших хийгээд 8 түвшинд нь хэдэн мянган хүн хоргодон байрлаж болно. Хотод хүнсний агуулах, худаг, агааржуулалтын хоолой, дотор нь усан үзэм дарж дарс хийдэг чулуунд цоолон гаргасан чингэлэг гээд хүн удаан хугацаагаар амьдран суухад шаардлагатай бүхий л зүйл байна. Эдгээр газар доорх хотод хүмүүс амьдран сууж хурим найр хийн цэнгэлдэж хүүхдээ төрүүлж өсгөн хүмүүжүүлж, нас дээр гарч өөд болдог байжээ. Тэнд мөн сүм дуганаас гадна гар үйлдвэрлэлийн урлангууд, адууны хашаа, малын хашаа хороо байжээ.

Гаднын халдан довтолгооны аюул байхгүй үед хүмүүс газрын доорх хотуудаас ил гарч газар хагалж тариа, хүнсний ногоо тариална. Тэгээд аюул заналхийлэхэд бүх орцыг сайтар далдалж газар доорх хотдоо орж нуугдана.

Каймакли, Деринкюю хотуудын оршин суугчдын үе бүр газар доорх орон сууцаа улам гүнзгий, соёлжонгуй болгож дайсны халдлагаас аюулгүй байдлаа хангах бүхий л арга хэмжээг авч байлаа. Тэрбээр гүн ангал руу хүргэдэг хуурамч шуудуу татаж орон сууц, сүмүүд орох хэд хэдэн нууц шуудууг хийж байжээ. Газар доорх хотуудад агаар чөлөөтэй нэвтэрч байсан учир бүтэж үхэх ямар ч аюул байсангүй. Газар доорх хотын түвшин бүрт хөрсний ус татах хоолой тавьж цэвэр усны хэрэгцээгээ хангадаг байлаа. Тэрчилэн зузаан олсонд уяж тогтоосон ховоогоор гүний худагнаас ус татаж авна.

Каймакли, Деринкюю хотууд хоорондоо газар доорх хонгилоор холбогдсон байх ёстой гэж эрдэмтэд таамаглаж удтал эрсэн ч олсонгүй. Гэвч нэгэн удаа Деринкюю хотод малталт хийж байгаад гуравдугаар түвшинд нэгэн хонгилоос салаалсан өндөр, өргөн хонгил олсон нь Каймакли хотод хүргэжээ. Хоёр хотын иргэд газар дээр гарахгүйгээр хоорондоо харьцаж аюул тулгарсан үед бие биендээ харилцан тусалдаг байжээ.

XIV зуунд хүчирхэг Византийн эзэнт гүрэн туркүүдэд дийлдэн унаж лалын шашны оронд христосын шүтлэг өргөн нэвтэрч эхлэв. Туркүүд христос шүтлэгтэнгүүдэд хүлцэнгүй хандаж сүм, орон сууцыг сүйтгэж нураасангүй. Гэвч лам нар нь тарж явснаас Гереме хөндийд үйл ажиллагаа явуулдаг сүм үгүй болжээ. Хамгийн сүүлчийн христос шүтлэгтэнгүүд 1924 онд Каппадокийг орхин явжээ.

Христос шашны лам нарын орон сууц барих туршлагыг туркийн тариачид өвлөн авч царцаж хатсан хайлмаг, хатуурсан үнсээр шовгор хэлбэрийн орон сууц барьдаг байлаа. Голдуу 3 метр өндөр тийм орон сууцны байшинг нэгэн зэрэг зочдын, хоолны өрөөний зориулалтаар ашиглаж байв. Өрөөний голд сийлж урласан чулуун ширээ байх хийгээд хана дагуу хивс дэвсэж олон дэр тавьсан чулуун вандан сандал байрлуулжээ. Орон сууцны байрууд нь ухаж цоолон гаргасан ихэнхдээ хоёр цонхтой ажээ.

Турк тосгодын оршин суугчид өнөөдөр ч нарийхан шатаар өгсөж агуулахын зориулалтаар ашиглаж байгаа эзэнгүй байруудад хүрч очно.

## ТБИЛИС

Тбилис хотод Куру голын хоёр эрэг дээр өөд өөдөөсөө харсан хоёр цайз байгаагийн нэг нь Метехсийн цайзын үлдэгдэл, нөгөө нь бүр Александр Македонский суурийг нь тавьсан гэж зарим судлаач үздэг Нарикалы цайзын балгас юм. Эдгээр цайзуудын бууны нүхээр түүх биднийг ширтэн харж байдаг.



Гүржийн түүхч Л.Мровели Тбилис хотын үүсэлтэй холбоотой Парнавоз хааны (манай эриний өмнөх 302-237 он) тухай бичихдээ:

Гүржийн хаан өнөөгийн Тбилис хот оршиж байгаа газар байсан битүү ширэнгэ ойд ан хийж явахдаа буга харважээ. Суманд оногдсон буга үсрэлт дундаа цус урсган хүхэрлэг булагт хажуулдан унаж хөлбөрснөө агшин зуур үсрэн босож ойд далдран алга болжээ. Хаан мэл гайхаж уг булгийг судлуулж халуун эмчилгээний чанартай болохыг мэдэж тэр газар суурших зарлиг буулгажээ.

Хот байгуулагдсан үеэсээ Тбилис (“тбили” гэдэг нь “халуун” гэсэн утгатай ажээ.) нэртэй болжээ. Эртний “Картли Цховреба” зохиолд “Вахтанг Горгасали Тбилис хотын шавыг тавьж түүний хүү Дачи Тбилиси хотын хэрмийг босгож эцгийнхээ гэрээслэсэн ёсоор хотод хааны өргөө босгожээ.” гэж дурджээ.

Тбилис хотын эх суурь Куры голын баруун эрэг дээр хүхэрлэг булгийн дэргэд, өнөөгийн Метехсийн гүүр, “300 арагванчүүдийн” далангийн хооронд тавигджээ. Хотод эрт дээр үеийн олон халуун усны газар байдгаас XVI зуунд хааны гэр, сүмийн вангууд эзэмшихийн төлөө хоорондоо ач тач өрсөлдөж байсан “Ираклиевийн халуун усны газар” хамгийн цуутай билээ.

Халуун усны газруудыг газрын түвшнээс дор, дугуй дээвэртэй барьж танхимын бөмбөгөр оройны таазнаас унжуулсан шилэн дэнлүүгээр гэрэлтүүлдэг байжээ. Тбилисийн халуун усны газар нь хүмүүсийн чөлөөт цагаа өнгөрөөх дуртай, ажил хэрэгч уулзалт явуулж үдийн зоог барьдаг газар байжээ.

Иран улс Гүржийн дорнод хэсэгт улс төрийн нөлөөгөө бэхжүүлж байсан IV зууны үеэс Тбилисийн тухай түүхэн эх сурвалжид дурдсан байдаг. Эртний зохиолд бичихдээ “Персийн



шахын питиа XIII (бие төлөөлөгч) цайз бүхий Тбилиси хотыг сонгон сууж Сололаксын ууланд бэхлэлт нэмж барьжээ. Энэ бүхнийг, үйл ажиллагааг нь питиа XIII нар байнга хянаж байх ёстой гүржийн хаадын эртний нийслэл Мцхеттэй сөргөлдүүлэн хийж байв.” гэжээ.

Тбилис хот олон зуун жилийн хугацаанд цөөнгүй удаа хатуу бэрх сорилт шалгалтыг туулжээ. Өрнөдөөс Дорно руу чиглэсэн худалдааны зам дагуу орших тус хот руу довтолж эзлэн түрэмгийлж байсан дайснуудыг тоочоод баршгүй. Иранчууд, туркүүд, хазарууд, арабууд, византичууд, хоремзийнхэн, монголчууд, Доголон Төмөр хааны цэргүүд түрэмгийлэн халдаж хотыг хуу дээрэмдэж эвдэн сүйтгэж байлаа. Гадаадын түрэмгийлэгчид хотыг дөч гаруй удаа эзлэн авахдаа оршин суугчдыг нь толгой дараалан хядаж хааны ордон шилтгээн, энгийн иргэдийн овоохойг галдан шатааж үнэт эрдэнэсийг дээрэмдэн булаан авч гүржийн соёлын хосгүй үнэт дурсгалуудыг хайр найргүй эвдэн нурааж байжээ. Гэвч хот дайсны өмнө толгой гудайлгаж байсан удаагүй хийгээд тухай бүр балгас, нурам дотроос өндийн босож иржээ.

Улс орны улс төрийн эв нэгдлийг бэхжүүлэх, аж ахуй, соёлын амьдралыг цэгцлэх талаар дорвитой арга хэмжээнүүд авч Бүтээлч Давид гэж алдаршсан IV Давид хаан сельжкүүдээс Гүрж улсын тусгаар тогтнолыг сэргээж томоохон феодалуудтай тууштай тэмцэл хийж байнгын цэрэг бий болгосон гавьяатай билээ. Түүнийг хаанчлалын жилүүдэд (1089-1125) эмнэлэг, асрамжийн төв, шинэ барилга байгууламж, усан хоолой олноор баригдаж гар урлал, худалдаа эрчтэй хөгжиж байлаа. Тэрбээр дөчин залууг сонгож тусгай дээд боловсрол эзэмшүүлэхээр Константинополь хот руу илгээж байв. Ираны түүхчдын бичиж үлдээснээр тэр үед Тбилис нь баян, хүн ам ихтэй, цэцэрлэгт хүрээлэн, 68 халуун усны газартай хот байжээ.

Тбилисийн гар урчууд чамин гоё хийцийн морины тоноглол, эмээл, нум саадаг хийдэг, тэдний урласан ваар, үнэт чулуу, төмөр, арьсан, шилэн эд зүйлс Дундад Ази, алс холын Энэтхэгт алдаршиж байжээ. Дундад зууны үеийн Тбилис хотод бараа тэгнэсэн тэмээн жингийн цуваа дараалан ирж дарс, зэсэн сав суулга, шавран домбо, аяга, таваг худалдаалдаг байв. Тбилисийн зах дээр гүрж, армян, перс, турк, еврей, орос яриа хөөрөө хадаж морьд тахалж үс засаж мөрийтэй тоглоом тоглож наадна.

Тбилис хотын энх амгалан амьдрал удтал үргэлжилсэнгүй, ядуу зүдүү байдлаасаа ангижрах, гаднын дайснуудтай тэмцэх холбоотон олохоор XVIII зуунд Гүрж улс Оросын эзэнт гүрэнд ханджээ. Гэхдээ Гүрж, Оросын улс төр, соёлын харилцаа аль эртнээс хөгжиж бүр ХҮ зуунд гүржийн элчин сайд Москвад очиж Догшин Иван хаан хасагийн баг цэрэг Тбилиси рүү илгээж байжээ. Нэгдүгээр Петр хаан 1722 онд Перс рүү аян дайн хийж байх үедээ Гүржийн VI Вахтанг хаантай цэргийн холбоо тогтоож байв.

Дундад зууны Тбилис хотод Ш.Руставели, И.Шавтели, М.Хонели зэрэг гарамгай яруу найрагчид уран бүтээлээ туурвиж шинжлэх ухаан, урлаг өндөр амжилтад хүрч шашны болон иргэний утга зохиол хөгжиж байв. Гүрж нутагт оросын сод яруу найрагч А.С.Пушкин, М.Лермонтов, зохиолч А.Грибоедов, Л.Н.Толстой, М.Горький, жүжгийн зохиолч А.Островский, зураач И.Айвазовский, дуучин Ф.Шаляпин нар ирж амьдран сууж байхдаа олон сайхан зохиол бүтээлээ бичиж байлаа.

Тбилис хотын баруун талд орших ариун Мтацминда уул хүрэх зам зуур гүржийн алдарт

зохиолч, нийгмийн зүтгэлтнүүдийн бунхан оршино. Уулын хадархаг налууугийн бэлд Мамадавити сүм байна. VI зуунд Сириэс Гүрж нутагтаа буцан ирсэн 13 ламын нэг болох гэгээн Давид битүү ширэнгэ ой байгаа газрыг сонгож бяцхан сүм, мөргөлийн байр барьжээ. Дараа нь арай том сүм босгосныг нь дундад зууны үед дайн байлдааны явцад эвдэн нураажээ. Өнөөгийн бөмбөгөр оройтой Гэгээн Давидийн сүмийг 1861-1871 онуудад нийтдээ арван жилийн хугацаанд барьжээ. Сүмийн дэргэдэх хаданд байх нэгэн булгийн тухай ийм нэгэн домог бий. Бурханд нандин хүслээ илэрхийлэхээр ирсэн эмэгтэй жижиг чулуу авч түүнийг булгийн усанд норгоод сүмийн хананд наалдуулахад жижиг чулуу доош унахгүй бол эмэгтэй хүний нандин хүсэл заавал биелдэг ажээ.

Сүмийн ойролцоох янз бүрийн өндөрт барьсан тагт дээр зохиолч, яруу найрагч И.Чавчавазе, Н.Бараташвили, Г.Табизе, жүжгийн зохиолч Д.Эристави зэрэг гүржийн алдарт уран бүтээлчдийн бунхан байна. Тагтны өмнөд хэсэгт дөрвөн гишгүүртэй цул хаданд “Акаки” гэсэн үгийг сийлсэн байна. Энд гүржийн ард түмний хайртай яруу найрагч А.Церетелийн шарилыг нутаглуулжээ.

Тбилис хотод музей олон хийгээд хот хаана дуусаж музей хаанаас эхлэж байгааг тодорхойлох аргагүй. Тбилиси хотын өвөрмөц дүр төрх нь түүний байрлалаас их шалтгаална. Хотын нэг хэсэг нь гурван талаасаа намхандуу уул нуруу, өндөрлөг газраар хүрээлэгдсэн бол нөгөө хэсэг нь Мтацминда, Таборис-мта, Сололаксын уулсын энгэрт оршино. Хотод эрт дээр үеэс байшин барилгыг уулын энгэрт нэгэнд нь тулган барьсаар ирсэн болохоор хотын хуучин хэсэгт явган замаар явахгүй, нэг байшингийн дээврээс нөгөө байшингийн дээвэр дамжин өгсөж уруудсаар гэртээ очиж болно гэж ярьдаг ажээ.

Хуучин хотын байрлал олон арван жилийн турш огт өөрчлөгдсөнгүй, иймд хотын орчин үеийн хэсэг Куры хөндийгээр гучин километр урт сунжирчээ. Гэхдээ гудамжууд нь мөн л урьдын адил уулын энгэрээр явсаар уулын цаана далдарна.

## ПРАГА

1125 онд өөд болсон түүхч Кузьмагийн бичиж үлдээсэн домогт дурдсан чехийн вангуудын эмэг эх болох Либушаг Прага хотыг үндэслэгч гэж үздэг юм.



Нэгэн удаа удаа Либуша хатан нөхөр Пржемысл, омгуудын захирагч нартай Влтава мөрний эрэг дээр өндөр хадан хясаа дээр гарчээ. Жаргаж байгаа нарны туяа дор хайлууран байгаа тарианы талбайг алтархаг өнгөөр гийгүүлнэ. Нэгэн омгийн захирагч ам нээж::

- Энд хэдэн жилийн өмнө эл хуль нутаг байлаа, гэтэл одоо тариан талбай халиурч байна гээд ой мод битүү уул руу зааж: - Харин тэртээ голын цаана битүү ой шугуй л байна, тэндээс өлсгөлөн чоно хүн мал руу дайрч биднийг мөн их зовоож байна даа гэж санаа алдан хэлэв.

Тэгтэл хатны царай гийж, нарны туяа гийгүүлж байгаа ширэнгэ ой руу харж::

- Тэнд их хот харагдаж байна! Түүний алдар одод хүртэл цуурайтаг! Эндээс 30 гон зайтай (1 гон нь 125 алхамтай тэнцэх эртний уртын хэмжээ) Влтава мөрний хөндийд үржил шимтэй, ер бусын сайхан нутаг байна. Хойд зүгээс нь Брусница мөрөн урссаар уулын хавцалд шингэж байна, урд талд нь хадархаг уул байна, тэнд байшингийхаа босгыг сүхээр тэгшилж байгаа нэг хүн байна. Тэнд барих хотыг Прага гэж нэрлэе! гэж өгүүлжээ.

Прага шиг гайхам сайхан байрлалтай хот европ тивд цөөхөн билээ, гэхдээ “Алтан Прага” хот болтлоо ихээхэн замнал туулжээ. Тус хотод роман, гот, сэргэн мандалт, барокко, модерн гэх зэрэг бүх үе, дэг тусгалаа олсон байдаг. Хот сүйрч байгаагүй ч хэд хэдэн удаа эзлэгдэж байв. Прага хот баатарлаг тэмцлээрээ төдийгүй идэвхгүй эсэргүүцлээрээ алдартай билээ. Фашистууд чехүүдийг “инээдэг чөтгөрүүд” гэж дургүйцэн нэрлэж байв.

Эртний анхны байгууламж нь Градчаны буюу Алтан гудамж дов дээр байгуулагдсан үеэс Прага хотын түүх эхэлдэг. 880 онд чехийн ван Борживой өнөө үед ч тус улсын ерөнхийлөгчийн өргөө болж байгаа Град ордны эх суурийг тавьж Влтава мөрний зүүн эрэг дээр Гэгээн Марияд зориулсан анхны христос шашны сүмийг бариулжээ. Тэр сүмийн барилга өнөөг хүртэл хадгалагдаж ирээгүй ч XIII зууны дунд үе хүртэл Чехэд ихэд дээдэлж байсан роман дэгийн барилга Прага хотод цөөнгүй бий. Тэдгээрийн тоонд Гэгээн Хэрээс,

Гэгээн Мартин, Гэгээн Лонгин нарын дугуй байгууламж, тэрчилэн Гэгээн Йиржийн (Георгий) сүм багтана. 973 онд анх баригдаж 1142 онд өнөөгийн дүр төрхөө олсон Гэгээн Йиржийн сүмийн гоолиг цамхагууд хоёр цагаан хуруу шиг Град ордны дээр сүндэрлэнэ.

XIII зууны үед Влтава мөрний баруун эрэг дээр тайж нарын эдлэн газар, худалдаачдын байшингуудаас бүрдэх Старо хотхон (“Хуучин дүүрэг”) бий болжээ. Старо хотхоны хамгийн жижиг түүхэн дүүрэг нь Вышеград юм. Домгоор бол Град ордноос өмнөх үед Чехийн өвөг эцгийг залгамжлагч, захирагч Крак уг дүүргийн эх суурийг тавьжээ. Гэхдээ Старо дүүрэг модон цайз баригдсан X зуунд л дөнгөж бий болсон гэж эрдэмтэд үзэж байна.

Прага хотын Кремлийн ойролцоо тавин жилийн дараа, хожим нь Бага эх орон гэж нэрлэгдсэн бас нэг дүүрэг байгуулагджээ. XIV зууны эхээр Град ордон руу хүргэдэг замын дэргэд Градчаны, IV Карл хааны үед Влтава мөрний баруун эрэг дээр Шинэ дүүрэг бий болжээ.

Олон зууны турш бие даасан байдалтай байсан Прага хотын түүхэн дүүргүүдийг хоёрдугаар Иосиф хаан 1784 онд нэгдмэл хот болгон нэгтгэжээ. Прага хот нь европийн эртний хотуудын нэг болохоор дүүрэг бүр нь өөрийн өвөрмөц баялаг түүхтэй юм. Мянгаад жилийн тэртээ худалдаачид, аялагчид Прага хотыг гайхамшигт хот хэмээн уулга алдаж Влтава мөрний хоёр эрэг дагуу орших чулуун байшингууд, авьяаслаг гар урчуудын бүтээлүүд дүүрэн захуудыг магтан шагшиж байлаа.

Прага хотод цэцэглэж байсан уран барилгын бас нэг дэг нь гот дэг байлаа. Хурц сэтгэлгээ, мэргэн гүйлгээ ухаанаараа европ даяар гайхагдаж байсан IV Карл хааны үед гот хийцийн олон барилга баригдсанаас дийлэнх нь өнөөг хүрчээ. Тэрчилэн Прага хотын Кремлиэс холгүйхэн Влтава мөрний хоёр эргийг холбосон гүүр баригджээ. Хаан зөвлөхүүд, бие хамгаалагчдаа дагуулан хотын гулдан хаалганаас Град дахь өргөө рүүгээ явдаг байсан хааны эртний замд Карлов гүүрийг барьжээ.

Хааны гаралт ердийнхөөсөө илүү олон хүнтэй байвал хотын иргэд чухал үйл явдал болж байна гэдгийг төвөггүй ойлгоно. Тийм үед хонхнууд хангинаж хааны дагуулууд замын хажуугаар хуран цугларсан олон түмэн рүү зоос шиднэ. Тэр гаралт нь хаанаар өргөмжлөх ёслол биш гэлээ гэхэд, хааны хурим юм уу хааны залгамжлагчийг загалмайлах ёслол байв.

Хааны зам нь бүр XII зууны үед Прага хотын хамгийн чухал зам байлаа. Тиймд хүмүүс зам дагуу орон сууцны байшин, урлан барих юм уу жижиг ч атугай дэлгүүр, зоогийн газар байгуулахыг эрмэлзэж хоорондоо өрсөлддөг байв. Замаар яваа хаан түүний хатан, тэдний ойр дотнын хүмүүсээс дэлгэн тавьсан бараанд харц тусгаж зарц нартаа худалдан авахыг дохих нь дэлгүүрийн эзний хувьд азтай, том үйл явдал байлаа.

Карлов гүүр олон зуун жилийн хугацаанд олон түүхэн үйл явдал, чехийн ард түмний цэцэглэлт, уналтын гэрч болж байлаа. Уг гүүрийг барихдаа чулууг барьцалдуулсан зуурмагт өндөг нэмж хийж байсан учир хамгийн бат бэх гүүр болсон гэж ярьдаг билээ.

Гүүрний асар том 16 нуман гулдан, мөн тооны тулгуурыг барьцалдуулахад хэрэглэх өндөг хүрэлцэхгүй болоход IV Карл хаан чехийн бүх хотын оршин суугчдад хандаж гүүр барихад зориулж өндөг ирүүлэх зарлиг буулгажээ. Тэгээд тус улсын өнцөг булан бүрээс гүүр барихад

зориулж түүхий өндөг тэрэг тэргээр зөөн авчирна. Гэтэл нэгэн хотын иргэд чанасан өндөг ирүүлэхэд Прага хот тэр аяараа шоолон даажигнаж байжээ.

520 метр урт Карлов гүүр ашиглалтад орсны дараа ганц ч уран баримал, ганц ч чимэглэлгүй болохыг анзаарч маш их гайхацгаажээ. Гагцхүү эрт дээр үед хүн цаазалдаг байсан шиг модон хэрээс л байв. Одоо бол Гэгээн Хэрээсний сүмийг гүүрний нэг цамхагтай холбосон хананд чулуугаар сийлсэн нэгэн сахалтай хүний толгой байгааг харж болно. Энэ бол гүүрний анхны барилгачин өөрийн дүрсийг хойч үедээ үлдээх зорилгоор толгойныхоо дүрсийг чулуунд сийлсэн нь энэ гэж ярьцгаадаг.

Өнөө үед Карлов гүүрийг Ялалтын хаалга болон барокко дэгээр урласан уран баримлуудаар чимэглэжээ. Гүүрний нэгэн тулгуурын хайсны цаана шудрага үйлсийн төлөө тулалдахаар хэрэн явж байсан рыцарь эр Брунцвикийн баримал бий.

Рыцарь эр Брунцвик алс оронд явж байхдаа аймшигт лууг алж хааны охиныг үхлийн савраас аварчээ. Хаан охиных нь амийг аварсанд талархаж түүнийг эхнэрээ болгон авахыг санал болгоход рыцарь эр эх нутагт нь сүйт бүсгүй минь хүлээж байгаа гэсэн шалтгаанаар татгалзжээ. Тэгтэл хаан багтартлаа уурлаж эрэлхэг рыцарь эрийг шоронд хорьжээ. Гэвч рыцарь эр шидэт илдийн ачаар шоронгоос суллагдаж чаджээ. Тэр илдийг гүүрний сууринд тавьжээ. Прага хотод аюул занал учрахад илд гадагшаа гарч хурц ирээрээ дайсны зүг рүү зааж чехүүдийг байлдаанд уриалан орно гэж үздэг ажээ.

926 онд Вацлав вангийн байгуулсан дугуй байгууламжийн буурин дээр IV Карл хаан Гэгээн Витийн сүм босгожээ.

Өнөөдөр Прага хот дахь хамгийн том төдийгүй дэлхийн гот дэгийн уран барилгын сувд эрдэнэ болж байгаа энэ сүм хэдэн зуун жилийн хугацаанд баригдсан хийгээд нүүрэн тал нь Париж дахь Дарь Эхийн сүмийг санагдуулна.

Карлов гүүрээр гарч Старомест талбай хүрэхэд чулуун дуулга оройд нь залсан өвөрмөц цамхаг бүхий Хотын захиргааны байшин оршино. Эрт дээр үед алтаар бүрсэн орой нь жаргаж байгаа нарны туяанд Прага хотын бусад алтадмал цамхагтай хослон нүд гялбуулдаг байсан тул “Алтан Прага” гэсэн нэр үүссэн гэдэг. XIX зуунд амьдарч байсан эрдэмтэн Больцано Прага хотын бүх цамхагийг тоолоход 103 хүрч байсан бол одоо түүнээс илүү олон болсон нь мэдээж.

Старомест дүүрэг 1338 онд бие даасан дүүрэг болсноо билэгдэж Хотын захиргааны байшин босгохоор шийдэж барих газрыг удтал шинжиж хотын төвд орших нэгэн байшинг сонгож уг байшинг эзнээс нь худалдан авч гот хийцийн цамхаг нэмж барьжээ. ХҮ зуунд байшингийн зүүн талд нь бас нэг жигүүр залган барьж түүний цонхны дээд талд “Praga regni” (“Прага бол хаант улсын тэргүүлэх хот”) гэсэн үгстэй сүлд тогтоосон байна. XIX зуунд Прага хотын захиргааны байшингийн цогцолборт хөрш зэргэлдээ оршиж байсан хоёр байшинг нийлүүлжээ.

Прага хотод бүх зүйл өнгөрсөн үеийг санагдуулах хийгээд Хотын захиргааны байшингийн цамхагт 1410 онд анх тогтоож хэдэнтээ засаж янзалсан алдарт цаг бий. Нэгэн домгоор хотын

цагийг бүтээгч, цагны дархан Ганушийг бусад хотод тийм гайхамшигт цаг барих бололцоо олгохгүй гэж түүний нүдийг сохлохоор шийджээ. Цагны дархан Гануш хотынхондоо гомдож нүдийг минь сохлохоос өмнө хийсэн цагийг нь сүүлчийн удаа харуулахыг хүсэж гуйлтыг нь биелүүлэх агшинд гараа цагны механизмд хүргэж цагны явалтыг зогсоосон гэдэг.

Прага хотын Захиргааны байшингийн цамхагийн цаг гурван хэсгээс бүрдэнэ. Дээд хэсэг болох хоёр жижиг цонх дотроос Найдангууд гарч ирнэ. Найдангууд тойрог үүсгэн явж байх зуур доод хэсгийн жижиг цонхнуудад Араг яс элсэн цагийг хөмрүүлж хонх цохиж хээнцэр залуу Турку залуу руу толгой дохино. Турку залуу хариуд нь татгалзан толгойгоо сэгсэрч толь руу харна. Харамч эр түрүүвч зоос хангинуулан дуугаргана. Гэвч тэд бүгдийг үхэл хүлээж байна.

Цагны хоёрдугаар хэсэг болох нүүрэнд нь Дэлхий ертөнцийн төв гэж үздэг дундад зууны үеийн ойлголтыг үндэслэн тэнгэрийн эрхэс гаригийн хөдөлгөөнийг дүрсэлжээ. Цагны гуравдахь хэсэг нь зурхайн тэмдэг бүхий 12 сарыг харуулсан билэгдэл байна.

Олон зууны түүхтэй Прага хотын том Хуучин хот дэлхий дэх бараг хэвээр уламжлагдан ирсэн цөөхөн хотуудын нэг билээ. Хотын захиргааны байшин дээр гарч эргэн тойрон харахад Хуучин хот яг дэргэд, тоймгүй олон цамхаг, улаан-саарал вааран дээвэр, худаг бүхий гудамжууд нүд баясгана.

Чехийн алдарт зохиолч Ярослав Гашекийн “Эрэлхэг цэрэг Швейк” романд дурдсан бүх гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, дагуул хотхон, ордон, байшингуудын нэрсийг гаргавал хотын тухай өвөрмөц лавлах болно.

## БРЮССЕЛЬ

Бельги улсын нийслэл Брюссель нь Европийн хойд хэсгийг Франц, Герман болон бусад оронтой холбосон эртний тээврийн зам дагуу туйлын ашигтай байрлалд байдаг учир VIII зуунд үүсчээ. X зуун гэхэд Брюссель нь Брабантын ванлигийн гол хотын нэг болж дөрвөн зуун жилийн дараа Бургундын гүнгийн удмынхны эзэмшилд орсон үеэс баян худалдаачид, язгууртнууд бүхий худалдааны томоохон төв болон хувирсан байлаа.



Тус хот нь дэлхийн бусад орны нийслэлтэй огт адилгүй билээ. Мянга гаруй жилийнхээ түүхийнхээ найман зуу орчим жилийг Бургундын гүнгүүд, Австри, Испани, Наполеон, голландчууд, германчуудын захиргаанд байжээ. Шинэ эзэн бүр тус хотод өөрийн үзэмжээр дэглэм, журам тогтоож байв.

Эл хот нь олон зуун жил гадаадын дарангуйлалд байсан ч европийн улсуудын нийслэл болж алдаршсан билээ. Өнөөдөр тус хотод Европийн Холбоо, НАТО зэрэг олон улсын нөлөө бүхий олон улсын байгууллагуудын өргөө байрлаж байна.

Брюссель хотыг олон тооны эзлэн түрэмгийлэгчид тухай бүр түйвээн сүйтгэж байлаа. Тухайлбал XVII зууны сүүлчээр Францийн XIV Людовик хааны арми хотын түүхэн төвийг устгаснаар дундад зууны үеийн гар урлал, худалдааны хотын уламжлалт дүр төрх үгүй болжээ. Францчууд бас тус хотын билэг тэмдэг болж байсан Мароллийн хорооллын хэсгийг сүйтгэсэн ч хожим нь Хууль зүйн ордны гоёмсог барилгыг босгожээ.

Уран барилга дахь “модерн” чиглэлийг үндэслэгч, гарамгай уран барилгач Виктор Хортын шилдэг уран бүтээл болох Ард түмний ордонг хорьдугаар зууны эхээр мөн нураажээ.

Өнөөгийн Брюссель хот нь зүүн-өмнө тал руугаа өндөрдүү уужим тэгш тал дээр оршино. Үүнээс улбаалан эл хот нь төв хэсэг нь голд нь байх дээд, доод хэсэг гэж хуваагджээ.

Хотод ирсэн хүн бүр Гранд-Плас буюу дундад зууны үеийн цогцолбор барилга байгууламж бүхий Том талбай руу очно. Олон тооны баримал, нуман хэлбэрийн гуутай цонх, тэнгэр өөд тэмүүлсэн шовх оройтой цамхаг, хээ угалзтай хөвөө эмжээртэй урт хонгил, өвөрмөц хээ угалзтай хаалга бүхий гот, барокко хийцийн эртний барилгууд харц булааж сэтгэл баясгана.

Гранд-Плас талбайд гол хаалга нь уран барилгачны алдаанаас болж цамхагийн гол тэнхлэгээс зөрсөн хотын Захиргааны сүрлэг байшин байна. XIII зуунаас “Талхны ордон” гэж алдаршсан байшинг өргөжүүлэн барьсан гот хийцийн, арван багана бүхий тэр гоёмсог байшин нь чулуун сүлжээсээс бүрдсэн мэт харагдана.

Одоо Брюссель хотын түүхийг харуулсан Хотын музей байрлах “Хааны ордон”-ы барилга ХҮ зуунд баригджээ. Хотын хөгжлийн түүхийг харуулсан уг музейн танхимуудад гар урлалын корпорациудын тугуудыг хананаас өлгөн унжуулж шилэн хорго дотор тус орны алдарт хүмүүстэй холбоотой ховор нандин баримтуудыг дэлгэн тавьжээ.

Сүүлийн арваад жилд Гранд-Плас талбайд жилд хоёр удаа хайтан цэцгэн хивсний үзэсгэлэн зохиодог уламжлал тогтжээ. Эрт дээр үед уг талбайд буруу номтнуудыг цээрлүүлдэг, босогчдын толгойг тасдан цаазалдаг байжээ.

XIX зууны дунд үеэс Европ тивийн төвд зөөн авчирсан халуун орны ургамал сонирхдог болсон Стаутеманс хэмээх хүн хорьдугаар зууны дунд үеэс Фландрын зарим жижигхэн хот, Францийн Лилль хотод цэцгэн хивс байгуулан сурталчилж байгаад 1971 оноос Брюссель хотын Гранд-Плас талбайг байлдан дагуулж Гент хот дахь хүлэмжээс хайтан цэцэгний 70 мянган үндэс авчирч 77\*24 метрийн хэмжээтэй тэгш өнцөгт талбайд хэдхэн цагийн дотор суулгадаг байв. Ийнхүү хайтан цэцгэн хивс Брюссель хотыг жил бүр гурван хоногийн турш чимдэг байна.

Өнөөгийн цэцгэн хивс нь харьяат оршин суугчид нь Фландрын уугуул, Испанийн Ү Карл хаанд зориулан урлаж байсан цэцгэн хивснээс эхлэлтэй билээ.

1549 онд брюссельчүүд Ү Карл хааныг ёслол төгөлдөр угтаж байсныг өнөө үед жил бүр “Омеганг” гэсэн нэртэй баяр болгон тэмдэглэдэг уламжлал тогтжээ. Уг баярын үеэр таван зуун жилийн тэртээх байдлаар жагсаал хийж түүнд Фландр, Брабантын язгууртны удмын залгамжлагчид оролцоно. Брюссель хотод очиход Ү Карл хааны алхаж байсан явган зам, өвдөглөн мөргөж байсан тахил, бүжиглэн хөгжилдөж байсан шар айрагны газрыг үзүүлнэ.

Гранд-Плас талбайны хажууханд булангийн цаана бараан баганын дор хэвтэж буй хандмаагийн товгор дүрс байдаг. Дээр үед ядуу зүдүү байдлаасаа болж хүүхдээ өсгөж бойжуулах бололцоогүй болсон эхчүүд дөнгөж төрүүлсэн хүүхдээ уг товгор дүрсний дор байрлуулсан тусгай хайрцаг дотор тавьсныг хандмаа нар нөгөө талаас нь гаргасан нүхээр гараа шургуулж өргөн авдаг байжээ. Хэвтэж буй хандмаагийн гялалзтал өнгөлсөн зэсэн гарт хүрсэн хүн бүр хууч өвчнөөсөө ангижирдаг гэсэн домог бий.

Бельгичүүд “манай нийслэлийн ахмад гишүүн” гэж дээдэлж “Маннекен пис” буюу “Шээж байгаа бяцхан хүү” гэж өхөөрдөн нэрлэдэг жижигхэн усан оргилуур юм. Сараалжаар хүрээлүүлсэн усан оргилуурын голд шээж байгаа хоёр гурван насны бяцхан хүүгийн хүрэл баримал байна.

Уг баримлын үүслийн тухай маш олон домог байдаг. Тухайлбал дүрсгүй хүү байшингийнхаа үүдэнд шээж зогсохыг нь Эх Дагина хараад уурлаж чулуу болгон хувиргасан гэдэг домог бий. Түүнээс гадна гүн Гетфрид Брабантын отгон хүүг бельгийн уран барилгач Ж.Дюкесной 1619



онд бүтээсэн гэдэг.

“Гүн бослого гаргасан харьяат иргэдээ дарахаар тулалдаж байтал байдал хүндэрч аргагүйд тулж ухарлаа. Тулалдааны эгзэгтэй үед гүнгийн зарц нь эцэг нь аян байлдаанд дагуулж гарсан бяцхан хүү өлгий дотроо шээснийг дуулгаж “Хүү шээчихлээ!” гэж хашгирчээ. Цэргүүд хөгжилдөж “Хүү шээчихлээ!” гэж давтан хэлж урам зориг орж, дайралтад уулгалан орж босогчдыг дийлжээ. Энэ тэмдэглэлт үйл явдалд зориулан гүн Брабант энэхүү цуутай усан оргилуурыг босгожээ.”

Өнөөгийн 61 сантиметр өндөртэй “Шээж байгаа бяцхан хүү” баримлыг XIX зуунд урлаж урьд нь байсан баримлын оронд байрлуулжээ.

Уг барималд баяр ёслолын үед гоёлын хувцас өмсгөдөг, гадаад орнуудаас үндэсний хувцас, цэрэг цагдаагийн дүрэмт хувцас бэлэг болгон ирүүлдэг уламжлал тогтжээ. Баварын курфюстийн 1698 онд бэлэглэсэн костюм нь түүний анхны хувцас болж тавин жилийн дараа Францийн ХҮ Людовик хаан алтан торгоор урласан хувцас ирүүлж байжээ.

Хотын музейд “Маннекен пис”-ийн францийн хувьсгалчид, Наполеоны үеийн тVШмэл, улаан арьстны өдтэй хувцас, америкийн цагдаагийн дүрэмт хэвцастай гээд янз бүрийн хувцас өмсгөсөн зуу гаруй хуулбар баримал байдаг.

Тэрчилэн “Шээж байгаа бяцхан хүү” баримал олон арван одон, медальтай бөгөөд түүний дотор Бельгийн дээд одон бий.

Гранд-Плас талбайд орших эртний байшингуудаас Францийн гуравдугаар Наполеон хаанд хөөгдсөний дараа францийн алдарт зохиолч амьдарч байсан “Оёдолчин үйлчид ба Виктор Гюгогийн ордон” ихэд цуутай билээ. Энэ цогцолборын дунд байгаа, дээвэр дээр нь талбай руу гараа сунгасан хүрэл эмэгтэйн баримал бүхий байранд В.Гюго сууж байжээ.

Ш.де.Костерийн “Уленшпигелийн тухай домог” романы 35 дугаар бүлэгт “Тиль Уленшпигель гурван өдрийн дараа Брюсселийн ойролцоох Уккле хэмээх баян тосгон руу ортол “Анчны эвэр” буурчийн газрын зүгээс халуун хоолны үнэр ханхийв.” гэж бичсэн байдаг.

Өнөөдөр Брюссель хотын дагуул хот болох Укклед улаан тойпуун эртний байшин байгаа нь Уленшпигель ядуу сохор хүмүүсийг хооллосон “Анчны эвэр” хэмээх бяцхан зоогийн газар ажээ.

## ЧИЧЕН-ИЦА

Дорнын нутагт байх Улаан Чак бурхны зүгээс төөнөм улаан нар гэрэлтэж хойд нутагт байх Цагаан Чак бурхны зүгээс хөлдөм хүйтэн агаар үлээж, цасаар хучна. Элсэн цөл дээрээс уулс өнгийн харж буй баруун нутагт Хар Чак бурхан байна, янз бүрийн өвс ургамал алагласан хээр тал, битүү ой шугуйг Шар Чак захирна. Бурхдын ноёрхлын нутгийн хооронд майя ард түмний нутаг оршино. Майя ард түмний үржил шимтэй нутагт Чаки бурхад усан бороо асгаруулан аянга цахилуулан тал бүрээс ирнэ. Ус дүүргэсэн том домбо салхинд ганхаж тэнгэрт солонго татаж эрдэнэ шиш, ойн мөнхийн залуу бурхан Юм-Кааш ногоон яргуй бэлэглэнэ.



Энэ бол майя ард түмний тухай нэг домог. Гэхдээ Паленке, Тикаль, Ушмаль, Чичен-Ица гэх зэрэг сайхан хотуудын тухай мөн адил сэтгэл татам домгууд бий. Эдгээр хот хээ угалзаар чимэглэсэн чулуун ордон, дээд талбайнууд дээрээ Нарны сүмүүдтэй шаталсан пирамидууд, одон орон судлах төв, бөмбөг тоглох цэнгэлдэх хүрээлэн, театрын чулуун тайзаараа алдартай билээ.

Чичен-Ица хотын нэр нь “худагны амсар, ам” гэсэн утгатай хийгээд Ү зууны дунд үед ица омгийнхон хэрэн тэнүүчилж явахдаа энэ нутагт сенот буюу байгалийн худаг олж сууршижээ.

Тус хот нь Х зуун хүртэл майя ард түмний соёл иргэншлийн чухал төвүүдийн нэг, баян сайхан хот байжээ. Хотод урлаг, гар урлал эрчтэй хөгжиж сүм хийдэд заримдаа хүнээр тахил өргөж шашны сүрлэг ёслол хийдэг байлаа. Гэвч 692 онд улаан арьстны ица омгийнхон одоо тодорхой бус шалтгаанаар үлэмжийн сайхан хотоо орхиж явснаас бүх барилга байгууламж, сүм дуган, ордон өргөө эзгүйрч аажимдаа нурж унажээ.

XI зуунд Юкатан хагас арал дээр тольтек омгийнхон нүүдэллэн ирж майя улсын газар нутгийн дийлэнх хэсгийг захиргаандаа оруулж Чичен-Ица хотыг нийслэлээрээ зарлажээ. Майя, тольтекүүд хоорондоо дайтсангүй, найрсагаар хэлэлцэн тохиролцож нэгдсэн бололтой. Тольтекүүд майя ард түмний бичгийг өвлөн авч одон орон судлал, математикийн ололтыг нь цааш үргэлжлүүлж газар хагалж тариа тарих аргыг суралцаж түүний зэрэгцээ шинэ дэглэм журам тогтоожээ. Майячууд ч тольтекүүдээс одон орон судлалын жижигхэн цамхагууд шиг дугуй байшин барих урлагт суралцаж тэдний дээдэлдэг бурхдыг мөн бишрэн шүтэх болжээ. Тула хотоос хөөгдсөн, майячууд Кукулькан гэж нэрлэдэг байсан Топиль-Кецалькоатль дээд

Бурхны нийслэл нь Чичен-ица байсан байх гэсэн таамаглалыг эрдэмтэд дэвшүүлдэг юм. Дээд бурханд зориулан эртний байгууламжийн буурины балгас дээр “Кастильо” пирамидийг босгожээ. Өндөрлөг газар барьсан пирамид нь дөрвөн талдаа тус бүр нь 91 гишгүүртэй шат бүхий есөн түвшинтэй байгууламж билээ.

Ертөнцийн дөрвөн зүг бүр рүү харуулан тэгш хэмтэй байрлуулсан шатууд нь жилийн улирал, сар, өдрүүдийг билэгдэнэ. Хавар, намар өдөр, шөнө тэнцэх өдөр нарны туяа пирамид дээр тусах үед толгой, хөлийг нь пирамидийн орой, сууринд сийлэн хийсэн Өдтэй могой-Кукульхан амь орж сүмээс мөлхөн гарч байгаа мэт сэтгэгдэл төрнө.

Тольтекийн удирдагч Өдтэй могой эзэгнэн суусан майягийн хотод өөрийнхээ нэрээр нэрлэх Кецаль бурхны шүтээн барих зарлиг буулгажээ. Мексик орныг эзлэн түрэмгийлсэн испаничууд тэрхүү уран барилгын дурсгалыг салхи ивээгч Кецаль бурхны өвөрмөц нэг онцлог нь дун байдаг тул “Караколь” буюу “Дун” гэж нэрлэдэг болжээ.

Мексик улсад Өдтэй могойны шүтээн л зөвхөн бортогон хэлбэртэй байсан хийгээд майя омгийнхон энэ байгууламжийг Кецаль бурхантай төдийгүй өдөр тутмын амьдралдаа байнга хэрэглэдэг хуанлитай холбон үздэг байв. Дугуй хэлбэртэй байшинг хожим нь тойруулан тагт барьж дараа нь нэгдүгээр давхар дээр нь мөн адил дугуй хэлбэртэй ч хэмжээний хувьд бас нэг давхрыг нэмж босгож, дээд давхрын хананд нь дөрвөн дөрвөлжин нүх гаргаж дээр нь одон орон судлах төв байгуулж зурхайч нар эрхэс гаригийн ажиглалт хийдэг болжээ.

Майя омгийн зурхайчид Каракольд хоёр хуанли ашигладаг байсан учир тооцооны хоёр тогтолцоог хэрэглэдэг байв. Өдтэй могой Чичен-Ица хотыг захирдаг болмогцоо бүтэн жилийн үргэлжлэх хугацааг Сугар гаригийн эргэлтийн 584 хоногоор тооцдог гурав дахь хуанлийг нэмжээ. Эрхэс гаригийн хоорондын харилцаанд хатуу дэг журам эрж хайдаг улаан арьстан зурхайчид майя омгийн баримталдаг “иргэний” хуанли болон Сугар гаригийн жилийн хооронд тодорхой харьцааг дор нь бий болгожээ.

Чичен-Ица хотын төвөөс нум сумны гурван нисэлтийн зайтайд бороо, чийгний Юм-Чак бурхан амьдран суудаг “Үхлийн худаг” оршино. Бурхан хилэгнэвэл мод, амьтад, шувууд гээд хорвоогийн бүх зүйл сөнөнө, бороо орохгүй бол бүх зүйл хатаж түймэр гарна, тэгвэл хүн ард ч үхэж, ертөнц дээр гагцхүү өндөр уулс, зах хязгааргүй тэнгэр үлдэнэ. Юм-Чак бурхныг тайтгаруулахын тулд залуу хөөрхөн бүсгүйчүүд өргөн барих ёстой гэж үздэг байжээ.

Тольтекүүд ирж сууршисанаар майя-тольтекийн холимог соёл бий болж хэдэн зуун жил оршин тогтножээ. Сул шохойн чулуугаар барьсан, асар том хэмжээний сүмүүд нь тухайн цаг үеийн уран барилгын өвөрмөц онцлог болж байв. Сүмүүдийг том тавцан маягийн суурин дээр босгож товгор дүрс, ханын зургаар үргэлж чимдэг байлаа. Түүний нэг сонгодог жишээ нь тольтекийн дайчдад зориулсан “Цэргийн сүм” юм. Сүмийн орцны үүдэнд дайнч тольтек омгийнхныг Чичен-Ица хотод даллан ирүүлсэн Өдтэй могойн дүрс бүхий хоёр өндөр багана босгожээ. Сүмийн дотор ханыг домгийн, түүхэн, тэр ч бүү хэл ахуйн сэдэвтэй зургуудаар чимсэний дотор шар ирвэс, бүргэдийн дүрс олон байна.

Баганууд бүхий уужим танхимаар явж “Цэргийн сүм”-д хүрнэ. Тольтекийн догшин ширүүн, эрэлхэг дайчдыг дүрсэлсэн тоймгүй олон багана өнөө үед дээвэргүйгээр хадгалагдан иржээ.

Эндээс тохойгоо тулж толгойгоо өндийлгөн хажуулдан хэвтэж байгаа эрэгтэй хүний сонин баримал гарчээ. Сүм, хот он цагийн уртад сүйдэж байхад ч огт өөрчлөгдөөгүй чулуун хүн мянган жилийн өмнөх үеийнх шигээ ихэмсэг, шоглонгүй инээн хэвтсээр байна. Энэ бол дайнч тольтек омгийн шүтээн болох Чак-Мооль бурхан ажээ. Тэрбээр гартаа том таваг барьсан байгаа нь эрт дээр үед ариун гал асааж юм уу өргөл барьц болгон хоол унд тавьж байсныг нь гэрчилнэ.

“Цэргийн сүм”-ийг малталт хийж нээсэн америкийн эрдэмтэн Эрл Морис сүмийн довжоонд илүү эрт дээр үеийн шүтээн байна гэсэн таамаглал дэвшүүлжээ. Тэгээд сүмийн гадна ханыг цөмөлж үзэхэд арай жижиг хэмжээний яг адилхан сүм байгааг илрүүлэв. Хоёр сүмийн дотоод хананд Юкатаныг байлдан эзлэх үед Өдтэй могойны удирдсан цэргүүдийн баатарлаг гавьяаг харуулсан гоёмсог ханын зургууд байлаа.

## ВЕНЕЦИ

Сүүлийн таван зуун жилийн хугацаанд ямар нэгэн өөрчлөлтгүй бараг яг хэвээр байгаа хот бол Венеци юм. Гэгээн Маркийн талбай, гайхамшигт ордон, сүм, олон тооны суваг, гудамж, дэлгүүр, мухлаг 1566 оных шигээ яг хэвээр байна.



Галт тэрэг Венеци хот руу 222 нуман тулгууртай том гүүрээр явж ирнэ. Чухамдаа энэ гүүр түүнтэй зэрэгцэн зурайх засмал зам хотыг тэнгисийн эрэгтэй холбоно. Венеци хот нь 118 арал дээр орших хийгээд 175 суваг байдгаас хамгийн том нь 3 орчим километр урт, 50 метр өргөн “Том суваг” ажээ. Засмал зам Ромын жижгэвтэр талбайд тулж очно. Венеци хотын хаалга гэж нэрлэж болох Ромын талбайг хөндлөн гарсны дараа зөвхөн усаар л урагшилж болно.

Том сувгаар ачаа бүхий хөдөлгүүрт болон сэлүүрт завь, жижиг завь, хөдөлгүүрт гоёмсог завь, далбаат завь мэдээж хэрэг гондол завь гээд олон төрлийн завь, усан онгоц тасралтгүй сүлжилдэнэ. XI зуунд бий болсон хөнгөн, гоёмсог гондол завь бараг өөрчлөгдсөнгүй, 1630 онд болсон тарваган тахлын үеэс гондол завийг хар өнгөөр буддаг болсон нь өнөөг хүртэл уламжлагдан иржээ. Хамар дээрээ эмтэрхий төмөр чимэгтэй, хитэг дээр ганц сэлүүртэй гондол завиуд нэг нэгнээс нь багтаамж, чимэглэлээрээ ялгагдана.

Том сувгаар хөвж байхад музей үзэж байгаа юм шиг сэтгэгдэл төрнө. Венецийн хамгийн гоё гүүр болох XVI зуунд барьсан алдарт Риальто гүүрийн доогуур гарч Алтан байшин, суут хөгжмийн зохиолч Р.Вагнер 1883 онд өөд болсон Вендромин ордны хажуугаар өнгөрнө. Том сувгийн хоёр талаар байх зарим эртний байшингийн хаалга сувагт тулсан байдаг тул гондол завинд сууж л байж тухайн байшингаас гарна.

Адриатын тэнгисийн хойд хэсэг, Падуяд оршин суугчид ард түмнүүдийн их нүүдлийн үеэр гуннуудын довтолгооноос зугтааж тэнгисийн эргийн жижигхэн арлуудад ирж сууршижээ. Он удаан жил баг бэх байх байшин барилга барихын тулд юуны өмнө намагтай газрыг хатаах, далан байгуулах, суваг татах зэрэг асар их ажил хийжээ. Тэд намагтай хөрсөнд шон зоож байшин барьж эхлэжээ. Иймд Венецийн бүх барилгыг модон шонгууд дээр барьсан гэж болно. Тухайлбал хотын тарваган тахлын аюулаас ангижруулсны дурсгалд зориулан босгосон Санта-Мария делла Салюте сүмийн барилгыг 1500 шон дээр барьжээ.

Венеци хот нь газар зүйн ашигтай байрлалынхаа хувьд XI зуунд Өрнөд болон Дорнын хооронд худалдааны зуучлагч болсноор улс төрийн нэр хүнд нь өсөж эдийн засгийн хүчин чадал нь нэмэгджээ. Венецийн Бүгд Найрамдах Улс нь загалмайтны аян дайны жилүүдэд ихээхэн газар нутаг эзэмшиж эрх дархаа өргөжүүлж худалдааны нөлөөгөө нилээд тэлжээ. Венеци нь Византийн эзэнт гүрний бүрэлдэхүүнээс гарч бие даасан улс болсноор хүчирхэг эзэнт гүрэн болон манджээ.

Хотын цорын ганц талбай болох Гэгээн Маркийн талбайд гоёмсог гуу доторхи сувд эрдэнэ мэт Гэгээн Маркийн сүм оршино.

Хотын ивээгч нь анхандаа Византийн Гэгээн Фёдор байсныг IX зуунд латиний Гэгээн Маркаар сольжээ. Тэр тухай нэгэн домог байдаг:

Гэгээн Марк Аквилейд христос шашин сурталчилан дэлгэрүүлээд буцах замдаа шуурганд өртөж нэгэн арал дээр саатжээ. Нойронд нь охин тэнгэр ирж энэ нутагт амар амгалан нойрсоно гэж түүнд хэлжээ. Гэгээн Марк тэр ёсоор Александрид амьсгаа хураахад түүнийг тэнд оршуулжээ. Венецийн хоёр худалдаачин түүний шарилыг нууцаар авчрахдаа давсалсан мах авч явна гэж гаалийнхнийг залилжээ.

“Марк Та амгалан нойрс!” гэсэн үгийг хожим нь Венецийн Бүгд Найрамдах Улсын далбаа дээр бичдэг болжээ. 828 онд шинэ шүтээнээ Венеци хотод авчирч түүнд зориулан сүм барьжээ. 150 жилийн дараа түймэр гарч сүм оргүй шатахад төдөлгүй сэргээн босгож, бас нэг зуун жилийн дараа шинэ барилга барьжээ. Гэхдээ түймрийн үед гэгээнтний шарил алга болсон байжээ.

Өнөөгийн Гэгээн Маркийн сүм XI зууны үед баригджээ. Тэгээд сүмийг аравнайлж Гэгээн Маркийн шарил олдоосой гэж мөргөл хийжээ. Чухамдаа тэр үед нэгэн гайхамшигт явдал болжээ.

Дожд тэргүүлсэн жагсаал сүм сүм рүү алгуур ойртож байтал үүдний нэгэн баганаас гэрэл цацарч чулуун суурь дотроос дунд хуруундаа алтан бөгж бүхий гар гарч ирж тэр агшинд эргэн тойронд нь анхилуун үнэр ханхалжээ. Цугларан хурсан олон Гэгээн Маркийн шарил олдлоо гэж баярлаж, гэгээнтний шарилыг буцаан өглөө гэж бурханд талархлаа илэрхийлж байжээ.

Сүмийн барилгыг босгох ажил хэдэн зуун жил үргэлжилж венецичүүдийн үе бүр тодорхой хувь нэмрээ оруулж сүмийн дүр төрхийг улам сайхан болгосоор иржээ. Венецийн эзэмшлийн нутгаас хамаг үнэт зүйлсийг нь хураан авчирч сүмийг чимэглэжээ. Суут зураачдын бүтээлээр чимэглэсэн үүдний танхимаас дотогш ороход 35 килограм алт, 2500 ширхэг үнэт чулуу шигтгэж хийсэн Алтан тахил өөдөөс утана.

Гэгээн Маркийн талбайн нөгөө өнцөгт кампанилла буюу 100 метр өндөр хонх байна. Сүмийн өмнөх талбайд Венецийн Бүгд Найрамдах Улсын захиргааны эртний байшин болох Хуучин, Шинэ урт байшин байдаг. Гэгээн Маркийн талбайд Венецийн хамгийн сүрлэг байшин болох Дожийн ордон байна. Олон зуун хүний хосгүй оюун ухаан, авьяаслаг гар урчуудын уран гараар бүтсэн энэхүү уран барилгын гайхамшигт дурсгалыг хэдэн зуун жилийн хугацаанд барьж босгожээ.

Дожийн ордны яг дэргэд аймшигт домог, ярианы сэдэв болох Карчери шоронгийн байшин бий. Английн нэрт яруу найрагч Д.Г.Байрон хоригдолд ямархуу сэтгэгдэл төрж байсныг мэдрэх зорилгоор нэг шөнийг уг шоронгийн харанхуй өрөөнд өнгөрөөж байжээ.


Венеци нь битүүлэг, үлгэрийн хот мэт ажээ. Венеци нь ордон, шилтгээн сүмийн хот, төөнөсөн нар, гондол завины эздийн чихэнд чимэгтэй аялгуу, тэнгисийн долгио цалгисан сэрүүн сайхан шөнийн хот билээ. Венеци хот өдөр ч сайхан, шөнө ч сэтгэл амгалан сайхан хот юм. Чулуу бүрт нь тэнгисийн үнэр шингэсэн, байшин бүр нь түүхийн гэрч болсон гайхамшигтай сайхан хот ажгуу. Ханын зураг, уран зураг, уран баримал, шигтгэмэлээрээ аль хэдийнээ хот-музей болон дэлхийд алдаршжээ.

Хот жилд 2,5 миллиметрээр, алгуур усанд сууж байна, тухайлбал хотын төвд орших Кампо Сан-Стефаногийн баримал 13 сантиметр усанд суужээ гэсэн мэдээлэл хорьдугаар зууны жараад оны эхээр тархаж бөөн шуугиан дэгджээ. Арлуудын түвшин доошилж байгаа учир тэнгисийн давалгаа хотын амьдралд нөлөө үзүүлэх болж, тэнгисийн зүгээс хүчтэй салхи гарсны дараа Гэгээн Маркийн талбай давстай нуур болон хувирдаг болжээ. Сувгуудаар завь явах бололцоо хаагдаж байна.

Венеци хотын 200 гаруй ордон, шилтгээний тал хувийг сэргээн засварлах ёстой, нийт барилга байгууламжийн аравны нэг хэсгийг нурааж шинээр барих хэрэгтэй гэсэн тооцоог мэргэжилтнүүд гаргажээ. Хэдэн жилийн өмнө усанд шумбагч хуучныг судлаачид, тэнгисийн гүнээс дундад зууны үеийн усан онгоцны сэгүүд, эртний ромын усан боомтын хотын дүүрэг илрүүлжээ. Хамгийн чухал нь, хотыг тэнгисийн хүчит давалгаанаас хамгаалж байсан 150 метр урт, нуман хэлбэрийн чулуун хэрэм олджээ. 2100 жилийн тэртээ барьсан тэрхүү хэрмийн өндрийг нэмбэл Венеци хотыг усанд живэх аюулаас найдвартай хамгаалах бололцоо гарна гэсэн тооцоо хийжээ. Тодорхой төсөл өнөө хэр байхгүй ч “Адриатын тэнгисийн сувд эрдэн”-ийг тэнгисийн “довтолгоон”-оос хамгаалах арга олдох нь мэдээж хэрэг юм.

## ЛХАС

Дэлхийн өндөр уулсын цаана оршдог, хүрч очиход туулж давшгүй байгалийн саад байдаг зэргээс болж түвд нь гадаадынхны хувьд олон зууны турш хаалттай байв. Үүнд дундад зууны үед “ариун нутагт бузар булайг дэлгэрүүлж болзошгүй” европчуудаас айн эмээж улс орноо хаалттай байлгаж байсан нь бас нөлөөлжээ. Бүддийн шашны хойд төвд хүрсэн хятадын лам, Лхасыг зорьж алс холын замд гарсан католик шашныг сурталчилан дэлгэрүүлэгч лам, англичуудаас нууц даалгавар авч худалдаачин, аялагчдын дүрээр нэвтэрсэн энэтхэгийн тагнуулч, үл мэдэх орныг шохоорхсон аялагч-эрдэмтэн, аялагч-балмад этгээдүүдийн тоо даан ч цөөхөн байлаа.



Европ хийцийн хувцсаа лалын сүсэгтний хувцсаар сольж Түвдэд нэвтрэх гэсэн доктор Муркрофт баригдаж хоолойгоо хэрчүүлж амиа алдаж байв. 1885 онд английн армийн хурандаа Таннер баруун Түвдийн нутагт Гималайн нурууны зүгээс очих гэж зүтгээд алах заналхийллээс айж зорилгоосоо буцаж байв.

Энэтхэгийн иргэн Сарат Чандра Дас тэргүүн сайд Ванчин ламын туслалцаатайгаар 1881 онд Лхас орж эсэн мэнд буцан иржээ. Тэгтэл Түвдийн Засгийн газар жилийн дараа тэр тухай санамсаргүй мэдмэгц Ванчин ламыг олны нүдэн дээр саваагаар занчин алж түүний хамаатан садан, ойр дотнын хүмүүсийн эд хөрөнгийг хурааж бүх насаар нь шоронд хорих ял оноожээ.

Харин гагцхүү буриад иргэн Г.Цыбиковын аялал амжилттай болжээ. Тэрбээр Лхас хотод зорчих зөвшөөрөл авч түвдийн оршин суугчдын шашны зан үйл, ахуй, урлагийг судалж түвдийн анагаах ухаан, гүн ухаан, түүх, хэл зүйн сэдэвтэй 333 хуучны ном авчирч Санкт-Петербург хотын номын санд өгчээ.

Гадаадын иргэд тусгай зөвшөөрөл худалдан авч чөлөөтэй зорчдог болсон цаг саяхан билээ.

Анхандаа түвдийн эртний нийслэлд байснаа дараа нь Раса хэмээх газарт нүүн очиж шинэ нийслэл барьж эхлэсэн Соронзонгомбын ноёрхлын үед VII зууны үед Лхас хот үүссэн тухай домог байдаг.

Лхас хот нь 640 он хүртэл нутагт дэвсгэрт нь ариун луу амьдардаг нуур байжээ. Тэр жил



бүддийн шашны тэргүүн Соронзонгомбо балба гаралтай хатныхаа ятгалгаар бүддийн шашны сүм босгохоор шийдэж хатнаа дагуулан нуурын эрэг дээр очиж сүм барих тохиромжтой газар зааж өгөхийг гуйж бөгжөө усанд хаяжээ. Бөгж нуурын голд унаж тэндээс нь ариун луу харагдав. Тэгээд Соронзонгомбо ард олноо уриалан нуурын усыг чулуугаар дүүргэж Лхас хот бий болжээ.

Ариун луугийн дурсгалд зориулан Лхас хотын цац сүм дотор жижиг сүм босгож дэргэд нь нуурын усны урсгалыг хааж байгааг билэгдэж том чулуун хавтан байрлуулжээ. Жил бүрийн хоёрдугаар сард ёслол хийж хавтанг өргөж уурлаж ус тавьж Лхас хотыг живүүлэхгүй байхыг луугаас гуйж өргөл барьц өгнө.

VIII зууны сүүлч хүртэл хот Раса буюу “Хашсан газар” гэсэн нэртэй байв. Харин Лхас (“Бурхдын хот”) нэр нь Соронзонгомбын хятад, балба үндэстэн хоёр хатны авчирсан Бүдда бурхны баримлуудаас үүссэн ажээ.

Лхас хотын баруун хэсэгт өндөр уртавтар хадан дээр сүүлийн гурван зуун жилийн хугацаанд Түвдийн шашны удирдагч Далай ламын өргөө болж байгаа Потала ордон байна. Потала буюу Хоёр дахь тэжээгчийн ордон руу хүрэхэд дээд хэсгийг нь зузаан ноосон хөшгөөр хаасан, хажуугаар нь шашны эрх мэдлийн билэг тэмдэг болох барын арьсаар хийсэн хоёр том бийр унжуулсан асар том чулуун нуман хаалгаар орно. Потала ордны нэг хананд Ү далай ламын үед байсан бүх сүм дуганы байрлалыг дүрсэлсэн газрын зураг байна.

Потала ордны бүүдгэр танхимуудад нарны гэрэл хэзээ ч тусахгүй, гагцхүү лам нарын гартаа барьсан лааны гэрэлд нарийхан шатны гишгүүр, хананд дүрсэлсэн ордны харуулуудын дүрсүүд л анивчина. Улаан ордонд зузаан хананы цаана Далай лам нарын бунхнууд байна, XIII Далай ламын бунханд нэг тонн шижир алт зарцуулжээ.

Лхас болон Түвдийн хамгийн том, хамгийн ариун нандин сүм нь бүддийн шашны шүтээнүүдийг хадгалах зорилгоор Соронзонгомбын бариулсан Жукханг (“Ноёны ордон”) юм. Бако талбайд орших уг сүм орон сууцны байшингууд дотор байх учир холоос харагдахгүй. Жукханг сүмд мөргөл үйлдэхээр ирсэн хүмүүс хэдэн зуун жилийн хугацаанд сүм рүү хөтлөх чулуун хавтанг бүр хонхойлжээ. Чулуун хавтанд мөргөлчдийн толгой, гарын ор гарсан нь их сонин.

Бако талбайд сүмийн өмнө тус бүр нь 3 метр голчтой, бараг 1 метр орчим гүн гурван зэсэн тогоо байна. Шашны баяр ёслолын үед тэдгээр тогоонд цай чанаж хэдэн мянган лам нарыг дайлна. Түвдийн оршин суугчдын хамгийн их таашаадаг ундаа нь цай болохоор эрт дээр үед хятадын хаад жил бүр хэдэн тонн цайг бэлэг болгон ирүүлдэг байжээ.

Жукханг ордны баруун зүг рүү харсан (бүддийн шашны бүх сүм, дуганы хаалга өмнө харсан байдаг.) гол хаалгыг бүддийн шашны билэгдэл болох алтадмал “амьдралын хүрд”, хоёр бугын дүрсээр чимэглэсэн байна. Цогцолборын гол сүмийн дээвэр дээр Бүдда Шакьямуни, бодьсахивар Авалокитешвар, ирээдүйн Майтре бурхан, Түвдийн удирдагч Соронзонгомбын нарт зориулсан дөрвөн алтадмал жижиг сүм байна.

Жукханг сүмийн гол шүтээн нь Бүдда бурхны 16 настай байх үеийн баримал юм. Түүний

хаан ширээнд заларсан баримлыг сүмийн зүүн буланд байрлуулжээ. Баримлын өмнөх урт ширээ дээр алтан цөгцнүүдэд өдөржин шөнөжин арц хүж уугиж байна.

Сүмийн зүүн хэсэгт Соронзонгомбо түүний хятад гаралтай хатан Вэнь Чэн нарын баримал, хажуу танхимд сүмийг үндэслэгчийн баримал байна. Сүмд мөн бусад олон бурхны баримал бий. Тухайлбал эмэгтэйчүүдийг ивээгч Пэл-Лхам бурхны өмнө арвайн дарс, арвайн үр өргөж мөргөл үйлдэнэ.

Жукханг сүмд ороход цоо шинэ ертөнцөд орсон мэт сэтгэгдэл төрнө. Энд мөргөлчдийн цуваа үл тасрах хийгээд Түвдийн бүх хүн ам цугларсан мэт санагдана. Мөргөлчид эрх эргүүлж мөргөлийн хүрд тойрно. Эрэгтэй, эмэгтэй, хөгшин залуу бүх хүн чулуун хавтан дээр доош харан сунаан хэвтэж мөргөнө.

Лхас хот нь сүм хийдийн орон ажээ. Гэхдээ түвдүүд хэдэн зуун жилийн туршид огт мэддэггүй байсан байшин барилга бас байна. Ардын банкны байшин, түүний цаана Улсын худалдааны компанийн ордон байна.

Өнөөдөр Түвд тодруулбал түүний Лхас, Шиганзе хоёр хотод жуулчид чөлөөтэй зорчиж байна. Тиймд бүтээн байгуулалтын ажил эрчтэй өргөж байна. Гудамж, талбай хүн ихтэй болж заримдаа худалдагч, худалдан авагчийн аль олон болох нь мэдэгдэхгүй дорнын захыг санагдуулна. Байшин бүрийн нэгдүгээр давхарт мухлаг, хоёрдугаар давхарт нь гэрийн эзэд сууна. Дулааны улиралд мухлагийн эзэд гадаа үүдэндээ цагаан даавуугаар саравч юм уу шүхэр татаж бараагаа зарна.

Лхас хотын гудамж, талбайн нэрүүд нь худалдаа наймаатай холбоотой. Төв талбай Бако буюу “Худалдааны”, хоёр дахь том гудамж нь “Вайдуйсика” буюу “Арилжааны” гэнэ. Энд оёдлын машины зүүнээс авхуулаад морины эмээл, сэрүүлэгтэй цаг, хивс гээд түвдийн өнцөг булан бүрээс болон жинчдийн алс холоос тээж авчирсан элдэв зүйл борлуулна. Жуулчдад зориулан янз бүрийн өнгийн алчуур, хүрэл хонх, цом, бурхдын баримал, эртний зоос, мөргөлийн хүрд, арц хүж зарж байгаа хүмүүс эд зүйлсээ зам дагуу газар дээр эгнүүлэн тавьжээ.

Хорьдугаар зууны ерээд оны үед Лхас хотын гудамжаар явахад нүүрэндээ шавар шавхай түрхсэн бүсгүйчүүд тааралддаг байлаа. Хэдэн зуун жилийн тэртээ залуу гэлтгүй лам нарыг хорвоогийн шохоорхлоос холдуулахын тулд залуу бүсгүйчүүдийг нүүрээ шавар шавхай түрхэж гадуур явж байхыг үүрэг болгосон зарлиг гарсан байжээ.

Сүүлийн арваад жилүүдэд түвдийн анагаах ухаан дэлхий даяар их түгэж байна. Түвдийн анагаах ухаан, зурхайн Мынцзикан сургууль дотор ороход он цагийн уртад шарласан зургуудыг хана дагуу битүү өлгөсөн байна. Зургуудад хүний биеийн бүтэц, зарим зурагт нь янз бүрийн өвчин үүсэх шалтгааныг, гурав дахь хэсэгт нь зүү хатгуур хийх, цус ханах цэгүүдийг харуулсан байна.

Ү Далай ламын үед Гал, Лууны жил байгуулсан Мынцзикан сургуульд түвдийн өнцөг булан бүрээс сонгож ирүүлсэн авьяаслаг залуус 12-15 жил суралцан анагаах ухаан судалж өвчин анагаах дадлага хийнэ. Төмөр, мод, ус, гал, газар гэсэн анхдагч таван бодисоос бүх амьд амьтан түүний дотор хүн бүтдэг гэсэн сургаал түвдийн анагаах ухааны үндэс болно. Таван

анхдагч бодисийн зохицолдоо хүний биед алдагдсанаас өвчин үүснэ, ямар бодис хүний биед илүүдэж, дутагдаж байгааг эмч илрүүлж өвчнийг илааршуулах ёстой гэж үзнэ.

Мынцкикан сургуулийн эмийн санд түвдийн амьтны болон ургамлын аймаг, үнэт чулуу, эрдэс баялагийн үнэхээр атаархам цуглуулга байна. Түвдийн анагаах ухаанд 8 үндсэн төрөлд хуваагдах 6 мянган нэрийн эм бий. Эхний төрөлд чулуугаар бэлтгэсэн 64 нэрийн эм багтана, дараа нь хөрс, өвс, цэцэг, модны үндсээр хийсэн эмүүд цуварна.

Мынцзикан сургуулийн сурагчид 9 жил анагаах ухааны Дюши сургаал үзнэ. Түвдийн эмч нар халууны шил, рентген төхөөрөмж гээд ямар ч тоног хэрэгсэл байхгүй. Эл сургуулийг төгсөгч хүний судасны цохилт, нүүр царай, нүд, хэлний өнгөөр дөрвөн зуу орчим өвчнийг, туршлагатай эмч нэг мянга хүртэлх өвчнийг илрүүлэн таньж мэднэ. Олон зуун жилийн туршлагаар эмч хүн хүний биеийн 26 цэгт судас дарж өвчтөний байдлыг мэдэж болдгийг тогтоожээ. Хүний судсыг голдуу үүр цайх үед хагас цаг барина. Эмч судасны цохилтыг өөрийн амьсгаагаар хэмжинэ, нэг удаа амьсгаа авахад судас таван удаа цохилж байвал хүн эрүүл байна гэж үзнэ.

## ЛИССАБОН

Португал улсын нийслэлтэй танилцахад аль хэсгээс нь эхэлж байгаагаас төрөх сэтгэгдэл өөр өөр байна. Усан онгоцоор ирж байгаа хүн дундад зууны ертөнцөд орох шиг болно. Усан онгоцны тавцан дээрээс эрэг дагуух бяцхан тохилог хотхон, сувиллын тосгон, эгц дов толгод, улаан вааран дээвэр, өргөн Тежу гол дээгүүр тавьсан болдон гүүр харц булаана.



Хурдан галт тэрэг юм уу хөнгөн тэрэгний цонхоор голын эрэгт тулган барьсан олон цайз харагдаж байгаагаас уран барилгын хувьд хамгийн гоёмсог, хамгийн алдартай нь Белений цамхаг юм. Белен гэдэг нь Вифлеемийн португал нэр ажээ. Чухамдаа ХV-XVI зууны зааг дээр энэ цайзанд хүчирхэг Португалын эзэнт гүрэн бий болжээ.

ХV зууны газар зүйн аугаа нээлтүүд нь Лиссабон хотыг шинэ түүхэн заагт гаргажээ. 1497 оны долоодугаар сарын эхээр Белен тосгонд голын эрэг дээр зангуугаа хаясан дөрвөн усан онгоцыг алс замд үдэхээр тосгоны бүх оршин суугч цугларсан байлаа. Тэрхүү аялал нь португалын зоригт далайчдын Энэтхэгийн эрэг хүрэх далайн замыг нээх эхлэл болж Лиссабоныг европийн тэргүүлэх хотуудын тоонд багтаасан юм.

Нэгдүгээр Мануэль хааны зарлигаар анх Гэгээн Висентийн цайз гэж нэрлэгдэж байсан Беленийн цамхаг нь XVI зууны хамгийн гоёмсог дурсгалуудын нэг билээ. Цамхагийг анх арал дээр барьсан ч он цагийн уртад Тежу гол голдрилоо сольсноор эрэг дээр гарчээ. Цамхагийг цайзын зориулалтаар биш, төрийн гэмт хэрэгтнүүдийг хориход ашиглаж байжээ.

Цамхагаас холгүйхэн иеронимитүүдын Жеронимуш сүм байрлаж байсан хийгээд Рештелу усан боомтоос португалын далайчид алс холын аялалд морддог байжээ. Сүмийн буурин дээр анх португалын ханхүү, Далайчин гэж алдаршсан Энрикод зориулан босгосон бяцхан сүм байжээ. Ханхүү далайн аялалд ганц ч удаа оролцож байгаагүй хэдий ч Сагреш хотод Тэнгисийн сургууль байгуулж европ тивийн орнуудаас шилдэг далайчдыг урьж хичээл заалгаж олон зоригт далайчин сургасан гавьяатай ажээ. Чухамдаа алдарт далайчин Васко да Гама Энэтхэг рүү хийх гайхамшигт аялалынхаа өмнө энэ сүмд ирж мөргөл үйлдэж байсан хийгээд хоёр жилийн дараа Мануэль хаан түүнийг алдарт аялалаасаа буцан ирэхэд нь энд мөн ёслол төгөлдөр угтан авч байжээ.

Нэгдүгээр Мануэль хааны үе нь тус орны хөгжил цэцэглэлтийн оргил үе байв. Цаг үеийнх нь хүмүүсийн бичиж үлдээснээр үр тарианы баялаг ургац авч байжээ. Лиссабон хот тансаг байдлаараа бусад бүх нийслэл хотыг давж байжээ. Үнэт эдлэл, торго, жимс ногоо, хар боолчууд тээвэрлэсэн хоёр мянга орчим усан онгоц жил бүр Тежу голын эргийн усанд зангуугаа хаядаг байв.

Португалийн хаад хуримтлуулж байгаа асар их баялгаа ордон шилтгээн, сүм дуган барихад гар татахгүй зарцуулж байжээ. Тухайлбал Мануэль хаан Иеронимитүүдийн сүм барих зөвшөөрлийг Ромын хамба ламаас 1496 онд авч сүм босгох ажил бараг хоёр зуу шахам жил үргэлжилсэн учир уран барилгач бүр ур ухаанаа шингээж уг сүмийн барилгад уран барилгын олон дэг тусгалаа олжээ.

Сүмийн Ялалтын танхим нь бунхан хийгээд түүнд португалийн хаад тэдний хатад, ханхүү, гүнж нарын шарил мөнхөд нойрсож байна. Энд мөн алдарт аялагч Васко да Гама, суут яруу найрагч Луис де Камозансийн бунхан бий. Сүм дотор 1578 онд Марокко улс руу аян дайнд мордож 18 мянган цэргээс нь 60 цэрэг л амьд гарсан Себаштиан хааны хөшөө бий. Себаштиан хаан элсэн цөлд ор сураггүй алга болсон ч португалийн ард түмэн түүнийг эргэж ирнэ гэж одоо ч итгэсээр байдаг ажээ.

Португалийн ард түмэн туулж ирсэн түүхээрээ бахархдаг хийгээд Лиссабон хотод алхам тутамд тус орон хүчирхэг гүрэн байх үеийн дурсгал тааралдана. Тус хотын гудамжны нэрүүдээр газар зүйн их нээлтийн үе шатыг мэдэж болно.

Беленийн цамхагийн ойролцоо боржингоор урласан Анхдагч нарт зориулсан том баганат хөшөө сүндэрлэн байна. Усан онгоцны өндөр, нарийхан чулуун далбааны дэлгэц дээр тодрон байх шатаар рыцарь эрчүүд, усан онгоцны ахмадууд, эрдэмтэд, лам нар дээш өгсөж, жижиг завины загвар гартаа барьж алс тэнгисийн гүн рүү зааж байгаа Далайчин Энрико зогсож байгаа усан онгоцны хошуу руу чиглэн алхаж байна.

Хөшөөний дэргэд жуулчид ирж, Васко да Гама Энэтхэг орох замыг олохоор алсын аянд мордсон газрыг гэрэл зургийн хальсанд буулгана. Хөшөөний өмнө, хотын гол талбай болох “Праса-ду-Комерсия” талбай дээр португальчуудын хийсэн газар зүйн нээлтүүдийг харуулсан дэлхийн газрын зургийн шигтгэмэл байна. Голын нөгөө эрэг дээрээс сүсэгтэн олны хандиваар 1962 онд босгосон Христос бурхны том цагаан хөшөө хотыг тольдоно.

Урьд нь хамба лам эзэмшиж байсан Митра ордонд байгуулсан Хотын музейд XVI зуунаас өнөө үе хүртэлх Лиссабоны түүхийг харуулсан үзмэрүүдтэй танилцаж болно. Тус хотод сүйх тэрэгний өвөрмөц музей бий. Уг музейд сүйх тэрэгний хөгжлийн бүхий л түүхийг харуулсан баялаг цуглуулга байдгаас XVII зууны үеийн дотор талыг нь хилэн, торгоор доторлосон таван гоё сүйх тэрэг бусдаас онцгойрно.

XVI зуунд Лиссабон хотын төв нь тоймгүй олон нарийхан гудамж, догол гудамжнаас бүрдэж байв. Тухайлбал “Оуривесариа да Прата” (“Мөнгөний дархчуудын гудамж”) гудамж нь ачаатай морь багтахааргүй давчуу байжээ.

XVII зуунд хотын хүн амын тоо 70 мянгад хүрсэн ч нийтийн тээвэр байгаагүй учир язгууртан

хүмүүс хоёр зарц өргөж гурав дахь нь сууж буухад нь тусалж зам гаргадаг нэг зарц бүхий жуузаар зорчдог байв. Язгууртан эмэгтэй суусан жуузыг хар өнгийн дүрэмт хувцас өмссөн гурван морьтон дагалддаг байв.

XVII зууны сүүлчээр хоёрдугаар Педру хааны зарлигаар “дэлхийн бусад хотын иргэд шиг шөнийн цагаар тохь тухтай, аюул осол багатайгаар явах”-ад зориулж Лиссабон хотод гэрэлтүүлэг тавьжээ.

Хотын нарийхан давчуу гудамжуудтай ч гэсэн XVIII зууны дунд үед европийн гоё сайхан хотуудын нэг гэж зүй ёсоор тооцогдож байв. Хотын католик шашинтин оршин суугчид чинээлэг аж төрж шашны бүх баяр ёслолыг өргөн дэлгэр хийнэ. Хааны ордон, Дуурийн театр хотын хамгийн сайхан барилга гэж алдаршиж байв.

1755 оны 11 дүгээр сарын 1-ний өглөө лиссабончууд католик шашны жил бүрийн уламжлалт Бүх гэгээнтний баярыг тэмдэглэхээр гудамжинд гарч жагсаал хийхээр зэхэж байлаа. Тэгтэл гэнэт газар хөдөлж хотыг тугалган саарал үүл нөмөрчээ. Газар хөдлөлтийн гурван удаагийн цохилтоор хотын 20 мянга орчим байшингийн 17 мянга орчим нь нурж эвдэрчээ. Хотын төвд Хааны ордон, Дуурийн театрын байшингийн зарим хэсэг нь нурсангүй үлдэж, бүх зүйл үнсэнд дарагджээ. Олон хүн гэр орондоо амьдаар шатаж голоор гэр орны эд зүйлс, үхсэн хүн, малын шарил хөвж байжээ.

Лиссабон хот сэргэн мандсан ч хотын уран барилгын дүр төрхөнд тэрхүү тэрхүү аймшигт явдлын ул мөр мэдрэгдсээр байдаг юм.

## АНТВЕРПЕН

Хоёр зуу гаруй жилийн түүхтэй, Бельги улсын эртний Антверпен хотын тухай VII зууны үеэс мэдээлэл бий. Олон зууны туршид норманнчууд, германы хаад эзлэн түрэмгийлж байсан ч Фландри улс алдарт хот, усан боомтоо тухай бүр эгүүлэн авч чадаж байлаа. Европийн худалдаачид усан онгоц хөлөглөн Энэтхэг, Шинэ Тив хүрдэг болсон XVI-XVII зуунаас Антверпен дэлхийн худалдааны төв гэсэн алдрыг зүй ёсоор хүртжээ.



Нам дор газар орших учир намаг балчиг ихтэй Шельда голын эрэг дээр босгосон анхны хэрэм болох Замок (фламанд хэлээр “хэрэм” гэсэн утгатай үг) нэртэй хэрмээс энэ хот үүсэлтэй ажээ. Норманнчууд Замок хэрмийг барьж эхэлсэн ч түүнийг бүр хожуу X зуунд барьж дуусгажээ.

Өндөр зузаан ханатай хэрмийг загалмайтны анхдугаар аялалын удирдагч Гофтрид Буйонский эзэгнэж байв. Дараа нь хотын захиргааны байр болсныг испанчууд эзэлж залхаан цээрлүүлэх шүүх байрлуулжээ. Гадаадын эзлэн түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн хүн бүрийг, чөлөөтэй сэтгэдэг хэн бүхнийг энэ хэрэмд авчирч удтал тамалсны эцэст цаазалдаг байв. Одоо хэрэм дотор Далайн музей байрлана.

Антверпен хотын бусад эртний барилга байгууламж нь түүхийн урт удаан хугацааны туршид анхны дүр төрхөө алдаж янз бүрийн цаг үеийн уран барилгын дэгийн тусгал болжээ. Гэхдээ аугаа Рубенсийн зуун гэж алдаршсан XVI зуунд тус хотын уран барилгын өвөрмөц дүр төрх бий болжээ. “Рубенсийн эх нутаг” гэж ярьдаг тус хотын төвд орших Ногоон талбайд суут зураачийн хүрэл хөшөө сүндэрлэн байна. Хэлхгэр ханцуйгүй цамц, өргөн өмд, гутал өмссөн фламандын нэрт зураачийн хөл дор будаг бүхий зургийн тавиур байдаг.

Хотын эзэн гэж бахархдаг Рубенсийн хөшөө зочид гийчид, жуулчдыг угтан авч үдэж гаргана. Дээр үед зуны дулаан үдэш лхагва, бямба гариг бүр их зураачийн дурсгалд зориулан концерт тоглодог уламжлал байв. Хотын иргэд суут зураачийн амьдарч байсан, италийн сэргэн мандалтын дэгээр барьсан жижиг байшинг хайрлан хамгаалдаг. Одоо тэр байшинд суут зураачийн урланг анхны байдлаар нь сэргээн засжээ.

Тус хотыг ивээгч гэж үздэг Гэгээн Марияд зориулсан Эх Дагинын сүмийг XVI зуунд гот дэгээр барьжээ. Антверпен хотын гол шүтээн болох Эх Дагинын баримал байсан бяцхан

сүмийн буурин дээр уг сүмийн барилгыг барих ажлыг уран гартан Жан Амель гэдэг хүн 1352 онд эхлүүлж хүү Петер нь гүйцээжээ.

Сэтгэл хөдөлгөсөн дуу гаргадаг дөчин хонх бүхий сүмийн цамхаг алсаас харагдана. Уг сүм дотор шилдэг хөгжимчдийг урьж байнга баяр ёслол хийдэг уламжлал бүр XVI зуунаас эхтэй ажээ. Уг сүмд Рубенсийн маш олон уран зураг байгаагаас хамгийн алдартай нь “Цовдлогдсон Есус Христосыг хэрээснээс буулгасан нь” зураг билээ.

Хотын захиргааны байрны өмнөх чулуун талбай дахь алдарт усан оргилуур нь тус хот үүсэн байгуулагдсан явдалд зориулсан олон түүхэн дурсгалт байгууламжийн нэг юм. Уламжлал ёсоор уран барилгач К.Массейсийн төслөөр барьсан гэдэг Усан оргилуурын зохиомж нь лусын охид дэргэд нь байгаа ялагдсан асар том амьтны тасалсан гарыг гартаа барьсан залууг уснаас өргөн гаргаж байна. Сараалжин хашаа дотор хотын эх суурийг тавьсан гэж үздэг домогт баатар Брабогийн баримал бий.

Эрт дээр үед өнөөгийн Антверпен хотын буурин дээр ойр орчмын оршин суугчид болон Шальд голоор хөвж байгаа далайчдаас өндөр татвар авдаг Друон Антигон хэмээх асар том биетэй, шуналтай амьтны ордон байжээ. Гэвч нэгэн удаа Сальвий Брабо хэмээх зоригт залуу аймшигт амьтантай халз тулалдаж түүний гарыг тасалж гол руу хаяжээ. Тэр үеэс тус хот “Hand werpen” буюу “Гар тасалж хаях” гэсэн нэр авчээ.

Антверпен хот аль дээр үеийнх болохыг олон тооны эртний гудамж, талбай нь гэрчилнэ. Хотын захиргааны талбайн эргэн тойронд дундад зууны үеийн нуман цонх, хаалга, нарийнхан өндөр багануудтай, хавчгар ч 5-6 давхрын хэртэй өндөр байшингууд эгнэн байна. Тус хотод орчин үеийн шил толь болсон дэлгүүрүүд, зоогийн газруудтай зэрэгцэн үнэт эдлэл, хиам, махны худалдаачны жижигхэн мухлагууд байдаг. Махны наймаачдын гудамжинд Г.ван Вагемакерийн төслөөр барьсан Мал нядалгааны газар бий. Мал нядалж өвчдөг чулуун шалтай, өндөрт гаргасан цонх бүхий доод давхрын хөндий уужим том танхимаас гадна дээд давхруудад нь ажил хэргийн уулзалт яриа, баяр ёслол зохиодог танхим, өрөөнүүд байжээ. Одоо энэ байшинд Түүх, хуучны судлал, хавсарга урлагийн музей байрладаг хийгээд уг музей бууны цуглуулгаараа их алдартай юм.

Эртний Антверпен хот эзлэн байгаа талбайны хувьд бага агаад Шельда голын баруун эрэг дээр л багтаж байв. Хотыг хүрээлж байсан хэрмийн буурин дээр өнөөдөр Италийн, Францийн, Английн, Америкийн гэсэн нэртэй гоёмсог сайхан цэцэрлэг гудамжууд сунжирч Меирийн талбайгаар дайрч голд тулна.

Меирийн талбайд уламжлал ёсоор “Хааны өргөө” гэж нэрлэдэг ХҮ Людовик хааны үеийн дэгээр барьсан энгийн мөртөө хээнцэр байшин оршино. Хотын язгууртан оршин суугч Ян Сустерний захиалгаар уран барилгач Баурсшейдтийн төслөөр 1745 онд зочид буудлын зориулалтаар барьсан энэ хоёр давхар байшин нь эл талбайн гол чимэг болж байдаг юм. Английн Викториа хатан хаан, Францийн Наполеон Бонапарт хаан, Мария Луиза хатан хаан нар энэ зочид буудалд бууж байснаар хотын оршин суугчид ихээхэн бахархдаг билээ.

Орчин үеийн Антверпен хот нь олон давхар байшингууд, тэдгээрийн хажуугаар зурайх өргөн цэцэрлэгт гудамжууд юм. Хотыг хоёр хэсэгт хуваадаг Шельда гол дээгүүр ганц ч гүүр



байдаггүй нь нь тус хотод анх ирсэн гадаадын зочдын гайХШийг төрүүлнэ. Голоор усан онгоц хөвөхөд саад болгохгүй гэж голын доогуур хотын хоёр хэсгийг холбосон олон арван хоолойгоор хөнгөн тэргүүд тасралтгүй зөрөлдөн хөврөдөг юм.

## ДЕЛИ

Дели хот шиг баялаг түүхтэй нийслэл дэлхийд бараг үгүй биз ээ. Манай эринээс бүр өмнө байгуулагдсан тус хот нь Тарын элсэн цөл болон Гималайн өндөр уулсын хоорондох нарийхан хонгил болох Хайберийн давааг давж Энэтхэг улсын үржил шимтэй нутагт халдан довтлогч нарын замд ямагт саад болсоор иржээ. Эзлэн түрэмгийлэгчид долоон удаа газартай тэгшлэхэд Дели хот долоон удаа сэргэн босчээ.



Эрэлхэг зоригт “Махабхарат” хаадын угсааны ах дүү таван Пандав манай эриний өмнөх XIII-XII зуунд Жамна мөрний эрэг дээр гайхамшигт Индрапрастха хотыг үүсгэн байгуулсан гэж энэтхэгчүүд итгэдэг. Туульсын таван эрэлхэг баатрын эхэд зориулж дундад зууны үеийн Пуран-кил цайзын нутаг дэвсгэр дээр барьсан “Кунта хатан хааны сүм” гэж цууд гарсан нэгэн жижиг сүм бий. Гурван баатар хөвгүүн өсгөн бойжуулсан алдарт эхийн дурсгалын хүндэтгэхээр Энэтхэгийн өнцөг булан бүрээс мөргөлчид цувсаар хэдэн зуун жил болж байна.

Гуптын эзэнт гүрний (IV-XI зуун) үед Индрапрастха муж тус гүрний бүрэлдэхүүнд багтаж байв. Тэр үеэс V зуунд тус хотод байгуулсан 6 метр өндөр, 40 сантиметрт голчтой Төмөр багана гадаадад нэрд гарчээ. Тэрхүү баганыг хольцгүй цэвэр төмрөөр хийсэн учир он цагийн уртад ямар ч зэврэлт гарсангүй өнөөг хүрчээ.

Дели хотын захад буй зуун метр өндөр Кутб-Минар сүмийн дээрээс харахад Төмөр багана шүдэнзний хайрцаг шиг өчүүхэн жижиг үзэгдэнэ. Төмөр баганын ханад дараах үгсийг сийлсэн байдаг:

Есөн зуун жилийн тэртээ Дели хотыг мэргэн Ананг Пал хаан захирч байх үед гар урлал, урлаг цэцэглэн хөгжиж байв. Цул төмрөөр багана цутгаж газарт булсан могойны толгой дээр босгохыг хаан тушаажээ.

Бүх зүйлийг хааны тушааснаар хийжээ. Нилээд хэдэн жилийн дараа түүний удмын нэгэн хаан могойны тухай домогт итгэсэнгүй, баганыг хөдөлгөж газар дор могой булсан эсэхийг шалгахыг хүчээ. Хаан үл итгэснээс болж Ананг Пал хааны удам унаж тасарчээ.

Эрдэмтэд хананд сийлсэн үгсийг судалж Төмөр багана 1500 гаруй жилийн настайг тогтоож

Ананг Пал хаан баганыг бариулаагүй, зүгээр нь нүүлгэн авчирч байрлуулсныг мөн нотолжээ.

VI зуунаас VII зууны эх хүртэл худалдааны том төв, индуизмын шашны эртний нийслэл болох Индрапрастха хот Пушпабхут мужийн бүрэлдэхүүнд багтаж байсан ч нийслэл нь биш байв. Томар угсааны ражпутын вангууд улс төрийн байр сууриа бэхжүүлж Жамна хотын эрэг дээр хаант улс байгуулж Индрапрастха хотын буурин дээр өөр хот байгуулж “Дхиллика” гэж нэрлэсэн нь он цагийн уртад эхлээд Дхилли дараа нь Дехли буюу Дели гэсэн үг болон хувирчээ. Ийнхүү Энэтхэгийн нийслэлийн нэр 736 онд бий болжээ.

Ражпутын вангууд эзэмшил ванлигууддаа индуизмын шашны сүм хийд байгуулж гоёмсог багана, баримал болон эртний домгийн сэдэвтэй товгор дүрсээр чимэглэж байлаа. Өнөөгийн Дели хотын өмнөд хэсэгт тэр үеэс үлдэж хоцорсон гуч орчим сүмийн сийлбэрээр чимэглэсэн 480 чулуун багана бүхий цогцолбор бий. Энд мөн, хүмүүс ирж ёслолын угаалга хийж наранд мөргөдөг байсан Суражкунд нуур буюу “Нарны цөөрмийн” үлдсэн хэсэг байна.

Афганы удирдагч Мухаммед Гури ражпутын вангуудыг байлдан дийлж Дели хотын хувь заяанд эргэлт хийжээ. Тэрбээр тус хотыг лалын шашинтан удирддаг энэтхэгийн анхны улс болох Делийн султанатын нийслэл болгон зарлажээ. Хотын амбан захирагч байсан цэргийн жанжин Кутб-уд-дин нэрээ мөнхжүүлэх зорилгоор сиймхийтэй сийлбэрүүд нь үл тайлагдах бичиг үсгийг санагдуулсан Кутб-Минар нэртэй сүрлэг сүм байгуулсан нь тус хотын чимэг болсоор байна.

Шинэ улсад лалын шашныг албан ёсны шашнаар өргөмжилснөөр хотын дүр төрх өөрчлөгдөж бөмбөгөр оройтой лалын шашны олон сүм хийд сүндэрлэн босож тэрчилэн ордон шилтгээн, музей байгуулж тэдгээрийг чулуун сараалж, тэгш хэмтэй хээ угалз, араб үсгийн чамин сонин сүлжээсээр чимэглэж байв. Делийн султанатын захирагчид хөрш орнууд руу уулгалан довтолж их олз омогтой буцан ирдэг байлаа. Тухайлбал захирагч Гияс-уд-дин цэргүүдийнхээ олзолсон алтан эдлэлийг хайлуулж Суражкунд нуурын усанд живүүлж байв.

Делийн хотын бас нэгэн чимэг болох том саарал гулдан хаалга олон зууны туршид ихийг үзжээ. XIV зууны сүүлчээр Доголон Төмөр хааны цэргүүд хотыг эзэлж оршин суугчдыг нь хядаж толгойгоор нь пирамид босгож байлаа.

Хаан суудалд ээлжлэн суух лалын шашинтан захирагчид халдан довтлогчдын дайралтаас хамгаалахын тулд хотыг тойруулан зузаан бат бэх хэрэм байгуулж байснаас хорин метр өндөртэй Пурана-кила хэрэм илүү цуутай билээ. Хотын дийлэнх оршин суугч лалын шашин шүтэх болж шариатын хуулийг баримтлах болсноор тэдний аж төрөх ёс өөрчлөгджээ.

1526 онд Энэтхэгийн хойд хэсэгт байгуулагдсан Их Моголын улсын Бабур, Хумаюн, Акбар, Жахангир, Шах-Жахан зэрэг ухаантай улс төрч, цэргийн жанжин захирагчид энэтхэгийн соёлын түүх, ард түмний санаанд урлаг, шинжлэх ухааныг ивээн тэтгэгчид болон мөнхөрсөн юм.

Акбар хаан түүний хүү Жахангирын үед Дели хот өргөжин тэлж байсан ч хөдөөгийн хот хэвээр байлаа. Ягаан дагдаршмал элсээр Хумаюна бунхан барьсан нь цэцэрлэгт хүрээлэнтэй нийлээд нэгэн цогцолбор болжээ. Хүнийг шашин шүтлэгээр л ялгаварлан гадуурхдаггүй

байсан Акбар хаан зураач, хөгжимчин, яруу найрагч, уран барилгачдыг урьж ирүүлж сүм хийд олноор бариулжээ.

Шах-Жахан хаан 1638 онд өргөөгөө Агра хотоос шилжүүлэн ирүүлснээр Дели дахин нийслэл болжээ. Тус хотын түүхэн дурсгалт байгууламжуудаас зөнч Мухаммед гараараа бичсэн Коран судар, түүний эрүүний сахлын үс, гантиг дээр гарсан түүний тавхайны мөр, сарнай цэцгийн дэлбээгээр чимсэн сэрүүн шаахай зэрэг ховор нандин эд зүйлс хадгалагдаж байгаа Жам Масжид сүм онцгой байр суурь эзэлнэ.

1739 онд Персийн Надир-шах хааны цэрэг хув, маргад эрдэнэ, бадмаараг, индраанил, очир эрдэнээр гангарч тансаг баян байдлаараа хол, ойрын орнуудад гайхагдаж байсан Дели хотыг хуу тонон дээрэмдэж үнсэн товрог болгожээ. Гэвч хот цаг хугацааны уртад сэргэн босчээ.

Дели нь дорно зүгийн аливаа хотын адил хоёр хэсэгт хуваагдах агаад Их Моголын үед бий болсон хуучин хэсэг, англичууд 1911 онд эх суурийг нь тавьсан шинэ хэсгээс бүрдэнэ. Тасралтгүй үргэлжлэх дайны хөлд энэтхэгийн олон хот, тосгон сүйрч худалдаа арилжаа хумигдаж гар урлаг түүний дотор алтаар эд зүйлс хийх урлал үгүй болж, торго, нэхмэлийн үйлдвэрлэл зогсонги байсалд орсон хэцүү үед тус орныг эзэгнэсэн англичууд хуучин Делийн дэргэдэх шинэ хэсэгт хот байгуулалтыг асар өргөн хэмжээгээр өрнүүлжээ. Гэвч Их Британийн колонийн эзэнт гүрний хүчирхэг хүчин чадал, тогтвортой байдлын билэг тэмдэг болох ёстой гэж үзэж байсан Нью-Дели хотыг сүндэрлүүлэн босгосноос 16 жилийн дараа тус орныг орхин явсан билээ.

Шинэ хотын ногоон цэцэрлэгт хүрээлэн, өргөн, талбай, гудамжны дунд английн язгууртнууд, энэтхэгийн төрийн томоохон зүтгэлтнүүд амьдран суухад зориулсан гоёмсог шилтгээн, ордон умбан байна. Нью-Дели хотод энэтхэгийн хөлгүй баян Бирлийн хөрөнгөөр 1938 онд босгосон асар том Лакшми Нарайе сүмийн цогцолбор бий.

Дели хотын Ражхад хэмээх том цэцэрлэгт хүрээлэнд Махатма Ганди, Жавхарал Неру зэрэг энэтхэгийн ард түмний бахархал болох гарамгай зүтгэлтнүүдийг оршуулсан байдаг. Энэтхэгчүүд өглөө эрт уг цэцэрлэгт хүрээлэн дотор гүйж биеийн тамирын дасгал хийдэг нь их сонин. Махатма Гандийн шарил өвс битүү ургасан тэгш өнцөгт шороон далангаар хүрээлүүлсэн том зүлгийн голд байна. Энэтхэгчүүд эртний заншил ёсоор шороон даланд гаргасан ганц хаалгаар орж чулуун хавтан суулгасан нарийханхан зөрөг замаар явж мөнхийн гал асаастай хар гантиган өндөр бунханд очиж хүндэтгэл үзүүлнэ. Алан хядагч үхлүүт шархдуулахад Махатма Гандийн хэлж амжсан “Рам” хэмээх таалал төгсөж байгааг илэрхийлсэн ганц үгийг хар гантиган дээр сийлсэн байна.

Английн цэргийн ерөнхий командлагчийн өргөө байсан байшинг хүний дурсгалыг дурсан санах хамгийн шилдэг арга нь түүний баримталж байсан үзэл санааг ухааран ойлгож түүнийг нь амьдрал хэрэгжүүлэх явдал гэж үздэг байсан Жавхарал Неругийн дурсгалын цогцолбор болгожээ.

## СТОКГОЛЬМ

Швед улсын нийслэл айлчлан ирж байгаа зочид гийчдийг сүм хийд, ордон шилтгээний ногоон-улаавтар урт орой, орчин үеийн шил толь болсон өндөр байшингуудаараа угтана. Стокгольм хот арал болон хагас арлууд дээр байрласан болохоор хаашаа ч алхсан тэнгист хүрнэ. Хаана л бол тэнгисийн эрэг, тоймгүй олон суваг байдаг учир “Умард Венеци” хот ч гэж бас нэрлэнэ. Хуучин хотод сүмийн суман хэлбэртэй хонх, ордон шилтгээний нүүрэн тал усны мандалд тусаж, хойд болон өмнө зүг чиглэсэн олон урт гүүрийн хажууд эрэг дээр загасчид бүтэн өдрийг өнгөрөөнө.



Хотын оршин суугчид гол шүтээн нь болох Тэнгисийг бүхнээс илүү бишрэн дээдэлнэ. Тэнгистэй холбоотой нэртэй зоогийн газар, цэнгээний клуб, дэлгүүр, бэлэг дурсгалын зүйлсийг тоочоод баршгүй. Скепсбрун хороололд тэнгисийн эрэг дээр нэрт уран барималч А.Миллерийн урласан туяхан биетэй лусын дагиныг шүүрэн тэвэрч байгаа хүн төрхтэй тэнгисийн аймшигт амьтны дүрс бүхий гантиган хөшөө бий.

Олон арал, хагас арал, булан тохой Стокгольм хотын өвөрмөц нүүр төрхийг тодорхойлно. Хоолой, суваг, голын салаа нийслэлийн хотын нутаг дэвсгэрийг хувааж арал бүр дээр төв гудамж, юм уу талбай тэрчилэн тухайн арлын уран барилгын нүүр царайг тодорхойлох хөшөө дурсгал байдаг.

Шведийн нийслэлийн хамгийн гоёмсог байшин нь өмнөх талбайд нь зэвсэг барьсан идэр залуу цэргийн эрс хоёр жилд нэг удаа жавхаалаг жагсаал хийдэг Хааны ордон ажээ. Ордны хажууд дээр үед шведийн хаад ард түмэндээ тангарах өргөх ёслол хийдэг байсан Гэгээн Николай сүм болох Стурчюрк оршино. 1270 онд барьсан франкын жижигхэн сүмээс үүсэлтэй, хотын эртний чулуун байшингуудын нэг болох энэ сүмд XIII зуунаас шведийн хаад тэдний хатдыг оршуулдаг байв. Одоо энэ сүмийг уран барилгын ховор нандин дурсгалын хувьд арчлан хамгаалдаг бөгөөд шашны ёслол хийхийг хоригложээ.

Стурчюрк сүмийн хамгийн гол үнэт зүйл нь уран гартан Б.Нотке гэдэг хүний 1489 онд урласан Гэгээн Георгийн бүлэг уран баримал юм. Лууг бяц гишгэн дарж устгаж байгаа морь унасан Гэгээн Георгий болон өвдөг сөхрөн сууж байгаа гүнж гэсэн хоёр хэсгээс бүрдэх бүлэг баримлыг хааны үүрэг гүйцэтгэгч байсан ах Стен Стуре 1479 онд даничуудыг дийлсэн ялалтад зориулан захиалан хийлгэсэн байжээ. Захиалагч нь тусдаа тавцан дээр байрлуулсан гүнж-Швед орныг өмгөөлөн хамгаалж байгаа рыцарь эр Гэгээн Георгийтэй өөрийгөө

адилтган үзсэн ажээ. Шведийн үндэсний шүтээн болох Гэгээн Георгийн бүлэг уран баримал нь хоёр ширхэг байдаг агаад нэг нь Хуучин хотын Худалдааны талбайд, алтадсан хуулбар нь хотын Захиргааны байшин дотор бий.

Хотын захиргааны байшинг хорьдугаар зууны гучаад оны үед уран барилгач Р.Эстбергийн хийсэн ХҮ зууны үеийн хийцээр барьжээ. Тухайлбал эртний рыцаруудын цонхгүй шилтгээнд нарны гэрэл шувуун нурууны хөндлөвч модод сүлжин тусдаг байсан шиг хотын захиргааны байрны нэг танхимын таазыг “үүл бүрхсэн тэнгэр” шиг зурж чимэглэжээ.

Стурчюрк сүмээс явж хотын хамгийн өндөр газар болох зах руу хүрнэ. Захын талбай дээр Данийн хоёрдугаар Христиан хаан шведийн эзэмшил нутгийг захиргаандаа хэвээр хадгалж байх зорилгоор Ромын католик шашны тэргүүн хамба ламын нэрийг барьж Стокгольм хотын нэг зуун нэр нөлөө бүхий оршин суугчдын толгойг тасдан цаазалж байжээ.

Хотын бараг бүх талбай, өргөн чөлөөг шведийн хаад, тус орны алдарт хүмүүсийн баримлаар чимэглэжээ. Тэдгээр хөшөө, баримлаас хамгийн цуутай нь морь унаснаар дүрсэлсэн Густав Адольф хааны хөшөө юм. Жил бүр 11 дүгээр сарын 6-ны үдэш энэ хөшөөний дэргэд Дуу сонирхогчдын нийгэмлэгийн гишүүд цугларч эх оронч сэдэвтэй түүний дотор Люцений ойролцоо болсон тулалдаанд орохын өмнө хааны дуулж байсан “Бяцхан баг цэрэг минь, сэтгэлээр бүү уна!” гэсэн дууг дуулдаг уламжлал байжээ.

Стаден арлын зүүнтээ залгаа орших Риддархольм арал дээр сиймхийтэй өндөр шовх оройтой шведийн гот дэгээр урласан хонх бүхий язгууртнуудын сүм байна. Энэ сүм дотор шведийн хаадын болон тус орны алдарт иргэдийн бунхнууд тэрчилэн цэргийн олзны эд зүйлс хадгалагдаж байна. Сүмийн гол хаалганы хананд Шведийн хамгийн дээд одон болох Серафимийн одонгоор шагнагдаж байсан бүх хүмүүсийн нэрсийг бичсэн жижиг төмөр хавтангуудыг хар дэлгэц дээр эгнүүлэн өлгөсөн байна.

Хаадын бунхныг сүмийн хананд гаргасан том хонхорхойд байрлуулжээ. XII Карл хааныг цайз дээрээс дайсны буудсан суманд өртөж амь эрсэдсэн үү эсвээс төрсөн эгч нь илгээсэн франц иргэн Сигьед буудуулж алагдсан эсэхийг шалган нотлох гэж түүний бунхныг 1764, 1859 онуудад онгойлгож байжээ. Эмч, хүн судлаач нараас бүрдсэн тусгай комисс хаан дайсны суманд өртөж алагджээ гэсэн дүгнэлтийг хийжээ.

Стокгольмын төв нь Рыцаруудын арал буюу Риддархольм гэж нэрлэдэг Хуучин хот ажээ. Шведийн нийслэлийн хуучны үеийн байшингууд байгаа тэр газар Есус Христосыг төрөхөөс өмнө загасчдын жижиг овоохойнууд байжээ. Хэн ч үл мэдэх үржил шим муутай газрыг дараах үйл явдлын дараа хүмүүс сууршиж эхлэжээ.

Инглинг угсааны хаадын 12 дугаар үеийн хаан Агн Финланд улс руу довтолгоон хийгээд буцаж ирэхдээ алагдсан вангийн охин Скиальфийг дагуулан иржээ. Мэларен нуурын эрэг орчим ирэх үеэс Агн өнөөх бүсгүйтэй гэрлэхээр шийдэж хуримын бөгж өгөхөд олзны бүсгүй түүнийг үзэн ядах сэтгэлээ дотроо нууж хатан нь болохоо зөвшөөрчээ.

Хуримын өдөр баярлаж хөөрсөн Агн хамтран зүтгэгч нарынхаа хамт архи ууснаас шал согтож унахад, Скиальф бүсгүй олзонд байгаа нутаг нэгтнүүдээ суллажээ. Тэд усан онгоцуудаа сууж,

эх нутагтаа буцжээ.

Шведүүд уг газрыг сониучирхан байснаа удалгүй ирж сууршижээ. Стокгольм хотын тухай түүхийн эх сурвалжид 750 оноос анх бичигдсэн байдаг. Тэр үед хот ганц Стаден арал дээр багтаж байсан учир “түүрүүдийн дундах хот” гэж нэрлэгдэж байжээ. XII зуунаас германы наймаачид шведүүдийн төмөр болон зэсийн хүдэр, давирхай, ангийн үсийг сонирхож Балтийн тэнгис орох дамжлага баазууд энд байгуулж байжээ.

Шведийн хааны үүрэг гүйцэтгэгч байсан Биргер Ярл байсхийгээд л довтолж Мэларен нуурын гүн рүү нэвтрэх түрэмгийлэгчдээс залхаж 1252 онд Хольмия хэмээх жижиг сууринг бэхлэлт болгосон тэр үеэс тус хотын түүх эхэлнэ. Анхандаа гурван арал дээр багтаж байсан хот 1400 оны орчим хуурай газар нэмэгдэхийн хэрээр хэрмийн хүрээг тэлсээр 17 цайзтай болсон байв.

Стокгольм нь ХҮ зууны эхний хагасаас тус орны гол хот байсан ч 1634 онд сая нэг нийслэл хот болжээ. Шведийн нийслэл нь арлууд дэр оршдог учир голдуу чулуун байшин барьдаг байсан ч хотын зах хавиар хөдөө нутгийнх шиг уламжлалт модон байшингууд бий. Тэнгисийн булангийн ус үргэлж шавхуурдаж байдаг хадархаг Скансен арал дээр хана, дээвэргүй задгай музей бий. Уг музейд нээсэн эрт дээр үеийн тосгонд очиход хамгийн түрүүнд царс модны сүүдэрт байгаа сүрлэн дээвэртэй улаан өнгийн жижигхэн байшин нүдний өмнө содон тусна.

Энэ бол XVIII зууны үе нэгэн баян тариачны эдлэн газар ажээ. Байшингийн үүдэнд зузаан торгон оймстой хөлдөө шаахай угласан, зузаан гадуур цамц өмсөж толгойдоо цагаан алчуур зангидсан тариачин бүсгүй байна. Энэ музейг хоёр гурван цаг үзэх хугацаанд Швед орны түүх, байгаль, ахуй амьдралтай бүрэн танилцсан мэт сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө.

Скансен арал дээр ирсэн хүүхдүүдэд Амьтны хүрээлэн их таалагдана. Зөрөг замын хажууд гургуул шувуу жуулчид байгааг эс хайхран ихэмсэг зугаацаж өдөө гөвнө. Хаданд гаргасан хонхорхойд амьд баавгай байна.

Швед улсад сүүлийн гурван зуу гаруй жилийн турш буун дуу гараагүй, амгалан тайван амьдарч байна. Дэлхийн хоёрдугаар дайны дараа европийн бүх орон дайны шарх сорвио эдгээж бүтээн байгуулах үйлсэд зүтгэж байхад Швед улсад хөдөлмөр хамгааллын асуудалд онцгой анхаарч байв.

## БАГДАД

Библийн сударт “газар дээрх диваажин” гэж нэрлэсэн “үржил шимтэй” Ирак орон Тигр, Евфрат мөрнүүдийн хооронд байрлана. Тигр мөрний эрэг дагуу хэдэн километр сунжран орших орчин үеийн Багдад хот арабчуудад эзлэгдэхээс өмнө бий болж тогтмол зохиогдож байсан үзэсгэлэн худалдаанд морьд үнэ хаялцуулан худалдаалдаг байжээ.



Аббасид угсааны халиф аль-Мансур нийслэл байгуулж болох тохиромжтой нутаг хайж эх нутгаараа олонтаа аялал хийж 762 онд Тигр мөрний баруун эрэг дээр Мадина-аль-Салам хотын шавыг тавьжээ. Чухам яагаад энэ газрыг сонгосон тухай лавлан асуухад “Цэргийн хуаран шиг эмх цэгцтэй газар байна. Тигр мөрөн биднийг алсад орших Хятад хүртэлх гадаадын орнуудтай холбоно, тэнгисийн баялаг тэрчилэн Хоёр голын сав нутаг, Армен, хөрш орнуудаас хүнсний зүйл тээвэрлэн авчрах бүрэн бололцоо байна.” гэсэн тайлбарыг халиф хийжээ.

Аль-Мансур халиф хотын зургийг газар дээр үнсээр тэмдэглүүлж ирээдүйн хотын хэрэм, гулдан хаалга, гудамжуудыг тойрч үзсэний дараа шугамуудын дагуу газрын тос шингэсэн хөвөн тавьж шатаахыг үүрэг болгожээ. Дараа нь Мадина-аль-Салам буюу “Дэлхийн хот”-ын шавыг тавьжээ. Энэ бол албан ёсны баримт бичгүүдэд хэрэглэж байсан шинэ нийслэлийн нэр юм. Түүнээс гадна Мадина-аль-Мансур (Мансурын хот), Мадина-аль-Халияли (“Хадуур хэлбэрийн хот”), Мадина-аль-Заура (“Мурилзсан хот”) гэж нэрлэж байв. Гэхдээ лалын шашин дэлгэрэхээс бүр өмнө бий болсон Багдад хэмээх том тосгоны нэрээр шинэ хотыг мөн нэрлэж байлаа.

Дугуй юм уу зууван хэлбэрийн байрлалтай хот эртний хотуудын түүхэнд хэд хэд байжээ. Тийм хэлбэрийн байрлалтай хот нь дайсны довтолгооноос хамгаалах, барилгын материалыг хэмнэх талаар нааштай нөлөө үзүүлдэг байна. Мадина-аль-Салам хот нь яг дугуй хэлбэрийн байрлалтай байсан нь эртний уран барилгачдын хосгүй авьяасын илэрхийлэл байв. Хотын голч 2638 метр байсан хийгээд хэрмийн гурван ханыг босгохдоо түүхий тойпуу ашиглаж шатаасан тойпууг тааз, нуман хөндлөвчинд хэрэглэжээ.

Аль-Мансур халиф хотдоо зөвхөн өөрийнх нь үйл ажиллагаанд холбоотой хүмүүсийг суулгахыг хүсэж байснаас “Энх тайвны хот” нь цэргийн хуаранг санагдуулж байлаа. Хотын төв талбайд халифийн ордон, дэргэд нь лалын шашны сүм, диваны (засгийн газрын



байгууллагууд) 7 байшин, аль-Мансурын хүүхдүүдийн ордонгууд байлаа. Энэ дүүрэгт халифаас өөр хүн морь унаж явах эрхгүй байлаа.

Халифийн ордон руу Алтан хаалгаар гарч очдог тул заримдаа ордныг “Баб-аз-захаб” буюу “Алтан ордон” гэж шагшин магтана. Тэрчилэн “ал-Кубба ал-хадра” (“Ногоон бөмбөгөр орой”) гэж нэрлэнэ. Бөмбөгөр орой дээр гартаа барьсан жадаараа дайснууд юм уу босогчид дөхөж яваа зүг рүү харж заадаг морьтны баримал байжээ. 941 онд болсон хүчит шуурга, үерийн уршгаар ордны бөмбөгөр орой нурж унасан ч хана нь XII зуун хүртэл хэвээр байжээ.

Аль-Мансур халиф хүн амын тоог “хязгаарлах” арга хэмжээ авч байсан ч хотын хүрээ тэлж Дугуй хотхоноос хөөгдсөн худалдаачид хэрэм, мөрний эрэг дээр усан боомтын ойролцоо, хуурай замын дагуу мухлаг, лангуу барьж арилжаа наймаа хийнэ.

Багдад хот байгуулагдсаныхаа эхний хэдэн арван жил гадаадын цэргийн довтолгоонд өртсөнгүй, элдэв бослого хөдөлгөөн гарсангүй, эрчтэй хөгжиж байлаа. Тэр үеийн хотуудаас ганцхан Константинополь л тансаг байдлаараа Багдадтай өрсөлдөж чадахаар байжээ. Замын шороонд дарагдсан шаазан эдлэл, торго, ангийн үс, үнэт чулуу, үнэртэн, алт, зааны яс тэгнэсэн жингийн цуваа тасралтгүй ирсээр Багдад дэлхийн худалдааны төв болсон байлаа. Өрнө, Дорноос худалдаачид ирж тухайн үеийн хамгийн том гэрээ хэлэлцээр байгуулж Багдадын худалдаачид хорвоогийн хамгийн баянд тооцогдож байлаа.

Багдадын халифууд чамин гоё ордон, шилтгээн, тансаг амьдралаараа гайхагдаж байлаа. Тухайлбал нэгэн халифийн ордонд торгон цэрэг, тамгийн газрын тVIIIмэд, Коран судар дуудан уншигчид, зурхайч, цагчин, алиа самбаадай, элч, бөмбөрчин, эмч, тогооч гээд нийтдээ нэг мянга орчим хүн үйлчилж байлаа.

Хотыг үндэслэгчийн ач хүү Харун ар-Рашидийн хаанчлалын жилүүд Багдадын хөгжил цэцэглэлтийн оргил үе байжээ. Үүнд түүний хатан Зубайдын гавьяа зүйргүй их билээ. Тэрбээр үнэт чулуугаар чимэглэсэн эмэгтэй хүний өмсдөг өндөр өсгийтэй шаахайг бий болгож алтан болон мөнгөн тосгуур дээр хоол унд зөөдөг журам тогтоожээ. Аль-Муамун халифийн шадар сайдын охин, Буран нарын хуримын тухай хэдэн зуун дамжин ярьж байжээ. Сувд, индранил үнэт чулуугаар чимсэн алтан хивс дээр залран сууж байгаа хосын дээрээс алтан тосгуураас мянган ширхэг том сувд асгаж байжээ. Хуримын зочдод боол, эдлэн газар, хурдан морь зэрэг бэлгийн нэр бичсэн зурвас бүхий хуйлсан цаас шидэн тарааж байв.

Харун халиф өөд болсноор Багдад хотын энх амгалан амьдрал төгсгөл болжээ. Үлгэрийн мэт баялагт нь шунасан хүмүүс харь нутгаас дараалан довтолж гарчээ. Тэгээд ч Харун ар-Рашид халифийн хүүхдүүдийн хоорондын эрх мэдлийн төлөө тэмцэлдээний улмаас Багдадын хүчин чадал мөхөсдөж хот удтал бүслэгдэж дийлэнх хэсэг нь балгас болон хувирчээ. Дараалан болсон байгалийн гамшиг, эмгэнэлт явдлын уршгаар хорвоогийн хамгийн сайхан хот газрын хөрснөөс арчигджээ.

Гэвч 1258 онд халдан ирсэн татар-монголчуудын эсрэг хотынхон хүчээ нэгтгэн тулалдаж бут ниргэсний дараа Багдад хот богино хугацаанд сэргэж дэлхийн худалдааны хамгийн том төв алдраа буцаан авчээ. Түүнээс гадна монголчуудын байлдан дагуулалт хүртэл Багдад нь лалын шашны ертөнцийн оюун санааны нийслэл байлаа. Халиф улс төрийн нөлөөгөө алдсан ч олон

зууны турш лалын шашны ертөнцийг оюун санааны хувьд захирсаар байжээ.

Аль-Маамун халифийн үед нэртэй эрдэмтэд, яруу найрагч, эмч, хөгжимчдийг бүх талаар дэмжиж грекүүдийн хэдэн зууны туршид хуримтлуулсан мэдлэгийг эзэмшиж түүнийг баяжуулан өвөрмөц соёлоо бий болгосон байна. Бусад орны эрдэмтдийн бүтээлийг олноор орчуулж орчуулгын ажлыг өндөр шан харамжаар урамшуулж байлаа. Тухайлбал аль-Маамун халиф алдарт орчуулагч, эмч Хунайн ибн Исхакийг орчуулсан номынх нь жинтэй тэнцэх алтаар шагнаж байлаа.

Багдад хотод лалын шашны ертөнц дэх анхны эмийн сан, эмнэлэг нээгдэж VIII зууны сүүлчээр цаас үйлдвэрлэл нэвтэрчээ. Аль-Маамун халиф Багдад хотод “Номын ордон” байгуулжээ.

Монголчуудын халдлагаас бүтэн хагас зууны дараа Доголон Төмөр хааны цэрэг Багдад руу довтолж хотыг үнсэн товрог болгожээ. Дараа нь персүүд, туркүүд Багдад хотод ноёрхохын төлөө хоорондоо дайтаж түүнийг нь далимдуулан XVII зуунд Османы эзэнт гүрэн эзлэжээ. XX зууны эхэн үед Багдад нь 140 мянган хүн амтай, шороо тоос пургисан хот болсон байлаа.

Өнөөдрийн Багдад хотыг эртний байдалтай нь харьцуулах ямар ч боломжгүй билээ. Хүн пиг дүүрэн зөрөлдөх өргөн гудамжууд нам гүм догол гудамжуудтай, далдуу мод бүхий цэцэрлэгт хүрээлэнгүүд элсэн довуудтэй зэрэгцэн оршино. 1930 оны үед хавар цөн түрэх үеэр цорын ганц хөвдөг гүүр нь нурж байсан бол одоо шөнийн цагаар гэрэл цацраасан гүүрүүдийг тоолоод баршгүй. Тигр мөрний эрэг дээр ээлжит үлгэрээ хүүрнэж байгаа Шехеразадаг дэр тохойлдон чих тавин чагнаж байгаа Шахрияр хааны хүрэл баримал байна.

Багдад нь дорнын аливаа хотын адил захаараа алдартай. Түүнээс арьсан эдлэлийн Зэсэн сук (зах) бүр илүү цуутай. Зэсэн сукаар ороход чих дүлийрэм дуу чимээ хадна. Уг захын тухай нэгэн түүхийг хотын иргэн бүр ярина. Нэгэн ядуу залуу баян айлын охинд сэтгэлтэй болжээ. Гэтэл охины эцэг ядуу хүргэнтэй болохыг хүссэнгүй, Зэсэн захын дуу шуугианыг дартал хашгирсан тохиолдолд охиноо гэргий болгон өгөхөө залууд амлажээ. Мэдээж хэрэг залуу чанга хашгирч дийлсэнгүй, хайртай бүсгүйгээ эхнэрээ болгон авч чадсангүй өнгөрчээ.

## ТУЛА

Алсаас харахад энэ хот чулуун хашаагаар хүрээлэгдсэн нэг давхар байшингууд бүхий тосгоныг санагдуулна. Гэвч XIII зууны үед байгуулагдсан Тула нь Мексик улсын эртний хотуудын нэг билээ. Тольтек омгийнхны нийслэл, соёлын төв байсан Тула нь тэр үед Толлан буюу “Бичиг үсэгтэй хүмүүсийн нутаг” гэж нэрлэгдэж байв.



Захирагч Чальчиутланецин Толлан хотыг байгуулсан гэж улаан арьстнуудын эртний эх сурвалжид тодорхой тэмдэглэсэн байна. Төрөх үедээ Се-Акатль буюу “Ганц ширхэг зэгс” гэсэн нэр авсан ханхүү 980 оны хавьд хаан ширээнд өргөмжлөгджээ. Түүний бүтэн нэр нь Се-Акатль-Накшитль-Топильцин буюу “Манай эрхэмсэг ноён ганц ширхэг зэгс” ажээ.

Тольтек омгийнхон Мексик улсыг X зууны дунд үеэс XII зууны дунд үе хүртэл хоёр зуу орчим жил эзэгнэж байсан хийгээд тэдний эрэлхэг зориг, гайхам ур чадварын тухай домог яриа бидний үед өвлөгдөн хүрч иржээ. Тэд Кецаль буюу Өдтэй могой бурхныг бишрэн шүтдэг байв. Тийм Өдтэй могойны дүрсийг уран зураг, уран барилгын урлагт олон гаргасан байдаг. Тухайлбал Өдтэй могой байшин барилгын багануудыг хэдэнтээ ороож пирамидийн ханын зургаас ширтэнэ. Тула хотын олон дурсгалт зүйлээс хүний араг ясыг залгиж байгаа асар том хоржигнуурт могойг дүрсэлсэн Коатепантли буюу Могойнуудын хана онцгой анхаарал, шохоорхол татна.

Бүтнээрээ Тула-де-Альенде нэртэй мексикийн хөдөөгийн хот тус орны бусад бүх суурингийн адил маш цэвэрхэн ажээ. Гудамжаар явахад эрдэнэ шишийн бин үнэртэж сүмийн хонх хангинана.

Эрдэмтэд тольтек омгийнхны алдарт нийслэл хаана байгааг тогтоож чадахгүй их удсан. Гэтэл 1880 онд францийн хуучныг судлаач Д.Шарне Тула хотын захад байх довын ойролцоо малталт хийж эхлэжээ. Тэрбээр удсангүй сүрлэг сайхан пирамид олж Тула хот нь Х.Колумб америк тивийг нээхээс өмнөх үеийн шашны чухал төв байжээ гэсэн урьдчилсан дүгнэлтийг хийжээ. Харамсалтай нь төдөлгүй францийн эрдэмтний нээлтийг мартаж хотыг эрж малталт хийхдээ адилхан нэртэй хот байдаг гэж огт тааварлахгүй байлаа.

Гагцхүү XX зууны дунд үеэс хэний ч анхаарал татдаггүй байсан Тула хот руу Х.Колумбын өмнөх үеийн түүхийг судлаачид бөөнөөрөө тэмүүлж эхлэв. 1940 онд хийсэн анхны

малталтаар хэд хэдэн үнэт нээлт хийв. Өнөөгийн Тула хотын төвөөс холгүйхэн газраас, эгц пирамид голт зүрх нь болсон, улаан арьстнууд Тлауискальпантекули буюу Сугар, Өглөөний Од гэж нэрлэдэг байсан эртний хотын балгасыг олдлоо. Хүн алж таашаал авдаг хүчирхэг Мишкоатль бурхны элч гэж Сугар бурхныг дээдлэн шүтдэг хойд нутгийн хөрш нүүдэлчин омгийнхноос тольтекүүд өвлөн авч мөн сүсэглэдэг болжээ. Пирамидийг чулуун шар ирвэсийн болон хүний зүрхээр хооллодог бүргэдийн товгор дүрсээр чимэглэсэн байна. Шар ирвэс, бүргэд нь Төв Америкийн зарим дайнч омгийн сүлд ажээ. Пирамидын нүүрэн талыг чимэглэсэн хоёр хос бүргэдийн хооронд Сугар бурхны билэгдэл болох могойны ангайсан ам түүний дээр хүний толгойг дүрсэлсэн байна.

Пирамидын оройд тольтек омгийн удирдагчид өөрсдийгөө адилтган үздэг байсан Кецаль бурхны баримал байсан бололтой. Пирамидийн дээд талбайд, мөрөн дээрээ тэнгэрийг тулж байдаг эртний грекийн домгийн баатруудын нэрээр эрдэмтэд “атлантууд” гэж нэрлэсэн хэд хэдэн хүний баримал өнөөг хүртэл хадгалагдан иржээ.

Цул чулуу сийлэн урласан 4,6 метр өндөр тольтекийн омгийн дайчид зэвсгээ дааж ядан зогсоно. Атлантуудаар саравчийн дээврийг тулсан байсан бололтой.

Сүмийг чимэглэсэн олон сайхан товгор дүрсийн дийлэнх нь он цагийн уртад алга болжээ. Гэхдээ үлдэж хоцорсон товгор дүрсүүдийг судалж ямархуу чимэглэл байсныг нь таамаглаж болох талтай. Тольтекүүд цэргүүдээс гадна хүний зүрхээр хооллодог бүргэдүүд тэрчилэн хүзүүндээ хонх зүүсэн муурыг санагдуулсан хачин амьтдыг олноор дүрсэлдэг байжээ.

Сүмийн өмнө нийтийн цуглаан, хурал хийдэг байсан саравчаар битүүлсэн талбай байв. Саравчийг дороос тулсан зарим багана нь Тула хотод одоо ч байна.

Тула хотоос хар өнгийн хүрмэн чулуугаар сийлсэн Чак-Моолийн маш өвөрмөц сонин баримал олджээ. Эрдэмтэд баримлыг хөлөө бага зэрэг нугалж толгойгоо дээш харснаар урласныг нь иш үндэс болгож бурхдын элч бололтой гэсэн дүгнэлтийг хийжээ. Баримлын мөр дэр гаргасан нүхээр бурхны хамгийн их таашаадаг хүний цус дусаадаг байсан бололтой.

Толтекүүдийн материаллаг соёлын ул мөрийг судлахад хүнээр тахил өргөдөг дайнч ард түмэн байсан нь нотлогдож байна. Тольтек омгийн залуу, эрчтэй удирдагч “Манай эрхэмсэг ноён ганц ширхэг зэгс” хаанаар өргөмжлөгдмөгц, зүтгэхээ амласан Кецаль бурхны нэрийг авчээ. Х зууны сүүлчээр тольтекүүдийн удирдагч, дээд тайлгач Топильцин-Кецалькоатль ард иргэдийнхээ аж төрөх ёсыг энхийн хэв шинжтэй болгохоор оролдсон ч ширүүн эсэргүүцэлтэй тулгарчээ. Оршин суугчдын дийлэнх нь Өдтэй могойн шүтээндээ үнэнч хэвээр үлдсэн ч нөгөө хэсэг нь шинэ Тескатлипок бурхныг сүсэглэдэг болж түүнээс үүдэн шашны мөргөлдөөн гарав.

Мөргөлдөөн дамжирсаар хааны ордонд хүрч Топильцин-Кецалькоатль хаан ялагдал хүлээж нийслэл Тула хотыг орхин зугтав. Түүнтэй хамт хэдэн мянган иргэн дорно зүг чиглэн явлаа. Амьд Кецаль бурхан төрөлх нутгаасаа алсад одохын өмнө иргэддээ хандаж, дорно зүгээс нэгэн сайхан өдөр буцаж ирнэ гэж амлажээ. Тэгээд түүний амласан хугацаа ойртох үед испанийн байлдан дагуулагч Эрнан Кортес дорно зүгээс ирэхэд, улаан арьстнууд түүний эсрэг тэмцэх нь Кецаль бурхны өөдөөс гар далайсан хэрэг болно гэж үзэж эсэргүүцэн

тэмцээгүй байна.

## ФЕС

Арабын уудам ертөнцийн хамгийн баруун захад эрт дээр үеэс грекүүд, ромчууд, финикичүүд дайлаар ирж байсан эртний Марокко улс оршино. Гибралтарын хоолойн хоёр талаар өөртөө зориулан Гераклын босгосон “Геркулесийн баганын” тухай эртний домог бий. Эртний ард түмнүүд эдгээр “баганууд” болох Гибралтар, Жебель-Мусыг хорвоо дэлхийн баруун хязгаар гэж үздэг байжээ.



Марокко улсын хотууд янз бүрийн ард түмнүүд босгосон юм шиг нэг нэгэнтэйгээ огт адилгүй ажээ. Араб-берберийн улс орнуудын соёл нь эртний ертөнцийн баялаг өв, иудийн гар урчуудын ололт тэрчилэн шашны хавчилтаас болж Испаниас зугтан ирсэн эрдэмтний үзэл санааг шингээсэн учир тийм байдаг бололтой.

Дундад зууны үеийн арабын хотуудад хот байгуулалтын нэгдмэл дэг байсангүй. Дамаск зэрэг хотууд эрт дээр үед үүсэж эртний болон эртний византийн үеийн уран барилгын дүр төрхийг илэрхийлдэг бол Фустат, Куфа, Басра зэрэг хотууд арабын цэргийн хуарангийн буурин дээр байгуулагдсан болохоор хуаран-хотын дүр төрхтэй ажээ.

Фес хотын түүх лалын шашин үүсэн дэлгэрсэн анхны зуунуудтай холбоотой хийгээд дорнын Багдад, Каир хотуудаас илүү уран барилгын дүр төрхөөрөө олон зууны түүхийг хадгалж чадсанаараа ялгагдана. Тэрчилэн хоёр удаа бий болсноороо бас гайхагдана. Зөнч Магоменийн хүү, нэгдүгээр Мулай Идрис султан 789 онд Марокко улсын хуучин нийслэл Волубилис хотыг өргөжүүлэхгүй, харин Фес (“фес” гэдэг нь “модон зээтүү” утгатай ажээ.) голын баруун эрэг дээр шинэ хот байгуулахаар шийджээ. Түүний хүү, хоёрдугаар Идрис 808 онд эцгийнхээ бариулсан цайзын эсрэг талд, Фес голын зүүн эрэг дээр хааны өргөө, сүм, зах босгожээ.

XI зууны сүүлчийн арваад жил хүртэл өөд өөдөөсөө харсан энэ хоёр хот байнга хоорондоо дайсагнадаг байв. Кайрун хотоос гаралтай нэгэн иргэний хоёр охин хоёр хотод тус бүрт нь лалын шашны сүм байгуулжээ. Хоёр сүмийн мөргөлийн баганат танхим, бяцхан лалын сүм, сахн буюу мод тойруулан суулгасан жижиг хашаа гээд бүх зүйл нь яг адилхан ажээ. Хоёр сүм хоёр хотын нийгмийн амьдралын төв болж түүнээс худалдаа, нийтийн замууд салаалж тэдгээрийн эргэн тойронд орон сууцны хорооллууд бий болж эхлэжээ.

Гэхдээ Фес голын зүүн эрэг дээрх хот нь газар зүйн ашигтай байрлалынхаа ачаар нөгөө

хотоосоо илүү хөгжжээ. Чухамдаа баруун эргийн хотод Фес голыг Атлантын далай, Газрын дундад тэнгисийн эрэгтэй холбосон замууд тулж ирдэг байжээ. 1069 юм уу 1075 онд Юсуф ибн Тафшина Альморавид султан хоёр хотыг нэгтгэснээс зүүн хэсэг нь эрчтэй хөгжив. Хожим нь лалын шашны их сургууль болсон Карауун сүм нэгдсэн хотын төв болон тодров.

Уг сүмийн орчин үеийн дүр төрх нь нэмж барьсан хэсэг, зарим чимэглэлийг эс тооцвол үндсэндээ Альморавид угсааны хаадын ноёрхлын үед бий болжээ. XII зууны хоёрдугаар хагасаас Фес хот лалын шашны сүм-их сургуулийн чиглэлээр хөгжих болж сүмийн эргэн тойронд их сургууль, шашны дунд сургууль, халуун усны газар, зочид буудал гэх зэрэг олон барилга сүндэрлэн босож цогцолбор болон өргөжжээ. Энэ бүхнийг оюутнуудыг сургуулийн болон мөргөлийн байранд нь ойр байлгах зорилгоор хийжээ.

Фес хотод найман зуу орчим лалын шашны сүм байдгаас XIII зуунд өргөжүүлсэн Карауин хамгийн гол сүмд тооцогдоно. Хойд Африк дахь хамгийн том энэ сүмд шашны баяр ёслолын үеэр 22 мянга орчим сүсэгтэн багтана. Арабын эртний их сургуульд суралцахаар Ливи, Алжир, Суданаас залуучууд ирдэг бөгөөд Марокко улсын олон улс төрийн зүтгэлтэн энэ их сургуулийн төгсөгчид ажээ.

Фес хотын баруун хэсэгт орших Андалу сүм нь Карауинаас ялгаатай нь дан шашны үйл ажиллагаа явуулна. Уг сүмийн барилгыг хотын гол гудамжууд зөрж тойрон гардаг, дэргэд нь худалдааны том талбай оршдог, өндөр цоройсон хуш модон саравчтай гоёмсог том тагтаар чимэглэгдсэн зэргээрээ хотын баруун хэсгийн шүтээний гол төв болжээ.

Хоёр сүмийн нүүрэн тал хөл хөдөлгөөн ихтэй гудамж руу хардаг ч сүмд аль ч талаас нь орж болно, шашны баяр ёслолын үед тэдгээрийг сүсэгтнүүд жагсан тойрч болно. Жил бүр наймдугаар сарын сүүлч, есдүгээр сарын эхээр хотыг үндэслэгч хоёрдугаар Мулай Идрис хааны дурсгалд зориулсан баяр болно. Баяр ёслолд оролцогчид хотын гудамж, талбайгаар жагсан явахдаа хотыг үндэслэгчийн бунхан байдаг Завия дүүргийг тойрдог уламжлалтай ажээ. Бунхны хананд тогтоосон зэсэн самбарын голд гаргасан нүхэнд сүсэгтнүүд гараа шургуулна, энэ үйлдэл нь гэгээнтний сэтгэл зүрхтэй холбогдож Аллах бурхны ивээлд багтаж байгааг билэгдэнэ.

Карауины их сургуулийн оюутнууд, өндөр дээд эрх мэдэлд хүрэхэд нь үзүүлсэн дэмжлэгийн хариуд XVII зуунд Алауит угсааны хаадаас олгосон эрх ямбын дурсгалд зориулсан өөр нэг баярыг бас өргөн тэмдэглэнэ. Алауит угсааны хаад оюутнуудад талархлаа илэрхийлж жил бүр нэг сарын хугацаатай хотыг захирах эрх олгожээ. Оюутнууд эрх мэдэл авмагцаа шүүх, залхаан цээрлүүлэх ажиллагааг бүрмөсөн зогсоож хотын оршин суугчдыг гэгээрүүлэх, ядуучууд, өвчтөн, өвгөд хөгшдийн аж байдлыг хөнгөвчлөх зэрэг дан сайн санааны үйлс хийдэг байна.

Фес нь Марокко улсын бусад бүх хотын адил хуучин-Фес-аль-Бали, шинэ-Фес-аль-Жедид гэсэн хоёр хэсэгт хуваагдана. Зах хязгаар нь үл харагдах цэцэрлэгт хүрээлэн, усан үзмийн талбайгаар хүрээлэгдсэн Фес хот эрт дээр цагаас худалдааны том төв байжээ. Тиймд хотод өнөөдөр хаа ч байхгүй сайхан захууд бий. Хоёр илжиг зөрж гарахааргүй нарийхан гудамж-шуудуугаар явж төмөр саравчтай бүүдгэр хонгилоор орж зах хүрнэ.

Рабат хаан хотод шилжин сууснаар Фес нь хөдөөгийн хот болсон ч тус орны шашны шүтээн, худалдаа, гар үйлдвэрлэлийн төв хэвээр үлджээ. Хотын гол чимэг нь дундад зууны үеийн Медина дүүрэг юм. Зөнч Мухаммед Мекка хотод байх нь амь насанд нь аюултай болоход Медина хотод шилжин сууршижээ. Тэр үеэс хойш лалын хот бүрийн хуучны дүүргүүдийг Медина гэж нэрлэж заншжээ. Фес хотын Медина дүүргийн гудамж талбайгаар хэдэн цагаар алхан зугаалж чамин гоё сүм хийд, нийтийн халуун усны газар, янз бүрийн өнгийн вааран хавтангаар чимэглэсэн усан оргилуурыг сонирхон бахадна. 1357 онд баригдсан Бу Инания шашны дунд сургуулийн хүрлээр чимсэн хавгастай хаалганууд, оникс, шаазангаар урласан шат, модон чимэглэлтэй бөмбөгөр орой жуулчин бүрийн шохоорхлыг татаж сэтгэлийг сэргээнэ. Шашны сургуулийн дотоод хашааг оникс, гантиг, ховор үнэт модоор доторложээ. Гурван давхар байшингийн танхимуудыг хашаанаас сиймхийтэй модон хаалтаар тусгаарлажээ. Сургуулийн бүх ханыг шигтгэмэлтэй хавтанцараар бүрж хана дагуу хар үсгээр цагаан вааран дээр бичсэн шүлэг, найраглал байрлуулжээ.

Фес хотын Медина дүүрэг Бу-Желуд хаалганы цаанаас эхлэнэ. Баяр ёслолын үед султаныг орж гарахад зориулагдсан гулдан хаалганы дор өнөөдөр хөл хөдөлгөөн ихтэй ажээ. Медина дүүрэг нь тус бүр нь өвөрмөц бүтэцтэй хорооллууд болон хуваагдана. Хороолол болгонд сүм, усан хангамжийн хоолой, талхны үйлдвэр, хамам буюу турк халуун усны газар байна. Жуулчид Медина дүүрэг дэх султаны гоёмсог ордон, элдэв дээдийн бараа борлуулдаг лангуунууд, хамар цоргисон өвөрмөц үнэр, кафе зоогийн газраас сонсогдох андалуз нутгийн аялгууг онцгойлон сонирхоно.

Фес хотын оршин суугчид урт хормойтой нөмрөг, цагаан бабуши буюу цагаан урт хоншоортой арьсан шаахай, шовгор малгай гээд голдуу үндэсний хувцсаа өмсөж гангарна. Фес хотод арьс элдэх урлаг хөгжөөд мянга гаруй жил хөгжих хугацаанд арьс элдэх урлагийн дөч гаруй үе дараагийн үедээ арьс элдэх, шүүлэх, будах нууцаа дамжуулан иржээ. Фесийн урчууд арьсыг хүчил, шүлт гээд ямар ч “химигүй” боловсруулдагийг хүн тэр болгон мэддэггүй билээ. Тийм учраас Марооко улсын аль ч захаас гутал худалдан авахад харамсахааргүй байдаг.



## КИОТО

Японы Киото хот нь уран барилгын гайхамшигт дурсгалуудтай хот төдий биш юм аа. Бүтэн хагас сая хүн амтай хотод хоёр зуу орчим сүм, хэдэн зуун цэцэрлэгт хүрээлэн, хэдэн арван ордон шилтгээн бий. Япончууд Киото хотыг үндэсний эрдэнэс гэж тооцдог хийгээд японы уран барилгын шилдэг бүтээлүүдийн тавны нэг хэсэг нь чухамдаа энэ хотод байдаг.



Камму хаан үе залгамжлах ханхүүгийн хамт “Хэйан” буюу “Энх амгалангийн хот” гэж нэрлэсэн шинэ нийслэлдээ ёслол төгөлдөр орж ирсэн 794 оны аравдугаар сарын 22-ны өдрийг хот үүсэн өдөр гэж тэмдэглэдэг. Японы нийслэл урьд нь Нагаока хотод байсан ч ордны хуйвалдаан хэдэнтээ гарч цус урсаж байсан учир хаан нийслэлээ нүүлгэн шилжүүлжээ.

Шинэ нийслэлийг уулсын дундах үзэсгэлэнт хөндийд орших Кадоно мужийн Уда тосгон байрлаж байгаа газрыг сонгож, хятадын ёс заншлыг дагадаг ёсоороо тэгш өнцгөөр зөрөлдсөн тэгш гудамжуудтай хот байгуулжээ. Киото хот нэг мянга гаруй жил Мандаж байгаа нарны орны нийслэл байсан түүхэн урт хугацаандаа хөгжилт цэцэглэлт, байлдаан тулаан, түймэр гээд элдвийг үзжээ. Уран барилгын хосгүй сайхан олон барилга байгууламж сүйдэж алга болсон ч үлдэж хоцорсон нь тэгш шугам, гоёмсог чимэглэлээрээ харсан хүн бүрийн сэтгэлийг баясгана.

Гадаадын иргэдийн хувьд Киото нь цагаан-ягаан сакура модод дунд умбасан хааны ордон, шилтгээн, олон давхар сүм гэсэн төсөөлөл байдаг. Гэвч галт тэрэгний буудлын талбайд гарахад хөнгөн тэрэг тасралтгүй цувсан засмал зам, олон давхар байшингууд, зурагтын цамхаг бүхий орчин үеийн японы хотын дүр төрх тодорно. Далимд дурдахад зурагтын 100 метр өндөр цамхаг барих үед хотын иргэд хоёр хэсэгт хуваагдаж нэг хэсэг нь эртний хотын дүр төрхийг гутааж байна, нөгөө хэсэг нь хотын бас нэг чимэг болно гэж удтал маргалдаж байжээ.

Чухамдаа бол Киото хотод орчин үе өнгөрсөн үеийг сүр бараагаараа дарсангүй, түүнтэй нэгджээ. Жишээ нь Цэргийн жанжнуудын ордны сүрлэг байшингийн эсрэг талд өндөр зочид буудал дүнхийнэ, их дэлгүүр, буурчийн газар бүхий орчин үеийн галт тэрэгний буудлын хажуу талд эртний сүм харц булаана оршино.

Киото хотоор явахад сүмийн дотроо хоосон зай бүхий дээвэр, хуучны байшингууд бүхий гудамж гээд өнгөрсөн үеийн дурсгалт зүйл алхам тутамд тааралдана. Ялангуяа 1615 онд хааны хотын гаднах ордны зориулалтаар босгож эхлэсэн Кацура ордны цогцолбор нь япончуудын бахархал билээ. Цогцолборын энгийн байдал, цэцэрлэгт хүрээлэнгийн өнгө төрхөө байнга өөрчлөх талбай нь гоёмсог танхим, сүүдрэвчүүдтэй донжтой хосолжээ.

Байгуулагдсан үеэсээ байрлал нь хэдэнтээ өөрчлөгдөж байсан хааны Госё ордноос Киото хотын уран барилгын түүх эхлэсэн гэж үздэг. “Өндөр хүндэтгэлтэй нутаг” гэсэн утгыг илэрхийлдэг Госё ордон нь 1855 онд болсон түймрийн дараа өнөөгийн дүр төрхөө олжээ. 11 га талбайг ваараар дээвэрлэсэн өндөр шавран хэрмээр хүрээлүүлж, зургаан хаалга гаргасны Өмнөд хаалга нь чухал ач холбогдолтойд тооцогдоно. Уг хаалгыг жилд хоёрхон удаа онгойлгодог хийгээд түүгээр зөвхөн хаан л орж гарах эрх эдэлнэ. Жирийн иргэд, жуулчид “Сэйсёмон буюу “Намрын зарлигийн хаалга”-аар орж гарна.

Госё ордны төв нь дэргэдэх хашааны ёроолоор нь цагаан хайрга асгаж тэгшилсэн Сисинден буюу Еслолын танхим юм. Энэ танхимд байгаа том цацрын дор байх тана шигтгэж, хааны гэрийн билэгдэл болох 16 дэлбээтэй шивантиг цэцгээр чимсэн улаан зандан хаан ширээнд хаад ээлж дараалан залардаг байв. Ордны дотоод чимэглэл энгийн юм шиг мөртөө жавхаалаг сайхан харагдана. Тэгшилж өнгөлсөн шаланд нь будаагүй ч нямбай тэгшилж өнгөлсөн голуудаар хийсэн нүсэр дугуй модон шонгуудын сүүдэр тусна. Ордны өмнө зүг харсан нүүрэн талд байгаа хаалгаар том налуу шатаар явж элсэн цэцэрлэг рүү орно.

Сүмийн танхим бүрийг өвөрмөц зориулалтаар ашиглана. Исэ танхимд нь японы хаадад эрх мэдэл хайрладаг Амагэрасу эм бурханд хаан мөргөл үйлдэнэ. Өөр нэг танхимд нь “дуулдаг” шал байх ба уг танхимд хүн болгоомжтой гишгэхэд л дуу чимээ гарна.

Сёгунуудын үед тэдний өргөө нь XVI зууны сүүлчээр Токугава угсааны төлөөлөгчид үндэслэсэн Низо шилтгээнд байрлаж байв. Шилтгээн нь налуу, матигар дээвэртэй, гол хаалганы дээр байрлуулсан гурван өнцөгт бамбай дээр алдталмал хээ угалз бүхий модон байшин ажээ. Шилтгээний танхим бүр гурван ханатай ба танхимыг хонгилоос тусгаарласан дөрөв дэх хана гэж байхгүй. Танхимуудын ханыг Кано дэгийн гарамгай зураачдын бүтээлээр чимжээ. Тухайлбал нэгэн хананд салхинд ганхаж байгаа хулс, зэгсний бут, нөгөө хананд нь цэцэглэж байгаа сакура модны агаарт хөөрч дэгдэм хөнгөн байдлыг дүрсэлжээ.

Нэгдүгээр танхимд тVIIIмэд сууж орж ирж байгаа хүнийг шилтгээнд уригдсан хүн мөн эсэхийг шалгана. Тиймд өнөөдөр жуулчид энэ танхим руу дөхөн ирэхэд баяр ёслолын уламжлалт кимоно хувцас өмссөн хэдэн арван тVIIIмэд намхан тавцан дээр сууж байгаа сёгуны өмнө мэхийн ёсолж байгааг хараад гайхдаг.

Киото шиг олон сүмтэй хот Японд үгүй билээ. Чухам хэд болохыг нь оршин суугчид нь ч мэдэхгүй. Буддийн шашны сүмүүд нь бүдүүн том багануудтай, өргөн матигар дээвэртэй том модон байшингууд юм. Харин Киемидзу (“Тунгалаг усны сүм”) сүмийг ой бүхий уулын эгц налууд тулган барьсан болохоор түүний сэрүүн тагт дээр гарч зогсоход сүм агаарт тогтож байгаа юм шиг сэтгэгдэл төрнө.

Энэ сүм үүссэн тухай нэгэн домогт өгүүлэхдээ:

VIII зууны үед лам Энтин зугаацан явж байгаад хүрхрээ харж түүнийг сониучирхан очиход “Ёдо гол руу ус нь цутгаж байгаа булгийг ол!” гэсэн үгс чихэнд нь сонсогджээ. Тэгээд лам Отава уулаар удтал явж эрсээр балар ойн гүнд манан буданд битүү хучигдсан газар очжээ. Тэнд даянчлан сууж байсан мэргэн хүн Гёэй өрөвч сэтгэлийн Каннон эм бурхны сүнс шингэсэн нэгэн модыг ламд өгчээ. Энтин лам тэр модоор өрөвч сэтгэлийн Каннон эм бурхны дүрсийг сийлж нэгэн жижигхэн хулсан овоохойд залсан нь сүмийн эх суурь болж, уг сүмийг уулын налуугаар урсаж байж байгаа тунгалаг усны нэрээр нэрлэжээ.

Киёмидзу сүмийн тухай, уг сүм японы хаадын мэдэлд шилжсэн 811 оноос эх сурвалжид тэмдэглэн бичсэн бий. Сүмийн цогцолбор мөргөлийн танхим, Каннон эм бурхны дүрсийг тахилд залсан гол сүм болох хондо зэрэг нийтдээ гучин байгууламжаас бүрдэнэ. Бүдда бурхан хувирч чадах тоог билэгдсэн “Гучин гурвын сүм” буюу Сандзюсангэндо сүмд хүний хөл тасардаггүй. Сүмийн гол танхимд өрөвч сэтгэлийн Каннон эм бурхны том баримал түүний эргэн тойронд эм бурхны арай жижиг хэмжээний хэдэн мянган баримал байна.

Сүмийн гол танхимын цаана японы өнцөг булан бүрээс зөөж авчирсан уур хилэн нь бударч царай нь үрчийж хорчийсон, гар хөл нь татгалзсан чөтгөрүүдийн баримал байна.

Япончууд гоо сайхны үлгэр жишээ гэж үздэг байсан бяцхан хүрхрээ, намхан дов, жижигхэн хөндий тал, модод битүү тарьсан уламжлалт цэцэрлэгүүд жуулчдын шохоорхлыг их татна. Киото хот дахь уламжлалт цэцэрлэгүүд XVI-XVII зууны үед байгуулагдсан Дайтокузи сүмийн цогцолборт төвлөрсөн байна. Захиргааны төв болон цогцолборыг бүрдүүлж байгаа нийтдээ 23 сүмийн тус бүрийнх нь цэцэрлэг, цэцэрлэг-музей, цайны цэцэрлэг нь түүхэн дурсгалын их ач холбогдолтой ажээ.

Сүмийн үүдэнд гутлаа тайлж музейн шаахай өмсөж, тагтны хэдэн зууны туршид харлаж өнгөлөгдсөн шалаар алхаж, торгорхог сүрлэн олбог дэвссэн өрөөнүүдээр орж, хүнгүй өрөөг сонгож хананд байгаа уран зургуудыг харж хорвоогийн элдэв явдлыг бодож суух үнэхээр сайхан билээ. Нам гүм байдлыг анхааралтай чагнавал хаа нэгтээ бяцхан хүрхрээний ус хөөсрөн буух чимээ, хулсны оройд салхи хүнгэнэж мод, бутанд царцаа дүнгэнэж байгаа нь сонсогдоно.

Киото хотын хамгийн гол дурсгалт зүйл нь мэдээж хэрэг Рёанзийн цэцэрлэг буюу Чулууны цэцэрлэг юм. Түүнийг “Гүн ухааны цэцэрлэг” гэж бас нэрлэнэ. Хэдэн зуун жилийн тэртээ ухаант лам, алтан гарт Соами хоёр янз бүрийн хэлбэртэй, хар өнгийн 15 үнэт чулууг байгалиас олсон байдлаар нь байрлуулжээ. Гэвч энд ирдэг жуулчид, зочид зөвхөн 14 чулууг нь л олж харна. 15 дахь чулуу нь бусад чулуу дотроо уусан харагдахгүй ажээ. Элсэн тэгш өнцөгтийн хажуугаар зассан модон замаар явахад 14 үнэт чулуу харагдана. 15 дахийг нь нүдээрээ эрж дөнгөж олж харахад бас нэг чулуу нь харагдахгүй болчихно.

Камму, Комэй хаадад зориулсан синто шашны Хэйандзингу шүтээнийг босгосон 1815 оноос жил бүр аравдугаар сарын 22-нд тэмдэглэсээр ирсэн “Зуунуудын жагсаал” баяр үнэхээр өвөрмөц сонин билээ. Өглөө эрт сүмд шашны ёслол болж хаадын дурсгалд зориулсан мөргөл үйлдэнэ. Дараа нь хаадын сүнс түр зуур ирдэг гэдэг гэж үздэг хүн зөөдөг тэргийг гадагшаа зална. Жагсаалд оролцогчид Япон дахь хамгийн том хаалга болох Тории хаалганы доогуур гарах агшныг баяр ёслолын нээлт гэж үзнэ. Жагсаал Хааны ордон хүрэх зам зуур жагсагчид

японы түүхийн янз бүрийн үе шатны үйл явдлыг театрчилсан тоглолтыг үзүүлнэ. Жагсагчид үе шат бүрийн өнгө төрхийг тухайлбал Мэйдзийн (1868-1912) үеийг хааны арми, тариачдын зэвсэглэсэн багаар харуулна. Чухамдаа Мэйдзийн үед сёгунуудын (цэргийн удирдагчдын) ноёрхлыг дуусгаж хаант засаглалыг тогтсон билээ.

Тогугавын (1603-1868) үеийг сёгуны элч Киото хот орж хаанд өндөр хүндэтгэл үзүүлж байгаа явдлаар гаргажээ. Жагсаалын дараагийн хэсэг нь улс орны нэгтгэсэн төрийн хоёр гарамгай зүтгэлтэн, цэргийн жанжин Ода Нобунага, Тоётоми Хидэёси нарын дурсгалд зориулагджээ.

## НОВГОРОД

Хоёр эрэг дагуу нь оросын эртний Новгород хот орших Волхов голын усанд Кремлийн хэрэм, София сүмийн алтан ганжирууд, гүн цэнхэр тэнгэр тусна. Хотын чулуу бүр, дов бүр, хуучны судлалын малталт бүр Новгородын мөнхийн амьд түүхийг гэрчилнэ.



Хотын нэр, үүссэн цаг үеийн тухай асуудал маргаантай хэвээр байна. Новгород хот байгуулагдсан үеийг оросын түүхэн эх сурвалжид анх дурдсан үеэс нь буюу 869 он гэж тооцдог юм. Гэхдээ Византийн судар бичигт бүр түүнээс өмнө бий болсон тухай бичсэн бий. VIII зууны сүүлч, IX зууны сүүлчээр Новгородын ван Бравлиний удирдсан цэрэг Сурож хотыг эзлэж байсан тухай мэдээлэл бас бий.

Тус хот нь хуримтлуулсан баялаг, ач холбогдлоороо Киевийн дараа орох Оросын хоёр дахь том хот байсан төдийгүй Балтийн тэнгисээс Уралын нуруу, Ильмен нуураас Баренцевийн тэнгис хүртэлх асар их газрыг эзэгнэсэн, Оросын хамгийн том газар нутагтай вант улс байв. Гэхдээ энэ уужим дэлгэр нутаг үржил шимийн хувьд тааруу байсан тул хотын худалдаачид, шинэ орон нутаг нээгчид вант улсын хойд хэсэгт очиж сууршиж байлаа.

Новгород хотын хүчирхэг хүчин чадлын билэгдэл болгож Волхов голын эрэг дээр 13 бөмбөгөр орой бүхий София Эх Дагинын царсан сүмийг босгожээ. Уг сүм 1045 онд түймэрт сүйдсэний дараа Владимир ван зарлиг гаргаж Кремлийн чулуун цогцолборын төв, Тайжийн хаалганы урд талд София Эх Дагинын сүмийн чулуун барилгын суурийг тавьжээ. Сүм хэдэнтээ шатсан ч түүнийг тухай бүр сэргээн засварлаж улам гоёмсог болгосоор байлаа. Тийм учраас “София Эх Дагина байгаа газар Новгород байдаг.” гэсэн үг гарсан байв.

Новгород хот нь орос нутгийг өрнөдийн орнуудтай холбосон усан замын төвд оршдог хийгээд Цагаан тэнгис хүртэлх өргөн удам нутгийг хяналтдаа байлгадаг нь түүний хөгжилт цэцэглэлтийн үндэс болж байлаа. Хөдөө аж ахуй, гар урлал биш чухамдаа худалдаа арилжаа хотын дотоод болон гадаад амьдралын гол амин судас болж иржээ. Эрхэмсэг ноён Новгород худалдаачдаа германы хотууд, Бухар руу илгээж гар урчуудынхаа хосгүй ур чадварыг гайхуулж байв.

Киев нийслэлтэй Эртний Орос улсыг бий болоход Новгород чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Новгородын Олег ван 882 онд хүчирхэг цэрэг бүрдүүлж Киев хотыг байлдан дагуулж түүнийг Эртний Орос улсын нийслэлээр тунхаглажээ. Новгород нь Киев болон бусад вант улсын хамт Эртний Орос улсын бүрэлдэхүүнд орсон ч ач холбогдол нь буурсангүй. Киевийн вангууд эрх мэдлийн төлөө тэмцэлдээ Новгород хотод олонтаа тVIШиглэж аян дайнд мордохдоо энд ирж цэрэг элсүүлдэг байлаа.

Новгородчууд аж амьдралынхаа хэв маягаар ямагт бие даасан байдалтай байхыг эрмэлзэж байлаа. Тус хотод христос шашны сүсэгтнүүд бөө мөргөлтнүүд зэрэгцэн аж төрж янз бүрийн бүтээгдэхүүн ялангуяа гар урлалын урлангуудаараа алдартай худалдаачин-хот, гурван зуу орчим жил хонхны дуугаар эрчүүд нь цуглардаг байсан цэрэг-хот байлаа. Волхов голын эрэг дагуух шугуйд Васька Буслаев хэрэн тэнүүчилж туульсийн баатар Садко харь олон орноор аялал хийж байлаа.

Новгород хот үнэхээр атаархам баян хот байсан болохоор түүний баялагт шунагчид Өрнө, Дорнодод хаа сайгүй байлаа. София Эх Дагинын сүмийн дундах бөмбөгөр оройны хэрээс дээр залсан төмрөн тагтаа нь хотын сүлд ажээ. Хот ямагт чөлөөт байхыг эрмэлздэг байсан ч тоймгүй олон удаа түймэр, довтолгоон үзэж хатуужжээ. Татар-монголчууд арай ирээгүй ч Балтийн тэнгисийн зүгээс үүл хуйларч аюул заналхийлэхэд орос нутгийн бамбай болж байлаа. Залуу ван Александр Невскийн гавьяа зүтгэл Новгород хоттой нягт холбоотой байлаа.

XII зууны эхээр Киев нийслэлтэй Орос улс бугарч хэд хэдэн вант улс болон хуваагдахад Новгород бие даасан хот болж Эрхэмсэг Ноён Новгород феодалын бүгд найрамдах улс гэж нэрлэгдэх болжээ. Том эдлэн газар эзэмшдэг тайжууд, баян худалдаачид, дээд тушаалын лам нар Новгород хотыг захирч оросын бусад хотоос ялгаатай нь, гаднаас ван урьж улсаа удирдуулна. Түүнтэй тодорхой гэрээ байгуулж вангаар уригдсан хүн хэрээс үнсэж гэрээг хүчинтэй болсонд тооцно. Вангийн гол үүрэг нь хотыг гаднын довтолгооноос хамгаалах явдал байв. Хотын амьдралын бүх асуудлыг сүмийн хамба лам удирддаг Ноёдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Хамба лам Кремлийн эзэн байж хотын сан хөрөнгийг хадгалж гадаад харилцааны асуудлыг эрхэлж худалдааны ажлыг хянана. Ноёдын зөвлөлөөс гаргасан шийдвэрүүдийг хотын чөлөөт иргэдийн хурал болох вече баталгаажуулна.

Урьд нь мэргэн Ярослав вангийн баян тансаг эдлэн газар байсан Ярославийн хашаа нэртэй худалдааны алдарт дүүрэгт Новгородын Бүгд Найрамдах Улсын амьдрал буцална. Вечийн хуралдаан явагддаг энэ дүүрэгт улс төрийн чухал үйл явдлууд болж байсны дотор олон түмэн 1136 оноос үзэн яддаг тайжуудыг хашраахаар эндээс хөдөлж байв. Хотын оршин суугчид цугларсан вече хуралдаан дээр сөргөлдөгч талуудын төлөөлөгчид маргалдаж байдал хурцдахад Волхов голын хоёр эрэг дээр тусдаа хуралдаж гол дээгүүр тавьсан гүүр дээр хоёр талаас явж лам нар салгаж амжихгүй бол цус нөж гартлаа зодолдон занчилддаг байлаа.

Москвагийн вангууд оросын газар нутгийг нэгтгэхийн төлөө тэмцэл явуулахдаа Новгород хотыг хэдэнтээ дайлаар мордож байв. Тухайлбал Москвагийн ван Д.И.Донской хотыг эзлэж Москвагаас хамааралтай болохыг нь анх ойлгуулсан ч новгородчууд эсэргүүцэн тэмцсээр байлаа.

XV зууны далаад оны үед хотын язгууртнуудын зарим хэсэг Литовын ван Казимирийн захиргаанд орохоор завдахад Москвагийн гуравдугаар Иван ван Новгород хот руу дайлаар

мордож Шелони голын эрэг дээр болсон шийдвэрлэх тулалдаанд ялалт байгуулж “христос шашнаас урвасан” зарим язгууртнуудын эдлэн газрыг хураан авч цаазалж заримыг нь цөллөгт явуулжээ. Иван ван хотыг бүрэн захиргаандаа оруулахын тулд сүмийн хамба лам, чөлөөт иргэд, худалдаачдын бүх хөрөнгийг хурааж хотод бүрэн хяналт тогтоожээ. Тэрчилэн Вече хуралдааныг зарлан мэдээлдэг хонхыг буулган Москва руу авч одоход бие даасан байдлаа алдсан новгородчууд нүдэндээ нулимстай харамсан үдэж байжээ.

Цаг хугацаа явсаар, зуун жил өнгөрсөн ч чөлөөтэй аж төрж байсан уламжлалаа новгородчууд мартаггүй байлаа. Түүнээс гадна Догшин Иван хааны үед Ливоны дайн сунжирч хотын байдлыг дордуулж гадаад орнуудтай худалдаа арилжаа хийхэд саад болж байгаад новгородчууд дургүйцэл эсэргүүцлээ ил тод илэрхийлж байв. Бие даасан байдлаа сэргээх гэсэн новгородчуудын эрмэлзлэл тэмүүллийг нуга дарахын тулд Догшин Иван хаан цэрэг хөдөлгөж нэгдүгээр сарын 2-ны өдөр хотыг бүсэлж хотын захын сүм хийдийг эзлэж бүх эд хогшилыг нь булаан авч таван зуу орчим ламыг олзолжээ. Тэрчилэн хотын олон зуун айл гэр бүлийг мөн олзлон авч байшин, аж ахуйг нь битүүмжлэв.

Дөрвөн өдрийн дараа Логшин Иван хаан, ханхүү Иван, 1500 бууч дагуулан ирж олзонд авсан лам нарыг саваагаар зодож занчиж баривчлагдсан хотын иргэд, худалдаачдыг тамлан цаазалж эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг гулдчин чирсээр Волхов голын мөсөн дээр аваачиж модон алхаар толгойд цохин ухаан алдуулаад харзны усанд живүүлэн алжээ. Энэ аллага нийтдээ таван өдөр үргэлжилжээ.

Хаан ойрын хамтран зүтгэгчидтэйгээ цуг аймшигт аллага үйлдсэний дараа бүх сүм хийдийг дээрэмдэж дараа нь түймэрдэх, мал, тарианы агуулахыг хураах, эмэгтэйчүүдийг хүчиндэх, хотын эргэн тойронд 250 мод газарт байгаа бүх тосгон гацааг хуу тонож хүнгүй болгох зарлиг буулгаж байлаа.

Гэвч Новгород хот сөнөсөнгүй, түүхийн бүх хатуу ширүүн сорилт шалгалтыг даван туулж алдар суугаа мөнхжүүлсээр өнөөг хүрсэн билээ.

## КРАКОВ

Польшчууд сайхан, ашигтай бүхэн нэгмөсөн бий болдоггүй гэдэг хэллэгийг иш үндэс болгож “Краков хот шууд бий болоогүй.” гэж ярьцгаадаг. Польшийн эртний хот Краков хоногийн аль ч цагт, цаг агаарын ямар ч нөхцөлд сэтгэл булаам сайхан харагдана. Өглөө эрт Висла мөрний зүгээс бүрхэх манан эл хуль гудамж, цэцэрлэгт хүрээлэнд аажим нэвтэрч үд дунд нар Захын талбайд эгц дээрээс төөнөж Марьяцкийн сүмийн цамхагаас бүрээний дуу уянгалан хадна. Чухамдаа ийм үед вавелийн лууг ялан дийлсэн эрэлхэг зоригт Крах вангийн тухай домог санаанд бууна.



Крак ван дайн байлдааныг зогсоож бүх анхаарлаа улс орноо тохинуулахад хандуулж Висла мөрний эрэг дээр шилтгээн босгож түүний аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хот байгуулж өөрийнхөө нэрээр нэрлэжээ.

Гэтэл гай газар дороос гэгчээр Вавелийн дов дор могой ч юм шиг, луу ч юм шиг хачин жигтэй ховдог амьтан бий болж тариачдын мал, заримдаа хүн барьж идэж хотын оршин суугчид айж эмээснээс гэр орноосоо гарахаа байж дүрвэн одож эхлэжээ. Тэгээд Крак ван үхэр төхөөрч маханд нь хүхэр, давирхай, цагаан лав шингээж өнөөх аймшигт амьтанд хаяж өгчээ. Луу хаяж өгсөн үхрийн махыг залгин идэж, гэдэс дотор нь түлэгдэж амь тавьжээ.

Ард олноо түмэн зовлонгоос ангижруулсан Крак ван улс орноо олон жил ухаалаг удирдаж өндөр наслажээ. Шудрага их үйлсэд нь баярлаж талархсан олон түмэн түүнийг өөд болоход өндөр хүндэтгэлтэй оршуулж түүнийг хойч үе бахдан дурсаж байхаар бодож ойр орчмын бүх дов толгодоос өндөр элсэн овоо босгожээ.

Краков хотын тухай анхны бичмэл эх сурвалж VIII-IX зууны үед хамаарна. Тухайлбал арабын худалдаачин-аялагч Ибрагим ибн-Якуб “Кароко” хотын тухай бичихдээ түүний худалдааны харилцаа “оросууд, Константинополь” хүрдэг байна гэж магтсан байдаг. Хоёрдугаар зуунд александрийн эрдэмтэн Клавдий Птоломей нэгэн тэмдэглэлдээ Висла мөрний эрэг дээрх Карродунум хотын тухай дэлгэрэнгүй бичсэн бий.

XI зуунд Краков польш улсын нийслэл болон тодорч байсан үеэс тус хотын түүх эхлэдэг. XIII зуунд тус хотод ирж байсан хүмүүс “Краков нь цамхаг, буудлагын нүхүүд бүхий хоёр давхар



хэрмээр хүрээлэгдсэн, олон сайхан байшин, том сүм хийдтэй хот юм.” гэж бичиж үлдээжээ.

Польшийн Их Казимир хаан “модон” эх орон хүлээн авч “чулуун” болгож дараачийн үедээ өвлүүлсэн гэж ярьдаг нь юуны өмнө Краков хоттой холбоотой билээ. XVI зууны дунд үед Их Казимир хаан Вавелийн довыг өргөтгөж шинэ сүм, шинэ өргөө босгожээ. Дараа үеийн хаан бүр өргөөнд роман, гот, барокко гээд олон дэгийн шинэ байшин залган бариулж байжээ.

Дундад зууны үед хотын захиргааны байр, Сукенницы, Жингийн танхим, есөн шинэ сүм нэгэн зэрэг баригдаж хотын цайз, хэрэм өргөжин тэлсээр байлаа. Харамсалтай нь XX зууны эхээр хотыг тойруулан барьсан хэрэм, даланг нураажээ. Гэвч Краков хотод Флорианы гулдан хаалганы дэргэд далангийн хэсэг үлдсэн нь Европ тивд байгаа гот хийцийн хэдхэн нэн ховор дурсгалуудын нэг болж байдаг юм.

Флорианы гулдан хаалгаар ороход өмнөд тал нь Захын талбайд тус орны хамгийн цуутай гот хийцийн сүм болох Марьяцкийн сүм байрлаж байгаа хамгийн эртний, сайхан гудамжуудын нэг өөдөөс угтана. Марьяцкийн сүмийн 81 метр өндөр цамхаг цагтаа тус хотын хамгийн өндөр байгууламж байсан учир шашны байгууллагын биш, хотын захиргаа мэдэлдээ авчээ. Уг цамхагийн дээр зогсож байгаа бүрээчин дохио өгөхөд бусад цамхаг дээр байгаа бүрээчид хариу дохио өгнө. Бүрээний дуу сонссон оршин суугчид зэр зэвсгээ агсаж яаравчлан цуглардаг байжээ.

Жил бүр долоодугаар сард “Краковын өдрүүд” болохын өмнө дундад зууны үеийн ёслолын хувцас өмссөн хүмүүс гудамж талбайгаар явж баярын хөтөлбөрийг чангаар дуудан танилцуулна, олон нийтийн баяр ёслолын гол баатар татар үндэсний хувцсаар гоёж Лайконик захын талбай дээр морины явдлыг санагдуулсан хэмнэлтэй цоглог бүжиг хийнэ.

XIII зууны үед татарын халдан түрэмгийлэгчид Польш оронд халдан довтлохдоо Краков хотын дайрч бүслэлт хийсэн ч эзлэж чадахгүй удаан саатжээ. Татарчууд нэгэн удаа үүрээр хотын хэрэм рүү сэмхэн дөхөн ирж байгааг Марьяцкийн сүмийн харуул илрүүлж түгшүүрийн дохио өгч амжсан ч харвасан сум хоолойг нь нэвт хатгаж амь эрсэджээ.

Тийм учраас өнөөдөр цаг болгон цамхаг дээр бүрээчин гарч ирж польшийн рыцариудын эртний цэргийн дуу болох “гейнал”-ийг үлээнэ. Тэрбээр ертөнцийн зүг бүр рүү харж бүрээгээ үлээж байснаа эрт дээр цагт харуул амь эрсэдсэн шиг гэнэт таг дуугүй болно. Өдрийн 12 цагт бүх польш орон даяар “гейнал” дууг бүрээдэж Краковын одон орныг судлах оргилоос яг таг цагийг зарлана.

Захын талбайн зүүн-хойд хэсэгт XIII зууны хоёрдугаар хагаст эхэлж 1383 онд барьж дуусгасан Хотын захиргааны байрны цамхаг бий. Анх үр тариа хадгалах зориулалтаар ашиглаж байсан цамхагийг хэсэг хугацааны дараа шорон болгон хувиргажээ. Хачирхалтай нь дэргэд нь байрлах “Свидница” зоогийн газарт хүмүүс дарс, шар айраг ууж хөгжилдөн хашгиралддаг байжээ.

Хотын захиргааны байрны нэгдүгээр давхарт орших Ноёдын танхимд Краков хотын үнэт зүйлсийг авдарт хадгалдаг байжээ. Уран зураг, үнэт даавуугаар чимэглэсэн, хана дагуу дэр эгнүүлэн тавьсан урт сандал бүхий Ноёдын танхимд польшийн хаад Краков хотын иргэд

тангарагийг хүлээн авдаг байв.

Хотын захиргааны байрны хажууд найман зуу гаруй жилийн түүхтэй нийтдээ 100 метр урт, налуу дээвэртэй, худалдааны лангуутай Сукенницы худалдааны зах байна. Хоёрдугаар давхарт нь бүжгийн болон хүлээн авалтын том танхимуудаас гадна 1870 онд польшийн алдарт зохиолч Ю.Крашевскийн ойн үеэр нээсэн Польшийн уран зургийн галарей бий.

XIV зуунд Ягелло хаан Гэгээн Аннагийн гудамжинд худалдан авсан хэд хэдэн байшинд Польш улс дахь анхны их сургуулийг байгуулжээ. Их сургуулийн хэд хэдэн байшингуудаас Коллегиум Майюс (“Том зөвлөл”) байшин л өнөө үе хүртэл хадгалагдан ирсэн агаад энэ байшинд доктор Фауст суралцаж Н.Коперник судалгаа шинжилгээ хийж байжээ.

Эрт дээр үед Краков хотоор худалдааны зам дайрдаг байсан болохоор газар их үнэтэй болж байшин барилгыг өндөрсгөдөг байжээ. Гудамж, талбайгаар явахад эрт дээр үеийн хот гэсэн сэтгэгдэл өөрийн эрхгүй төрнө.

Дэлхийн хоёрдугаар дайны үед Краков хотод фашистуудын засаг захиргаа байрлаж Вавелийн шилтгээнд польшийн үндэсний үнэт баялгийг тонон дээрэмдэгч амбан захирагч генерал Г.Франк сууж байв. Марьяний шүтээний уран сайхны үнэ цэнийг мэддэг фашистууд түүнийг буулгаж Герман руу зөөхөөр завдаж байжээ.

Гитлерчүүд Вавелийн шилтгээнд хэд хэдэн барилгыг нураасан хийгээд нэгдүгээр Зигмунд хаан, Бона гүнж хоёрын цуутай тансаг хурим болж байсан “Хааны гал зуух” хэмээх гоёмсог цогцолборын буурин дээр засаг захиргааны байраа барьсан байжээ. Их Казимир ван, Ядвига хатны ёслолын танхимуудыг шар айрагны газар болгон хувиргаж Сенатын танхимд кино үздэг болж Хааны цэцэрлэгт хүрээлэн дотор бетон цутгаж усан сан байгуулжээ.

Фашистууд Краков хотын гүүр, хуаран, нисэх онгоцны буудал, газар доорх шугам сүлжээ, бүх засмал замыг минжүүлж дэлбэлэхээр зэхэж байсан ч зөвлөлтийн цэрэг шургуу давшиж хотыг чөлөөснөөр фашистууд хотыг тэнгэрт хийсгэж газартай тэгшлэх бузар төлөвлөгөөгөө хэрэгжүүлж амжаагүй билээ.

## ТЕГЕРАН

Тегеран хот нь IX зууны үед анх үүссэн, гэхдээ өнөөдөр дагуул хот нь болсон, тухайн үед баян хот байсан хөрш эртний Рей хотоос хамааралтай байжээ гэж эрдэмтэд таамагладаг юм. Гэтэл XII зуунд байсан бяцхан тосгоноос Тегеран үүсэлтэй гэж зарим эрдэмтэн зүтгэдэг.



Тегеран нь XIII зууны эхэн үе хүртэл хүчирхэг Рей хотын нөлөөнд байжээ. Хотын оршин суугчид харийн түрэмгийлэгчид довтолж ирэхэд булгийн цэвэр устай, урьдчилан хүнсний зүйл хадгалсан агуйнуудад орж хоргодон нуугддаг байжээ.

1220 онд монголчууд халдан довтолж Рей хотын дийлэнх оршин суугчид дүрвэж Тегеран хотын агуйнуудад очиж нуугджээ. Монголчуудын түрэмгийллийн хор уршгаар Рей хот дахин сэргэсэнгүй, харин Тегеран хот газар зүйн ашигтай байрлалынхаа буянгаар улам хөгжжээ.

XIV зуунд Тегеран худалдааны томоохон төв болон хувирсан бөгөөд XVI зууны сүүлчээр Тасмаспа шах зарлиг буулгаж хотыг тойруулан 114 цамхагтай 6000 алхам урт том хэрэм босгосноор хот болон төлөвшжээ.

XVII зуунд гурван мянга орчим байшин бүхий шавран хот байв. 1729 онд Надир шах хотыг афганчуудаас чөлөөлж бас гучин жилийн дараа Ираны хаан Керим-хан Занд хотыг ирж үзээд байрлал нь их таалагдаж нийслэл хотоо болгох гэснээ удтал эрэгцүүлэн бодсоны эцэст больж Ширазыг нийслэл хэвээр нь үлдээжээ.

Кажарын угсааг үндэслэгч Аг Мохаммед-хан XVIII зууны сүүлчээр 1785 онд хорь орчим мянган хүн амтай Тегеран хотыг бүслэлт хийж эзлэн авсны дараа түүний цэрэг-стратегийн оновчтой байрлалыг иш үндэс болгон Иран улсын нийслэлээр зарлажээ. Тэрбээр морин цэргийн том армийг нь тэжээж болох уулсын өмнөх өвс ногоо элбэг билчээр тэрчилэн олон мянган хүнтэй армийг нь хоол хүнсээр хангаж болох үржил шим сайтай газар нутагтай мужуудад ойрхон байгаад нь их олзуурхжээ.

Тегеран нийслэл хот болсноор олон ордон, шилтгээн, цайз, лалын шашны сүм баригдсанаас хамгийн сүрлэг нь Шахын сүм байв. XIX зууны дунд үеэс хотын хүрээ тэлж түүнийг тойруулан хэрэм барихдаа хотоос гарах 12 зам руу салаалсан 12 гулдан хаалга хийсэн байв.

Шөнө дунд 12 цагт их буугаар буудаж жингийн цуваа, аялагчдад хотын 12 гулдан хаалгыг хааж байгааг мэдэгддэг байлаа.

Дэлхийн нэгдүгээр дайны дараа Тегерен эрчтэй хөгжиж байсан ч дорно зүгийн хотуудын өвөрмөц шинжийг хадгалсан, 200 мянган хүн амтай хоёрдугаар зэргийн хот байв. Хотын төвд гэмт хэрэгтнүүдийг цаазалж байснаараа нэрд гарсан Топхане (Их бууны) талбай оршино, түүнээс хэд хэдэн өргөн гудамж салаална. Хотын шавран ханаар заагласан бусад дүүрэгт шороо тоос бургисан, заваан балиар давчуу гудамжууд байна.

1930 онд Тегеран хот Иран улсын засаг захиргааны гол төв болон хувирсныг хот шинээр мэндэлсэн гэж үзэж болно. Хотын зарим дүүргийн нүүр царай эрс өөрчлөгдөж төв болон хойд дүүргүүдэд шавар байшингуудын оронд шинэ өндөр барилгууд сүндэрлэн босчээ. Хотын хүрээ хойд зүгт Шимран буюу “сэрүүн нутаг” руу тэлэв. Ер нь бол Тегеран гэдэг үг нь “халуун нутаг” гэсэн утгатай ажээ.

Тегеранд орчин үеийн хийцийн байшингууд босгож байсан ч хавтгай дээвэр, хүнхгэр цонх, хаалга, ханын гадаад өнгөлгөөнд шигтгэмэл хээ угалз гаргах гээд дорнын уран барилгын өвөрмөц хэв маягийг мөн оруулж байв. Сүүдрэвч, усан оргилуур бүхий усан санг орон сууцны төдийгүй засаг захиргаа, албан байгууллагуудын байшингуудын хашаанд мөн барьж байв.

Хотын уран барилгын дүр төрхөнд хуучны шинж төрх бүрмөсөн алга болж ялангуяа хэрэмний 12 гулдан хаалганаас ганц нь ч үлдээгүйд хотын ахмад оршин суугчид ихэд харамсдаг. Гэхдээ гулдан хаалгануудын Дарвазе Казвин, Дарвазе Давлати зэрэг нэрээр хотын шинэ хорооллуудыг нэрлэснийг дурдах нь зүйтэй биз ээ. Давчуу нарийхан гудамж, шавран байшинтай хэд хэдэн хороолол л хотын өмнөд хэсэгт үлджээ.

Тегеран хотын захад Аятолла Хомейни амьдралынхаа сүүлийн жилүүдэд сууж байсан бяцхан байшин бий. Хорооллын нарийхан гудамжаар явахад XIX зууны үед барьсан хуучны жижиг байшингууд хоорондоо шахцалдан байрласан байна. Тийм нэгэн даруухан байшинд Хомейни сууж байв. Гаднах шатаар нь өгсөж байшин ороход жижигхэн өрөөнд зөөлөн буйдангийн өмнөх олбог дээр гэрийн эзний шаахай байна.

Аятолла Хомейнийн гэр энгийн даруу байдлаараа гайхаш төрүүлэх бол түүнийг оршуулсан сүм сүрлэг байдлаараа бүр их шохоорхол татна. Аятолла Хомейнийн дурсгалд зориулан босгосон лалын сүмийн бөмбөгөр орой, дөрвөн цамхаг алсаас тод харагдана. Хомейний бунханг мөргөлийн үед мянга орчим хүн багтах уужим танхимд байрлуулжээ. Хувьсгалын үед тэмцэгчдийн урсгасан цус, лалын шашны өнгийг билэгдсэн улаан, ногоон өнгийн даавуугаар бунхныг бүтээжээ. Бунхны булангуудад сараалжны завсраар сүсэгтнүүдийн өргөсөн цаасан мөнгө дүүрчээ.

“Мянган нэгэн шөнийн үлгэр” номын нөлөөгөөр бидний сэтгэлд бий болсон дорно зүгийн гайхамшигт хот гэсэн сэтгэгдэл Тегеран хотыг хараад алга болно. Дорно дахь олон улсын ажил хэргийн томоохон төв болон хувирсан хотын хороолол, дүүргүүд нь төрх байдлаараа жирийн нэгэн европийн хотыг санагдуулна. Гэхдээ дорнын хотын дүр төрхийн гол шинж болох зах нь түүний дорнын хот болохыг гэрчилнэ. Хоёр зуу гаруй жилийн тэртээ байгуулагдсан зах руу ороход худалдагч, худалдан авагчдын халуун маргаан, хөл нүцгэн зарц

хөвгүүд, бараагаа борлуулах гэж аргаа барж байгаа наймаачид, элдвийг сонирхогчид гээд элдэв дүр зураг харагдаж чих дүлийрэм шуугиан хадна.

Дэлхийн хамгийн том зах гэж алдаршсан энэ зах дээр авьяаслаг гар урчуудын хосгүй чамин бүтээлүүд, исфаганы паалангаар урласан эд зүйлс, Ширазын шигтгэмэл, кушаны хивс, даавуу, үнэртэн, гоёлын эд зүйлс гээд байхгүй юм огт үгүй ажээ. Энд тус орны бүх муж, хотоос ирсэн худалдаачид, худалдан авагчид өвөрмөц аялгуугаар шулганалдана.

Тегераны захын лангуунууд Зэсийн, Хивсний, Мөнгөн, Сав суулганы гэх зэрэг нэртэй хийгээд хэдэн километр үргэлжилнэ. Захын зарим хэсэг эрт дээр үед нуман хэлбэртэй байгууламжаар чимэглэгдсэн агаад дэлгүүрүүдийн дээврүүд хоорондоо завсаргүй нийлсэн болохоор захыг саравчаар битүүлсэн мэт сэтгэгдэл төрүүлнэ. 1950 оны үед захад нэгэн шинэчлэл хийхдээ зарим худалдааны лангууны нурж унах дөхсөн оройг шилэн хучлагаар сольжээ.

## РОСТОВ

Самуун цагийн тууж” хэмээх эртний сударт 862 оны орчим “Алдар нь түгсэн Ростов хот” гэж дурдсан бий. Гэхдээ хуучны судлаачид малталт хийж тэнд бүр өмнө үед хүн амьдран сууж байсныг тогтоожээ. Ижил мөрний хойд нутаг хавиар амьдран сууж байсан славяны меря омгийнхон нүүдэллэн өнөөгийн Ростов хотын ойролцоо сууршиж ан хийж, загас барьж, тариа тарьж тэрчилэн арьс шир боловсруулах, дархны, цутгах ажил эрхэлдэг байв.



X-XI зуунд ростов нутагт новгородын словене, кривичи омгийнхон нэвтэрч меря омгийнхон яваандаа славянчуудад уусаж байхгүй болжээ. Новгородчууд шинэ нутагт сууршсан ч өвөрмөц ёс заншил, дэглэм журмаа баримталж байв. Тийм учраас вангийн эрх мэдлийг хязгаарласан, газар эзэмшигч тайжуудын нөлөө ихтэй удирдлагын байгуулал Ростовг эрт дээр үеэс уламжлал болон иржээ.

Алс тэртээ, битүү ойн дунд орших Ростов хот улс төрийн чухал үйл явдлуудаас хол байж вангууд хааяа л зам зуур буудаллана. Хот XI зуунаас л зөвхөн хөгжин цэцэглэжээ. Юрий Долгорукий ван Ростов хотод “Их” гэсэн алдар хүртээсэн ч вангууд нь Новгород, Владимир хожим нь Суздаль хотод амьдардаг байлаа. Хүн ам олонтой, баян хотод вангууд яагаад сууршихгүй байв гэдэг нь их сонирхол татдаг. Ростовын тайжууд эртнээс ширүүн ааш зантай, оршин суугчид ч дандаа л хэл ам таталж зарга маргаан хийдэг учраас тэднээс айж эмээдэг байсан бололтой.

Гэвч энд нийслэлийн шуугиант амьдралаас алсад сүм дуган босгож Москва үүсээгүй байхад христосын соёлыг бий болгож байлаа. Ростовын лам нар өндөр боловсролоороо, сүм хийд нь номын сангуудаараа гайхагдаж байлаа.

Оросын эртний хотуудын нэг болох Ростов хуримтлуулсан баялаг, алдар нэрээрээ Новгород, Киев хотуудтай өрсөлдөж байсан тул түүнийг дайтаж үгүйрүүлэн хоосруулах муу санаатнууд цөөнгүй байлаа. Неро нуурын эрэг дээр татар-монголчууд, литовчууд, польшууд, шведүүд буудаллаж хотыг эзлэн сүйтгэж байсан ч Ростов тухай бүр нурам, балгаснаас сэргэн босож байлаа.

Константин Всеволодович ван (XII зууны сүүлч-XIII зууны эх) Дорнод-Оросын нийслэл хотыг

Владимираас Ростовг хэсэг хугацаанд шилжүүлэн байх үед хот ихээхэн хөгжжээ. Ванг өөд болсны дараа Дорнод-Оросын вант улс гурав хуваагдаж Ростов ван Василькогийн захиргаанд шилжжээ.

Ростовын Василько ван татар-монголчуудтай хийсэн байлдааны үед олзлогдож Бат хааны төлөө зүтгэхийг шаардахад “Манай эх орон, Христос бурхны дайснууд миний анд нөхөд биш.” гэж татгалзсан учир татарчууд түүний толгойг цавчин алжээ. Бэлэвсэн хатан нь хандмаа болж хотын захад Спаса-на-Песках сүм бариулж суусныг сүсэгтэн олон Хатны сүм гэж хүндэтгэн нэрлэжээ. Хожим нь хоёрдугаар Екатерина хатан хааны зарлигаар Яковлевскийн сүмтэй нэгтгэж Спасо-Яковлевскийн сүм болгожээ.

Ростов хотын эргэн тойронд нов ногоон зүлэг ногоо халиурч алсаас эртний сүм дуган цагааран харагдана, харин хотын төвд хэдэн арван ганжир бүхий Кремлийн ордон сүндэрлэнэ. Тариачин гаралтай, уран сайхны нарийн мэдрэмжтэй хамба лам Ион Сысоевичийн нэртэй цагаан чулуун Кремлийн түүх холбоотой. Тэрбээр Москвад сүмийн дэг журам сахиулагчаар ажиллаж байхдаа төрөлх хотынхоо уран барилгын дэгийг сайн мэддэгийн хувьд олон зүйлийг ажиглан харжээ. 1664 онд нутагтаа буцан ирээд өргөө болох сүм барихаар бодохдоо хотын төвд сүндэрлэн байгаа Успеный сүмтэй нэгэн цогцолбор болгохоор шийджээ.

Успеный сүмд бурхны хэрээсний модны хэсэг бүхий агар модон хэрээс, Владимирийн Эх Дагинын гайхамшигт зураг, гэгээнтэн Леонтий, Феодор болон ван Василько нарын занданшуулсан шарилууд тэрчилэн гэгээнтэн Исайи, Игнатий нарын занданшуулсан шарилууд, нийтдээ гэгээнтнүүдийн 150 орчим занданшуулсан шарил зэрэг ариун шүтээнүүд хадгалагдаж байлаа.

1160 онд Успеный сүм шатаж дахин босгосон нь бас галд сүйджээ. XVI зууны хоёрдугаар хагаст Москвагийн Успеный сүмийн дэгээр дахин барьжээ. Энэ сүм нь асар том ч уужим цэлгэр, хэмжээний зохицлын хувьд төгс, ханын бурхны зургийг Ярославь, Кострома хотуудын уран гартнууд үнэхээр бахдам сайхан бүтээжээ.

Чухамдаа уран барилгын тийм гайхамшигт бүтээлийн дэргэд хамба лам Иона Сысоевич өргөө болох сүм барихаар зоригложээ. Барилгын ажил эрчтэй урагшилж үлгэрийн гэмээр чулуун барилгууд дараалан сүндэрлэн босно. Хамгийн түрүүнд Владычийн хашааны өмнөд хэсэгт гол хаалга нь хойд талдаа Спас-на-Сенях (үнэн алдартны шашны сүмд гол хаалгыг баруун талд нь гаргадаг) сүм 1675 онд босов. Цагаан танхим баруун талд нь тулж байсан учир сүмийн хаалгыг хойд талд нь гаргасан ажээ.

Сүмийн ханыг Хуучин Гэрээнээс сэдэвлэсэн “Цовдлолт”, “Хэрээснээс буулгасан нь”, “Авс дотор байрлуулсан нь”, “Дахин амилсан нь” зэрэг зургуудаар чимэглэсэн байв. Баруун хананд нэлэнхүйд нь зурсан “Аймшгийн шүүх” зураг сүсэгтнүүд төдийгүй жуулчдын анхаарлыг их татна. Тамыг дүрэлзсэн бөөн галаар зүйрлэж голд нь ахмад чөтгөр суучихсан, өвөр дээрээ шуудайтай мөнгө барьсан Иудуг суулгажээ. “Аймшгийн шүүх”-ийг дүрслэхдээ бодит байдлаас ургуулан бодож нүгэлтнүүдийн тарчлааныг алуурчид шорон дотор хүмүүсийг тамлаж байгаагаар гаргажээ.

Зүүн хананд христосын шашныг түгээн дэлгэрүүлэгчдийг дүрсэлсэн хийгээд тэд нараас гартаа диваажингийн түлхүүр барьсан Гэгээн Павелийн дүр бусдаасаа онцгой сайхан, сэтгэл булаам болжээ.

1690 он гэхэд Дахин Сэргэлтийн сүм, Иоанн Богослов, Григорий Богослов нарын сүмийг барьж дуусгажээ. Сүмийн цогцолборыг тойруулан хэрэм босгож мөн Хамба ламын өргөө, “их хаадыг байрлуулах өргөө” болох Улаан танхим, Иерарын танхим зэрэг хэд хэдэн байгууламжийг барьжээ.

Ростовын Кремлийн түүхэнд олон үйл явдал болж байлаа. Кремлийг босгож өндөр нэр хүндтэй байх үед нь хамба лам Иона Сысоевичийг Ярославль хот руу шилжүүлсэн үеэс уналтын байдалд оржээ. Эртний үнэт судар ном, гар бичмэлүүд, архивын баримт бичгүүд хайхрах эзэнгүй болсноор алдагдаж үрэгдэж байв. Кремлийн барилга байгууламжуудыг ялангуяа цамхаг, жижиг сүмүүдийг өөр зориулалтаар ашигладаг болжээ.

XIX зууны эхээр цогцолборыг бүхэлд нь нурааж буурин дээр нь их дэлгүүр барихаар шийджээ. Аз болоход Часобитны цамхагийн дээд хэсэг, Улаан танхимын хоёрдугаар давхрыг нь л нураасан үед дээрх шийдвэрийг цуцалжээ. Ростовын худалдаачид Кремлийн бараг бүх байгууламжийг агуулах болгон хувиргажээ. Цагтаа олны бахархлыг төрүүлж байсан Улаан танхимд ханын гайхамшигт зургуудыг арилгаж дараа нь цоолж тавиурууд хийж дарс, давс хадгалдаг болсон байлаа. Ростовын Кремль бараг тавин жилийн турш уруудаж байсан ч 1870 оноос түүнийг сэргээн засварлах ажлыг төлөвлөгөөтэй хийж эхлэжээ.

Өнөө үед Ростовын Кремль гадна байдлаараа асар том сүмийг санагдуулна. Эрт дээр үеэс сүмийн хамгаалалтын байгууламжийн зориулалтаар барьдаг бол энд тэр зарчмаас ухарч эргэн тойрон гуу жалга ухсангүй, сараалжин гулдан хаалгагүй, буудлагын цамхаггүй барьсан ажээ. Ростовын Кремль амьдран сууж байсан хүмүүсийнх нь хүчин чадал, эрх мэдлийн билэгдэл болсон шилтгээн шиг харагдана.

Өнөөдөр Ростов нь Ярославль мужийн хөдөөгийн нэгэн дуу шуугиан багатай хот болжээ. Хот руу дөхөн ирэхэд нуурын уснаас сугаран гарч байгаа юм шиг хотын сэтгэл бахдам дүр төрх нүдний өмнө тодорно.



## КИЕВ

Буурал Днепр мөрний дээр орших өндөр уул дээр Богдан Хмельницкийн нэрэмжит өргөн, сүрлэг талбай байна. Тэгш, цэвэрхэн талбайгаар трамвай, троллейбус зөрөлдөх боловч эргэн тойрныг нягтлан харвал бүх зүйл эрт цагийг санагдуулна. Талбайгаас холгүйхэн Владимирийн гудамжны зүүн талд Мэргэн Ярослав вангийн хаанчлалын үед 1037 онд байгуулсан Алтан хаалганы үлдэгдэл байна. Түүний цаана Мэргэн Ярослав вангаас татарчуудыг дийлсэн ялалтын дурсгалд зориулсан босгосон София Эх Дагинын сүм байна.



Киев шиг үүсэл гарал нь түүхч, хуучныг судлаач, хуучныг сонирхогчдын дотор олон жилийн халуун маргаан өдөөсөн хот дэлхийд маш цөөхөн биз ээ. Тэр маргааны эхийг түүхч Нестор “Одоо цагийн тууж” номондоо тавьж найдан Андрей Нэгдүгээр зуунд Днепр мөрний сав газраар аялал хийж яваад өнөөгийн Киев хот оршиж байгаа нэгэн уул дээр гарч ирээдүйн хотын билэг тэмдэг болгон хэрээс зоожээ гэсэн домгийг дурдсан бий.

“Одоо цагийн тууж” ном 862 оноос Эртний орос улсын нийслэл болсон Киев хотын түүхээр эхлэдэг юм. Өнөөгийн Киев хотын нутаг дэвсгэр дээр манай эриний өмнөх нэгдүгээр зуунд хүн амьдарч байсныг хуучны судлалын малталтаар лавтай нотлоод байна. IV зуунаас славян хүн ам энд байнга суудаг болсноос хойш хот хүрээгээ тэлж хөгжиж байжээ.

Гэхдээ хотын уугуул иргэд хэн байсан талаар маргаан өнөөдөр ч тасраагүй байна. Энд славянчууд биш сармат, гот, гунн, норманн, аварчууд анх сууршиж байсан гэж үзэж холбогдох нотолгоог гаргадаг эрдэмтэд бий. Эртний скандинавын эх сурвалжийг иш үндэс болгон Киевийг готуудын домогт нийслэл болох Данпарстад хоттой харьцуулдаг. “Готын Германарих хаан Сванхильда хэмээх бүсгүйг хатнаараа өргөмжилсөн ч түүнийг тамлан алжээ. Хамди түүний хоёр дүү эгчийнхээ өшөөг авахаар замд гарч Готын хааны нийслэлд ирээд “Готын хааны ордон, өндөр эргийн налуу”-г харжээ.” гэж “Эгч Эдда” зохиолд бичсэн байдаг. Г.Вигфуссон зэрэг судлаач “Эгч Эдда” зохиолд гардаг “djurat” (гүнзгий) гэсэн үгийг “Danpar” (Днепр) гэж орчуулж Днепр мөрний эрэг дээр Германарих хааны өргөө, Киев хот хоёрыг нэг утгатай гэж тайлбарлаж байна.

“Атила хааны тухай дууль”, “Херварасаге”, “Хльод, Ангантын тухай дууль” зохиолуудад Данпарстадын тухай дурдсан байдаг ч тэр нь Днепр мөрний эрэг дээр байсан готуудын улс

төрийн төвийн тухай баримт болохоос биш орчин үеийн Киев хотын нутаг дэвсгэр дээр байрлаж байсны нотолгоо биш юм.

Киев хотыг ах дүү Кий, Щек, Хорив гурав үндэслэсэн тухай эртний домог эртний оросод анх бий болж дараа нь хөрш зэргэлдээ орнуудад түүний дотор өрнөдийн славянчуудын дунд өргөн дэлгэрч хожим нь славян бус ард түмнүүдийн дотор тархжээ.

Анхандаа бяцхан хот байсан Киев нь Поляны омгуудын холбооны төв байв. Цаг хугацаа өнгөрсөөр славян ард түмнүүдийн холбоо Эртний орос улс болон хувирч түүнтэй уялдан Киев хот хүрээгээ тэлж аажимдаа “эзэнт гүрний том хот” болон алдаршжээ.

IX зууны дунд үед Киев хотыг Кий угсааны хаадын сүүлчийн хаан Аскольд захирч байв. 862 онд Новгородын Олег ван “Киевийн уулсад ирж” хотын сайхныг бахдаж тэр даруй байлдан эзлэж Орос улсын нийслэлээр зарлаж “Оросын хотуудын эх хот болсугай!” гэсэн алдарт үгийг хэлжээ.

Киев хот нь дулаан уур амьсгал, үзэсгэлэн төгс байрлалтай, баян тансагаас гадна Днепр мөрөнд Припять, Десна хоёр том гол цутгадаг тэр газар оршдог, дорно зүгээс довтолж болзошгүй нүүдэлчин аймгуудаас хамгаалалт хийх тохиромжтой нутаг байжээ. Эндээс мөн оросын завиудыг цуглуулан нэгтгэж Хар далайн зүг аялалд явуулах боломжтой байв.

Олег вангийн хаанчлалын жилүүдэд Орос улс Хазарын эзэнт гүрнээс хамааралтай байснаа салсан нь үнэхээр томоохон үйл явдал болсон юм. Олег ван Царьград хот руу 907, 911 онуудад хоёр удаа дайралт хийж тухай бүр ялалт байгуулж 911 онд Орос-Византийн гэрээгээр Киев хотыг Орос улсын нийслэлээр хүлээн зөвшөөрүүлжээ.

Олег вангийн залгамжлагч Игорь ван, Ольга хатан хааны үед Киев хот өргөжин хөгжиж байсан ч модон хот хэвээр байлаа.

Эртний Орос улс түүний нийслэл Киев хотын түүхэнд ван Святослав яруу тод хуудсыг нээсэн билээ. Тэрбээр эрэлхэг цэргүүдээ удирдан Ижил мөрнөөс Дунай мөрөн хүртэл аян дайн хийж оросын зэвсгийн алдар сууг мандуулжээ. Святослав ванг алсын нутаг аян байлдаан хийж Киев хотод ховорхон суудгийг далимдуулж Печенегийн хаан 968 онд Киев хотыг бүслэж хотын иргэд цэвэр усны нөөцөө дуусаж хэцүү байдалд орсон үед Претич тайжийн удирдсан цэргүүд ирж бүслэлтийг сэт цохиж хотыг аварчээ.

Оросын туульсын үлгэрт Улаан нархан гэж нэрлэдэг Владимир вангийн хаанчлалын жилүүдэд эртний оросын өвөрмөц соёл үүсэн хөгжиж Киев хот цэцэглэв. Киевийн уул дээр оросын ард түмэн христос бурхны ариун шашныг өнө мөнхөд бишрэн шүтэхээ илэрхийлж байв.

X зууны сүүлч-XI зууны эхээр Киев хот эрчтэй хөгжиж байсныг тэнд зорчсон гадаадын аялагч, элчин сайд, худалдаачид цөм нэгэн дуугаар магтан шагшиж байснаас Саксоны түүхч Т.Меркербургский “Киев хэмээх том хотод дөрвөн зуу орчим сүрлэг сайхан сүм хийд байна.” гэж бичиж үлдээсэн байна.

Киев хотын түүхэнд Оросод болон гадаад орнуудад Мэргэн гэж хүндэтгэн нэрлэдэг байсан Ярослав ван бүхэл бүтэн үеийг төлөөлж байдаг юм. Вангийн хаанчлалын жилүүдэд Киев хил хязгаараа тэлж шороон далан дээр шинэ хэрэм босож Алтан хаалга баригдаж Константинополь хотоос дутахааргүй гоёмсог болсон байлаа. Мэргэн Ярослав ван сүм хийд барихад хөрөнгө мөнгө харамгүй зарцуулж байсны үр дүнд оросын үнэн алдартны шашны гол зүрх болох София Эх Дагинын сүм, Георгиевийн, Ирнинский сүмүүд баригджээ.

София Эх Дагинын сүмийг киевчүүд талын печенегүүдийг ялан дийлсэн хотын хамгийн өндөрлөг газар босгожээ. Олон бөмбөгөр оройтой София Эх Дагинын сүм хотын аль ч хаалгаар орж ирсэн харагдана. Мэргэн Ярослав ван амьдралынхаа сүүлчийн жил оросын үнэн алдартны шашны сүмийн гол дүр төрх, эрхэм тэмүүлэл болох Киево-Печерийн лавра сүмийн шавыг тавиулжээ.

Мэргэн Ярослав ван өөд болсон нь Киев хот төдийгүй Орос улсын хүчирхэг хүчин чадлыг аваад одсон мэт болжээ. Вангийн зарим залгамжлагч төрөлх хотоо хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байсан ч хувийн ашиг сонирхлоо хэт хөөцөлдөж байснаас гадаадын түрэмгийлэгчдийн идэш болж тэд нар Киев болон орос орныг сүйтгэн үгүйрүүлжээ.

Түүнээс гадна оросын зарим ван ч Киев хотыг тонон дээрэмдэж байв. Тухайлбал Андрей Юрьевич ван 1169 онд Киев хотыг байлдан эзлэж тонон сүйтгэсний дараа холбоотнууддаа шилжүүлэн өгч байв. Түүхч Н.М.Карамзин “Орос улсын түүх” номондоо “Ялагчид орос гэдгээ умартаж гурван хоногийн турш сүм хийд түүний дотор София Эх Дагинын сүм, оршин суугчдын орон байшинг цөлмөн дээрэмдэж үнэт чимэглэл, ном судар, хонхыг авч одсон.” гэж харамсан бичсэн бий.

Рюрик Ростиславич ван Киев хотыг буцаан авахаар шийдэж половчуудыг уриалан туслалцуулж 1204 онд дайран эзлэж хотыг тонон дээрэмдсэн төдийгүй гэм зэмгүй өвгөд хөгшид, хүүхдүүдийг өршөөлгүй хүйс тэмтэрчээ. Гэвч Киев хот дайралт бүрийн дараа сэргэн босож байсан билээ.

Гэвч татар-монголчуудын довтолгоон хотыг удаан хугацаагаар мартагдуулжээ. 1399 онд Бат хааны цэрэг Киев хотод дөхөн ирж хотын сайхныг харж бахдаж шууд дайран эзлэхээ больж бууж өгөхийг шаарджээ. Гэтэл киевчүүд татгалзаж Бат хааны нэгдсэн хүч 1240 онд хотыг довтолж эзлэв. Татар-монголчууд хотыг оргүй сүйтгэсний дараа баруун зүг хөлгийн жолоог залж Волынь, Галицкийн вант улсуудыг зам зуур дарж Польш, Унгарыг байлдан дагуулжээ.

Татар-монголчууд хотыг гартаа авсны дараа хотын оршин суугчдын нэг хэсгийг хүйс тэмтэрч нөгөө хэсгийг дагуулан одсоноос хотын хүн амын тоо 50 мянгаас 2-3 мянга хүртлээ эрс цөөрчээ. XIII зууны дунд үеэс татар-монголчуудын дараа Киев хотыг литовчууд дараа нь польшууд эзэгнэж байлаа.

XVII зууны дунд үед польшийн дарлалын эсрэг тэмцэл өрнөж Запорожийн гетман Богдан Хмельницкий хасагуудыг удирдаж хэд хэдэн цус асгаруулсан байлдаанд ялалт байгуулж Киев хотод орж ирэхэд түүнийг талархан баяр хөөртэй угтаж байлаа. Украины нутгаас үлдэн хөөгдсөн польшууд татарууд, туркуудтэй хамтран довтолход Богдан Хмельницкий Москвагийн хаан Алексей Михайловичид хандаж Украин улсыг ивээлдээ авч Орос улсад

нэгтгэхийг хүсчээ. Чухам тэр цагаас Киев хотын түүхийн цоо шинэ эрин үе эхлэсэн билээ.

## БУДАПЕШТ

Дунай мөрний эрэг дээрх Будапешт хот нь мөнгөрөн цайрах уулсын дунд шахцалдан байрласан барилгуудын бүүдгэр цагаан өнгөөрөө мөнгөнд шигтгэсэн том сувд мэт харагдана. Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд гитлерчүүд Будапешт хотоос зөвлөлийн цэрэгт хөөгдөн гарахдаа Дунай мөрөн дээгүүр тавьсан бүх гүүрийг дэлбэлж хотын дулааны халаалтын сүлжээг эвдэж олон үйлдвэрийн газруудын тоног төхөөрөмжийг дээрэмдэн авч одож хот балгас болсон байлаа.



Хотын оршин суугчид эвдэрч сүйдсэн, халуун байтугай хүйтэн ус, гэрэлгүй байшингуудын хонгилд хоргодож амь гарсан байлаа. Эртний орд харш, сүм, уран барилгын чамин гоёмсог барилгууд орших Буда хотыг фашистууд ихээхэн сүйтгэсэн байв. Тухайлбал Парламентийн байшинд нисэх онгоц, их бууны 250 бөмбөг тусаж дэлбэрчээ. Гэвч сэргээн засварласан гот хийцийн шовх оройтой, чулуун хээ угалзаар чимэглэсэн Парламентийн байшин Дунай мөрний дээрээс харласан хадан цохио мэт өнгийсөн үзэгдэнэ.

Дунай мөрний баруун эрэг дээр орших Буда хот байгуулагдаад хоёр мянга гаруй жил болж байна. Кельтийн арабиск омгийнхон булаг шанд олонтой, дайсан халдан довтлоход хамгаалалт болох модорхог ууланд Ак-Инк буюу “Усаар баялаг” гэсэн утга бүхий нэртэй цэргийн суурин байгуулжээ.

Манай эриний өмнөх нэгдүгээр зуунд Ромын эзэнт гүрэн Паннониг (өнөөгийн Унгарын баруун хэсэг) эзлэн түрэмгийлж кельтийн суурин дээр Аквинкум нэртэй хот байгуулсан нь гунн, алан, гепид, готов зэрэг олон омог, аймгийнхны дайралтад өртөж оргүй алга болжээ.

Унгарын омгууд IX зууны сүүлчээр энд ирж тусгаар улсаа байгуулснаас хойш түүхэн урт хугацааны явцад цэцэглэлт, бууралтын аль алиныг нь үзжээ. Унгарын хаант улс байгуулагдсан анхны хэдэн зуунд Дунай мөрний гатлага дээр орших Пешт, Буда хотууд эрчтэй цэцэглэн хөгжиж байсан ч тус улсын нийслэл өөр газар байрлаж байсан учир томоохон хотууд гэж тооцогдохгүй байжээ. Пешт гэдэг үг нь “агуй” гэсэн утгатай гэж үздэг. Монголын байлдан дагуулалтын үед 1241 онд Пешт, Буда хоёр хотыг газрын хөрстэй тэгшилсэн байлаа.

IV Бела хаан монголчууд дахин довтлохоос сэргийлж 1247 онд хотуудыг тойруулан хэрэм

босгох зарлиг гаргасан нь тус улсын хотуудын хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлжээ. Хүн суудаггүй Буда ууланд (хожим нь Вархедь гэж нэрлэдэг болжээ.) Хааны цайз байгуулж түүнийг тойруулан хэрэм босгожээ. Анжу угсааны хаадын үед (1308-1386) Хааны ордныг өргөтгөж хотын иргэд, язгууртнууд байшин барилга олноор барьж байжээ.

Италичуудыг бишрэн шүтдэг Матяш хаан Буда хотод Европ тивд хамгийн тансагт тооцогдох Хааны ордон барихаар шийдэж тус улсын хот, тосгодоос шилдэг уран гартнуудын дуудан ирүүлж ордны доторхи засал чимэглэлийг асар их хөрөнгө гаргаж хийлгэжээ. Ордонг улаан гантиган усан оргилуур, хүрэл баримал, хээ угалзтай хаалга, тааз, өнгөт паалантай вандан сандал, зуухаар чимэглэжээ.

Энэ зуур Дунай мөрний зүүн эрэг дээр хаант төрдөө их татвар төлдөг Пешт хот мөн давшингүй хөгжиж байлаа. ХҮ зуунд Пешт хотыг тойруулан хэрэм барьжээ. Гэвч туркийн эзэмшлийн үед хоёр хотын хөгжил саатаж дорно зүгийн хэв маягтай ядуу хот болсон байв. Буда хот дахь Хааны ордны тансаг чимэглэлийг сүйтгэж цэргийн хуаран, агуулах болгон хувиргаж сүмүүдийг лалын шашны зориулалтаар ашиглаж байв.

Пешт хотын алдарт яармаг худалдаа зохиогдохоо байж бараг 150 жил хөгжсөнгүй, ядуу тосгон болон хувчирчээ. 1686 онд болсон түймэрт Буда хот бүрэн шатаж оршин суугчдын тоо нь хэдхэн зуун хүн болтлоо багасчээ.

Унгарын хотууд австрийн цэргийн дэмжлэгтэйгээр туркийн дарлалаас чөлөөлөгдсөн ч Австрийн эзэнт гүрний цэргийн захиргаанд оржээ. Австрийн эзэнт гүрний хаанаас томилогдсон амбан захирагч хөнгөлөлт үзүүлэх, газар олгох амлалт гаргаж Австри, Герман, Чех зэрэг олон орноос хүмүүс ирж сууршихыг уриалжээ. Нүүдэллэн одсон унгар иргэд ч төрөлх хотууддаа буцан ирцгээв.

Австрийн эзэнт гүрний Мария-Тереза хатан хаан нийслэл Вена хотдоо байнга суудаг ч Буда хотын хэрэм дотор Хааны ордон бариулсан ч өөрөө ч түүний залгамжлагч нараас ганц нь ч ирж суусангүй өнгөрчээ. Уг ордонд 1777 онд Унгарын Их сургуулийг байрлуулсан нь Буда хотын нэр хүндийг улам өргөжээ.

Буда, Пешт хотууд Габсбургийн эсрэг тэмцэлд улс орныхоо аж ахуй, оюуны хүчийг нэгтгэхийн тулд 1873 онд засаг захиргааны хувьд нэгджээ. Дунай мөрөн дээгүүр байнга өлгөөстэй (Гинжин) байдаг гүүр Дунай мөрөн дээгүүр тавьж хоёр эргийг холбосон нь хоёр хот нэгдэх шалтаг болсон байна. Өнөөдөр гүүрүүд нь Унгар улсын нийслэлийн давгагдашгүй дүр төрхийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болжээ. Гүүрүүд бие биентэйгээ үзэмж төгс байдлаараа өрсөлдөх мэт дараалан бий болсон түүхтэй ажээ. Тус хотын хамгийн урт гүүр нь 928 метр урт Арпадын, хамгийн эртний гүүр нь Гинжин гүүр юм. Үдэш болж гүүрүүд гэрлэн чимэглэлээ асаахад хотын өнгө үзэмж улам төгөлдөр болдог.

Будапешт хотын тухайн хорооллын газар зүйн байрлал, хүн амын насны байдал, цаг агаарын онцлогтой нягт уялдсан, чимэглэл, зориулалт нь өөр өөр мянга гаруй цэцэрлэгт хүрээлэнгийн алдар суу гадаадад хүртэл өргөн түгжээ. Цэцэрлэгт хүрээлэнгүүдийн арчилж хамгаалахад хэдэн мянган иргэд ур чадвар, цаг заваа зарцуулсаар иржээ.

Унгар улс байгуулагдсаны 1000 жилийн ойд зориулан барьсан Ворошлигет цэцэрлэгт хүрээлэнг байгуулахдаа Франц улсаас авьяаслаг цэцэрлэгч Неббьенийг урьжээ. Салхины өчүүхэн сэвэлзээнд өнгө төрхөө өөрчлөн найгадаг янз бүрийн өнгө, хэлбэртэй модоуд бүхий төгөл Будапешт хотын захад бий болжээ. Усан үзмийн бут дунд барьсан сүүдрэвч, ёроолд нь хайрга чулуу дэвссэн худаг, өндөр улиангар, газар шүргэсэн мөчиртэй бургас сэтгэл булаана.

Ворошлигет нь янз бүрийн насны хүмүүс тус тусдаа цугларч тоглоом тоглож спортын тэмцээн уралдаан зохиож болох хэд хэдэн цэцэрлэгт хүрээлэн ажээ. Тэнд мөн Амьтны хүрээлэн, “Хөгжилтэй цэцэрлэг”, жижигхэн Ботаникийн цэцэрлэг байна. Инженер-цэцэрлэгч Чербоверо хараагүй хүмүүст зориулан голд нь усан сан бүхий сонгодог тойрог бүхий хайрган явган замтай, хэрмээр хүрээлүүлсэн цэцэрлэг санаачлан байгуулжээ.

Өнөөдрийн Будапешт нь гэнэтийн зүйлүүдийн хослол юм. Тус хот түүхээр амьсгалж, туркийн дарлалын үеийн зүйлийг ч нандигнан хамгаалдаг. Хөл хөдөлгөөн ихтэй Фё гудамжаар явж байхад нэгэн халуун устай булаг шанд дээр хэдэн зуун жилийн тэртээ барьсан, хана нь газарт суусан, ногоон бөмбөгөр оройтой турк халуун усны газар тааралдана. Шинээр боссон олон давхар байшингийн хонгилд ороход домгийн баатар Геракл, усан үзмийн бут руу дүүлж байгаа барыг дүрсэлсэн ромын үеийн шигтгэмэл байна.

Будапешт хот нь уран барилгын хосгүй нандин дурсгалаараа дэлхийд цуутай билээ. Хотын гудамж талбайгаар явж алдарт уран барилгачдын авьяас билэг, нөн хичээнгүй хөдөрмөрийн үр дүн болох гайхамшигт сайхан гүүрүүд, ширмэн хашааны элдэв сонин хэлбэртэй сараалж, ордон, харшны хээ угалзтай хаалгыг бахдан баясаад ханашгүй.

## МАДРИД

Прадо музей үзэхээс өөр сонирхох зүйл Мадридад байхгүй, шавар шавхай ихтэй, шуугиан чимээ тасардаггүй хот, шөнө цонхоороо шээсээ асгадаг гэж үзэж байсан цаг бий. Хамгийн гол нь дэлхийн хүчирхэг гүрэнд яагаад соёлжоогүй ард түмэн яаж оршин суудаг байна гэж мэл гайхдаг байсан цаг саяхан.



Мадрид хотын шавыг хэн хэзээ тавьсан асуудлаар испанийн түүхчид өнөөг хүртэл маргалдсаар байна. Хотын эргэн тойронд ромчуудын оршуулгын олон хавтан олдсоныг иш үндэс болгон хотыг ромчууд байгуулсан гэж зарим судлаачид үздэг. Гэтэл тэдгээр хавтангуудад Мадрид гэдэг үгийг санагдуулах суурин газрын нэр огт байдаггүй.

Эртний үеийн суут эрдэмтэн Птоломейн зохиолд гардаг Мантуа гэдэг үг нь Мадрид хотын анхны нэр гэж зүтгэдэг эрдэмтэд бас бий. Тэрчилэн Август хаан Сеговия, Титулсия хотуудын хооронд Миакум хот оршдог гэж бичиж үлдээсэн нь Мадрид хотын тухай өгүүлжээ гэсэн үзэл баримтлалыг дэмждэг эрдэмтэд бас байдаг.

Ямартаа ч болов Мадрид нь эртний түүхт хот юм. Арабын нэгдүгээр Мохаммед эмирийн босгосон цайзаас Мадрид хот үүсэлтэй гэдгийг одоо бүх эрдэмтэн хүлээн зөвшөөрөөд байна. Дайснууд халдан довголж ирж болзошгүй Гуадаррама уул, хөндий тал нутаг тод харагдах дов дээр, Монсанарес голын эрэг дээр Мохаммед эмир цайз бариулжээ. Хожим нь цайзын буурин дээр Кастилийн хоёрдугаар Энрике Гастамара хаан шилтгээн барьж дараа нь Габсбургийн угсааны хаад ордноо босгож одоо тэнд хааны ордон сүндэрлэн байна.

Испанийн хоёрдугаар Филипп хаан 1561 онд нийслэлээ Толедо хотоос Мадрид хотод шилжүүлэн нүүлгэх зарлиг гаргаснаар тус хот нь эзэнт гүрний улс төр, эдийн засгийн амьдралын төв болжээ. Хотын хуучны хэсэгт орших талбай, ордон зэрэг олон барилга байгууламжийн тухай зүйргүй олон домог, хууч яриа байдаг. Тухайлбал залуу хүн Паса (Үзэм гэсэн утгатай үг) гудамжаар ядахдаа ганц удаа зорчихгүй бол амьдралдаа огт гэрлэхгүй гэж үзнэ.

Мадрид хотыг баруун-өмнөд зүгээс нь харвал шинэ гот дэгийн Амульдены сүм харагдана. Испанийн нийслэлийг ивээгч Эх Дагинын баримал нь “Эх Дагина Амульдена” гэж нэрлэгдэнэ.



Нэгдүгээр зуунд Пиренейн хагас арал дээр христос шашны сурталчилан дэлгэрүүлж байсан Иаков найдан Испанид Эх Дагина Амударнагийн баримлыг авчирчээ. Арабын түрэмгийлэгчид эх нутгийг нь эзлэхэд нутгийн оршин суугчид тэнгэрийн ивээгчээ нуужээ. IV Альфонс хаан 1083 онд Мадрид хотыг арабын эзлэн түрэмгийлэгчдээс чөлөөлсний дараа Эх Дагинын баримлыг эрээд олсонгүй. Гэвч эх нутгаа чөлөөлсөн баярт үйл явдалд зориулан ёслолын мөргөл үйлдэж хаан тэргүүлсэн жагсаал Мадрид хотын гудамжаар явж байтал нэгэн байшингийн хананаас гэнэт хэд хэдэн чулуу нурж унахад Эх Дагинын баримал нүдний нь өмнө тодроход сүсэгтэн олон мэл гайхжээ.

Эх Дагина Амударнагийн баримал хэдэн зууны туршид Санта-Мария сүмд хадгалагдаж байв. Өнөөгийн Эх Дагина Амударнагийн сүмийн барилгыг 1833 онд Хааны ордны өөдөөс харуулан барьж эхлэжээ. Сүмийн барилгын ажил маш удаарширч иргэний дайны үед бүр зогссон ч 1944 онд дахин сэргэж өнөө үед баригдаж дуусаад байна. Хоёрдугаар Иоанн Павел тэргүүн хамба лам 1992 онд сүмийг аравнайлан ч сүмийн дотоод чимэглэлийн ажил дуусах болоогүй байна.

Мадрид хотын төв талбай Пуэрта-дель-Соль буюу “Нарны хаалга” гэж нэрлэгдэнэ. Эрт дээр цагт хотыг тойруулан барьсан хэрмийн чулуун хананд гаргасан хаалгаар нар мандаж түүний туяа хотод хэрхэн цацран тусаж байгааг ажиглан харж болдог байжээ. XVI зуунд орцыг томсгох зорилгоор хаалгыг буулгаж бий болсон сул зайд талбай байгуулжээ. Их Сервантесийн багш, шашны онолч, хүнлэг үзэлтэн Х:Л. Де Ойвосын бичиж үлдээснээр нэгдүгээр Карлос хаан 1521 онд Кастилд гарсан бослогыг дарсны дараа “хотод зорчих чухал гарцыг өргөжүүлэх тухай” тусгай зарлиг гаргаж хаалгыг буулгажээ. Гэхдээ уг талбай бараг зуу шахам жил Гвадалахару чиглэн явах гарааны цэг болж байв. Тэр үед Мадрид хотод гол үүрэг Хотын талбайд ногдож байжээ.

1438 онд гарсан тарваган тахлаас ангижрасны дурсгалд зориулан босгосон Буэн-Сусесо сүм нилээд хэдэн жилийн туршид тус талбай дахь цорын ганц барилга байв. Өнөө үед тус талбайн гол чимэг нь 1768 онд босгосон “Шуудангийн ордон” болж байна. Зуун жилийн дараа түүний дээвэр дээр жижиг цамхаг босгож түүний дээр цаг байрлуулжээ. Англид байхдаа цагны урлагт суралцсан жирийн малчин Рамон Лосада уг цагийг урлажээ. Тэрбээр цамхаг дээр дугуй дээвэртэй задгай сүүдрэвч барьж түүний дотор босоо төмөр голд бөмбөг тогтоожээ. Өдөр дунд болж бөмбөг “өөрөө” доошилж байгааг харахаар хотын иргэд цуглардаг байв. Одоо бол тэр эртний цаг нь одон орны судлалын оргил болон хувирч од эрхэсийн хөдөлгөөн, он, сар, өдөр, нар гийлт, агаарын даралтыг заана.

“Шуудангийн ордон”-д анхандаа Дотоод хэргийн яам байрлаж байсан ба 1939 онд Испанийн Бүгд Найрамдах Улс ялагдсаны дараа Ф.Франкогийн дэглэмийн Аюулыг хамгаалах газар байрлаж байв. Одоо ордонд орон нутгийн захиргааны байгууллагууд байрлаж байдаг хийгээд түүний дэргэдэх явган зам дээр тус орны газар нутгийн “О” цэг оршино.

Пуэрта-дель “Соль талбай хэмжээний хувьд тийм том биш ч Испани орны олон түүхэн үйл явдлын гэрч болсоор иржээ. Тухайлбал 1759 онд Y Карлосыг хаанд ширээнд залрах ёслолын үед талбайн эргэн тойронд орших хотын захиргааны болон орон сууцны байшингуудын хананд цэцэг, олон өнгийн тууз өлгөж талбайн эргэн тойронд найман багана босгож лаврын хэлхээгээр хооронд нь холбож чимэглэсэн байв.

Пуэрта-дель-Соль талбайн голд байх усан оргилуурыг хоёр зуу гаруй жил чимж байгаа Венера эм бурхны “Марибланка” буюу “Цагаан Мари” хэмээх баримал байдаг. Уг усан оргилуурын төслийг италийн уран барилгач Р.Гачи 1618 онд хийсэн ч найман өнцөгтийн оройд тогтоосон хүрэл багийн дугуй аяганаас ус оргилон буух хүртэл 12 жил өнгөрчээ. XIX зууны дунд үед талбайг шинэчлэх үед баримлыг буулгаж Реколетас өргөн чөлөөнд байрлуулсныг 1948 онд хэсэг залуус дүрсгүйтэн хагалжээ. Гэвч Марибланка баримлыг сэргээн засварлан музейд байрлуулж түүний хуулбарыг 1986 онд Пуэрта-дель-Соль талбайд дахин босгожээ. Гэхдээ Мадридын залуус хоёр зуу жилийн турш болзоо тогтоон уулздаг байсан усан оргилуурыг нь сэргээн барьсангүй өнгөрчээ.

Мадрид эрт дээр үеэс цөөрөм, усан оргилуураараа алдартай билээ. Тэдгээрээс испанийн нийслэлийн билэг тэмдэг болох “Сибелес” усан оргилуур хамгийн цуутай нь юм. Арслан хөллөсөн тэрэг дээр байрлуулсан Ялалтын хаалганы дэлгэц дээр дүрсэлсэн домгийн эм бурхныг “Мадридийн мөнхийн сүйт бүсгүй” гэж шагшин магтдаг.

1782 онд босгосон “Сибелес” усан оргилуур түүхэн урт хугацаанд олон үйл явдлын гэрч байсан төдийгүй өнөө үед түүний дор 37 метр гүнд барьсан хуягласан байшинд Испани улсын Төв банк алтны нөөцийн тодорхой хэсгийг хадгалж байна.

Христофор Колумбын нэрэмжит талбайд түүний цагаан гантиган хөшөө дүнхийж байна. Хөшөөг өндөр багана дээр байрлуулсан ч эсрэг талд нь орших орчин үеийн хоёр барилгаас намхан харагдана. Тэр бол Мадрид хотын хамгийн хамгийн өндөр барилгууд болох 45 давхар “Пикассогийн цамхаг”, “Европийн цамхаг” юм. Кастельяний өргөн чөлөөний хоёр талд барьсан дээрх хоёр тэнгэр баганадсан байшинг нь асар том гулдан хаалганы дүрсийг санагдуулдаг тул “Европийн гулдан хаалга” гэсэн нэр авчээ.

XIX зууны сүүлчээр байгуулсан Х.Колумбын нэрэмжит талбайн цаана чидун жимсний, замбага, нарс мод, зүлэг бүхий “Анхдагчийн цэцэрлэгт хүрээлэн” байна. Хөшөөнөөс ус олгойдож далайчны хөшөө болохыг улам тодотгоно. Доош цацрах усны цаанаас Х.Колумбын хийсэн гурван аялалын чиглэлийг заасан хүрэл, хөнгөн цагаан, боржин, цагаан тугалгаар урласан газрын зураг жуулчид, зочдын анхаарлыг онцгой татна.

## КАИР

Каир хотыг үзээгүй хүн хорвоо дэлхийг мэдэхгүй гэсэн үг.” гэж “Мянга нэгийн шөнийн үлгэр” номонд өгүүлсэн бий. 1970 онд Каир хотын 1000 жилийн ойг тэмдэглэсэн ч түүний үүх түүх түүнээс өмнөх үед хамааралтай ажээ.



639 онд Амра жанжны удирдсан Омар халифийн цэрэг Нил мөрний зүүн эрэг дээр орших Вавилон хотыг долоон сар бүслэлт хийсний дараа эзлэжээ. Энэ нутагт фараонуудын үед Хоёр мөрний билчээрээс туугдан ирсэн боссон арабчууд сууршиж байсан, тэд алс хол байгаа төрөлх нутгаа дурсаж шинэ нутгаа Вавилон гэж нэрлэжээ хэмээн зарим эрдэмтэн үздэг.

Амра жанжны цэрэг Вавилон хотыг бүслэлт хийж байх үед түүний байрласан майхны дээр тагтаа үүр засчээ. Тэр явдлыг сайн үйлсийг билэгдлээ гэж үзэж Амра жанжин тагтааг үргээхгүй байхыг тушааж Александри хот руу дайлаар мордохдоо Мукагтам улын бэлд барьсан майхнаа буулгалгүй тэр чигээр нь үлдээжээ.

Амра жанжны цэргийн хуаран байрлаж байсан газар байгуулсан хотыг “Фустат” (“Майхан”) гэж нэрлэж төдөлгүй лалын шашны сүм босгосон нь жирийн орон сууцнаас ялгагдахгүй байлаа. Уг сүмд шашны ёслолоос гадна зөвөлгөөн хийдэг, түүнийг мөн орон сууцны зориулалтаар ашиглаж байв.

Александри хотын нэр хүнд буурах тусам Фустат хотын ач холбогдол өссөөр VIII зууны дунд үед Египетийн улс төр, эдийн засгийн төв болон хувирчээ. Амра сүмийн булангуудад хаалганы дээр намхан цамхагууд босгож дараагийн үеийн олон захирагч сүмийг шинэчлэн улам гоёмсог болгожээ. 827 онд сүмийг хоёр дахин томсгосноор өнөөгийн хэмжээндээ хүрчээ. Каирчууд уг сүмийг “сүмүүдийн оргил” гэж нэрлэдэг нь учиртай. Олон удаагийн нийтийн сорилт шалгалтын үед нэгдмэл Бурхныг хүлээн зөвшөөрдөг янз бүрийн шүтлэгтэй сүсэгтнүүд чухамдаа энэ сүмд цугларч хэл амаа ололцож хамтын тэмцэлд босож байжээ.

Турк боолын хүүхэд байсан ч хосгүй авьяас чадвараараа эрх мэдлийн өндөрлөгт хүрсэн Ахмед ибн Тулуны хаанчлалын үед Фустат хотын хувь заяанд шийдвэрлэх эргэлт гарч Мукагтам уулын энгэрт том ордон сүндэрлэж Яшкур довын ойролцоо шинэ хотын шав тавьж “Мирз” (“Гялалзсан хот”) гэж нэрлэжээ.

904 онд Багдадын халифууд Египет оронд дахин ноёрхлоо тогтоож зөрүүд Тулуны ордонг газрын хөрстэй тэгшилсэн ч түүний 879 онд барьсан лалын шашны сүмд гар хүрсэнгүй, одоо тэр сүм Каир хотын чимэг болж байна. Домогт өгүүлснээр лалын шашны сүмийн зургийг шоронд хоригдож байсан христос шашинтан уран барилгач ирүүлжээ. Тиймд Фустат хотод лалын төдийгүй христос шашны сүмүүд байснаас хамгийн том нь христос шашны Гэгээн Сергийн сүм юм.

Цаг хугацаа өнгөрсөөр аббасид угсааны хаад асар уудам нутгаа захирч дийлэхээ байж 969 онд Фамитид угсааны хаадын цэргүүд Фустат хотыг төвөггүй эзлэж, холгүйхэн шинэ хот байгуулж хоёр жилийн дараа цэргээ байрлуулж анхны сүм, ордонг босгожээ. Фамитидийн угсааны халиф Муизз 972 онд шинэ нийслэлдээ ёслол төгөлдөр заларч “аль-Кахира” (“Ялалтын хот”) гэсэн нэрээр алдаршуулав.

Хотын нэр хэрхэн үүссэн асуудлаар эрдэмтэд хоёр таамаглал дэвшүүлдэг. Нэгдүгээрт нь халиф Муизз байгуулсан ялалт төдийгүй ирээдүйн ялалтуудаа билэгдэж тийнхүү нэрлэсэн гэдэг бол хоёрдугаарт Марс гаригийг арабчууд аль-Кахира гэж хүндэтгэдэг байсан учир тийм нэр хайрласан гэдэг.

Арабчууд Марсыг азгүй гариг гэж үздэг байсан ч сайн сайхан ирээдүйг билэгдэж шинэ хотдоо түүний нэрийг өгчээ. Нилээд хожуу хотод ирсэн италичууд нэрийг нь товчлон Каиро гэж, дараагаар нь европчууд өөр өөрийн хэлээр нэрлэж түүний дотор францчууд Кэр гэдэг байв.

Каир хотыг босгохдоо эртний Мемфисийн балгас, Фустат хот, фараонуудын пирамидуудаас голдуу чулуу зөөж байжээ. Тэдгээр чулуунууд нь маш хатуу, бат бөх байсан хийгээд тэдгээрт сийлсэн эртний ханз үсгүүдийг өнөөдөр ч харж болно.

Фустат, Каир хотууд удтал зэрэгцэн оршиж байсан ч Каир нь аажимдаа нөгөөгөө уусгасаар XVII зуунд бүрмөсөн “залгижээ.” Каир хотын алдарт Цайз оршдог хаднаас Нил мөрөн хүртэл үргэлжилдэг Кебеш хороолол л Фустат хотоос үлджээ.

Цайз буюу “Мухаммед Алийн үүр” цуут Саладин султаны хаанчлалын үед 1176 онд баригджээ. Саладин султаны бариулсан ордонд дараа үеийн султанууд нь сууж байжээ. Тэрхүү сүрлэг цайзаас өнөө үед түүнийг хүрээлүүлсэн хэрэмний өмнөд, зүүн тал нь л хэвээр хадгалагдан иржээ. Хэрэмний чулуун сууринд Наполеоны цэргийн их бууны сум зоогдсоныг одоо ч харж болно. Цайзын нутаг дэвсгэр дээр хөнгөн багануудыг нь болсон гөлтгөнөөр хийсэн учир Болсон гөлтгөний сүм гэж нэрлэдэг Мухаммед Алийн лалын шашны сүм байна. Энэ сүмийн том бөмбөгөр орой, гоолиг ганжирууд нь Каир хотын билэг тэмдэг болсоор удаж байна. Сүмийн гол хаалганы баруун талд хүрэл хашаагаар хүрээлүүлсэн Мухаммед Алийн шарил бий.

Сүмийн өмнөх талбайд бүр дундад зууны үед ухаж хийсэн “Иосифийн худаг” оршино. 1820 онд байгуулагдсан сүмийн өмнө гаргасан худагт ах дүүс нар нь боол болгон худалдсан өвөг эцэг Иосиф хоригдож байсан тухай домог бий. Хаданд ухаж гаргасан худагны гүн 88 метр байгаа нь Нил мөрний ёроолын түвшинтэй адил юм. Худаг руу өнгийн харахад, ус цалгих ер мэдэгдэхгүй.

Хуучин хотод коптын христос шашны сүм бий. Христос шашин Египет улсад лалын шашнаас бүр өмнө III зуунд дэлгэрчээ. Харин лалын шашин VII зуунаас тархаж эхлэсэн ч коптууд итгэл үнэмшлээсээ татгалзсангүй, одоо ч бишрэн шүтсээр байна.

Нил мөрний эрэг дээр орших Вавилоны цайзын өмнөд хаалганы дээх нь Эх Дагина Марияд зориулан босгосон Унжмал сүм Каир хотын хамгийн эртний сүмд тооцогдоно. Сүмийн суурийг шон дээр тогтоосон тул шилэн шалны дор ус цэлэлзэн харагдана.

Каир хотыг байгуулагдсан үеэс туркүүд эзлэх хүртэл тус орныг дөрвөн угсааны хаад ээлжлэн захирч байлаа. Шинэ Каиртай нас чацуу сүм нь дорно зүгийн дүр төрхөө хадгалсан лалын шашны эль-Азхар (“Цэцгийн сүм”) сүм юм. Хэдэн зуун жилийн өмнө энэ сүмд байгуулсан лалын шашны их сургуульд лалын ертөнцийн өнцөг булан бүрээс ирсэн 9 мянган оюутан суралцаж байлаа. Өнөөдөр ч гэсэн профессор багш нар X зууны үеийн уламжлалыг баримтлан хичээлээ заадаг байна.

XVI зуунд арабын Микеланжело гэж үзэж болох хосгүй авьяастны бүтээсэн Хасан султаны сүм сүрлэг сайхан гадаад төрх, гоёмсог байдлаараа Каир хотын чимэг болж байна. Энэхүү алдарт сүмийн урт 140 метр, өргөн 75 метр, олон ганжируудын нэг нь 86 метр өндөр ажээ. Хасан султан тухайн үед байсан лалын шашны дөрвөн урсгалыг эвлэрүүлэх зорилгоор дөрвөн сүм бариулжээ. Сүсэгтнүүд сүм дотор орж ирээд хашааны голд байх усан оргилуурт уламжлалт угаалгаа хийгээд мөргөл хийхдээ тусдаа хашаанд орно.

Каир хотод эрт дээр үеэс тус бүр нь хэсгүүдэд хуваагддаг хэд хэдэн хорооллоос бүрдэж байна. Хороолол бүр нэг хаалгатай хийгээд шөнө болмогц түгжинэ. Нэг хороололд адил мэргэжлийн, нэг шашин шүтдэг хүмүүс голдуу оршино сууна. Хороолол болгонд тухайн хорооллын нэрээр нэрлэгдсэн гол гудамж байна.

Каир хот үнэхээр том, олон өнгө төрхтэй болохоор тэр тухай бүгдийг өгүүлэх ямар ч боломжгүй. Сүмүүдийн бөмбөгөр оройнууд алсаас алтран гялалзаж гудамж, захууд бүүдгэр гэрэлд умбажээ. Ашраф Халиль султан 700 гаруй жилийн тэртээ үндэслэсэн “Хан эль-Халиль” буюу алдарт “Алтан зах”-аар гадаадын иргэн явахдаа хөтөчгүй бол дорхноо төөрнө. Тодорхой бараа борлуулдагаараа 12 “сук” буюу захад хуваагдах “Алтан зах” нь даавуугаараа алдартай төдийгүй алтан гартай уран гартнуудын урласан хосгүй нандин бүтээлүүдээрээ цууд гарчээ.

Каирчууд гунихыг мэддэггүй хөгжилтэй хүмүүс. Шөнө унтдаггүй хотод инээд хөөр хаа сайгүй хадна. Гэхдээ каирчууд бараг бүгдээрээ лалын шашинтангууд болохоор радиогоор мөргөлийн цаг болж байгааг зарлахад хэдэн сая хүнтэй хотын амьдрал зогсох шиг санагдана. Жолооч, үсчин, үйлчлэгч, худалдаачид цөм ажлаа зогсоож өдөрт таван удаа мөргөлийн олбогоо дэвсэж мөргөл үйлдэж “Аллах акбар! Ля илляхи илле Аллах!” (“Аугаа их Аллах! Аллах Танаас өөр бурхан хорвоод үгүй!) гэж өгүүлнэ.

## ХАНОЙ

Эх хүн хүүхэддээ төрсөн агшнаас нь инээмсэглэл бэлэглэж байдаг шиг Ханой хот дандаа инээмсэглэлээр бялхаж байдаг. Сүм хийдэд өвдөглөн суусан Бүдда бурхан мөргөлчдийг харж жуумалзана, лянхау, шийвантиг цэцэг, далдуу мод оройгоо ганхуулан инээнэ. Вьетнамын уран барилгачид элдэв чамин шийдэлгүй, тохилог энгийн байшингууд барих авч дээвэр дээр шавран чимэглэл нь сайхан сэтгэл, зочломтгой занг илэрхийлнэ. Байшингуудын дээвэр дээрх лууны чулуун сүүл нь уг байшинд амьдран суугчдын эвтэй найртай, амар жимэр амьдралын билэгдэл болно. Усыг эзэгнэгч лууг эрт дээр үеэс сайн үйлсийн билэгдэл гэж үзсээр ирсэн учир Ханой хот олон зуун жилийн тэртээ “Тханглонг” буюу “Нисэн дүүлж байгаа лууны хот” гэж нэрлэгддэг байжээ.



IX зуунд хятадын захирагч Гао Бянь Улаан голын эрэг дээр сүм барьсныг өнөөдөр эртний уран барилгын ховор дурсгал гэж нандигнан хамгаалж байна. Хоёр зуун жилийн дараа Вьетнамын Ли Тхай Хо хаан хот барихаар шийдсэн ч намагтай газар учир бүтэлгүйтжээ. Гэвч зорьсон хэргээ гүйцэлдүүлжээ. Тэр тухай эртний нэгэн домгийг сонирхуулья:

Хаан нэгэн удаа зүүдэндээ цагаан морь харжээ. Цагаан морь сүмээс гарч хэд хэдэн тосгоныг тойрч давхиснаа буцан сумд оржээ. Хаан цагаан морины туурайны мөр гарсан газрыг санаандаа тогтоон авч тэр газар хэрэм босгохыг тушаасан нь маш бат бэх болжээ. Тэр үеэс уг сүмийг “Бать Ма” буюу “Цагаан морь” гэж нэрлэх болжээ.

Тханглонг хот байгуулагдсан цагаасаа хойш олон удаа эвдрэл сүйрэл үзжээ. Тухайлбал XIII зуунд умард зүгээс эзлэн түрэмгийлэгчид гурвантаа халдан ирсэн ч хотын иргэд эрэлхэг зоригтой тулалдаж үлдэн хөөж байв. Эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг бослого дэгдээсэн Чынг угсааны зоригт эмэгтэйчүүдийн дурсгалыг хүндэтгэхээр өнөө үед ч хүмүүс “Эгч дүү хоёр бүсгүйн сүм”-д ирнэ. Хятадын сүмийн дэгээр босгосон сүмийг Бүдда бурхны жижиг цээж баримлаар чимж хананд нь тэнгэрт хөөрч байгаа лууны араас архирч байгаа бар, лянхуа цэцэг шиг хэлбэртэй хоншоортой өрөвтас шувуу, могой бяц гишгэж байгаа зааны товгор дүрсүүд хийжээ.

1789 онд хятадын 200 мянган хүнтэй армийг бут ниргэсэн Баньяний дов байдаг Донгда хороололд жуулчид олонтаа ирнэ.

Тханглонг хот нь 1000 гаруй жилийн түүхтэй цайзаас үүсэлтэй гэдэг. Уг цайзаас зөвхөн Хойд гулдан хаалганы нь л хэсэг үлдсэн агаад түүний чулуун хананд харласан нүх байгаа нь 1872 оны дөрөвдүгээр сард францийн их бууны сум туссанаас бий болсон ажээ. Тиймд цайзтай залгаа гудамжийг “Шархадсан цэргийн гудамж” гэнэ.

Цайзаас холгүйхэн, хотын төвд “Буцааж өгсөн илдний нуур” бий. Эл нуур бараг тэгш өнцөгт хэлбэртэй агаад ус нь цэнгэг болохоор нуурын ёроолоор хөвж байгаа хоёр яст мэлхий тод харагдана. Улаан голын хуучин голдрилоос үүссэн нуурын голд “Яс мэлхийний сүм” хэмээх жижигхэн цамхаг байна.

Хятадын Мин угсааны хааны цэргүүд халдан ирэхэд загасчин Ле Лой эх орон нэгтнүүдээ тэмцэлд уриалан байлдсан ч зэвсэг сайтай дайсанд дийлдэн ухарч ууланд гарч нуугджээ. Тэгтэл нэгэн вьетнам эр араас нь ирж тариачдын армийн удирдагч Ле Лойд хандаж:

- Нуурын эрэг дээр загас барьж байтал торонд минь амандаа илд зуусан нэг том яст мэлхий ороход нь би маш их гайхлаа. Тэгээд би танд тэр илдийг өргөн барьж байна, халдан довглогчдыг бут ниргэ! гэж өгүүлээд илдийг хүндэтгэлтэй гардуулжээ.

Ли Лой боссон тариачдаа удирдан тулалдаанд орж эзлэн түрэмгийлэгчдийг эх нутгаасаа элдэн хөөв. Байгуулсан их ялалтаа нуурын эрэг дээр тэмдэглэж байтал нуур дотроос нэгэн яст мэлхий гарч ирээд Ле Лойд хандаж:

- Ле Лой чамд би дайсныг дар гэж илд явуулсан, чи үүргээ биелүүллээ, одоо илдийг минь буцааж өг! гэж шаарджээ. Ийнхүү өгүүлтэл илд усны мандал дээр эргэлдэхэд яст мэлхий түүнийг амандаа зууж усанд далдарчээ.

Эх орноо хамгаалахад зүйргүй гавьяа байгуулсан загасчинд зориулж нуурын дунд нефритээр Гок Сон сүм, дэргэд нь мөн “Яст мэлхийн сүм” байгуулж түүн рүү хүрэх жижигхэн махир гүүр барьжээ.

Вьетнам улсын нийслэл “Хоёр голын дундах хот” гэсэн утгатай Ханой нэрээр 1839 оноос нэрлэгдэх болжээ. Үнэндээ бол Ханой нь харьцангуй жижиг газар дээр нэг сая хүн амьдран сууж байгаа “дотоод хот” юм. Гурваас дээшгүй давхартай байшин шигүү барьсан 1 хавтгай дөрвөлжин километр талбайд 20-30 мянган хүн оршин сууна.

XIX зууны сүүлчээр францчууд хотыг эзлэж хааны ордон, шилтгээнийг нурааж эртний сүм хийдийн буурин дээр холбоо, телеграфын байшингууд барьж эхлэсэн үеэс тус хотын нүүр царай эрс өөрчлөгдөж “европийн” хэсэг нь онцгойрох болжээ. Хотын орон зайг тэлэх боломжгүй байсан тул дээш өндөрсгөх ганц арга л байв. Байшингуудын нэгдүгээр давхар хэвээр үлдэж дээд давхруудыг нь захиалагч, уран барилгач бүр уран сэтгэмжээрээ өөрчилж жижигхэн тагт, саравчтай хашлагатай бяцхан талбайтай болгож шавран хээ угалзаар чимэглэдэг байлаа.

Гэвч Ханой хотын “хуучин хэсэг” дэх ганц сүйх тэрэг арай ядан багтан явах бололцооотой хавчиг тахиралдсан гудамжууд улам баргар, заваан болсоор байлаа. Францийн дарлалд орохоос өмнө согтууруулах ундааны амт мэддэггүй байсан вьетнамчууд дарс, тамхины

мухлагаас салахаа байжээ. Францчууд хотын “европийн” болон “хуучин” хэсгүүдийн дунд Ша-Тьен нэртэй шорон байгуулжээ.

1940 онд францчуудын орыг авсан япончууд хотыг хөгжүүлэх талаар дорвитой арга хэмжээ авсангүй, харин 1945 онд есдүгээр сард тус улс тусгаар тогтнолоо зарласан үеэс вьетнамчууд нийслэл хотоо сайхан болгохын төлөө ихийг санаж сэдэж эхлэжээ. Гэхдээ түүхэн дурсгалуудыг нандигнан хамгаалахад онцгой анхаарч байв. Хотын олонх гудамж дундад зууны үеэс уламжлагдан ирсэн Замын сагсны, Цаасан эдлэлийн, Шарсан загасны гэх зэрэг нэрээ хадгалж үлджээ.

Эрт дээр үеэс зурхайч, зохиолч, эрдэмтдийн гудамж гэж алдаршсан Кхамтхиений гудамж 1972 онд америкийн бөмбөгдөгч нисэх онгоцуудын дайралтад өртөж оргүй болсныг вьетнамчууд түрэмгийлэгчдийг үлдэн хөөсний дараа эртний байдлаар нь байшингуудад гарсан нүхийг тойпуугаар бөглөх зэргээр сэргээн засварлаж “Кхамтхиений гудамжинд амь эрсдэгсэдийн дурсгалын хөшөө” байгуулж түүн рүү хүрэх гудамжны хоёр талаар мод ургуулжээ.

Вьетнамын нийслэлийн бас нэг чимэг нь суут сэтгэгч Конфуцийд зориулсан “Уран зохиолын сүм” юм. Бараг нас чацуу асар том гадил, манг модны сүүдэрт орших сүмийн дотор ороход нарийхан лааны сүүмэлзэх гэрэл Бүдда бурхны том хүрэл барималд тусна. Бүдда бурхны өмнөх жижиг зандан ширээн дээр цагаан будааны аяга, жимсний ваар байна. Баримлын ойролцоо үхэшгүй мөнхийн билэгдэл болох яс мэлхий дээр зогсож амандаа лянхуа цэцэг амандаа зуусан аз жаргал, амгалан байдлыг билэгдэл болох хүрэл өрөвгас шувуу байна.

XI зуунаас вьетнамын ухаантнууд сүм хийдэд шавилан сууж эрдэм боловсрол эзэмшиж байна. Сүм байгуулагдсан үеэс францийн түрэмгийлэгчид довтлон ирэх үе хүртэлх хугацаанд тогтмол явагдаж байсан уран зохиолын тэмцээн, эрдмийн дээд зэрэг хүртэхийн төлөөх уралдаант шалгалтад тэргүүлж байсан хүмүүсийн нэрийг сийлэн бичсэн 84 хавтанг дороос нь чулуун яст мэлхийгээр тулжээ. Хавтангийн өмнө байгаа, урьд цагт индрийн зориулалтаар ашиглаж байсан өндөр гоё цамхаг дээрээс эрдэмтэд хулсан дуу чангаруулагчаар үг хэлж яруу найрагчид шүлэг, найраглалаа уншдаг байжээ.

Ханой хотын билэг тэмдэг нь 1049 онд баригдсан “Нэг багана дээрх сүм” юм. Ле Тхань Тонг хаан нэгэн удаа уулнаас буун ирж байгаа Гуаньинь эм бурхныг хараад түүнд зориулан Бядинь талбайд сүм барих зарлиг буусгаснаар уг сүм бий болсон гэдэг домог бий.

Сүүлийн хэдэн арван жил Ханой хот маш их өөрчлөгдсөн нь мэдээж билээ. Хотын газар зүйн төв болох Бядинь талбайны төвд вьетнамын гарамгай удирдагч Хо Ши Миний мавзолей байна. Хивс битүү дэвссэн мавзолей дотор ороход арц хүж үнэртэнэ.

Ханойчууд хот газар амьдран суудаг ч хөдөөгийн байдлаар аж төрөхийг эрмэлзэнэ. Таван давхар байшингийн хоорондох зайд хүнсний ногооны талбай байна, олонх үйлдвэр, байгууллага, сургууль хажуудаа туслах аж ахуйн талбай ажээ. Тэр ч бүү хэл томоохон хорооллын оршин суугчид тахианы донгодолтоор өглөө сэрнэ.

Дэлхийн улс бүрийн нийслэл өвөрмөц уламжлал, онцлогоороо бие биенээсээ ялгагдана.



Ханой хотын гудамж талбай өглөө үүрийн гэгээнээс авхуулаад хэдэн мянган унадаг дугуйны намуун дуугаар амилна. Ажилчид, оюутнууд, сурагчид, албан хаагчид, залуучууд бүгд унадаг дугуй хөлөглөн явахдаа хоорондоо мөргөлдөхгүй, эмх замбараатай явж байгааг нь хараад гадаадын зочид, жуулчид гайхна.

## ВЕНА

Дунай мөрөн Венийн хаалганы хавчиг хавцлыг нэвтрэн тэгш тал руу уруудан урсдаг тэр газар Вена хот оршино. ХҮП зууны дунд үед австрийн байр зүй судлаач эрдэмтэн М.Цейлор “Хүн зоньг талх тариа, дарс, жимсээр элбэг дэлбэг хангадаг нутаг ажээ.” гэж бахархан үнэлж байсан тэгш тал нутаг аль эрт дээр үеэс нүүдэллэн сууршигчдын анхаарлыг татдаг байжээ.



Вена хот нь Австрийн түүхтэй нягт холбоотой ч тус улс байгуулагдахаас өмнө үүсэн бий болсон ажээ. Манай эриний өмнөх гурван мянган жилийн тэртээ өнөөгийн Вена хотын нэгэн хорооллын нутаг дээр венето-иллири омгийн суурин байв. Дараа нь тэнд кельтүүд ирж сууршисныг нь манай эриний 16 онд ромчууд элдэн хөөж “Виндомина” сууринд цэргийн хуарангаа байгуулсны төв хэсэг нь одоогийн Хохер-Маркт гудамж юм.

Яваандаа цэргийн хуарангийн эргэн тойронд худалдаа, гар урлал эрхэлдэг тосгон, гацаа олноор бий болж энд Ромын эзэнт гүрний хаан Марк Аврелий удтал сууж байна. Тэр үеэс хойш Виндобоне суурин олон булаан эзлэгчдийн гар дамжиж германы дайнч омгийнхон 1030 оны орчим Вений гэж өөрчлөн нэрлэжээ. Гэхдээ Австрийн дийлэнх нутгийг захирч байсан Бабенбергийн удмын вангуудын эзэмшилд байсан Вена 1037 оноос л хот гэж нэрлэгдэх болжээ.

1138 онд Бабенбергийн удмын гүн Генрих Язомирготт тэр үеийн Вена хотын гулдан хаалганы дэргэд өргөө бариулж байнга хүлээн авалт, бүжгийн үдэшлэг зохиож тансаг амьдралд умбаж байжээ. Тэрбээр Ирландаас дуудан ирүүлсэн лам нарт зориулан Бенедиктийн сүм тэрчилэн Гэгээн Стефаны сүмийн барилгын ажлыг эхлүүлжээ.

VI Леопольд гүнгийн үед Вена хот Германы хотуудаас хамгийн сайханд тооцогдож тэр үед Цэмбэний, Гоёлын эд зүйлсийн гудамж тэрчилэн худалдаачин, жижиг гар урчууд суухыг хориглож зөвхөн язгууртнууд нь амьдардаг Тайжийн гэж нэрлэсэн олон гудамжтай болсон байлаа. Оршин суугчдын давхарга хоорондын ялгаа эрс их байсан нь хотын гадаад дүр төрхөд нөлөөлж хороолол бүр оршин суугчдынхаа онцлогоос улбаалан өвөрмөц “өнгө төрх”-тэй байлаа.

VI Леопольд гүнгийн гаргасан “Хотын аж байдлын дүрэм”-д “Эдлэн газар үе залгамжлан

эзэмшдэг иргэд нь худалдаачин, борчуулаас илүү эрх дарх эдэлнэ, хотын Зөвлөлд гар урчуудыг суулгаж болохгүй.” гэж заасан байв. “Үе дамжсан бюргерүүдийг” ялан дийлсэн гар урчууд 1408 онд Гахайн талбай дээр цаазлуулсан хотын захирагч К.Форлуф түүний хоёр “зөвлөх”-ийн дурсгалд зориулсан дурсгалын хавтан бий.

XIII зууны сүүлчээр Вена хот Габсбургын удмын хаадын захиргаанд оржээ. Түркүүд Унгарыг байлдан дагуулсны дараа 1529 онд Вена хот руу довтлон ирэхэд хотын оршин суугчид түрэмгийлэгчдийг хоргодох газаргүй болгох зорилгоор дагуул тосгон, гацааг цөмийг нь түймэрдэж Каленбург цайзанд хориглолт хийж Германы Нюрнбург зэрэг олон хотын дэмжлэг туслалцаатайгаар 18 хоногийн бүслэлтийг давж гарчээ.

Австрийн эзэнт гүрэнд үндэстэн хоорондын зөрчилдөөн тасралтгүй үргэлжилж байсан ч далай руу чөлөөтэй гарц байгаагүй учраас улс хоорондын дайн тулалдаанаас ангид байсан Вена хот нь уран барилгын хувьд европийн бусад хоттой харьцуулахад дээр үеийн дэг, хийц бүхий барилга, байгууламж нилээд олонтой билээ.

Хуучин Вена хот нь давчуу мурилзсан гудамж, хооронд нь тулган барьсан байшин, сүм бүхий дундад зууны үеийн хотын өвөрмөц шинжийг хадгалсан түүх-уран барилгын музей юм. Энэ хотод сул чөлөөтэй зай талбай огт байхгүй. Гэхдээ эрт дээр үеийн бөмбөгөр орой, хурц шовх талст цамхагтай барилга байгууламж XIX зууны сүүлчээр босгосон чамин барокко, гот хийцийн барилгууд дотор содон харагдана. Сүмийн талбайд дүнхийж байгаа хотын оршин суугчид “Штефель” гэж өхөөрдөн нэрлэдэг Гэгээн Стефаны сүмийн 140 метр өндөр гоолиг цамхаг нь тус хотын төв, билэг тэмдэг төдийгүй Австрийн гот дэгийн томоохон сүм ажээ.

“Штефель” сүм нь гурван зуу гаруй жилийн тэртээ боссон ч засварт олонтаа оржээ. Сүмийн цамхагийн сиймхий онгорхойгоор Дунай мөрөн түүний зүүн эргээс эхлэн үргэлжлэх тэгш талаас Венийн ойн өндөр довууд хүртэлх өргөн цэлгэр нутаг тод үзэгдэнэ.

Сүмийн өнгөт гялтгануур вааран дээвэр, хээ угалз битүү ханыг нэр нь мартагдсан уран гартнууд урлажээ. Дундад зууны үед Вена хотод туслах зэрэгтэй уран гартан мастерийн зэрэг хүртмэгцээ нэгэн модон шонд нэг хадаас хаддаг уламжлал тогтсон байв. Гоц чадвартай уран гартнуудын тоо тоймгүй олон болж өнөөх модон шон удсангүй “төмөр” шон болон хувирч байжээ. Тэрхүү “төмөр” болсон модон шон одоо “Штефель” сүмээс холгүйхэн дэлхийн сайхан хотуудын нэгийг бүтээн босгосон ард түмний хосгүй авьяас билэг, хичээнгүй зүтгэлийн билэг тэмдэг болон жуулчдын анхаарал шохоорхлыг гойд татсаар байна.

Гитлерчүүд 1945 онд Вена хотоос дүрвэн зугтахдаа Гэгээн Стефаны сүмд гал түймэр тавьсан нь гурван хоног дүрэлзэж дээвэр нь хуу шатаж 20 тонн жинтэй хонх газар унаж олон сайхан чимэглэл нь устжээ. Тэрчилэн дэлхийд алдартай олон хөгжимчин, хөгжмийн зохиолч тоглож байсан цуутай бадралт баг бишгүүр хөгжим мөн сүйджээ.

Вена хотыг баруун, өмнөд талаас нь алдарт Венийн ой хүрээлнэ. Энэ бол хотоос холдох тусам улам өндөр, эгц болдог Альпийн нурууны зах, налуу өндөрлөг ажээ.

Дундад зууны үед хотыг хүрээлүүлсэн цайзын хэрэмний буурин дээр үүссэн Рингштрассе гудамж нь тус хотын ёслолын зам болдог. Уг гудамжны хоёр талаар Австри улсын Засгийн

газрын байгууллагуудын гоёмсог байшингууд оршино.

Хотын засаг захиргааны билэг тэмдэг, бахархал болох Рыцарь эрийн баримлыг цамхагийн орой дээр нь босгосон гот дэгийн хотын захиргааны байр алсаас сүндэрлэн харагдана. Хотын захиргааны байшинг барьж эхлэхэд лам нар дэргэд нь байгаа сүмээс өндөр байх ёсгүй гэсэн шаардлага тавьсан учир хоёр метрээр намсгажээ. Гэвч Рыцарь эрийн баримал бэлэг болгон өгөхөд хотын захиргааны байрны дээврийн цамхагийг орой дээр байрлуулж сүмээс өндөр болгосон сонин түүхтэй ажээ.

“Цэнхэр Дунай” мөрний эрэг дээр орших нов ногоон үзэсгэлэнт Вена хот хүн бүрийн сэтгэлийг булаана. Вена, хөгжим гэсэн хоёр үг хоорондоо нягт холбоотой. Хотын гудамжаар алхаж явахад, байшингийн цонхноос В.А.Моцартын менуэт, Л.В.Бетховений сонат, И.Штраусын вальсын аялгуу сонсогдож сэтгэл хөглөнө.

Нэгэн шар айрагны газрын хүнхгэр таазанд уг шар айрагны газарт тухлан сууж тагтай том хундагаар шар айраг шимэн ууж баясаж байсан В.А.Моцарт, М.Твен, И.Штраус, Ф.Шаляпин, С.Цвейг, Э.Карузо нарын гарын үсгийн хуулбарыг сийлсэн байдаг.

Нэгэн давчуу муруй гудамж дахь эртний байшингуудын нэгэнд суут хөгжмийн зохиолч Ф.Шуберт суудаг байжээ. Тэрбээр гудамж руу харсан цонхныхоо тагтнаас халаасыг нь эргүүлэн унжуулсан өмдөө өлгөж өр нэхэж ирсэн хүмүүст мөнгөгүй байгаагаа ойлгуулдаг байжээ.

Вена хотыг инээд хөөр, тансаг байдал, хувцасны цоо шинэ загвар, хөгжим бүжгээр гайхагдаж байгааг нь үнэлж XVIII зуунд дэлхий даяараа “хөгжөөнтэй хот” гэж дээдлэн хүндэтгэдэг байжээ. Вена хотын нэрийг хэлэхэд л вальс бүжгийн сайхан аялгуу чихэнд сонсогдож сүүдэрхэг Венийн ой, “Цэнхэр Дунай” мөрний үелзэх долгио нүдэнд харагдаж сэтгэл баясна.

## ВАРШАВ

Европийн хуучны бусад хотын адил Варшав нь мөн эртний хот билээ. Хот үүсэхэд усан онгоц, завь аргамжихад тохиромжтой өндөр эрэг бүхий том мөрөн, гол чухал ач холбогдолтой байлаа. Висла мөрөнд Буг, Нарев хоёр гол цутгадаг тэр газар, эрэг дээр хот бий болжээ.



Варшав нь Краков, Познань зэрэг польшийн бусад хотоос илүү түрүү үед үүсэн ч чухам яг хэдийд үүссэн нь тодорхой бус байна. Энд X зуунд эртний полянуудын удам болох польшууд Висла мөрний баруун эрэг дээр Старе Брудно суурин байгуулан амьдарч байв. Хоёр зуун жилийн дараа мөрний зүүн эрэг амилж Уяздов, Солец суурингууд бий болж хүн амын тоо түргэн нэмэгдэж хоёр эрэг дагуу гуч гаруй тосгон байгуулагдсан нь яваандаа дагуул хот, гудамжууд болжээ.

XIII зууны үед Висла мөрний зүүн эрэг дээр цайз баригдаж түүнийг тойрон нэгэн тосгон байгуулагдсан нь тус хотын эх суурь болох Хуучин хот-Старувка байв. Уялдов тосгонд амьдардаг Мазовецкий вангийн төлөөлөгч-каштелян тэр цайзанд суудаг байв.

Варшав хотын нэр хэрхэн үүссэн тухай олон хувилбар байдаг. Эх орондоо хавчилгад өртөж 1108 онд Мазовецкийн вант улсад гэр бүл, олон тооны дагуулуудтайгаа ирж сууршисан баян чех эр Варшев(Варшов)-ийн нэрнээс тус хотын нэр үүссэн гэдэг. Тэрбээр Висла мөрний эх хавьд сууршиж тэр газраа Прага дараа нь нөгөө эрэгт уулархаг газар нүүдэллэж, тэр газраа Варшав гэж нэрлэсэн гэнэ.

Гэтэл зарим эрдэмтэн зөрж чех хүн огт байгаагүй, цайзанд сууж байсан каштелян Варцислав гэдэг хүний нэрнээс хотын нэр гарчээ гэдэг. Зарим судлаач, Висла мөрний эрэг дагуу амьдардаг загасчид загас барихдаа хэрэглэдэг байсан ороонго өвсөөр сүлжиж хийсэн урт сагсны “верши” нэрнээс тус улсын нийслэлийн алдар нэр бий болжээ гэсэн таамаглал дэвшүүлдэг.

Он жилүүд өнгөрч 1378 оны түймрийн дараа хотыг шинэ хэрмээр хүрээлүүлснээс хотын хүрээ улам тэлж Нове Место тосгон Старувкатай хойд талаас нь нийлэв. Модон байшин, тариан талбай, тариачдын аж ахуйгаас өөр ялгарахгүй зүйлгүй хотод бөө мөргөлийн сүмийн буурин дээр барьсан Эх Дагинын сүм л онцгойрч байлаа.

Мазовецкийн угсааны бас нэг ван Януш Варшавын вант улсыг (XV-XVI) үндэслэж Варшавыг нийслэлээрээ өргөмжилж бүх хөрөнгө, мөнгөө хотыг өргөжүүлэхэд зарцуулж оршин суугчдын орлогыг нэмэгдүүлж хил хязгаарыг тэлснээр хөгжлийн шинэ үе шатанд гаргажээ. Тэр үед П.Брун, Н.Панчатка гэдэг хоёр иргэн Солец тосгоныг дэлгүүр, усан тээрэм, хэд хэдэн жижиг үйлдвэрийн хамт хотын захиргааны мэдэлд шилжүүлэн өгч байжээ.

Хотын аж ахуй, нийгэм, улс төрийн амьдралын төв нь Старувка дүүргийн Зах байв. Вавелийн шилтгээнд гал гарсны дараа гуравдугаар Зигмунд хаан нийслэлээ Краковоос Варшав хот руу шилжүүлэх үед Захын талбайд Хотын захиргааны байшинг босгожээ. Уг байшинг 1818 онд буулгажээ.

Гоо сайхны урлагийг бишрэн шүтэгч гуравдугаар Зигмунд хаан харьяат иргэддээ Варшав, түүний ойр орчмын нутагт үзэмж төгс барилга барихыг хөхүүлэн дэмжиж байлаа. Хааны ордныг дагаж Варшавт ирж сууршисан польшийн баячууд газар худалдан авч италийн уран барилгын “палаццо” дэгээр ордон, шилтгээн дараалан барьж байжээ.

Гуравдугаар Зигмунд хааны хүү Владислав эцгийнхээ дурсгалд зориулж орой дээр нь баруун гартаа тахир сэлэм, зүүн гартаа хөшөөнөөс хэмжээний хувьд том хэрээс барьсан, хааны нөмрөгөө тайлж байхад нь рыцарь эрийн хуяг нь ил гарч байгаа хааны баримлыг 1644 онд босгожээ. Хааны зэсэн баримлыг гантиган багана дээр суурилуулжээ. Угтаа бол гуравдугаар Зигмунд хаан 1607 онд шляхт тайж нарын бослогыг дарсны дурсгалд зориулж гоо үзэмжээрээ ромын хөшөө дурсгалуудыг давах багана босгохыг хүсэж байсан ч тээвэрлэх явцад баганад ан цав гарсан учир больжээ. Хүү нь тэрхүү баганын хэсгийг эцэгтээ зориулсан багана босгоход ашиглажээ.

Дэлхийн хоёрдугаар дайны үед обергруппенфюрер фон ден Бах Варшав хотын оршин суугчдыг номхруулж газрыг хөрстэй тэгшлэх тухай Гитлерийн тухай захирамжийг авч эзэгнэн байсан таван жилийн хугацаанд польшийн нийслэлийн байшин, гудамжийг гаргасан төлөвлөгөөний дагуу ээлж дараалан агаарт хийсгэж байв. Нийт байшин барилгын 85 хувийг эвдэн сүйтгэж хотын гудамж, талбай, сүм, ордны асар том оршуулгын газар болгон хувиргаж хот хүн амьтангүй эль хуль болсон байв.

Зөвхөн гитлерчүүд эзэгнэн сууж байсан байшингууд л эвдэрсэнгүй үлдсэн юм. Польшийн цэргийн гудамжны нэгэн байшингийн хажуугаар хотын оршин суугчид явж байхдаа яагаад ч гудамжны нөгөө тал руу гардаг. Варшавчууд “трамвай” гэж нэрлэсэн тэр байшинд дайны үед гестапо, урьдчилан хорих шорон байжээ. “Трамвай”-д суусан хүн эргэж ирж байсан удаагүй ажээ.

1945 оны нэгдүгээр сард Зөвлөлтийн арми, Польшийн цэргүүд амь өрсөн тулалдаан хийж хотыг чөлөөлөхөд, хотын гудамж талбайд 700 мянган варшавчуудын үхдэл дүүрсэн, зөвхөн 162 мянга хүн амьд мэнд байв.

Гэвч чөлөөлөгч цэргүүдийн хамт дүрвэсэн иргэд явганаар, унадаг дугуй унаж хүүхдээ суулгасан тэргээ чирэн төрөлх хотдоо ирэхдээ нийслэл хотоо танисангүй. Хааны шилтгээн, ордон шилтгээн цөмийг нурааж сүйтгэжээ. Аугаа одон оронч Н.Коперник, яруу найрагч А.Мицкевич, 1794 оны бослогын баатар Я.Килинский, Зигмунд хааны баримал алга болсон

байлаа.

Варшав хотын хамгийн хуучны байшин нь эртний домгоор Польш улсын нийслэлийн нэр үүссэн гэдэг домогт Варша, Савы хоёр хөвгүүн төрсөн овоохой байсан газар барьсан “Мазовецкий вангийнхны ордон” байжээ. Нэгэн домогт өгүүлэхдээ:

Ван нэгэн удаа ан хийж яваад төөрч загасчны овоохойд очиход хоёр нярай хүүхдээ тэвэрсэн Ева хэмээх бүсгүй байж гэнэ. Ван хоёр хөвгүүнд Варша, Савы гэдэг нэр өгч загасчны гэр бүлд ихээхэн зоос бэлэглэжээ. Тэр мөнгөөр нь загасчин эр байшин барьж бусад загасчид нь эргэн тойронд ирж сууршиж Варшав хот бий болжээ. Хожим нь загасчны овоохой байсан газар Мазовецкий ван ордон босгож Варшав хотыг үндэслэгчдийг дурсаж ордныхоо нэг буланд хоёр хүүхдээ тэвэрсэн Ева бүсгүйн баримлыг хүндэтгэлтэй залжээ.

Варшав хотын хамгийн эртний сүм нь Гэгээн Иоанны сүм ажээ. Сүмийн гол шүтээний хажууд олон түмэн “Хөгшин Езус пан” гэж нэрлэдэг том модон хэрээс бүхий жижиг “Есус бурхны сүм” бий.

Варшавчууд үнс, нурмаас төрөлх хотоо сэргээж чадсан гайхамшигтай хөдөлмөрч хүмүүс билээ. Хотын сүлдэнд мөнхөрсөн грекийн домгийн Сиренка бүсгүй үнэхээр ид шидийн хүчтэй ажээ. Варшавчууд юуны түрүүнд Старувка дүүргийг сэргээв. Висла мөрний эрэг дээр гарч Старувка дүүрэг рүү харахад эргэн тойрон байшин барилга биш чухамдаа саарал, хүрэн, улаан, ягаан өнгийн, мөөг, нарны халхавч, бүрх малгай шиг, дөрвөлжин гээд түмэн хэлбэрийн дээвэр үзэгдэнэ. Босоо, налуу, эгц, хавтгай, өргөн, нарийн дээврүүдээс сонин хийцийн яндангууд цухуйна.

Варшавын эртний гудамжуудын нэг нь XIII зуунд бий болсон Шар айрагны гудамж юм. Анхандаа модон байсныг нь чулуун болгон сольсон байшингуудын нүүрэн тал нь их давчуу, хоёроос гуравхан цонхтой. Энэ гудамжинд хоорондоо адилхан ганц ч байшин байхгүй, бүгд нэг нэгнээсээ ялгагдана. Жишээ нь хааны тамгын газар байрлаж байсан нэгэн байшингийн гол хаалганы дээр Польшийн сүлд болох бүргэдийн дүрс байна. Бас нэг байшингийн дээр ямаа дагуулсан Христ хүүгийн баримал харагдана. Өнөр өтгөн айлын эзэн хүүхдүүдээ Аврагчид даатгаж уг баримлыг босгожээ.

Коперникийн нэрэмжит талбайн төвд “нарыг зогсоож газрыг хөдөлгөсөн” их одон орончийн хөшөө байна. Уран барималч Б.Торбальдсений урласан энэ хөшөө анхандаа Шинжлэх ухаан сонирхогчдын нийгэмлэгийн байрны үүдэнд байжээ. Хөшөөний тавцангийн хоёр хананд “Николай Коперник Танаа Эх орон нэгтнүүдээс нь” гэсэн үгсийг латин, польш хэлээр сийлсэн байв. Фашистууд латин үсгээр сийлсэн бичээсийг арилгаж гот үсгээр “Алдарт эрдэмтэн Коперник” гэсэн үгтэй самбар өлгөжээ. Тэгтэл польшийн партизанууд самбарыг хэдэнтээ хулгайлж гитлерчүүд залхаж дахин самбар өлгөхөө больжээ.

“Варшав зөвхөн газар зүйн ойлголт болсон” гэж Гитлерт сайрхан тайлагнаж байсан хүмүүсийн нэрс аль хэдийнээ мартагдаж шинэ Варшав улам өнгөжин жавхаажсаар байна.

## ТОМБУКТУ

Европийн судлаачид Томбукту хотыг аль эрт дээр үеэс нууцлаг, битүүлэг хот гэж нэрлэсээр иржээ. Сахарын цөлийн өмнөд хэсэгт өнөөгийн Бүгд Найрамдах Мали улсын нутаг дэвсгэр дээр орших Томбукту хот нь Баруун Суданы худалдаа, соёлын эртний төв ажээ. Хотын нэр алдар нутгийн хүн амын дотор төдийгүй африк тивээс хальсан байлаа.



Хотын бусад байгууламжийн адил жирийн нэгэн ганц давхар байшингийн хашаа дотор байгаа элсэнд 50 сантиметр гүнзгий ухаг гаргасан Букту хэмээх жижигхэн худгаас эл хот үүсчээ.

XI зуунд ирээдүйн хотын нутаг дэвсгэр дээр үр тарианы агуулах, Нигер голын эргээс хэдэн километр зайтайд нүүдэлчин туарег омгийнхны гаргасан худаг байв. Өргөн Нигер голын ус дорно зүг аажим урсана. Борооны улирал эхлэмэгц туарег омгийнхон цацар майхнуудаа буулгаж малаа хариулан хойд зүг одож Букту нэртэй хөгшин боол эмэгтэй үр тарианы агуулах, худгаа сахин хоцорно. Нүүдэлчид буцах замд гарахдаа “Тим Букту” буюу “Буктуг чиглээд” гэсэн үгийг хэлнэ. Энэ үг нь яваандаа нүүдэлчдийн суурин дараа нь хотын нэр болж хожим нь “Томбукту” гэж дуудагдах болжээ.

Мали улсын түүхийн хамгийн хүчирхэг Канку Мусса хааны ноёрхлын үед XIV зуунд хот хөгжлийнхөө оргилд хүрчээ. Тэр үед тус улс Атлантын далайгаас Чад нуур хүртэлх өргөн уудам нутагт оршин тогтнож байв. Канку Мусса хаан лалын шашны шүтлэгтний хувьд ариун Мекка хот орж мөргөл хийж буцан ирснийхээ дараа хожим нь Баруун Африкийн лалын шашны бүх хийдийн үлгэр жишээ болсон шинэ сүмүүдийг нийслэлдээ бариулж эхлэжээ. Тэр үед Томбукту хотод хананаас нь гадагш сэртийн гарсан модон шонгууд бүхий өвөрмөц гоё сүмүүд бий болсон нь өнөөг хүрчээ. Сүмийн пирамид хэлбэрийн ганжирыг харуулын цамхаг, удаан хугацааны бүслэлтийн үед хүнсний агуулахын зориулалтаар ашиглаж болохоор багтаамж сайтай хийжээ.

Ойрхи Дорнодын орнууд болон лалын шашны ариун нутгаар явж нүд тайлсан Канку Мусса хаан нийслэлээ гоёмсог хот болгохоор зорихдоо чамин гоё сүм олныг барьж худалдаа арилжааг хөгжүүлэхэд онцгой анхаарч байлаа. Тэгээд Томбукту хот руу баялаг урсаж өмнө зүгээс завиар алт, зааны яс, хар мод, хойд зүгээс жингийн цуваагаар венецийн сувд,



дамасскийн даавуу, үнэртэн, сав суулга, давс тээвэрлэн авчирна.

Томбукту хот алт, чамин сонин бараа бүтээгдэхүүнээр төдийгүй шашны сургууль, номын сангуудаараа гайхагдана. Асар их баялаг хуримтлагдсан нь боловсрол, соёл үсрэнгүй хөгжих үндэс суурь болж байжээ.

XV-XVI зуунуудад Томбукту лалын шашны томоохон төвүүдийн нэг болон хувирчээ. Мавруудыг хөөсний дараа Испаниас оргон ирсэн арабын зарим эрдэмтэн Томбукту хотод шилжин сууршихдаа шинжлэх ухааны судар шашдир олныг авчирчээ. Санкор сүмийн дэргэд их сургууль байгуулагдаж төдөлгүй Кордова, Каир, Дамасск, Фес хотуудын их сургуулиудтай эн зэрэгцэх их сургууль болж арабын ертөнц даяар алдаршжээ. Египет, Турк зэрэг олон орноос ирсэн оюутнууд их сургуулийн нэртэй эрдэмтэд, шашин судлаач, уран илтгэгч нарын лекцийг сонсохоор хашаагаар пиг дүүрнэ. Их сургуульд лалын шашны Коран судраас гадна байгалийн шинжлэх ухаан, утга зохиол, түүх, гүн ухаан, газар зүй судална.

Хотод байгуулагдсан номын хадгаламжийн газруудад эртний гар бичмэлүүд хуулан бичиж орон нутгийн омог, аймгуудын түүхийн тэмдэглэлийг хийнэ. Үүнд Сонгаи улсын түүхийн тухай “Улс орон, арми, язгууртнуудын тухай эрэн хайгчийн тайлан”-г дурдаж болно. Тэр түүхэн бичигт тэр үеийн амьдрал, шашин, соёлын тухай дэлгэрэнгүй өгүүлсэн бий. Загалмайлуулж Жованни Леоне нэр авч Африкийн Арслан хочтой болсон олзны мавр иргэн Хасан ибн-Мухаммед-аль-Ваззан Баруун Суданд 1511-1515 онуудад зорчсон тухай бичихдээ “Хаан нь алтан ембүү гээд асар их баялаг эзэмшинэ... Хаан эрдэм номтой хүмүүсийг хүндэтгэн дээдэлнэ... Тэнд ховор гар бичмэлүүд худалдаж бусад бүтээгдэхүүн борлууснаас илүү орлого олно.” гэж онцлон дурдаж байв.

Баян тансаг Томбукту хотын тухай сураг чимээ Орос улсад хүрэхэд гүн Г.Орлов Парижийн Газар зүйн нийгэмлэгт мянган франк хандивлаж Томбукту хотод хүрч дэлгэрэнгүй мэдээлэл авчирсан европийн анхны иргэнийг урамшуулах шагнал бий болгохыг хүсчээ. Томбукту хотод хүрч очсон европийн анхны иргэн нь Английн армийн хошууч Александр Гордон Лэнг байсан хийгээд тэнд 1826 онд нас баржээ.

Тэнд байхдаа түүний сууж байсан байшинд дурсгалын самбар өлгөжээ. А.Г.Лэнгийн байшингаас холгүйхэн, хотын тухай томоохон тэмдэглэл нийтлүүлсэн францийн иргэн Рене Кайе, германий иргэн Г.Барт нарт зориулсан дурсгалын самбар мөн байрлуулжээ. Рене Кайе христос шашинтнууд зорчдоггүй хотод 1828 онд лалын шашинтны дүрээр нэвтэрч байжээ.

XIX зууны сүүлчээс Африк тивийг тойрч тэнгисээр ачаа тээвэрлэдэг болсноор Томбукту хот Сахарын цөлийг дайрсан худалдааны жингийн цувааны төгсгөлийн цэгийн ач холбогдлоо алджээ. Хотын хүн амын тоо багасаж, XV зуунд 45 мянган хүн амьдардаг байсан бол одоо 8 мянган орчим хүн сууж байна. Хотын оршин суугчдын дийлэнх нь жижиг наймаа эрхэлж бэлэг дурсгалын эд зүйлс хийж амьжиргаагаа залгуулж байна.

Томбукту хот аж ахуйн ач холбогдлоо алдсан ч лалын соёлын африкийн томоохон төв хэвээр байна. 1960-аад оны дундуур малталт хийхэд нийтдээ таван мянга гаруй ховор ном, судар бүхий гурван номын сан гарчээ. Эндхийн омгийн удирдагч ч бай, ядуу хүн ч бай ялгаагүй, ховор судар, ном олсон бол гэртээ шүтээн болгон залж ямар ч өндөр үнэ амласан

худалддаггүй ажээ.

Хот олон зууны хугацаанд ихээхэн өөрчлөгдөж чулуун давс тэгнэсэн тэмээн жингийн цуваа жилд хоёр гурван удаа ирнэ. Эрт дээр цагт алт, мөнгө, цаасан мөнгө гараагүй үед нутгийн оршин суугчид давсаар хэмжиж хоорондоо наймаа хийдэг байсан болохоор одоо ч давсыг дээдлэн биширнэ.

Бүгд Найрамдах Мали улсын иргэн бүр Томбукту хотыг эх орныхоо түүх, өнөө үеийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үзэж бахархан хүндэлнэ. Эртний энэ хотыг “Сахарын цөлийн өмнөд хаалга”, “Эртний Суданы сувд эрдэнэ”, “Нууцлаг Томбукту” гэж олон янзаар нэрлэнэ.

## ЭДИНБУРГ

Шотланд виски, шотланд хөөрөгт хуурцаг, шотланд ноос, шотланд овчарк гэх зэрэг нэр, ойлголтыг хаа сайгүй мэднэ. Энэ сайхан нутагт Г.Бернс, В.Скотт гээд дэлхийд цуутай хүмүүс уран бүтээлээ туурвиж байсан бөгөөд үе үеийн шотландчууд тэмцэл, ялалтаар дүүрэн баялаг түүхийнхээ бүхий л дурсгалт зүйлсийг нандигнан хадгалсаар иржээ.



Шотланд нь бас утааны яндангаараа алдартай билээ. Тус улсын эртний нийслэл болох Эдинбург хотод орон сууцны тохилог байшингуудад хичнээн задгай зуух, утааны яндан байгааг тоолж баршгүй билээ. Тус хот хөдөө аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой газар нутгийн төвд оршдог болохоор аль дээр үеэс эрчтэй хөгжиж байжээ. Хотын худалдаачид алс холын Фландр, Скандинавын арлууд, Германы хойд нутагт хүрч арилжаа хийдэг байв.

Энэ хотын буурал түүх асар том цул хүрмэн чулуун хаднаас ургаж боссон мэт санагдах цайзнаас эхтэй ажээ. XVIII зууны дунд үе хүртэл тэр цайзын түүх тус хотын түүх болж байлаа.

Домогт өгүүлснээр Шотландын Макбет хааны алсан гэдэг Дункан хааны үе залгамжлагч, төрсөн хүү гуравдугаар Малькольмийн ноёрхлын үеэс тэр цайзын тухай мэдээлэл байдаг. Цайз, хотын түүхэнд тэмдэглэлт тэр үеийн тухай дурсгал нь гүн Малькольмийн шүтлэг ихтэй хатны нэрээр нэрлэсэн Цайзны хадны орой дээр барьсан Гэгээн Маргарита жижигхэн сүм билээ.

Шотландын уугуул хүн ам болох пиктүүд эх газрын зүгээс Британы арал руу халдан ирсэн англосаксчуудтай хоёр зуу гаруй жилийн туршид байлдаж байжээ. Гэвч VII зуунд саксчуудад дийлдэж XI зуун хүртэл англосаксчуудын ханлигуудаас хамгийн хүчирхэг нь болох Нортумбрын ханлигийн захиргаанд байжээ.

Тус хот анх кельт хэлээр “Динэдин” нэртэй буюу “Хадны налуу дээр оршин буй цайз” гэсэн утгатай байжээ. Дараа нь Нортумбрын хаан Эдвинтэй адилхан дуудлагатай болгож Эдвинсбург гэж нэрлэжээ. Хожим нь дээрх хоёр нэрийг нэгтгэж өнөөгийн Эдинбург гэсэн нэрийг бий болгожээ.

Жижигхэн, хүчин чадал дорой шотланд орон олон зууны туршид тусгаар тогтнол, бие даасан байдлынхаа төлөө тууштай тэмцэж Англитай удтал байлдаж их зовлон гачаал туулж хатуужжээ.

Английн нэгдүгээр Эдуард хаан 1296 онд цайзыг эзлэн түрэмгийлж 17 жил ноёрхож байх хугацаандаа шотландын түүхтэй холбоотой бүх архив, үнэт зүйлсийг Лондон хот руу шилжүүлэн аваачжээ. Тэрчилэн Гэгээн Маргарита сүмээс бусад бүх барилга байгууламжийг эвдэн нураасан байв.

Эрх чөлөөнийхөө төлөө цуцалтгүй тэмцэж сурсан шотландчууд дахин тэмцэлд босож гүн Морейн удирдлагаар англичуудыг эх нутгаасаа үлдэн хөөжээ.

Эдинбургийн цайзын бэлээс Хуучин хот баригдаж эхэлжээ. Хуучин хотод хадан хясааны налуугаар баруунаас зүүн тийш тавьсан цорын ганц гудамжаар нь л машин явж болно. Тэр замаар явсаар Шотландын Мария Стюарт хатан хааны зуны Холируд ордонд хүрдэг.

Сум шиг тэгш Принсес-стрит буюу Ханхүүгийн гудамж Эдинбург хотыг хоёр хэсэгт хуваажээ. Энд Гэгээн Иоанны сүмийг барьсан үеэс уг гудамжны өмнөд хэсэгт аливаа байшин барихыг хоригложээ. Цайзны бэлд байсан Нор Лох нуурын усыг ширгээж хотын чимэг болох цэцэрлэгт хүрээлэн, ногоон нуга байгуулах болзолтойгоор иргэддээ 1820 оноос өмчлүүлжээ. Баячуудын хувьд Принсес-стрит гудамжны цэцэрлэгийг мөнгөөр зодож эзэмшилдээ авах нь нэр төрийн хэрэг байдаг байна. Дорнод цэцэрлэгт хүрээлэнгийн нэгэн цэцэрлэгийг эзэмших хүндэт эрхийг английн суут зохиолч Вальтер Скоттод олгож байжээ.

Тэр цэцэрлэг нь тал бүртэй нуман хаалга бүхий дөрвөлжин цамхагаас гот хийцийн сүмийн ганжирыг санагдуулсан 60 метр өндөр чулуун байгууламж байна. Нуман хаалганы сараалжны завсраар харахад их зохиолч өвдөг дээрээ ном тавьчихсан сууж байгаа, хажууд нь хайртай нохой нь түүн рүү ширтэн байгаа хөшөөг цагаан гантигаар урлаж байрлуулсан нь үзэгдэнэ. Хөшөөний тавцангийн хажуу хананууд дахь хонхорхойнуудад В.Скоттын зохиолын баатруудын гүдгэр дүрсүүдийг сийлжээ.

Эдинбург хотод XVII зууны үед болсон тарваган тахлын үеэр халдвар авсан олон зуун хүнийг тусгаарлан хорьж байсан газар доорхи Мери Кинг хэмээх “хаалттай хотхон” байдаг. Хатан хаан сүм хүртэл нэг бээр зам явсан учир Хатан хааны бээр гэж нэрлэсэн гудамжны дор “хаалттай хотхон” байдаг юм.

Жижиг гарын наймаачид, хөлсний ажилчид, үзмэрч бариач, улс төрөөр хэнээрхэгчид, хулгайч луйварчин, дээрэмчид хөлсний алуурчид, биеэ үнэлэгч бүсгүйчүүд гээд нийгмийн элдэв бүтэлгүй хүмүүс Хатан хааны бээр гудамж дагуу пиг дүүрэн байдаг байжээ. Энд мөн зодоон, халз тулаан байнга болдог байсан учир залхаан цээрлүүлэх шүүх ажиллуулж тухайлбал гурван зуу шахам эмэгтэйг амьдаар нь шатаах зэрэг харгис арга хэмжээг авч байж энэ гудамжийг дэгтэй журамтай, амгалан тайвуун болгож байжээ.

Өнөө үед “хаалттай хотхон”-д очихдоо Хатан хааны бээр гудамжнаас хашлаганы бариул нь чийг даасан нарийхан шатаар 20 метр гүнд бууж нарийхан хонгилоор явж хүрнэ. “Хаалттай хотхон”-ы гудамж нь нам гүм, гэрэл гэгээгүй хонгил, догол гарц юм.

Гудамж дагуу орших байшингийн цонхнуудыг банз хадан таглаж модон хаалгыг шохой, сайр чулууны холимогоор хаажээ. Зарим байшин дотор нь дарсны агуулах, талх барьдаг зуух, хоолны сав суулганы шүүгээ, утааны яндан одоо ч байдаг. Гэхдээ нэгэн байшин жуулчид,

үзэгчдийн анхаарал, шохоорхлыг гойд татна. Тэр байшин дотор байхад агаарын хэм гэнэт дээд доош болон савлан өөрчлөгдөх юм, ноорхой, хир даасан хувцастай, гартаа хугалсан хүүхэлдэй барьсан нэгэн бяцхан охин тасалгаа дотор шурхийн хийн гүйхийг харсан гэж жуулчид ам нийлүүлэн ярьдаг. Заримдаа гэрэл зургийн аппаратын дамар өөрөө эргэлдэж зарим хальс нь гэрэлд цохиулчихсан байдаг нь хачирхалтай.

## ОСЛО

Норвег улсад бүх зүйл викингүүдтэй холбоотой байдгийн адил Осло хотын түүх мөн тэдэнтэй нягт холбоотой билээ. 1043 онд рыцарь эр Геральд Хардроде эзлэн авсан дорно зүгийн сайхан хот Стамбулыг орхиж Норвегийн хаан болохоор нутаг буцах зам зуур хүчирхэг холбоотонтой болж дэмжлэг олж авах зорилгоор Киев хотоор дайрахдаа Ярославль вангийн охин Елизаветаг хатнаа болгон дагуулан иржээ.



1047 онд Норвегийн хаанаар өргөмжлөгдөж дараа жил нь улсынхаа өмнөд хэсэгт Лу голын адагт цэргийн бэхлэлт барьж “Лу голын адаг” буюу Осло гэж нэрийджээ.

Осло хот тус орныг Швед, Дани болон өрнөд европийн бусад хоттой холбодог дээр дурдсан хоёр улсын хөгжингүй муж, гол хотуудтай ойролцоо оршино. Тус орныг түүхийн тодорхой үе шатуудад Дани, Швед орнууд түрэмгийлэн захирч байсан тул эдгээр улс орны нөлөө багагүй үлдсэн байна. Ялангуяа Копенгаген хотын нөлөө удтал үргэлжилсэн байдаг.

Осло, Копенгаген хоёр хот хөлддөггүй тэнгисийн эрэг дээр адилхан оршдог болохоор усан боомтын үйлдвэрлэл өндөр түвшинд хүрсэн байна. Түүнээс гадна Осло нь улс орныхоо гүнээс урсдаг олон голын ойролцоо байрлалтай учир модны аж үйлдвэр хурдацтай хөгжсөөр иржээ.

Олон удаа түймэрт өртөж байснаас 1614 оны аймшигт түймэрт бүрэн сүйдсэн учир түүний хажууд шинэ хот байгуулж Данийн IV Христиана хатан хааны нэрээр “Христиани” гэжээ. Осло нэрээ 1925 онд буцаан авчээ.

Умардын дайны үед шведийн арми Христиани хотыг эзлэж үнсэн товрог болгосныг сэргээн босгоход ихээхэн хугацаа зарцуулж байжээ. 1814 онд Христиани хотыг Норвег улсын нийслэлээр зарлажээ. Европийн орнуудын хаад Килийн энх тайвны гэрээгээр, Норвег улсыг Францийн Наполеон хааны холбоотон байсан гэж шийтгэл ногдуулж түүнийг Данийн бүрэлдэхүүнээс гаргаж норвегийн ард түмнээс гаргасан тусгаар улс байх хүсэлтийг нь эс харгалзан Финланд улсын бүрэлдэхүүнээс гарсны нь төлбөр болгож Швед улсын захиргаанд Норвег улсыг шилжүүлжээ.

Холменкаллен дов дээрээс алдарт цанын гулгуурын өндөрлөгөөс Осло хот руу шөнийн харанхуйд харахад, үй түмэн гэрэл солонгорч том хот мэт сэтгэгдэл төрүүлнэ. Тэрбээр битүү хад асгатай тэнгисийн буланг тэнгэрийн хязгаар хүртэл тэвэрч арлууд дамжин задгай тэнгис хүртэл үргэлжилнэ. Гэвч доош буун очиход жижигхэн хот болох нь мэдэгдэнэ.

Осло хотын баруун хэсэг дэх гудамж, талбайд хөл хөдөлгөөн бага, гачуур нарс модны дунд чамин ганган шилтгээн, харш эгнэн байна. Хэрэм мод дамжин үсрэн дүүлж байгаа нь үнэхээр сонин. Осло нь Норвегийн бусад хотын адил байгальд их ойрхон, гудамж, талбай нь тэнгис рүү хөтлөн хүргэнэ. Зарим гудамж нь эгц хадан ууланд тулж ой мод, тал дундуур далдарна.

Европийн дундад зууны хотуудын нэгэн адил Осло хотын Захиргааны байр нь улаан тойпуугаар өнгөлсөн, уран барилгын өвөрмөц сонин хийцтэй байшин юм. Уг байрны хоёр өргөн цамхаг нь алсаас тод үзэгдэнэ. Байрны гол хаалганы дээд талд эмэгтэйчүүдийн тэгш эрхийн билэгдэл болгож норвег бүсгүйн баримал байрлуулжээ.

Хотын захиргааны байрны 21 метр өндөр таазтай том Төв танхимын ханыг ажилчны хөдөлгөөний түүх, худалдааны төв, гестапчууд айлын байранд түрэмгийлэн дайран орж байгаа, Гэгээн Хольвардын амьдрал, үйл ажиллагаа зэрэг янз бүрийн сэдэвтэй зургаар чимэглэжээ. Хотын Захиргааны байрны тэнгисийн эрэг рүү харсан талд уг байшинг барьсан ажилчдын мэргэжлийг билэгдсэн зургаан хүрэл баримал байна.

Хотын ойролцоох хад асгатай олон уулын нэг дээр дайны өмнөхөн “Нарлаг хөндийн дуулал” киноны гол дүрд тоглосон жүжигчин эмэгтэй Сони Хени түүний нөхөр, нэрт бизнесмен Н.Унстад нар хөрөнгө гаргаж 1968 онд Уран сайхны музей нээжээ. Шил, бетон, хөнгөн цагаанаар босгосон музейн барилгыг дээрээс нь харахад таван хурууных нь оронд үл мэдэх цэцгийн таван дэлбээг дүрсэлсэн гарын алганы хэлбэртэй юм шиг харагдана.

Бюгдай хагас арал дээр нээсэн “Норвегийн алдрын музей” их цуутай билээ. Энэ музейд норвегийн алдарт далайчдын усан хөлгүүд, викингүүдийн дээш сэрдийсэн шовх, хотойлгосон хошуутай завиуд зэргийг уудам цэлгэр танхимуудад байрлуулсан байна. Эртний завиудыг хийсэн хар царс мод нь нүүрс шиг гялтганана.

Том шилэн хоргууд дотор викингүүдийн нүсэр хүнд завиудыг тухайлбал Фритьоф Нансен, Р.Амундсен нарын домогт “Фрам” завь, Тур Хейердалийн “Кон-Тики” гуалин сал зэргийг мөнхийн зогсоолд тавьжээ. “Кон-Тики” салыг доод давхраас харахад замаг дун наалдан орооцолдсон ул түүнээс унжсан “усанд шумбадаг” сагс үзэгдэнэ.

Дөрвөн өнцөгт дэн өлгөсөн, элдэв дүрслэлтэй сараалжин гулдан хаалгатай Фрогнерийн цэцэрлэгт хүрээлэнгийн түүх маш сонирхолтой ажээ. Дөрвөн өнцөгт дэн өлгөсөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дүрс бүхий сараалжаар цэцэрлэгт хүрээлэнгийн төв дов руу хүргэсэн гишгүүр бүхий жижиг талбайг хүрээлүүлжээ.

1914 онд энэ цэцэрлэгт хүрээлэн дотор үзэсгэлэн гаргахаар бэлтгэж байхдаа уран барималч Г.Вигелланд хандаж усан оргилуурын төсөл зураг хийх хүсэлт тавихад усан оргилуурын оронд асар том уран баримлын зохиомжоор цэцэрлэгт хүрээлэнг чимэх санал сөргүүлэн

гаргажээ. Энэхүү уран баримлын зохиомж нь хүний амьдралыг төрөхөөс нь үхэх хүртэл харуулсан, хүүхэд, залуу нас, азтай болон бүтэлгүй дурлал, эх болж байгаа, үерхэл, зугаа цэнгэл, тэмцэл, бодлогошрол, гуниг зовлон, өвчин, хөгшрөл, үхэл, шинэ амьдралыг билэгдсэн боржин, хүрэл, ширэм, төмрөөр урласан нийтдээ гурван зуу дүрс бүхий уран баримлаас бүрдэнэ.

Аливаа бодитой баримал ч мөн билэгдлийн утга агуулдаг билээ. Тухайлбал “Сайн сайхны төлөө хүн төрөлхтөний тэмүүлэл” гэрэлт хөшөөнд амь эрсдэж байгаа эрчүүд эмэгтэйчүүдийг, эмэгтэйчүүд нь цэх зогсож, нар өөд тэмүүлсэн хүүхдүүдийг дараалан дороос нь тулж байна.

Уран барималч Г.Вигеллан 17 метр өндөр, 270 тонн жинтэй энэхүү гэрэлт хөшөөг босгохдоо л гэхэд амьдралынхаа бүтэн 15 жилийг зарцуулжээ.



## МОСКВА

1147 оны хавар Москвагийн анхны эзэмшигч, тайж Кучкиний эдлэн газарт оросын хоёр ван уулзсаны нэг нь саяхан Смоленск нутаг руу дайлаар мордоод ирсэн ван Святослав Северский, нөгөө нь Торжок хотыг түйвээж Мста голын сав нутгийг байлдан дагуулсан Суздалийн ван Юрий Владимирович Долгорукий байв. Юрий Долгорукий дайн хийж их олз олсны дараа анд ванд хандаж “Ах минь Москов руу ир !” гэж хэлүүлсэн байжээ.



Хоёр ван Москва голын эрэг дээр тайжийн эдлэн газрын байр байгаа өтгөн ойн дунд уулзан учирч хэд хоног хөгжилдөн наргиж бэлэг сэлт солилцсоны дараа салж оджээ. 9 жилийн дараа түүхч бичихдээ “Ван Юрий уул өөд гарч Москва голын хоёр эрэг түүний цаана Неглинная голыг тольдон харж бахдан магтаад бяцхан хот, тосгоны шав тавих зарлиг буулгажээ.” гэж онцлон өгүүлжээ.

Гэхдээ түүхэн уран зохиолд, Москваг үндэслэгч гэж Юрий Долгорукийг үздэггүй. Түүнийг энэ нутагт хөл тавихад Боровицкийн дов түүний бэлээр цайзыг тойруулан ухсан гуу жалга, томоохон аж ахуйтай хот аль хэдийнээ бий болсон байжээ.

Москва хот хэрхэн үүссэн үүх түүхийн талаар эрдэмтэд, түүхчид өнөөдөр ч толгойгоо гашилгасаар байна. Святослав ван Хазарын Итиль хотыг дайтахаар мордохдоо үүгээр дайрсан эсэх тэрчилэн ростов-суздалийн ой, хөндий тал, гол мөрнийг гартаа багтай оруулахаар ирсэн Владимир Мономах ч мөн энэ нутгийн сайхныг олж харсан эсэх талаар маргаан үргэлжилсээр байна. Гэтэл хуучны судлалын малталтаар Армян, Дундад Азийн мөнгөн зоос, өнөөгийн Кремлийн ордны баруун-өмнөд булангийн хавиар дайрсан хамгаалалтын гүнзгий гуу жалга, 1093-1096 оны үеийн христос шашны сүмийн тамга, тэр тамганы үеийн чулуу дэвссэн явган замын хэсэг илэрч эрдэмтдийг мухардалд оруулжээ.

Дурсгалт үйл явдал болсон 1147 оноос хэдэн зуун жилийн өмнө байгуулагдсан, славянчуудын эртний төв болох Аркаим сууринг Москва хотын эх суурь байж болзошгүй гэсэн таамаглалыг оросын нэрт эрдэмтэн А.Асов дэвшүүлээд байна. Чухамдаа 1147 онд христос шашны баримт бичигт Москва гэдэг үгийг анх удаа дурдсан байдаг. Түүнээс есөн жилийн дараа Юрий Долгорукий ван төрсөн хүү Андрейд хандаж хуучин хэрэм жижигхэн төдийгүй хуучирсан учир шинэ том хэрэм байгуулахыг даалгажээ.

1156 онд Неглинная голын адагт бүтээн байгуулах их ажил өрнөх үед Юрий Долгорукий ван Киев хотод байсныг иш үндэс болгож Андрей Боголюбскийг Москва хотыг үндэслэгч гэж үздэг эрдэмтэд бий. Үнэндээ бол Андрей нь эцгийнхээ өгсөн үүргийг л биелүүлж байсан юм.

Москва хотын өнөөгийн нутаг дэвсгэр дээр тайж Степан Кучкиний эдлэн газар байсан ч Москва голд Неглинная гол цутгаж байгаа Кремлийн баруун-өмнөд хэсэгт оршиж байсан тайжийн суурингаас хот бий болсон юм. Тэр сууринг тойруулан модон хэрэм босгож гуу хусанаас хожим нь Москвагийн Кремль үүссэн билээ.

Тэрхүү хотхоны нутаг дэвсгэрийн хэмжээ анхандаа маш жижигхэн, урт нь дөнгөн данган 220 метр хүрч байв. Хотхоны голд найдан Иоанны мэндэлсэнд зориулсан дүнзэн сүм түүний дэргэд тайжийн ордон буюу доод давхарт нь албаны талсалгаанууд, дээд давхарт орон сууны өрөөнүүд бүхий модон байшин, аж ахуйн зориулалттай амбаар, саравч байв. Кремлийн өндөр дов дээрээс Москваг цагираг үүсгэн хүрээлсэн тосгод түүний дотор Замоскворечье дэх шилмүүст ойн дундах тосгон түүний цаана Воробьевийн уул дээрх Воробьево тосгон, хотхоны яг дэргэдэх Кудрино, Сухошаво зэрэг тосгон гацаа харагдана.

Тэр үед Оросод хүчирхэг улс бий болоогүй, ван бүр эзэмшил нутгаа нөгөөгийнхөө нутгийг түрэмгийлэх замаар өргөжүүлдэг байсан тул Москва нь Ростово-Суздалийн вант улсын хилийн хот-цайз байлаа.

1238 онд монголын Бат хааны үй түмэн цэрэг довтлон ирэхэд оросын вангуудын тархай бутархай цэргүүд эсэргүүцэл үзүүлж чадсангүй, харийн түрэмгийлэгчдийн арми хүрээгүй Новгород, Галич хотуудаас бусад хот суурин эзлэгджээ. Монголчууд оросын хот тосгодыг балгас болгон хувиргаж тариан талбайг үхдэлээр дүүргэж үлдсэн орос иргэд ой, ууланд гарч амь мэнд мултарчээ.

Монгол-татарын цэргийн дайралтыг Москвагийн цайзын цөөхөн тооны цэрэг тэсэж гарсангүй, хотын буурин дээр нурам үнс л үлдэж хот дахин сэхэхгүй мэт санагдаж байв. Гэвч удсангүй сүх, хөрөө хангинаж балгас дээр цайзын хэрэм, сүм хийд сүндэрлэн босож шинэ Москва бий болж XIII зууны дунд үе гэхэд бүрэлдэхүүндээ Москва хот, Звенигород хотуудыг багтаасан бие даасан Москвагийн вант улсын нийслэл болон тодорчээ.

Эргэн тойрны битүү ой, нэвтэршгүй намаг балчиг, вант улсууд зэрэг газар зүйн ашигтай байрлал нь Москваг элдэв дайсны олон удаагийн довтолгооноос хамгаалж байв. Тиймд литовчууд, татар-монголчуудын халдлагын дараа хүмүүс олноор нүүдэллэн ирж Москва голын эрэг дагуу сууршина. Москвагаар Владимирийн зам тэрчилэн баруун зүг Днепр мөрөн рүү хүрэх зам дайрдаг байсан тул худалдаачид бөөнөөр ирж суух болжээ.

Москва хөгжин баяжиж эзэмшил нутгаа аажмаар тэлж оросын газар нутгийг мэдэлдээ авсаар байлаа. Жишээ нь Москвагийн анхны ван Даниил Александрович Переславль-Залесский хотыг нэгтгэж хүү нь Можайскийг мэдэлдээ авав. Төдсөнгүй Москва голын эрэг дагуух бүх нутаг түүнд нэгдэж хотын өмнөд хэсэгт Даниловын модон сүм барьж түүний эргэн тойронд Даниловын эртний суурин бий болжээ.

Иван Калит ван нийслэлээ эртний их вангийн хот Владимираас хол давуу гоёмсог болгохоор шийдэж шинэ байгууламж, сүм, ордонг зүүн хэрмийн цаад талд бариулж байв. Найдан Иоанны дурсгалын сүмийн буурин дээр хамба лам Михаилын сүмийг босгож түүний хойд талд хотын гол сүм болох Успеный сүмийн чулуун барилгын шавыг Оросын үнэн алдартны шашны тэргүүн Петрийн хамт 1326 оны наймдугаар сард тавьжээ.

Москва голын эрэг дээр хэрмийн цаана худалдааны суурин, шинэ шинэ тосгон дараалан бий болсоор байлаа.

Тэр үед оросын гол дайсан нь татар-монголчуудын байгуулсан Алтан ордны улс байлаа. Тиймд Иван Калит ван Алтан Ордны улсын хаанд есөн удаа бараалхаж бэлэг сэлт, мөнгө хөрөнгө өргөн барьсаар түүний итгэлийг олж Владимирийн Их вангийн суудлыг эзэгнэв. Тийнхүү Москвагийн ван Их ван болж оросын нутаг дахь хамгийн нөлөө бүхий вангаар тодорчээ. Хэсэг амьсгаа авсан Их ван Иван Калит хөрш вангуудын нутгийг мэдэлдээ авч эзэмшил нутгаа тэлж худалдаачдын жингийн цувааг зам зуур нь тонодог дээрэмчдийн эсрэг эрс шийдвэрлэг тэмцэж нийслэлээ худалдааны төв болгож чадав.

Модон Москва бараг таван жил болгон түймэрт автаж маш хэцүү байдалтай байсан үед залуу шинэ ван Дмитрий Иванович хотыг тойруулан чулуун бэхлэлт, цамхагууд бариулж дарь үйлдвэрлэдэг болсноор Москва улам хүчирхэгжиж оросын газар нутгийг татар-монголын дарлалаас чөлөөлөх ариун их үйлсийг толгойлов. Москвагийн уриа дуудлагаар тус хоттой дайсагнадаг Рязань, Тверээс бусад хотын харьяат вангууд, тайжууд цэргээ дагуулан ирж тэрчилэн худалдаачид, жирийн иргэд цугларчээ. Асар их хүч хуримтлуулсан Москвагийн Их ван Дмитрий Иванович Троицкийн сүмд очиход хамба Сергей Радонежский эх орныхоо төлөө цэргийн алдар гавьяа байгуулахыг ерөөв.

Непрядва гол Дон мөрөнд цутгадаг Куликовын талд цус асгаруулсан тулаан бүтэн өдөр үргэлжилж монголчууд оросуудыг шахан ухруулах тэр үед Их вангийн ах, Владимир Андреевичийн хороо отолтоос байлдаанд уулгалан орж тулалдааны хувь заяаг шийдвэрлэжээ. Куликовын тулалдааны ялалтын үр дүнд орос нутаг бүхэлдээ татар-монголын дарлалаас чөлөөлөгдөж чадаагүй хийгээд Алтан Ордны улсад урьдын адил асар их татвар төлсөөр байв.

Татар-монголын дарлалаас эх орноо бүрэн чөлөөлөх хувь заяа Их ван гуравдугаар Иванд ногджээ. Тэр үед Москва нь хил хязгаар нь хойд зүгт Цагаан тэнгист, зүүн зүгт Уралын нуруу хүрсэн хүчирхэг Орос улсын нийслэл болсон байжээ. Гуравдугаар Иваныг албан татвар төлөхөөс татгалзаж байгаага мэдэгдэхэд Алтан ордны улсын хаан Ахмет цэрэглэн хөдөлж Угорь гол дээр ирсэн ч байлдахаас айж ухрав. Москвагийн цэргүүд баян Новгород хотыг байлдан дагуулж Тверь хот бүслэгдмэгц бууж өгч Рязань хот Москваг бүрэн хүлээн зөвшөөрчээ.

Орчин үеийн Кремлийн хэрэм, цамхагууд бүтээн байгуулах асар их үйлс өрнүүлсэн гуравдугаар Иван хааны үед босчээ. Уг үйлсэд оросын янз бүрийн хотуудын уран гартнууд оролцож өнөөдөр сүрлэг, тансаг байдлаараа гайхагдаж байгаа Кремлийн цогцолборыг бүтээжээ. Москва хотын өнгө төрхийг өөрчилж улам гоёмсог болгоход италийн уран барилгачид асар их хувь нэмэр оруулсныг оросын ард түмэн ямагт бахархан дурсаж байдаг.

Москвагийн Кремль дэх цэвэр итали дэгийн ганц байгууламж нь Их вангийн ордны хаан суудлын танхим болох Грановитая тасалгаа юм. Уг тасалгааг Оросын төвлөрсөн нэгдмэл улс байгуулагдах үед босгосноороо бүр ч илүү цуутай билээ. Энэ үед Туркийн Баязет хааны өмнө өвдөг нь чичирдэг байсан европийн тивийнхэн дорнод зүгт орших Москвагийн вангийн ихэмсэг үгийг сонсож хүчирхэг гүрэн бий болсныг сонсож хүлээн зөвшөөрсөн билээ.

## ТУРКУ

Тэнгисийн хаан охиддоо хуримын инж өгөхөөр шийдэж Азид хүчирхэг хүчин чадлынхаа гол үндэс болох цайз, Африкт нарны титэм, Америкт гоо сайхан, үржил шим, Австралид далайн үнэт эрдэнэсийг өгчээ. Тэгээд Европт өгөхгүй зүйл олдохгүй болоход далайд гараа дүрж бусад охиддоо өгсөн бүх зүйлийг хамж гардуулжээ.



Европ хатан олон хүүхэдтэй болж эцгээсээ өвлөн авсан бэлгээ тэдэнд хуваан өгөхөөр шийдэв. Тэгтэл Испани усан үзмийн хөөсөрдөг дарс, Франц шуугидаг оргилуун дарс, Грек чидун жимс, Норвег май загас, Орос улаан буудай бэлэг болгон авах хүсэлтээ илэрхийлэв. Бусдын ард зогсож байсан Финланд өвлийн урт шөнийг багасгах нар гуйхыг маш их хүсэж байсан ч таг дуугүй байв. Гэтэл нар, дулааныг аль хэдийнээ бэлэг болгон тараасан Европ хатан түүнд хэдэн мянган нуур, гол бэлэглэжээ.

Чухамдаа тийм гайхамшигт голын нэг нь Аура-Йоки байв. Финланд хэлээр “анжис”, латин хэлээр “салхины үлээлт” гэсэн утгатай Аура голын адагт, Ботнийн буланд цутгадаг тэр газар финландын эртний Турку хот оршино. Турку нь шведийн Або хотын нэр аж. Турку нь Аура голын хөндийд хот байгуулагдахаас өмнө худалдааны суурин байсан хийгээд XIII зууны үед хот болох үед шведүүд Финланд улсад ноёрхлоо тогтоосон байв.

Шведүүд Финланд улсын нутаг дэвсгэр рүү анхны загалмайтны аян дайн хийхээс өмнө Аура голын эрэг дагуу христос шашинтан хүмүүс амьдран сууж байсан нь их сонин. Гэвч таваст омгийнхон христос шашинтнууд Шведийн Гэгээн Эрик хааны байлдан дагуулалтын эсрэг тэмцэж ер гаруй жил эрх чөлөө, бишрэн шүтдэг бурхдаа өмгөөлөн дайтжээ.

Шведийн улсын хүчин чадал хаан ширээг залгамжлагчийн төлөөх дотоодын тэмцэлдээний улмаас доройтсон ч Фолкунгийн угсааг үндэслэгч Ярл Биргер цэргийн хүчээ зузаалж, тэнгис гатлан ирж, 1259 онд таваст омгийнхнийг бут цохижээ.

Шведүүд Финланд улсад бараг зургаан зуун жил ноёрхож байсан ч финландын омгуудтай худалдаа арилжаа хийж байх сонирхолтой хүчирхэг Новгородын вант улс шведүүдтэй бололцоо л гарвал сөргөлцөн тэмцэлдэнэ. Тэгээд новгородчууд 1318 онд Турку хотыг галдан шатааж олон барилга байгууламжийг түймэрдсэнийн дотор алдарт Або шилтгээн байв. Аура голын адаг хавьд боржин, тойпуугаар эгц хадан дээр барьсан Або шилтгээн нь христос шүтлэгтэнгүүд, бөөгийн шашны эсрэг шведүүдийн тэмцлийн тVIIIиц тулгуур байв.

XIV-XVI зуунуудад Або чухал бэхлэлтийн нэг байсан ч их бууны хэрэгт гарсан дэвшлийн үр

дүнд хамгаалалтын үүрэг нь буурчээ. XVI зуунд шилтгээний цамхаг дахь цорын ганц цонх нь хонгил руу харсан давчуу өрөөнд XIV Эрих хаан хоригдож байхад ханхүү Иоанн гэргий Екатерина Ягеллонкаг дагуулан ирж байв. IX Карл, Густав Адольф хаад Финландад ирэх үедээ шилтгээнд буудаллаж байв.

Шилтгээн XX зууны үе хүртэл олон удаа түймэрт өртөж байсан хийгээд нарийн чамбай хөдөлмөрийн үр дүнд түүнийг XVI зууны байдлаар нь сэргээн засварлажээ.

Шилтгээнтэй нас чацуу бас нэг дурсгалт байгууламж нь 1229 онд барьж эхлэсэн сүм юм. Сүмийн доод хэсэгт том цул хадыг засаж янзлан суурь болгож дээд хэсгийг нь тойпуугаар өрж босгожээ. Сүм мөн олон удаа түймэрт өртөж байсан бөгөөд нэгэн нүүрэн талд нь финландын утга зохиолын хэлийг үндэслэгч, шашин, соёлын нэрт зүтгэлтэн Микаэль Агриколийн хөшөөг босгожээ.

XVI зуунд даничуудын эсрэг тэмцэл ялалтаар өндөрлөсний дараа Турку хотыг Финланд улсын нийслэлээр зарлажээ. Турку улс орны хувьд чухал ач холбогдолтой хот байсан ч дундад зууны туршид тэнгис рүү чиглэсэн гол дагуу л өргөжиж бяцхан хот хэвээр байлаа. Амбан захирагч Пер Брахе 1640 онд тус хотод Або академи үүсгэн байгуулсан нь финланд улс дахь анхны их сургууль болжээ. Тэрбээр хотын байршлын анхны зургийг гаргаж хотын түүхэн хэсгийг хэвээр үлдээжээ. Турку хотын иргэд амбан захирагчийн үйл ажиллагааг өндрөөр үнэлж 1888 онд сүмийн оройлцоо өндөр тавцан дээр түүнийг хөшөөг босгож хөшөөний хананд “Би эх орондоо сэтгэл хангалуун байдаг, ард түмэн маань ч надад талархалтай ханддаг.” гэсэн үгсийг сийлжээ.

Умардын дайнд шведүүд ялагдал хүлээснээр Финландад үзүүлэх нөлөө нь улам буурав. Шведийн эрХШээлээс гарсан Турку хот хөгжиж Стокгольм, Гетёберг хотын дараа улсынхаа гурав дахь том хот болжээ. Хотын хүн амын бүтцэд өөрчлөлт гарч лам нар, худалдаачид, гар урчуудаас гадна тэнгисийн цэргийн албаны офицерүүд, усан цэргүүд, тVIIIмэд, академийн багш, оюутнууд, дээд шүүх, мужийн захиргааны тVIIIмэд, явуулын тариачид гэсэн давхарга бий болжээ.

1809 онд Финланд нь Оросын эзэнт гүрний бүрэлдэхүүнд Финландын вант улс нэрээр багтсанаар шведийн ноёрхлоос бүрмөсөн ангижирч Турку хотод оросын амбан захирагч суух болжээ. Гэтэл Оросын хаан 1812 онд зарлиг гаргаж Финландын вант улсын нийслэлийг залуу Гельсингфорс (Хельсинки) хотод шилжүүлж түүнээс 15 жилийн дараа аймшигт түймэр гарч хэдхэн цагийн хугацаанд Луостаринияки дов дээрх орон сууцны хэдэн байшингаас бусад хотын бараг бүх барилга байгууламж хуу шатжээ.

Гэвч Турку хот үнс нурмаас сэргэж хотын төвдөө түүхэн барилга байгууламжаа хадгалсан орчин үеийн хот болон хөгжсөөр байна. Бүтэн жилийн турш ус нь хөлддөггүй Балтийн тэнгисийн эргийн усан боомт болох Турку хот Финланд улсын усан хөлөг онгоцны үйлдвэрлэлийн томоохон төв болжээ. Тэнгисийн эрэг болон дагуул хотхонуудад өндөр кранууд алсаас сүндэрлэн харагдана.

Турку хотод бас нэг “тэнгисийн” дурсгалт зүйл байдаг нь хоттой зэрэгцээ орших Аландын бүлэг арлууд юм. Финланд, Швед улсуудын хооронд, уул нуруудын оройгоос тэнгис дунд бий

болсон мянгаад арлын дийлэнхэд нь хүмүүс амьдран суудаг бөгөөд тэдгээрийг хооронд нь засмал замаар холбожээ.

## БЕРЛИН

Берлин анх харахад орчин үеийн хот шиг сэтгэгдэл төрүүлдэг ч эртний нэн баян түүхтэй хот билээ. Эрдэмтэд маш нарийн судалгаа хийж байгаа ч хот хэдийд хэрхэн үүссэн тухай лавтай мэдээлэл одоо ч алга байна.



Энэ нутагт маш элбэг байсан баавгайнаас хотын нэр үүссэн гэсэн хувилбар нилээд дэлгэрсэн байдаг. Гэтэл энэ нутаг нуур, гол олонтой, намгархаг байсан болохоор “Берлин” үг нь эртний славян хэлний “бирл” буюу “намаг, балчир” гэсэн үгнээс гаралтай гэсэн таамаглалыг германы болон оросын хэл судлаачид дэвшүүлсэн бий.

Энэ нутгийн анхны оршин суугчид нь венд омгийнхон байсан хийгээд германчууд, славянчууд энэ нутгийг булаацалдаж олон удаа дайтсанаас төмөр Фридрихийн үед германчууд славянчуудыг үлдэн хөөж бүрмөсөн сууршисан ажээ.

Берлин хотын тухай анхны түүхэн баримт 1244 оны үед нэгдүгээр Иоганн, гуравдугаар Отто гүнгүүдийн үед хамаарах хийгээд тэр үед Шпрее голын хоёр эрэг дээр хөрш зэргэлдээ оршиж байсан хилийн суурин болох Кёльн, Берлин хотуудын ул мөр ер үлдээгүй байна. Эртний худалдааны зам дайрдаг байсан голын гарц дээр гүүр барьж ойролцоо нь олон тооны салхин тээрэм байжээ.

Гэгээн Петрийн сүм бүхий Кёльн хот нь улс төр, шашны хувьд Берлин хотоос тусдаа байсан бөгөөд зоос сийлэх, шүүх эрх, еврейчүүдийг хамгаалах зэрэг асуудлаар хоёр хот XIV зууны үед хамтран ажиллаж байв. Гэхдээ хоёр хот тус тусын бие даасан байдлаа хадгалж тэр ч бүү хэл хоёр дахь гүүр дээр захиргааны нэгдсэн байр барьж байжээ.

XIV зууны дунд үед хотуудын Ганзейн холбоонд нэгдсэнээр тус хоёр хот хөгжлийнхөө оргилд хүрчээ. Гэвч хоёрдугаар Төмөр Фридрих курфюст энэ хоёр хотын хоорондын бат бэх холбоог сулруулан таслах зорилгоор бяцхан Кёльн, илүү хүчирхэг Берлин, гар урчууд худалдаачдын хоорондын өрсөлдөөнийг ашиглажээ. 1442 онд Төмөр Фридрих курфюст Берлин хотыг эзлэж Шпрее голын эрэг дээр том цайз байгуулсан нь хагас зуун жилийн дараа Гогенцоллернуудын өргөө болжээ.



Төмөр Фридрих курфюст хоорондын өрсөлдөөнийг нь далимдуулж эрх мэдэлд хүрснийг хоёр хотын иргэд сая нэг ухаарч 1448 онд нэгдэж хамтран тэмцэлд боссон ч дийлдэж курфюст эрх мэдлээ улам батжуулсан төдийгүй хоёр хотын нөлөө бүхий баячуудын эд хөрөнгийг хураан авчээ.

XVI зууны эхний хагаст гуравдугаар Иоахим курфюстын үед Берлин хот төрж байгаа хүчирхэг улсын нийслэл болжээ. Тэр үед хотын хүн амын тоо 14 мянгад хүрсэн ч олон удаагийн түймэр, Гучин жилийн дайны хор уршгаар XVII зууны сүүлч гэхэд хоёр дахин цөөрсөн байлаа. Берлин хот уналтад орж шведүүдийн гарт золтой л орчихсонгүй.

Пруссын вант улсыг үндэслэгч түүний анхны хаан Фридрих-Вильгельмийн үед Берлин хот нийслэл хот болон төлөвшжээ. Хаан хоёр хотыг төдийгүй ойр орчмын суурингуудыг нэгтгэж хааны өргөөг сэргээн засварлаж гудамж талбайг өргөн болгож гэрэлтүүлэг хийжээ. Тэр үед хотын гол гудамж болох алдарт “Унтер дер Линден” бий болжээ.

Фридрих-Вильгельм хаан хотын гадаад дүр төрхийг өөрчлөхийн зэрэгцээ оюун санааны өсөлтөд онцгой анхаарч голландын алдарт зураачдыг урьж ирүүлж Нийтийн номын сан байгуулж биечлэн уран сайхны цуглуулга хийдэг байв.

XIX зууны эхээр 1806 оны аравдугаар сард Францийн Наполеон хааны цэрэг Берлин хотыг эзлэж хоёр жил эзэгнэхдээ үгүйрүүлэн хоосруулжээ. Хүнд хэцүү цаг өнгөрмөгц Берлин хот сэргэж уран зохиол, театр, шинжлэх ухаан цэцэглэн хөгжив. 1809 онд Берлиний их сургууль байгуулагдаж В.Гумбольдт, К.Рихтер, Г.В.Ф.Гегель зэрэг алдарт эрдэмтдийн ачаар Германы бусад дээд сургуулийн дотор тэргүүлэх үүрэг гүйцэтгэх болжээ.

Хот гоёмсог байшин, дурсгалт зүйлүүдээр улам баяжиж байлаа. Тухайлбал XIX зуунд нэрт уран барилгач К.Ф.Шинкель сонгодог хийцээр Хуучин музей, Драммын театр, Барилгын академи, Ордны гүүр гот хийцээр Вердений сүм, Кройцберг дүүрэгт хөшөө босгожээ. Дараагийн жилүүдэд Берлин хотын хөгжил бүр эрчимжиж ялангуяа уран барилгач А.Шлютерийн хосгүй уран сэтгэмжээр Хааны шилтгээн, Их Курфюстэд зориулсан хөшөө сүндэрлэн боссон нь өнөөдөр хотын чимэг болжээ.

Берлин хотын зүүн-өмнөд хэсэгт “Венеци” гэж нэрлэгдсэн зугаалгын газар бий. Эрт дээр үед Шпрее гол түүний олон салаагаар ачаа бүхий усан онгоц, чиргүүлт завь зорчдог байсан ч яваандаа больж олон тооны нуур, сувгийн эргэн тойронд арлын “улс орон” бий болжээ. XIX зууны хоёрдугаар хагаст эмч мэргэжилтэй Д.Г.Шребер гэдэг хүн энд төрөлхийн согогтой тахир дутуу иргэдэд зориулсан сувиллын эмнэлэг байгуулахаар шийдэж эмнэлгийн барилгын ажилд оролцож байгаа хүмүүсийг шургуу ажилласны дараа цэвэр агаарт амрахад нь зориулж, амралт, зугаалгын хотхон байгуулжээ. Одоо тэр хотхон нь “Шреберийн жижиг цэцэрлэгт хүрээлэнгүүд” буюу “Хүүхэлдэйн бяцхан байшингууд” гэж алдаршжээ.

Шпрее голын эрэг дагуух үзэсгэлэнт булан тохой бүхий Рансдорф дүүрэгт ангийн бяцхан отог, харц булаасан гоёмсог шилтгээн, эртний ордон болон рыцарь эрийн цайзны жижигрүүлсэн загварууд бий.

Эртний ном судар, марк, зоосны цуглуулга, шаазан баримал гэх зэрэг эртний эд зүйлс

худалдаалдаг жижигхэн дэлгүүр, урлан, шилэн хорго байрлах София гудамж их цуутай. Энэхүү гудамжийг Берлин дэх XVIII зууны үеэс өвлөгдөн ирсэн барокко дэгийн барилга бүхий цорын ганц сүмийг барихад зориулж 2000 талер хандивлаж байсан София хатан хааны дурсгалд зориулан тийн нэрлэжээ. Сүмийн хашаа дотор германы алдарт яруу найрагч К.Ф.Гетёгийн дотнын анд К.Ф.Цельтерийн баганат хөшөө бий. Баян айлын хүү К.Ф.Цельтер бүхий л амьдралаа залуучуудын хөгжмийн боловсролыг дээшлүүлэхэд зориулж Гоо сайхны урлагийн академийн хөгжмийн профессор байхдаа Берлиний Найрал дууны нийгэмлэгийг санаачлан байгуулж ядуу айлын авьяаслаг хүүхдүүдийг үнэ төлбөргүй сургаж байсны дотор нэрт хөгжмийн зохиолч Ф.Мендельсон-Бартольди байжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дуусахаас өмнө ялагч орнууд Берлинд байрлах Олон улсын хяналтын зөвлөл байгуулах тухай гэрээ байгуулж хотыг дөрвөн хэсэгт хувааж АНУ, Англи, Францийн армиуд баруун хэсэг, Зөвлөлтийн цэрэг дорнод хэсгийг хяналтдаа авчээ.

1989 онд хоёр Герман нэгдэж Берлиний ханыг нураасны дараа хотын дүр төрх танигдашгүй болтлоо өөрчлөгджээ. Гагцхүү Рейхстаг л урьдын сүрлэг байдлаа хадгалан дүнхийнэ. Рейхстагийн ордонд өөрчлөлт хийхдээ бөмбөгөр оройг XIX зууны эхээр уран барилгач П.Валлотын хийж байснаар биш английн уран барилгач Н.Фостерийн санал болгосноор шилэн болгожээ.

Берлиний ханыг нураасны дараа Кройцберг дүүрэг хотын төв болж нэр хүнд нь улам дээшилж байр, газрын үнэ тэнгэрт хаджээ. Өнөөгийн Берлин хотод дэлхийн 180 орны цагаач иргэд амьдарч байгаагаас дийлэнх нь Кройцберг дүүрэгт оршин сууж байна.

Жил бүрийн тавдугаар сард энэ дүүрэгт олон улсын урлагийн наадам болдог уламжлал тогтжээ. Урлагийн наадам баасан гаригт хүүхдийн баяраар эхэлж бямба гаригт яармаг худалдааны нээлт болж ням гаригт гол үйл явдал болох багт наадам болно. Жагсаалын өмнө алхах үлээвэр найрал хөгжмийн хамтлагийн араас болгарын бүжигчид, югославын жүжигчид, Баруун Африкийн хөгжимчид, хүүхэлдэйн театр, үггүй жүжгийн театрын жүжигчид, алиалагчид, илбэчид тоглолт хийн алхана. Жаз, рок, свинг, кантри, африкийн бөмбөр, альпийн уулсын гуурсан бишгүүрийн үлээлт гээд түмэн хэлийн түмэн дэгийн хөгжим дуу хадна.

## БАНДИАГАРА

Өнөө үед догон омгийнхон Хойд Африкийн баруун хэсэгт, Бүгд Найрамдах Мали Улсын нутаг дэвсгэр дээр амьдран сууж байна. Гэхдээ эрт дээр цагт эртний Мандинго эзэнт гүрний яг төв, Нигер голын эх хавьд сууж байв. Дараа нь бусад омогтой холилдож XIII зууны сүүлчээр Бандиагарын тал хөндийд шилжин сууршиж телем омгийг хөөн туужээ.



Хөрш зэргэлдээх омгийн удирдагч Бандиагара тосгонд өргөөгөө байрлуулан сууж байсан ч дараа үеийн нэгэн удирдагч нь 1887 онд 30 километрийн зайтай орших Хамдалей сууринд шилжүүлжээ. Зургаан жилийн дараа Бандиагара сууринг эзлэн авсны дараа францийн армийн хурандаа Аршинар сууринг тойруулан барьсан хэрмийг нурааж тукулер омгийн нэгэн өвгөнийг “хаан”-аар өргөмжилж шинэ засаг захиргааны нэр хүндийг өргөхийн тулд “хаан”-д зориулан ордон босгожээ.

Өнөөдөр Бандиагара мужийн төв ч нам гүм тосгон ажээ. Хүнгүй эл хуль нарийхан гудамжаар явахад хоёр талаар нь нар, бороонд агийж хорчийсон хөвөө бүхий нэг давхар шавар байшингууд, далдуу, манго мод л харагдана. Шавар хашааны цаана овоохойнуудын шовгор хэлбэрийн сүрлэн дээвэр мөн үзэгдэнэ. Шар будааны сүрлийг шовгор хэлбэртэй бухалдаж сүрлэн уяагаар дээд хэсгээр нь ороож шавар хана дээр бүрх малгай мэт углан тавьж дээвэр болгоно. Тийм дээвэр төөнөм халуунд байшин дотор сэрүүнийг алдахгүй хадгална, бороотой үед найдвартай хамгаалж борооны дуслыг хананд хүргэхгүй доош урсгана.

Сүрлэн дээвэртэй, догон омгийн өвөг дээдэс, домгийн баатруудын дүрс сийлж чимэглэсэн модон шонгоор дороос нь тулсан том байшинг “тогу на” буюу эрчүүдийн байшин гэнэ. “Тогу на” дотор зөвхөн эрчүүд цугларч ахуй амьдралын асуудлуудаа хэлэлцэн шийдвэрлэнэ.

Баруун Африк судлалд Африк тивийн ард түмнүүд туулж өнгөрүүлсэн баялаг сайхан түүхгүй, уран сэтгэмжгүй хүмүүс тул бие даасан урлагийг хөгжүүлж чадаагүй гэсэн бодол санаа удтал ноёрхож байлаа. Үүний нэг тод жишээ нь Зимбабве улсад байгаа их хотын балгас нь тус тивийнх биш гэсэн байр суурийг зарим эрдэмтэн одоо ч баримталсаар байгаа явдал юм. Колонийн дайны үед бүрэлдэн бий болсон бүдүүлэг африк хүмүүсийн тухай ойлголтыг нэр цуутай эрдэмтэд ч хүлээн зөвшөөрдөг явдал бий.

Догон омгийнхны туулж өнгөрүүлсэн баатарлаг түүх, бий болгож чанд баримталдаг ёс журам, шүтдэг шашин гээд бүх зүйл нь маш сонирхолтой юм. Их нүүдлийн үед догон

омгийнхон дьон, ару, оно, домно гэсэн дөрвөн хэсэгт хуваагдаж омог бүр тус тусдаа явсаар Бандиагара хүрч нэг нэгнээсээ ангид сууршижээ. Гэвч одоо Бандиагара тосгонд бүх омог хамт оршин суудаг болсон нь мэдээж хэрэг гэхдээ омог бүрийн хэл нөгөөгөөсөө эрс ялгагдах тул хоорондоо харьцахад их төвөг учирдаг ч эмч домч, ид шидтэн, эртний шашны тайлгач, өвөг дээдсээ гэж догончууд тооцдог “цагаан үнэг”-ийн хэлээр ёслол үйл хийх үед бие биенээ амархан ойлголцоно.

Догон омог бараг 500 гаруй жилийн тэртээгээс Баруун Суданы томоохон улсуудын бүрэлдэхүүнд багтаж байгаа ч өвөрмөц соёл, байдлаа хадгалсаар иржээ. Тэд одон орон судална, өөрийн хуанли, тооны аргатай, хүний биеийн бүтэц, сэтгэл зүйн тухай өргөн мэдлэгтэй, гэхдээ бичиг үсэг байхгүй. Домог яриаг нэг үеэс нөгөөд аман хэлбэрээр дамжуулсаар ирсэн бөгөөд бий болгосон өвөрмөц зураг, тэмдгүүдээр бичлэг хийнэ.

Догон омгийнхны “ертөнцийн үүслийн тухай” онол маш сонин, ертөнцийн үүсэл гарлын тухай тийм санаанд оромгүй хувилбартай ард түмэн дэлхийн бөмбөрцгийн хаана ч үгүй биз ээ. Тэдний нэгэн домогт өгүүлснээр хүн зон аль хэдийнээ сууршисан Дэлхий Сириус одны ойролцоо байна, гэвч Сириус од дээр дэлбэрэлт болох аюул нүүрлэхэд, Амма бурхан Дэлхийг Нар хэмээх өөр нэг одонд ойртуулан шилжүүлжээ.

Анхандаа бол ямар нэгэн зүйл дээр тVШиж тулаагүй, нэг нэгэнтэйгээ нийлсэн, дөрвөн зууван хэлбэртэй хэсгээс бүрдэх дугуй өндөг шиг Амма бурхан байв. Хорвоод өөр юу ч байгаагүй байжээ. Амма бурхан хэсэг тус бүртээ ус, агаар, гал, газар гэсэн дөрвөн бодистой байснаас гадна бодис бүр нь дэлбэрэлт үүсгэж тэр нь тэдгээрийн оршин тогтнох үндэс болно.

Догон омгийн соёл эрдэмтдийн анхаарлыг удтал татсаар байна. 1930 оны эхээр францийн эрдэмтэн М.Гриоль, Ж.Дитерлен хоёр тус омгийн ахуй, шүтлэгийг судалж 1950 онд “Африк тивийг судлаачдын нийгэмлэгийн сэтгүүл”-д тэнгэрийн Сириус одны тухай догон омгийн ойлголтыг нийтлүүлж шуугиан тарьжээ. Догончууд “сиги-толо” гэж нэрлэдэг од нь үнэндээ бол гурвалсан бүтэцтэй од ажээ. Бидэнд харагдаж байгаа од нь бол одны бүхэл бүтэн тогтолцооны өчүүхэн хэсэг ажээ. Тэр тогтолцоог гол од Сириус А, хүний нүдэнд үл харагдах цагаан одой Сириус В (по-толо), бас нэг үл харагдах Сириус С (эмме йа толо) од бүрдүүлнэ. Эмме йа толо одыг Ара толо, Йу толо гэсэн хоёр дагуул тойрон эргэлдэнэ.

Сириус од нь Дэлхийд ойрхон одуудын нэг боловч түүний дагуул “Сириус В” одыг 1862 онд л дөнгөж нээжээ. “Сириус С” одны тухайд бол одон орончид одоо ч маргалдсаар байна. Хамгийн гайхалтай нь догон омгийн домогт гардаг “по-толо” одны тодорхойлолтууд нь цагаан одой “Сириус В” одныхоос бараг ялгагддаггүй. Маш хүнд жинтэй, нягт энэ од маш том хэмжээтэй, “бүх одноос хамгийн бага, хамгийн хүнд од” юм. Догонуудын домогт “по-толо” од нь “Төмрөөс илүү гялалзсан зүйлээс бүрдэнэ, газрын бүх амьтад нийлэн өргөөд ч хэсгийг нь ч даахгүй тийм хүнд.” гэжээ. Догонууд “по-толо” одны “сиги-толо”-г эргэх хугацаа нь 50 жил гэж үздэг бол одон орончид 49,9 жил гэж тооцоолжээ.

Догон омгийнхны хэдэн зуун жил нэг үеэс нөгөөд дамжуулан ирсэн хууч домгийг тусгай бэлтгэл хийж “сиги со” хэмээх онцгой хэлийг эзэмшсэн Ава буюу Олубару багны нийгэмлэгт элссэн хүн л хүүрнэн ярих эрх эдэлнэ. Догонууд францийн эрдэмтэн М.Гриоль домог яриаг

нь чин сэтгэлээсээ маш их сонирхож байгааг хүндэтгэж Ахмадуудын зөвлөлийн шийдвэрээр нууц мэдлэгээ танилцуулах болжээ. Францийн угсаатны зүйчид, догонуудаас хаанаас яаж ийм ер бусын мэдлэгтэй болсныг нь лавлан асуухад Сириус од, сансар огторгуйн тухай бүх мэдлэгийг Их агуйнаас ажиглан олж тогтоосон юм гэж хариулаад Их агуй хаана байдгийг цагаан арьстнуудад хэзээ ч зааж өгөхгүй гэж татгалзжээ.

Нигер голд цутгадаг Бани голоос баруун зүгт 250 километрт сунжран оршдог догон омгийнхны хад асганд Их агуй байдаг юм болов уу? XX зууны дунд үед эрдэмтэд Мали болон Дээд Вольт улсуудын хилийн зааг дээр Телем хэмээх өвөрмөц сонин соёл иргэншлийн үлдэгдлийг олж нээжээ. Догон омгийнхны хад асга гэдэг нь 400 гаруй метр эгц өндөр хатуурсан элсэн хана юм. Хүн авирш гаршгүй эгц босоо хананд жижигхэн сүмтэй адилхан тагтнууд, дотор нь янз бүрийн хэлбэр, хэмжээтэй цамхаг харж болох янз бүрийн гүнтэй нүүхүүд байна. Энэ эгц хадан хананы бэлд оршин суудаг бяр тэнхээтэй, авхаалжтай догон эрчүүд хад асга өөд чөлөөтэй авирч гардаг ч тэнд байгаа олон тооны агуйд хүрч үл чадах ажээ.

Голландын Роттердам хотын эрдэмтэн Ган агуйнуудын нууцыг мэдэх хүсэлдээ хөтлөгдөн орчин үеийн техник хэрэглэж олон саад бэрХШЭэлийг давж хаалттай бүсэд нэвтрэхэд гайхамшигтай дүр зураг нүдний нь өмнө тодорчээ. Уужим цэлгэр агуйнуудад олон тооны заримд нь гуч хүртэлх тооны байгууламж байна. Шовгор болон бортогон хэлбэртэй эдгээр байгууламжийн суурийн голч нь 1,5-2 метр, өндөр нь 4,5 метрт хүрнэ. Цонх, хаалганы оронд дугуй юм уу зууван нүх гаргажээ. Цамхагуудыг шавраар урласан хийгээд хананд сийлсэн тэмдгүүдийг эрдэмтэд одоо хэр тайлж уншиж чадаагүй, судалсаар байна. Байгууламж болгонд сайтар хадгалагдан ирсэн араг яс илэрсэн ч бунхан гэж үзэж болохгүй ажээ. Агуйнуудад хүн байнга оршин сууж байсан шинж тэмдэг байхгүй ч тогтмол орж гарч байсан нь нотлогджээ.

Хадан хананд 100-аас 150 метрийн өндөрт байгаа агуйнууд доторх байгууламжуудыг шатаасан тойпуугаар хийсэн байна. Тэндээс хүмүүс авиран гардаг байсан мөчир, саваа сүлжиж хийсэн залгамал шатууд мөн олджээ. Хүмүүс яаж ийм өндөр авиран гарч байв? Хүн амьтан нэвтэршгүй агуйд ямар зорилгоор очиж байв? гэх зэрэг олон асуулт хариултаа хүлээж байна.

## АМСТЕРДАМ

Бурхан дэлхийг бүтээсэн, бид Нидерланд улсаа байгуулсан” гэж голландчууд ярьдаг. Тэд эх орныхоо газар нутгийн бараг тал хувийг тэнгисээс булаан авсан болохоор тэгж ярьдаг нь үнэний хувьтай билээ. Голландчууд тэнгисээс булаан авсан намагтай хуурай газарт 1275 онд хэдэн зуун мянган шон суулгаж нийслэл Амстердам хотынхоо эх суурийг тавьжээ. Хааны ордны дор гэхэд л 13659 шон суулгаж байжээ. Өнөө үед модон биш харин бетонон шон хэрэглэдэг болсон нь мэдээж.



Голланд нь нам тайвуун, ногоон орон хийгээд зөөлөн салхи нь эртний салхин тээрмийн далавчуудыг аажуу эргэлдүүлнэ. Тус орныг салхин тээрэмгүйгээр төсөөлөх аргагүй бөгөөд тэнгисийн усыг цаашлуулдаг гэж үздэг байсан урьдын 8 мянга орчим салхин тээрмээс үлдсэн 1500 салхин тээрмийг өнөө үед эртний ховор нандин дурсгал болгон арчлан хамгаалдаг байна.

Амстердам олон нэртэйгээс “шон дээрх хот”, “май загасны ясан дээр босгосон хот” (Чухамдаа май загасны худалдаа бяцхан тосгоныг Европийн томоохон хот болон хувирахад гол үүрэг гүйцэтгэжээ.) буюу “Амстел голын эрэг дээрх хот” гэсэн хоёр нэр нь их түгжээ. Тус хотод мянга гаруй суваг, хэдэн зуун гүүр байдаг тул “Хойд Венеци” гэж ч бас шагшина. Сувагнуудын гүн нь 3 метр орчим хийгээд долоо хоногт нэг удаа хаалтыг нь хааж усыг нь далай руу урсгаж Зейдер-зее нуураас ус тавьж усыг нь сольдог байна.

Амстердам хотын байшин бүр түүхэн дурсгал агаад эрт цаг, орчин үе нягт холбоотой. Тухайлбал эрт дээр үеэс “Нулимсны цамхаг”-аас усан онгоц далайн гүн рүү аялалд гарч эрэлхэг далайчдыг эхнэр, хүүхдүүд нь уйлан хайлан үддэг байв. Тус хотын зарим байшин голландын суут зураачдын уран бүтээлдээ дүрсэлсэн яг тэр хэвээрээ байдаг.

Тус хотын олон зуун жилийн хугацаанд олон ивээгч солигдсоор ирснээс Синтерклаас-Гэгээн Николас удтал хэвээр байна. Домогт өгүүлснээр Ү зуунд зоогийн газрын хорон санаат эзэн гурван хүүхдийг алахаар шийдэж давсалсан ногоон дотор хийсэн байсныг Гэгээн Николас аварч бяцхан хүүхдүүдийг өмгөөлөн хамгаалагч алдар хүртжээ.

Амстердамчууд Гэгээн Николасыг мөн далайн шуургыг номхруулдаг, загас барилт, арилжаа наймааг ивээгч гэж шүтэн биширдэг юм. Газар зүйн аугаа нээлтүүдийн үед, Аж үйлдвэрийн

хувьсгалын жилүүдэд, Ост-, Вест-Энэтхэгийн компаниудын дээрэмдлэгийн жилүүдэд ч ялгаагүй Амстердам хот арилжаа наймаагаар амьдарч байжээ. 1628 онд испанийн Мөнгөн флотыг дайран буулган авч америкийн улаан арьстануудаас дээрэмдэн авсан үнэт эрдэнэсийг олзлон авчирсан ахмад Пит Хейнийг төрөлх хотынхон нь үндэсний баатар болгон өргөмжилжээ.

Гүн Альба тус орныг захирч байсан XVII зууны эхээр “гезеллинг” буюу хөшиггүй цонх гэсэн нэр томъёо үүсчээ. Голландын 1800 орчим энгийн иргэнийг цаазалсан цуст амбан захирагч олон харгис арга хэмжээ авч байсны дотор дайсагнагч үйлдэл хийхээс нь сэргийлж иргэдэд цонхны хөшгөө хаахыг хориглосон зарлиг буулгаж байжээ. Цаг нь болохоор испанийн түрэмгийлэгчид нутаг буцаж “гезеллинг” үг үлдсэн ч одоо гэр орны тохь тух, цэвэр цэмцгэр байдал, голландчуудын цонхонд хандах өвөрмөц хандлагыг илэрхийлдэг болжээ.

Амстердам нь XVII-XVIII зууны үед баригдсан шовх дээвэртэй, нэг тасалгааны хэмжээтэй өргөнтэй байшингуудаараа цуутай юм. 400 гаруй жилийн тэртээ босгосон, нэг нэгэнд нь тулган барьсан байшингуудын вааран дээвэр нөгөө дээвэртэй тулсан байх хийгээд давхар бүртээ ганц цонхтой байшин бүр нь цамхаг шиг дээш цоройж байдаг. Тийм байшингуудын доторх давхруудыг холбосон шатууд нарийхан болохоор хөлөө хажуулдан тавьж өгсөж уруудах ба гэрийн модон тавилгыг хаалгаар нь багтахгүй болохоор цонхоор нь оруулна.

Амстердамын дагуул хот болох Саардам дахь Ост-Энэтхэгийн усан онгоцны үйлдвэр эрт дээр үеэс цуутай юм. Хүн, амьтны цогцсыг занданшуулж яг хэвээр нь чадамгай хадгалж чаддаг байсан голландын нэрт анатомч Ф.Рюйшийн цуглуулгыг үзэхээр өнөөдөр ч дэлхийн олон орноос эрдэмтэд, судлаачид Амстердам хотод ирдэг ажээ.

Голланд улсын нийслэл анх үүссэн Дам төв талбайд Хааны ордны эсрэг талд Дэлхийн хоёрдугаар дайны дурсгалд зориулсан Үндэсний хөшөө бий. Фашистын эзлэн түрэмгийлэгчидтэй сөрөн тэмцэж байсан амстердамчуудын зоригийг бахдаж Вильгельмина хатан хаан хотын хуучны сүлдэнд “Баатарлаг, Нугарашгүй, Өрөвч сэтгэлтэй” гэсэн үгсийг оруулах зарлиг буулгажээ.

## КОПЕНГАГЕН

Хүүхэд бүр Ханс Кристиан Андерсений шидэт үлгэрийн амт шимтэнд орсон үеэсээ Дани улсын нийслэлийг мэддэг болдог гэж хэлэхэд хилсдэхгүй биз ээ. Вааран дээвэр дамжин явдаг яндан хөөлөгч өнөөдөр ч Копенгаген хотод ажиллаж байна, Өнөө үед цөөрмүүд болгон хувиргасан эртний цайзны сувгуудад хун шувууд хос хосоороо амгалан хөвөх хийгээд 1874 онд ихэмсэг бардам хун шувууг Дани улсын билэг тэмдгээр залжээ.



Хааны цэцэрлэгт хүрээлэн дотор саглагар эвэрлэг моддын дунд гартаа ном барин сууж байгаа их зохиолч Х.К.Андерсений хөшөө нэг буланд нь сүндэрлэн байдаг Хотын захиргааны талбайгаас жуулчид хоттой танилцаж эхлэнэ.

Нюторвын талбайгаас “Хэт” үлгэрийн гол баатар цэрэг цаазлуулах цагаа хүлээн сууж байгаа шүүхийн танхимын хонгилын цонх харагдана. Цэргийг хэрхэн цаазлахыг сонирхон харах гэсэн хүмүүс гудамжаар пиг дүүрч хааны торгон цэргүүд бөмбөрийн хэмнэлд алхаж байгааг алах ял заагдсан цэрэг төмөр сараалжны цаанаас гунигтайхан ширтэнэ. Арьсан хормогчтой гуталчны туслах хүү олны өмнө гүйж явтал нэг шаахай нь хөлөөс нь сугарч хананд ойн чулуун зам дээр өнхрөн унаж байгааг цэрэг хараад өхөөрдөн инээмсэглэнэ.

Дэлхийн хамгийн урт явган зам болох Стрөётоос холгүйхэн 1647 онд барьсан Дугуй цамхаг хэмээх эртний нүсэр том байшин байна. Дугуй цамхаг дотор Гэгээн Троица сүмийн болон хотын их сургуулийн одон орныг судлах оргил байрлаж байжээ. Дундад зууны үеийн алдарт одон орон судлаач Тихо Браге өөд болсноос дөчин жилийн дараа Дугуй цамхаг боссон ч чухамдаа энд тэнгэрийн гариг, эрхэсүүдийн байрлалыг яг таг тодорхойлсон болохоор түүнийг нэрт эрдэмтний нэртэй ямагт холбон ярьдаг. Цамхагийн өндөр довжоо дээр суут эрдэмтний цээж баримал бий.

Өнөө үед Дугуй цамхагийг одон орны судлалын төвийн зориулалтаар ашиглахаа больж жуулчид тойпуугаар доторлосон харах талбай өөд өгсөн гарч хотын байдлыг тольдон сонирхоно. 1716 онд Оросын нэгдүгээр Петр хаан Дугуй цамхаг дотор морьтой орж хотын оршин суугчдын гайХШийг төрүүлсэн бол түүний хатан, ирээдүйн нэгдүгээр Екатерина хатан хаан нөхрөөсөө дутахгүй гэж сүйх тэрэгтэйгээ цамхаг дотор орж бүр илүү гайХШийг нь төрүүлж байжээ.



Эрт дээр үед хотыг тойруулан барьсан шороон далан байсан хийгээд шөнө болохоор хаан дэр дороо тавьж хонодог түлхүүрээр хотын гулдан хаалгыг цоожилдог байжээ. Хотын гол гудамжуудын нэг болох Вестерброград гудамжинд орших Хотын музейн үүдэнд хотын 1536 оны байдлыг загвараар хийж тавьсан байдаг нь жуулчид төдийгүй оршин суугчдын шохоорхлыг их татна.

Тус хот нь загасаар элбэг Эрезундын хоолойн эрэг дээр улс төр, эдийн засгийн чухал байрлалд оршдог ч XIV зуун эхэн үе хүртэл жирийн нэгэн хот байжээ. Гэхдээ Гэгээн Варфоломей болон Гэгээн Дионисий нарын төрсөн өдрүүдийн хоорондох саруудад жил бүр зохиодог үзэсгэлэн худалдаагаараа л цуутай байжээ. Дээр үед хотын хүн амын дийлэнх хэсэг нь хөдөө аж ахуйн салбарыг эрхэлдэг байсан болохоор өглөө малчид үнээ, хонио хашаанаас нь гаргаж гудамж талбайгаар хариулж өдрийн цагаар тахиа, гахай ийш тийш хөлхдөг байв. Ер нь бол Копенгаген нь дөрвөн мянга орчим оршин суугчтай, дөрөвхэн сүмтэй, вааран дээвэртэй байшин цөөхөн, чулуу дэвссэн гудамж, талбай байхгүй хөдөөгийн хот байв.

Гэвч хэсэг хугацааны дараа Копенгаген хот хааны худалдаа-улс төрийн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэх болж шашны дээд удирдлага, язгууртнуудтай хийж байгаа тэмцэлдээ хаан тус хотын бюргерүүдийг ашиглах, дэмжлэгийг авах зорилгоор тус хотод хөнгөлөлт үзүүлж татварыг багасгаж байсан ба соёл нь илүү иргэний шинж чанартай, ёс заншил илүү чөлөөтэй болжээ.

Тэр үед Копенгаген хотод хэдэн арван сүм баригдсан нь уран барилга, уран зураг, уран баримлын гайхамшигт дурсгалууд болон алдаршжээ. Хамгийн том сүм нь бараг 80 метр өндөртэй, чамин гоё сийлбэртэй тахил бүхий Дарь Эхийн сүм байв. Шашны боловсрол эзэмших нь чинээлэг бус, язгууртан бус гаралтай хүмүүсийн хувьд нийгэмд тодорхой байр суурь эзлэх бололцоог олгож байсан учир тус хотын залуус шашны эрдэм заадаг их сургуулиудад бөөнөөр явж суралцдаг байжээ.

Данийн төрийн болон шашны нөлөө бүхий зүтгэлтнүүд идэр залуудаа гадаад суралцаж боловсрол эзэмшиж байсан тул Данийн хаан 1487 онд Копенгаген хотод их сургууль байгуулах зарлиг гаргаж бүх багш, оюутан, ажилтнуудыг нь ивээлдээ авчээ. Энэ бол скандинавын орнууд дахь анхны их сургууль байжээ. Байр барих хөрөнгө хүрэлцэхгүй байсан учир их сургуулийн хичээлийг Дарь эхийн сүмийн латин сургуульд мөн дэргэд нь орших хотын захиргааны байранд явуулдаг болсон учир уг гудамж Студиестреде нэртэй болжээ. 1489 онд хичээлийн жилийн нээлт болоход Герман, Нидерландаас урьж ирүүлсэн багш нар, Данийн 76 болон Норвег, Исланд, Герман, Нидерландаас ирсэн оюутнууд хичээлд оржээ.

Жуулчид Стрөет гудамжаар явсаар Нюхавн буюу “Шинэ усан боомт” нэртэй хороололд хүрнэ. Уг гудамжинд 1673 онд тавьсан нарийнхан сувгийн хоёр талаар нэг нэгэнд нь тулган барьсан, шовх оройтой байшингууд сунжирна. Суваг үргэлжилсээр Конгенс-Нюторв талбайд тулж байгаа тэр хэсэгт чулуун зам дээр Дэлхийн хоёрдугаар дайны үед амь эрсэдсэн данийн 1450 усан цэргийн дурсгалд зориулсан усан онгоцны зангуу байрлуулжээ.

Гэхдээ хотын хамгийн гол дурсгалт зүйл нь Лангелинье голын эрэг дээр усан боомтын дэргэд байгаа, цул хадан дээр байрлуулсан “Лусын дагина” хүрэл баримал юм. Хотын билэг тэмдэг болох “Лусын дагина” баримал Худалдааны усан боомт (Копенгаген гэдэг үг ийм

утгатай ажээ.) руу орж байгаа дотоодын болон гадаадын усан онгоц, завиудыг бараг зуу гаруй дахь жилдээ элэгсэг дотноор угтсаар байна.

Копенгаген хотоор явахад Андерсений үлгэр алхам тутамд санагдах авч Алжир дахь Данийн консулын хүү Георг Карстенсенийн 1843 онд санаачлан байгуулсан "Тиволи" цэцэрлэгт хүрээлэн дотор шөнийн цагаар хэдэн мянган гэрэл цацруулдаг мавритан хийцийн ордон, Хятадын үндэсний театрыг үзэж сэтгэл санаа баяр хөөрөөр дүүрнэ.

Г.Карстенсен 1844 оноос цэцэрлэгт хүрээлэн дотор торгон цэргийн улаан-цагаан дүрэмт хувцастай эрэгтэй хүүхдүүдийн жагсаал зохиодог уламжлал тогтоожээ. Нарийхан явган гудамжаар торгон цэргийн гоёмсог дүрэмт хувцастай хөвгүүд хөл нийлүүлэн алхаж жагсаалын өмнө сүйт тэрэг дотор бяцхан "хатан хаан" явааг харахад андерсений үлгэр амилсан мэт санагдана.

Бредгадэ гудамжинд дөрвөн байшингаас бүрдэх Хатан хааны ордны цогцолбор оршино. Ордны нүүрэн тал дахь ханын цаг өдрийн 12 цагт дохио өгөхөд, ордны өмнөх талбайд харуул солих, туг залах ёслол болно. Торгон цэргийн том малгай, цагаан бүс бүсэлсэн хар шинельтэй гоёмсог дүрэмт хувцастай торгон цэргүүд алхан өнгөрдөг уламжлал тогтоод олон арван жил өнгөрчээ. Өндөр гоолоог нуруутай, цэргийн үлээвэр найрал хөгжмийн удирдагч очирт таяг өргөж буулган дохиод хөгжимчид маршийн аялгуу тоглоно. Шар орхимжтой, улаан нөмрөгтэй, эртний үеийн гурвалжин малгай өмссөн тVШмэл ордны хаалгыг ихэмсэг онгойлгоход төрийн дуулал эгшиглэж харуулын дарга, тугчин буцан орно.

## ТОКИО

Токио японы эртний хотуудын тоонд багтдаггүй. VIII зуунд хятадын хотуудын маягаар Нара, Киото хотуудыг байгуулж байх үед өнөөгийн нийслэл хот байрлаж байгаа Канто тэгш тал газар битүү намагтай байжээ. Гэвч энэ нутагт хүмүүс эрт дээр үед сууж байсан нь хуучны судлалын малталтаар нотлогддог билээ. Эртний Токио-Сенсёзи сүм тус оронд бүддийн шашин дэлгэрснээс бараг зуун жилийн дараа 628 онд баригджээ. Ойр орчмын нутагт цагаан будаа тариалдаг тариачид, мөн загасчид ирж энэ сүмд мөргөл үйлддэг байв.



Канто тэгш талын нэгэн хэсэг дээр үеэс Эдо (японоор “голын адаг” гэсэн утгатай үг) гэж нэрлэгддэг байсан хийгээд 1100 оны үед нутгийн цэргийн дарга Таро Сиэнага бэхжүүлсэн хурангаа мөн Эдо гэж нэрлэсэн байв. Гэвч феодалуудын хоорондын үл тасрах байлдаан тулаанаас болж энэ хүчирхэг омог задарч тус тусдаа удирдагчтай олон омог бий болжээ. Гэвч Хонсю арлын дорнод хэсгийн феодалууд 1192 онд бусад өрсөлдөгчөө дийлж омгийнхоо удирдагч Минамото Ёритомог улсынхаа хаанаар өргөмжилсөн ч бүх эрх мэдлийг сёгунууд атгаж, хаан тэргүүлэх бөөгийн үүрэг гүйцэтгэх болжээ.

XV зууны дунд үеэс газар нутгаа харийн дайснаудаас хамгаалах зорилгоор бэхжүүлсэн шилтгээн барьж 1457 оны дөрөвдүгээр сарын 8-нд нээлтээ хийснийг Эдо байгуулагдсан өдөр гэж тооцдог. Шилтгээний эргэн тойронд яваандаа гар урчууд сууршиж оршин суугчдын тоо улам нэмэгдсээр хот болон хувирчээ. Гэвч XV зууны сүүлчээр феодалуудын тэмцэлдээнээс болж хот уналтад орж зуу гаруй жил хөгжсөнгүй өнгөрчээ.

Канто мужийн амбан захирагч Токугава Иэясу Эдо хот нь худалдааны хувьд маш ашигтай байрлалтай болохыг ойлгож хуучин шилтгээний буурин дээр илүү том ордон босгож намхан ч зузаан хэрэм, ус дүүргэсэн өргөн довоор хүрээлүүлж 80 мянган самурай бүхий армия байрлуулжээ.

Тэр үед бүддийн шашны Асакуса цогцолбор мөн баригдаж эхлэсэн ба түүн рүү Накамисе гудамжаар явж очно. Хоёр талаар нь жинхэнэ болон хиймэл сакура модны мөчир сагсайх гудамж дахь тоймгүй олон дэлгүүр, лангуунуудад голдуу бэлэг дурсгалын зүйлс худалдаална. Олон түмэн Каннон гэж нэрлэдэг саарал дээвэртэй Сенсёзи сүмийн цогцолбор эл гудамжны гол чимэг болно.

Сүмийн үүдэнд модон саравчны дор байрлуулсан том тавиур дээр асаастай байгаа цаас нарийхан хуйлж хийсэн “лаа”-ны утаанд ирсэн хүмүүс гараа эргэлдүүлж бие сэтгэлээ ариусгана. 628 онд ах дүү загасчид Сумида голоос олсон нинжин, өрөвч сэтгэлийн Каннон эм бурхны баримал сүм дотор байна. Хэд хэдэн барилга байгууламжаас бүрдэх сүмийн цогцолборын гол байшин дотроос нь эм бурхны баримал олдсон Гогудзи хэмээх сийлбэрээр чимсэн алтадмал тахил байрлуулсан байшин юм. Уг байшинг XII зуунд босгожээ. Энэ сүмд алтаар урласан лянхау цэцгийн дунд байрлуулсан Бүдда бурхны баримал бас бий.

Токугава угсааны сёгунууд хаанчлалынхаа жилүүдэд нийгмийн харилцааны хатуу дэг журам тогтоосон байжээ. Улс орныхоо хүн амыг цэрэг-самурайнууд, тариачид, гар урчууд, худалдаачид гэх дөрвөн давхаргад хуваасан төдийгүй тус бүрийг нь үе залгамжлагч даймё захирдаг феодалын хоёр зуу гаруй омог бий болгожээ. Сёгунуудын засаг захиргаа даймё нарыг дуулгавартай, багтай захирч байхын тулд тэдэнд Эдо хотод ордон байгуулж жил бүр ирж байхыг тушаажээ. Тэрчилэн эхнэр, хүүхдүүдээ Эдо хотод байнга байлгахыг үүрэг болгосон нь үнэн хэрэгтээ тэд нарыг нь барьцаанд авсантай адилхан ойлгогдож байжээ.

Сёгунууд зарлиг гаргаж уламжлал ёсоор хотын хорооллуудыг тэгш өнцөгт хэлбэртэй байгуулсан нь хот өргөжин тэлэхийн хэрээр зорьсон байшин, гудамж олж очиход бүр төвөгтэй болжээ. Сёгунууд шилтгээний нутаг дэвсгэр дээр намхан модон байшингууд бариулж байсан нь түймэрт олонтаа сүйдэж байв. Тэгээд 1657 онд гарсан аймшигт түймрийн дараа шилтгээнээ хотын төвд байрлах биеэ үнэлэгч бүсгүйчүүд цуглардаг Ёсивара хороолоос цагаан будааны талбайд шилжүүлэн барьж Эдо хотын хөгжөөнтэй аж байдлыг байнга хяналтдаа байлгах зорилгоор тойруулан гүн жалга ухаж ганц хаалга гаргаж үдэш 22 цагт хаадаг байсан ч эрчүүд яаж ийгээд Ёсивара хороололд орчихдог байжээ.

1868 онд хөрөнгөтнүүд төрийн эргэлт хийж сёгунуудыг унагаж хаант засаглалыг сэргээсэн үед хотыг Токио гэж өөрчлөн нэрлэжээ. Эртний ямато омгоос гаралтай 15 настай хүү Мицухито Киото хотоос цэргийн ачаанд нууцаар дайн авчирч хаанаар өргөмжилж сёгунуудын шилтгээнийг Хааны ордон болгон хувиргаж түүнд залжээ.

Мицухито хаан цэргийн ачаанд хамт ирсэн, сёгунуудыг төрийн өндөрлөгөөс зайлуулах байлдааны ажиллагаанд хэрэглэх зэвсэг худалдан авахад зориулж хөрөнгө мөнгө гаргасан Мицуи, Ивасаки хэмээх хоёр худалдаачинд талархал илэрхийлж тэдэнд язгууртны хэргэм зэрэг олгожээ. Худалдаачин Ивасаки Хааны ордны өмнөх талбайны цаана байх хүн амьтангүй газрыг худалдан авч гурван чулуун байшин бариулжээ. Хожим нь аж үйлдвэр-санхүүгийн Мицубиси концернийг үндэслэгч болсон Ивасаки цэргийн ар талын албатай ажил хэрэгч холбоо хэлхээтэй байж асар их баяжжээ.

Токио хотод гудамж талбайг эрт дээр үеэс эмх замбаараагүй барьж байсан тул өнөөдөр японы нийслэлийн бүх гудамж нэр байхгүй, оршин суугчдын хаяг нь аж төрж байгаа хороолол, байшингийн дугаараас бүрдэнэ, гэтэл байшингуудыг дэс дарааллаар нь биш, баригдсан оноор нь дугаарласан учир тухайлбал 8 дугаартай байшин 80 болон 1000 дугааруудтай байшингийн хооронд байрлаж байх жишээтэй.

Токио хотын төв гудамж л Гинза (“Мөнгөн”) гэсэн нэртэй, хэдэн километр урт эл гудамжаар явахад хоёр талаар нь байх шил толь болсон олон давхар их дэлгүүрүүдийн хооронд нэгээс

хоёр давхар жижиг мухлаг, лангуу эгнэн байна.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Токио хотын тал хэсэг нь сүйдсэн, хүн амын тоо нь гурав дахин буурсан байсан ч төдөлгүй орчин үеийн хот болон алдаршсан билээ. Тус хотыг хөгжүүлэхдээ “цогцолбор төв”-үүд болон дагуул-хотууд байгуулах гэсэн хоёр зарчмыг баримталж байжээ. Өрнөдөд дөнгөж төлөвлөж байгаа зүйлүүдийг Японд тэр дор нь хэрэгжүүлж эхлэсэн байдаг. Тухайлбал хорьдугаар зууны далаад оны үед Париж хотод тээврийн хэрэгсэл явах замыг явган зорчигчийнхоос тусгаарлах тухай төслийг хэлэлцэн батлаж байхад Токиод аль хэдийнээ хотын төвийг хэсэг хугацаагаар хааж, явган зорчигч явах замыг тээврийн хэрэгсэл явах замаас тусгаарлах ажил төгсгөлийн шатандаа орсон байв.

Хэдхэн арван жилийн өмнө Токио хотын усан боомтод хөвдөг хот байгуулахаар газар ухагч, бульдозер, экскаватор татан авчирч тэнгисийн ёроолыг тэгшилж шон суулгах ажил эхэлж байсан бол одоо засмал болон төмөр замын шугамууд агаарт сүлжилдсэн, тэнгэр баганадсан өндөр барилгуудтай хэдэн зуун мянган оршин суугчтай хот аль хэдийнээ байгуулагджээ. Токиогийн усан боомтоор дайруулан дэлхийд хамгийн урт гүүр тавьж агаарын дэрээр хурдан галт тэрэг алсад одно.

Байшин барилгууд нь хэт замбараагүй байрласан, үй түмэн хөнгөн тэрэгний утаанаас амьсгаа давчидсан гурван хорооллыг өөрчлөх ажлыг Синзюку хорооллоос эхлэжээ. Хөнгөн тэрэгнүүд хурдлан давхисаар хорооллын төвд байдаг дөрвөн урт явган замыг тойрч том нүх рүү далдран алга болох шиг санагдана. Тэр бол газар доорх хотхоны нэгдүгээр давхар ажээ. Хоёрдугаар давхарт нь өдөрт нэг сая орчим хүн өдөр шиг гэрэл цацарсан, өчнөөн төчнөөн дэлгүүр, лангуу бүхий гудамжаар явж зогсолтгүй дээшилж доошлох өргөдөг шатаар зорчино.

Японы ихэнх дэлгүүр, зоогийн газар мэдээж хэрэг айл гэрүүдэд савраа өргөн мэндчилж байгаа хөөрхөн муурууд буюу манэки-нэко (орчуулбал “Урьж байгаа муур” гэсэн утгатай холбоо үг) байдаг. Түүнээс гадна Токиод манэки-нэкод зориулсан Готокузи хэмээх сүм бий. Сүм дотор ороход том хүрэл хонх унжуулсан П хэлбэрийн байгууламж түүний дэргэд хар том чулуун аяга байна. Тусгай бунхан дотор савраа өргөн мэндчилж байгаа хэд хэдэн муур байна.

Эртний нэгэн домогт “Хэдэн зуун жилийн тэртээ энэ сүмийн ядуу лам олдсон идэх зүйлээ хайртай мууртайгаа хувааж идэн өдөр хоногийг өнгөрөөдөг байжээ. Нэгэн удаа язгууртан самурай эр сүмийн хажуугаар өнгөрч яваад хаалганы завсраар муур байгааг хартал урьж байгаа мэт савраа өргөсөн байв. Самурай гайхаж сүм дотор ортол тэнгэр гэнэт бүрхэж аадар бороо орж, самурайн дөнгөж сая зогсож байсан газар аянга цохижээ. Самурай амьд гарсандаа маш их баярлаж сүмийг ивээлдээ авчээ.” гэж өгүүлсэн байдаг.

Чухам тэр үеэс “Урьж байгаа муур” буюу Готокузи сүм өргөжиж хүнд ямагт тус хүргэж байдаг Каннон эм бурхныг мууртай адилхан дүрсэлдэг болжээ.

1993 онд нээсэн “Эдо-Токио музей”-н тавдугаар давхарт өргөдөг шатаар гарч очиход хуучин Эдо хот болон түүний гол гудамж болох Нихонбаси дахь тус орны өнөөгийн гол гүүр угтана. Уг гүүрийг 1603 оноос тус орны газар зүйн төв гэж үзсээр ирсэн ажээ.

## ГАВАНА

Христофор Колумб анхны аялалын үед 1492 онд Куба орныг нээж энэ бол “Миний амьдралдаа харсан хамгийн сайхан газар нутаг.” гэж магтсан ч түүний дараа ирсэн испанчууд алт, очир алмаас олоогүй учир орхин явжээ.



Далайн хязгааргүй цэнхэртэх уужимд халуун орны ургамалд битүү хучигдсан нов ногоон арал байгаа нь Куба улс оршдог арал болой. Далдуу модны саглагар оройны сүүдэрт далдуу модны навчаар сүлжиж хийсэн дээвэртэй сургааган бяцхан байшингууд ярайна. Конкистадорууд арлын хойд хэсэгт далайн зүгээс хошууны нарийхан зураасаар хүрээлэгдсэн, өнөө үед ч орчин үеийн том усан хөлөг чөлөөтэй орж гардаг гүнзгий устай өргөн, сайхан усан боомт барих газар олжээ. Испанчууд энэ арлыг огт сонирхохгүй байсан тул Гавана буюу “Хоосон эл хуль орон дахь хот” гэж нэрлэж байлаа.

Гавана хот анх 1514 онд Кубын өмнөд эрэг дээр байгуулагдаж дараа нь хойд эрэг рүү шилжин байрлаж гадна дүр төрхөөрөө агч модны навч санагдуулах тэнгисийн том булангийн ойролцоо эгнэгт сууршижээ. “Алт бүхий нутаг” хайж өрнө зүг чиглэн яваа испанийн усан онгоцууд энэхүү жижиг суурингаар хэдэн арван жилийн турш дайрдаг байлаа.

Кубын өнөөгийн нийслэлд түүхэн урт хугацаанд асар их “зовлон амссан” хоёр газар бий гэж ярьдаг нь усан боомт, хуучин Гавана хот дахь сүмийн өмнөх талбай ажээ. Х.Колумб удаан аялалын хугацаанд усан онгоцнуудын ёроолын улд наалдсан хавчнуудыг цэвэрлэх зорилгоор усан онгоцны ахмад нарт зангуугаа хаяж анх буудалласан учир испанчууд “Пуэрто де каренас” (“Хавчны усан боомт”) гэж нэрлэсэн усан боомтоор анхны жилүүдэд нь Шинэ Тивийн испани болон английн эзэмшил орнуудын хоорондын бараа солилцооны гол бүтээгдэхүүн болох тамхи, элсэн чихэр тээвэрлэж байгаа усан онгоцууд л орж гардаг байлаа.

Америк тивийн асар их баялаг нь Карибын тэнгисийн сав нутагт далайн дээрэмчдийн анхаарлыг гойд татаж Пуэрто де каренас усан боомт испаничуудын хувьд стратегийн ач холбогдолтой болов. Тэгээд ээлжит амбан захирагч Дерес де Ангуло ордноо 1553 онд Баракоагоос Гаванад шилжүүлж нийслэлээ болгожээ.

Тэр үеэс дээрэмдэж тоносон их баялгийг эх орондоо ачиж явуулахад ашиглах болсон усан боомтын хамгаалалтын асуудалд испанчууд онцгой анхаарч анхны Ла-Фуэрс цайзыг 1558

оноос барьж эхлэжээ. Гавана нь усан замын гол зангилаа боомт хот болохыг билэгдэж тус хотын сүлдэнд түлхүүрийн дүрс оруулсан байдаг. Тус хотын хамгийн төгс, өнөөг хүртэл хэвээр хадгалагдан ирсэн Ла-Фуэрс цайзанд Кубын амбан захирагч хоёр зуу гаруй жилийн турш сууж байсан хийгээд уснаас урган гарсан хэрмээр явж гурван талаасаа нэг давхар байшингуудаар хүрээлэгдсэн дээд талбайд хүрнэ. Хэрмийн хананд гаргасан буудлагын нүүхүүдийг дотор талд нь болж байгаа үйл явдал харагдахааргүй хийсэн нь их сонин.

Усан боомтыг далайн дээрэмчдээс найдвартай хамгаалахын тулд испаничууд өөр цайз, харуулын цамхаг олноор босгож тэрчилэн Гавана хотын эргэн тойрны өндөрлөгүүдэд бэхлэлт байгуулж хооронд нь холбожээ. XVIII зуунд англичууд 200 гаруй байлдааны усан онгоц, бараг 20 мянга десантын цэргийн хүчээр дайрч 70 шахам хоног зогсолтгүй дайрч байж сая нэг цайзыг эзлэж чаджээ.

Нэг жилийн дараа испаничууд арлыг буцаан авч С.Абарк гэдэг цэргийн инженерт эвдэрч нурсан бэхлэлтийг сэргээх, шинээр цайзууд босгох үүрэг даалгавар өгч явуулжээ. Өнөөдөр тэдгээр цайз Гавана хотын уран барилгын өвөрмөц онцлог, “нэрийн хуудас” болдог юм.

Арлын эрэг нь хадан хясаа, намгархаг нам дор газар солбилцон байдаг, тэрчилэн хотыг тойруулан босгосон хэрмийн тойрог жижигхэн байсан нь хотын хөгжилтийг нилээд чөдөрлөж байв. Мөн түймэр байнга гарч ихээхэн хохирол учруулж байсан учир Испанийн хоёрдугаар Филип хаан модон байшин барихыг хориглосон зарлиг гаргаж байжээ.

Хуучин Гавана хотын хорооллууд, гудамжны өргөний хэмжээ хоорондоо бараг адилхан хийгээд хотын тэгш өнцөгт хэлбэртэй төв талбайг анх цэргийн сургуулилтын зориулалтаар ашигладаг байсан учир Плас-де-Арм гэсэн нэртэй болжээ.

Ла-Фуэрс цайзаас холгүйхэн орших Кубын амбан захирагчийн өргөөг эртний Испанийн дэгээр дотоод гоё хашаатай, барокко дэгийн өндөр баганууд, өргөн тагт, давхарлагуудыг нь нарны гэрэл өрөө, тасалгаануудад шууд тусахааргүй хийжээ. Гэхдээ нутгийн уран барилгачид барокко хийцийн мушгимал чимэглэлийн оронд хан боргоцойн дүрс хийсэн нь шохоорхол татна.

Амбан захирагчийн өргөөтэй бараг нэгэн зэрэг хөлгүй баян, креол үндэстэн Доминго Альдама сонгодог дэгээр ордон бариулж эхлэсэн нь испанийн хаанд дургүйцэж байгаагийнх нь илэрхийлэл байлаа. “Мигель Альдамагийн ордон” гэж одоо алдаршсан тэрхүү ордны италийн цагаан гантигаар урласан шатууд нь агаарт хөвж буй мэт сэтгэгдэл төрүүлдэг ба танхимуудын таазны чимэглэлийг европоос шилдэг урчууд урьж авчирч хийлгэжээ. Энэ ордонд алдартай жүжигчид, кубын дэвшилтэт зохиолчид цугларч Италиас ирсэн дуучид ая дуугаа өргөдөг байжээ. Боолчлолыг халах тухай уриа энэ ордноос анх цуурайтжээ.

Куба дахь хааны талыг баримтлагчид Альдама ордонд ноёрхож байгаа эрх чөлөөт сэтгэлгээг нугачин дарахаар ордон руу дайрч бүх зүйлийг эвдэн сүйтгэж шатаажээ. Мигель Альдама амь наана там цаана АНУ-д оргон гарч тэнд ядуу зүдүү байдалд өөд болжээ. Ордон дотор эхлээд тамхины үйлдвэр байсан бол хожим нь нэгэн албан байгууллага байрлаж байжээ. Он цаг өнгөрсөөр эздэд нь өөрчлөгдөх авч ордон хэвээр байсаар өнөөг хүрчээ. Помпейн дэгээр бүтээсэн уран зургууд нь дөнгөж өчигдөр уран гартны гараас гарсан мэт цоо шинэ мэт

харагдах нь үнэхээр бахархам билээ.

Чихрийн нишингэ, тамхи, кофе үйлдвэрлэлийн ачаар Куба орон XVIII зуунаас түргэн хурдацтай хөгжиж эхлэжээ. Тэрчилэн усан онгоцны үйлдвэрлэл эрс нэмэгдэж Куба улсаас хуучин тивийн орнуудтай хийдэг худалдаа арилжаа өргөжсөнөөр кубачууд тэдний орны соёл, урлаг, амьдрал ахуй, уран барилгатай гүнзгий танилцжээ. Нутгийн креол үндэстний язгууртнуудын гарт асар их баялаг хуримтлагдав. Хаант Испани улсын соёлын уламжлал болон нутгийн креол үндэстний соёлын уламжлал хоорондын сөргөлдөөний дундуур хувьсгалт Францийн неоклассицизм дэг хүчтэй нэвтрэн орж иржээ. Хот байгуулагдсаны 300 жилийн зориулан босгосон Плас-де-Арм талбай дахь Темплет хэмээх бяцхан сүм босгосон нь неоклассицизм дэгийн хөгжлийн эхлэл болжээ.

Хорьдугаар зуунд европ тив хэд хэдэн удаа аймшигт дайн болж түүний “ачаар” кубын элсэн чихрийн эрэлт улам өсөж улам баяжсан нутгийн баячууд хотын баруун хэсэгт орших Ведадо (“Хаалттай” гэсэн утгатай үг) хороололд тохилог тансаг ордон, харш бариулж байв. Голдуу хоёр давхар байшингийн нэгдүгээр давхарт онгорхой тагтаар цэцэрлэгт хүрээлэн рүү хүрдэг хүлээн авалтын танхим, ёслолын хоолны танхим, хоёрдугаар давхарт нь байх олон өрөө, тасалгаанд гэрийн эзэд амьдран сууна.

Кубын зохиолч А.Карпентьерийн “Багануудын хот” гэж нэрлэсэн Гавана хотод эртний болон мавританы уран барилгын дэгүүд холилдон байдаг. Хэдэн зуун жил оршин тогтнож байгаа байшингууд бат бэх ч мөнхийн биш билээ. Тиймд ЮНЕСКО “Хуучин Гавана” хотыг нийт хүн төрөлхтөний соёлын аугаа ололтын нэг гэж албан ёсоор зарлажээ. 1981 онд хотын хуучин хэсгийг сэргээн засварлах төлөвлөгөөг батлан гаргаж нилээд олон эртний байшин барилгыг сэргээн засварласаар байна.



## ЖАКАРТ

Индонези улс нь тоймгүй олон арал дээр оршдог ба арал бүр нь “эрдэнэсийн арал” билээ. Индонезийн бүрэлдэхүүнд гурван мянган арал байдаг гэж ярьдаг ч үнэндээ бол 14 мянган орчим арал байдаг. Гэхдээ тэдгээр арлын дийлэнхэд нь хүн суудаггүй, зарим нь хүн суурших аргагүй жижигхэн ажээ.



XVI зуунд Ява аралд голландчууд ирэхээс өмнө орчин үеийн Жакарт хотын буурин дээр худалдааны жижигхэн Сундакелапа хот байжээ. Задгай далай, тэнгисүүдэд дээрэм тонуул, хууль бусаар хил давуулах наймаа, үнэртэн арилжааны ид цэцэглэлтийн үе байсан тул португальчууд, голландчууд, англичууд ертөнцийн энэ хэсэг рүү өрсөлдөн тэмүүлж байлаа. Тэд ач тач тэмцэлдэхдээ нутгийн иргэдийн дэмжлэг, туслалцааг авахыг мөн эрмэлзэж байлаа.

1522 онд Сундакелапе хотод анхны голландын далайчид буудаллаж худалдааны бүс худалдан авч дараа нь зөвшөөрөл авч цайз барьж эхлэжээ. Сундакелапа усан боомтыг эзэмшиж байсан вант улсын султан Бантам хотыг Жаякерта гэж өөрчлөн нэрлэжээ. Тэрбээр цайз барьж байгаа тухай дуулаад англичуудад хандаж туслалцаа үзүүлэхийг гуйв. 1619 оны тавдугаар сарын сүүлчээр голландын усан цэргийн жанжин Я.П.Кун бараг хамгаалалтгүй шахам сууринг эзлэж англичуудын агуулахуудыг шатааж сууринг газрын хөрстэй тэгшилжээ. Тэгээд баригдаж байгаа цайз нэргүй байгаад гайхаж Батавия гэж нэрлэв. Батавия гэдэг нь голландын өвөг дээдсээ гэж дээдэлдэг батав дайнч омгийнхны нэр ажээ.

Жакарт хотын нутаг дэвсгэрийг Дорнод-Энэтхэгийн компани эзэгнэж усан боомтын шинэ хот байгуулж хэрэм, эргийн хамгаалалтаар бэхжүүлжээ. Гэвч гадаадын түрэмгийлэгчдэд дургүйцсэн индонезичууд тэмцэлд босож Батавия цайзын ойролцоох ойд бүгж үргэлж довтолж амар заяа үзүүлдэггүй байв. Тэдний довтолгооноос айж эмээсэн голландчууд хотоос гардаггүй байлаа. Дорнод-Энэтхэгийн компани европ маягаар барьсан Батавия цайзыг Ява дахь нийслэлээ болгож тэр үеэс худалдааны хэлхээ холбоогоо өргөжүүлж түүний ачаар хот ч хөгжин цэцэглэв. Анхандаа Батавия цайзанд дан эрчүүд суудаг байсан ч яваандаа XVIII зууны эхээр эмэгтэйчүүд амьдардаг болжээ.

Голландын бусад эзэмшил нутгийн адил Батавия цайзанд бүх зүйлийг түүний дотор сувгуудыг хүртэл голланд маягаар хийжээ. Байшингуудад халуун усны хоолой татаагүй байсан тул голланд хатагтай нар цайзыг халуун усны газрын зориулалтаар ашиглаж байлаа.

XVII зууны туршид Батавия нь олон улсын худалдааны төв байж түүний агуулах, усан хөлгүүд Индонезийн өнцөг булан бүрээс тэрчилэн Перс, Энэтхэг, Японоос тээвэрлэж авчирсан бараагаар пиг дүүрч байлаа. Гэвч XVIII зуунаас Батавия хотын ач холбогдол буурч ялангуяа 1732 онд халуун орны хумхаа өвчний тахал гарч хотын дийлэнх оршин суугч хөдөө нутагт шилжин сууршиж амбан захирагч өргөөгөө Богор хотод шилжүүлсэн үеэс бүр эл хуль болжээ. Цаг хугацаа өнгөрч амьдрал байдал хэвийн хэмнэлдээ орсон ч XIX зуун гэхэд Батавия өсөн нэмэгдэж байгаа ачааллыг даахаа байснаас Танжунг-приок хэмээх усан боомт нэмж барьжээ.

1942 онд Батавия хотыг япончууд түрэмгийлэн эзлэж АНУ болон түүний холбоотнуудын эсрэг тэмцэлд нутгийн оршин суугчдын дэмжлэгийг авах зорилгоор индонезийн зарим удирдагчийг талдаа татаж хотод хуучин нэрийг нь өгч Жакарт гэх болжээ. Япончууд хотыг гурван жил эзэгнэх хугацаанд ямар нэгэн өөрчлөлт, ахиц дэвшил гарсангүй.

Батавия нь хорьдугаар зууны дунд үед гэхэд ч вааран дээвэртэй нэг давхар байшингуудтай, халуу шатсан хот байсан тул түүнийг хот гэхээсээ том тосгон гэж нэрлэж болохоор байлаа. Гэвч өнөөдөр шинэ Жакарт хот “байгалийн нөлөөллөөс” улам бүр бага хамааралтай болсоор байна. Ихэнх зочид буудал, гадаадын компаниудын албан байр, банк, олон нийтийн байгууллагуудын байр сэрүүцүүлэгчээр бүрэн хангагдаж цонхоор харахад л дэлхийн халуун цэгт байгаа нь мэдрэгдэнэ.

Хорьдугаар зууны жараад оны үед нэг давхар Жакарт хотод анхны өндөр байшингууд сүндэрлэж тэдгээрийн анхных нь “Индонесия” зочид буудал байв. Бүтээн байгуулалт эрчтэй өрнөсөөр байгаа ч жакартчууд тэнгэр баганадсан өндөр байшин барихыг тэмүүлдэггүй. Тухайлбал хотын томоохон зочид буудлын нэг болох “Дхарма Нирмала” зочид буудал нь цэцэрлэгт хүрээлэнд байрлах бүлэг шилтгээнүүд юм. Байгалийн сайханд олон давхар байшин барих нь утга учиргүй биз ээ.

Жакарт хотын хүн амын дийлэнх нь хөрөнгө чинээ багатай ядуучууд байдаг. Харамсалтай нь тэдний тоо жил өнгөрөх бүр нэмэгдсээр байна. Хамгийн гол нь ядуурсан тариачид, хөдөөгийн хотуудад ажил төрөлгүй болсон сэхээтнүүд, хялбар аргаар мөнгө олохыг хүсэгчид хотын оршин суугчдын тоог нэмэгдүүлж байна.

Өнөөгийн Жакарт хотод иллэгийн төв, шөнийн клуб, турк халуун усны газар, мөрийтэй тоглоомын газар олноор ажиллаж байна. Шөнийн амьдрал хотын төсөвт нэг сая рупий оруулж байгаа нь нийт төсвийн дөрөвний нэг хувь болж байдаг. Жишээ нь Исмаил Марзукийн нэрэмжит Соёлын төвийг мөрийтэй тоглоомын газруудаас хураасан татварын хөрөнгөөр босгожээ.

Жакарт хотоос холгүйхэн 1000 гаруй жилийн түүхтэй Прамбанан сүм сүндэрлэн байна. Ойр орчмын тосгодын оршин суугчд сүм хэрхэн бий болсон тухай ийм нэгэн домог ярьцгаадаг: Хүдэр том биетэй ид шидтэн залуу Лара Жангранг хэмээх үзэсгэлэн төгс гүнжид дурлаж гэрлэх саналаа хэлжээ.- Чи нэг шөнийн дотор чулуугаар 1000 баримал сийлж тахиа донгодохоос өмнө амжиж дуусгавал би чиний гэргий болно гэсэн болзлыг Лара Жангранг бүсгүй өөдөөс нь тулгажээ.

Хүдэр залуу тэр үдэш нь баримал сийлэх ажилд ханцуй шамлан орж, үүр цайхаас өмнө 999

баримал сийлж сүүлчийн баримлыг урлаж байлаа. Хорон санаат гүнж өгсөн амлалтаасаа буцаж тосгоны бүсгүйчүүдийг сэрээж тэд сав суулга нүдсэнээс тахиад сэрж донгодож эхлэжээ. Итгэл эвдсэнд уурласан хүдэр залуу хорон санаат гүнжийг 1000 дахь баримал болгон хувиргажээ.

## БУЭНОС-АЙРЕС

Испаниас бид усан онгоцууддаа 72 азрага, гүү ачиж замд гарсан билээ. Биднийг шинэ нутагт керанди гэж өөрсдийгөө нэрлэдэг нутгийн уугуул иргэд болох улаан арьстнууд угтав. Тэнд гурван мянга гаруй улаан арьстан эрчүүд эхнэр, хүүхдүүдтэйгээ амьдран суудаг ажээ. Тэд загас, мах авчирч биднийг дайлахад бид гэдэс орж билээ. Улаан арьстан эмэгтэйчүүд хөвөн даавуугаар хийсэн жижиг алчуураар нандин эрхтэнээ халхалдаг юм байна.



Орчин үеийн Аргентин улсын нийслэлд анх хөл тавьсан европчууд анхны сэтгэгдлээ дээрх байдлаар илэрхийлж байв. 500 орчим жилийн тэртээ Ла-Плата голын эрэг дээр нэгэн хот байгуулагдсан нь хожмоо Мөнгөн орон гэж алдаршсан Аргентин улсын нийслэл болжээ. Испаничуудын байгуулсан анхны сууринг эрх чөлөөг эрмэлзэгч кечуа, гуарани омгийн улаан арьтнууд довлон сүйтгэжээ. Хуан де Гарай 1580 онд тэднийг бут цохиж “Вилья Санта Мариа де лос Буэнос-Айрес” хотыг хоёр дахь удаагаа үндэслэжээ. Өнөө үед тэр урт нэрнээс “Буэнос-Айрес” буюу “сайхан агаар” гэсэн үг л үлджээ. Испанийн эзлэн түүрмгийлэгчид энэ нутагт хөл тавимагцаа “Ямар сайхан агаартай юм бэ!” гэж уулга алдсан учир тэгж нэрлэсэн гэдэг ч үнэндээ бол зун тэсвэрлэшгүй халуун, өвөл чийгтэй, тасхийм хүйтэн жавартай нутаг билээ.

Тусгаар тогтнолын төлөө дайн эхлэхээс өмнө Буэнос-Айрес хот испанийн эзэмшил нутгуудын амьдралд тодорхой үүрэг гүйцэтгэж байсангүй. Тэр үед эзэмшил нутгийн нийслэл нь Лима хот байсан тул испанчууд Шинэ тивээс дээрэмдэн авсан үнэт эрдэнэсээ Буэнос-Айресээр биш чухамдаа Панамаар дамжуулан эх орондоо илгээж байв. XVIII зууны эцэс хүртэл Буэнес-Айрес хотод гадаад орнуудтай худалдаа арилжаа хийхийг хориглодог байсан дээрээс хотын оршин суугчид хууль бус наймаагаар амьжиргаагаа залгуулж байжээ. Түүгээр ч барахгүй Рио-де-ла-Плата тусгай муж байгуулж Буэнос-Айрес хотыг нийслэлээр нь зарласан ч хотын амьдралд олигтой өөрчлөлт гарсангүй.

XVIII зууны сүүлчээр Испани улс баримталж байсан бодлогоо өөрчилж Буэнос-Айрес хотыг Атлантын далайн өмнөд хэсэг дэх бэхжүүлсэн хил хязгаар болгохоор шийдэж бусад оронтой бие даан арилжаа наймаа хийхийг зөвшөөрчээ. Тэр үед европ тивээс нүүдэлчид бөөнөөр ирж бод малын наймаа ид өрнөж хотын хөгжилт улам түргэсчээ.

1810 онд Аргентин улс тусгаар тогтнолоо зарласнаас хойш Буэнос-Айрес нь Өмнөд

Америкийн хамгийн том, шуугиантай, орчин үеийн, гоёмсог хот болон манджээ. Тэр үеэс Буэнос-Айрес болон Кордоба, Мендоса хотуудын хооронд өрсөлдөөн гарсан ч аргентинчууд Байрес гэж нэрлэдэг Буэнос-Айрес 1880 онд нийслэл хотоор тодорчээ.

Гэвч дэлхийн хоёрдугаар дайны дараа Бразил улс эрчтэй хөгжиж Венесуэл баяжиж улс төрийн талаар Куба улс урагшилж байдал өөрчлөгдөж Аргентин Өмнөд Америкийн жирийн нэгэн улс болон хувирав.

Хуучин Буэнос-Айрес нь нийслэлийн нэгэн дүүрэг болох Ла Бока жижигхэн усан боомтын хотхон юм. Энд далайчид, усан хөлөг онгоц баригчид сууна. Тэд эхлээд усан хөлгөө будаж үлдсэн будгаар нь байшингаа өнгөлнө. Тийм учир эндхийн орон сууцны байшингууд нь янз бүрийн өнгөтэй ажээ.

Өнөө үед Буэнос-Айрес эх орныхоо аж үйлдвэрийн томоохон төв болон хувирч хотын оршин суугчид үйлдвэрийн газруудад олон зуун мянгаараа ажилладаг ч өөрсдийгөө “портенъос” буюу “усан боомтын оршин суугчид” гэж уламжлал ёсоор нэрлэсэн хэвээр байна. Буэнос-Айрес хотод гадаадын цагаач иргэд олон байдаг тул Аргентиний бусад муж, хотын иргэд нийслэлийнхээ иргэдийг “криожьо” буюу “аргентиний уугуул иргэн” гэж ер хэлэхгүй, зүгээр л “портенъос” гэнэ.

Манай хот нь аргентиний биш чухамдаа олон үеийн цагаач иргэд усан онгоцоор тээвэрлэн авчирч босгосон европ хот гэж “портенъос”-чууд ярьдаг. Тус хотод дан франц, итали, испан, польщ, украин, югослав иргэд голдуу оршин суудаг дүүргүүд бий. Тэд паспортаар бол цөмөөрөө аргентинчууд гэхдээ “эзэмшил” дүүрэг бүр хөршүүдээсээ “тусдаа” байхыг хичээнэ. Тийм “эзэмшил” дүүргийн оршин суугчид зөвхөн үндэснийхээ зоогийн газар кафед орно, төрөлх хэлээрээ сэтгүүл сонин гаргана, алс хол байгаа “төрөлх” эх орныхоо баяруудыг тэмдэглэж үндэснийхээ дууг дуулж баясна. Буэнос-Айрес нь үнэндээ бол олон ард түмний соёл, техникийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг өөртөө шингээсэн хот юм.

Орчин үеийн энэ сайхан хот зуу хүрэхгүй жилийн дотор бий болсон гэхэд заримдаа итгэмээргүй. Улс орон нь баян болохоор нийслэл хотоо шинэчлэхэд хөрөнгө мөнгө харамгүй зарцуулж байв. Италийн гантиг хэрэгтэй болоход Италид очиж худалдан авч байлаа, Португалийн вааран хавган шаардлагатай болоход наймаачид тэр зүг хөлгийн жолоо залж байв. Тэнгэр баганадсан байшин барих болоход хуучны барилгуудыг эргэлзэж тээнэгэлзэлгүй шууд нурааж байлаа. Тиймд XVI зууны үеийн барилга байхгүй болж XVII зууны үеийн хэдхэн тооны сүм, XVIII зууны үеийн цөөхөн барилга үлджээ.

Колонийн эзэмшлийн барилга байгууламж бүхий дүүрэг нь Сантельмо юм. Нуман хаалга, төмөр сараалжаар битүүлсэн жижиг тагтнууд, вааран дээвэр бүхий цагаан шохойгоор будсан байшингууд, чулуу дэвссэн гудамжууд, сүм, голдоо цэцэрлэгт хүрээлэн бүхий дөрвөлжин хэлбэртэй талбайнууд Сантельмо дүүргийн өвөрмөц өнгө төрхийг илтгэнэ. Өнөөдөр жуулчдын гэсэн тодотголтой болсон дүүрэгт хэзээ ч хуучрашгүй, жавхаалаг танго бүжиг бүжиглэнэ. Усан боомтын дэргэдэх цэнгээний газарт мэндэлсэн усан цэргүүд, ачигч, үйлдвэрийн эмэгтэй ажилчдын энэ бүжиг хорьдугаар зууны эхээр Париж хотыг байлдан дагуулж байсан нь түүх болон мөнхөрчээ.

Буэнос-Айрес хотын албан ёсны төв нь тусгаар тогтнолын төлөө тэмцлийг толгойлж байсан генерал Сен-Мартиний чандар хадгалагдаж байгаа сүм байрлаж байгаа Пласа де Майо талбай юм. Гэтэл зарим хүмүүс хотын төв нь Пласа де Конгресиу талбай гэж үздэг нь буруу.

Нийт өргөн нь 150 метр, 4 эгнээ, эгнээ бүр нь 4-6 урсгал бүхий Авенида долоодугаар сарын 9-ны гудамж нь аргентинчуудын бахархал юм.

Хотын гурван гол гудамж салаалдаг Бүгд Найрамдах Улсын талбайд 1936 онд хот байгуулагдсаны 400 жилийн ойгоор нь 72 метр багана босгожээ. Орой нь үзүүрлэсэн харандааг санагдуулах шовх үзүүртэй пирамид гэж нэрлэвэл илүү тохирох энэ баганыг дөрвөн шон дээр тогтоож, доторх хоосон зайд нь хоёр зуун гишгүүр бүхий могой шиг шат дээш мурилзуулан хийжээ. Уран барилгач А.Пребиш баганыг босгохдоо түүний дээрээс нь хот руу харах биш түүнийг доороос нь тольдох санааг удирдлага болгожээ.

Багана босгосны дараа хотын нүүр царайг гутааж байгаа тухай бөөн маргаан дэгдэж хотын захиргаа түүнийг буулгах шийдвэр гаргаж бульдозер татан авчрав. Энэ үед 1939 оны зургаадугаар сард Засгийн газраас зарлиг гаргаж Баганыг ард түмний бахархал гэж үнэлж түүнийг буулгах ажлыг зогсоожээ.

Хотын хөгжимт драмын “Колон” театрын барилгыг босгоход уран барилгачид, барилгачид хамгийн шилдэг барилгын материалыг ашиглах тооцоо хийж Италиас алтархаг-шар гантиг, Венециэс олон өнгөт шигтгэмэл, Францаас шилэн хорго захиалан авчирч байв. Театрын барилгын хана, гантиган баганын алтадмал хээ угалз, баримлууд, тавилга, чимэглэл үзэгч бүрийн нүдийг баясгана. Театрын тайзнаа тоглогдсон бүх жүжгийн нийтдээ 80 мянган хувцсыг нандигнан хадгалж байна. Тус театрын тайзнаа тоглож байсан дэлхийн шилдэг жүжигчдийн биеийн хэмжээг мөн хадгалж байдаг болохоор театрын арын албаны уран гартнууд тэдэнд зориулж ямар ч хувцас оёход бэлэн байдаг.

Буэнос-Айресийг хөшөө, дурсгалын хот гэдэг нь үнэний хувьтай билээ. Байлдан дагуулагч, чөлөөлөгч, яруу найрагч, хөгжимчин, эрдэмтэн, уран зохиолын баатар, зүгээр л сайн хүмүүст зориулсан хөшөө, баримлыг тоолоод баршгүй. Өмнөд Америк тивд хилийн будлиан, төрийн эргэлт гэсэн орон нутгийн чанартай байлдаан болж байснаас биш томоохон дайн болж байгаагүй атал генералуудын дурсгалд зориулсан хөшөө олон байдаг нь хачирхалтай.

Сен-Мартиний талбайд уран барималч Ж.Даунас 1862 онд үндэсний баатар Хосе де Сан-Мартиний морь унасан баримлыг хүрлээр цугтаж урласныг тавин жилийн дараа уран барималч Г.Эберлейн илүү өндөр том тавцанд залжээ.

Энэхүү сүрлэг уран баримлын цогцолборыг урлагийн бүтээл төдийгүй испанийн эзэмшилд байсан орнуудын эрх чөлөөний төлөө тэмцлийн лавлах гэж үзэж болно. Улаан боржин тавцан дээрх морь унасан генералын баримлын эргэн тойронд “Аян дайнд мордов.”, “Тулалдаан”, “Ялалт”, “Ялагчид буцан ирэв.” гэсэн дөрвөн бүлэг баримлууд байна. Хөшөөний бэлд дэргэд нь том бүргэд шувуу суугаа дайны бурхан Марсын баримал байна. Баримлын тавцангийн гурван талд Сан-Лоренсо, Чабабуко, Майпугийн дэргэд болсон байлдаанд Сен-Мартиний байгуулсан гурван ялалтыг харуулсан товгор дүрсүүдийг сийлжээ.

Алдарт Бока дүүрэг хүрэх зам зуур сүүлчийн эзэмшигчийнх нь нэрээр нэрлэсэн Лесомийн гоёмсог цэцэрлэгт хүрээлэн тааралдана. Энэ цэцэрлэгт хүрээлэн дотор Өмнөд Америк тив рүү хийсэн хамгийн том аялан байлдах баг цэргийг удирдаж байсан испанийн байлдан дагуулагч Педро де Мендосад зориулсан баримал байна. Түүний ар нуруунд гараа өргөн зогсож байгаа улаан арьстны дүрсийг сийлсэн нь испаничуудыг талархалтай угтсан улаан арьстнуудын нөхөрсөг хандлагын илэрхийлэл гэж тайлбарладаг.

Чухамдаа Педро де Мендоса одоогийн Бока дүүрэг байгаа газар суурин байгуулах гэж бүтэлгүйтсэн ч 44 жилийн дараа мөн испанийн байлдан дагуулагч Хуан де Гарай Ла-Плата голын эрэг дээр, гэхдээ арай өөр газар суурин байгуулж чадсан нь яваандаа Буэнос-Айрес хот болон хувирчээ. Тиймд германы уран барималч Г.Эберлейн 1915 онд Хуан де Гарайд зориулсан хөшөө босгожээ.

Буэнос-Айрес хотод тус орны аж ахуй, улс төрийн эрх мэдэлд төвлөрч байгаад тус орны олон муж дургүйцэж “Буэнос-Айрес хот дуусаж байгаа тэр газар жинхэнэ Аргентин улс эхлэдэг.” гэж шүүмжилж нийслэл хотыг нүүлгэхийг шаардсаар байна.

## КУСКО

Алт гэдэг шидэт үг испаничуудыг Атлантын далайг гатлахад хүргэж эрэг дээр буусан цагаан арьстан хүн бүр түүний эрэл хайгуул болж байлаа. Шинэ Тивийн уугуул иргэд цагаан арьстнуудын алт гэсэн дийлдэшгүй шуналыг ойлгохгүй, толгой сэгсрэн гайхна. Тэр тухай испанийн байлдан дагуулагч Э.Кортесээс сониучирхан асуухад “Цагаан арьстнууд зүрхний өвчнөөр байнга өвддөг улс, зүрх эмчилэхэд ганцхан алт л хэрэг болдог.” гэж хэвнэг тайлбарлаж байв.



Улаан арьснууд бол алтанд шал өөрөөр хандана. Инкүүд алтыг Хаадыг нь төрүүлсэн гэж хүндэтгэн биширдэг Нарны бурхны ариун эд гэж үзэж алтыг Нарны бурхныг тайвшруулах увидастай гэж дээдэлж алтаар гоёлын зүйлс, баримал, хаадынхаа хаан суудлыг урладаг байжээ.

Испанийн байлдан дагуулагч Франсиско Писарро инкүүдийн удирдагч Атауальпуг олзлон баривчилахад цаадахь нь суллаж явуулсан тохиолдолд тасалгаа дүүрэн алт өгөхөө амлаж өлмий дээрээ өндийж хананд гараараа зуржээ. Эрх чөлөөтэй болох гэсэн хүний хоосон үг гэж тэнд байсан хүмүүс дургүйцэхэд Ф.Писарро түүний үгийг бодитой амлалт гэж ойлгожээ.

Өөрийг нь суллах зорилгоор ордон, сүм, нийтийн байшингуудаас бүх алтан сав суулга, гоёл чимэглэлийг авчрах тухай Атауальпугийн тушаал бүхий элчүүдийг Инкийн эзэнт гүрний бүх өнцөг булан бүрт тэр даруй явуулав. Куско хотоос шижир алт дүүрэн ачсан хэд хэдэн дамнуурга өргөсөөр авчрав. Дамнуурга бүрийг дөрвөн хүдэр чийрэг эр өргөн явна. Төдсөнгүй алт, мөнгөн эдлэл тасалгаанд пиг дүүрч Ф.Писарро агшин зуур европийн аль ч хаан, язгууртнаас илүү баян хүн болов.

Гэвч хүний шунал хязгааргүй болохоор испанчууд хэлсэн үгнээсээ буцаж Атауальпуг алж хэдэн сарын дараа эзэнт гүрний нийслэл болох Куско хотыг чиглэн хөдлөв. Куско хот дахь Кариканче буюу Нарны сүмийн дээд хөвөөг чулуунд шигтгэсэн алтаар чимэглэсэн байлаа. Тэрчилэн Нарны бурхны болон бусад бурхны (бүтээгч Виракочи, аянга салхины бурхан зэрэг) баримлууд, Инкүүдийг билэгдсэн алдарт том зээрэнцэгийг алтаар хийсэн байна. Сүмд алтаар хийсэн олон тооны хөгжмийн зэмсэг, мөн үнэт чулуугаар чимэглэсэн бөмбөрүүд байв.

Кариканче сүмтэй залгаа бас нэгэн гайхамшиг байсан нь “Кускогийн алтан цэцэрлэгт хүрээлэн” юм. Энэ цэцэрлэгт хүрээлэнд өсөж торниж цэцэглэж нисэж байсан бүхнийг алтаар урласан байсан тухай эртний домог бий. Алтан эрдэнэ шиш, алимны алтан модноос



алтан алим тасалж авч байгаа 24 улаан арьстан малчин, алтан мөчир дээр нь алтан зөгий сууж байгаа алтан мод, бут байна, үнэт чулуугаар нүдийг нь урласан алтан могой газраар мөлхөнө. Энэ цэцэрлэгт хүрээлэн нь хүний гараар бүтсэн ертөнцийн нэгэн гайхамшиг байжээ. Алтан цэцэрлэгт хүрээлэнгийн тухай тэр үеийн нэгэн бичигт дурдахдаа:

Тус вант улсын нутаг дэвсгэр дээр ургадаг хамгийн гоё мод, цэцэг, анхилам үнэртэй өвс ногоог цэцэрлэгт хүрээлэнд суулгажээ. Тэдгээрийн дийлэнхийг нь алт, мөнгөөр урлаж хамгийн сонирхолтой нь ганц нэг цэцэг, бут биш газраас дөнгөж цухуйж байгаа яргуйнаас авхуулаад бүтэн төгөл мод, бут хүртэл бүхнийг цогцоор нь байгуулсан нь үнэхээр гайхамшигтай.

Эрдэнэ шиш халиурсан талбайд очиход шилбийг нь мөнгөөр, буурцагийг нь алтаар урласан байна. Цэцэрлэгт хүрээлэнд молтогчин туулай, хулгана, гүрвэл, могой, эрвээхэй, зэрлэг муур, үнэг гээд алт, мөнгөөр хийсэн маш олон амьтан байна. Тэнд мөн дэрхийн нисэх гэж байгаа мэт санагдах шувууд, цэцгийн дэлбээ дээр найган ганхан байгаа шувууд ч байна. Алтаар урласан бор гөрөөс, буга согоо, шар ирвэсийг дөнгөж төрсний дараах байдлаар нь, бие гүйцсэн үеийнх нь байдлаар дүрсэлсэн нь сэтгэл булаана.

Уайн Капак Инкийн эзэнт гүрнийг захирч байсан XVI зуунд их хот Куско яг тийм байжээ. Уайн Капак бүх ордон, сүмийн ханыг алтаар доторлодог байсан төдийгүй нийслэлээ алтаар чимэглэхэд онцгой анхаарч байв. Хотын бүх байшингийн хаалгыг алтан гуугаар хийж мөн хас болон өнгөт гантигаар чимдэг байлаа.

Баяр ёслолын үеэр цэргийн жагсаал хийхдээ Инкийн эзэнт гүрний 50 мянган дайчид шижир алтаар хийсэн зэвсэг барьж алхдаг байжээ. Уайн Капак хааны тушаалаар хаан суудлыг алтаар урлаж тоть шувууны өдөөр бүрж Куско хотын төв талбайд хааны ордны өмнө байрлуулсан байна. Хаан мөн зарлиг гаргаж нийслэлийн төв талбайд шижир алтаар урласан 350 алхам урт (ойролцоогоор 250 метр) гинж хийж тавьсан нь хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн том гоёлын зүйл гэж тооцогдсоор байна. Хотын чимэг болсон хэдэн тонн хүнд алтан гинжийг шашны баяр ёслолын үед хоёр зуу орчим хүн өргөж тойрон бүжиг хийдэг байжээ.

Испанийн байлдан дагуулагч Франсиско де Перес “Перу улс, Куско хотыг байлдаан дагуулсан тухай дурсамж” номондоо ийн бичжээ:

Куско хотын ойролцоох нэгэн тосгонд шижир алтаар хийсэн хоёр байшин тэдгээр байшингийн дээврийг сүрлэн хэлбэртэй алтаар урласан тухай ярьцгаахыг бид чих дэлсэн. Куско хотоос алтан сүрэл авчрахад бид мэл гайхаж итгэж ядаж байлаа. Куско хотоос авчирсан алтан эд зүйлсийн тухай тоочин бичээд баршгүй билээ. Ганц жишээ дурдахад том алтан аяганд хийсэн цэвэр ус алтан хоолойгоор урсаж алтан усан санд цутгана, алтан усан сангийн эргэн тойронд янз бүрийн алтан шувууд болон усан сангийн уснаас алгаараа халбагадан ууж байгаа хүмүүсийн баримлуудыг цөмийг нь алтаар урласан байлаа.

Перу улсад испанийн байлдан дагуулагчдын тонон дээрэмдсэн асар их үнэт эрдэнэс нь инкүүдийн хуримтлуулсан үнэт зүйлсийн өчүүхэн хэсэг байсан ажээ. Перу улсыг испаничууд бүхэлд нь эзлэн түрэмгийлсний дараа Инкийн эзэнт гүрний хоёрдугаар Манко хаан Испанийн элчин сайдтай уулзаж, өмнө нь шилэн аяга дүүрэн эрдэнэ шишийн үр асгаж ганц

ширхэгийг нь авч элчинд үзүүлж “Энэ бол инкүүдээс та нарын залилж авсан алт!” гэж өгүүлээд үлдсэн эрдэнэ шишийн үрүүдийг зааж “Энэ бол бидэнд гарт үлдэж хоцорсон алт.” гэж шуналыг нь улам дэвэргэн хэлж байжээ.

Чухамдаа тэр үеэс тэр их алтны эрэл хайгуул эхэлж өнөө үеийг хүртэл үргэлжилсээр байна. Испаничуудын гарт ороогүй тэр их алт хаана байна вэ? Инкийн эзэнт гүрний хууль ёсоор жил бүр нийслэл хотдоо авчирч тушаадаг байсан тэр их “алтан ургац” хаана хадгалагдаж байна бэ? гэсэн асуулт өнөөдөр ч адал явдал сонирхогчдын төдийгүй эрдэмтдийн анхаарал шохоорхлыг татсаар байна. Түүхэн эх сурвалжаас үзвэл испаничууд дээр дурдсан алтан гинжийг булаан авч чадаагүй өнгөрчээ. Тэрчилэн Инкийн эзэнт гүрний хаадын хуримтлуулсан хувийн үнэт эрдэнэсийг мөн дээрэмдэж амжаагүй байна.

Инкүүд үнэт эрдэнэсээ домогт Пайтити хот байдаг тал хөндийд аваачиж нуусан байж магадгүй гэсэн таамаглалыг Оросын эрдэмтэн Ю.Зубрицкий дэвшүүлжээ.

Инкийн эзэнт гүрний Пачакутек хаан тал хөндий нутгийг эзлэн түрэмгийлэхээр шийдэж урьдчилан тагнуулын баг явуулжээ. Тагнуулын баг төдөлгүй буцан ирж алтны судалтай хэд хэдэн гол олсон тухай баярт мэдээ авчрав. Тэгээд Пачакутек хаан Куско хотоос алтны орд газар тийш зам тавьж тал хөндийн төвд хот байгуулах үүрэг өгсөн байжээ.

Шинэ хот дорхноо өнгө төрхөө олж нүдний өмнө цэцэглэн хөгжив. Тэгээд шуналтай байлдан дагуулагчид Куско хот руу дайлаар мордсоныг дуулаад инкүүдийн удирдагчдын шийдвэрээр хотын оршин суугч эрэгтэй эмэгтэй бүх хүн, өвгөд, хүүхдүүд Пайтити хот оршин байгаа тал хөндийд дүрвэн иржээ. Инкүүд ийнхүү дүрвэн явахдаа асар их үнэт эрдэнэсээ авч оджээ.

XX зууны эхээр хоёр залуу эр очихоос өмнө Пайтити хот ор тас мартагдсан байлаа. Тамлан зовоогч эзнээсээ зугтсан хоёр залуу дөрвөн хоног битүү шугуй дундуур явсаар тав дахь өдрөө халуун орны ургамал битүү ургасан барилга байгууламж олж харжээ. Тэд удалгүй мөхсөн хотод ирснээ ойлгож дундуур нь явж сонирхоход хаа сайгүй алтан эд зүйлс хөглөрөн байгааг хараад мэл гайхжээ. Хоёр залуу даах чинээгээр алтан эд зүйлс авч буцахаар шийдэж урт чулуун шатаар гартал нүүрэн талдаа Нарыг билэгдсэн алтан дугариг бүхий өндөр хаалганд тулж очжээ.

Тамлан зовоогч эзнийхээ гараас мултарч асар их баялагийн эзэн болсон хоёр залуу шуналаасаа болж хоорондоо муудалцаж амь өрссөн зодолдож нэг залуу нь л Куско хотод иржээ.

1925 онд тал хөндийд орших мөхсөн хотыг эрж олохоор 6 лам залуу шийдэж хөтөч ачигч хөлсөлж хоол ундаа базаан алсын замд гарчээ. Гэвч зам зуур улаан арьстнуудын дайралтад өртөж Санчес нэртэй ганц хөтөчөөс бусад нь нум суманд өртөн алагджээ. Хөтчө залуу ухаан жолоогүй зугтан гүйсээр сая нэг амьсгаа авахаар дороо зогсов. Тэгтэл хажууд нь хүнийг бодит хэмжээгээр урласан алтан баримал байгааг хараад нүдэндээ итгэсэнгүй. Тэрбээр алтан хүний хуруунаас чигчий хурууг нь тайрч хэд хоног явсаар тал хөндийг туулж Куско хотод ирсэн ч нууцлаг хотын тухай хэнд ч ам алдсангүй. Хэсэг хугацааны дараа эрдэмтэн Р.И.Ордоньестэй уулзаж өнөөх алтан чигчий хурууг үзүүлж мөхсөн Пайтити хот хаана байгааг зааж өгөхөө амлажээ. Гэвч гэнэт нас барж Перу улсын хязгааргүй уудам тал хөндийн

ХЭДЭН зуун жил нууцаа хадгалсан хэвээр байна.

## ТЕНОЧТИТЛАН

Мехико хотын баруун-өмнөд дүүрэг “пиедра” буюу “чулуу” гэсэн үгнээс гаралтай “Педрегаль” гэж нэрлэгдэнэ. Манай эрний өмнөх 1 мянган жилд Кситле галт уул дэлбэрч улаан арьстнуудын куиквилка омгийн соёлыг баллаж цагтаа хүчирхэг байсан ард түмний тухай домог л үлджээ. Галт уул дэлбэрэхэд айж мэгдсэн хүмүүс амиа аврахаар пирамид өөд мацан гарахад нэгэн мэргэч хэдэн зуун жилийн дараа энэ нутагт амьдрал дахин цэцэглэнэ гэж зөгнөн хэлсэн тухай домог байдаг.



Долоон зуун жилийн тэртээ ацтек омгийнхон хотын шав тавих тохиромжтой газар хайж Мексикийн уул нуруугаар хөндлөн гулд явж байлаа. Нэгэн удаа тэдний нүдний өмнө сэтгэл булаам сайхан хөндий тодорчээ. Хөндийн голд нуурын ус цалилцаж түүний дунд арал харагдана. Ацтекүүдийн удирдагч хоншоороо могой базан алж байгаа бүргэд олж харж сайн үйлс муу үйлийг ялахын билэгдэл гэж үзэж тэр газар хот байгуулах зарлиг буулгажээ. Могой алж байгаа бүргэдийг улс орны билэг тэмдэг болгож хожим нь бүргэд домгоос Мексик улсын төрийн далбаанд заларчээ.

Тескоко нуурын хоёр арал дээр 1325 онд байгуулсан Теночтитлан хотыг хөндий талтай гурван далангаар холбож олон тооны суваг, салаа голоор улаан арьстнууд каноэ, татлага завиар нааш цааш сүлжинэ. Хот усны дунд мэндэлж ус түүний төрөлх нутаг, тээврийн хэрэгсэл, зоригжуулан зохион байгуулагч, аюул занал нь болж байдаг. Аутсоль хааны хаанчлалын жилүүдэд хоолой татаж Койоаканы булгаас хотын цэвэр усны хэрэгцээг хангадаг болжээ. Гэвч энэ арга нь буруудаж усны урсгалыг нь дийлэхээ байснаас үер болж олон хүний амь нас эрсдэж ургац алджээ. Тэгээд далан барьж Тескоко нуурын шорвог усыг Сочимилко голын цэвэр уснаас тусгаарлажээ.

Нэг нэгэнтэй нь болон нуурын эрэгтэй далангаар холбосон арлууд дээр пирамид хэлбэрийн сүмүүд, сүрлэг том орднууд, цэргүүд худалдаачид гар урчуудын орон сууцууд дараалан босож нуураас тал бүр тийш сувгууд татаж нийслэл хот руу барилгын материал, хүнсний зүйл, цэцэг зэрэг бараа, эд зүйлс тээвэрлэн авчирдаг болжээ. Мехико хотын дагуул Сочимилко хотхонд венеци хийцийн сувгууд зөндөө, байгуулагдсан хугацааны хувьд ч урьд билээ. Хотын оршин суугчид зургаан зуун жилийн тэртээх үеийнх шигээ суваг, салаа голуудын эрэг дээр хүнсний ногоо, цэцэг ургуулж байгаа хийгээд энэ дагуул хот өнөөдөр жуулчдыг очдог хамгийн дуртай газар болжээ.

Сочимилко нь трахинерас буюу мексикийн гондол завиар хөвж байдаг сувгуудын дундах ногоон хонгил юм. Трахинерас завинд аливаа завинд байдаг шиг вандал сандал байхгүй, хоёр захаар нь хатуу тVIIIлэгтэй сандлууд, голд нь шар айраг, давсалсан загас, өргөст хэмх байна. Сочимилкогийн жижиг нууруудад замгийн дээрх хатуу гадаргууд ургасан ягаан, шар цэцгэн хэлхээ хоорондоо хэлхэлдэн хөвнө.

Мексик улсын нутаг дэвсгэр дээр Эрнан Кортесийн удирдсан испанийн байлдан дагуулагчид хөл тавихад Улаан арьстны хаан хоёрдугаар Монтесума испаничуудад үнэтэй бэлэг өгч эсэргүүцэн тэмцэхийг хүсэхгүй байгаагаар илэрхийлж байлаа. Гэвч 1520 онд Теночтитлан хотод бослого гарч Монтесума алагдаж испаничууд хотоос зугтан гарчээ. Мехико хотын захад “Тунигтай шөнийн мод” нэртэй дурсгал бий. Олон зуун жилийн настай тэр модны дор Латин Америк тивийг байлдан дагуулагч Э.Кортес одны цаг минь өнгөрлөө гэж харамсан уйлж байсан гэдэг. Гэвч улаан арьстнууд хоорондын маргалдааныг далимдуулан испаничууд ацтекүүдийн эсрэг шинэ эвсэл байгуулж Теночтитлан хотыг бүслэв.

Э.Кортесийн цэргүүд ер орчим хоног бүслэлт хийж бүх эрчүүдийг устгаж дуусгасны эцэст 1521 оны наймдугаар сард хотыг эзлэж хүчирхэг гүрний захирагч Куатемокийг баривчлан дүүжлэн цаазалжээ. Улаан арьстнуудын эх сурвалжид бичсэнээр Куатемокийн шарилыг хулгайлж Икскатеопан гэдэг газар ёслол төгөлдөр оршуулсан ажээ.

1971 онд Икскатеопанд судалгааны баг очиж Куатемок хааны амьдралын сүүлчийн өдрүүд, үхлийн тухай бүх материалыг судалж түүний шарил 1539 онд испаничуудын барьсан сүмийн дор байж магадгүй гэсэн дүгнэлтийг хийжээ. Эрдэмтэд малталт хийсээр сүмийн шүтээний дороос бараг арилах шахсан “Куатемок” гэсэн үг сийлсэн XVI зууны үеийн хавтан түүний дороос нэгэн эрэгтэй хүний шарил олж хүн судлалын шинжилгээгээр ацтекуудын домогт удирдагчийн шарил болохыг тогтоожээ.

Испаничууд Теночтитлан хотыг эзлэн авмагцаа улаан арьстнуудын сүм, ордонг эвдэн нурааж сувгуудыг шороо асган битүүлж жижигхэн нуурын усыг урсгаж хотыг газрын хөрстэй тэгшилсний дараа Шинэ Испанийн нийслэл Мехико хотын шавыг тавьжээ. Гэвч сувгуудыг үгүй хийснээр байнга үер болдог болж тэгээд үерийн урсгалыг холдуулж байх зорилгоор 6,6 километр урт суваг байгуулж хөндийгөөс үерийн усыг зайлуулж байх хоолой байгуулжээ. 1629 онд бүтэн хагас өдөр үргэлжилсэн ээлжит үерийн үеэр хэдэн мянган хүн амь насаа алдаж испаничууд нийслэлээ өөр газарт шилжүүлэхээр шийдэж гарах зарлагын тооцоо ч хийж байв.

Испанийн эрXIIIээлд гурван зуу гаруй жил байсан нь Мехико хотод гүн гүнзгий ул мөр үлдээжээ. Намхан, бараан өнгийн, зузаан ханатай, цонх, хаалганы дээрээ чулуун сийлбэртэй сүм дуган, хуарангийн маягийн ордон-цайзууд гээд өнөөгийн уран барилгын бүх дурсгал нь цөм тэр үеийнх ажээ. Мехико хотын уран барилгын шилдэг цогцолбор нь ховорхон хэрэглэдэг албан ёсны Үндсэн хуулийн талбай нэртэй ч Сокало гэдэг нэрээр алдаршсан хотын төв талбай юм. Тэгш дөрвөлжин хэлбэртэй бетондсон талбайны нэг талд Ерөнхийлөгчийн ордон, нөгөө талд сүм, гурав дахь талд хотын Захиргааны байр, дөрөв дэх талд эртний зочид буудлын маягаар барьсан “Сайхан сэтгэлийн уул” нэртэй барьцаалан зээлдүүлэх газар байна.

Мексикчүүд тусгаар тогтнолоо олж авсны дараа улс орныхоо эдийн засаг, улс төрийн хөгжлийн зам төдийгүй уран барилгын өвөрмөц дэгийг удтал эрэлхийлж байв. XIX зууны сүүлч, XX зууны эхээр уран барилгач П.Диас нийслэлээ хотоо “францжуулах” зорилго тавьж Чапультепек цэцэрлэгт хүрээлэн дэх довын орой дээр орших испанийн хаадын өргөөнөөс хотын төвд Шинэчлэлтийн өргөн чөлөөг Париж дахь Елисейн тал гудамж шиг өөрчилжээ. Өргөн чөлөөний дагуу хооронд нь тодорхой зайтайгаар Шинэчлэлтийн үеийн цэргийн болон улс төрийн зүтгэлтнүүдийн хүрэл баримлуудыг байрлуулжээ.

Тэрчилэн өндөр тавцан дээр улаан арьстны удирдагч Куатемокийн гартаа жад барьсан хөшөө, өргөн чөлөөний голд Мексик улсын гол дурсгал болох Тусгаар тогтнолын багана сүндэрлэн байна. Тусгаар тогтнолын баганыг арван жил барьж мексикийн ард түмний испанийн дарлалын эсрэг тэмцлийн 100 жилийн ойд бэлэг болгожээ. Хөрсөнд шон суулгаж босгосон баганын оройд Ялалтын баримал, суурийнх нь хананд үндэсний эцэг Мигель Идальгогийн гантиган товгор дүрсийг сийлжээ.

Мехико хөгжлийнхөө хэдэн зуун жилийн хугацаанд Тескоко нуураас хуурай газар хэсэг хэсгээр авсаар өнөөдөр хот нуурыг тал бүрээс нь шахан хавчсан мэт санагдана. Намгархаг хөрстэй болохоор хотод хэдхэн тооны тэнгэр баганадсан байшингуудыг эс тооцвол өндөр барилга барьдаггүй, тэгш нүүрэн талтай, голдуу л цэнхэр ногоон өнгийн хана бүхий гуравдөрвөн давхар байшингууд байна.

1928 онд Урлагийн ордон хэмээх гоёмсог байшин босгож түүнд Мексикийн Үндэсний драмын театр байрлуулжээ. Гэтэл байшин хориод жилийн хугацаанд доош 2 метр орчим сууж тэгээд байшинг барьсан талбайг гүнзгийрүүлж хэвийн байдалд нь оруулжээ. Тус хотод байшин барихдаа хөрсний усны урсгалыг урьдчилан сайтар тооцоолдог байна.

60 настай хөдөөгийн лам Мигель Идальго испаничуудын эсрэг тэмцэлд мексикийн ард түмнийг уриалан дуудсан есдүгээр сарын 15-ны өдрийг жил бүр Сокало талбайд сүрлэг баяр хийж тэмдэглэдэг. 1810 онд лам М.Идальго Долорес хотын жижигхэн сүмд хонх цохиж сүсэгтнүүдээ цуглуулж эх орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэлд босохыг уриалжээ. Хожим нь тэрхүү хонхыг Мехико хотод шилжүүлэн авчирч Үндэсний ордны гол тагт дээр байрлуулжээ. Жил бүрийн есдүгээр сарын 15-ны өдрийн 11 цагт Мексик улсын ерөнхийлөгч тагт дээр гарч хонх цохиж цугларсан олон түмэнд хандаж “Долоресийн уриа” болох М.Идальгогийн “Мексик орон, тусгаар тогтнол мандтугай!” гэсэн үгийг хэлдэг.

## ЛА-ПАС

Испаничууд Ла-Пас хотыг байгуулахдаа Альтиплано уулсын зүүн-хойд хотгорыг маш оновчтой сонгожээ. Энэхүү асар том аяганы амсар нь хотыг мөсөн малгайгаар хүрээлэгдсэн Андын нурууны чөмөг царцам хүйтэн салхинаас хамгаална. Альтиплано уулсын уур амьсгал нь өндөр уулын эх газрынх болохоор халуун хүйтний хэм огцом өөрчлөгдөнө, тиймд Ла-Пасын оршин суугчид зуны үдэш хүртэл углаа цамц дээр хүрэм давхарлан өмсөнө.



Далайн түвшнээс 3700 метрийн өндөрт байрлах хотод очоод аажим алхлахгүй бол агаар нь сийрэг тул ухаан алдаж болзошгүй. Боливийн нийслэлийн агаарт дасах шилдэг арга нь хөдөлгөөн алхаа, тэгээд хоёр-гурван хоногийн дараа чөлөөтэй алхаж болно.

Боливи улсын албан ёсны нийслэл нь Сукре хэмээх бяцхан хот ч Ла-Пасыг дэлхийн хамгийн өндөрт байрладаг нийслэл хот гэж тооцдог. Тус орны хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын байгууллагууд, парламентийн болон ерөнхийлөгчийн ордон, яамд бүгд тэнд байрлана, Сукре хотод Дээд шүүх л байрлана.

“Ла-Пас” гэсэн үг нь “энх амгалан” гэсэн утгатай. Үүнийг нь хотын сүлдэнд дээр нь хошуундаа чидун жимсний мөчир зуусан тагтаа суусан дуулганы дор Иллимани уул, эрэг дээр нь бие биенээ тайвуун харж байгаа арслан, хонь хоёрыг дүрсэлсэн нь гэрчилнэ. Сүлд дээр “Маргааныг зөвшилцөж энх амгалан, хайраар үүрд нэгдэхийн төлөө хот босгов!” гэсэн үг байдаг. Энэ үгсийг испаничууд Чуки-Апу тосгоны улаан арьстан иргэдтэй найрамдаж нөхөрлөсний дурсгалд зориулж биш харин олзоо хуваахдаа маргалдсан испанийн хоёр байлдан дагуулагч эвлэрсний билэг тэмдэг болгон 1548 онд хэлжээ.

Боливи улсын түүх нь алт, мөнгөний олборлолттой холбоотой байсан ч нөөц нь дууссанаас XIX зууны сүүлчээс мөнгийг дагалддаг цагаан тугалга олборлож эхэлсэн ч яваандаа нөөц нь бас барагдав. Тэртээ тэргүй дэлхийн хамгийн ядуу орнуудын нэг гэж тооцогдож байсан Боливи улс цаашид яаж амьжиргаагаа залгуулахаа мэдэхгүй мухардалд орж байв. Тус орон харьцангуй богино түүхэн хугацаандаа эдийн засгийн хямралыг хэдэнтээ амсаж хатуу хүтүү амьдралыг ханатлаа туулсан билээ. Тэдгээр хямралт үйл явдлын гэрч болох олон дурсгалт зүйл Ла-Пас хотод бий.

Тийм нэгэн дурсгалт гэрчийн нэг нь хэний ч анхаарлыг татахааргүй гурван давхар

Ерөнхийлөгчийн ордон юм. Алонсо де Мендоса улаан арьстны Чуки-Апу суурины буурин дээр хот байгуулахаар шийдэж гол талбайд нь Захирагчийн ордон, шоронгийн зориулалттай байшин бариулжээ. Харамсалтай нь Тиауанако тосгоны ташуурын дор ажиллаж үзээгүй улаан арьстнууд Ерөнхийлөгчийн ордонг барихдаа хараал тавьснаас энэ ордонд муу ёр шүгэлсэн юм гэж Ла-Пас хотын иргэд ярьцгаадаг ажээ.

Ерөнхийлөгчийн ордонд олон жилийн турш Захирагчийн танхим, шорон, морин цэргийн хорооны хуаран, шар айрагны газар тэр ч бүү хэл эмсийн хүрээлэн байрлаж байлаа. Ордны “намтар” дахь анхны цуст үйл явдал 1661 оны 12 дугаар сард болсон билээ. Шөнө дунд ордонд зэвсэглэсэн эрлийзүүд “Олхиогүй захирагчид сөнөтүгэй!” гэж хашгиран дайран орж Испанийн хааны бие төлөөлөгч, амбан захирагч Крестобаль де Коньедог жадлан цааш харуулжээ.

Төвийн болон орон нутгийн засаг захиргааны татварын дарамтад ядуурч туйлдсан улаан арьстнууд 1781 онд Тупак Катарийн удирдлагаар бослого гаргаж бөөн хэрэг өдөөж байсныг Ерөнхийлөгчийн ордны өмнөх талбай санаж байдаг. 1875 онд засаг захиргааны үйл ажиллагаанд дургүйцсэн иргэд хотод цэргийн анги байхгүй байгааг далимдуулан газрын тосонд норгосон даавуу ордон руу шидэж түймэрдсэний дараа ордонг “Паласио Кемадо” буюу “Шатсан ордон” гэж зэвүүцэн нэрлэх болжээ.

Испанийн ноёрхлын эсрэг тэмцлийг зохион байгуулагч Педро Доминго Мурильогийн дурсгалд зориулан байгуулсан Мурильогийн нэрэмжит талбайг Ла-Пас хотын түүхэн төв гэж тооцно. 1952 оны хувьсгалаас өмнө улаан арьстнууд явахыг хориглодог байсан Ерөнхийлөгчийн өмнөх талбайд өнөөдөр оюутнууд, улс төрчид, худалдаачин, гадаадын жуулчид гээд хүмүүс өдөр бүр пиг дүүрэн байна.

Ла-Пас хот цайз бүхий довыг тойрон хүрээгээ тэлсээр байна. Хотын төв Альтиплано хонхорын ёроолд амсараасаа 40 метр дор оршино. Тэртээ дээр уулын налуугаар харагдах гудамжууд нь өгсүүр шаг мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Ла-Пас хотоор явахад хуучны уур амьсгал хаа сайгүй мэдрэгдэнэ. Испанийн эзлэн түрэмгийлэгчдийн үед барьсан улаан ч он цагийн уртад харласан вааран дээвэртэй, хананд нь жижигхэн төмөр тагт наалдуулан барьсан намхан байшингууд байна.

Эртний улаан арьстнуудын тэнгэрлэг шүтээн болох Иллимани уулын цасан цагаан оргил тал бүрээс нь харагдах уулын дунд Ла-Пас оршино. Эндхийн ууланд мод, өвс ургадаггүй болохоор хад асга овоолон барьсан мэт аймаар сэтгэгдэл төрмөөр ч цэгмэг цэнхэр тэнгэр, нарны хурц туяа тийм бодлыг зөөлрүүлнэ.

Ла-Пас нь аль ч зүгт алхсан уул харагдах хосгүй сайхан хот юм. Уулын оройд орших Гэгээн Франсискийн сүм рүү нарийхан гудамж хөтлөдөг болохоор хөнгөн тэрэг багтахгүй, явган алхсан нь дээр. Тэнд суудаг “эм тантай суурин” гэсэн утгатай кальяуайха омгийн улаан арьстан эмч домч, мэргэч төлөгч нартай “уулзаж” өвчнөө илааршуулж амьдрал байдлаа цэгцлэх гэсэн баян ноёд, хатагтай нар, эмнэлэгт хэвтэх мөнгөгүй ядуучууд, дурлалдаа шатсан залуус, хардаж зовсон эмэгтэйчүүд цувна.



Инкийн эзэнт гүрний үеэс Өмнөд Америк даяар цууд гарсан кальяуайха омгийн эмч домч, мэргэч төлөгч нар Титикака нуурын зүүн-хойд нутгаар орших төрөлх тосгодоосоо нуруундаа элдэв эм тан дүүргэсэн шуудай үүрч алсын замд гарч хэдэн жилээр хэсүүчлэн явна. Тэд Гэгээн Францискийн сүмд ирж гадаа нь лангуу дээр элдэв эм бүхий шилэн төмөр сав, төрөл бүрийн өнгийн шавар, төрөл бүрийн өвс тавьж наймаална.

## ВАЛЕТТА

Газрын дундад тэнгисийн усан замуудын зөрлөг дээр байрладаг Мальта арал эрт дээр үеэс түрэмгийлэгчдийн анхаарлыг татаж байжээ. Финикичүүд, карфагенчүүд, ромчууд, византичүүд, Сицилид ноёрхож байсан норманнчууд, Хойд Африкийн арабууд бүгд түүхийн янз бүрийн үе шатанд Мальтын арал дээр амьдран сууж түүний түүх, уран барилгад ул мөрөө үлдээжээ.



Мальтчууд төрөлх газар нутгаа бүлэг арал гэдэг хийгээд Мальта нь хамгийн том Мальта арал, арай бага Гозо, Комино арлууд тэрчилэн хүн суудаггүй гурван хадан арлаас бүрдэнэ. 320 хавтгай дөрвөлжин километр талбай бүхий бүлэг арал дээр 350 мянган хүн оршин сууна.

Өнгөрсөн түүхийг нь байлдан дагуулагчид байрлаж байсан үйл явдалтай холбон үзэхэд мальтчууд дургүйцэж бидний түүх дундад зууны үед биш түүнээс бүр өмнө хэдэн мянган жилийн тэртээ эхлэсэн, манай мегалитийн сүмүүд египетийн пирамидаас ахмад настай гэж зүтгэдэг. Мальта арлын түүхэнд анхны баримтат ул мөрийг финикичүүд гурван мянгаад жилийн тэртээ үлдээж дараа нь грекүүд арлыг “Мелита” гэж нэр өгсөн нь “Балын арал” гэсэн утгатай байв. Үнэндээ ч Мальта арал нь зөгийн балаар төдийгүй хурц үгтэй лус савдгаараа алдартай юм. Одиссейг долоон жил зовоосон лусын охин Калипсо чухамдаа Мальта арал дээр амьдарч байсан тухай домог бий. Мальта гэдэг нь финикиний “малет” буюу “усан боомт, хамгаалагдсан газар” гэсэн үгнээс үүсэлтэй гэсэн таамаглал бас бий.

Грекийн цэргүүдийг бут ниргэсэн карфагенчүүд ромчуудад дийлдэж дараа нь Ромын эзэнт гүрэн нуран унасны дараа Мальта арлыг византичууд захиргаандаа авсныг арабчууд зайлуулжээ. Хожим нь арал дээр загалмайтнууд буудаллажээ.

Родос арлаас туркүүдэд хөөгдсөн Гэгээн Иоанны нөхөрлөлийн рыцарууд долоон жилийн турш орох орон эрж яахаа мэдэхгүй зүдэрч байхад Ромын VII Климент тэргүүн хамба лам тус болж Испанийн V Карл хааныг ятгаж зөвшөөрүүлсний ачаар тэд 1530 онд Мальта аралд сууршихаар иржээ. Мальт, Гозо, Комино арлыг сайн дураар олгосонд талархаж рыцарууд V Карл хаанд нэг ширхэг ангийн шонхор шувуу илгээжээ.

Иерусалим хотын Загалмайлагч Иоанны “Сакра Инфермерия” цэргийн эмнэлгээс нэрээ авсан нөхөрлөл тэр үед 400 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байв. Гэгээн Иоанны

нөхөрлөл загалмайтны аян дайны үед цэрэг-шашны байгууллага болон хувирч улаан дэлгэц дэх цагаан хэрээсийг билэг тэмдгээ болгосон юм. Хэрээсийн дөрвөн үзүүр нь христос шашны даруу, туйлбартай байх, эр зориг, шудрага ёс гэсэн сайн үйлсийг билэгдэнэ. Мальтийн хэрээсний найман булан нь Иисус Христосын номлол ёсоор аз жаргалд хүрэх найман зам тэрчилэн рыцаруудын олон улсын нөхөрлөлд багтсан бүс нутгуудыг билэгдэнэ.

Рыцарууд Мальта арал дээр сууршимагц хамгаалалтын асуудалд онцгой анхаарч эрэг дагуу харуулын цамхагууд босгож харуулууд гаргаж арлын оршин суугчдыг далайн дээрэмчдээс найдвартай өмгөөлдөг болжээ. Рыцарууд ирснээр туркийн, далайн дээрэмчдийн ганц ч усан онгоц Мальта, Сицили арлуудын хоорондох усан орон зайгаар нэвтэрч чадахаа больжээ.

Бяцхан Мальта христос шашны түшиг тулгуур болсонд нөхөрлөлийн Их Магистр Жан Паризо де ла Валлетт их санаа зовж туркүүд гарцаагүй довтолно гэж айж байв. 200 усан онгоц хөлөглөсөн туркийн 40 мянган цэрэг 1565 оны тавдугаар сарын 18-ны өдөр 600 орчим рыцарь, 7 мянган сайн дурынхны эсрэг довтолж Сент-Эльмо цайзыг таван өдрийн дотор эзлэж Мальта арлыг эзэгнэх зорилго тавьжээ. Гэвч 52 рыцарь, 500 цэрэг хамгаалсан цайзыг бүтэн сар байлдаж эзлэж байжээ.

Туркүүд хоёр дахь цайз Сент-Анжело руу дайрч тэнгисийн булангийн тунгалаг цэнхэр ус цусанд булингартаж хэдэн зуун үхдэл усанд хөвж байсан ч мальтчууд эрэлхэг зоригтой тулалдаж түркүүд аргагүйд тулж буцжээ. Тэгээд Их Магистр Ла Валлетт хожим нь өөрийнх нь нэрээр нэрлэгдсэн шинэ хот байгуулах ажилд оржээ.

Бүслэлтийн хэцүү хүтүүг ойлгосон рыцарууд шинэ хот байгуулах газрыг сонгохдоо цэргийн урлагийн бүхий л шаардлагыг удирдлага болгож гүнзгий устай байгалийн хоёр усан боомтын дунд орших эль хуль Скиберрас хошууг илүүд үзэв. Туркүүдийг үлдэн хөөснөөс хагас жилийн дараа 1566 онд шинэ хотыг шавыг тавьж их буюгаар ёслолын буудлага хийжээ.

Ромын IV Пий тэргүүн хамба лам шинэ хот байгуулах тухай Их Магистрийн шийдвэрийг сайшааж Мальта арал руу их Микеланжелогийн шавь, цэргийн инженер, уран барилгач Ф.Лапареллийг илгээв. Италийн инженер нөхөрлөлийн уран барилгачидтай хамтран ирээдүйн хотын хамгаалалтын байгууламжийн нарийн төлөвлөгөө, гудамж талбайн зургийг гаргажээ.

Валлетта хотыг ийнхүү урьдчилан боловсруулсан зургаар барьсан тул европийн бусад эртний хоттой харьцуулахад нь гудамжууд гайхам тэгш, бүх барилга байгууламжийг шохойн чулуугаар барьжээ. Нутгийн язгууртнууд, шашны удирдлага, чинээлэг иргэд цөмөөрөө хотыг байгуулахад идэвхтэй оролцов.

Хотыг босгоход 80 мянга гаруй сицилийн иргэд, олзны боолчуудыг дайчлан оролцуулж нас өндөр гарсан Их Магистр ажлын явцыг өдөр бүр очиж биечлэн шалгаж хянадаг байв. Тэрбээр жижиг сүм, хэд хэдэн цайз баригдаж дуусахыг хараад нүд анижээ. Дараагийн Их Магистр Пьетро дель Монте түүний үйлсийг үргэлжлүүлж хотыг барьж дуусгажээ. 1571 оны гуравдугаар сарын 15-ны өдөр хот барьж дууссан явдалд зориулсан ёслол мөргөл хийж Их Магистр өргөөгөө барих газрыг сонгожээ.

Валлетта хот хөгжин цэцэглэж ялангуяа урлаг, шинжлэх ухааныг бишрэн дээдэлдэг байв. Тухайлбал Мальтын нөхөрлөлийн номын сан 900 мянга гаруй ном, ховор гар бичмэлүүдээрээ дэлхийн томоохон номын сангуудын нэг болон алдаршиж байв. Харамсалтай нь Францийн арми Мальтын арлыг эзлэсний дараа Наполеоны тушаалаар номын санг усан онгоцоор тээвэрлэж явтал усан онгоц гэнэт живж номын сан сүйджээ.

Өнөөдөр Их Магиструудын ордон, Гэгээн Иоанны сүм Валлетта хотын голт зүрх болж байна. Лам рыцарийн даруу хувцастай адилхан гадна төрх нь энгийн байдалтай сүмийг 1578 онд барьж дуусгажээ. Тагт дээр гарч доош харахад сүмийн шал болох нөхөрлөлийн алдарт зүтгэлтнүүдийн шарилын хавтангууд мөр мөрөө тVШин сүүлчийн тулалдаанд жагссан дайчид шиг харагдана. Сүмийн тахилын дор Нөхөрлөлийн Их Магиструудын бунхан байна.

Өнөөгийн Валлетта хот рыцарийн үеэс бараг өөрчлөгдсөнгүй, үнэхээр үлгэрийн сайхан хот билээ. Нарийхан гудамжууд нь огцом дээш өгсөж доош уруудна. Олон давхар байшин байхгүй ч уран барилгын хийцээрээ хоорондоо өрсөлдөх мэт шилтгээн, сүм дэндүү олон.

## БОМБЕЙ

Жаргаж байгаа нар Арабын тэнгисийн мандал дээр тогтох үеэс Малабирин дов дээр орших Бомбей хотод хөл хөдөлгөөн ихтэй, шуугиантай байдаг. Довын зах руу дөхөн очиход хотын төв хэсэг гарын алга дээр байгаа юм шиг тод харагдана. Тэнгисийн эргийн Чоупатти цэцэрлэгт хүрээлэнгээс тус хотын хамгийн өмнөд хэсэг хүртэл “хааны сондор” хэмээх Нетажи-Субхазроуд гудамж үргэлжилнэ. Тэндээс зүүн тийш харц сунгахад “Энэтхэгийн Голливуд” кино студийн хороолол, цаана нь усан боомтын өргөгч цамхагуудын дүрсүүд сүүмийн харагдана.



Бомбей нь азийн томоохон усан боомт гэдгээрээ цуутай ч түүний гуншин олон. “Энэтхэгийн хоёр дахь нийслэл”, “Тэрбумтангуудын хот”, Жижигхэн Энэтхэг” гэж бас нэрлэнэ. Энэтхэгийн хотууд өвөрмөц олон өнгө төрхтэй, өрнөдийн хотуудтай адилгүй, гудамж дагуу олон тооны мухлаг, цайны газар байна, унадаг дугуй машинуудын хоорондуур аажуу тайвуу сүлжин хөлхөлдөх үнээ гээд гудамжны шал өөр амьдрал ноёрхоно. Гэхдээ Бомбей гадаад төрх байлаараа европийн хотуудтай адилхан.

Борчуул суудаг хорооллуудад нь долоо хүртэлх давхартай ч намхан гэж тооцогдох байшингууд байна. Дорны хэв хийц, хэлбэрээр босгосон байшингууд нь үнэхээр гайхалтай гэж уран барилгачид уулга алддаг билээ. Энэтхэг эрт дээр үеэс том барилга байгууламжийг чулуугаар барьдаг, энэтхэгийн уран барилгын өвөрмөц дэгийг араб хийцтэй хослуулдаг уламжлалыг Бомбейн уран барилгачид бүтээлдээ оновчтой үргэлжлүүлж онгодоо хөглөдөг байжээ. Иймд тус хотын орон сууцны байшингууд нь сүлжээсэн хөвөөгөөр чимсэн мэт нүд сэргэм сайхан харагддаг юм. Тагт, саравчит тагтанд модон самбар, олбогоор хаалт хийсэн байдаг. Энд халууныг биш сэрүүнийг хадгалахыг эрмэлздэг билээ.

Энэтхэгийн модон сийлбэрийн урлагийн гайхамшигийг чухамдаа энэ хотод харж болно. Тус хотод хэмжээний хувьд бага ч гоё хээнцэр өөр барилга байгууламж бас бий. Арслан, барын амнаас ус олгойдож байгаа, залуу бүсгүйн гартаа барьсан домбоноос ус гоожиж байгаа, Ассирийн, Египетийн далавчит бурхад, үлгэрийн жононгуудын баримал гээд тоймгүй олон усан оргилуур байдаг ч ав адилхан нь ганц ч байхгүй ажээ. Усан оргилуурыг барихдаа амьдралын эх булаг болох усыг дээдлэхийн зэрэгцээ усан оргилуураас ус ууж цангаагаа тайлж хиртэй цамцаа угаагаачихаад дэргэд нь хажуулж шөнийн нойроо авдаг ядуучуулын тав тухыг мөн бодолцсон байна.

Бомбейчүүд үдшийн цагаар Малабарын дов дээрх “унжмал цэцэрлэгт хүрээлэн” дотор цэцэрлэгч-уран барилгачдын уран сэтгэмж, нөр их зүтгэлээр бүтсэн цоморлиг цэцэгтэй ваар, заан, дугуйны хэлбэртэй цэцгэн мандал, бут дотор зугаацан сэтгэлээ сэргээнэ. “Унжмал цэцэрлэгт хүрээлэн” дотор хотын хүүхдүүдийн хайрыг булаасан дээвэр, дотор нь шаттай тагттай, хажуу хананд нь цоолон гаргасан хаалгатай “Шаахай” хэмээх гайхам байгууламж бий.

Бомбей хотын гадаад төрх байдал, дэг хийц, нийгмийн эрс тэс ялгаатай байдал нь өрнөдийн соёл иргэншлийн нөлөө энэтхэгийн бусад хоттой харьцуулахад илүү их туссаныг нотолно. Энэ хотод маратхам, гужарат, кашмир, тамил, пенжаб гээд олон үндэстэн ястны иргэд оршин сууна. Индус, жайнист, синкх, лалын зэрэг олон шашны сүм дуган, бунхан, шүтээн, мавзолей Бомбей хотын европжсон дүр төрх дотор их содон харагдана.

Гал шүтэгчид гэж голдуу нэрлэдэг зороастризмын шашныг бишрэн шүтэгчид болох парсуудын 2500 жилийн өмнө барьсан өвөрмөц байгууламж хотын оршин суугчид болон гадаадын зочдын анхаарал шохоорхлыг гойд их татдаг ажээ.

Арабууд газар нутгийг нь эзлэн түрэмгийлэхэд парсууд Иранаас Энэтхэгт дүрвэн ирж амьдрахдаа гар урлал, хүнсний ногоо тарих, гудамж талбайг цэцэрлэгжүүлэх арвин туршлага, ур чадвараа гаргаж анхлан сууршисан Гуджарит мужийг улам хөгжүүлж өнгө төрхийг нь засжээ.

Зороастризмын шашныг шүтэгчид нь ус, гал, газар, агаарыг ертөнцийн дөрвөн ариун шүтээн гэж биширдэг учир тэдний оршуулгын зан үйл нь их сонин, нас барсан хүний биеийг ариун бус гэж бишүүрхдэг тул ариун гэж дээдэлдэг галд шатааж, усанд тавьж газарт булж оршуулахгүй европийн уран зохиолд “нам гүмийн цамхаг” гэж нэрлэсэн “дагма” хэмээх тусгай байгууламж дотор тавьдаг ажээ.

Дагма нь дээд талд нь байгаа талбай руу нь гаднах шатаар өгсөж очдог намхан цамхаг юм. Дээд талбайд голд нь гаргасан гүн худгийг тойруулан гурван гүн биш хонхорхой байна. Өөд болсон хүний цогцсыг уг хонхорхойд тавихад тас шувуу нисэн ирж махыг нь тастчин идсэний дараа үлдсэн яс нь тусгай ховилоор өнхрөн худаг руу ойчиж цаг хугацааны уртад уусан алга болно.

Парсууд сүмд үргэлж асаастай байдаг ариун галыг зандан модны саваа нэмж унтраалгүй байлгаж чаддаг байна.

Парсууд тооны хувьд Бомбей хотын нийт оршин суугчдын дотор харьцангуй цөөхөн ч улс төр, соёлын амьдралд ихээхэн нөлөө үзүүлдэг байна. Тэдний дотроос алдарт физикч Хоми Жехангир Бхабха, жүжгийн зохиолч найруулагч Ади Морбзан гэх зэрэг цуутай хүмүүс төржээ.

## РИО-ДЕ-ЖАНЕЙРО

XVI зууны эхээр өнөөгийн Бразил улсын эрэг дээр Гонсало Коэльогийн удирдсан португалын эзлэн түрэмгийлэгчид буудаллаж европ тив рүү тухайн орны нэр үүссэн “бразил” хэмээх үнэт модыг зөөж гарчээ. Рио-де-Жанейро гэсэн үг нь “Нэгдүгээр сарын гол” гэсэн утгатай хийгээд португальчууд Гуанараб усан боомт руу орох газрыг том голын адаг гэж харсан учир тэгж нэрлэжээ. Угтаа бол тэнд ямар ч гол байхгүй ажээ.



Португалийн иргэн Эстасис Сан-Себастьяна-де-Рио-де-Жанейрог байгуулсны билэг тэмдэг болгож 1565 онд тэнгисийн булангийн эрэг дээр чулуун баганат хөшөө босгосныг хот байгуулагдсан он гэж үздэг. Хожим нь “Элсэн чихрийн толгой”, “Нохойны хошуу” гэсэн нэртэй хоёр боржин хадны хооронд бяцхан цайз, сүм, сүрлэн дээвэртэй жижигхэн байшин босгосон байв. Дараа үеэс нь байшин байгууламжийг цагаан чулуугаар барьдаг болсон бөгөөд Рио хотын оршин суугчид тэдгээр барилгуудыг улаан арьснуудын “кариоки” гэдэг үгээр “цагаан байшин” гэж нэрлэнэ.

Португалчууд эндхийн усан боомтын ашигтай байрлалыг анх өндөр үнэлж байсан бол бразилчууд байгалийн энэхүү гайхамшигт бүтээлийг давтагдашгүй сайхан хот байгуулахдаа үндэс болгожээ.

Рио-де-Жанейро бол ер бусын сайхан хот билээ. Кобакабаны алтан элсэн эрэг рүү хойд талаас нь халуун орны ой битүү бүрхсэн уулын эгц налуу түрэн орж иржээ. Өмнө зүгээс нь далайн цэнхэр алс сэрүү татаж эрэг дагуу тэнгэр баганадсан байшингууд ярайна. Хажуу гудамжуудад нь эртний шилтгээн, ордон үзэгдэнэ. Сиймхийтэй ширмэн сараалжин хашааны дотор халуун орны нов ногоон ургамлууд харагдаж мянга нэгэн шөнийн үлгэр амилах гэж байгаа мэт сэтгэгдэл төрнө.

Рио хотын унаган иргэнтэй яриа өдөхөд таван минутын дараа гэхэд таныг газар дээрх хамгийн гоё хот “сидаде маравилльо́за”-д ирсэнд баяр хүргэж Бурхан манай дэлхийг бүтээхэд нийтдээ долоо хоног зарцуулснаас таван хоногийг нь Рио хотод зориулсныг бахархан хүүрнэнэ.

Бразил улсын анхны нийслэл нь Сальвадор хот байсан ч XVIII зуунд “Алтны хийрхэл”-ийн үед Рио хотын нэр хүнд суга дээшилж нийслэл хотын алдрыг булаан авчээ. Он жилүүд өнгөрч түүнтэй өрсөлдөгч хот бий болов. XIX зууны сүүлчээр “кофений хийрхэл”-ийн үед Сан-Паулу хот өргөжин тэлж 1890 онд 65 мянган оршин суугчтай байсан бол хагас зуун жилийн

дараа 2,5 сая оршин суугчтай болж Рио хотыг халз тулаан дууджээ. Ууланд тулсан Рио цаашид өргөжихгүй, нийслэлийг нутаг дэвсгэрийн гүн рүү шилжүүлэх нь бусад бүс нутгийн хөгжилд түлхэц өгнө гэх зэрэг үндэслэлийг Сан-Паулу хотынхон дэвшүүлэн гаргав.

Гэвч Рио нийслэл хэвээр үлжээ. 1711 онд францийн генерал Р.Д.Труиний удирдсан цэрэг Рио хотыг байлдан эзлэхэд бразилчууд тэр үеийн үнэлгээгээр маш их мөнгө болох 1000 крузейро буюу хойр зуун хайрцаг элсэн чихрийн үнэ өгч нийслэлээ буцаан авчээ.

XVIII зууны сүүлчээр Луис Васконселос-и-Соус гэдэг хүн Бразил улсын дэд ерөнхийлөгчөөр томилогдсоныхоо дараа Рио хотын хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж усан хоолой тавьж төрийн захиргааны байгууллагуудын олон сайхан барилга босгожээ. Португалийн хааны ордон Наполеоны дайралтаас дүрвэж Рио-де-Жанейро хотод нүүн ирж том эзэнт гүрнийг захирч байлаа. Энэ үед хэд хэдэн даринь үйлдвэр баригдаж Тэнгисийн цэргийн сургууль нээгдэж Ботаникийн цэцэрлэг, Үндэсний номын сан, Уран сайхны академи байгуулагджээ.

1821 онд Португалийн хаан эх орондоо буцаж Бразилийн амбан захирагчаар ханхүү Педруг томилжээ. Гэтэл португалийн язгууртны ханхүү Бразилд үлдсэнд дургүйцэж түүнийг татан ирүүлэхийг хаанаасаа шаардаж байв. Энэ үед Латин Америк даяар эрх чөлөөний төлөө хөдөлгөөн өрнөж ханхүү Педру 1822 оны есдүгээр сард Бразил улсын тусгаар тогтнолыг тунхаглан зарлажээ. Педру хаанаар өргөмжлөгдөж тусгаар тогтнолыг тунхагласан өдрийг үндэсний баяр болгон зарлажээ.

Рио-де-Жанейро хотын билэг тэмдэг нь Аврагч Христосын аврага хөшөө билээ. Бразил улс тусгаар тогтнолынхоо 100 жилийн ойг тэмдэглэж байсан 1922 онд тийм хөшөө босгох санал гарч уран барималчдын дунд зарласан уралдаанд Эктор да Силва Костын төсөл шалгарчээ. Дор нь оршин буй Рио хотыг гараа алдан дэлгэн тэвэрч байгаа Христос бурхны хөшөөг 704 метр өндөр Корковадо довын орой дээр байгуулахад сүм хийдийн уриалгаар тус улсын бүх иргэн, пүүс компани хандив өргөжээ.

Рио хот анхандаа уулсаар хүрээлэгдэж байсан бол одоо хот уулсыг тойрон оршиж, гудамжууд уул дундуур тавьсан хоолойгоор хоорондоо холбогдоно. Хотын гол чимэг нь Копакабаны элсэн жалгай билээ. Урьд нь далдуу модны төгөл битүү бүрхсэн байсан элсэн довууд одоо ногоон зүлгэнд умбасан тансаг шилтгээн, ордноор дүүрчээ. Энэхүү алдарт жалгай нь 6 километр урт нарийхан элсэн зураас ажээ. Түүнийг нэг талаас давалгаа нь хэмнэлтэй нүдэх тэнгис, нөгөө талаас нь хөнгөн тэрэгний хөдөлгөөн үл тасрах засмал зам тулжээ.

Копакабаны элсэн жалгай Рио-де-Жанейро хотын зарим иргэний хувьд амралт зугаалгын газар, зарим иргэний хувьд ажлын байр нь ажээ. Олбог, нүдний шил, жимс, мөхөөлдөс, ундаа зарж буй хүмүүс хаа сайгүй хөлхөлдөнө.

Рио хотын тухай бичихдээ жил бүрийн хоёрдугаар сарын дундуур болдог багт наадмын тухай өгүүлэхгүй байж хэрхэвч таарахгүй. Хот таван өдрийн хугацаанд багт наадмын талбар болон хувирч бүх банк, албан байгууллага, дэлгүүр, хэвлэх үйлдвэр хаагдаж хэн ч улс төрийн тухай яриа хүүрнэхгүй, гудамж талбай цэвэрлэхгүй, шаахайгаа ч арчиж цэвэрлэхгүй.

Хаа сайгүй гэрлэн чимэглэл цацарч бразильчууд хөгшин залуугүй бултаараа гудамж талбайд



пиг дүүрч цоглог аялгуунд жавхаалаг самба бүжгээ хийж хөгжилдөн зугаацна. Тэд бөмбөрөө нүдэж самбо бүжгээ хийсээр хотын гол гудамжаар жагсан явна. Бүтэн жил өмсөх хувцас, дууны үг, бүжгийн аялгуу, хөдөлгөөнөө нууцлан хадгалж байсан “самба бүжгийн сургуулиудын жагсаал” бразильчууд төдийгүй гадаадын зочид, жуулчдын анхаарлыг гойд татна. Самба бүжгийн тэмцээнд түрүүлэгчид үндэсний баатрууд болон мандан алдаршина.

## МАНИЛА

1564 онд Мексикийн Ауденсия боомтоос гарсан Мигель Лопес де Легаспийн удирдсан багийн зорилго, эрхэм тэмүүлэл нь алс газар орших арал олж суурших явдал байлаа. Л. Де Легаспи Панайд суурин байгуулсны дараа 1570 оны тавдугаар сард туслахаа Лусон арал руу илгээж жилийн дараа тэнд тэнгисийн усан онгоцны зогсоолын эрэг дээр испанийн конкистадоруудын штаб байрлуулжээ. Манила шинэ хотын захиргааг байгуулсан 1571 оны зургаадугаар сарын 24-ний өдөр түүнийг Филиппин улсын нийслэлээр зарлажээ. Тагаль хэлний “Майнила” гэдэг үг нь “индиго өвс ургадаг нутаг” гэсэн утгатай ажээ. Энэ өвс өнөөдөр ч Пасигу голоор үл тасрах “ногоон мөс хагалагч” шиг хөвж байдаг.



Манила хотод испаничууд гурван зуун жил ноёрхож XIX зууны сүүлчээр тэднийг америкчууд залгамжилж, Филиппин улс 1946 онд л дөнгөж тусгаар тогтнолоо олжээ. Орчин үеийн Манила хот нь нэг нэгнээсээ ялгагдах өвөрмөц онцлог бүхий 17 дагуул хотоос бүрдэнэ. Хэдэн арван километр сунжран орших “Том Манила” нь “сити” гэж нэрлэгдэх хэд хэдэн дүүрэг болон хуваагдана. Манила хот үүссэн тагалийн эртний суурин болох Тондо дүүрэг нь сэтгэлд багтамгүй овоохой, урцын бөөгнөрөл хэдий ч энд суудаг хүмүүс Сан-Николас, Сампалок дүүргүүдийн оршин суугчдын адил эх орноо хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсаар байдаг юм.

Тондо дүүргээс өмнө зүгт испанийн анхны цэргүүд, лам нар сууршиж байсан тэр газар испанийн болон испани-филиппинийн язгууртнуудын эртний хотхон оршино. Ихэмсэг эзлэн түрэмгийлэгчид 1589 онд раж Салиман-Мэйнилийн эдлэн газар байсан газар чулуун хэрэм босгож “Интрамурос” буюу “хэрмийн дотор” гэж нэрлэж, “индио” гэж нэрлэсэн нутгийн уугуул иргэдээс өөрсдийгөө тусгаарлаж байв. Испаничууд эдлэн газрыг их буугаар буудаж газрын хөрстэй тэгшилж дараа нь “мөнхийн чулуун хотхон” байгуулж хотын захиргааны байр, Сантьяго цайз, Гэгээн Августиний сүм босгожээ. Манила хот нь нарийхан, муруй тахир гудамж, дундад зууны үеийн барилга байгууламж, гот болон роман дэгийн сүмүүдээрээ “Дорно дахь испанийн хот” гэсэн алдрыг хүртжээ.

Интрамурос хотхон дөрвөн зуу гаруй жилийн турш оршин тогтнож хөвд битүү ургасан

хэрмийн хана нь хонх хангинахад ойр орчмын тосгодын оршин суугчид чичрэн дагжиж өвдөглөн суудаг байжээ, Захиргааны байрны өмнөх талбайд цэргийн хөгжмийн жагсаал болж байсан, цайзанд хоригдож байсан хүмүүсийн ёлолт, гуйлтын гэрч байжээ. Цайз далайн дээрэмчид, английн усан цэргүүд, япон, америкийн эзлэн түрэмгийлэгчдийн мэдэлд ээлжлэн шилжиж байв. Америкчууд Манила хотод удтал сууршихаар шийдсэнийг Флорида, Небраска, Дакота зэрэг хороолол, гудамжны нэрүүд нотолно. Манила хотын усан боомтын эрэг дагуу байрлах эдгээр хорооллыг анхандаа америкийн командор Дьюигийн, одоо тусгаар тогтносон Филиппин улсын анхны ерөнхийлөгч Рохасын нэрэмжит цэцэрлэгт гудамж хүрээлж байдаг.

1937 онд Интрамурос цайзын дээр АНУ тус оронд “хагас тусгаар тогтнол” олгосон учир өөрийн мөн Филиппин улсын далбааг зэрэг мандуулжээ. Гэвч 1946 оны долоодугаар сард АНУ-ын далбааг буулгаж тэр үеэс Филиппин улсын үндэсний цэнхэр-улаан далбаа намирч байна.

Өнөөгийн Интрамурос цайз нь нам гүм байдал, Гэгээн Августиний пирамид хэлбэрийн саарал чулуун сүм, алтадмал ханаас бүрдэх дархан цаазат музей юм. Сантьяго цайз дотор байрлах үндэсний баатар Хосе Рисалийн музей нь филиппинчүүдийн хувьд үндэсний бахархал нь билээ. Нэрт нүдний эмч, гүн ухаантан, түүхч, яруу найрагч, хэл зүйч Хосе Рисаль байгалиас заяасан бүх авьяас чадвараа төрөлх эх орноо испаничуудын дарлалаас чөлөөлөх ариун үйлсэд эргэлт буцалтгүй зориулжээ.

Х.Рисаль 1892 онд “Филиппиний эвсэл” байгууллага байгуулж эрх чөлөөний тэмцэлд босчээ. Тэрбээр баривчлагдаж цаазлуулах үедээ дөнгөж 35 настай байжээ. Түүний шарилыг одоо түүний нэрээр нэрлэсэн цэцэрлэгт хүрээлэнд оршуулжээ. Өнөөдөр Манила хотын оршин суугчид тэр цэцэрлэгт хүрээлэнд тогтмол очиж зүлэг дээр хэвтэн амарч цэвэр агаар амьсгална. Цэцэрлэгт хүрээлэнд задгай драмын театр, консерватори бий. Филиппиний үндэсний симфони найрал хөгжим тэнд долоо хоногт нэг удаа үнэ төлбөргүй концерт тоглодог ажээ.

Манилад хотод ажил хэргийн, санхүүгийн төв болох “Манхэттен”, урлагийн өвөрмөц ертөнц болох “Монмартр” (Мабиний гудамж), усан боомтын “зугаалга, цэнгэлийн гудамж” “Сохо” бий. Хятадын дүүрэгт сая гаруй хятад иргэд өвөрмөц уламжлал, зан заншил, аж төрөх ёсоо баримтлан аж төрж байна. “Европийн Манила”-гаас Чайн-таунд ирсэн хүмүүс сүйх тэргээр зугаацаж хятад үндэсний хоол иднэ.

Манила хотын ажил хэрэгч хэсэг нь Интрамурос дахь испанижсан хорооллуудтай харьцуулбал зохион байгуулалт нь шал өөр ажээ. Пасигу голын адгаас өмнөд зүг рүү чиглэсэн багавгар тэгш гудамжууд нь Өмнөд усан боомтын 13 буудалд хүргэнэ.

“Ядуучуудын хороололгүй” хотын тухай мөрөөдөж байсан ерөнхийлөгч М.Кэсоны санаачилгаар бүр дэлхийн хоёрдугаар дайны өмнө сүүрийг нь тавьсан Кэсон-сити дагуул хотыг 1948 оноос Филиппиний Бүгд Найрамдах Улсын нийслэл гэж тооцож байв. Тиймд Кэсон-сити хотод засгийн газрын байгууллагууд, гадаадын элчин сайдын яамд, гадаадын компаниуд, арилжааны банкууд, даатгалын нийгэмлэгүүдийн байрууд байрлана.

Манила хотод нэгэн сонин тээврийн хэрэгсэл бий. Америкчууд дэлхийн хоёрдугаар дайны дараа жип хөнгөн тэргүүдийг далайд живүүлэх гэснээ больж филиппинчүүдэд нэг бүрийг нь хоёр зуухан доллараар борлуулжээ. Өнөөдөр тэдгээр жипүүд чиглэлийн таксины журмаар ажиллаж зорчигчдыг хямд үнээр түргэн шуурхай үйлчилж байна.

## НЬЮ-ЙОРК

Францийн нэгдүгээр Франциск хааны харьяат иргэн, флоренцийн далайн аялагч Ж.да Веразано “Дофин” усан онгоцоор 1624 оны дөрөвдүгээр сард Хойд голын адаг хүрч эрэг дээр гарахад нутгийн уугуул иргэд найрсаг угтжээ. Ж.да Веразано энд удсангүй, эрэг дагуу хойд зүгт явж эргэн тойрны байдлыг ажиглана. Тэрбээр далайн шуурга гарахаас эмээж задгай далайд гарахдаа тэнгист цутгаж байгаа цэвэр устай гол харжээ. Тэр бол Статен арлаар урсдаг гол байсан хийгээд усан цэргүүд “цэвэр устай газар” гэж нэрлэжээ. Чухамдаа ирээдүйн хот Нью-Йорк хот сүндэрлэн боссон Манхэттен арал дэр хөл тавьсан анхны европ хүн нь Ж.да Веразано байсан юм.



Түүний дараа энд хэд хэдэн хүн ирснээс Баруун-Энэтхэгийн компанид ажилладаг, голландын далайчин Г.Гудзон 1609 онд Номхон далайн баруун-хойд хэсэгт гарц байгаа эсэхийг судлах үүрэг авч хожим нь өөрийнх нь нэрээр нэрлэгдсэн Хойд голыг өгсөн явжээ. Таван жилийн дараа Манхэттен арлын газрын зураг гарч голландын худалдаачид 1625 оноос байсхийн ирэх болжээ. Тэд модон байшингууд барьж шинэ нутгаа Шинэ Нидерланд гэж нэрлэжээ.

1626 онд анхны амбан захирагч Петер Минуит улаан арьстны “манхатан” омгоос нийтдээ 60 гольденгийн үнэтэй хэд хэдэн хутга, хөнжил мөн хэд хэдэн жижиг сажиг зүйлсээр арлыг “худалдан авчээ.”

Манхэттений өмнөд үзүүрт байрлах 60 орчим цэрэг бүхий гарнизонтой Шинэ Амстердам цайз нь Шинэ Нидерланд арлын төв болж байлаа. Нийтдээ арал дээр 18 хэлээр ярьдаг таван зуу орчим хүн оршин сууж байв. Цайз дотор чулуун сүм, амбан захирагчийн байр, агуулах, урт нийтийн байр л байжээ. Гэвч хэсэг хугацаа өнөгөрөхөд Шинэ Амстердам арлын захиргааны төдийгүй худалдааны том төв болж түүний эргэн тойронд нилээд хэдэн суурин бий болсноос 1639 онд усан боомтын зүүн талд Брейкен тосгон бий болсон нь хожим нь Бруклин хороолол болжээ.

Гурван жилийн дараа данийн иргэн Йоханнес Бронк арлаас гарч Гарлем голыг гаталж хуурай газар олж тамхины ургамал тарьж эхлэсэн нь Бронкс дүүргийн эх суурь болжээ. 1643 онд өнөөгийн Куинс дүүрэгт анхны суурин, хорин жилийн дараа Статен-Айленд хорооллын эх суурь тавигджээ.

Гэвч улаан арьстнууд байнга халдлага хийж амар тайван байдалд нь заналхийлж байсан учир

амбан захирагч Стьювисент хотыг тойруулан арлын өмнөд хэсгийг хөндлөндөйрсэн модон хэрэм босгосон ч хотын оршин суугчид банзыг нь байшингаа засаж сэлбэх тэрчилэн гал түлэх зорилгоор шөнийн цагаар нууцаар буулган авсаар эцэст нь хэрэм үгүй болжээ. XVII зууны сүүлчээр хуучин модон хэрмийн буурин дээр Уолл-стрит гудамж бий болжээ.

Шинэ Амстердам эзэмшил нутаг олигтой ашиг өгөхгүй байснаас 1660 оны сүүлч гэхэд бүрэн дампуурчээ. Тэнгисийн худалдааны замыг мэдэлдээ авахын төлөө Голланд, Англи улсуудын хоорондын өрсөлдөөн дайн болон хувирч 1664 онд английн морин цэргийн суман арлыг бүрэн хяналтдаа авчээ. Мөн онд Английн хоёрдугаар Карл хаан Йорк, Олбаны гүн, төрсөн ах Яковдаа Шинэ Нидерланд арлын зарим хэсгийг бэлэг болгон өгч Шинэ Амстердам цайзыг шинэ эзний нэрээр Нью-Йорк гэж нэрлэх болжээ.

Нью-Йорк хот XVIII зуунаас Америк тив дэх Английн эзэмшил нутгийн соёлын төв болон хувирч сонин сэтгүүл хэвлэгдэж Нью-Йоркийн нийгэмлэгийн театр, номын сан нээгдэж одоо Колумбын их сургууль гэж нэрлэдэх болсон Хааны коллеж үйл ажиллагаагаа эхлэжээ. Цэцэрлэгт гудамжууд бий болж олон сүм сүндэрлэн босож орон сууцны болон албан байгууллагуудыг цэвэр усаар хангадаг болж хотын тээврийн сүлжээ бий болов. Английн эзэмшлийн үеэс тус хотод хэдхэн барилга байгууламж үлдсэнээс Гэгээн Павелийн сүм, 1712 онд барьсан “Фронсын шар айрагны газар”-ыг дурдаж болно.

Эрх чөлөөний төлөө дайн эхлэхийн өмнөхөн Англичууд цэргийн гол хүчээ Нью-Йорк хотод байрлуулж Гудзоны мөрний хөндийг эзлэж босогчдын хүчийг хоёр хуваахаар зэхэж байлаа. Тэгтэл 1776 онд хотод түймэр гарч барилга байгууламжийн гуравны нэг хувь нь сүйджээ.

Өнөөгийн Нью-Йорк хот нь Манхэттен, Бронкс, Бруклин, Ричмонд, Куинс гэсэн үндсэн таван дүүргээс бүрдэнэ. Бүхнээрээ тэргүүлэхийг эрмэлздэг аугаа Нью-Йоркийн гол хороолол болох Гудзон, Ист-Ривер голуудын усаар угаагдаж хойноос урд зүг рүү урт хэл шиг сунжран орших Манхэттен арал дээр тэнгэр баганадсан барилгууд байна. “Довуудын арал” гэсэн утгатай арал дээр 1929 оны аравдугаар сард битүү шугуй, заарт харх сүлжилдэж байсан нуур байсан газар дээр 102 давхар Empire State Building (ESB) байшин босгосон нь Нью-Йорк хотын чимэг болсоор байна. Тэнгэр баганадсан байшингийн харах талбайгаас хотыг тольдоход үнэт чулуу мэт анивчин гялалзах гэрлэн далай дунд гүүр, урт гудамж, цэцэрлэгт хүрээлэн тод үзэгдэнэ.

ESB байшингийн дээврийн талбайг анх нисэх онгоцны буудлын зориулалтаар ашиглах гэж байсан боловч “Гинденбург” дирижабль сүйрснээс больжээ. 1945 онд 79 дүгээр давхрыг бөмбөгдөгч нисэх онгоц санамсаргүй мөргөсөн ч болдон төхөөрөмж тэсэж чаджээ.

Хотод тэнгэр баганадсан байшин олон ч гудамж, талбай нь өргөн болохоор нарны гэрэл хангалттай тусна. Гэхдээ хотын ажил хэргийн төв болох Уолл-стрит гудамж нь нарийхан, давчуу, богинохон билээ. Уг гудамжны эхэнд цагаан чулуугаар гот хийцээр босгосон Гэгээн Троица сүмийн он цагийн уртад харласан байшин байна, гудамжны дунд хавьд Нью-Йоркийн хамгийн эртний байшин болох үүдэндээ баганууд бүхий намхан, бор боржингоор хийсэн байшин оршино. Энэ байшинд АНУ-ын анхны ерөнхийлөгч Ж.Вашингтон тангараг өргөж “Хүний эрхийн тунхаглал”, “Тусгаар тогтнолын тунхаглал”-ыг тунхаглан зарлаж байжээ.

Манхэттен арал дээр дэлхийд цуутай Бродвей гудамж үнэндээ бол хоёр жижигхэн Бродвей

гудамж оршино. Жирийн Бродвей нь арлын өмнөд үзүүрээс эхлэн хэдэн арван километр мушгиран сунжирна. Бяцхан Бродвей хэмээх Бродвей гудамжны хэсэгт Манхэттений төвд хэдэн арван хороолол байна.

Манхэттений хойд хэсэгт хар арьстнуудын Гарлем ертөнц мөн Чайн-таун, Бруклиний өмнөд хэсэгт зугаалга, цэнгэлийн Кони-Айленд цэцэрлэгт хүрээлэн оршино. Нар төөнөсөн өдрүүдэд хотын өнцөг булан бүрээс ирсэн хүмүүсийн олон өнгийн шүхэр, усны хувцас ойн цоорхойд алаглана.

Эллис арал дээр орших Гринвич-Виллижийн дүүрэг Нью-Йорк хотын дурсгалт газруудын нэг билээ. XVII зууны эхээр энд улаан арьстны суурин байсныг английн түрэмгийлэгчид 1696 онд эзлэж Гринвич гэж нэрлэжээ. XVII зуунд олон баян газрын эзэн Гринвич дүүрэгт эдлэн газартай болсноос энэ хороолол их нэрд гарчээ.

XX зууны эхээр Гринвич дүүрэгт АНУ-ын улс төр, шинжлэх ухаан, соёлын алдар цуутай хүмүүс тэрчилэн хөл дээрээ зогсохыг тэмүүлж байгаа залуу жүжигчид, хөгжимчид, зураачид, уран барилгачид амьдран суудаг болжээ.

Нью-Йорк хотын усан боомт руу ороход “дэлхийн хамгийн аугаа эмэгтэй” болох Эрх чөлөөний хөшөө угтана. Тэрбээр ирж байгаа хүн бүрийг найрсагаар мэндчилж америкийн үндэстэн эрмэлзсээр байгаа эрхэм тэмүүллийг сануулна.

## УЛААНБААТАР

Монгол улсын нийслэл үүсэн бий болсон түүх нь Өндөр Гэгээн нэрээр алдаршсан бүддийн шашны тэргүүн Занабазарын шашны үйл ажиллагаатай ихээхэн холбоотой юм. Томоохон феодалын гэр бүлд төрсөн Занабазар тухайн цагийн уламжлалаар лам багшид шавь орж гэрийн боловсрол эзэмшжээ. Тэрбээр 1639 онд Цагаан нуурын дэргэд монголын бүддийн шашны тэргүүнээр өргөмжлөгдөж өргөө, шүтээнээ босгож Өргөө гэж нэрлэсэн нь өнөөгийн Монгол улсын нийслэл Улаанбаатар байжээ.



Өргөө гэдэг үг нь язгууртан хүний ордон, шилтгээн гэсэн утгатай хийгээд хожим нь Их Хүрээ буюу Богдын Хүрээ гэж өөрчлөгджээ. Өргөө хот монголчуудын шашны гүн бишрэлийг бүрэн эзэмдэж соронзон мэт татдаг болохоор түүний амьдралд чухал байр суурь эзлэнэ. Өргөө хот нь 140 жилийн хугацаанд олон удаа шилжин нүүдэллэж эцэст нь Туул голын эрэг дээр дөрвөн талаасаа нарс, жодоо, хуш модоор бүрхмэл уулсаар хүрээлэгдсэн хул аяга хэлбэрийн тэжээллэг өвс битүү ургадаг хөндийд сууршижээ.

Өндөр Гэгээн Их Хүрээ дэх сүмд сууршин амьдардаггүй байсан ч хотыг өргөжүүлэн хөгжүүлэх тэр дотроо анхны бүддийн шашны сүм хийд босгох ажлыг санаачлан биечлэн удирджээ. Тэр олон сүм хийдээс хамгийн гоёмсог нь хожим нь монголын бүддийн шашны тэргүүн Богд хааны гол шүтээн болсон Энх амгалангийн сүм байв. Сүмийг хотын гол талбайд Богд хааны ордны дэргэд, шар хашаа дотор барьжээ.

Оройг нь монголын гэрийн тооно шиг янз бүрийн хээ угалзаар чимэглэсэн Майдар сүм үнэхээр сайхан харагдана. Энэ сүмийн гол шүтээн болох ирээдүйн Майдар бурхны зэсээр урлаж алтадсан баримлыг Өндөр Гэгээн одоогийн Хятад улсын нутагт байдаг Долнуурт шилжүүлэн байрлуулсан урландаа бүтээжээ. Баримлыг хэсэг болгон хувааж Өргөө хотод авчирч модон сүмд угсарч байрлуулахад сүм нь нурж унажээ. Майдар бурхан хятадын уран барилгын дэгээр барьсан сүмд залрах дургүй байна гэж лам нар үзэж шинэ сүм барихаар шийдэж суурийг нь түвдийн сүмтэй адилхан хийж ханыг нь дүнз модоор босгожээ.

Сүүдрэвчийн дор хөлөө завилан, гараа цээжнийхээ өмнө авч залбиран сууж байгаа Майдар бурхны баримлын өмнө тавьсан сангийн хүрэл бойпороос арц хүж уугиж, дөрвөн өнцөгт нь өндөр улаан лаа асаастай, вааран дотор хиймэл ариун лянхау цэцэг байна. Сүүдрэвчээс янз бүрийн өнгийн урт торго унжуулжээ. Шүтээний байрын дээд хэсэгт байх дугуй тавцан руу



хажуу байрнаас явж очно. Майдар бурхны баримлын толгой шүтээний таазанд бараг тулжээ.

Монгол улсын хүн амын бараг тал хувь нь оршин суудаг Өргөө хотын 100 мянга хүн амын дийлэнх нь ядуу лам нар байв. Зун бүр цам залах том ёслол хийнэ. Энх Амгалангийн сүмийн эсрэг талд байх Гулдан хаалга руу “амьд бурхан” болох Богд гэгээн ганцаараа явж хүрнэ. Ариун Гулдан хаалга хүрэх замд байх Мөргөлийн талбайд мөргөлчид буян болно гэж үзэж 100 мянган удаа мөргөл үйлдэнэ.

Мөргөлийн талбайн баруун талд Өргөө хотын бүх гол сүм орших хийгээд тэдгээрийн цаана зурхайн сүм зэрэг байна. Ёслолын жагсаал дууссаны дараа сүм дахин нам гүм байдалд автаж нэг шүтээнээс нөгөөд орж байгаа мөргөлчид л харагдана. Лам нар бүсгүй хүнд хавьтахгүй сахил хүртсэн болохоор сүмийн нутаг дэвсгэр дээр аж ахуй ажил эрхэлдэг настай эмэгтэйчүүд л байна.

Петербургийн зураач А.Мартынов 1806 онд Монгол улсын нийслэлийг байгуулагдсанаас хойш гуч дахь жилд нь анх удаа зуржээ. Түүний бүтээсэн усан болон тосон будгийн зурагт хот дөнгөж байгуулагдсан биш, төлөвшин хөгжсөнөөр гарчээ. Үнэндээ ч “Том тойрог” буюу Их Хүрээ хотыг нүүдлийн суурингийн байдлаар дөрвөлжин хэлбэртэйгээр байгуулсан болохоор их үзэмжтэй харагдана. Монголчууд эрт дээр үеэс ил задгай талд гэрүүдийг өнгөлзөгч дайсны халдлагаас хамгаалахад зохимжтой байхаар тооцоолж цагираг хэлбэртэй байрлуулдаг иржээ.

Өргөө нь зөвхөн шашны төв байсан гэж зарим судлаач үздэг ч бүддийн шашны тэргүүний нүүдлийн өргөө нь тус орны улс төр, соёл-шашны гол төв болон хувирчээ. Чухамдаа энд монголын өвөрмөц соёл бүрэлдэн бий болж хүүхдүүд шашны сургуульд орж монгол болон түвд хэл сурч шашны ёс дэгт суралцдаг байв. 1921 онд болсон хувьсгалаас өмнө Өргөө нь монголын ном хэвлэлийн төв байсан бөгөөд энд Дандар маарамба, Шижээ гавж, Ш.Дамдин зэрэг нэртэй эрдэмтэд амьдран сууж уран бүтээлээ туурвиж байжээ.

Өргөө хот руу ойртон ирэхэд бүддийн шашны сүм хийдийн наранд гялтганасан бөмбөгөр алтан ганжир, байшин барилгын вааран дээвэр алсаас тодорно. Хотын энд тэнд шавааралдан байх тойпуун болон шавар жижигхэн байшингууд нь нарийхан давчуу гудамжууд бий болгожээ. Гудамжны хоёр талаар жирийх хашаанууд дотор жижиг тVIIIмэд, худалдаачид, гар урчууд сууна.

Хотжих явц гүнзгийрэхийн хэрээр худалдаачид, лам нарын хооронд хурц тэмцэл өрнөв. XIX зууны эхээр худалдаачдын лангуу, мухлаг, худалдааны зах өргөжин тэлсээр сүм хийдэд улам ойртоно. Тэгтэл худалдааны хуаран сүм хийдээс хүний дуу сонсогдохгүй зайтай байх ёстой гэсэн журам баримталдаг шашны удирдлага дургүйцлээ илэрхийлж Бээжинд хүсэлт гаргаж Богд гэгээний ордныг хөндийн баруун-хойд хэсэгт шилжүүлэн байрлажээ.

Тэмцэл хурцадсаар хот гурван хэсэгт хуваагдаж нэг хэсэгт нь бүддийн шашны тэргүүнийн сүм, хоёр дахь хэсэгт нь сүм хийд оршино, лам нар амьдарна, гурав дахь хэсэгт нь ангид хууль ёсоор амьдардаг худалдаачдын Наймаачин хотхон бий болжээ. Маргаан удтал үргэлжилж эцэст нь лам нар ялагдал хүлээжээ. Удалгүй хятад, орос, америкийн худалдааны хорооллууд бий болжээ.

1911 онд Хятад улсад манжийн засаглалыг унагасны ачаар Монгол улс тусгаар тогтнолоо олж Богд гэгээн толгойлсон хэмжээлшгүй эрхт хаант улс байгуулагджээ. Тэр үйл явдлаас арван жилийн дараа монголын хувьсгалт цэрэг зөвлөлтийн Улаан армийн дайчидтай хамтран монголын нутагт дэвсгэрт нэвтрэн ирсэн Барон Унгерний цагаантнуудыг нийслэлээс үлдэн хөөж Монголын Ардын Их Хурал 1924 онд тогтоол гаргаж Улаанбаатар гэж өөрчлөн нэрлэжээ.

XX зуунд монгол улсын нийслэл танигдашгүй болтлоо өөрчлөгдөж хуучин үеийн байдал нь Гандантэгчилэн хийдийн ойролцоо л үлджээ. Эрт цагийн маягийн хашаа дотор хотын иргэд уламжлалт гэрүүдэд амьдран суусаар байна. Улаан хувьсгалаас өмнө монголд ийм нэртэй сүм олон байсан ч нийслэлд байдаг сүмийн алдар нэр гадаад орнуудад хүртэл түгжээ. Гандантэгчилэн сүмд залуу лам нар “ертөнцийн мөн чанар”-ыг суралцан ойлгож чухамдаа энэ хийдэд гүн ухаантан, эмч, зурхайч домч нарт эрдмийн зэрэг цол олгодог байжээ.

Гандантэгчилэн хийдийн нутаг дэвсгэр дээр монгол дахь бүддийн шашны хамгийн томоохон шүтээн болох Мигжиджанрайсиг бурхны баримал байна. Монголын уран барилгын түүхийн хамгийн өндөр байгууламж болох энэ баримлын өндөр нь 42 метр байв. XX зууны гучаад оны үед уг баримлыг буулгаж Зөвлөлт Оросод явуулснаар сураг нь тасарчээ. Гэвч ардчиллын замд гарсан монголчууд хуучны уран баримлын сүрлэг дурсгалаа сэргээн босгохоор нийт ард түмний хөдөлгөөн өрнүүлж 2000 онд дахин барьжээ.

Монголчууд нийслэл хотынхоо бахархал болох Богд хан уулыг бишрэн шүтэж, дотор нь шигтгэн суулгаагүй бол ямар ч үнэт чулуу үл гялалзах чамин гоё гуутай зүйрлэнэ. Чухамдаа Богд хан уулнаас Улаанбаатар хот эхлэх хийгээд түүний өнгөрсөн, эдүүгээ, ирээдүй нягт холбоотой юм. Эртний Монгол оронд Богд гэгээний дараа хоёр дахь шүтээн нь болж байсан, тойргийн урт нь 100 гаруй километр урт Богд хан уулыг явганаар тойрч чадвал үйлдсэн бүх нүгэл өршөөгдөнө гэж лам нар үздэг байжээ.

Эртний нэгэн домогт Тэмүүжин энэ ууланд дайснаас нуугдаж, амь аврагдсан тухай өгүүлсэн бий. Тэрбээр Бүх монголын Чингис хаанаар өргөмжлөгдсөний дараа Богд хан уулыг бишрэн шүтэж явах зарлиг буулгажээ. Уулын оройд хаа нэгтээ их хааных нь хуяг дуулга, сэлэм хадгалаастай буй гэж монголчууд өнөө ч итгэсээр байдаг юм.

## МОНРЕАЛЬ

Канад улсын хамгийн томоохон хот болох Монреаль нь тус орны аж үйлдвэрийн төв юм. Тус хотын нэр үүссэн Мон-Руаяль буюу Хааны довын бэлээр урсдаг Гэгээн Лаврентийн голын эрэг дээр хот сүндэрлэн байна. Гэгээн Лаврентий, Оттава, Ришелье гурван гол энэ хотоор дайрдаг болохоор тус хот томоохон усан боомт гэж алдаршсан бөгөөд хэд хэдэн суваг тулж ирдэг. Тус хотод галт тэргэнд суухад Квебек, Портленд, Бостон, Нью-Йорк зэрэг олон хот руу хүргэнэ.



Монреаль хотын үндэс суурийг 360 гаруй жилийн тэртээ францийн нүүдэлчид тавьсан бөгөөд оршин суугчдын дийлэнх нь франц хэлийг төрөлх хэл гэж үздэг тул тус хотыг “Хойд Америкийн Париж” гэж бас нэрлэнэ.

Францчууд европийн нүүдэлчдээс хамгийн түрүүнд Гэгээн Лаврентий голын эрэг дээр сууршиж улаан арьстнуудаас булаан авсан нутаг дээр Шинэ Франц нэртэй эзэмшил газраа бий болгожээ. Гэтэл англичууд мөн ирж францчуудыг зэвсгийн хүчээр дийлж 1763 онд тэд Английн амбан захирагчийн захиргаанд оржээ.

Өнөөдөр гурван сая гаруй хүн амтай Монреаль нь Квебек мужийн төдийгүй Канад орны томоохон хот болжээ. Канадын нийт есөн мужаас хамгийн том нь болох Квебек муж нь Франц улс гурав дахин багтахаар том газар нутагтай ажээ.

Монреаль нь Канадын эртний хотуудын нэг болохоор түүхэн дурсгал, эртний уран барилгын хийцтэй байшин барилга олонтой. Тухайлбал эгц ууланд тулган барьсан төмөр замын Виндзор буудлын барилга дундад зууны үеийн шилтгээнийг санагдуулна. Буудлын өмнөд талын нэгдүгээр давхар нь явган замтай нэгэн түвшинд оршдог ч хойд талаас нь орохдоо өргөгч шатаар өгсөж очно.

Худалдаа болон захиргааны барилгуудын тэгш өнцөгт хайрцаг бүхий байрлалтай америкийн хотуудтай харьцуулахад Монреаль шал өөр, хотын төвд нь гоёмсог баганууд, цэлгэр тагттай чулуун барилгууд оршино Давчуу гудамжаар явахад он цагийн уртад харласан хананд нь эртний түүхтэй гудамж талбай, дурсгалт барилга, хуучны үеийн сүм хийдийг дүрсэлсэн

элдэв зураг өлгөсөн бэлэг дурсгалын лангуунууд пиг дүүрэн байна.

Монреаль хотод европ хийцийн байшин маш олон хийгээд дэлхийн уран барилгын алдарт дурсгалуудын жижигрүүлсэн хуулбарууд бас бий. Хотын төвд орших захын дөрвөлжин хэлбэртэй талбайг хөндлөн гарахад 1824 онд барьсан болохоор тус хотын хамгийн эртний байшин гэж тооцогдох Парижийн Дарь Эхийн сүмийн сүрлэг бараан барилга нүдний өмнө тодорно. Өнөө үед Атлантын далайн усанд амь алдагсадын эцэг эх, ах, эгч, нөхөр, эхнэр, хүүхдүүд энэ сүмд ирж сэтгэлээ тайтгаруулж хандив өргөдөг байна. Иймд уг сүмийн саарал гантиган хана хүний харуусал, гашуудлын нулимсыг шингээж байх шиг санагдана.

Сүмийн дотор ороход далай, тэнгист хөвж байгаа болон аялал жуулчлал хийж байгаа бүх хүнийг ивээгч гэгээнтнүүдийн дүрсүүд өөдөөс угтана. Сүмийн ханад гаргасан хонхорхойнуудад ХҮ зууны үеийн загасчны далбаат завинаас өнөөгийн том усан хөлөг онгоц хүртэлх янз бүрийн усан хөлгүүдийн бяцхан загваруудыг байрлуулжээ. Сүмийн шүтээний хажууд эрт дээр үеийн далбаат завины зэвэрсэн зангуу, далайчны хэрэглээний эд зүйлс дэлгэн тавьжээ.

Хотын баян иргэд эртний түүхэн дурсгалт барилгуудыг огт хайхарч үздэггүй нь харамсалтай. Ром хотын Гэгээн Петрийн сүмийн загвараар 1870 онд дууриалган барьсан Гэгээн Жеймсийн сүмийн барилгын эргэн тойронд орчин үеийн тэнгэр баганадсан байшингууд босгожээ. 8 давхар байшингийн хэртэй өндөр сүмийн барилгын том бөмбөгөр орой нь сүмийн барилгаас гурван дахин өндөр ажээ. Сүмийн нүүрэн талын дээд хэсгийг нь элдэв дүрсээр чимэглэсэн өндөр гоолиг багануудтай саравчтай тагтны дээх нь гэгээнтнүүдийн товгор дүрсүүдийг байрлуулжээ.

Пляс д'Арм гудамж дагуу орших эртний барилгуудын дунд босгосон “Бэнк оф Монреаль” банкны барилгын сүүдэрт Эх Дагина Мадонна сүмийн эртний барилга хүүхдийн тоглоом шиг өрөвдмөөр жижигхэн харагдана. Гэвч жил бүр ирдэг хэдэн зуун мянган жуулчин орчин үеийн бетон, шилэн өндөр байшингуудыг биш чухамдаа он цагийн уртад сүрлэг жавхаалаг байдлаа хадгалан үлдсэн эртний барилгуудыг онцлон сонирхоно. Иймд тус хотын хамгийн өргөн, сайхан гудамжуудаас илүү эртний үеийн Сен-Катрин худалдааны гудамж үргэлж хөл хөдөлгөөн ихтэй байдаг.

Хааны дов нэртэй намхан уулнаас зүг бүр тийш хэдэн зуун гудамж салбарлан үргэлжилж Гэгээн Лаврентийн гол дээгүүр тавьсан олон арван гоё гүүр хараа булаана.

Тус хотод гурван зуу шахам сүм хийд байдаг бөгөөд олон тооны гудамж, талбай, гүүр, сургууль, эмнэлэгийг гэгээнтнүүдийн нэрэмжит болгожээ. Тиймд хотын оршин суугчид “Монреаль бол бүх гэгээнтний хот” гэж бахархдаг нь үнэний хувьтай билээ.

## КАЛЬКУТТА

Үүсэн бий болсон түүх нь Дорнод-Энэтхэгийн компанитай холбоотой Калькутта хот нь гурван зуун жилийн настай, харьцангуй залуу хот билээ. Тус компанийн ажилтан Д.Чарноб Делиг захирч байсан Их Моголын угсааны хаанаас 1687 оны сүүлчээр үзэсгэлэн худалдаагаар алдартай Сутатнути бүсэд худалдааны пүүс байгуулах зөвшөөрөл авчээ. Уг худалдааны пүүс үйл ажиллагаагаа эхлэсэн 1690 оныг Калькутта хот үүссэн жил гэж тооцдог.



Бенгаль бүсгүйтэй гэрлэж энэтхэг аж төрөх ёсоор амьдарч байсан хотыг үндэслэгч Д.Чарнобыг Гэгээн Жоны хуучин сүмд оршуулж бунхан босгожээ.

Англичууд худалдааны бүсийг хамгаалах зорилгоор Ульям цайз байгуулж Дорнод-Энэтхэгийн компани XVIII зууны дунд үе хүртэл цэцэглэж Калькутта хот Их Британийн Энэтхэгийн нийслэл болж тэр алдраа 1911 он хүртэл хадгалжээ. Английн ноёрхлын үеэс Калькуттад тус хотын гол чимгүүдийн нэг болох “Виктория хатан хааны дурсгалын цогцолбор” л үлджээ. Уг дурсгалын цогцолборын шавыг ирээдүйн IV Георг хаан 1906 онд тавьж барилгын ажил 1921 онд дуусаж, хажуу талын дөрвөн бөмбөгөр оройг 1935 онд гүйцээн босгожээ.

Дурсгалын цогцолборыг тойруулан тод улаан элсэн зөрөг зам, оройг нь жигд тэгшилсэн бут бүхий суваг, цөөрөм бүхий бяцхан цэцэрлэг хүрээлэн байгуулжээ. Гол хаалга хүрэх замд гартаа очирт таяг барьж хатан хааны гоёмсог хувцсаа өмссөн Виктория хатан хааны хүрэл суудалд заларсан баримал байна. Энэ баримал нь Энэтхэг улс тусгаар тогтнолоо зарласнаас хойш колонийн дарлалын үеэс үлдэж хоцорсон хэдхэн тооны баримлын нэг нь юм. Виктория хатан хааны баримлын ойролцоо Худалдаа, Энх амгалан, Хөдөө аж ахуй, Ядууралтай тэмцэх үйлсийг өгт дүрсүүдээр хүрээлүүлсэн Энэтхэгийн дэд хаан лорд Керзоны баримал байжээ.

“Виктория хатан хааны дурсгалын цогцолбор” нь нов ногоон зүлэгний дунд орших том цагаан тэгш өнцөгт хэлбэртэй байгууламж юм. Цав цагаан гантиг нь Их Британы эзэнт гүрний үзэл санаа цэвэр тунгалаг, цогцолборын сүрлэг том хэмжээ нь эзэнт гүрний хүчирхэг хүчин чадлыг билэгдэнэ. Цогцолборын уужим саруул танхимуудад Виктория хатан хааны эдэлж хэрэглэж байсан ширээ, зөөлөн буйдан, морины тоноглол гээд олон зүйл байна,

алтадмал гуунуудад Английн хаадын хөргүүдийг байрлуулжээ.

Энэтхэг даяар алдартай Калькутта хотын Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн колонийн дарлалын үеэс мөн үлдэж хоцорчээ. Дорнод-Энэтхэгийн компанийн ажилтан, хурандаа Р.Кидийн 1786 онд хувийн хөрөнгөөрөө энэтхэгийн ургамлын аймгийг судлах зорилгоор байгуулж захирлаар нь ажиллаж байсан уг цэцэрлэгт хүрээлэнд дөчин мянга орчим ургамал байгаагаас гол бахархал нь Их Баньян мод юм. Нийт хоёр га талбай эзлэх орших төгөл дотор хүн зугаалж явахдаа энэ бол цорын ганц мод гэдгийг мартдаг билээ.

Их Баньян модыг англичууд 1769 онд анх олж ажиглажээ. 150 жилийн дараа өвгөрч хөгширсөн эцэг-мод хүчит шуурганы үед унахад түүний 600 салаа “хүүхэд” нь үлджээ. Байгалийн гайхамшигт үзэгдэл болох энэ модны салаа газартай тэгш хэмтэй ургасаар, хэдэн метр өндөрт байгаа мөчрүүд дээр нь сууж ганхуулан наадаж болно. Агаарт байгаа зуу орчим үндсүүд нь олон салаа засмал зам мэт тал бүр тийш уртассаар байна.

Калькутта хотын түүхэн хэсгийн гол гудамж нь Жавахарлал Неругийн нэрэмжит Чауринги гудамж билээ. Урьд нь бар, ирвэс, баавгай, зэрлэг гахай, буга, усны үхэр, чоно, сармагчин амьдардаг байсан битүү шугуй, матар хөвдөг байсан намаг байсан газрыг хатааж Уильям нэртэй цайз барьж ойр орчмын газар нутгийг мод, бутнаас цэвэрлэж Италиас урьж ирүүлсэн уран барилгачид гоёмсог ордон, шилтгээн барьсаар хотын цорын ганц өргөн, цэлгэр Чауринги гудамж бий болжээ.

Калькутта нь энэтхэгийн хамгийн зөрчилтэй хот гэж тооцогдоно. Тэрбээр тэнгэр баганадсан байшин, сиймхий оромж, үнэтэй зоогийн газар, түүдэг гал дээр хоол ундаа бэлтгэдэг хүмүүс, тансаг зочид буудал, засмал зам дээр шөнийг өнгөрөөдөг ядуус, япон, америкийн гоё хөнгөн тэрэг, хүн суулгасан тэрэг түрэгчид гээд өвөрмөц ертөнц юм. Калькутта хотод орчин үеийн барилгууд английн эртний хийцийн байшингуудтай зэрэгцэн оршино. Европийн уран барилгын хийц энд дорнын дэгтэй “сэтгэл амар” хосолжээ. Угтаа бол энэтхэгийн хуучны тосгоны буурин дээр өрнөдийн соёл иргэншил, техникийн дэвшил, гоо сайхны билэгдэл болох “цэвэр” англи хот сүндэрлэн босчээ. Гэвч энэтхэгчүүд энэ хотыг “залгиж” английн хийцийн шилтгээнүүдийг танигдахгүй болтол нь өөрчилж халцарч холцорсон оронцог болгон хувиргажээ.

Хотын гудамж, талбайд худалдаа арилжаа хийж байгаа, унадаг дугуй унаж толгой дээрээ элдэв ачаа зөөж байгаа хүмүүс гээд тоймгүй олон хүн пиг дүүрэн байна. Жуулчин хүн гудамжаар явж байхдаа агшин анхаарлаа сарниулахад л шалбаагт хөлөө дүрж зам дээр хэвтэн унтаж байгаа хүн дээр гишгэж, хүн зөөдөг тэрэгтэй мөргөлдөж болзошгүй.

Калькутта нь Кали эм бурханд зориулсан хот хийгээд “Кали эм бурхны амьдран суудаг газар”, “Кали эм бурхны эх орон” гэсэн утга илэрхийлнэ. Кали эм бурхны зураг дэлгүүр, байшин, мухлаг, урлан бүрээс таныг ширтэнэ. Хотын хамгийн том сүм болох Калигхатыг 1809 онд босгожээ. 10 метр орчим өндөр сааралдуу-цагаан өнгийн нүсэр шатаар алхан сүм дотор ороход сүмийн гүнд хар царайдаа гурван цусан улаан нүдтэй, цагаан шүд, унжсан улаан хэлтэй Кали эм бурхны толгой бүхий тахил харагдана. Эм бурхны хүзүүнд хүний хиймэл толгойгоор хийсэн цэцгэн сондор зүүснийг харахад дотор хүйт даана.

“Аугаа эх Кали” гэж индуслууд нэрлэдэг Кали (Хар) эм бурхан нь Шивы бурхны хатан Парватийн олон тооны хувирлын нэг ажээ. Үзэсгэлэн төгс, өгөөмөр уян сэтгэлтэй, сайн сайхан бүхнийг бэлэглэгч, гэр бүлийн амьдралыг ивээгч Парвати эм бурхан олон дүр төрхтэй байж болно. Хорвоо дэлхий дээр муу үйлс ихсэхэд Дурги хэмээх харгис хатуу ч үзэсгэлэн гоо эм бурхан болон хувирна.

Калигхат сүм рүү ойртож байгаа нь хэдэн хорооллын алсаас мэдрэгдэнэ. Комар Тули хэмээх “хамгийн энэтхэг дүүрэг”-т нэгдүгээр давхарт нь дан дэлгүүр байрлах хоёр-гурван давхар байшингууд байна. Тэдгээрийн цаанах тоймгүй олон хонгил, өрөө, оромжинд бурхан бүтээдэг хэдэн мянга уран барималч гэр бүлээрээ сууна.

Кумар Тули дүүргийн урлангуудад хоёр зуу гаруй жилийн хугацаанд Шивы бурхан, Кали эм бурхан, дайны зургаан толгойт Сканды бурхан, оюун ухааны заан толгойт Ганеши бурхан гээд энэтхэгийн бусад бурхны хичнээн баримал бүтээснийг бурхад л мэдэх байх.

Калькутта хотын өсөлт, цэцэглэлтэд Энэтхэгийн хойд нутаг дахь тээврийн гол шугам болох Ганг мөрний бэлчирийн олон салааны нэг болох Хугли голын эрэг дээр газар зүйн хувьд маш ашигтай байрлалд байдаг нь ихээхэн ач холбогдолтой байсаар иржээ. Ариун Ганг мөрний тухай нэгэн домгийг сонирхуулья.

Хэт бардам зан, үйлдсэн нүглийнхээ төлөө шийтгэл хүлээсэн Сагары хааны 60000 хөвгүүний чандарыг ариусгах зорилгоор Шивы бурхны зөвшөөрснөөр тэнгэрийн Ганг мөрнийг газарт буулгажээ. Ганг мөрөн Гималайн уулнаас бууж, хойд зүгийн хөндийгөөр дайрч зүүн-өмнөд зүгийг чиглэн явжээ.

Эртний энэтхэгийн “Пуранах” туульсын зохиолд Ганг мөрөн нь Вишну бурхны хөлөөс урсан гарсан, тиймд түүнийг “Гималайн уулсын эзний Охин”, “Вишну бурхны хөлийн улнаас бий болсон” гэх зэргээр нэрлэдэг гэжээ.

Ганг мөрнийг энэтхэгийн соёл иргэншлийн төрөлх нутаг гэж үзэж эрт дээр үеэс ариун мөрөн гэж бишрэн дээдэлж иржээ. Хэдэн сая энэтхэгчүүд жил бүр Ганг мөрөн рүү аялал хийж түүний ариун усанд ёслолын угаалга хийж бүх нүглээсээ ангижирна. Энэтхэг хүн Ганг мөрний эрэг дэр амь хураавал түүний шарилыг мөн тэнд чандарлаж тэнгэрийн аугаа их хишиг хүртлээ гэж бахдан дуулна.

## САЙГОН

ХҮИ зуунд ирээдүйн Сайгон хотын нутаг дэвсгэр дээр анх удаа нүүдэллэн ирсэн вьетнамчууд тус нутгийн давуу талыг дор нь ойлгожээ. Энд цагаан будаа болон хөдөө аж ахуйн зарим ургамлын ургац жилд гурван удаа авч болж байгаа нь вьетнамчуудын түүхэн эх нутаг болох Улаан голын сав газартай ч харьцуулашгүй илүү их үржил шимтэй нутаг байлаа.



Сайгон хот нь вьетнам орны амьдралд онцгой байр суурь эзэлж Европ, Америк ер нь дэлхийн соёл иргэншилтэй холбох түүхэн үүргийг гүйцэтгэжээ. Вьетнамын хойд болон төв нутаг дээгүүр өнгөрч барилга байгууламж, тариалангийн талбайг сүйтгэж олон хүний амь насыг хөнөөдөг далайн шуурга эл хотоор дайрдаггүй нь их сонин.

XIX зууны үед хотод сүм барихаар суурийг ухаж байтал чулуун зэвсгийн үед хамаарах хөдөлмөрийн зэвсэг олдсоныг эрдэмтэд судалж үзээд орчин үеийн кампучийн иргэд болох кхмерүүд оршин сууж байсныг тогтоожээ. Энд мөн индонезийн бүлгийн ард түмнүүд, дундад зууны үед цус урсгасан дайнаас дүрвэсэн хятад иргэд ирж сууршиж байжээ. Чухам тийм учраас хотын нэр ямар үгнээс гаралтайг эрдэмтэд яг таг тогтоож чадахгүй өнөөг хүрчээ.

1998 онд Сайгон хот байгуулагдсаны 300 жилийн ойг тэмдэглэхдээ анхны суурин бий болсон цаг үе төдийгүй түүхэн эх сурвалжид анх удаа (1674 онд) дурдсаныг биш чухамдаа Меконг мөрний сав нутагт вьетнамчуудын оршин сууж байгаа нутгийн захирагчаар Нгуен Хыу Кань томилогдож Зядинь мужийг байгуулсан 1698 оныг иш үндэс болгожээ.

Ханой хот тус орны нийслэл хэвээр байсан тул Сайгон нь бараг зуугаад жил нэгэн хэвийн байдалтай оршин тогтнож байв. 1772-1802 онуудад ах дүү Тэйшон нарын удирдсан тариачдын бослогын үед Нгуен угсааны төлөөлөгч Зядинь мужид тариачдыг зэвсэглэж босогчдыг дарж нийт Вьетнам орны захирагч болж хааны угсааг бий болгожээ.

1859 онд францчууд Сайгон хотыг эзлэн авч гурван жилийн дараа гарын үсэг зурсан гэрээгээр Зядинь болон өөр хоёр муж Францийн эзэмшилд шилжжээ. Хотын байгалийн их баялаг, жимсний арвин ургац, орон нутгийн хүмүүсийн аядуу зөөлөн зан ааш францчуудын



анхаарлыг гойд татжээ. Сайгончууд эзлэн түрэмгийллийн анхны өдрөөс гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэлд босож францийн цэргүүдийг хотод орж ирэхэд дийлэнх оршин суугчид нь хотоос дүрвэж эсэргүүцлийн зэвсэгт багуудад элсчээ.

Францчууд тус хотыг Энэтхэг-хятадын хойг дахь эзэмшил нутгийнхаа гол төв төдийгүй “бьяцхан Париж”, “Дорнын сувд эрдэнэ” болгохыг зорьж анхны амбан захирагч адмирал Бонар хотыг “европийн эзэмшил нутгийн уран барилга” гэж нэрлэсэн дэгээр өөрчлөхийг үүрэг болгожээ. Хоёр талаар нь өндөр нам нь адилхан мод бүхий урт гудамж байгуулж 1866 онд дэнлүүний тавин шон босгож хорь гаруй гол гудамжийг гэрэлтүүлэгтэй болгожээ.

Францчууд тэнгисийн эрэг, усан боомтын хавиар голдуу байшин барьж байснаас шуудан, Дарь Эхийн сүм, Түүхийн музей, амьтны хүрээлэн бүхий Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн байшингууд өнөөг хүртэл хэвээр хадгалагдан иржээ. 1899 онд францийн уран барилгач Феррагийн төслөөр уран барилгач Гишарын удирдлага дор европ хийцийн театрын барилга ашиглалтад оржээ.

Хотын театр байртай боссоноор Бонарын цэцэрлэгт гудамжны төв хэсэгт өөрчлөлт гарч урьд нь суулгасан байсан моддыг булгалж оронд нь явган зам бүхий ойн цоорхой бий болгож вьетнамын газар нутгийг эзлэн түрэмгийлсэн цэргийг удирдаж байсан францийн цэргийн дарга Фрэнсис Гарньегийн дурсгалд зориулсан хөшөөг 1910 онд босгожээ. Түүхч, амьтан судлаач, эмч гээд францийн сэхээтний төлөөлөгчид маш олноор ирж ажиллаж амьдарч байсан учир Сайгон хот Париж маягийн цэмцгэр гоёмсог хот төдийгүй франц уур амьсгал алхам тутамд нь мэдрэгдсэн хот болон хувирчээ.

Гэвч хотын амар жимэр амьдралыг дэлхийн хоёрдугаар дайн эвдэж 1946 оноос Сайгон хотод францийн ашиг сонирхлыг дуулгавартай хэрэгжүүлэгч засгийн газар байрлажээ. 1953 онд францийн аялан байлдагч арми вьетнамын эх орончидтой цус урсган тулалдаж байхад америкчууд тус улсын “ерөнхийлөгч”-өөр Нго Динь Дьеме гэгчийг “сонгов.” Шинэ “ерөнхийлөгч” албан тушаалдаа ормогц Женевийн конвенциэр заасан нийт вьетнамын чөлөөт сонгуулиас татгалзаж байгаагаа мэдэгдэв.

Нго Динь Дьеме бүх франц хаяг, нэрийг өөрчлөх зарлиг гаргаснаар алдарт эрдэмтэн Луи Пастер түүний шавь Иерсен, Кальмет тэрчилэн латин үсгийг ашиглан вьетнам хэлний цагаан толгойг зохиосон Александр де Род гэсэн дөрөвхөн хүний нэрнээс бусад хаяг, нэрийг вьетнам хэлээр бичих болжээ.

Нго Динь Дьеме ерөнхийлөгчийн үед эхэндээ хуучны барилгуудад байрлаж байсан яамд, элчин сайдын яамд, цэргийн штабуудын шинэ байрууд баригджээ. Үүнд францийн амбан захирагчийн өргөө байсан байшингийн буурин дээр Ерөнхийлөгчийн ордон (одоо бол “Эв нэгдлийн ордон”) босгожээ. Харамсалтай нь ерөнхийлөгчийн явуулж байгаа бодлогод дургүйцсэн францийн нисгэгч уг ордонг 1962 онд бөмбөгдөж сүйтгэжээ.

Вьетнамын алдарт уран барилгач Нго Вьет Тхугийн удирдсан багийн боловсруулсан төслөөр Ерөнхийлөгчийн шинэ ордныг барьж 1966 онд нээлтийг хийжээ.

Сайгон хот эрчтэй хөгжиж Бангкок, Куала-Лумпур зэрэг Зүүн-Өмнөд Азийн олон орны

нийслэлүүдийг ардаа хол орхисон ч АНУ-ын өдөөсөн дайн тус хотын үсрэнгүй хөгжлийг чөдөрлөсөн билээ. АНУ ноёрхлолоо бэхжүүлэхийн тулд цэргийн тоогоо эрс нэмэгдүүлснээр хотын хүн амын тоо геометрийн дэвшлээр өсөж байлаа. Америкчуудын эзэмшлийн үед дэлхийн хамгийн олон цагдаатай хот болон алдаршив. “Аюулгүй байдал”-даа онцгой анхаардаг АНУ-ын захиргаа, Сайгоны дэглэмийн ноёд хотод шүхрийн дөрвөн тусгай анги тэрчилэн тэнгисийн явган цэрэг, өвч зэвсэглэсэн “командос” багуудыг байнгын байлдааны бэлэн байдалд байлгаж байлаа. “Босогчидтой тэмцэх тусгай баг”-уудын хэдэн мянган цагдаа ямар ч бослого хөдөлгөөнийг нухчин дарахад бэлхэн байжээ.

Гэвч бүр францийн эзлэн түрэмгийллийн үед бүрэлдэн бий болсон дайчин уламжлалтай сайгончууд гар хумхин суусангүй. Иймд нийслэл хотын оршин суугчдын дайнч үзэл бодол санааг мохоох зорилгоор америкчууд хотын нутаг дэвсгэрийг “стратегийн ач холбогдол”-той дөрвөн зуун бүс болгон хувааж бүс бүрийг өргөст тороор заагласан байлаа. Тэрчилэн байр бүрийн үүдэнд оршин суугчдын нэрсийн жагсаалт бүхий самбар хадахыг тушааж айл гэрт дуртай цагтаа нэгжлэг үзлэг хийж “илүү гишүүн” илэрвэл тэр даруй баривчилж байв. Бүх айл гэр бүрийг “тавт”-ын бүрэлдэхүүнд багтааж гишүүн айл бүрт “тавт”-ын өмнөөс хариуцлага хүлээлгэдэг болгожээ.

Сайгон хотын хоёр эрэг дагуух амьдрал байдал тэс ондоо байлаа. “Азийн Монте-Карло” хэмээн нэрлэгдсэн хэсэгт олон давхар зочид буудал, албан байгууллага, банкуудын шил толь болсон барилгууд, том тагт, хөргөлтийн төхөөрөмж бүхий тансаг шилтгээн гудамж дагуу эгнэн байна. Нөгөө хэсэгт хатуу цаас, сургааг мод, нимгэн банзаар барьсан оромжуудад энгийн вьетнам иргэд бөөнөөрөө сууна.

Гэвч АНУ-ын дэмжлэгээр оршин тогтнож байсан тоглоомын арми 1975 оны дөрөвдүгээр сард эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө он удаан жил тэмцэж ялалт байгуулсан вьетнамын босогчдод бууж өгсөн билээ.

Тус хот 1975 оноос Вьетнамын анхны ерөнхийлөгч Хошиминий нэрээр нэрлэгдэх болсон ч Сайгон гэсэн нэрээр гол, усан боомт нэрлэгдсэн хэвээр үлджээ. Хошимин хотын гудамж, талбайгаар явахад, шинэ амьдралын нэгэн жигд хэмнэл, хатуу дэг журам алхам тутамд мэдрэгдэнэ.

## САНКТ-ПЕТРБУРГ

Оросын нэгдүгээр Петр хаан 1703 оны тавдугаар сарын 16-ны өдөр тус хотын суурийг тавьсныг хэн бүхэн сурах бичгээс мэднэ. Ирээдүйн хотын буурин дээр олон тооны тосгон гацаа оршдог байсан хийгээд тухайлбал Литейная гудамж эхэлдэг тэр хэсэгт Фроловщина тосгон, Фотанка гудамжны эхэнд, Зуны цэцэрлэгт хүрээлэнгийн дэргэд Кандуя тосгон байжээ.



Энэ нутагт оросууд төдийгүй финчүүд тэрчилэн ижора, корел омгийнхон суудаг байв. “Водская Пятинна” хошуу Новгород мужийн бүрэлдэхүүнд багтдаг байв.

Петр хаан Шведийн эсрэг дайн өдөөхдөө тухайн цагтаа Москвагийн вант улсад болж байсан үймээн самууныг далимдуулан булаан авч 1617 оны Столбовын гэрээгээр шведүүд эзэмшдэг болсон “өвөг дээдсийнхээ төрөлх нутгийг” эгүүлэн авах зорилго тавьсан байлаа. 1702 онд шведүүдийг үлдэн хөөхөөр томилон явуулсан Ф.М.Апраксиний удирдсан баг Нева мөрний эрэг дагуух тосгон сууринг түйвээн сүйтгэснийг хаан дуулаад их дургүйцэж байжээ.

1702 онд оросын арми новгородын эртний Орешек хот болох шведийн Нотебург цайзыг эзлэн авахад хаан хязгааргүй баярлаж “Шлиссельбург” буюу “Түлхүүр хот” гэж нэрлэх зарлиг гаргаж А.Д.Меньшиковийг амбан захирагчаар нь томилжээ.

Гэвч эндхийн хөрс үржил шимгүй, эргэн тойрон намаг, битүү ой, тосгон суурин энд тэнд л хааяа тааралдана. Петр хаан ирээдүйн нийслэл хотоо босгох газар үзэж яваад Том Нева мөрөн Нева, Невка гол болон хуваагдаж байгаа Иени-Саари (Туулайн) арлыг сонгож нэрийг нь Люст-Эйланд (“Хөгжөөнтэй”) гэж өөрчилж Петропавловын цайзын суурийг тавьжээ.

Нэгдүгээр хаан Петр өөрийнхөө дурсгалд зориулан хот босгосон гэдэг буруу, тэрбээр Гэгээн Петрийн дурсгалд зориулан хот ч биш, зүгээр л цайз барих зарлиг буулгасан гэж судлаач С.П.Заварихин үздэг юм. Тэгээд ч Финланд, Ливони (Латви, Эстони) улсуудыг заагласан тэрчилэн цэргийн эд зүйл хадгалах бяцхан хотыг Нева мөрний адагт байгуулах саналыг анх адмирал Ф.Головин гаргасан байна.

Петр хаан цайзын суурийг тавих ёслолд оролцож хоёр ширхэг ширэг зүсэж хэрээслэн тавиад “Энд хот сүндэрлэн босно!” гэж хэлжээ. Тэгээд цайзыг тойруулан барих хэрмийн хананы дагуух гууг ухаж эхлэхэд лам нар жалгыг аравнайлж хаан Гэгээн Андрейн дүрс бүхий алтан дуулгыг жалгын ёроолд тавьжээ. Цайзыг босгох ажилд олзлогдсон швед цэргүүд, дараа нь орос цэргүүд, нутгийн оршин суугчид оролцож 1703 оны зургаадугаар сарын 22-ны өдөр ван Н.И.Репниний удирддаг торгон цэрэг, дивиз цайзанд нүүн оржээ.

Цайзын цэргийн гарнизоныг ундны цэвэр усаар хангах зорилгоор арлаар зүүнээс нь баруун хүртэл хөндлөн суваг татаж түүний хоёр талаар барьсан дөрвөн эгнээ байшингуудад цэргүүд, комендант нарыг байрлуулж мөн зэвсэг, дарь, хүнсний агуулах барьжээ. Цайзын төв дэх цамхаг дээр далбаа мандуулж баяр ёслолын өдрүүдэд түүний оронд орос улсын шар тугийг мандуулдаг байжээ.

Оросын арми Полтав нуурын дэргэд ялалт байгуулснаас хойш Санкт-Петербургийн хүн амын тоо эрс нэмэгдэж Нева мөрний хоёр эрэг дагуу голланд хийцийн вааран дээвэртэй нэг-хоёр давхар чулуун байшингууд барьж чулуу дэвсэж тэгш өргөн гудамжууд байгуулан мод суулгажээ. Олзны швед цэргүүд чулуун гудамжийг долоо хоног бүр цэвэрлэдэг байжээ.

Хотын Петербургийн хэсэгт Васильевийн арал аажимдаа байшин барилгаар дүүрч байлаа. Петр хаан ойр орчмын тосгоны эзэд, лам нар, тайж нарт эдлэн газраа эзэмших эрхээ алдахгүйн тулд гурван жилийн хугацаанд арал дээр байшин барих зарлиг буулгасан байв. Уг зарлигт газар, мод унэ төлбөргүй олгож байгааг заахын зэрэгцээ гагцхүү чулуун барилга барихыг үүрэг болгосон байжээ.

Петр хаан Васильевийн арлыг шинэ нийслэлийнхээ төв болгохыг эрмэлзэхдээ усан онгоцууд зах, дэлгүүрүүдэд шууд тулж ирж чадаж байхаар тооцоолж Амстердам, Венеци хотууд шиг 12 суваг байгуулах төсөл гаргажээ. Хамгийн гол нь сувгуудаар хотыг үерээс хамгаалж байх зорилго тавьж барих ажлыг ван А.Д.Меньшиковт даалгажээ. Гэтэл ван хайхрамжгүй хандсанаас сувгууд нь Амстердам хотын сувгуудаас нарийхан болсон тул хаан уурлаж сувгуудыг шороо асгаж дүүргэх үүрэг өгчээ.

1712 онд хааны гэр бүл Москвагаас нүүн ирэхэд Санкт-Петербург аль хэдийнээ хотын дүр төрхөө олж арав гаруй гудамж бий болж мянга орчим байшин боссон байв. Нийслэлийн хамгийн хөл хөдөлгөөнтэй газар нь Троицийн гудамж байсан хийгээд уг талбайд орших шавар байшинд цайзаас Сенатын хуралдааны байрыг шилжүүлэн байрлуулжээ. Троицийн талбайд олон баяр ёслол тэмдэглэдэг байснаас хамгийн цуутай нь Полтавын дэргэдэх байлдааны ялалтын баяр байжээ.

Итали гаралтай швейцарын иргэн Доменико Трезини Санкт-Петербург хотын анхны уран барилгач байлаа. Ажилсаг, тэвчээртэй, хурц сэтгэдэг зангаараа хааны итгэлийг хүлээж Кронштадын усан боомтоос Петропавловын цайзын анхны өөрчлөлт хүртэлх гээд хаанаас өгсөн бүх даалгаврыг чин сэтгэлээсээ ухаалаг гүйцэтгэж байлаа.

1712 онд Санкт-Петербург хотыг Оросын эзэнт гүрний нийслэлээр тунхаглан зарласны дараа хотын сүм барих асуудал гарч хаан Петропавловын модон сүмийн оронд чулуун барилга босгох ажлыг уран барилгач Д.Трезинид даалгажээ.

Нэгдүгээр Петр хаан өөд болсны дараа хүн бүрт дуртай газраа амьдрахыг зөвшөөрсөн учир хамгийн түрүүнд язгууртнууд хотыг орхин явжээ. Шинэ хатан хаан Елизавета Петровна ихэнхдээ Москва хотод сууж байсан учир Санкт-Петербург хот эзгүйрч зарим гудамж талбай хогийн өвсөөр хучигдаж байшин барилгын ихэнх нь нурж унажээ. Нийслэлийн хүн амын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч байсан ч олигтой үр дүнд хүрэхгүй байлаа. Тэгээд хотыг орхин явсан бүх худалдаачин, гар урчууд, улаач нарыг гэр бүлийнхээ хамт буцан ирэх тухай зарлиг 1729 онд гарч зарлигийг эс дагаваас эд хөрөнгийг хураах цөллөгт явуулахыг хатуу анхааруулсан байлаа.

Орос хүмүүс яагаад нийслэлдээ амьдран суухаас зайлсхийж байсан юм болов оо? Петр хааны сонгосон газар нь нийслэл гэхэд арай тохиромжгүй, усан боомт байхад илүү зохимжтой нутаг байсан юм. Хот байгуулагдсан цаг үеэс хий үзэгдлийн, бодит бус, улс орны түүхтэй огт холбоогүй хот гэсэн ойлголт бий болсон байв. Нэрт шүүмжлэгч В.Г.Белинский 1845 онд бичсэн “Петербург ба Москва” өгүүлэлдээ “Петербургийн тухай намаг дээр биш гэхэд, бараг агаарт босгосон хот гэж боддог нь нууц биш ээ. Энэ бол түүхэн шүтээнгүй, домог дурсамжгүй, төрөлх эх оронтойгоо ямар ч холбоогүй, шонгууд дээр дан тооцоо дээр үндэслэн байгуулсан хот гэж олон хүн үздэг билээ.” гэжээ.

Санкт-Петербург хот түүхэн хугацаандаа ихийг үзэж аймшигт үер, түймэр, хувьсгал, өлсгөлөн, бүслэлт гээд он цагийн шалгалт сорилтыг нэр төртэй даван туулж Петроград, Ленинград нэрийг дамжиж 2003 онд 300 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэсэн билээ.

## САН-ФРАНЦИСКО

1776 оны гуравдугаар сард одоо Сан-Франциско хот байрлаж байгаа хагас арлын хойд хэсэгт испаничууд анхны цэргийн усан боомт буюу пресидио барьж католик шашны анхны эмэгтэй Гэгээнтэн Долорес сүмийг босгожээ. Дөчин дов дээр 1835 онд үүссэн анхны сууринг “Йерба буена” (“Сайхан өвс”) гэж нэрлэжээ. Америкчууд 1846 онд уг сууринг эзлэж тэнгэр хангай харж үзэж байхыг хүсэж Гэгээн Францискийг билэгдэн Сан-Франциско гэж өөрчлөн нэрлэжээ.



Үнэхээр ч Гэгээн Франсиск тэднийг харж үзэж хоёр жилийн дараа алт гарч таван зуугаадхан оршин суугчтай бяцхан тосгон руу хэдэн мянган хүн зүглэлээ. 1848 онд нэр ч өгч амжаагүй байсан усан боомтод дөнгөж 12 усан онгоц ирж байсан бол дараа жил нь тэр тоо 755 хүрсэн байлаа. Калифорнийн жижиг тосгон маш түргэн өргөжин тэлж хот болон хувирч дэлхийн ач холбогдолтой усан боомт болон мандав. Таван жилийн дараа гэхэд хотын оршин суугчдын тоо тавин мянга хол давсан байлаа.

Алтны эрэлчид майханд юм уу саравчинд хоног төөрүүлэхийг хүссэнгүй, угсардаг жижиг байшингууд авчирч суужээ. Алтны эрэлчдийг зөөн авчирсан усан онгоцуудыг орон сууц, зоогийн газар, тэр ч бүү хэл шоронгийн зориулалтаар ашиглаж байлаа. Сан-Франциск хотыг бүрэлдэн бий болоход олон үндэстэн ястны хүмүүс оролцсон учир тус хот олон шашин, хэл, соёлын төв болон төлөвшжээ.

Хотын анхны уран барилгач болох ирландын инженер Д.О.Фаррел Париж хот дахь Елисейн тал гудамжны маягаар том өргөн чөлөө байгуулахаар шийдэж элдэв эсэргүүцлийг үл хайхран хотын байрлалын голчоор Маркет-стрит хэмээх өргөн гудамж байгуулсан нь хотын гол гудамж болсон билээ.

1856 онд францийн уран барилгач Версеман эх орноосоо нэгэн байшин нүүлгэн авчирч түүнтэй адилхан хэд хэдэн байшин босгов. Мөн тийм байдлаар Голланд, Англи, Шотланд хийцийн барилгууд, Бельги маягийн багтаамж сайтай зоогийн газрууд бий болжээ. Хятад иргэд боржин байшингууд барьж байв.

Хөрөнгөжиж чинээлэг болсон хотын иргэд шилтгээн, ордон бариулахаар дэлхийд нэртэй уран барилгачдад мөнгө гамгүй шидэн бие биентэйгээ өрсөлдөн урина. Хот улам хөгжиж захиргаа, албан байгууллага, зочид буудал, аж үйлдвэрийн корпорац, банкуудын гоёмсог байшингууд дараалан сүндэрлэн босно. Банкуудад алтнаас гадна хөрш Невада мужийн нутаг дэвсгэрээс 1859 онд илрүүлсэн мөнгө маш их хэмжээгээр хадгалуулж байлаа.

Гэтэл 1906 оны дөрөвдүгээр сарын 18-ны өглөө 5 цаг 11 минутанд газар хөдөлж хотын иргэд сэрцгээв. Нийтдээ дөчин минут үргэлжилсэн газар хөдлөлтийн хугацаанд олон давхар байшингууд найган ганхаж цахилгаан шугам сүлжээний шонгууд унаж цахилгаан тасарч хий дамжуулах болон цахилгаан дамжуулах хоолой, засмал зам хагарч трамвайны шугам махиралдаж вагон, хөнгөн тэрэгнүүд онхолджээ. Бөөн шороо тоос тэнгэр өөд хуйлран босож нар халхалж хаа сайгүй түймрийн гал дүрэлзэнэ. Тэнгисийн буланд орших амралт зугаалгын ногоон хот хоромхон зуур сүйрч балгас болон хувирчээ.

Хотын оршин суугчид энэхүү аймшигт газар хөдлөлтийг дурсаж жил бүр дөрөвдүгээр сарын 18-ны өдөр 5 цаг 11 минутанд Маркет-стрит гудамж дахь “Лотто охины усан оргилуур”-ын дэргэд цугларна. Тэд тогтсон уламжлал ёсоор дүрэлзсээр байсан түймрийн галыг унтраах зорилгоор бүтэн гурван хоногийн турш ус шахаж байсан “алтан хоолой”-г будаж өнгө оруулдаг ажээ.

Хотыг сэргээн босгох ажил эрчтэй явагдаж 1915 онд гэхэд сувгийн нээлтэд зориулсан Панам-Номхон далайн үзэсгэлэн зохион байгуулж байжээ. Хорьдугаар зууны эхээр Сан-Франциско хотод өндөр барилгууд барьж эхлэсэн нь өнөөдөр хотын гол чимэг болж байна. Санхүүгийн хорооллын голт зүрх нь шил, болд, бетоноор босгосон тэнгэр баганадсан байшингууд юм. 1972 онд барьсан пирамид хэлбэртэй “Трансамерика” корпорацийн байр тус хотын билэг тэмдгийн нэг болж байдаг билээ.

Тэнгисийн хоолой дээгүүр тавьсан, дэлхийн хамгийн урт өлгөмөл гүүр болох гоёмсог улбар-улаан “Голден-Гейт”(“Алтан хаалга”) гүүрийн нээлт 1937 оны тавдугаар сарын 27-ны өдөр болжээ. Сан-Франциско хот болон Мэрин мужийг холбосон гүүр ашиглалтад ороход тийм гүүр барих техникийн боломж огт байхгүй гэж эсэргүүцэж байсан хүмүүс сая нэг таг дуугүй болж байжээ. 1730 метр урт гүүрийг барихад усан дотор шон суулгах үер, ширүүн урсгал, битүү манантай тэмцэх гэх зэргээр нийтдээ дөрвөн жилийг зарцуулжээ.

Алтан хаалга гүүрний хойд талд уран барилгач У.Х.Холлын төслөөр байгуулсан Сан-Франциско хотын алдарт Цэцэрлэгт хүрээлэн бий. Цэцэрлэгт хүрээлэнг барих ажлыг хариуцаж байсан шотланд иргэн Д.Макларен хоёр сая шахам мод суулгаж улам гоёмсог болгожээ. Энэхүү цэцэрлэгт хүрээлэнг элсэн довууд дээр байгуулсан хэдий ч хүмүүс хурц оюун ухаан, цуцашгүй хөдөлмөрөөрөө ногоон дов толгод, хүрхрээ, тал хээр, нуур, арал олныг барьжээ. “Алтан хаалга” хэмээх баян бүрдийн бүрэлдэхүүнд тухайлбал Библийн судрын, Сайхан үнэртний гэх зэрэг арав орчим цэцэрлэг багтана. Шекспирийн цэцэрлэг дотор английн суут жүжгийн зохиолчийн бүтээлүүдэд гардаг моддыг тусгайлан ургуулсан байдаг.

Европ, Азийн хэмжүүрээр Сан-Франциско нь маш залуу хот билээ. Өнөөгийн Сан-Франциско өнгө төрхөө өөрчилж улам гоё болж байгаа ч өнгөрсөн хоёр зуу гаруй жилийнхээ дурсгалт зүйлүүдийг нандигнан хадгалсаар байна. Тэрбээр хуучны барилгууд төдийгүй газар

хөдлөлт, түймрээс үлдсэн байшингийн нүүрэн талыг ч яг хэвээр хадгалж байна.

Неоклассицизм дэгээр барьсан Олон нийтийн төвийг 1978 онд нийт үндэстний хэмжээний дурсгалт зүйл гэж зарлажээ. Энэ нутагт алтны судлыг олсон Ж.Маршалл хэмээх мужааны нэр бүхий талбайн эргэн тойронд хэд хэдэн саарал боржигон байшин сүндэрлэн байдаг.

Сан-Франциско хот руу өмнө зүгээс нь орж ирэхэд хотод гарч байгаа өөрчлөлтүүд нүдэнд содон тусна. Зам дагуух чавга, гүйлс жимсний модод алга болж орон сууцны намхан байшингууд ярайна. Тэнгэр баганадсан байшин цөөхөн хийгээд уран барилгачид өнөөдөр орчин үеийн барилга босгохдоо испанийн эзэмшлийн үеийн уламжлалт дэгтэй хослуулахыг хичээсээр байна.

Твин Пикс дов дээрээс хот руу тольдон харваас тэнгисийн булан, гүүр бүхий цагаан, гялалзсан дорнод хэсэг, далайн бүрхэг бараа бүхий баруун хэсэг гээд хотын дүр төрх бүхэлдээ тодорно. “Та Сан-Франциск хотод сэтгэл зүрхээрээ татагдана!” гэж сурталчилгааны товхимолд бичсэн байдаг нь үнэний хувьтай биз ээ.



## АЮТИ

Аюти хот хэдэн зууны туршид уран сайхны үнэт зүйлсээ хуримтлуулж тансаг ордон, сүрлэг сүмүүд босгосоор иржээ. Аюти Тайланд улсын нийслэлээр 400 гаруй жил байсан хугацаа нь Тай улсын хөгжил цэцэглэлтийн үетэй давхцаж байлаа. Хаан ширээнд 33 хаан ээлжлэн солигдож 1767 онд Авы улсын бирмийн цэргүүд Аюти хотыг удтал бүслэлт хийсний дараа эзлэж эвдэн сүйтгэж газрын хөрстэй тэгшилжээ. Ханхүү Пья Тасину 50 цэрэгтэй амьд зугтан гарч удалгүй бут цохигдсон армиасаа үлдсэн цэргээ цуглуулж хэд хэдэн байлдаанд ялалт байгуулж гадаадын түрэмгийлэгчдийг эх нутгаасаа үлдэн хөөжээ.



Пья Тасину хаанаар өргөмжлөгдсөн ч ёслолоо нийслэл хот нь балгас болсон учир хаанаар залрах ёслолоо хийх газаргүй байлаа. Хотын дөрвөн зуу орчим сүмийг тэрчилэн Хааны ордонг эвдэн сүйтгэж хуу галдан шатаасан байлаа. Үлгэрийн амьтдын дүрсүүдээр чимэглэсэн завиараа хаан зугаалдаг байсан цөөрмийг мөн сүйтгэсэн байв.

Хааны ордны өндөр хэрэмний цаана байрлаж байсан нийслэлийн Шрисанпхета гол сүмийн балгас харлана, түүний дэргэд сэргээн засварласан Вихар Пра Монгол Болхит сүм сүндэрлэнэ. Уг сүмийн дотоод танхимд 16 метр өндөр суумал Бүдда бурхны баримал байна. Тэрбээр уламжлалт байдлаараа хоёр хөлөө нугалан сууж хоёр гараа өвдөг дээрээ тавьж баруун гарынхаа хуруунуудыг газар сунган үйлс нь үнэн зөвийнх нь гэрч болохыг уриалан дуудаж буй мэт ажээ. Гэгээрсэн Бүдда хорон санаатны ятгалга, заналхийллийг даван туулж гарсандаа баярлаж сэтгэл хангалуун сууна.

Сүмийн өмнөх жижиг талбай нь хотын өвөрмөц төв юм. Уг талбайд сүсэгтнүүд, мөргөлчид ирнэ, жуулчид хөнгөн тэргээ тавина, жижиг худалдаачид бэлэг дурсгалын зүйл, “эртний эд зүйлс” өрсөлдөн борлуулна.

Аюти хотод засмал пирамид мэт хэлбэртэй Шри Сурьятай сүм холоос харагдана. 1563 онд болсон нэгэн байлдааны үеэр авааль нөхөр, хаан Маха Чакрапатын өмнүүр орж амь насаа алдсан хатны чандарыг энэ сүмд тус орны түүхийн нэгэн баатарлаг эмэгтэй гэж хүндэтгэн хадгалж байна.

Сүмийн барилгыг уран барилгын уламжлалт дэгээр дөрвөн талаас нь өргөн шатаар явж очдог задгай тагт, дээх нь пирамидийн дунд хавьд хүрдэг нарийхан эгц гишгүүрүүдтэй барьжээ. Сүмийн голд байгаа чулуун бунхан дотор хайрга, Бүдда бурхны чулуун толгойноос өөр юу ч байхгүй. Эргэн тойрон нам гүм ноёрхоно.

1782 онд генерал Чакрийн удирдсан тайландын арми Кампучи руу очиж босогчдыг дарав. Генерал Чакри буцан ирмэгцээ өөрийгөө хаанд өргөмжилж тус улсыг одоо хүртэл захирч байгаа хааны угсааг үндэслэжээ. Тэрбээр хотыг голын нөгөө эрэгт загасчны жижигхэн тосгон байсан газар шилжүүлэн байрлуулснаар Тайланд улсын шинэ нийслэл бий болжээ. Сүйдэж нурсан Аяти хотын дурсгалд зориулан байгуулсан хиймэл сувгуудад эртний уран барилгын дэгээр босгосон сүм, ордуудын дүрс тусна.

Тайландын вант улсын нийслэл албан ёсоор “Крунгтеп Ратана Косин Махинтара Аютхайя Махадилокпоп Нопаратана Ратчани Буриром Удомратчани Махасан Амокпиман Аватансатит Сакатуттия Висанукам” буюу “Бурхдын хот, аугаа их хот, Маргад эрдэнийн Бүдда бурхны өргөө, хэн ч халдашгүй хот, есөн үнэт чулуугаар чимсэн, хааны олон ордон бүхий болон бурхны элч захирдаг диваажингийн орон байрыг санагдуулсан дэлхийн аугаа их нийслэл, Индра бурхны бэлэг болгон барьсан, Висануком барьсан хот.” гэж нэрлэгдэнэ.

Гадаадын иргэд Тайландын нийслэлийг Бангкок, нутгийн иргэд “Крунгтеп” буюу “Охин тэнгэрүүдийн хот” гэж нэрлэнэ. Хотыг зүг бүрт хөндлөн зүссэн олон тооны сувгаар нь үнэлж “Дорнын Венеци” гэж удтал нэрлэж байлаа. Бангкок хотод ус гудамжуудын үргэлжлэл хийгээд түүнийг газар шиг эзэмшиж, усан дээр амьдарч, амарч худалдаа арилжаа хийдэг байв. Одоо ихэнх суваг шуудуу шороогоор дүүрч гудамж болон хувирч үлдсэн сувгуудаар нь хөдөлгүүрт завиуд хөлхөлдөж хэдэн мянга завь, салаар дагуул хотуудаас хүнсний ногоо, жимс, загас зөөнө.

Түүхэн хэмжүүрээр бол Бангкок нь залуу хот, эртний үеийн дурсгал, өнгөрсөн үеийн үйл явдалтай холбоотой зүйл хотод бараг байхгүй. Хотын байшин барилгуудыг эмх замбараагүй барьсан болохоор түүхэн төв байхгүй боловч гэсэн засаг захиргааны бүх байшин, төрийн байгууллагууд, яамдууд Хааны ордны ойролцоо байрлана. Харин гадаадын компани, пүүсийн орчин үеийн барилгууд хотын нөгөө төгсгөлд Силом, Патпонг гудамжуудын дүүрэгт байрлана. Түүний зэргэлдээ ядуучуудын хорооллууд байна.

Бангкок хотод Хааны ордны цасан цагаан гантиг, алтаар бүрсэн олон шатлалтай ганжирууд, задгай тагттай оройнуудыг тэгшилж янзалсан модод гоо үзэмжээрээ өрсөлдөнө. Хааны ордныг зөвхөн хааны тушаалыг л биелүүлэх үүрэгтэй торгон цэргүүд хамгаална.

Бангкок хотод гудамжаар хэд алхаад л шар орхимж нөмөрсөн лам нартай тааралдана. Чинээлэг айлын хүүхдүүд тодорхой хугацаагаар сүмд шавилан сууж сэтгэл санаагаа ариусгаж хатуу дэглэм журам баримталж суралцана.

Лам хүн өмчтэй байх эрхгүй, нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчино, харин галт тэргээр явахдаа тасалбарын тал үнийг төлнө. Лам нар өглөө бүр айл бүрээр орж сайхан сэтгэл гаргаж ламын сагсанд цагаан будаа, загас, чанасан өндөг хийж өгөхийг гуйна.

## СИНГАПУР

Английн лорд Стэмфорд Томас Раффлз Сингапурыг Английн хааны эзэмшилд авсан 1819 оныг Сингапур арал, улс, хот байгуулагдсан он гэж үздэг. Гэвч уг арал дээр Ү зуунаас домогт Тумасикийн улс оршин тогтнож байсан ч тэр үеийн тухай мэдээлэл маш хомс хэвээр байна.



Тумасик гэдэг малайз хэлээр “Тэнгисийн эрэг дээрх хот”, “Тэнгисийн хот” гэсэн утгатай нэрийг тэнгист ойрхон учир авсан бололтой. VII зууны үед энд шон дээр байгуулсан хорь орчим байшин бүхий тосгон байсан хийгээд байшингийнхаа үүднээс усанд дэгээ хаяж загас барьдаг байв. Таван зуун жилийн дараа загасчны тосгоны буурин дээр жижигхэн усан боомт бий болж Малакксын хоолойгоор дайрдаг худалдааны замыг хяналтдаа байлгаж байлаа. Арлын оршин суугчдын амгалан тайван байдлыг эх газраас хийсэн хэд хэдэн удаагийн довтолгоон алдагдуулж байв.

Сингапур нь Зүүн-Өмнөд Азийн эрэг дагуух стратегийн чухал тVIIIиц газар болохыг голландын болон английн эзлэн түрэмгийлэгчид ойлгож Дорнод-Энэтхэгийн компанийн ухаалаг овсгоотой тVIIIмэл С.Т.Раффлз хахууль өгөх, айлган сүрдүүлэх гэх зэрэг элдэв явууллага хийсний үр дүнд 150 орчим загасчин оршин суудаг Сингапурыг Суматр арлын султанаас “худалдан авчээ.”

С.Т.Раффлз амбан захирагч болмогцоо тVIIIмэдийн байгууллагыг байгуулахад онцгой анхаарч английн эрх зүйд үндэслэсэн, орон нутгийн шашны болон гэр бүлийн уламжлалыг тусгасан хуулиудын эмхэтгэл гаргаж газар бүртгэх, усан боомтын үйл ажиллагааг чиглүүлэх, цагдаагийн байгууллага байгуулах тэрчилэн мөрийтэй тоглоомын газрыг хаах, тахианы тулааныг зогсоох зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

1826 оноос Их Британи улсын эзэмшил нутаг болж “Стрейтс-Сеттльментс” буюу “Тэнгисийн дэргэдэх суурин” гэж нэрлэгдэх болжээ. Англи улс уг арлыг 150 жил ноёрхож байсныг лорд С.Т.Раффлзын хүрэл баримал, английн олон ханхүү, гүнжийн нэртэй гудамж, талбай тэрчилэн Засгийн газар, Парламент, Театр, Үзэсгэлэнгийн танхим байрлаж байгаа байшингуудын уран барилгын дэг гэрчилнэ.

Сингапурын Засгийн газраас үндэсний соёлын дурсгал гэж зарласан “Раффлз” зочид буудлын

музейд олон тооны гэрэл зураг, эрт дээр үеийн ховор марк наасан захидал, ил захидал, тооцооны хуудас, хоолны нэрсийн жагсаалт бүхий самбарууд бий.

Япончууд 1942 онд Сингапур буюу “Арслангийн хот”-ыг эзлэж Английн далбааг буулгаж Шанан буюу “Өмнө зүгийн гэрэл” гэж өөрчлөн нэрлэжээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар англичууд аралд буцан ирж 1959 он хүртэл эзэгнэн суужээ. Сингапур дараа нь Малайзын холбооны улсын бүрэлдэхүүнд орсон ч 1965 онд тусгаар улс болжээ.

Арлын урт нь 42, өргөн нь 22,5 километр нийт талбай нь 227 хавтгай дөрвөлжин километр юм. Гэсэн ч арлын бүх нутаг дэвсгэр барилга байгууламжаар дүүрэн биш ажээ. Хотын хойд хэсэгт орших Мак-Ритчи усан сангийн эрэг бүхэлдээ ойгоор бүрхмэл ажээ.

Сингапур хот нь тэнгис рүү харсан агаад усан боомтын ойролцоох эрэг, гудамжуудад XIX зууны сүүлч XX зууны эхэн үед барьсан, англи хийцийн тав-зургаан давхар байшингууд жирийнэ. Сингапур гол урссаар усан боомт руу цуггадаг тэр хэсэгт хэмжээний хувьд бага Мерилин цэцэрлэгт хүрээлэн оршино. Энэхүү нов ногоон зүлэг бүхий ойн цоорхойн голд амнаас нь ус цацарч байдаг, гэрэлтэж байгаа нүд нь дийз санагдуулсан, 8 метр өндөр арслангийн толгойтой загас сүүлээрээ газар тулан байдаг. Энэхүү “Мерлайн” (англи хэлний “арслан, “лусын охин” хэмээх үгнээс гаралтай) баримал нь тус хотын билэг тэмдэг билээ. Арал дээр арслан огт байгаагүй ч ийм нэгэн эртний нэгэн домог байдаг.

VII зуунд ханхүү Санг Нила Утама тэнгист аялал хийж яваад далайн шуурганд өртөж завьтайгаа усанд живэхгүй гэж хамаг эд зүйлс түүний дотор хааны титмээ усанд хаяжээ. Шуурга сая нэг намдаж тэд хуурай газар дээр гарч хоноглох газар эрэв. Ханхүү гэнэт алсад хачин амьтны дүрс харагдахад арслан гэж бодож буудалласан газраа “Синга Пура” буюу “Арслангийн хот” гэж нэрлэжээ.

Тэнгисийн эрэг дээр орших “Барын давирхайны цэцэрлэг” тус хотын хамгийн нэртэй дурсгалт зүйл ажээ. “Барын давирхай” хэмээх эмчилгээний зориулалттай тосон эм гаргаж баяжсан ах дүү хятад иргэн Ау Бун-хау, Ау Бун-пар хоёр 1937 онд байгуулсан цэцэрлэг рүү орох чамин гоё нуман хаалга алсаас харагдана. Ах дүү хоёр түүхэнд нэрээ мөнхжүүлэх зорилгоор тэнгисийн эрэг дээр 8 га доворхуу налуу газар худалдан авч газрыг тэгшилж дорно зүгийн сүм хийдийн уламжлалт дэгээр сүүдрэвч, нуман хаалгатай, сэрүүцүүлэх ундаа худалдаалдаг мухлаг, лангуу бүхий гоёмсог цэцэрлэг байгуулсан ажээ. Цэцэрлэгийн дээд тагт дээр ах дүү хоёрыг оршуулж, хөшөө босгожээ.

Цэцэрлэгийн гол чимэг нь хиймэл агуй, сонин хачин хэлбэртэй хад асга, модот гудамж юм. Гөлтгөнөөр урласан домгийн амьтад, эртний баатрууд, жагссан цэргүүд, оршин суугчид нь гудамжаар нь алхалж байгаа хотхон ирсэн хүн бүрийн шохоорхлыг татаж сэтгэлийг нь сэргээнэ.

Сингапурын хүн амын дийлэнх хэсэг нь хотын өнцөг булан бүрт суудаг хятад гаралтай иргэд юм. Зарим нь бараг хоёр зуу гаруй жилийн тэртээ барьсан голдуу хоёр давхар байшингуудаас бүрдэх Хятад хотхонд бөөнөөрөө сууна. Хятад иргэд түүхийн урт удаан хугацаанд зэрэгцэн амьдарч байгаа малайз, энэтхэг зэрэг бусад үндэстэн, ястантай цусан холбоо огт тогтоож байгаагүй болохоор эртний уламжлалт ёс журам, гэр бүлийн өвөрмөц заншлаа яг хэвээр нь

хадгалж иржээ.

Сингапурт хятадын арав орчим сүм байдгаас хамгийн том нь зуу гаруй жилийн тэртээ босгосон бүддийн шашны “Ихрүүдийн шарил” сүм, хамгийн эртнийх нь 1815 онд барьсан “Аз жаргал, сайн үйлсийн сүм” юм. Яруу найрагч, уран зохиолчийн авьяасаараа алдаршсан лам Си У ХХ зууны эхээр “Хотын бурхны сүм”-ийг босгожээ.

Тооны хувьд хоёрдугаарт малайз иргэд орно. 1819 онд Сингапурыг англичуудад “өгсөн” султан Хусейний хойч үеийнхэн хотын төвд намхан жижиг байшингуудад сууна. Дийлэнх нь ядуувтар амьдардаг малайз иргэд тус орны улс төрийн амьдралд одоо ямар ч нөлөө үзүүлдэггүй ажээ. Хэлбэрийн хувьд яст мэлхийг санагдуулсан Кусу хэмээх арал бяцхан арал дээр орших лалын шашны бунхныг малайз иргэд дээдлэн шүтдэг. Үүдэнд нь шар од, тал сар дүрсэлсэн ногоон туг намирч байдаг бунханд чухам хэний шарил байдгийг хэн ч мэдэхгүй ч зөнч Мухаммедийн охиныг оршуулсан гэж малайз иргэд итгэсээр өнөөг хүрчээ.

Сингапурын хамгийн эртний түүхэн байгууламж нь малайзын эх сурвалжид “Букит Ларангам” (“Хориотой дов”) гэж нэрлэсэн байдаг, арлын анхны захирагчид цасан цагаан ордонд залран суудаг байсан Форт-Каннинг дов ажээ. XIV зуунд Явын эзэнт гүрний Маджахалит хааны удирдсан цэрэг Шривижай угсааны хаадын эрхлэлд байсан Сингапурыг байлдан дагуулахдаа удтал тулалдаж олон мянган цэргийн цусыг урсгажээ.

Сингапурын энэтхэг оршин суугчид нь тамил, телугу, малаяли, пуштун гэх зэрэг олон үндэстэн ястнууд юм. Тэд арлын бусад үндэстэн иргэдээс тусдаа өвөрмөц шашин, ёс заншлаа хатуу чанд баримтлан амьдарсаар өнөөг хүрчээ. Тэд хоол унд бэлтгэх болон хувцас хунараа сонгон өмсөхдөө хүртэл үндэсний уламжлалаа дагана. Тухайлбал тамил үндэстэн бүсгүйчүүд Энэтхэг улсад үйлдвэрлэсэн хувцас л дандаа өмсдөг учир дэлхийн хоёрдугаар дайны үед Сингапур, Энэтхэг хоёр улсын хоорондын харилцаа тасарч хил хаагдсан үед шинэ хувцас авч чадахгүй, урагдаж ноорсон хуучин хувцас өмсдөг байжээ.

Сингапурын энэтхэг оршин суугчдын дийлэнх нь индусын шашин шүтнэ, тэдний гол шүтээн нь “Мариаман ковил” сүм юм.

Субраманиам бурханд зориулан босгосон “Четтиар сүм”-ээрээ хот их алдартай. Жил бүр Сар, хамгийн тод од болох Пусамтай (Алтан гадас од) учирч уулздаг тай сард (нэгдүгээр сарын сүүлч хоёрдугаар сарын эхээр) тэмдэглэдэг “Тайпусам” баярын үед мөнгөн дугуйтай тэргээр Субраманиам бурхны хүрэл баримлыг хөгжим дуугарган жагсаж сүмд залдаг байна.

Хотын дорнын дүр төрхийг олон тооны зах, хятадын дэнлүүгээр бараагаа гэрэлтүүлдэг шөнийн зах, зөөврийн гал зуух, халуун орны жимс, ногоо, гадаад дотоодын гоёл, хувцас хунар, тэнэмэл илбэчид, могой сургагчид зэрэг гэрчилнэ.

Сингапурын гол зам дагуу эхүүн хурц үнэр ханхална. Гудамж талбайгаар толгойгоо алчуураар ороосон энэтхэг иргэд, малайз үндэсний сангоки малгай, европ хийцийн бүрх малгай өмссөн хүмүүс зөрөлдөнө. Хананд нь “Цэвэрч байдлыг сахицгаая!” гэсэн үгс бичээстэй том хоёр давхар автобус замаар хурдална. Татсан тамхиныхаа ишийг хаявал 100 доллараар торгоно гэсэн анхааруулга гудамж болгонд байна. Сингапурын бүх үйлдвэр, албан байгууллагад

бүдүүлэг зан гаргасан, бие биенээ хүндэтгээгүй, хогоо цэвэрлээгүй гэсэн элдэв шалтгаанаар байнга торгоно. Иймд Сингапур хот маш цэвэрхэн, бүх зүйлд хатуу дэг журам мэдрэгдэнэ.

## ЧИКАГО

Хойд Америкийн Их нуурууд шиг эх газрын гүн рүү шаантаглан түрэн орсон нутаг дэлхийд үгүй билээ. Тэрхүү сонин усан тогтоцын хамгийн өмнөд хэсэгт Мичиган нуурын баруун-өмнөд эрэг дээр Чикаго хот АНУ-ын төмөр замын томоохон зангилаа болон үүссэн ч одоо ч тус орны албан ёсны бус нийслэл гэж тооцогдсоор байна.



Дэлхийн бараг бүх хотын адил тус хотын нэр үүссэн тухай сонин түүх домог бий. Анхны европчууд Мичиган нуурын баруун-өмнөд эрэг дээр хүрэхэд тэнд улаан арьстнуудын бяцхан тосгон байлаа. Шарсан сонгинотой хурц үнэртэй хоол хийж байсан улаан арьстнуудаас европчууд тосгоны нэрийг асуухад цаадуул нь учрыг сайн ойлгосонгүй, идэж байгаа хоолыг нь сонирхож байна гэж бодоод “чикаго” гэж хэлжээ.

Энэхүү асар том хотын ажил хэргийн төв нь түүний зүүн хэсэгт орших бөгөөд “Луп” нэртэй ажээ. Хотын төвийг бусад хорооллоос нь тусгаарлан хоёр төгсгөлөөрөө нуур руу тулсан газрын дээрх метроны шугамын гогцооноос “Луп” нэр бий болжээ. Дээр үед Лупаас хойд зүгт Чикаго хотын цуутай мал нядалгааны газар, мах комбинатууд байсан бөгөөд 1971 онд хамгийн сүүлийн хонийг ёслол төгөлдөр төхөөрч бүрмөсөн хаажээ.

Гэхдээ мал нядлах газар байсны дурсгал болгож бухын цементэн толгойтой нуман хаалга босгожээ. Тэнд байрлаж байсан мах нядалгааны газар, мах комбинатуудыг хотын баруун хэсэгт, мал тээвэрлэн авчирдаг төмөр замын буудлын ойролцоо нүүлгэн шилжүүлжээ.

Хүнд аж үйлдвэрлэл салбарын эрчтэй хөгжилт махны аж үйлдвэрлэлийн салбарыг аль хэдийнээ ардаа хол хаяжээ. Чикаго хотын өмнөд хэсэгт АНУ-д хар металлургийн хамгийн томоохон төв болох аж үйлдвэрийн хороолол босчээ. АНУ-д мөн анхных болох “Мак Кормик” тракторын завод бий. Энэ хороололд машин үйлдвэрлэл, химийн аж үйлдвэрлэлийн дийлэнх үйлдвэр байрлана.

Луп төвд томоохон банк, трест, корпорациудын удирдлага байрладаг учир Чикагогийн Уолт-стрит гэж бас нэрлэнэ. Луп төвд ажилладаг хүмүүс хойд зүгт Чикаго голын цаана Мичиган

нуурын Алтан эрэг дээр сууна. Энд АНУ-д хамгийн тансаг болох орон сууцны хороолол оршино.

Мичиган нуурын эрэг дагуу байрлуулсан сайхан цэцэрлэгт хүрээлэнгийн цаана зүүнээс баруун зүг рүү чиглэсэн босоо хэмтэй гудамжуудыг зүссэн гудамжууд бүхий Мичиган-авеню хэмээх өргөн чөлөө байна. Ер нь бол Чикаго хотын үндсэн төлөвлөлт нь тэгш хэлбэртэй боловч нуур, голын мурилзсан эргийн шугамаас үүдсэн ташуу чиглэлтэй гудамж бас цөөнгүй бий.

Луп төв болон түүнтэй залгаа хорооллуудад XIX зууны үеэс шинээр ирсэн хүмүүс сууршиж эхэлжээ. Үүнд Саутсайд хороололд хар арьстан иргэд голдуу сууршина. Оршин суугчид үндэстэн, ястнаараа ялгаран тус тусдаа байрлаж байсан нь ихээхэн хор уршигтай байсан ч сүүлийн хэдэн арван жилд энэ байдал нилээд нааштай өөрчлөгджээ.

Чикаго хоттой америкийн ажилчны хөдөлгөөний олон гайхамшигт хуудас холбоотой билээ. Энэ утгаараа бусад аль ч хотоос илүү цуутай юм. Иллинойс муж улсад боолчлох ёс хэзээ ч байгаагүй ч аболиционистууд хар арьстнуудыг АНУ-ын өмнөд муж улсуудаас Канад руу дамжуулан гаргадаг алдарт “газар доорхи төмөр зам-”ын хойд төгсгөлийн цэг нь Чикаго хот байжээ. Тус хотын цагаан арьстан оршин суугчдын дийлэнх нь аболиционистуудыг дэмждэг байсан учир “хар арьстнуудад хайртай хот” гэсэн нэр авч байв. Чухам тийм учраас Авраам Линкольн 1860 онд ерөнхийлөгчийн сонгуульд Чикаго хотоос нэрээ дэвшүүлж байжээ.

Арван жилийн дараа Чикаго хот хар арьстан оршин суугчид иргэний эрхээ эдлэх болж анхны хар арьстан цагдаагийн офицер тодорчээ. Хожим нь дэлхий даяар тэмдэглэдэг болсон Майн баярын эмгэнэлт явдал Чикаго хотод болж америк орныг донсолгосон билээ.

XIX зууны хоёрдугаар хагаст АНУ-д ажилчдын тухай холбооны хууль байхгүй байсан тул аж үйлдвэрийн гол муж улсуудад ажилчдын байгууллага үүсгэн үйл ажиллагаа явуулахыг тас хориглодог байв. 1870 онд шүүхээс тусгай захирамж гаргаж ажил хаялт, хурал цуглаан хийхийг хатуу хоригложээ.

1886 онд улс орон даяар бүх нийтийн ажил хаялт өрнөж ажлын хөлсийг хэвээр үлдээж ажлын цагийг багасгах тухай шаардлагыг тавдугаар сарын 1-ний өдөр хийх жагсаал дээр албан ёсоор тавихаар бэлтгэж байлаа. Тэр жагсаалын бэлтгэл ажил Чикаго хотод аль хэдийнээс эхэлж “Мак Кормик” завод дээр, дараа нь өрнөдийн гол төмөр замын Чикаго хотын зангилааны ачигчид бас ажил хаялт хийж нийт ажил хаягчдын тоо 40 мянгад хүрчээ.

Хотын засаг захиргаа ажил хаялт эхэлсэн үеэс нийтийг хамарсан залхаан цээрлүүлэх ажиллагаа явуулж ажилчдыг хашраах зорилгоор ажил хаягчдын дунд элдэв өдөөн хатгалга хийж байлаа. Ингээд тавдугаар сарын 3-ны өдөр “Мак Кормик” үйлдвэр дээр болсон цуглааны үед цагдаа нар гал нээхэд гурван ажилчин алагдаж хэд хэдэн хүн шархаджээ.

Ажил хаягчид эсэргүүцлийн цуглааныг Хеймеркатийн талбайд хийхээр товлож 4-ний өдрийн үдэш болсон цуглаанд гурван мянга орчим ажилчин цугларчээ. Цуглаан эхэлж тайвуун үргэлжилж байтал гэнэт дэлбэрэлт болж буун дуу хадаж нилээд хэдэн хүн алагдахад тэдний дотор нэг цагдаа байв. Хотын захиргаа цагдаа алагдсаныг далимдуулан ҮЭ болон ажилчны



хөдөлгөөний идэвхтэнүүдийг баривчилж ажилчдын бүх байгууллагын үйл ажиллагааг хориглож сонин хэвлэлийг нь хаажээ.

Хотын захиргаанаас Хеймаркет-стрит, Вест-Рендольф-стрит хоёр гудамжны зөрлөг дээр хууль, дэг журам сахиулагч, дуулга өмссөн, дүрэмт хувцастай цагдаагийн хөшөө босгосныг нь ажилчид хэд хэдэн удаа дэлбэлж нурааж байсан учир эцэст нь аргаа барж 1982 онд хотын Цагдаагийн газрын байрны өмнө шилжүүлэн байрлуулжээ.

Гэтэл Хеймаркет-стрит гудамжинд зуу гаруй жилийн тэртээ болсон цуст үйл явдлын тухай дурсгалын самбар, хөшөө өнөө хүртэл байхгүй байна. Гэвч тавдугаар сарын 1-ний өдрийг жил бүр дэлхий даяар хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр гэж тэмдэглэсээр зуу гаруй жил болж билээ.

## МЕЛЬБУРН

Газар зүйн аугаа нээлтийн эрин үед голландчууд, испаничууд Энэтхэгийн далайн зүүн хэсэгт хэд хэдэн чухал нээлт хийсэн ч Австрали тив хүрсэнгүй өнгөрчээ. Манай эриний өмнөх II зуунд эртний грекийн эрдэмтэн Птоломей Энэтхэгийн далайгаас өмнө зүгт “терра аустралис инкогнита” буюу үл мэдэгдэх өмнөд нутаг бий гэж бичиж байлаа. Дундад зууны үеийн нэрт газрын зургийн мэргэжилтэн Г.Меркатор 1569 онд хэвлүүлсэн газрын зурагтаа өмнөд нутгийг мөн оруулсан байжээ. Гэвч алт эрж явахдаа Шинэ Гвинейн өмнөд эрэг хүрч тэндээсээ 1606 онд Карпентарий хоолойн нам дор эл хуль эрэг дээр анх хөл тавьсан голландын ахмад В.Янсзон “ногоон тив”-ийг нээгч гэсэн алдрыг албан ёсоор хүртсэн ажээ. Түүнээс 11 жилийн дараа мөн голландын аялагч Д.Хартог Австрали, Шинэ Гвиней, Тасманийн баруун эргийг нээжээ.

Голландчууд шинэ нутаг нээсэн ч эзэмшиж чадаагүй бөгөөд бүр хожуу английн аялагч Жеймс Кук Австрали тивийг “хоёр дахь” удаагаа 1770 онд нээсэн үеэс европчууд тус тивд бөөнөөр ирж сууршиж эхлэжээ.

Англичууд шинэ нутгийг эзэмшихээр очиход нутгийн уугуул иргэдийн зүгээс ямар нэгэн эсэргүүцэл үзээгүй учир анхандаа эрүүгийн гэмт хэрэгтнүүд, ирландын хувьсгалчид, цөллөгт заагдсан хүмүүсийг авчирч хорьж байлаа. 1788 онд ахмад А.Филиппийн удирдсан усан онгоцууд ирж дорнод эргийн Ботан-бей хэмээх газарт буусан ч намгархаг газар байсан тул хойд зүгт Порт-Жексон булан хүрч суурин байгуулсан нь ирээдүйн Сидней хот байлаа.

XIX зуунаас эхнээс чөлөөт иргэд Австрали тивд нүүдэллэн ирдэг болжээ.

1835 онд усан онгоцоор Порт-Филипп буланд хүрэх зам зуур Ярр голын адгийг нээсэн английн усан цэргийн ахмад Жон Бетменийг Мельбурн хотыг үндэслэгч гэж үздэг юм. Түүний багийн нэгэн офицер нутгийн омгийн удирдагчидтай дохио зангаар яаж ийгээд ойлголцож, 500 мянган га газар “худалдан авах” тухай тохиролцож чаджээ. Англичууд оронд нь хэдэн хутга, толь, хадуур, даашинз, ноосон бүтээлэг, хайч, хэдэн шуудай гурил, мөн тамхи өгчээ.

Мельбурн хотын нэгэн төв гудамжинд дөрвөн давхар байшингийн хэрийн өндөр тавцан дээр амандаа гаанс зуусан, халаасандаа гараа хийсэн, эрүүндээ сахалтай нэгэн эр том байшингийн битүү зураг бүхий хана руу ширтэн байна. Уг зурагт тэнгисийн буланд тулсан балар битүү ой, хөвж байгаа усан онгоцны дэлгэц дээр хар арьстан уугуул иргэд өвдөглөн суусан харагдана. Энэ бол ахмад Д.Бетмений модон хөшөө ажээ. Тэрбээр толгойгоо эргүүлэн харахад түүний нүдний өмнө Виктория мужийн төв Мельбурн хот тодорно.

1837 онд Д.Бетмений үүсгэн байгуулсан Мельбурн хот нэг зуун жилийн дараа далайн худалдаа хийдэг олон орны арилжаа наймааны гол цэг болж маш түргэн өргөжин тэлжээ. Британы арлаас нүүн ирсэн иргэд эх нутгаа санаж байсны илэрхийлэл нь Ричмонд, Виндзор, Кентерберри, Кенсингтон зэрэг нэр хаяг болно.

Австрали улсад Сидней, Мельбурн муж, хотууд аль дээр цагаас хоорондоо бүх салбарт

өрсөлдсөөр иржээ. Учир нь гэвэл өнөөгийн Виктория муж, ач холбогдлоороо тус орны хоёр дахь хотын иргэд алс орших Сидней төвтэй Шинэ Өмнөд Уэльс мужийн бүрэлдэхүүнд байгаадаа ихэд дургүйцэж тэр тухай Английн Виктория хатан хаанд хандаж тусдаа муж болох хүсэлт гаргажээ. Хатан хаан хүсэлтийг нь зөвшөөрөхөд, оршин суугчид баярлаж талархсанаа илэрхийлж шинэ муждаа хатан хааны нэрийг өгчээ.

Өнөөгийн Мельбурн хотын төв нь “Алтан бээр” гэж бас нэрлэдэг Сити ажээ. Тэнд тус хотын улс төр, худалдаа, соёлын амьдрал төвлөрч байдаг хийгээд орчин үеийн уран барилгын илэрхийлэл болох банк, томоохон корпорац, компани, санхүү, даатгалын байгууллагуудын өндөр байшингууд сүндэрлэн байна.

Сити хорооллын өмнөд талаар урсах Ярр гол дээгүүр гурван гүүр тавьсан бөгөөд зүүн талын гүүрээр гарч цэцэрлэгт хүрээлэн рүү, баруун гүүрээр гарч Виктория-док усан боомт руу очно. Мельбурн хот 400 хавтгай дөрвөлжин километр талбай эзлэн оршдогоос Сити хороололд 2,5 хавтгай дөрвөлжин километр нь ногдоно.

Хотын төвийн орчим улаан вааран дээвэртэй голдуу нэг давхар орон сууцны байшингууд байна. Хотын эргэн тойронд өөрийн хил хязгаартай, өвөрмөц нэр, хууль журамтай жижигхэн тосгон гацаа маш олон бий. Хотын гудамжууд өргөнөөрөө засмал замыг санагдуулах бөгөөд намхан байшингуудын далай тэнгис мэт харагдах дээвэр дундуур сүлжин мушгирна. Байшин бүрийн дэргэд нэгэн жигд өндөртэй тайрсан өвс бүхий жижигхэн зүлэг, бяцхан цэцгийн мандал байх агаад тэдгээрийг энгийн мөртөө намхан хашаагаар хүрээлүүлсэн байна.

Мэдээж хэрэг Мельбурн хотод ширмэн сараалжин хашаа тойруулан барьсан усан сан, том цэцэрлэгт хүрээлэн бүхий хоёроос гурван давхар тансаг чамин шилтгээн зөндөө бий. Хотод хэд хэдэн гоёмсог хороолол байдгаас саятнууд суудаг Турак хэмээх дагуул хот их алдартай. Австралийн нэрт эдийн засагч Э.Кембеллийн бичсэнээр “Турак хороололд дэлхийн аль ч өнцөг буланд байхгүй олон саятан оршин суудаг.” гэжээ.

Турак хороололтой залгаа орших Өмнөд Мельбурн хотхонд Домэн хэмээх том цэцэрлэгт хүрээлэн бий. Уг цэцэрлэгт хүрээлэнгийн төвд дов дээр Дэлхийн нэгдүгээр дайнд амь эрсэдсэн австралийн дайчдын дурсгалд зориулсан гантиг, хүрлээр урласан, хэлбэрийн хувьд пирамид санагдуулсан чулуун хөшөө бий. 1918 онд дэлхийн нэгдүгээр дайн дууссан 11 дүгээр сарын 11-ний өдрийн 11 цагт жил бүр хөшөөний шилэн бөмбөгөр оройд гаргасан нүхээр нарны гэрэл тусаж, хүрэл хавтан дээр сийлсэн “Хүнийг үзэн ядах биш хайрлах хэрэгтэй!” гэсэн үгийг гэрэлтүүлнэ.

Мельбурнчууд нийт австраличуудын адил спортод их дуртай. Талбайн одон бөмбөг австраличууд хувьд бараг үндэсний спорт нь болохоор тус оронд дэлхийд хамгийн олон талбайн одон бөмбөгний талбай байдаг. Австралийн тамирчид нэр хүндтэй Дэвисийн цомыг олонтаа хүртэж байсан хийгээд тус орны мужуудын хооронд болдог нээлттэй тэмцээн нь дэлхийн зиндааны ач холбогдолтой юм. Хотын иргэд хөнгөн атлетик, усан сэлэлт, гольф мэдээж хэрэг серфингийн спортоор түүний дотор эмэгтэйчүүд илүү олноор хичээллэнэ. Серфингийн спортын тамирчид тэнгисийн хүчит давалгааны нуруунд дээш доош шидэгдэн тэнцвэрт байдлаа хадгалан зугаацна.

1956 онд Мельбурн хотод болсон зуны олимпийн XVI наадамд зориулан босгосон 104 мянган хүний багтаамжтай Крикет-граунд цэнгэлдэх хүрээлэн тус орны томоохон барилга байгууламжийн нэг билээ.

Хотын иргэд ертөнцийн өнцөг булан бүрээс авчирч ургуулсан сонин чамин мод бут, цэцэг бүхий Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд чөлөөт цагаараа зугаалж чулуун давхарлагаас хоржигнон урсах усны чимээг чагнаж, сэтгэл амарна.

Виктория нь Австрали улсын хамгийн модорхог муж гэж тооцогдох хийгээд түүний нутаг дэвсгэрийнх нь 25 хувь нь ойгоор битүү хучигдсан байдаг учир жуулчдад зориулсан сурталчилгаанд Мельбурн хотыг “Австралийн цэцэрлэгт хот” гэж нэрлэсэн бий. Европийн олонхи хотын дээгүүр хуйлран байдаг утаан үүлс Мельбурн хотод байхгүй. Асар том ногоон байгууламж нь хотын агаарын цэвэршүүлж байдаг болохоор агаар нь цэвэр сайхан байдаг.

Виктория мужийн дархан цаазат газарт Австрали улсад ургадаг зэрлэг хүн орхоодойн таван зуун төрлийг үржүүлдэг бөгөөд түүнээс 145 төрөл нь тус мужийн нутаг дэвсгэрт ургадаг ажээ. Австрали улсад хуайс модны таван зуу гаруй төрөл ургадагаас мөнгөн хуайс мод илүү өргөн талбайд ургана. Хуайс модны нэгэн төрөл болох сийрсэн модыг Австрали улсад үндэсний ургамал гэж дээдэлдэг байна.

## ШАНХАЙ

Шанхай хот үүссэн цаг үеийг тогтоох маш хэцүү хийгээд тус хотын түүхийг судлаач эрдэмтэн Г.Г.Сюлленберг түүнийг Есус Христос төрөхөөс бүр өмнө бий болсон гэдэг. Хотын нэр хэрхэн үүсэн тухай олон таамаглал бий. Манай эриний өмнөх 300 оны үед өнөөгийн хотын буурин дээр загасчны хоёр тосгон байснаас нэг нь Хуанпу мөрний дээд хэсэгт байсан учир шан-дээд, хай-тэнгис гэсэн үгнээс бүтсэн Шанхай гэсэн нэртэй байжээ. Нөгөө тосгон нь ся-доод гэсэн үгнээс үүдэлтэйгээр Сяхай гэж нэрлэгдэж байжээ.

Хятадууд загас барихдаа ашигладаг байсан хулсан хэрэглэлээс үүсэлтэй “Ху” гэсэн нэрийг тус хот бас зүүж байв. Тэрчилэн манай эриний өмнөх үед эл газрыг эзэмшиж байсан Чунь Шэнь гэдэг хүн эзэмшил нутгаа бас “Шэнь” гэж хэлж байхыг мөн шаардаж байжээ.

Эрт дээр үед Хуанпу мөрөн ус багатай байсан учир Дорнод Хятадын худалдаанд гол үүрэг гүйцэтгэдэггүй, тиймд хотын хөгжилт удаан байв. Гэвч яваандаа мөрний ус нэмэгдэж хэдэн километр урсаж Янцзы голын адагт хүрч тэнгист гарцтай болсноор тээврийн гол зангилаа болжээ.

Хотын оршин суугчид худалдаа хийж чинээлэг амьдарч эхэлсэн ч тэдний баялагт шунасан далайн дээрэмчид байнга уулгалан довглож төвөг учруулж эхлэхэд хотын иргэд эрэлхэг зоригоо харуулж хамтын хүчээр эсэргүүцэн тэмцэж байжээ.

XIII зуун сүүлчээс тус хотод гадаадын усан онгоц ирж янз бүрийн бараа бүтээгдэхүүн худалдаалах болж гаалийн газар байгуулагджээ. Гэвч “Дундад иргэн улсын хөвгүүд” болох хотын оршин суугчид гадаадын иргэдийг бүдүүлэгчүүд гэж бишүүрхэж тэдэнд их дургүйцдэг байлаа.

Далайн дээрэмчдийн халдлага улам ширүүсч хотын оршин суугчид 1554 онд Хятадын эзэнт гүрний хаанд хандаж хотыг тойруулан хэрэм барих зөвшөөрөл олгохыг хүсэж өргөдөл явуулсан нь үр дүнд хүрчээ.

Гадаад орнууд Хятад улстай худалдаа арилжааг Кантон хотоор дамжуулан хийж байснаа Шанхай хотоор дайруулах нь илүү ашигтай болохыг ойлгож Дорнод-Энэтхэгийн компанийн зуучлагч Пигу гэдэг хүн 1756 онд тус хотод барааны агуулах барих хүсэлт гаргахад түүний хүсэлтийг зөвшөөрсөнгүй өнгөрчээ.

1839 онд эхэлсэн Англи, Хятадын “анхдугаар хар тамхины дайн”-ы явцад англичууд Гонконг, Амой, Нибо хотуудыг эзлэж 1842 оны долоодугаар сард оршин суугчдынх нь эсэргүүцлийг хялбархан дийлж Шанхай хотыг байлдан дагуулж Нанжингийн гэрээгээр бусад хэд хэдэн хотын хамт гадаад худалдааны нээлттэй хот болгон зарлажээ.

Г.Поттингер, ахмад Бальфур нар сеттльмен (колонийн том орнууд эзэмшил нутагтаа эх орон нэгтнүүдээ нүүдэллэн ирж амьдрахад зориулан барьсан суурин) босгох үүрэг авч Сучжоу гол болон Янкинпаны сувгийн хооронд газар сонгож намаг хатаах бөөн ажлыг амжуулжээ. Хэдэн жилийн дараа францчууд мөн газар авахаар хөөцөлдөж зорилгоо биелүүлжээ. Гэвч XVIII

зууны дунд үед америкчууд Шанхай хотыг концессийн гэрээгээр эзэмших хүсэлт гаргажээ. Тэгээд Шанхай хотын нутаг дэвсгэр дээр хятадын, францийн болон өөрийн удирдлагатай олон улсын сеттльмен бий болж тусдаа удирдлагатай гурван хот үүсчээ.

Шанхай хотыг “Хятадын хаалга” гэж нэрлэсэн гадаадын наймаачид Янцзы голыг уг голын сав нутгаас цуглуулан авч байгаа хэдэн мянган тонн түүхий эдийг гадаадад гаргах гол зам гэж үзэж байлаа. Шанхай хотын усан боомтод харуулын жижиг завиудаар хамгаалуулсан англи, францийн том усан хөлгүүд далбаагаа намируулан орж ирнэ. Харамсалтай нь хятадын далбаатай усан онгоц байсангүй.

Гадаадын иргэд бөөнөөр сууршиснаар Шанхай хот улам өргөжин тэлсээр хятадын чухал ач холбогдолтой хот болон мандлаа. Гэвч гадаадынхан болон хятад иргэдийн хооронд үргэлж маргаан зөрөлдөөн гардаг нь их таагүй явдал байлаа. Тухайлбал хятад иргэдийн олон нууц нийгэмлэгүүдийн нэг болох “Жижиг хутганы эздийн нөхөрлөл” хэмээх байгууллагын гишүүд 1835 онд “хятадын Шанхай”-г зэвсэглэн эзлэхэд Засгийн газар цэрэг илгээж цус урсган даржээ. Тариачид ч бас гар хумхин суусангүй, байсхийгээд л бослого хөдөлгөөн гаргана.

Иймэрхүү маргаан тэмцэлдээний үед гадаадын иргэд сууршисан хэсэгт байдал нилээд тайвуун байсан учир чинээлэг хятад иргэд тийшээ очиж суудаг болсноор барилга байгууламж барих ажил өргөн далайцтай өрнөж байлаа.

Тайпинуудын бослогыг дарсны дараагаар элдэв өрсөлдөөн намдаж хот эдийн засгийн хувьд улам хүчирхэгжжээ. Гэвч францчууд XIX зууны сүүлчээр засмал зам тавих зорилгоор хятад иргэдийн шүтээн болох Нинбоск сүмийг нураах гэж оролдсоноос болж 1900 онд “боксчдын” бослого гарсан ч гадаадын ихээхэн цэрэг байрлаж байсан учир төдөлгүй намжжээ. 1911 онд хувьсгал гарч манжийн дарлалыг устгаж дараа нь дэлхийн нэгдүгээр дайн эхлэсэн ч хотын ердийн хэмнэлийг өөрчилсөнгүй өнгөрчээ. Дайны үед фронтын хэрэгцээг хангахад чиглэсэн үйлдвэрүүдийн тоо эрс нэмэгдэв.

Орос улсад гарсан Октябрийн хувьсгалаас дүрвэсэн олон орос иргэн Шанхай хотод ирж сууршиж үнэн алдартны шашны сүм босгож драмын театр, балетийн сургууль байгуулж сонин сэтгүүл гаргаж байв. 1937 оны хоёрдугаар сард Тоор жимсний гудамжинд оросын их яруу найрагч А.С.Пушкиний мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан түүний хүрэл цээж баримлыг босгосон нь тус хот дахь гадаадын яруу найрагчид зориулсан цорын ганц хөшөө болжээ.

Уг хөшөөг дэлхийн хоёрдугаар дайны үед япончууд, соёлын хувьсгалын үед хунбейнчүүд дараалан нурааж байсан ч 1987 онд дөрөв дэх удаагаа сэргээн барьжээ.

Шанхай хотын барилга байгууламжийн дийлэнхийг гадаадын иргэд барьж босгосон болохоор хятадууд түүнийг хятадын хот гэж үздэггүй бол оршин суугчид нь хятадын хамгийн шилдэг хот гэж бахархана. Тэд “Шанхай нийслэл биш ч улс орны хоёр дахь хот биш.” гэж ярьцгаана. Өрнөдийн соёл иргэншлийн ололт, дорно зүгийн хачин чамин байдлыг хослуулсан тус хотын гол чимэг нь Хуанпу мөрөн ажээ. Мөрний усаар том, жижиг усан онгоц, завь өдөржин шөнөжин хөвж байна.

Шанхай хотын чимэг, бахархал нь тус хотын “европийн” хэсэг эхлэдэг үзэсгэлэнт Вайтан эрэг юм. Тус хотын нэрийн хуудас болсон мод, зүлэг бүхий зөрөг зам, цэцэрлэгт хүрээлэн бүхий эргийг 1870 оноос барьж тохижуулж эхэлсэн ажээ. Мөрөн дээгүүр тавьсан олон арван гүүрээс анх 1846 онд модоор барьж XX зууны эхээр шинэчлэн босгосон Вайбайдуцяо (“Үнэгүй зорчих гүүр”) гүүр хамгийн гоёмсог нь юм.

Гүүр рүү очихдоо 1888 онд анх байгуулах үед “Хятад иргэд болон нохой гарахыг хориглоно!” гэсэн үг бүхий самбар орох хаалганд нь хадсан байсан Хуанпу цэцэрлэгт хүрээлэнгээр дайрна. Европийн түүхчид тийм бамбар огт байгаагүй гэж нотлохыг оролдсоор байдаг.

Хуучин хотын төвд хятадын цэцэрлэгт хүрээлэнгийн урлагийн гайхамшигт бүтээлүүдийн нэг болох Юйюань (“Таашаалын цэцэрлэг”) цэцэрлэгт хүрээлэн оршино. XVI зууны хоёрдугаар хагасын үед баян тVШмэл Пань Юнь-дуан өндөр настай эцэг, эхдээ зориулан байгуулсан уг цэцэрлэгт хүрээлэн хожим нь олон өмчлөгчийн гар дамжсан хийгээд эзэн бүр нь цэцэрлэгт хүрээлэнгийн уран барилгын хийц, дэгийг улам чанаржуулсаар иржээ. Өнөө үед уг цэцэрлэгт хүрээлэн дотор Өмнөд Хятадын байгалийн өвөрмөц бүх онцлогийг жижигрүүлсэн хэлбэрээр харуулсан байдаг. 1920 онд тус цэцэрлэгт хүрээлэнд байрлуулсан хоёр хүрэл арсланг япончууд эзлэн түрэмгийлж байх үедээ эх нутагтаа аваачсан ч хожим нь буцаан өгчээ.

Соёлын хувьсгалын үед Шанхай хот Хятад улсын чухал усан боомт, аж үйлдвэрийн төв байсан ч хамаг орлогыг нь улсын төсөвт авдаг байжээ. Гагцхүү XX зууны ерээд оноос тус хотын байдал эрс өөрчлөгдөж эдийн засгийн шинэчлэлтийн бодлогын төв болж “лууны толгой”-ны үүрэг гүйцэтгэх болжээ.

## ХОНКОНГ

Хятадууд 1842 онд Нанжиний гэрээгээр Хонконг хэмээх “Үр ашиггүй чулууг англичуудад өгөхдөө шар үстэй бүдүүлэгчүүд чухам ямар чулуу болгон хувиргахыг төсөөлөхгүй байсан биз ээ.”

Англичууд 1839-1842 онуудад Хятадтай хийсэн “хар тамхины анхдугаар дайн”-ы үеэр Хонконгийг эзлэжээ. Английн алдарт дипломатч лорд Макартней 1793 онд Засгийн газрынхаа даалгавраар Өмнөд Хятадын эрэг орчмын арлыг худалдан авах ажлаар ирж байв. Тэрбээр Хятадын Цянь-лун хаантай уулзаж “английн бэхлэлт байгуулахад зориулж ямар нэгэн арал өгөх”-ийг гуйхад цаадуул нь эрс татгалзжээ.

“Хар тамхины анхдугаар дайн”-ы үед хятадууд Гуанчжоу дахь хар тамхийг нь хураах, устгах замаар бенгалийн хар тамхийг улс оронд нь зөөн оруулахыг хориглосныг, англичууд ашиг сонирхлыг нь хөндлөө гэж үзэж Өмнөд Хятадын нутгийн эрэг дээрх арлыг мөнхийн өмч болгон шилжүүлэн өгөх тулган шаардлагыг Хятадын хаанд тавьжээ. Тэгээд англичууд Янцзы голын адаг хавьд байрлуулсан усан цэргийн флотоо хөдөлгөж эрт дээр үеэс загас барих, далайн дээрэм хийх ажил эрхэлсээр ирсэн 6 мянга орчим хүн оршин суудаг Хонконг арлыг байлдан эзлэжээ.

Хятадын хаан буулт хийж 1842 онд Нанжиний гэрээгээр Сянган (Хонконгийн хятад нэр) арлыг Их Британий өмчлөлд шилжүүлжээ.

Сянган гэдэг нь “анхилуун үнэртний усан боомт” гэдэг утгатай ч энэ нэр хэрхэн үүссэн тухай маргаан одоо ч үргэлжилсээр байна.

Чухамдаа Нанжиний гэрээ байгуулагдсан үеэс Хонконгийн түүх эхлэсэн гэдэг билээ. Гэтэл Англичуудад нэг арал авсан нь багадаж “хар тамхины хоёрдугаар дайн”-ы (1856-1860) үед Хонконгийн арлаас хоолойгоор тусгаарлагддаг Коулун хагас арлын хэсгийг мөн эзлэжээ. Коулун хагас аралд залгаа хуурай газар болох “шинэ газар нутгийг” зуун жилийн хугацаагаар түрээслэн авсан 1898 онд Хонконг өнөөгийн хил хязгаар тогтжээ. Энэ “шинэ газар нутаг” нь Хонконг, хуучин Коулун газар нутгаас арав дахин илүү байв.

Гадаадын компаниуд валютын болон худалдааны гэрээ тэрчилэн хямд ажиллах хүчний ачаар Хонконг алтан ёроол болжээ. Гадаадын пүүсүүд жил бүр Хонконгоос 500 сая ам.долларын цэвэр ашиг олж байсан тухай албан ёсны мэдээлэлд дурдсан байдаг. Хонконгт ганц ч өрсөлдөгчгүй худалдааны диваажин байв. Гаалийн татваргүй байсан тул гэрэл зургийн аппаратыг Гамбургас хямд, японы техникийг Японоос хямд, швейцарын бугуйн цагийг Женевээс хямд зарах бололцоо олгож байв. Хятадын нэгэн улс төрийн зүтгэлтэн “Бид хоосон хад алдаад алтан уул буцаан авлаа.” гэж бахархан өгүүлж байв.

Хонконг орчин үеийн хот атугай ч дорно зүгийн чамин байдал нь жуулчид, гийчдийн шохоорхлыг татсаар байна. Арал дээр тоймгүй олон үндэстэн, ястны, янз бүрийн шашин шүтлэг, зан заншилтай хүмүүс оршин суудаг ч хүн амын дийлэнх буюу 98 хувь нь хятадууд ажээ. Хэдэн арван мянган даньцзя буюу “усны хүмүүс” жонк буюу сампангийг (төрөл бүрийн



завиуд) гэр орноо гэж үзэж өнөөг хүртэл амьдран суусаар байна.

“Усны хүмүүс” түүхийн аль цагт бий болсныг бүү мэд гэхдээ эрэг дээр оршин суудаг хүмүүс тэдэнд эрт дээр үеэс үл итгэдэг ажээ. Бүр 1729 онд хятадын хаан зарлиг гаргаж Гуандун мужийн оршин суугчдыг “усны хүмүүс”-т нөхөрсөгөөр хандаж байхыг даалгаж байжээ. Эртний домгоор, “усны хүмүүс” хөлдөө зургаан хуруутай, “ногоон нүд”-ээрээ тэнгист хөвж яваа лууг хүртэл харж чаддаг ажээ. “Усны хүмүүс” үргэлж халаас хоосон, татвар хураамжаа дандаа өндгөөр барагдуулдаг тул хуурай газрын хүмүүс тэднийг “танкууд” (“өндөгний хүмүүс”) басамжлан нэрлэдэг байна.

Хонконг, Коулун хагас арал дээр уран барилгын ямар ч дэг, хийцгүй олон тооны хөвдөг хотхон, тосгон шавааралдан оршино. Усан дээр барьсан хотхон, тосгон тэнгисийн давалгааны аясаар найгаж хөвдөг гудамж, догол гудамж нь мөн адил өөрчлөгдөнө. Тэнгисийн булангийн эрэг дагуу зангуугаа хаясан жонк завиуд будлим гудамж, догол гудамж үүсгэж хүнс, шуудангийн гэх зэрэг олон зориулалтын сэлүүрт болон хөдөлгүүрт завиуд ямар ч саадгүй сүлжин хөлхөлдөх нь их сонин. Эдгээр хотхон, тосгон цөмөөрөө нэртэй бөгөөд хамгийн том хотхон нь Абердин гэж нэрлэгдэнэ. Уг хотхон уран барилгын хувьд бусад хотхон, тосгоноос ялгагдахгүй ч жуулчид ирж хятад үндэсний дуртай хоолоо захиалж идэж болдгоороо алдартай хоёр хөвдөг зоогийн газраараа цууд гарчээ.

Хятадын хувьсгалын үед болон манжийн Цин угсааны хаадын ноёрхлыг унагаасан үед нутгийн хувьсгалчид англичуудын эсрэг хэд хэдэн удаа бослого гаргасан ч бүтэлгүйтжээ. Хорьдугаар зууны гучаад оны дунд үед Шанхайд болсон хятадын оюутнуудын жагсаалыг английн цагдаа нар буудсанаас улбаалан Хонконгийн оршин суугчид бүх нийтийн ажил хаялт зарлаж эзэмшил нутгийн бүх амьдрал зогсонги байдалд орж байлаа. Гэхдээ дэлхийн хоёрдугаар дайны үед япончууд арлыг эзлэж харгис хатуу дэглэм тогтоосон нь байдлыг өөрчилж английн дэглэм шудрага ёсны илэрхийлэл мэт санагдаж байжээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараа Өрнөд, Дорнод нийлж хоёр өөр соёл иргэншил энх тайвнаар зэрэгцэн оршсон Зүүн-Өмнөд Азийн эдийн засгийн төв болох Хонконгийн орчин үеийн дүр төрх бий болжээ.

Гэвч 1982 оны есдүгээр сард “төмөр хатагтай” М.Тэтчер Хятад улсад айлчлал хийх үед тус улсын удирдагч Дэн Сяопин “Шинэ газар нутгийн” түрээсийг сунгах буюу шинэчлэх ямар боломжгүй.” гэсэн хариу өгснөөр Хонконгийн дээгүүр бараан үүлс хуралдав. Байдлыг ойлгосон төмөр хатагтай Хонконгийг аль болох удаан хугацаагаар дотоод өөрөө удирдах ёс, эдийн засгийн боломжийн хэрээр улс төрийн эрх чөлөөг хангах нөхцөлд хятадын удирдлагад шилжүүлэн өгөх саналыг хариу болгож Дэн Сяопиний “нэг улс-хоёр систем” гэсэн үзэл санааг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгджээ. Энэ шийдвэрээ 1984 онд Хятад-Их Британий хамтарсан тунхаглалаар баталгаажуулж Английн сүүлчийн эзэмшил нутаг болох Хонконг 1997 оны долоодугаар сарын 1-ний өдөр Хятад улсын бүрэлдэхүүнд засаг захиргааны тусгай район болон хувиргах болжээ. Английн эзэмшил нутаг байсан Хонконгийн аж төрөх ёсыг тавин жилийн хугацаанд өөрчлөхгүй гэсэн амлалтыг Бээжин өгчээ.

Хонконгийн оршин суугчид дээрх шийдвэрийг янз бүрээр хүлээн авав. Олон нийтийн санал асуулгаар, оршин суугчдын 40 хувь нь нэгтгэснийг сайшааж 35 хувь нь эзэмшил нутаг бие

даасан улс болох ёстой, 20 хувь эзэмшил нутаг хэвээр байж улам цэцэглэн хөгжих нь зүйтэй гэж байв.

Хонконгийг Хятадын мэдэлд шилжүүлэх ёслолын өмнөхөн Үзэсгэлэнгийн төвд том түймэр гарч олон нийтийн санал бодлыг ихэд зовоов. Тэрхүү ёслолд Английн үе залгамжлах хунтайж Чарльз, ерөнхий сайд Т.Блэр, БНХАУ-ын дарга Цзян Цзэминь, ерөнхий сайд Ли Пэн, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга М.Олбрайт, ОХУ-ын Гадаад хэргийн сайд Е.Примаков нар ирж оролцжээ. 1997 оны зургаадугаар сарын 30-ны өдөр сүүлчийн амбан захирагч К.Пэттен Хонконгоос явж 19.09 цагт английн цэргийн гарнизоны штаб байрлаж байсан “Уэльсийн хунтайжийн Ордон” дээрээс нар жаргах агшинд Англи улсын далбааг буулгажээ.

# Table of Contents

[Өмнөх үг](#)

[НИНЕВИ](#)

[ВАВИЛОН](#)

[ИЕРИХОН](#)

[СПАРТА](#)

[УР](#)

[ДАМАСК](#)

[МЕРВ](#)

[МЕМФИС](#)

[АНУРАДХА ПУРА](#)

[МОХЕНЖО-ДАРО](#)

[АХЕТАТОН](#)

[ЭБЛА](#)

[ПАЛЬМИР](#)

[САМАРКАНД](#)

[ФИВЫ](#)

[БУХАР](#)

[АФИН](#)

[ИЕРУСАЛИМ](#)

[БЭЭЖИН](#)

[ХАНЧЖОУ](#)

[КАРФАГЕН](#)

[ЕРЕВАН](#)

[РОМ](#)

[ВИФЛЕЕМ](#)

[МЕРОЭ](#)

[ПЕТРА](#)

[КОНСТАНТИНОПОЛЬ СТАМБУЛ](#)

[АЛЕКСАНДРИ](#)

[МЕККА](#)

[БАРСЕЛОН](#)

[КОРДОВА](#)

[СИАНЬ](#)

[АКСУМ](#)

[ТОЛЕДО](#)

[КАБУЛ](#)

[ФЛОРЕНЦ](#)

[ЛОНДОН](#)

[ПАРИЖ](#)

[КЁЛЬН](#)

[ТИПАЗА](#)

[ЖЕНЕВ](#)  
[КАПШАДОКИ](#)  
[ТБИЛИС](#)  
[ПРАГА](#)  
[БРЮССЕЛЬ](#)  
[ЧИЧЕН-ИЦА](#)  
[ВЕНЕЦИ](#)  
[ЛХАС](#)  
[ЛИССАБОН](#)  
[АНТВЕРПЕН](#)  
[ДЕЛИ](#)  
[СТОКГОЛЬМ](#)  
[БАГДАД](#)  
[ТУЛА](#)  
[ФЕС](#)  
[КИОТО](#)  
[НОВГОРОД](#)  
[КРАКОВ](#)  
[ТЕГЕРАН](#)  
[РОСТОВ](#)  
[КИЕВ](#)  
[БУДАПЕШТ](#)  
[МАДРИД](#)  
[КАИР](#)  
[ХАНОЙ](#)  
[ВЕНА](#)  
[ВАРШАВ](#)  
[ТОМБУКТУ](#)  
[ЭДИНБУРГ](#)  
[ОСЛО](#)  
[МОСКВА](#)  
[ТУРКУ](#)  
[БЕРЛИН](#)  
[БАНДИАГАРА](#)  
[АМСТЕРДАМ](#)  
[КОПЕНГАГЕН](#)  
[ТОКИО](#)  
[ГАВАНА](#)  
[ЖАКАРТ](#)  
[БУЭНОС-АЙРЕС](#)  
[КУСКО](#)  
[ТЕНОЧТИТЛАН](#)  
[ЛА-ПАС](#)  
[ВАЛЕТТА](#)  
[БОМБЕЙ](#)

[РИО-ДЕ-ЖАНЕЙРО](#)

[МАНИЛА](#)

[НЬЮ-ЙОРК](#)

[УЛААНБААТАР](#)

[МОНРЕАЛЬ](#)

[КАЛЬКУТТА](#)

[САЙГОН](#)

[САНКТ-ПЕТРБУРГ](#)

[САН-ФРАНЦИСКО](#)

[АЮТИ](#)

[СИНГАПУР](#)

[ЧИКАГО](#)

[МЕЛЬБУРН](#)

[ШАНХАЙ](#)

[ХОНКОНГ](#)